

みんなくりポジトリ

国立民族学博物館学術情報リポジトリ National Museum of Ethnology

ХХ зууны Монголчууд /2/ :
Социалист Монголын улс
төрийн амьдрал

メタデータ	言語: ru 出版者: 公開日: 2009-04-28 キーワード (Ja): キーワード (En): 作成者: I., ルハグワスレン, 小長谷, 有紀 メールアドレス: 所属:
URL	https://doi.org/10.15021/00001396

Senri Ethnological Reports

72

**XX зууны Монголчууд /2/
— Социалист Монголын улс төрийн амьдрал**

Редактор

И.Лхагвасүрэн

Конагая Юки

Улсын улсаат зүйн музей
Осака 2007

The National Museum of Ethnology
Senri Expo Park, Suita
Osaka 565-8511, Japan

© 2007 by The National Museum of Ethnology
All rights reserved. Printed in Japan

Publication Data

The Twentieth Century in Mongolia (2) — Political Life in Socialist Mongolia
(Senri Ethnological Reports 72)

Edited by I. Lkhagvasuren and Yuki Konagaya

Includes bibliographical references

ISBN 978-4-901906-51-7 C3039

ISSN 1340-6787

1. Mongolia, 2. Socialism, 3. Narrative, 4. Political Power, 5. Purge

Book design by B2 Design, Kyoto, Japan
Typeset by Yubunsha Co., Ltd., Osaka, Japan

Оршил

И.Лхагвасүрэн

Уншигч авхай танд толилуулан буй энэхүү товхимолд МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбалын баримталж байгаа улс төрийн бодлого, чиг шугамтай санал нийлэлгүй түүнийг шүүмжлэж байсан Цогт-Очирын Лоохууз, Бадандоржийн Нямбуу нар болон Ю.Цэдэнбалтай олон жил хамт ажиллаж байсан С.Жалан-Аажав, Д.Содном, П.Очирбат, түүний төрсөн дүү Ю.Аюуш нартай 2005 оны 6-р сард хийсэн ярилцлагууд багтаж байна.

1964 оны 12-р сарын 20-21 нд хуралдсан МАХН-ын ТХ-ны 6-р бугд хурал дээр ЗХУ-ын Темирязов нэрэмжит ХАА-н Академийн аспирант Цогт-Очирын Лоохууз, Коммунист Намын Дээд сургуулийн сонсогч Балдандоржийн Нямбуу нар МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Юмжаагийн Цэдэнбалын баримталж байгаа улс төрийн бодлого, чиг шугам үндсээрээ буруу байна хэмээн шүүмжлэж, энэ алдаатай бодлогыг засаж залруулахыг шаарджээ. Тэд нар :

– Ю.Цэдэнбал улс орноо удирдаж чадахгүй байна. Тэрээр улс үндэстнийхээ эрх ашгийг тууштай хамгаалж чаддаггүй, өөрийн төрж, өссөн газар нутгаа харийн гүрэнд найр тавьж өгдөг, өөрийн орны эдийн засгийг хөгжүүлэх жинхэнэ шинжлэх ухааны үндэстэй төлөвлөгөөгүйн улмаас гадаадын зээл тусламжинд дулдуйдсан, бие даах чадваргүй эдийн засагтай болж, хараат байдалд орсон, “үндэсний үзэлтэн” гэсэн зохиомол нэр, хаяг зүүлгэж үндэсний залуу сэхээтнүүдийг элдэв янзаар дарамталдаг, ажлаас нь халж цөлдөг гэх мэтээр шүүмжилжээ. Мөн Ю. Цэдэнбал МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга, СнЗ-ийн даргын өндөр албан тушаалд он, удаан жил улиран ажилласан боловч хийж бүтээсэн зүйл нь үлэмжийн бага байна хэмээжээ. Ю. Цэдэнбал бол жинхэнэ авьяас билэг, ажил төрлөөрөө шалгарч МАХН-ын удирдагч, Монголын төрийн тэргүүн болсон хүн биш, түүний орос эхнэр авсан явдлыг Зөвлөлтийн Улсыг Аюулаас Хамгаалах Хороо / хуучин нэрээр / зохион байгуулсан бөгөөд тэр өөрөө орос эхнэрийнхээ нөлөөнд бүрэн орсон хүн гэжээ. Ю.Цэдэнбал бол намын хамт олны өмнө зүгээр нэг алдаа гаргасан хүн биш, Монголын төрийн өмнө гэмт хэрэг үйлдсэн хүн мөн хэмээжээ. Ю.Цэдэнбалын алдаатай бодлогод Бугд хурлын гишүүд дүгнэлт хийж, түүнийг нам, төрийн удирдлагаас нэн даруй гаргаж, “тахиж, шүтэж” байх явдлыг зогсоох хэрэгтэй гэжээ. Ц.Лоохууз, Б. Нямбуу нар энэ шүүмжлэлээ МАХН-ын болон улс орныхоо эрх ашгийн төлөө хийж байгаа бөгөөд тэдний шүүмжлэл хэзээ нэгэн цагт заавал

биелэх тул хурлын дараа тэднийг яаж шийтгэхээс айхгүй байна гэх мэтээр ярьжээ.

Энэ бол МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн даргын бүх үйл ажиллагаа нь зөв эсэхэд намын хамт олны дотор эргэлзээ төрүүлж чадсан маш хурц шүүмжлэл байв.

МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбал энэ шүүмжлэлийн хариуд нь МАХН-ын ТХ-ны гишүүдийн нэрийн өмнөөс “хуурамч тогтоол” гаргаж, Ц. Лоохууз, Б.Нямбуу нар болон тэдэнтэй хамт үг хэлсэн Б.Сурмаажавыг “МАХН-ын эсрэг бүлэг” гэж нэрлээд, МАХН-ын ТХ-ны бүгд хурлын гишүүнээс хасаж, МАХН-ын гишүүнийх нь батлахыг хураан авч, нутаг заан хугацаагүй цөллөгт явуулжээ. Энэ хугацаанд өөрийн хөдөлмөр, хичээл зүтгэл, авхаалж самбаагаараа өмч, хөрөнгөтэй болж амьдрал ахуйгаа өөд нь татаж явсан Ц.Лоохуузыг хуулийн ямар ч үндэслэлгүйгээр шийтгэж, зургаан жил шоронд хорьж, эхнэр хүүхдэд нь Монгол улсын иргэний паспорт олголгүй хавчин гадуурхаж байжээ. Ц.Лоохууз, Б.Нямбуу Б. Сурмаажав нар Дотоод яамны байнгын хатуу хяналт, дарамтан дор цөллөгт 25 жилийг өнгөрөөсөн байна. Ц. Лоохууз, Б. Нямбуу нар Ю.Цэдэнбал ямар хүн байсан, яагаад түүнийг шүүмжлэх болсон, тэднийг ямар үндэслэлээр, хэрхэн цөлсөн, цөллөгт тэд нар хэрхэн, яаж амьдарч явсан тухайгаа өөрсдөө маш сонирхолтойгоор бидэнд ярьж өгсөн юм.

Товхимолд бас Ю.Цэдэнбалтай он удаан жил хамт ажиллаж байсан, түүнийг сайн мэдэх МАХН-ын ТХ-ны Улс Төрийн Товчооны гишүүн, нарийн бичгийн дарга, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн орлогч дарга зэрэг нам, төрийн өндөр албан тушаалыг хашиж байсан Санпилын Жалан-Аажав, МАХН-ын ТХ-ны Улс Төрийн Товчооны гишүүн, Сангийн яамны сайд, Улсын төлөвлөгөөний комиссын дарга, Сайд нарын Зөвлөлийн дарга зэрэг албыг хашиж байсан Думаагийн Содном, Ю.Цэдэнбалын төрсөн дүү, Гадаад худалдааны яамны орлогч сайдын албыг хашиж байсан Юмжаагийн Аюуш болон Монгол улсын анхны Ерөнхийлөгч Пунсалмаагийн Очирбат зэрэг хүмүүстэй хийсэн ярилцлагууд багтаж байна.

– Ю. Цэдэнбал бол социализмын төлөө тууштай тэмцэгч, олон улсын коммунист ажилчны хөдөлгөөний нэрт зүтгэлтэн, өндөр болосролтой, өргөн мэдлэгтэй, хурц сэргэлэн ухаантай, хүнлэг энэрэнгүй, эелдэг, зөөлөн зантай, ард түмний хайр талархалыг хүлээсэн, Монголын ард түмний жинхэнэ удирдагч байсан гэж тэд нар үзэж байна. Ю.Цэдэнбал бол Монгол улсад социализмыг байгуулж, хөгжүүлэхийн төлөө, ард түмний сайн сайхан амьдралын төлөө өөрийн бүх мэдлэг, оюунаа бүрэн зориулсан цогтой эх оронч, шалгарсан коммунист байсныг тэд нар

онцлон тэмдэглэж байна. Уншигч авхай та мэргэн оюундаа болгоон соёрхоно уу.

Эцэст нь бидний хүсэлтийг хүлээн авч, ярилцлага өгсөн бүх хүнд болон энэхүү товхимолыг Япон хэлэнд орчуулах, хэвлэх ажилд гүн туслалцаа үзүүлсэн Японы авъяаслаг монгол судлаач эрдэмтэн, профессор Конагая Юки авхайд гүн талархал илэрхийлж байгааг минь болгоон соёрхоно уу.

Гарчиг

Оршил	1
Цогт-Очирын Лоохууз	7
Балдандоржийн Нямбуу	177
Юмжаагийн Аюуш	253
Санпилын Жалан-Аажав	285
Думаагийн Содном	333
Пунсалмаагийн Очирбат	387
Төгсгөлийн уг	417

Цогт-Очирын Лоохууз

1 1930-аад оны үеийн Монгол орон.	11 Би эрдмийн зэрэг хамгаалахаар болов.
2 Бага сургуульд.	12 Ю. Цэдэнбалыг би ингэж шүүмжлэв.
3 Улаанбаатар хот орж ирсэн.	13 МАХН-ын ТХ-ны 6-р бүгд хурал.
4 Би Намын шинэ хүчний сургуульд орлоо.	14 Манайх гэдэг айл.
5 МАХН-ын Төв Хороонд.	15 Атар газрыг эзэмшиж эхлэв.
6 Ю.Цэдэнбал.	16 Бидний зөв.
7 Би ЗХУКН-ын Дээд сургуульд сурахаар явлаа.	17 “Эсэргүү Лоохууз”.
8 МАХН-ын ТХ-ны Марксизм-Ленинизмийн тасагт.	18 Монголын уламжлал.
9 Би Говь-Алтай аймагт ирлээ.	19 Шоронд.
10 Намайг “САА-нуудыг удирдах газар”-ын даргаар томилов.	20 Хорин жилийн дараа Ю. Цэдэнбалыг халжээ.
	21 Монголд ардчилал, шинэчлэл өрнөж эхэллээ.

1 1930-аад оны үеийн Монгол орон.

Ичинхорлоогийн Лхагвасүрэн (цаашид **ИЛ**): Цогт-Очирын Лоохууз таныг 20-р зууны Монголын хамгийн алдартай улс төрчдийн нэг гэж ард түмэн үнэлдэг. Энэ удаагийнхаа ярилцлагыг таны бага насны амьдралаас эхэлбэл ямар вэ? Та хэдэн онд, хаана төрсөн бэ? Та өөрийн бага нас болон аав, ээж, ах, эгч, дүү нарынхаа тухай бидэнд ярьж өгнө үү?

Цогт-Очирын Лоохууз (цаашид **ЦЛ**): За. Хол газраас ирж, монголчууд бидний амьдралыг сонирхож байгаад би их баяртай байна. Би 1923 онд, Монголын баруун хязгаарт, Монгол Алтайн их нурууны Говийн Алтайн уулсын дунд төрсөн хүн. Би хулгана жилтэй хүн. Миний төрсөн нутаг Улаанбаатараас 1.000 гаруй км-ийн алсад байдаг юм. Засаг захиргааны хуучин хуваариар бол Засагт хан аймгийн Засагт ханы хошуу, одоогийнхоор бол Говь-Алтай аймгийн Чандмань сумын нутаг юм. Манай гэр Ботгоно гол гэдэг газар зусланд байхад би төрсөн юм гэнэ билээ. Миний аав Равжаагийн Цогт-Очир гэдэг хүн байв. Тэр нийгмийн гарлын хувьд тайж юм.

И Л: Цагаан ястай хүнийг тайж гэдэг биз дээ.

Ц Л: Тийм. Чингис хааны “алтан ураг”-ийн удмын цагаан ястай

хүмүүсийг тайж гэдэг шүү дээ. Миний эцгийн аав Равжаа тойн гэдэг хүн байв. Тэр хөх номин жинстэй, угсаа залгамжилсан тайж хүн байж. Түүний ах, дүүс нь Гончиг тайж гээд, хэн, хэн тайж ч билээ, зөндөө олон тайж нар байлаа. Тэд нар удмаараа тайж хүмүүс байв. Равжаа тойны хүү нь болох манай аав тайж угсааны хүн байна биз дээ. Манай нутагт Чингисийн удмын, тайж угсаатай “Хөх Дангийнхан” гэдэг нэг хэсэг, төрөл хүмүүс байсан юм. Миний эцгийн удам бол тэд нараас гаралтай юм билээ.

Миний ээж бол Баатарын Лхамжав гэдэг хүн байсан юм. Түүний аав Халгай Баатар бол Богд хаант Монгол улсын үед баруун хязгаарыг хамгаалах цэрэгт явж байсан хүн. Тэднийх зургаан сайхан охинтой айл байж. Ууган охин нь миний ээж юм билээ.

Бид нар чинь эцэг, эхээсээ ах, дүү тавуулаа юм л даа. Би дээрээ хоёр эгч, нэг ахтай, доороо нэг охин дүүтэй хүн. Би айлын дөрөв дэх хүүхэд нь байгаа юм. Намайг бага байхад миний хоёр эгч хоёулаа айлын эхнэр болоод, нэг нь 2 хүүхэдтэй, нэг нь 5 хүүхэдтэй айлууд болжгоосон. Тэд нар малаа маллаад л амьдарцгааж байв.

Миний аавыг 1932 онд Дотоод яам баривчилж, одоогийн Завхан аймгийн “Улиастайн шорон”-д хорьсон юм. Би аавынхаа баривчлагдсантай холбогдуулаад энд товчхон түүх ярья л даа.

1921 онд Монгол оронд Ардын хувьсгал яллаа. Энэ үеэс Ардын төр, Ардын засгийн газрын үйл ажиллагаа эхэлдэг юм. 1924 он хүртэл Монголд социализмыг байгуулах уу, үгүй юү гэдэг нь тодорхой бус байлаа. Тэр үеийн Ардын төр, Ардын засгийн удирдлагууд энэ асуудлаар нэгдмэл санаа бодолтой байсангүй. Нэг хэсэг нь социализм байгуулахаас эрс татгалзаж байхад бас түүнийг дэмжих хандлагатай нэг хэсэг хүн байсан юм шиг байгаа юм. Ийм байдалтай байсаар 1924 онтой золгожээ. 1924 он бол Монголын шинэ үеийн түүхэнд эргэлтийн шинжтэй он болсон юм. 1924 оны 5-р сард Монголын Бурхны шашны тэргүүн Богд Жавзандамба хутагт таалал төгсжээ. Бурхны шашин бол Монголын нийгэмд үлэмжийн их нөлөөтэй байлаа шүү дээ.

Богд Жавзандамба хутагт бол Бурхны шашны тэргүүн төдийгүй Монголын төрийн тэргүүн байлаа. 1921 оноос өмнө тэр Монголын хэмжээгүй эрхт хаан байв. Ардын хувьсгалын дараа Ардын засгийн газар түүний эрх мэдлийг нь хязгаарлаад хэмжээт эрхт хаан болгосон юм. Монголын шинэ үеийн түүхчид, эрдэмтэн судлаачид, Богд Жавзандамба хутагтын таалал төгссөн шалтгааны талаар үнэн үгийг хэлэх байх гэж би найдаж байна. Түүнийг таалал төгссөний дараа өрнөсөн улс төрийн олон үйл явдлууд ийм зайлшгүй шаардлага байна гэдгийг харуулаад байдаг юм.

Богд Жавзандамба хутагтын таалал төгсөхийн өмнөхөн 1923 оны 2-р сард бас нэг хүн нас барсан юм. Энэ бол 1921 оны Ардын хувьсгалын

удирдагчдын нэг Д.Сүхбаатар юм. Д.Сүхбаатар бол энэ хувьсгалын удирдагч нарын дотроос хамгийн шалгарсан удирдагч, халуун эх оронч хүн гэж Монголын ард түмэн үнэлдэг юм. Монгол Ардын Хувьсгалт Нам (МАХН)-ын түүхэнд “Д.Сүхбаатар хатгаа авч, бие нь муудаад нас барсан!” гэж тэмдэглэдэг юм. Гэвч “энэ бол түүний нас барсан шалтгаан биш!” гэж эргэлздэг хүн олон байдаг юм. МАХН-ын үзэл суртлаас ангижирсан түүхчид энэ талаар үгээ хэлнэ биз ээ.

Богд Жавзандамба хутагтийг ийнхүү таалал төгссөний дараа Монголын улс төрийн амьдралд олон үйл явдлууд зэрэгцэн өрнөсөн юм. Удалгүй 1924 оны 11-р сард Улсын анхдугаар их хурал хуралдаж манай анхны Үндсэн хуулийг батласан юм. Энэ хуулинд манай улсын засаглалын хэлбэрийг “Бүгд Найрамдах Бүрэн Эрхт Ард Улс” гэж тодорхойлсон байна. Ингэж хаан ширээг дахин залгамжлуулахгүй байхаар шийджээ. Энэ бүгдийг МАХН шууд удирдаж байлаа шүү дээ. Энэ үед МАХН бол засгийн эрхийг барьдаг улс төрийн цорын ганц хүчин байлаа. Монгол орны хөгжил, ард түмний амьдралтай холбоотой бүх асуудлыг энэ намын бодлогоор тодохойлж байлаа.

1924 оны 8-р сард МАХН-ын 3-р Их хурал хуралдаж Монгол орны ирээдүйн хөгжлийн чиг, шугамын тухай асуудлыг авч хэлэлцсэн байна. Тэгээд Монгол орныг цаашид “Хөрөнгөтний бус замаар хөгжүүлнэ!” гэсэн улс төрийн бодлогын чиг шугамыг дэвшүүлж баталжээ. Энэ чиг шугамыг “МАХН-ын жанжин шугам” гэж нэрлэсэн байна. Ийм чиг шугам батлахыг их хуралд оролцсон МАХН-ын удирдлагын нэг хэсэг нь маш хүчтэй эсэргүүцсэн байна. Гэтэл хурлын явц дундуур тэднийг бүгдийг нь баривчлаад, үг дуугүй буудаж алсан аймшигт хэрэг явдал гарчээ. Ингэж буудуулж амь насаа алдсан хүмүүсийн дотор Ардын төр, Ардын засгийн томоохон зүтгэлтнүүд багтаж байсан юм.

Ийм эмгэнэлтэй хэрэг явдал гарахад “Коммунист интернационал” (КОМИНТЕРН–товчлол.) томоохон үүрэг гүйцэтгэсэн гэж Монголын түүхэнд тэмдэглэдэг юм. “Коммунист Интернационал” бол Орос оронд ялсан Октябрийн социалист хувьсгалын удирдагч В.И.Лениний санаачлагаар 1918 онд байгуулагдсан олон улсын ажилчны хөдөлгөөний байгууллага юм. Коминтерний Гүйцэтгэх Хороо нь Москвагаас үйл ажиллагаагаа явуулж байлаа. Энэ байгууллагын гол зорилго нь “дэлхийн социалист хувьсгал”-ыг орон болгонд ялуулах явдал байлаа. “Дэлхийн социалист хувьсгал”-ын тухай онол нь анх 19-р зууны дунд үед Германд буй болсон юм. Энэ онолын үндсийг К.Маркс, Ф.Энгельс нар тавьжээ. Тэд нар “Социалист хувьсгал нэг оронд ялаад амжилт олохгүй. Түүнийг олон улсын хөрөнгөтнүүд нийлээд дарчихна. Тийм учраас орон бүхний пролетари нар хүчээ нэгтгээд социалист хувьсгалыг

орон бүхэнд зэрэг ялуулах хэрэгтэй!” гэж сургаж байсан байна. Тэр хоёр 1848 онд бичсэн “Коммунист Намын тунхаг” гэдэг алдартай бүтээлдээ анх энэ санаагаа дэвшүүлжээ. Тэд нар “Орон бүхний пролетари нар нэгдэгтүн!” гэдэг алдартай лоозунгоо энэ үед анх дэвшүүлж байв. 1924 он хүртэл Коимнтерний үйл ажиллагааг В.И.Ленин удирдаж байлаа. 1936 онд олон улсын ажилчны хөдөлгөөний энэ байгууллага өөрөө тарсан юм. Байгуулагдсан цагаасаа хойш 20 шахам жил “Дэлхийн социалист хувьсгал”-ыг орон болгонд ялуулах гэж янз бүрийн “террорист” ажиллагаа явуулсан боловч ямарч амжилтанд хүрээгүй нь ийм шийдвэр гаргахад нөлөөлсөн байх.

МАХН-ын түүхэнд 3-р Их хурал онцгой байр суурийг эзэлдэг юм. Энэ үеэс эхлээд Монголын угсаа залгамжилсан ноёд, тайж нарын зэрэг дээд язгуурын сурвалжит хүмүүс, Монголын Бурхны шашны дээд лам нарыг дарлагч анги гэж үзэх болсон юм. Ингээд тэднийг “ангийн дайсан”, “хувьсгалын эсэргүү нар” гэж тодорхойлоод, шууд устгах бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн юм. 1923 оны 1-р сард Ардын засгийн газраас “Монголын олон засаг ба засаг бус ван, гүнгийн эрх хэмжээний дүрэм”, “Монгол улсын нутгийн захиргааны дүрэм” гэдэг баримт бичгүүдийг батлан гаргасан байлаа. Энэ хоёр баримт бичиг бол Монголын угсаа залгамжилсан ноёд, тайж нарыг нийгмийн амьдралаас шахан зайлуулж, “ангийн дайсан”-ны хувьд устгахад чухал үүрэг гүйцэтгэх ёстой байж.

Гэтэл МАХН-ын 3-р Их хурлаас хойш МАХН-ын дотор энэ асуудлаар дахин санал зөрөлдөж, хагарал гарсан байна. 3-р Их хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхээс татгалзаж, түүнийг эсэргүүцсэн нэг хэсэг гишүүд МАХН-ын удирдлагад байсан байна. Тэднийг “баруунтан” гэж түүхэнд тэмдэглэдэг юм. Харин энэ шийдвэрийг дэмжиж, түүнийг нэн даруй хэрэгжүүлэхийн төлөө ажиллаж байсан нэг хэсгийг нь “зүүнтэн” гэж нэрлэх болсон байна. Эд нарын тэмцэл нилээд хэдэн жил үргэлжилжээ. Эхэн үедээ “баруунтан” нь дийлэх хандлагатай байсан байна. Тэд нар ард олонд өөрсдийн чадал чинээгээрээ хөрөнгөжиж, чинээлэг амьдралтай болохыг уриалж байсан байна. Энэ бодлого ард түмний зүгээс ихээхэн дэмжлэг авч байж.

Гэвч “баруунтан”-ууд сүүлдээ ялагджээ. 1928 оны 10-р сард МАХН-ын 7-р их хурал хуралдаж “баруунтан”-уудыг МАХН-ын удирдлагаас гаргаж, МАХН-ын гишүүнээс хөөсөн байна. Эд нар хожим бүгд баривчлагдаж, цаазлуулсан юм. Энэ үеэс эхлээд МАХН-ын удирдлагад “зүүнтэн”-үүд олонхи болж, өөрсдийн бодлогыг хэрэгжүүлж эхэлжээ. Тэд нар МАХН-ын 7-р их хурлаас “дарлагч анги”-ийг эдийн засгийн хувьд хүчин чадалыг нь устгах зорилт дэвшүүлсэн байна. Ингээд хөрөнгөтэй чинээлэг иргэд, эртний сурвалжит ноёд, тайж нарын өмч, хөрөнгийг нь

хураан авах шийдвэр гаргасан байна. 1929 онд Улсын Бага хурлын дэргэд “Өмч, хөрөнгө хураах улсын төв комисс” байгуулагджээ. Энэ комисс бүх орон даяар өмч, хөрөнгийг хураан авах ажлыг удирдсан юм.

Энэ ажлын хүрээнд Монголын Бурхны шашны сүм, хийдийн өмч, хөрөнгө, түүний мэдэлд байгаа малыг нь хураан авч эхэлсэн юм. Энэ ажил “жасын кампани” гэдэг нэрээр Монголын түүхэнд орсон юм. 1930 онд “зүүнтэн”-үүдийн удирдлагын дор МАХН-ын 8-р их хурал хуралдсан юм. Энэ их хурал ард түмний хувийн өмч болсон малыг нийгэмчилж хамтралуудыг олноор нь байгуулах шийдвэр гаргасан юм. Ингээд ард түмний хувийн өмч болсон малыг хүчээр нийгэмчилж эхэлсэн байна. Энэ бол “Монгол оронд социализмыг түргэвчлэн байгуулах зорилгоос урган гарсан шийдвэр юм!” гэж тэр үед МАХН-ын удирдлагад олонхи болж байсан “зүүнтэн”-үүд өөрсдөө тайлбарлаж байсан юм. Монголын Бурхны шашны сүм, хийдээс хурааж авсан малыг шинээр байгуулагдаад байсан хамтралуудад өгч эхэлсэн байна.

1930 онд МАХН, Ардын төр, Ардын засгийн газар Монгол улсын “Гадаад худалдааны улсын онц эрх”-ийг тогтоосон юм. “Гадаад худалдааны онц эрх” улсын мэдэлд шилжээд, хувийн худалдаа бараг хориотой болсон байна. Энэ үеэс эхлээд улсын худалдаа, хоршооны шугамаар гадаадаас импортоор орж ирсэн бэлэн бараа, бүтээгдэхүүн худалдаалагдаж эхэлжээ. Үүний зэрэгцээ ард түмний өргөн хэрэглээний барааны хомсдол газар авч эхэлсэн байна. Өргөн хэрэглээний барааны хомсдол манайд 1990-ээд он хүртэл үргэлжилсэн юм шүү дээ.

1920-оод оны сүүлч, 1930-аад оны эхээр хуралдсан МАХН-ын их хурлуудаас гаргасан эдгээр шийдвэрүүд нь улс орны хөгжилд үлэмж саад учруулсан, маш алдаатай, буруу шийдвэрүүд байсан юм.

Ийм үйл явдлуудын дунд, ийм учир шалтгаануудын улмаас миний аав 1932 онд баривчлагджээ. Түүнд манай Дотоод яам цаазаар авах ял оноосон байгаа юм. Түүнийг бас л “ангийн дайсан”, “хувьсгалын эсэргүү” гэж үзсэн биз. Тэр үед миний аав шиг зөвхөн “цагаан ястай” угсаа залгамжилсан ноён, тайж гаралтай байсныхаа төлөө Дотоод яаманд баривчлагдаад, цаазлагдах ял сонссон хүн улс орны хэмжээнд маш олон байсан юм шиг байгаа юм. Гэтэл миний аав шоронд байх хугацаандаа тураалд ороод, амь нас нь эгзэгтэй байдалд орсон байгаа юм. Тэгээд түүнийг шоронгоос суллажээ. Сулласан шалтгаан нь ч үүнтэй холбоотой биш байх л даа. 1930-аад оны эхээр МАХН-ын бодлогод дургүйцсэн ард олны дургүйцэл дээд цэгтээ тулаад, Монголын бараг бүх аймаг ард олны бослогод автсан байна. Босогчид хүчээр байгуулсан олон хамтралууд болон улсын хоршоо, худалдааны газруудыг тарааж эхэлсэн байна. Энэ бослогуудыг “хувьсгалын эсэргүү лам нарын бослого” гэж Монголын

түүхэнд тэмдэглэдэг юм. Учир нь ард олны дотор аяндаа, ямарч зохион байгуулалтгүй эхэлсэн энэ бослогуудад Монголын Бурхны шашны лам нар олноороо оролцсон юм. Энэ бослогуудыг МАХН, Ардын засгийн газар Дотоод яамны цэрэг болон Ардын журамт цэргийн хүчээр дарж, удирдагч нарыг нь баривчлан авсан юм. МАХН-ын бодлогыг амьдарлд хэрэгжүүлэх явцад үүссэн энэ нөхцөл байдалд Ардын төр, Ардын засгийн газар дүгнэлт хийж, урьдын гаргасан алдаатай шийдвэрүүдээ яаралтай хүчингүй болгож эхэлсэн байна. Ингэж миний аав шоронгоос суллагдан гарч ирсэн юм даа. Миний аавтай хамт Улиастайн шоронд хоригдож байсан цөөхөн хүн суллагдсан юм билээ. Гэвч гэм, зэм хийгээгүй олон сайхан хүмүүс шоронгоос суллагдаж чадалгүй цаазлагдсан юм билээ. Миний аав суллагдаж гарч ирж байсан үеийн Ардын төр, Ардын засгийн бодлогыг Монголын түүхэнд “Шинэ эргэлтийн бодлого” гэж нэрлэдэг юм. Энэ үеэс эхлээд МАХН-ын хэтэрхий их эрх мэдлийг хязгаарлаж, түүний бодлого, шийдвэрийг дагахаас татгалзах хандлага газар авч эхэлсэн байна. МАХН-ын бодлогыг шууд хэрэгжүүлж байснаас болоод, улс орон аюулын ирмэгт тулаад байсныг Ардын төр, Ардын засгийн удирдагчид ойлгож эхэлсэн юм. Гэвч “Шинэ эргэлтийн бодлого” удаан үргэлжлэж чадсангүй, удалгүй төгсгөл болсон юм.

Миний аавыг Дотоод яам баривчлаад аваад явсан тэр жил бидний амьдралд өөр нэг том үйл явдал болсон юм. 1932 онд миний ах Ардын цэргийн албанд татагдаад явлаа. Тэр үед манай улсад 18-25 насны бүх хүн цэргийн алба хаах хуультай байв. Ах маань Улаанбаатарт цэргийн албаа хааж байсан юм билээ. Тэгээд нэгэн золгүй явдлын улмаас миний ах нас барсан юм. Ахыг цэрэгт татагдах тэр үе бол манай улсын дотоод байдал маш тогтворгүй, бүхэлдээ их түгшүүртэй байсан үе шүү дээ. Монголын бараг бүх аймаг “хувьсгалын эсэргүү лам нарын бослого”-д автаад байсан үе. Ах маань Улаанбаатарт Цагаан хуаранд цэргийн алба хааж байсан юм билээ. Дотоод яамны цэрэг болон Ардын журамт цэрэг бослого, үймээн самуун гарсан гол, гол аймгуудад очиж тэднийг дарж, бослогын удирдагчдыг баривчлах ажлыг гүйцэтгэж байсан байна. Миний ах чухам тийм ажилд явж байсан юм уу, үгүй юм уу, мэдэхгүй. Ийм эгзэгтэй хүнд үед манай цэргүүдийн байрладаг Цагаан хуаранд, цэргийн хүнсний ус нийлүүлдэг худагт хор буюу шохой хийж цэргүүдийг олноор нь алсан хэрэг гарсан юм байна. Энэ хэргийг МАХН, Ардын төр, Ардын засгийн газраас явуулж байгаа бодлогод дургүйцэж, өшөө, хонзон санасан хүмүүс зориудаар үйлдсэн байж болох юм. Олон хүн нас барсан юм гэнэ билээ. Ингэж миний ах нас барсан юм.

Ахыг нас бардаг тэр жил ээж маань бас нас барсан юм даа. Энэ бол аав шоронгоос гарч ирээд хоёр жил болж байсан үе юм. Тэр үед миний

охин дүү гарах их ойртсон байж л дээ. Энэ үед ахыг нас барсан тухай мэдээ иржээ. Тэр мэдээг сонсоод, миний охин дүүг гаргасны дараа ээжийн маань бие нь тэнхрэхгүй байсаар нас барсан юм. Тэр үед миний ээж 44 орчим л настай цэл залуу байж. Ингэж гэртээ сая гарсан миний охин дүү, аав бид гурав үлдсэн юм. Тэр үед би 14 настай байсан. Миний хоёр эгч тусдаа амьдардаг болсон үе юм.

Гэвч улс, орон, ард түмний амьдралд тайван, амгалан цаг тогтох бас л болоогүй байж. 1930-аад оны дунд үеэс урьдынхаас ч аюултай, эмгэнэлтэй үйл явдлууд эхэлсэн юм. Түүнийг Монголын түүхэнд “нэг хүнийг тахин шүтэх явдал” гэж нэрлэдэг юм. “Нэг хүнийг тахин шүтэх явдал” гэдэг нэрийн дор Монголд ямар хэрэг, явдлууд болж өнгөрсөн бэ? Юуны өмнө улс төрийн хилс хэргээр гэм, зэмгүй олон мянган монгол хүн цаазаар авхуулж, амь насаа алдсан юм. Үүнийг Монголын түүхэнд “улс төрийн хэлмэгдүүлэлт” гэж нэрлэсэн юм. Улс төрийн хэлмэгдүүлэлт нь 1937-1938 онуудад оргилдоо хүрсэн юм. Монгол оронд улс төрийн хэлмэгдүүлэлт өрнөхөд Ерөнхий сайд, маршал Х.Чойбалсан их үүрэг гүйцэтгэсэн гэж МАХН-ын түүхэнд тэмдэглэдэг юм.

Х.Чойбалсан бол МАХН-ыг үндэслэн байгуулагчдын нэг бөгөөд 1921 оны Ардын хувьсгалыг ялалтанд хүргэсэн эх орончдын нэг юм. Тэрээр 1895 онд Сэцэн хан аймгийн Санбэйсийн хошуунд төрсөн хүн. 1921 онд Д.Сүхбаатар Ардын журамт цэргийг байгуулж, Монголд байрлаж байсан Оросын цагаан цэргийн ангиуд болон Хятадын Гоминданы цэрэгтэй байлдаж, тэднийг Монгол орноос хөөж гаргахад Х.Чойбалсан оролцож, онцгой гавьяа байгуулсан юм. 1921 оны 7-р сард Бүх цэргийн жажин Д.Сүхбаатарын тушаалаар Х.Чойбалсангийн командалсан “Баруун замын тусгай анги” нийслэл хүрээнд байрлаж байсан Оросын цагаан цэргийн генерал Барон Унгерний цэрэгтэй гарамгай тулалдаж, Монгол улсын нийслэл Их хүрээг чөлөөлөхөд оролцож байсан юм. Тэр бол Монголын Ардын журамт цэргийн шалгарсан дарга нарын нэг байсан юм. 1921 онд Ардын хувьсгал ялсны дараа Х.Чойбалсан төр, засгийн өндөр албанд томилогдож байсангүй, харин МАХН-ын 3-р их хурлаас хойш улс төрийн нилээд идэвхтэй үйл ажиллагаанд оролцох болсон байна. 1929 онд “Хөрөнгө хураах улсын төв комисс”-ын даргаар томилогдож, энэ ажлыг онцгой сайн гүйцэтгэсэн гэдэг юм. 1936 онд Х.Чойбалсан Дотоод Явдлын яамны сайд, 1937 онд Ерөнхий сайд, Цэргийн яамны сайд, Бүх цэргийн жанжнаар томилогдсон байна. Энэ үеэс эхлээд тэр МАХН-ын үйл ажиллагааг бараг ганцаараа удирдах болсон байна. Ингэж түүний гарт МАХН-ын болон Ардын төр, Ардын засгийн бүх эрх мэдэл төвлөрчээ. Энэ байдал нь Монгол оронд “нэг хүнийг тахин шүтэх явдал”-ыг улам гааруулж, улс төрийн хэлмэгдүүлэлт

газар авах нөхцлийг бүрдүүлсэн гэдэг юм.

1921 оноос 1937 оны хооронд Монгол улсад нийтдээ 30 мянга орчим хүн улс төрийн хилс хэргээр цаазлагдсан гэсэн баримт байдаг юм. Тэдгээрийн томоохнуудаас нь дурьдвал 20-оод оны эхээр “Бодоо нарын хэрэг”-ээс эхлээд, 30-аад оны дунд үеийн “Лхүмбийн хэрэг”, “Гэндэн, Дэмид нарын хувьсгалын эсэргүү байгууллага”, “Амар, Товчин нарын хувьсгалын эсэргүү хэрэг”, “Лувсаншарав, Лосол, Догсом нарын хэрэг”, “Ёнзон хамба, Дэд хамба нарын хувьсгалын эсэргүү байгууллага” зэрэг юм. Эдгээр хэргүүд бол бүгд “зохиомол хэрэг” байсан бөгөөд түүнд маш олон хүнийг хамруулж, огт хийгээгүй хэргийг тулгаад, хийсэн гэж гүтгээд, шүүх хурлыг хуралдуулж, цаазаар авах ял оногдуулаад, бүгдийг буудаж хороосон юм. Ингэж цаазлагдсан хүмүүсийн дотор Ардын төр, Ардын засгийн томоохон зүтгэлтнүүд багтаж байлаа. Тухайлбал, Монгол улсын гурван Ерөнхий сайд улс төрийн “зохиомол хэрэг”-г гүтгэгдэж, цаазлуулсан юм. Тэдний дунд Ардын төр, Ардын засгийг үндэслэн байгуулагчид, Улсын Бага Хурлын дарга нар, төрийн сайд нар, цэргийн өндөр албан тушаалтнууд, Монголын бурхны шашны дээд лам нар, олон мянган энгийн лам нар багтаж, амь насаа алдаж, цаазлуулсан юм.

Улс төрийн ийм хэмжээний хэлмэгдүүлэлтийг Х.Чойбалсан ганцаараа санаачилж, гүйцэтгээгүй нь мэдээжийн хэрэг. Энэ хэрэг явдалд Зөвлөлт Холбоот Улсын Коммунист Нам (ЗХУКН)-ын бодлого маш хүчтэй нөлөө үзүүлсэн гэж МАХН-ын түүхэнд тэмдэглэдэг юм. Ялангуяа ЗХУКН-ын Төв Хороо (ТХ)-ны Ерөнхий нарийн бичгийн дарга, Сайд нарын Зөвлөл (СнЗ)-ийн дарга И.В.Сталины шууд “зөвлөлгөө” үлэмж их үүрэгтэй байсан гэж тэмдэглэдэг юм. И.В.Сталин бол Зөвлөлт Холбоот Улс (ЗХУ)-д том хэмжээний, маш аймшигтай улс төрийн хэлмэгдүүлэлтийг өөрөө гардаж удирдсан, цуст дарангуйлагч хүн.

Манай ерөнхий сайд Пэлжидийн Гэндэн их омголон зантай хүн байсан гэдэг юм. Тэр бол Арвайхээрийн талд залуу насаа өнгөрөөсөн, гайхамшигтай энгийн, сайхан монгол хүн байж. Монголын бурхны шашны олон лам нарын талаар ямар бодлого явуулбал зохистой талаар өгсөн “зөвлөлгөө”-г нь сонсоод, Ерөнхий сайд П.Гэндэнгийн уур нь хүрч И.В.Сталиныг алгадаж байсан баримт байдаг юм. Бие даасан хоёр улсын төрийн тэргүүнүүд уулзаад, өөр өөрийн оронд явуулах бодлогын талаар санал солилцож, туршлагаа хуваалцаж, бие биендээ зөвлөлгөө өгөх нь байж болох л асуудал шүү дээ. Гэхдээ И.В.Сталин түүнд ямар “зөвлөлгөө” өгснийг таахад амархан. И.В.Сталины үед Оросын үнэн алдартны шашин хэрэг дээрээ утсан шүү дээ.

Ардын төр, Ардын засагт томоохон алба хашиж байгаад цаазаар авхуулсан хүмүүсийн ихэнх нь МАХН-ын явуулж байгаа бодлоготой ямар

нэгэн байдлаар санал зөрдөг байсан нь ийнхүү зохиомол хэрэгт тэднийг гүтгэж, цаазлахад шууд нөлөөлсөн гэж үздэг юм. Тэр үед Монгол улсын гадаад улс төрийн байдал ч их хүнд болж байсан нь хэлмэгдүүлэлтийг улам лавшруулсан байх. Өөрөөр хэлбэл гадаадын хөрөнгөтөн оронтой, тухайлбал, хөрөнгөтөн Японтой дайн хийхэд хүрвэл МАХН-тай санал нийлдэггүй эдгээр дотоодын дайснууд, гадаадын дайсантай нийлж, улс оронд маш аюултай байдал үүсэж болох юм гэж МАХН-ын удирдлага болгоомжилсон байх. Тэгээд дайн эхлэхээс өмнө “дотоодын дайсан”-аа дарсан хэрэг байж л дээ. Энэ бол Халх голын дайны урьдхан болсон үйл явдлууд юм шүү дээ. Бид иймэрхүү байдалтай явсаар Халх голын дайнд тулж ирсэн юм даа.

2 Бага сургуульд.

Конагая Юки (цаашид **КЮ**): 1932 онд танай аавыг Дотоод яам баривчлаад, бас хөрөнгийг нь хураасан уу?

Ц Л: Манай аавд хураалгах хөрөнгө байгаагүй юм. Манайх цөөхөн малтай айл байсан юм. Манай бүх мал зуун толгой гарч л байсан байх. Унах унаатай, саалийн үнээтэй, идэшний хоньтой л айл байсан даа. Тайж нар “хамжлагатай тайж”, “хамжлагагүй тайж” гэж хоёр төрөл байсан юм. Манай аав бол “хамжлагагүй тайж” юм. Ийм тайж нарыг бас “хохь тайж” гэж нэрлэдэг шүү дээ. Миний аав бол их ажилсаг хүн байсан юм. Бас их алсын бодолтой хүн байсан юм шиг байгаа юм. Миний аав малаа маллахын зэрэгцээ дандаа гэрээрээ юм үйлдвэрлэдэг хүн байлаа. Малын арьс, ширийг элдээд хүүхдүүдийнхээ өмсөх хувцасыг нь бүгдийг нь өөрөө хийж өгдөг, малын ногт, чөдөр, татлагын сур зэргийг бүгдийг өөрөө элддэг байлаа. Бас мужааны ажил хийж, гэрийн мод, дотоод тавилгын модон авдар, модон ор, модон шүүгээ, саалийн модон хувин зэргийг бүгдийг нь өөрөө хийдэг байсан юм. Заримдаа дархны ажил бас хийж, хазаарын амгай, эмээлийн даруулга, монгол цоож, хутга, шөвөг зэргийг хийж чаддаг байсан юм. Ер нь 1921 оны Ардын хувьсгалаас өмнө Монгол хүн өөрийн хэрэгцээт бүхий л зүйлээ өөрсдөө хийдэг байлаа шүү дээ. Манайд чинь “өрхийн үйлдвэрлэл” маш хүчтэй хөгжсөн байсан юм. Өөрсдийн хэрэглэх эд, зүйлсийг хийдэг арга, технологи нь маш өндөр хөгжсөн байж. Энэ чинь олон мянган жилийн туршид шалгарч ирсэн арга, технологи байсан юм шүү дээ. Цагийн аяс дааж шалгарсан нь үлдээд, улам баяжаад, хөгжөөд л байж. Миний ажигласнаар 1921 оны Ардын хувьсгалын дараа “улсын худалдаа, хоршоо” буй болоод бэлэн бараа нийлүүлдэг систем тогтоод, “өрхийн үйлдвэрлэл” устаж, үгүй болох

замдаа орсон байна. Эд, юмсыг хийдэг арга, технологиуд нь ч мартагдаж, хийдэг хүмүүс нь цөөрч эхэлжээ. Хожим би МАХН-ын гишүүнээс хөөгдөөд, нутаг заагдаад, Дотоод яамны хатуу хяналтын дор цөллөгт амьдарч байхдаа энэ байдлыг маш сайн ойлгосон юм. Хүмүүс бэлэн юм аваад хэрэглэхдэг болсон байна. Энэ чинь маш аюултай сөрөг нөлөөг дагуулж ирж байгаа юм. Ер нь нэг шинэ юм буй болоход нөгөө талд нь заавал сөрөг үзэгдэл гарч ирдэг шүү дээ. 1920-оод оны дундаас эхлээд улсын худалдаа, хоршоо буй болсон нь цаашдаа Монголын нийгэмд маш их хортой сөрөг нөлөөг дагуулж ирсэн гэж би боддог юм. Миний аав ядуу хүмүүсийг цуглуулаад, арьс, шир, сур элдэх, эсгий хийх, дархан, мужааны ажил хийх аргыг нь зааж өгдөг байсан юм. Өөрөөр хэлбэл тэдэнд амьдрах ухааныг нь зааж өгдөг хүн байж л дээ.

Ээж, ах хоёрыг нас барснаас хойш аав намайг бага сургуульд оруулсан юм. Тэр үед бага сургуулийг “тэнхим” гэдэг байлаа. Манай Алтай нутагт сургууль ерөөсөө байгаагүй юм. Улсын худалдаа, хоршоо ч байгаагүй. Энэ бүхэн чинь их хожуу буй болсон зүйлүүд юм. 1922-23 онуудад Улаанбаатарт анхын сургуулиуд байгуулагдаж байсан байх. Түүнээс 10-аад жилийн дараа Алтай нутагт анхны сургуулиуд буй болж эхэлсэн юм. 1935 онд Говь-Алтай аймгийн Чандмань, Эрдэнэ, Бигэр, Баян-Цагаан, Баян-Өндөр гэсэн 5 сумын дунд анхны бага сургууль байгуулагдаж байсан юм билээ.

Аав намайг бага сургуульд оруулахдаа нилээд алсын юм бодсон юм шиг байгаа юм. “Шинэ төр, засаг тогтлоо. Шинэ цаг ирж байна. Хүүдээ энэ шинэ цагийн ном сургая! Цаашдаа энэ шинэ цаг үедээ амьдралаа залгуулж явахад нь хэрэг болно!” гэж бодсон юм шиг байгаа юм. Бас ах цэрэгт яваад харамсалтайгаар нас барсан явдал ч түүнд нөлөөлсөн байж магадгүй. Тэр үед чинь ард түмэн хүүхдээ сургуульд өгөх маш дургүй байлаа шүү дээ. Хүн бүр амины өмчтэй, мал ихтэй байсан үе юм л даа. Сургуулийн багш нар сургуулиа сурталчлаад л айлуудаар явна. “Сургуульд сурах нь амьдралд хэрэгтэй, сайн хэрэг шүү!” гээд л ухуулаад явдаг байсан юм. Ард, олон түүнийг нь бараг хүлээж авдаггүй байлаа. Тэр үед хүмүүс хүүхдээ лам болгох нь чухал гэж үздэг байлаа шүү дээ.

КЮ: Та сургуульд суухаар гэрээсээ бүр явчихсан юм уу?

Ц Л: Тэгсэн. Манай баруун хязгаарт байгуулагдсан анхны тэр бага сургууль маань долоо, найман гэрт багтаж байсан юм. Хүүхдүүд мориор эцэг, эхээрээ хүргүүлж ирээд, тэр гэрүүдэд амьдардаг байлаа. Тэр гэрүүд бол сургуулийн дотуур байр шүү дээ. Эхний үед улсын хэмжээнд сургуулийн дотуур байр ингэж гэрт байрладаг байсан юм. Хожим гэрийн

оронд байшин буй болсон шүү дээ. Манай сургуулийн хүүхдүүд эцэг, эхийнхээ хийж өгсөн ердийн хувцастайгаа ирцгээдэг байсан юм. Ирсний дараа сургуулиас нэг загварын хувцас тавьж өгч байсан юм. Тухайлбал, өвлийн цагаан хурган малгай, үстэй дээл, орос эсгий гутал, хавар, намрын ногоон эсвэл бор өнгийн хөвөнтэй дээл гэх мэтийн хувцаснуудыг өгдөг байлаа. Өөр газрын туршлагаас харахад эхний үед хүүхдүүд гэрээ санаад, сургуулиас оргох явдал их гардаг байж л дээ. Тэгээд манай нутагт хүүхдүүдийг сургуульд татах, түүнд дуртай болгох зорилгоор ийм ажил зохиодог байж. Сургууль хүүхдүүдэд өдөрт 3 удаа хоол өгдөг байлаа. Сургуулийн хүүхдүүд хоолоо иддэг тусгай гал тогооны гэртэй байсан юм. Манай сургуулийн гэрүүд чинь сумын төв дээрээ байна шүү дээ. Сумын төвд сумын захиргаа, хүн эмнэлэг, бага сургууль, мал эмнэлэг гэх мэтийн албан газрууд байдаг байсан юм. Бас Монгол Ардын Хувьсгалт Намын үүр, Монголын Хувьсгал Залуучуудын Эвлэл (МХЗЭ)-ийн үүр заавал байна. Сумын төвийн албан газруудад ажилладаг хүмүүс долоо, долоо хоногоор ээлжлээд хагас, бүтэн сайны амралтын өдөр сургуулийн хүүхдийг зугаацуулдаг байлаа. Сумын төвөөс гадагш гарч, хүүхдүүдийг уралдуулж, барилдуулдаг байсан юм. Бас дуу дуулуулж, бүжиг хийлгэнэ. Түрүүлсэн хүүхдэд чихэр, боов өгч шагнана. Ийм янз бүрийн ажил зохиодог байлаа.

КЮ: Танай сургуулиас хүүхэд оргох тохиолдол гарч байсан уу?

Ц Л: Бараг гараагүй юм аа. Харин чөлөө аваад гэртээ харьдаг байсан. Энэ үед хүүхдүүд сургуулиасаа оргох нь жаахан бага болсон байлаа л даа. Бас тэднийг их зугаацуулж байлаа шүү дээ. Тэнд сурч байсан хүүхдүүд насны хувьд бас чиг тийм бага хүүхэд биш байсан юм. Би л гэхэд 14 настай болчихсон 1-р ангид сурч байгаа юм. 10-аас доош настай хүүхэд бараг очоогүй байх. Дандаа л 10-аас дээш настай, зарим нь бүр 16-17 настай очсон байх. Тэгээд 19-20 нас хүрч байж л бага сургуулийн 4-р ангиа төгсч байлаа шүү дээ.

Бидэнд “Монгол бичгийн цагаан толгой”, “Тоо бодлого”, “Дэлхийн байдал” гэдэг хичээлүүд заадаг байлаа. Монгол бичиг зааж, уншиж, бичиж сургадаг байлаа. Тоо бодлогын хичээлээр нэмж, хасаж, үржүүлж, хувааж сургадаг байлаа. Тэгээд “Дэлхийн байдал”-ын хичээлээр “Дэлхийн улс төрийн газрын зураг” дээр ямар, ямар улс хаана байдгийг ялгаж мэддэг болгоно. Бас “Байгаль зүй” гэдэг хичээл заадаг байлаа. Дэлхийн хүн ам, ургамал, амьтны гарал, үүсэл, нар, сар, од, гаригийн байршил гэх мэтийг заана. Ер нь орчин үеийн танин мэдэхүйн ухааны анхны мэдээллүүдийг би тэр үед л олж авсан байх.

Манай сургуульд 3 багш ажиллаж байсан юм. Манай суманд бичиг үсэг сайтай, багш болохоор хүн байсангүй. Дандаа өөр сумаас ирсэн багш нар ажиллаж байлаа. Манай сургуулийн захирал Д.Гончиг гэдэг багш байлаа. Д.Гончиг багш бол Улаанбаатар хотод Багшийн техникумийг төгсөж ирээд, манай аймгийн Тайшир суманд байгуулагдсан бага сургуульд багшилж байсан юм. Тайшир сумын бага сургууль бол манай аймагт байгуулагдсан хамгийн анхны бага сургууль байлаа. Түүнээс гадна С.Ядмаа, Х.Лочин гэдэг хоёр багш байсан юм. С.Ядмаа багш бол манай аймгийн Төгрөг сумын хүн, Х.Лочин багш бол Эрдэнэ сумын хүн байв. Энэ гурав бол миний анхны багш нар юм.

Д.Гончиг багш надад монгол бичиг заадаг байлаа. Тэр өрөө их гоё бичдэг байв. Би түүнийг нь дурайж гоё бичих гэж их оролддог байлаа. Д.Гончиг багш хичээлийн бус цагаар хүүхдүүдтэйгээ бөмбөг их тоглодог байлаа.

Тэр үед бөмбөг маш ховор, түүнийг тоглодог хүн бараг байхгүй байлаа шүү дээ. Ингэж хотын соёл бага ч гэсэн нэвтэрч байлаа л даа. Тэр үед үзэг, харандаа, дэвтэр, ном их ховор байлаа. Балын харандаа, “төмөр үзэг”, үзгээ дүрж бичдэг “черниль” байсан. Манайд дээр үед “үнсэн самбар” хэрэглэдэг байсан шүү дээ. Модон дээр тос түрхээд, түүнийхээ дээр үнсийг жигд түрхэж, түүн дээрээ нарийн модоор зурж бичдэг байж. Намайг бага сургуульд сурч байх үед ийм самбарыг хэрэглэхээ болиод, түүний оронд “модон самбар” хэрэглэдэг болсон байлаа. Сургуулиас харандаа, дэвтрийг тавьж өгдөг байв. Ийм дэвтэр, харандаа гадаадаас ирж байсан байх. Үзэг, харандаа их үнэтэй байсан юм. Бид нар сургуулиас тавьж өгсөн харандаагаа гэртээ харих үедээ аваад харьдаг байв. Түүнийг сургуульд суугаагүй хүүхдүүд их сонирхдог, эцэг, эх нь хониор сольж аваад хүүхдүүддээ өгдөг байлаа. Би өөрийнхөө харандааг бас хониор солиод, хоньтой болж байсан хүн шүү.

Манай сургуульд нийт 20 гаруй хүүхэд сурч байсан юм. Эмэгтэй хүүхэд их цөөхөн байсан. Ердөө 2-3 эмэгтэй хүүхэд сурч байсан санагдаж байна. Бусад нь эрэгтэй хүүхдүүд байв. Эд нар сургуулиа төгсөөд, үргэлжлүүлэн суралцахаар бүгд Улаанбаатар явсан юм. Энэ бол 1939 оны үе юм шүү дээ.

Тэр үед Улаанбаатарт дээд сургууль байгаагүй. Харин 5 техникум байсан. Хүн эмнэлэгийн техникум, Мал эмнэлэгийн техникум, Багшийн техникум, Холбооны техникум, Санхүүгийн техникум гэсэн таван техникум байлаа. Энэ таван сургууль 20-оод оны сүүлчээр байгуулагдсан байх. Би эхний үед сургуулиасаа ганцаараа нутагтаа үлдсэн юм. Манай сургуулийнхан бүгд Улаанбаатарт техникумд сурахаар явцгаалаа. Манай ээж нас барсан, ах цэрэгт яваад нас барсан шүү дээ. Манай сумын дарга

нарт манай гэрийн энэ байдал нилээд хүнд сэтгэгдэл төрүүлсэн байх. Тэд нар намайг “Гэртээ үлдээд, аавдаа туслаж байг!” гэж бодсон байх, бусад хүүхдтэй хамт Улаанбаатар явуулсангүй.

Тэр жилээ би сумынхаа Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэлийн үүрийн даргаар сонгогдсон юм. МХЗЭ-ийн үүр бол тэр үед бараг сум болгонд байсан байх шүү. Би бага сургуульд сурч байхдаа МХЗЭ-д гишүүнээр элссэн юм. Ер нь тэр үед 16 нас хүрсэн, сургуульд сурч байгаа бүх хүүхдүүдийг автоматаар МХЗЭ-ийн гишүүнээр элсүүлдэг байв. Энэ практик бүр 90-ээд он хүртэл үргэлжилсэн юм шүү дээ. МХЗЭ-ийг 1921 оны 8-р сард байгуулагдсан гэж үздэг юм. “МАХН-ын дайчин туслагч, бэлтгэл хүчин бол МХЗЭ мөн!” гэж үздэг байлаа. Монголын залуучуудын улс төрийн энэ байгууллага байгуулагдсан цагаасаа эхлээд, МАХН-ын бодлогыг хэрэгжүүлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэж байсан юм. МАХН-аас явуулж байгаа улс төрийн томоохон кампанит ажилд МХЗЭ-ийн гишүүдийг шууд татан оролцуулдаг байлаа. Би ийм ажлыг 5-р сараас 9-р сар хүртэл хийсэн юм. Манай МХЗЭ-ийн үүр 20-оод гишүүнтэй байв.

МХЗЭ-ийн үүрийн дарга сард нэг удаа гишүүдийнхээ хурлыг хийдэг байлаа. Хурлаараа янз бүрийн асуудал хэлэлцэнэ шүү дээ. Голчлон сум, орон нутагт болж байгаа олон үйл явдлуудыг шүүн хэлэлцэнэ дээ. Мөн сум, орон нутагт зохиогдож байгаа хүн, хүч хэрэгтэй ажилд оролцдог байлаа. Тэр үед улсын хэмжээгээр “Ноос бол алт” гэсэн хөдөлгөөн өрнөж байсан юм. Ер нь зөвхөн ноос ч биш малын гаралтай түүхий эд, мах, сүүг улсад хямд үнээр тушаах төлөвлөгөөг айл бүхэнд малынх нь тоогоор оногдуулж өгдөг болсон юм. Ийм зүйлүүдийг айл бүр улсад заавал тушаах ёстой байсан тул түүнийг “албан журам” гэж нэрлэсэн юм.

Би МХЗЭ-ийн үүр ийнхээ гишүүдийг “Ноос бол алт” гэсэн ажилд оролцуулдаг байлаа. Тэр үед манайхан хонины ноосыг бага ашигладаг байж. Зөвхөн эр хонийг хяргаад, эм хонио хяргадаггүй байж. Эр хонийг жилд хоёр хяргана. Хавар хяргаж авсан ноосыг “уртын ноос”, намар хяргаж авсан ноосыг “ахрын ноос” гэж нэрлэдэг юм. Хонины ноосоор голдуу эсгий л хийнэ дээ. Заримдаа үхрийн хялгастай холиод дээс томдог байж. Ямааны ноолуур, ямааны хялгасыг бол бага хэмжээгээр хэрэглэдэг байж. Харин тэмээний ноосыг сайн ашигладаг байж. Сарлагийн савгыг тэмээний зогдортой холиод дээс томдог байлаа. Ийм дээсээр ачааны татлага, гэрийн бүслүүр, оосор, бүчийг хийнэ. 30-аад оны сүүлчээр Монгол улсын засгийн газар ЗХУ-д ноос, ноолуур нийлүүлэх тухай гэрээ байгуулсан байх. Би МХЗЭ-ийн үүрийн гишүүдээ цуглуулаад, нэг хүн 3 шуудай ноос түүх даалгавар өгдөг байлаа. Бид нар энэ гурван шуудай ноос түүх даалгавараа биелүүлэхийн тулд айлын бууцан дээр очиж хаягдсан ноос түүдэг байв. Тэр үед айлын бууцан дээр их ноос хаягддаг байлаа.

Ялангуяа хаваржаан дээр маш их ноос хаягдсан байдаг юм. Хонины ноос чинь хавар биенээсээ хөндийрээд ирдэг шүү дээ. Энэ үед нь хяргаж авах ёстой юм. Хяргахгүй бол ноос өөрөө унаж, хаягддаг юм. Бид нар ингэж унаж хаягдсан ноосыг бүгдийг нь түүгээд сумын хоршоонд тушаадаг байлаа. Бид нар хонь хяргах ажилд маш бага оролцоод, харин хаягдал ноосыг бол их түүсэн дээ.

МХЗЭ-ийн үүрийн дарга байхдаа миний хийдэг өөр нэг ажил бол сурталчилгааны ажил байсан юм. Тэр үед манай шинэ Үндсэн хуулийг батлан гаргах бэлтгэлийг хийж байсан юм. Би айлуудаар явж, шинээр гарах гэж байгаа Үндсэн хуулийн төслийн тухай яриа хийдэг байлаа. Энэ бүх ажлуудыг сумын МАХН-ын үүрийн даргын шууд удирдлагын доор хийнэ шүү дээ. Би ийм ажил хийгээд явж байтал Завхан аймгийн Санхүүгийн хэлтсийн дарга Ш.Гончиг гэдэг хүн манай суманд томилолтоор ирсэн юм. Тэр хүнтэй хамт би хөдөөгийн айлуудаар явж, сурталчилгааныхаа ажлыг хийдэг боллоо. Нэг өдөр тэр хүн:

-Чи бичиг үсэг гайгүй сайн мэддэг хүүхэд байна! Яагаад Улаанбаатарт сургуульд яваагүй юм бэ? гэж надаас асууж байна.

-Бага сургуульд хамт сурч байсан хүүхдүүд бүгд сургуульд явсан, харин би ар гэрийн байдлаас болоод явалгүй үлдсэн тухайгаа түүнд хэллээ.

-Тэгвэл чи өөрөө Улаанбаатарт сургуульд явах хүсэлтэй байна уу? гэж тэр надаас асууж байна. Би:

-Сурах хүсэл бол ч байна л даа! Харин одоо явах хугацаа нь өнгөрсөн байх! гэж түүнд хэлсэн юм. Ш.Гончиг гуай дахин энэ талаар ярьсангүй, удалгүй яваад л өглөө. Харин удалгүй манай аймгийн Санхүүгийн хэлтсээс намайг Санхүүгийн техникумд явуулж суралцуулах тухай албан бичиг ирсэн байлаа. Би тэр бичгийг аавдаа үзүүллээ. Аав маань шууд л “Яв, Яв! Явж ном сур!” гэж байна. Ингэж би Ш.Гончиг гэдэг хүний тусламжтайгаар Улаанбаатарт Санхүүгийн техникумд сурах болсон юм.

3 Улаанбаатар хот орж ирсэн.

КЮ: Та Улаанбаатарт анх хэдэн онд орж ирсэн юм бэ?

Ц Л: 1939 оны намар орой болсон хойно юм даа. Би шуудангийн машинаар Улаанбаатар хот орж ирсэн юм. Манай аймагт шуудангийн машин ирдэггүй байлаа. Харин Завхан аймагт шуудангийн машин ирдэг байсан юм. Улаанбаатар орох зорилготой нилээд хэдэн хүн нутгаас хамт гарлаа. Бид Завхан аймагт хүрч иртэл шуудангийн машин ирдэггүй. Тэнд олон хоног хүлээсний эцэст нэг орос машин ирж, бид сууцгааж байлаа. Тэр машин замдаа маш олон удаа эвдэрч зогсоод, бид нар бүгдээрээ

хамжиж машинаа засаж явсаар, Улаанбаатар хотод орж ирж байлаа. Хөдөөний бид нар машин засаж чадах биш дээ. Жолоочдоо л туслана шүү дээ. Бид нар машиныхаа моторыг 3 дахин задалсан шиг санагдаж байна. Хамгийн сүүлд одоогийн Төв аймгийн Лүн сумын нутаг Цэгээн нуурын орчим эвдрээд зогслоо.

Манай жолооч : “Поршен хагарчээ!” гэж байна.

“Поршен” гэж юу байдаг юм бэ? Түүнийг засаж болдог юм уу? Болдоггүй юм уу? Бүү мэд! Ингээд яалт ч үгүй сууцгааж байлаа.

Манай жолооч: “Явган явахад Улаанбаатар их хол байна шүү!” гэж хэлж байсан юм. Тэгээд жолооч маань Хустайн нуруунд очиж хус модыг тайрч ирэх даалгаврыг бидэнд өглөө. Бидний тайрч ирсэн хус модоор тэр машиныхаа “поршен”-г тааруулж зорж хийгээд, машинаа асаалаа. Ингэж бид нар Улаанбаатар хотод орж ирж байлаа.

Тэндээс Уланбаатар хүртэл 130 орчим км юм гэдгийн би хожим мэдсэн юм. “Машины поршенг хус модоор зорж хийсэн!” гэдэг яриа одоогийн залуучуудад үнэмшил муутай сонсогдож байгаа байх л даа. Ер нь тэр үеэс одоо болтол монгол жолооч нарт нэг айхтар сүрхий бэрхшээл байлаа шүү дээ. Энэ бол машины сэлбэгийн асуудал юм. Монгол шиг өргөн уудам нутагтай, хүн цөөнтэй оронд машин шиг сайн тээврийн хэрэгсэл байдаггүй байх. Гэхдээ сайн зассан зам байхгүй манай нөхцөлд машины эвдрэл гарах нь гарцаагүй тохиолддог зүйлийн нэг юм. Өвлийн нэгдүгээр сард хасах 40 градусын хүйтэн шөнө холын тээврийн ачааны машин Алтайн нуруунд ч юм уу, эсвэл зуны нэмэх 50 градусын аагим халуун өдөр Галбын говьд явж байгаад эвдрээд зогсвол яах вэ? Засварын газар луу утасдах уу? Утас нь ч байхгүй, засварын газар нь ч байхгүй бол яах вэ? Ийм тохиолдолд жолооч хүн машинаа засахаас өөр арга байдаггүй юм. Тийм учир монгол жолооч нар бүгд машинаа засч сурсан байдаг юм. Уг нь сэлбэг гэдэг юм байдаг биз дээ. Тэр бол бас л Монголд байдаггүй юмны нэг юм. Монгол өөрөө машин үйлдвэрлэдэггүй орон шүү дээ. Тийм учраас эвдэрсэн хуучин эд, ангийг засахаас л өөр арга байхгүй шүү дээ. “Поршен” ч бай, өөр юу ч байсан хамаагүй, бүгдийг нь монгол жолооч нар өөрсдөө засдаг юм. Үүнийг ёстой Монголын гайхамшиг гэж хэлж болох байх шүү. Мод ч бай, төмөр ч бай орлуулж болох л бүх зүйлээр орлуулдаг байсан байх. Манайд “монголчлох” гэдэг нэг үг байдаг юм. Энэ бол аливаа техникийн эд, ангийг “монгол арга”-аар орлуулж засахыг хэлдэг юм.

Сүүлийн үед гадаадын төрөл бүрийн машин Улаанбаатарын гудамжаар багтахгүй шахам олон болсон байна. Машиныхаа бензины сав хаана байдгийг мэддэггүй жолооч олон болсон гэж дуулсан юм байна шүү. Цаг үе их өөрчлөгджээ. Тэр үед бид нар замдаа бараг л 20 хоног

явж, Улаанбаатарын барааг харж байлаа шүү дээ. Бидний сууж ирсэн машин бол орос машин байсан юм. ЗХУ-д үйлдвэрлэсэн “Пулу” гэдэг машин байсан байх. Ер нь 20-р зууны 20-оод оны эхэн үед Монголд Америк машинууд нилээд олширч байсан юм билээ. Манайхан тэднийг “шилэн Форд” гэдэг байсан юм. Хувьдаа “шилэн Форд”-той хүн мэр сэр байсан юм билээ. Тэгээд гол нь гадаадын компаниуд машин их хэрэглэж байсан байх. Энэ үед Монголд Америк, Герман, Оросын компаниуд нилээд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг болж байсан юм билээ. Японы компаниуд Монголд орж ирж байсан талаар би сонсоогүй юм байна. Харин тэд нар Монголын зах зээлд сонирхолтой байсан байж магадгүй. Ямар ч байсан Япон улсын засгийн газрын төлөөлөгч нэг хүн хувийн худалдаачны дүрээр Их хүрээнд ирж байсан тухай би сүүлд уншиж байсан юм байна.

Тэр үед Монголын зах зээлд Хятад улс ноёлох хандлагатай болж байсан гэдэг юм. 20-р зууны эхэнд дотоодын хямралдаа идэгдсэн Манж Чин улс мөхлөө шүү дээ. Үүний дараа Хятад улс төрөн гарлаа. Хятад улс бол Манж Чин улсын албан ёсны залгамжлагч биш гэж би боддог юм. Харин Манж Чин улс мөхсөн нь дэлхийн улс төрийн тавцан дээр байгаагүй нэгдмэл Хятад улс гарч ирэх нөхцлийг бүрдүүлж өгсөн байх. Ингэж Хятад хүн өөрийнхөө төр, засгийн эрхийг барих болсон байна. Үүнээс өмнө Монгол, Манж зэрэг тал нутгийн нүүдэлчид одоогийн Хятадын нутаг дээр өөрийн төр, улсыг олон зуун жилийн туршид ээлжлэн байгуулж ирсэн түүхтэй юм. Энэ түүх бол олон тасархай, нэгдмэл биш байсан Хятадыг нэгтгэж өгсөн зэрэг олон эерэг үр дагаварыг дагуулсан юм. Шинээр төрөн гарсан Хятад улс Монголын зах зээлийг эзэгнэн авахын тулд бусад гадаад орнуудтай тэр үед хүчтэй өрсөлдөх хэрэгтэй болсон байна. Монгол улстай шууд хил залгаа оршдог газар зүйн байршил нь түүнд нилээд давуу байдлыг олгож байсан байж магадгүй. 1924 онд хуралдсан МАХН-ын 3-р Их хурлаас хойш Монголын эдийн засгаас “Гадаадын капиталыг шахан зайлуулах бодлого”-ыг хэрэгжүүлж эхэлсэн юм. 1930 онд Монгол улсын засгийн газар “Гадаад худалдааны онц эрх”-ийг улсын мэдэлд авсан шүү дээ. Энэ үеэс эхлээд гадаадын компаниуд, түүний дотор Хятадын мөнгө хүүлэгч компаниуд Монголоос бүр мөсөн гарч явжээ.

Биднийг Улаанбаатар хотод анх орж байхад радио, чийдэн зэргийг нилээд хэрэглэдэг болсон байсан үе юм. Манай хөдөө, орон нутагт ийм зүйлүүд нэвтрээгүй байсан үе юм шүү дээ. Би энэ бүгдийг анх удаа Улаанбаатарт ирсний дараа үзсэн юм. Улаанбаатар надад маш том хот юм шиг санагддаг байлаа. Гэхдээ тэр үеийн Улаанбаатарыг одоогийн Улаанбаатартай харьцуулбал инээдэмтэй дүр зураг гарах байх л даа. Тэр

үед чинь 3 давхар байшин огт байгаагүй юм. Харин 2 давхар байшин 2-3 ширхэг байсан шиг санагдаж байна. Одоогийн Төрийн ордны орчимд гэр шиг дугуй хэлбэртэй, ногоон өнгийн дээвэртэй театр байлаа. Тэр театрын барилга нь Герман хүний зураг, төслөөр баригдсан гэж ярьдаг шиг санагдаж байна. Манайхан түүнийг “Бөмбөгөр ногоон” гэдэг байв. Одоогийн Дүрслэх урлагийн музей байгаа байшинд Улсын их дэлгүүр байсан юм. Хүмүүс түүнийг “Өндөр хоршоо” гэж нэрлэдэг байлаа. “Ленин клуб” одоогийнхоо байгаа тэр л газраа байсан юм. Одоогийн “Ард” кино театр байгаа орчим МАХН-ын Улаабаатар хотын хороо байсан юм.

Одоогийн Боловсролын Их Сургуулийн байшин тэр үед 2 давхар байлаа. Тэр үед ч улаан л өнгөтэй байсан. Түүний 2-р давхарт Монгол Улсын Засгийн газар байрлаж байсан юм. Тэнд бас Ерөнхий сайд, маршал Х.Чойбалсангийн ажлын өрөө байлаа. Тэр байшингийн доод давхрын цаад үзүүрт нь Багшийн техникум байрлаж байсан юм. МАХН-ын одоогийн төв байрны орчимд жижиг цагаан байшин байсан. Тэр бол МАХН-ын Төв Хорооны байр байв. Түүнээс зүүн тийш Шүүхийн товчоо, ЗХУ-ын Элчин сайдын яам байсан. Түүнээс зүүн тийш байдаг “Амэрсан дэнж” дээр Америкийн пүүс, компанийн төлөөлөгчийн газрууд байв. Германы пүүс компаниуд бол Шүүхийн товчоо орчимд байсан.

Тэр үед Гандандэгчинлин хийд дээр байдаг Жанрайсэг бурхан их содон харагддаг байлаа. Түүнийг манайхан “Өндөр Жанрайсэг” гэдэг шүү дээ. 19-р зууны эцсээр Богд Жавзандамба хутагтын хараа муудаж, юм муу хардаг болсон байна. Түүнд хараа оруулах зорилгоор Жанрайсэг бурханыг бүтээсэн гэж ярьдаг шүү дээ. Түүнийг бүтээж байсан талаар хожим би номноос олж уншсан зүйл одоо болтол санаанаас огт гардаггүй юм. “Өндөр Жанрайсэг” бурхныг бүтээж байх үед Орос улс өөрийн элчин сайдын яамны хэрэгцээнд нэг шинэ барилга барьж эхэлсэн юм байна л даа. Гэтэл барилга нь манай “Өндөр Жанрайсэг”-ээс өндөр болох гээд байсан бололтой. Манай Гандандэгчинлин хийдийн лам нар Оросын ЭСЯ-нд очиж: “Танайх энэ барилгаа намхан болго! Энэ чинь манай “Жанрайсэг бурхан”-аас өндөр байж болохгүй!” гэсэн агуулгатай шаардлага тавьж байсан юм билээ. Биднийг анх орж ирж байх үед Улаанбаатарын хүн ам зуун мянгад хүрч байсан юм уу, үгүй юм уу мэдэхгүй. Тэр л орчим байсан байх.

КЮ: Таныг ирж байх үед Улаанбатарт гадаадын хүн олон байсан уу?

Ц Л: Гадаадын хүн тийм олон байгаагүй. Гадаадын хүний ихэнх нь хятадууд байсан юм. 1921 оны Ардын хувьсгалаас өмнө Их хүрээний зүүн талд байдаг Амгалан гэдэг жижиг хот бол бүхэлдээ хятадын наймаачдын

суудаг хот байлаа шүү дээ. Одоо тэнд хятад хүмүүс амьдарч байсан ул мөр огт байдаггүй юм. Ардын төр, Ардын засгаас Монголын эдийн засгаас “Гадаадын капиталыг шахан гаргах бодлого”-ыг хэрэгжүүлж эхэлснээр Монголд амьдарч байсан хятад хүний тоо эрс цөөрсөн юм. Тэд нар хятадын мөнгө хүүлэгч компаниудын хамтаар Монголоос гарч явсан юм. Тэгээд цөөн тооны хятад хүн үлдсэн юм байж.

Ер нь хятад хүн хаана ч очсон нэг л мэдэхэд олон болчихдог шүү дээ!

1970-аад оны дундуур Монголд хууль бусаар амьдарч байгаа хятад хүмүүсийг нутагт буцаах ажлыг зохион байгуулсан юм. Монгол улсын иргэн болсон хятад хүмүүст Зүүн хараа орчим амьдарах тусгай газар хуваарьлаж өгөв. Ингээд хятад хүн их цөөрсөн юм шүү дээ. Бараг байхгүйтэй адил болсон юм. Гэтэл 1990 -ээд оноос хойш янз бүрийн шалтгаанаар Монголд хятад хүн олноороо ирэх болжээ. Ялангуяа манай засгийн газраас 2000 оноос хойш хэрэгжүүлж эхлээд байгаа “Мянганы зам” барих төслийн шугамаар олон хятад хүн ирэх болсон байна. Ингэж Монголд хууль бусаар амьдардаг хятад хүний тоо өсөх хандлагатай болоод байна. Монголд хууль бусаар амьдарч байгаа хятад хүмүүс манай хууль, дүрмийг сайн мөрдөхгүй байгаа нь нийгмийн сэтгэл зүйг түгшээх боллоо.

Намайг анх Улаанбаатарт орж ирж байх үед хятад хүн олноороо суудаг “Есөн гудамж” гэдэг нэртэй гудамж байсан юм. Тэнд үсчин, хоолны газар зэрэг хятадын хувийн үйлчилгээний газрууд маш олон байв. Тэнд бас жорлон ухдаг хятад хүн олноороо амьдарч байлаа. Тэд нар жорлон ухаад, бохир зүйлүүдийг нь морин тэргэнд ачиж аваачаад, ногооны талбайд бордоо болгон хэрэглэдэг байлаа. Улаанбаатарын орчим, тухайлбал Улиастай хавиар хятадын ногооны талбай байсан юм. Хятадуудын тарьсан ногоог хятад хүн өөрөө л иддэг байсан байх. Монгол хүн хятадаас ногоо авч иднэ гэдэг бол огт байгаагүй зүйл шүү дээ. Жорлонгоор бордож байгааг нь мэдэж байсан болоод ч тэр үү, хятад хүнээс ногоо огт авдаггүй байлаа.

Тэр үед Улаанбаатарт морин тэргээр хүн их зөөдөг байлаа. Налайхаас морин тэргээр хүн зөөгөөд орж ирдэг байлаа шүү дээ. Бас морин тэргэнд модон бочка ачаад, түүнийгээ усаар дүүргээд, айлуудаар тараадаг байлаа. Усыг айлууд мөнгөөр худалдаж авдаг байсан юм. Ийм ажлуудыг голдуу монгол хүн хийдэг байлаа. Бас хятадууд ч хийдэг л байлаа. Одоо Гэсэр сүм байгаа газар хятадын “Шаанзан” гэдэг ресторан байсан юм. Тэнд голдуу хятад хүмүүс хоол иддэг байсан байх. Элдэв төрлийн хоолны үнэрийн хажуугаар өмхий, эхүүн үнэр гардаг байсан нь хөдөөнөөс орж ирсэн надад маш содон үнэртдэг байж билээ.

Тэнд бас “сүүдэр ший”, жүжиг гарна. Тэр үед киног “сүүдэр ший”

гэж нэрлэдэг байсан бөгөөд монголчууд их үздэг байлаа. Тэр үед Улаанбаатарын баруун талаар Чингэлтэйн гол, зүүн талаар нь Сэлбийн гол урсдаг байв. Тэр хоёр нийлээд Дунд гол болоод Туул голд цутгадаг байлаа. Сэлбийн гол дээр байсан гүүрийг “Арслантай гүүр”, Чингэлтэйн гол дээр байсан гүүрийг “Төмөрчингийн гүүр” гэдэг байв.

Тэр Төмөрчингийн гүүр орчмоор мухлаг олон байсан юм. Тэр бүгд чинь Хятадын жижиг үйлдвэрийн мухлагууд байлаа шүү дээ. Төмөр, модоор хийсэн зүйлүүд, даавуугаар оёж хийсэн зүйлүүдийг зардаг байв. Монгол хүн хот газар сууж амьдрах хэзээний сонирхолгүй шүү дээ. Монгол хүн малаа дагаад л хөдөө амьдрахыг илүүд үздэг байлаа. Ийм учраас суурин газар амьдардаг монгол хүн тэр үед их цөөн байж. Хожим сургууль, соёлын газрууд буй болоод л аажмаар Улаанбаатар хотын хүн ам өссөн юм.

Тэр үеийн барааны зах одоогийн “Бөмбөгөр” зах байгаа газарт байсан юм. Амралтын өдрүүдэд тэр зах руу маш олон хүн цувдаг байлаа. Өвлийн улиралд хөдөөнөөс тэмээн жингээр цагаан идээ орж ирнэ дээ. Бас Улаанбаатарын хойд талын уулнаас тэмээгээр мод ачиж ирээд зардаг байлаа. Тэр үед бүхий л хэрэгцээний зүйлс зах дээр л байдаг байлаа шүү дээ. Энд адуу, хонь, үхэр зэрэг мал бас зардаг байлаа. Тэр үед мал болон бусад барааны үнэ их хямд байлаа. Хөдөө газар эм хонь 3-4 төгрөг, эр хонь 5 төгрөг байсан юм. Хотод бол 5-10 төгрөг байсан байх. Би бага сургуулиа төгсөөд сумынхаа МХЗЭ-ийн үүрийн даргын ажилтай байхдаа сард 30 төгрөгийн цалин авч байсан юм. Би анхныхаа цалингийн 5 төгрөгөөр нь нэг өмд, нэг цамц, боодлын цаасан дээрээ сарлагийн зурагтай, дотроо бурамтай, Орос улсад үйлдвэрлэсэн чихэр нэг кг-ийг, 1 хайрцаг сахар, нэг боодол дүнсэн тамхи авч байлаа. Ингээд энэ бүгдийгээ үлдсэн 25 төгрөгийн хамт аавдаа аваачиж өгч байлаа. Өмд, цамцаа бол өөртөө авсан юм. Их том ганган залуу болох гэж бодож явсан юм болов уу даа. Бусдыг нь бүгдийг нь аавдаа өгч байгаа юм. Хүү нь улсад ажил хийгээд, цалин авдаг болоод, аавыгаа бас баярлуулж байгаа юм байх л даа. Тэр үед чинь цалинтай ажил хийдэг хүн ховор байлаа шүү дээ. Тийм учраас бэлэн мөнгөгтэй хүн гэж бараг байхгүй дээ. Тэгээд би аавдаа: “Гурван төгрөгөөр нь хонь аваарай!” гэж бас хэлж байсан юм. Тэр үед манай нутаг мал ихтэй байлаа. Айл бүр л суурь, суурь хоньтой байлаа шүү дээ. Тийм учраас малын худалдааны зах, зээл байгаагүй юм. Бүгд олон малтай учир мал худалдаж авах хүн ховор байсан юм. Харин хот орчмынхон бол зах дээр зардаг байсан байх. Тэр үед Улаанбаатарын зах дээр малыг цаасан мөнгөөр л зарна шүү дээ. Хөдөө бол малыг малаар сольдог байв.

4 Би Намын шинэ хүчний сургуульд орлоо.

КЮ: Та анх кино хаана үзсэн бэ?

Ц Л: Манай баруун Алтайд Улаанбаатараас их хоцорч орчин үеийн соёл нэвтэрсэн гэж ярьсан шүү дээ. Бид нар хүүхдүүд зуны цагт гутал өмсөхгүй шүү дээ. Хонинд явахдаа ч өмсөхгүй. Намар анхны цас орсоноос хойш л гутал өмсөнө шүү дээ. Намар анхны цас орсны дараа би нэг өдөр хонио хариулаад явж байлаа. Гэтэл тэнгэр дуугарч байгаа юм шиг их чимээ гараад байна. Тэнгэрт үүл байсангүй. Бас тэнгэр дуугардаг цаг биш байсан болохоор би юу дуугараад байгааг ойлгосонгүй. Гайхаад л ийш, тийш харлаа, юу ч харагдсангүй. Тэгээд орой гэртээ иртэл хүмүүс манай гэрээс холгүй газраар “Машин явсан!” гэж ярьж байна. “Машин” гэж юу байдаг юм бэ? Бүү мэд! Тэгтэл хүмүүс холгүй газар Зээрэгтийн талд машин явсан мөр байгаа тухай ярьж байна. Би найзалдаг үеийн хүүхдүүдтэйгээ нөгөө машиний мөр байгаа газар гүйж очлоо. Гуталгүй, хөл нүцгэн шүү дээ. Гэтэл цасан дээр их гоё урт хээ гарсан байна. Тэр хээ их гоё юмаа. Тэгээд бид нар машинийг нь үзэх гээд тэр мөрийг дагаад гүйгээд байлаа. Тэр мөр зүүнээс баруун тийш явсан мөр байсан юм. Гэтэл нөгөө мөр дуусдаггүй. Машин ч харагддаггүй. Бид ч нөгөө замаа дагаад гүйгээд л байлаа. Тэгээд орой боллоо. Буцахаар шийдлээ. Гэтэл гэрээсээ төөрчихлөө. Харанхуй болчихлоо. Манай гэр хаана байгаа талаар баримжаагаа алджээ. Тэгээд бид нар гэрээ хайгаад гүйгээд байлаа. Тэгээд шөнө болж байхад эцэж, унахаа шахсан хүүхдүүд гэрээ арай гэж нэг юм олж ирж байлаа. Бидний хөл хөлдөхөө шахсан байж билээ. Ингээд тэр үед машин үзэж чадаагүй юм. Би 10 орчим л настай байсан байх.

Тэгтэл Хятадын талаас манай хилийг нэвтэрч ирээд, нэг сумын нутаг дээр баахан дээрэм тонуул хийдэг бүлэг дээрэмчин бий болжээ. Дээрэмчид нутгийн ардуудын мал, эд хөрөнгийг дээрэмдээд, эсэргүүцсэн хүнийг алж, хядаад их түйвээдэг болсон юм. Тэднийг Монгол нутгаас хөөж гаргах гэж Улаанбаатараас Ардын журамт цэрэг ирлээ. Тэд нар дээрэмчдийг удалгүй Монгол нутгаас хөөж гаргаад, буцахдаа манайх нутагладаг Ботгон уул гэдэг газар ирж буусан юм. Цэргүүд машинаар ирсэн юм. Тэр үед бид нар нөгөө үзэж чадаагүй машинаа үзсэн юм. Дугуй нь гоё хээтэй болохыг өөрсдийн нүдээр харлаа. Бидний хүүхдүүд тэр машиныг амьд амьтан шиг л боддог байлаа шүү дээ. Жолооч урд талын моторын тагийг нь сөхөж байгаад л юм хийнэ. Түүнийг нь бид нар “Машины амыг нь онгойлголоо!” гэж бодно. “Ямар том амтай юм бэ?” гээд л хоорондоо ярина. Хойд талаар нь тойрч, доогуур нь шагайж хараад “Бөөсөг нь эндээ байдаг байх!” гэж ярьдаг байлаа.

Би анх киног 17-18 настай байхдаа үзсэн юм. Тэр үед манай нутагт Улаанбаатараас “Суртлын бригад” ирдэг байлаа. Тэр суртлын бригадынхан кино үзүүлдэг байсан юм. Киног “Сүүдэр ший” гэдэг байсан юм. Бид нар анх удаа кино үзээд “Дэлгэцний цаана хүн байна!” гэж бодож байлаа. Тэгээд араар нь тойрч ч харж байсан юм. Тэнд хүн байхгүй болохоор их гайхаж байсан юм. Би анх киног сумын төв дээр “Улаан гэр”-т үзсэн санагдаж байна. “Улаан гэр” гэж соёлын арга хэмжээ явуулдаг гэрийг хэлдэг юм. Одоо “Соёлын төв” гэж нэрлэдэг болсон. Сум болгонд байдаг юм. Тэр үед манай нутагт очдог байсан кино бол дуугүй, зөвхөн дүрсийг нь л үзүүлдэг байлаа.

Би ногоотой хоолыг анх удаа Улаанбаатарт орж ирээд л идсэн юм шүү дээ. Төмснөөс газар амтагдаад, анх идэхэд их эвгүй зүйл байсан юм. Манай нутагт таримал ногоо иддэггүй байлаа. Зэрлэг сонгино бол иднэ. Манай нутагт улаан арвай их тарьдаг байлаа. Түгээрээ гурил хийнэ. Арвайн гурил гэж их сайхан амттай зүйл байсан юм. Бас шар будаа тарина. Манайх өөрөө тариа тарьдаггүй байв. Харин арвайн гурил, шар будаа зэргийг тариа тарьдаг айлаас малаар сольж авдаг байлаа. Ер нь айл бүр арвайн гурил хэрэглэдэг байсан юм. Бүгд л малаар сольж авна даа. Арвайн гурилыг Монгол хүн өөрөө л тарина шүү дээ. Манай нутагт Хятад хүн бараг байгаагүй юм.

Улаанбаатарт орж ирээд анх удаа тахианы өндөг идээд бөөлжиж байлаа. Бид нар Улаанбаатар орох замдаа машин эвдрээд олон хоног яваад их ядарсан, өлссөн хүмүүс хотод орж ирсэн юм. Бидний суусан машин биднийг Тээврийн товчоон дээр буулгасан юм. Тэр үед Тээврийн товчоо одоогийн “Бөмбөгөр зах” байгаа орчим байлаа. Би чинь Улаанбаатарт нэг ч хүн танихгүй л анх ирж байлаа шүү дээ. Нутгаас өмсөж гарсан гутал маань ханзарч урагдаад, нүцгэн хөл цухуйчихсан, мөнгө байхгүй, идэх юм байхгүй, их ядарч, өлссөн, хаашаа явахаа мэдэхгүй хүн л машинаас бууж байлаа шүү дээ. Биднийг хотод орж ирэхэд үд өнгөрч л байсан байх. Тэгээд машинаасаа бугаад л тааралдсан хүн бүрээс “Ахаа, эгчээ, Санхүүгийн техникум хаана байна?” гээд л асуугаад яваад байлаа. Тэр үеийн хотын хүмүүс их сайхан зантай байсан юм. Одоогийнх шиг биш. Зарим хүн зогсоод л надад зам зааж өгнө дөө. Тэгээд тэдний заасан замаар явсаар байгаад одоогийн Багшийн их сургуулийн байр өнгөрөөд, Арслантай гүүрний орчим хүрч ирлээ. Арслантай гүүрний урд талд Хятадын олон мухлаг, гуанзууд ажилладаг байсан юм. Тэнд хүрч иртэл хоолны үнэр гараад л сонин байлаа. Тэгтэл тэр гуанзнуудын урд талд хэсэг залуу юм яриад зогсож байна. Би тэдэн дээр очоод :

-Санхүүгийн техникум хаана байна? гэж асуулаа. Тэгтэл тэдний нэг нь:

-Чи хөдөөнөөс ирсэн үү? Санхүүгийн техникумд суралцах гэж байгаа юм

уу? Чи анх удаа хотод орж байгаа юм уу? гэж олон юм асууж байна.

Би:

-Тийм. Говь-Алтайгаас ирлээ гэвэл,

-Би бас Санхүүгийн техникумд сурдаг юм. Чи намайг дагаад яв! гэж байна. Тэгээд түүнийг дагаад хэсэг явлаа. Би хоол унд идэж уугаагүй л шинжтэй харагдсан юм байлгүй дээ. Тэр залуу хэсэг явснаа:

-Одоо би чамайг хоолонд оруулна! гэж байна.

Тэгээд бид хоёр нэг хоолны газар ороод суулаа. Тэгээд тэр залуу үйлчлэгчид юм захиад л яриад байна. Юу захиж байгааг нь би анзаарсангүй. Тэгтэл удалгүй үйлчлэгч хоёр том шилэн аягатай “шар юм” авч ирээд бидний өмнө тавилаа. Нөгөө залуу түүнийг аваад л их амтархан ууж байна. Би урд нь үзэж хараагүй, ууж бас үзээгүй тэр шар юмнаас уух санаатай нэг балгаж үзлээ. Тэгтэл муухай, гашуун амттай юм байна. Уух арга алгаа. Муухай амттай байгаа гэж ярих юм алга. “Энэ лав морины шээс л байх!” гэж дотроо бодож суулаа. Тэр бол миний ууж үзсэн анхны пиво байсан юм.

Нөгөө залуу намайг ажигласан байх:

-Ууж чадахгүй байна уу? Цай уух уу? гэж байна. Тэгээд үйлчлэгч хар цай авч ирж өглөө. Тэгээд цай ууж суутал үйлчлэгч тавагтай хоол авч ирээд өгч байна. Хоолыг нь харвал цагаан будаа байна. Цагаан будаа манай нутагт маш ховор байсан юм. Би нутагтаа байхдаа нэг юм уу, хоёр удаа л цагаан будаа идэж үзсэн юм. Ер нь хөдөөний хүмүүс цагаан будаанд тийм ч их дуртай биш байдаг юм. Ялангуяа настай хүмүүс түүнийг бараг иддэггүй юм. “Цагаан будаа их сэрүүн хоол. Түүнийг идвэл шээс их хүрдэг!” гэж ярьдаг байлаа. Надад авч ирж өгсөн хоолны цагаан будаанд дээр нь нэг цагаан юм, бас түүний дээр нялцгай шар юм байна. Тийм юм огт үзээгүй болохоор “Юу юм бол?” гэж дотроо гайхлаа. Нөгөө залуу тэр хоолыг аваад л идэж байна. Би будаанаас нь жаахан идээд, нөгөө шар юмнаас нь жаахан аваад идвэл их муухай цэлцийж, нялайсан амтгүй юм байна. Тэгтэл нөгөө шар юмыг амссанаас болоод бөөлжис хүрээд болдоггүй. Тэгээд хоолоо идэж чадалгүй тэндээс гарлаа. Гадаа гараад хүнгүй газар, буруу харж байгаад, жаахан огилоо. Хоол идээгүй явсан болохоор юу ч гарсангүй. Ингэж би анх удаа тахианы өндөг идэж үзсэн юм. Тэр үеийн Улаанбаатарчууд ч ногоог бага зэрэг хэрэглэдэг байсан юм. Талхыг бол арай илүү хэрэглэдэг байсан. “Талхны завод” гэдэг жижиг завод ажиллаж байв.

И Л: Тэр үед Санхүүгийн техникумд хэдэн хүн сурч байсан юм бэ?

Ц Л: Тэр үед манай сургуульд надтай хамт 40-өөд хүн сурч байлаа. Би

саяхан сураглаад үзсэн чинь тэр үед хамт сурч байсан хүмүүсээс 6 хүн одоо байгаа юм билээ. Бусад нөхдүүд маань бүгд байхгүй болсон байна. Хамгийн сүүлд Д.Цэрэндорж гэдэг хүн энэ өвөл нас барлаа. Манай сургуулийг төгсөгчдөөс олон хүн цэргийн газрууд, улсын үйлдвэрийн газрууд, төрийн яам, тамгын газруудад нягтлан бодогчийн ажилд хуваарилагдаад явсан юм. Гадаад Явдлын Яамны сайд Намсрай гэдэг хүний хүү Сэр-Оджав бид нар хамт сурч байлаа. Н.Сэр-Оджав Зөвлөлт Хобоот Улс (ЗХУ)-д түүхийн шинжлэх ухааны эрдмийн зэрэг /Ph.D/ хамгаалаад, Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Түүхийн хүрээлэнд олон жил ажилласан юм. Түүний бичсэн “Эртний түрэгүүд” гэдэг нэгэн сэдэвт бүтээлийг би уншиж байсан юм. Манай төгсөлтийн урд жил Д.Долгормаа гэдэг эмэгтэй төгссөн юм. Тэр эмэгтэй олон жил Монгол улсын Сангийн яамны сайдын албыг хашиж байлаа. Д.Долгормаа манай сургуулийг төгсөөд Монгол Улсын Их сургуульд багшийн ажил хийж байгаад, дараа нь ЗХУ-д явж Санхүү, эдийн засгийн чиглэлээр дээд сургууль төгссөн юм. Бас тэндээ эдийн засгийн ухаанаар эдрмийн зэрэг /Sc.D/ хамгаалсан юм. Д.Долгормаа бас олон жил социалист орнуудын Эдийн Засгийн Харилцан Туслалцах Зөвлөл (ЭЗХТЗ)-д Монгол улсыг төлөөлж Москвад суусан юм. Би Санхүүгийн техникумыг 1942 онд төгссөн.

КЮ: Та сургуулиа төгсөөд хаана хуваарилагдсан бэ?

Ц Л: Надтай нэг ийм учрал тохиолдсон юм. Би сургуулиа онцсайн дүнтэй төгсөх гэж байлаа. Би сүүлчийнхээ улсын шалгалтыг өгөөд сууж байв. Би шалгалтынхаа асуултанд хариулахад бэлтгээд ангидаа сууж байтал, манай сургуулийн нэг багш орж ирээд, шалгалт авч байгаа багшид:

-Ц.Лоохуузыг захирал багш өрөөндөө дуудаж байна! гэж хэллээ.

Багш:

-Шалгатынхаа асуултанд хариулаагүй байна шүү дээ! гэж түүнд хэлэв.

-Зүгээр, Зүгээр! Одоохон оруулчих! гэж байна.

Тэгээд би багшийн зөвшөөрснөөр сургуулийн захиралын өрөөнд явж очлоо. Тэнд сургуулийн захирал, хичээлийн эрхлэгч хоёр сууж байна. Өөр бас гадны хоёр хүн сууж байна. Би нилээд гайхлаа. Захирал багш тэднийг “МАХН-ын Төв Хорооноос ирсэн хүмүүс!” гэж танилцуулж байна.

Тэдний нэг нь:

-Чамд МАХН-ын сайн ажилтан болох сонирхол байна уу? гэж надаас асууж байна. Би энэ асуултын учрыг нь сайн ойлгоогүй боловч:

-Сонирхол бол байна! гэж хэллээ. Тэгтэл тэр хүн хананд өлгөөтэй байсан газрын зураг дээр очоод :

-Чи дэлхийн тивүүдийг нэрлээд энэ зураг дээр заана уу? гэж байна. Би өөрийн мэдэх тивүүдийг заагаад, нэрийг нь хэллээ.

Тэгтэл нөгөө хүн хэдэн улсын нэр хэллээ:

-Миний сая нэрлэсэн улсуудыг газрын зураг дээр заана уу? гэж байна. Би бага сургуульд байхдаа тэр хүний нэрлэсэн улсуудыг хаана байдгийг нь сайн мэдэх болсон учир заачихлаа. Гэтэл тэр:

-Сая чиний заасан улсууд ямар улсууд вэ? гэж нэмж асууж байна.

Би хөрөнгөтнөөс өөр улс байх ёсгүй гэдгийг сайн мэдэж байсан учир:

-Энэ бүгд хөрөнгөтөн улсууд шүү! гэж хэллээ. Үүний дараа дахин юм асуусангүй. Тэгтэл тэдний нөгөө нэг нь:

-За. Чамайг цаашид “Намын шинэ хүчний сургууль”-д суралцуулна. Чи зөвшөөрөх үү? гэж асууж байна. Би жаахан гайхаж байгаад :

-Зөвшөөрнө! гэж л хэллээ.

Ингэж би Санхүүгийн техникум аас шууд Намын шинэ хүчний сургуульд шилжсэн юм.

Энэ яриа болсноос хойш удалгүй би Санхүүгийн техникумаас хэрэглэж байсан ном болон бусад эд хэрэглэлийг бүгдийг нь буцааж өглөө. Тэгээд Намын шинэ хүчний сургуульд явах бэлтгэлээ хийж эхэллээ. Тэгээд нэг өдөр автобусанд суугаад шинэ сургууль дээрээ очлоо. Тэнд намайг бүртгэж авлаа.

Дараа нь байранд орууллаа. Байр нь тохилог, сайхан юм. Өрөөндөө хивс дэвсээд, нөгөө алдартай “цагаан ор”-ыг тавиад, одооноос бүтээсэн байна. Харин нэг өрөөнд 4 хүн амьдрахаар боллоо. Би өөрийн амьдрах өрөөгөө аваад, өөрийн ном, дэвтэр зэрэг жаахан эд хөрөнгөө оруулж тавьлаа. Байранд орсны дараа бидэнд бас шинэ хувцас тавьж өгч байна. Шинэ костюм, пиджак, хар ботинк, галстук зэргийг тавьж өглөө. Хуучин хувцас бүгд хэрэггүй боллоо. Бидэнд тавьж өгсөн хувцас бол Германаас импортоор орж ирж байсан хувцас байсан юм. Би энэ бүгдийг хийж дуусаад байрныхаа гуанзанд орж хоол идлээ. Тэнд /үнэгүй/ 1,2-р хоол өгч байна. Санхүүгийн сургуультай харьцуулахад маш сайн хангамжтай сургуульд орсон байж л дээ. Тэгээд сар бүр цалин авдаг боллоо. Ингэж миний амьдралын нэгэн шинэ үе эхэлж байлаа.

Тэр жил манай сургуулиас надтай хамт хоёр хүн энэ сургуульд шилжиж ирсэн юм. Тэд нарыг Г.Жамсранжав, Д.Бадамжав гэдэг байсан юм. Г.Жамсранжав бол сүүлдээ утга зохиолын нэртэй шүүмжлэгч болсон хүн. Н.Бадамжав нь нэг аймгийн даргын албыг хашиж байгаад Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Төв Зөвлөлийн даргаар сонгогдсон юм. Тэр сүүлдээ “намаас арга хэмжээ авхуулсан” юм. “Намаас арга хэмжээ авхуулсан” гэдэг нэг хэллэг манайд байдаг юм. МАХН-ын гишүүн хүн улсын ажил харицууцаж байгаад ажлын хариуцлага алдах, сахилага

батгүй явдал гаргах, ажлаа сайн хийхгүй доголдол гаргавал МАХН-аас “арга хэмжээ авч” шийтгэдэг байсан юм. Харин зарим үед МАХН-тай үзэл, бодол таарахгүй байгаа хүнийг албан тушаал бууруулах, ажлаас халах, өөр ажилд томилох зэргээр шийтгэдэг байлаа. Шийтгэл нь адилхан байсан болохоор үүнийг бас “намаас арга хэмжээ авхуулах” гэж ижлээр нэрлэдэг байсан юм. Уг нь хоёр өөр шалтгаантай юм шүү дээ. Ийм хоёр өөр шалтгаантай юмыг ижлээр нэрлэх бас нэг шалтгаан байсан юм. Тэр үед “МАХН бол маш эв нэгдэлтэй нам. МАХН-ын гишүүд бол бүгд нэг үзэл бодолтой, Монгол оронд социализмыг байгуулах талаар намынхаа явуулж байгаа бодлогыг бүгд хүлээн зөвшөөрдөг, намын удирдлага нь ч нэгдмэл нэг зорилгод захирагдсан нам. Намын эгнээнд өөр үзэл бодолтой хүн байхгүй!” гэж сурталчилдаг байсан юм. МАХН-ын эгнээнд түүний удирдлагатай санаа нийлдэггүй, түүний явуулж байгаа бодлогыг хүлээн зөвшөөрдөггүй хүн байх ёсгүй юм. Үнэн хэрэг дээрээ амьдрал өөрөө их баян болохоор ийм хүн байж л таарна шүү дээ. Ийм хүнийг тас нуугаад, ил гаргадаггүй байлаа. Хоёр өөр юмыг нэг ижлээр “амаас арга хэмжээ авхуулсан” гэж нэрлэдэг байсан нь ийм учиртай юм.

КЮ: Тэр үед Намын шинэ хүчний сургуульд багшилж байсан багш нарынхаа тухай жаахан ярьж өгнө үү?

Ц Л: Тэгье. Энэ Намын шинэ хүчний сургуулийг байгуулж, ажиллуулахад МАХН-ын Төв Хороо, манай Засгийн газраас анхнаас нь их анхаарч, тэнд ажиллах багшийг сонгож авахад их ач холбогдол өгч байсан юм. 1921 оны Ардын хувьсгал ялснаас хойш манай ухаантай, чадалтай, тэргүүний шилдэг олон сайхан хүмүүс “ангийн дайсан”, “ардын дайсан”, “хувьсгалын эсэргүү” гэсэн элдэв янзын нэр, хаягтай болоод, улс төрийн хилс хэрэгт гүтгэгдээд, цаазаар авхуулсан шүү дээ. Амьд үлдсэн нэг хэсэг нь дахин МАХН болон Ардын төр, Ардын засгийн ажлыг хийхээс татгалздаг болчихсон юм. Мэргэжилтэй боловсон хүчний дутагдалд орчихсон ийм хүнд үед Намын шинэ хүчний сургуулийг байгуулсан юм. Уг нь манай улс 1921 оны Ардын хувьсгалын дараа үндэсний боловсон хүчин бэлтгэх асуудалд ихээхэн анхаарсан юм шүү дээ. Ардын засгийн анхны Боловсролын сайдаар Э.Батхаан гэдэг хүн ажиллаж байв. Энэ хүн Монголын шинэ үеийн боловсролын ситемийн үндсийг тавихад үнэлж баршгүй хувь нэмэр оруулсан хүн. Тэр бол Байгал нуурын хөвөөнд төрж өссөн, эгэлгүй сайхан монгол хүн байж. Түүний санаачлагаар Герман, Франц, Орос зэрэг улсуудад залуучуудыг явуулж сургадаг болсон юм. Манай их зохиолч Д.Нацагдорж Германд, дараа нь Орос улсад сурч байсан хүн. Гэтэл түүн шиг гадаадад сурч, боловсроод ирсэн ухаантай,

чадалтай, боловсролтой хүмүүсийн ихэнх нь улс төрийн хилс хэрэгт их, багаар холбогдоод, шорон гянданд хоригдоод, цаазлагдах нь цаазлагдаад дууссан байгаа юм. Сайд Эрдэнийн Батхаан өөрөө хүртэл улс төрийн хилс хэрэгт гүтгэгдэж, цаазлуулсан юм шүү дээ. Ийм учраас Намын шинэ хүчний сургуульд их ач холбогдол өгч байсан юм. Энэ сургууль бол цоо шинэ үзэл бодолтой, шинэ цагийн боловсон хүчнийг бэлтгэж гаргах зорилготой байсан юм. Гол нь энэ сургуулиар “үндэсний үзэл”-гүй, бас шашин шүтдэггүй боловсон хүчнийг бэлтгэх зорилго тавьсан юм билээ. Тэгээд марксизм-ленинизмын сургаалийг судалсан, түүнд үнэнч, социализмыг байгуулах зориг, эрмэлзэл төгс хүмүүс байх нь мэдээжийн хэрэг шүү дээ. Бараг энэ үеэс эхлээд манай улс төрийн амьдралд “үндэсний үзэлтэн” гэдэг нэр томъёог их хэрэглэх болсон юм. Энэ чинь МАХН-тай үзэл бодлоороо таардаггүй хүмүүсийг нэрлэдэг шинэ нэр, хаяг юм.

Ямар хүмүүс ийм нэр, хаягтай болж байсан бэ? Ер нь товчоор хэлбэл Монгол Улсынхаа эрх ашгийг нэгдүгээрт тавьсан хүмүүс л “үндэсний үзэлтэн” гэж нэрлэгдэх болсон юм. 40-өөд оноос хойш “үндэсний үзэлтэн” гэдэг нэр зүүгээгүй сэхээтэн ховорхон шүү. Манай урдаа барьдаг улс төр, нийгмийн зүтгэлтнүүд, эрдэмтэн, сэхээтнүүд “үндэсний үзэлтэн” болж, “намаас арга хэмжээ авхуулж” мөрдөгдөж, хавчигдаж, тун хэцүү нөхцөл байдалд амьдарч, ажиллаж байсан юм.

Манай сургуулийн ерөнхий захирал нь Ч.Сүрэнжав гуай байлаа. Ч.Сүрэнжав гуай бол Монгол улсын Ерөхий сайдын орлогч байлаа шүү дээ. Тэрээр Ерөнхий сайд, маршал Х.Чойбалсантай их ойр, дотно харилцаатай, түүний итгэлийг хүлээсэн хүн байв. Бас МАХН-ын Төв Хороо (ТХ)-ны Улс Төрийн Товчоо (УТТ)-ны гишүүн, нарийн бичгийн даргын албыг хашдаг байлаа. Сургуулийн дэд захирал нь Н.Давжаев гэдэг буриад хүн байв. Тэр бол Байгаль нуур орчмын Буриад нутагт төрж, өссөн, өндөр болосролтой, зохион байгуулах авьяастай хүн байсан юм. Н.Давжаев захирал сургуулиа чанга сахилга баттай, маш хатуу гараар барьж байсан юм. Манай сургуульд суралцагсдыг хичээл, ном үзэхийн хажуугаар заавал нэг ажил олж хийлгэдэг байлаа. Зуны амралтын улиралд хөдөө явуулж, ногоо тарих, хадлан хадахад туслах ажил хийлгэнэ. Бас “суртлын ажил”-аар явуулна. Өвлийн улиралд Богд ууланд гаргаж мод, гишүү түүлгэж, түлш бэлдүүлнэ. Бид нар хоёр жил иймэрхүү байдлаар огт завгүй явсаар төссөн юм.

Бидэнд Нянтайсүрэнгийн Лхамсүрэн лекц уншдаг байлаа. Н.Лхамсүрэн бол их авьяастай, гайхамшигтай мэдлэгтэй хүн байсан юм. Н.Лхамсүрэн МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүн, нарийн бичгийн даргын албыг хашиж байсан хүн шүү дээ. Монгол улсын Гадаад хэргийн яамны сайдын албыг нэгэн үе хашиж байсан хүн.

Бидэнд лекц уншдаг байсан багш нарын дотроос хамгийн өргөн мэдлэгтэй нь Н.Лхамсүрэн байлаа. Тэр лекц уншихдаа зөвхөн лекцийнхээ сэдвээр хязгаарлагдахгүй. Маш өргөн утгаар нь тайлбарлан ярьдаг байсан юм. Түүний лекцэнд суухад надад их өндөр сэтгэгдэл төрдөг байлаа. Ялангуяа Чингис хааны байгуулсан Их Монгол улсын түүхийн асуудлыг маш сайн мэддэг, тэр үеийн үйл явдлуудыг сайхан тайлбарладаг байж билээ.

Манай сургуульд “Нийгмийн хөгжлийн онол”, “Философийн сэтгэлгээний түүх” гэсэн нэртэй лекцийг Дарамын Төмөр-Очир заадаг байлаа.

Хожим Д.Төмөр-Очир МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүн, нарийн бичгийн даргаар ажиллаж байсан юм. Д.Төмөр-Очир бидэнд марксизмын 3 үндэс болсон “Марксист философи”, “Түүхийн материализм”, “Диалектик материализм”-ын лекцүүдийг бас уншдаг байлаа.

Бидэнд Санпилын Жалан-Аажав бас лекц уншдаг байсан юм. Энэ хүн манай Намын шинэ хүчний сургуулийн анхны төгсөлтийн хүн. Тэр өөрийн сургуульдаа багш болсон юм. Энэ хүн МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүн, намын ажил хариуцсан нарийн бичгийн дарга, Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн орлогч дарга зэрэг өндөр албан тушаалыг олон жил хашиж байсан хүн. 1970-аад оны дундуур Ю.Цэдэнбал түүнийг Сайд нарын Зөвлөлийн даргаар томилохоор бэлтгэж байсан боловч өөрөө зөвшөөрөөгүй юм билээ. 1983 онд Ю.Цэдэнбал түүнийг ажлаас нь халж, нийгмийн хог дээр хаясан юм. Гэтэл удалгүй МАХН-ын ТХ-ны Хянан Шалгах Хорооноос түүнийг “Ц.Лоохууз, Б.Нямбуу, Б.Сурмаажав нарын намын эсрэг бүлэглэсэн явуулгын нэг удирдагч байсан” гэж гүтгээд, МАХН-ын гишүүнээс нь хөөгөөд, нутаг зааж явуулсан юм. С.Жалан-Аажав бидэндтэй огт холбоотой байгаагүй. Тэр үед С.Жалан-Аажав Ю.Цэдэнбалын өөрийнх нь даалгавараар бидэндтэй уулзаж байсныг нь бид мэдэж байсан юм.

Бидэнд Дэмчигийн Моломжамц бас лекц уншдаг байлаа. Энэ хүн он удаан жил МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүн, эдийн засгийн асуудал хариуцсан нарийн бичгийн даргаар ажилласан юм. Нэг үе Сангийн яамны сайдын албыг хашиж байсан хүн. Д.Моломжамц бол Ю.Цэдэнбалыг засгийн эрх барьж байх хугацаанд “намаас арга хэмжээ авхуулаагүй” үлдсэн цөөхөн хэдэн хүний нэг юм. Гэхдээ бүр сүүлд, ардчилал, шинэчлэлийн уур амьсгал дор 1990 оны 3-р сард хуралдсан МАХН-ын Онц их хурал түүнийг “Ю.Цэдэнбалын тойрон хүрээлэгч” гэж тодорхойлоод, МАХН-ын гишүүнээс хөөж, прокурорт шилжүүлсэн юм. Энэ их хурал Д.Моломжамцаас гадна Ю.Цэдэнбалтай хамт он удаан жил МАХН-ын болон төр, засгийн өндөр алба хашиж явсан 40 орчим хүнийг

“Ю.Цэдэнбалын тойрон хүрээлэгч” гэж тодорхойлсон юм. Тэгээд тэдний Ю.Цэдэнбалтай хамтдаа хийж байсан бүх буруу хэргүүдийг нь шалгаж, шударга шийтгэл оногдуулах зорилгоор прокурорт шилжүүлсэн юм. Тэдэнд “шударга хуулиар шийтгэл оногдуулах бүрэн үндэслэл бий!” гэж олон нийт үзэж байсан юм.

Түүхийн лекцийг эрдэмтэн Ш.Нацагдорж уншдаг байлаа.

Манай О.Будаев багш бас сайхан лекц уншдаг багш байлаа. Олон улсын харилцааны тухай маш сонирхотой яриа ярьдаг багш байлаа. Хичээлийн явц дундуур авдаг шалгалтанд О.Будаев багш бидэнд бараг бүгдэд нь л “онц” тавьчихна даа. Харин улсын шалгалтын үед О.Будаев багшийн хичээлд бид нар “онц” дүн бараг авч чаддаггүй байсан юм. Бидэнд хамгийн хатуу дүнг С.Цэдэнжав багш тавьдаг байлаа. Тэр тооны багш л даа. Хичээлийн явцын шалгалтанд С.Цэдэнжав багшийн хичээлд бид нар бүгд л “плохо” гэсэн дүн авдаг байлаа. Тэгээд түүнийг “плохо Цэдэнжав” гэж хочилдог байлаа. Бид нар улсын шалгалтанд бэлтгэхдээ зөвхөн “плохо Цэдэнжав” багшийн хичээлд л бэлтгэнэ. Бусдад нь бол тийм их бэлтгэдэггүй байлаа. Улсын шалгалтыг хичээл заасан багш өөрөө авахгүй шүү дээ. Өөр багш авна. Ингээд сайн бэлтгэсэн болохоор С.Цэдэнжав багшийн хичээлийн шалгалтанд бүгд л “онц”, “сайн” гэсэн дүн авдаг байлаа.

КЮ: Танай Намын шинэ хүчний сургуульд сурлагаараа бусдаасаа эрс шалгарсан суралцагсад байсан уу?

Ц Л: Бидний дунд тийм залуучууд олон байсан юм шүү. Манай сургуульд Улаанбаатар хотод техникум төгссөн хүн нилээд байсан юм. Бас шууд орсон хүн ч нилээд байлаа. Тэдний дундаас Д.Хурметбек, С.Телехан гэдэг хоёр залууг онцгойлон нэрэлмээр байна. Тэд нар угсаа гаралын хувьд хасаг үндэстэн юм. Тэр хоёр дандаа “онц” сурдаг байлаа. Тэд нар гайхамшигтай авъяастай хүмүүс байв. Багш лекц уншиж байхад бусадтай л адил чагнаад сууж байна. Тэгээд л багшийн хэлснийг үг, үсгээр нь тэр чигээр нь тогтоогоод авчихдаг байсан юм. Дахиад энэ сэдвээр ном уншина гэж бараг байхгүй. Улсын шалгалт болоход өнөө тогтоож авснаа тэр чигээр нь эргүүлээд л ярьчихна. С.Телехан бол сүүлд манай Барилгын яамны сайдын албыг он удаан жил хашиж байсан хүн шүү дээ. 1960-аад оны үеэс эхлээд Улаанбаатар хотын барилгажилт эрс нэмэгдсэн шүү дээ. Олон шинэ барилгууд баригдаж, хотын өнгө төрх их өөр болсон юм. Д.Хурметбек нь хасаг үндэстэн олноороо амьдардаг Баян-Өлгий аймгийн даргын албыг олон жил хашиж байв. Бас өөрийн төрөлх сургуулийнхаа захирлын албыг нилээд хэдэн жил хашсан юм. 1958 онд манай Намын

шинэ хүчний сургуулийг Намын дээд сургууль болгож өргөтгөлөө. 1944 оны 6-р сард би сургуулиа төгслөө. Манай сургуулийнхан сургуулиа төгсөөд бараг бүгд хөдөө хуваарьлагдлаа. Төгсөгчдийн ихэнх нь 25-27 орчим л настай байсан байх. Тэд нар аймгийн дарга, эсвэл аймгийн захиргааны орлогч даргаар шууд томилогдоод явж байлаа.

5 МАХН-ын Төв Хороонд.

Ц Л: Намайг Улаанбаатар хотын МАХН-ын хорооны суртлын хэлтсийн даргаар томилсон юм. Надад энэ хуваарийг манай захирал Н. Давжаев багш өгсөн юм. Энд бас нэг ийм учирал таарсан юм аа. Бид нар сургууль төгсөх бүх шалгалтаа өгч дууслаа. Сургууль төгссөн диплоомоо авцгаалаа. Тэгээд өчиж ажиллах газарынхаа хуваарийг хүлээж байв. Манайхан хотод байдаг таньдаг айлдаа очих, дэлгүүр хоршооноос юм авах гэж явцгаагаад хэд хоног манай байр хүнгүй шахам болоод, нэг тийм уйтгартай байдаг болов. Надад хотод таньдаг айл ч байхгүй, авах юм ч санаанд орохгүй байсан болохоор байрандаа ганцаараа л сууж байдаг байв. Хуваарь уншихын яг урд өдөр би ерөөндөө иймэрхүү байдалтай, ганцаараа сууж байв. Гэтэл бидэнтэй хамт сургууль төгссөн нэг эмэгтэй манай ерөөнд орж ирлээ. Түүний нөхөр нь манай нэг яамны сайдын алба хашиж байгаад нас барсныг бид нар мэддэг байв.

-Чи ганцаараа энд юу хийж байгаа юм бэ? гэж тэр их гайхсан бололтой асууж байна.

-Надад хотод очих таньдаг айл ч байхгүй л дээ! Одоо хуваариа л хүлээж байна! гэж би хэлээ. Тэгээд бид хоёр ойр зуурын юм яриад манай ерөөнд жаахан суулаа. Тэр юу бодсон юм бэ? Бүү мэд! Тэр манай ерөөнд жаахан суугаад гарах үедээ :

-Чамд очих таньдаг айл байхгүй бол манайд очихгүй юу? Манай гэр их ойрхон шүү! гэж байна. Тэгээд бид хоёр тэдний гэрийн зүг алхлаа. Туул голын зүгээс урьхан салхи намуухан үлээгээд, шингэж байгаа нарны туяа татсан нэг тийм сайхан орой байв. Бид хоёр алхаж явсаар тэдний гэрт ирлээ. Тэр надад сайхан хоол хийж өглөө. Би түлээ модноос нь хагалаж өгөөд түүнд туслав. Ингэсээр байтал орой байрандаа буцах цаг нэгэнт өнгөрчээ. Ингээд би тэднийд хонолоо. Маргааш өглөө бид хоёр хамтдаа сургууль дээрээ ирлээ. Манайхан цуглараад сургуулийнхаа өмнө бүгд жагссаж байв. Гэтэл манай захирал Давжаев багш бид хоёрыг олоод харчихсан юм байна л даа. Тэр бид хоёрыг угтаж ирснээ :

-Манай сургуулиас шинэ гэр бүл төржээ! За та хоёрт баяр хүргэе! гээд гар барьж байна. Тэгээд бид хоёрыг Н.Давжаев багш өөрийнхээ ерөөнд дагуулаад орлоо. Тэр утсаа аваад нэг хүнтэй яриу. Хэнтэй ярьсныг би

мэдсэнгүй. Маршал Х.Чойбалсантай юм уу, түүний орлогч Ч. Сүрэнжав гуайтай л ярьсан байх. Миний хуваарийн тухай л яриа болж байв. Тэр ярьж дуусаад утсаа тавьчихаад :

-За Лоохууз! Чамайг бид нар Улаанбаатар хотын МАХН-ын хороонд хуваарьлахаар боллоо! гээд Н.Давжаев багш гараа өгч байна. Би баярласан, гайхсан хоёр зэрэгцээд түүний гарыг барьснаа санаж байна. Ингэж би Улаанбаатар хотод хуваарилагдсан юм. Н.Давжаев захиралын өрөөнөөс гарч ирэхэд манайхан алгаа ташаад, бид хоёрт баяр хүргэж байна. 1950 онд би Москва хотод Коммунист намын дээд сургуульд сурахаар явснаас хойш бид хоёр дахин нэгч уулзаагүй юм. Тэр болтол бид хоёр цугтаа амьдарч байв. Тэгээд 1990 онд дахин уулзлаа. Энэ тухай яривал их урт яриа болох тул үүгээр дуусгая.

Би 1944 оны 6-р сард шинэ ажилдаа орлоо. Шинэ ажилдаа ороод ажиллаж байтал, намар 9-р сард МАХН-ын Төв Хороонд намайг шилжүүлж авахаар болсон юм. 1944 онд Ерөнхий сайд, маршал ХЧойбалсангийн санаачлагаар МАХН-ын ТХ-нд лекторын товчоо гэдэг шинэ газрыг байгуулсан юм байж. Би энд ажиллах боллоо. Энэ шинэ газрын зорилго бол марксизм-ленинизмийг ард түмэнд сурталчлан таниулах явдал байсан юм. Тэр үед марксизм-ленинизмийг ард түмэн нэг их ойшоодоггүй, түүнийг бараг сурталчилдаггүй байж.

Манай Лекторын товчооны даргаар Чадраабалын Лодойдамба ажиллаж байсан юм. Ч.Лодойдамба тэр үед ЗХУ-ын Иркутск хотод дээд сургууль дөнгөж төгсөөд ирсэн залуу байлаа. Ч.Лодойдамба хожим нэг хэсэг хугацаанд Соёлын яамны орлогч сайдын албыг хашиж байсан хүн. Сүүлдээ их алдартай зохиолч болсон хүн. Тэр олон сайхан өгүүллэг, тууж, роман бичиж билээ. Хамгийн алдартай нь “Тунгалаг Тамир” роман юм. Энэ романыг тэр “Лекторын товчоо”-ны дарга байхдаа бичиж эхэлсэн юм. Бид нар сар бүр энэ романы шинэ бүлгийг авч хэлэлцээд, хүн бүр өөрийн саналаа хэлдэг байлаа. Ийм маягаар хүн бүрийн хэлсэн саналыг тусгаж, нэмэн засварласаар байж түүнийг бичиж дуусгасан юм. Энэ роман хэвлэгдэж гарснаасаа хойш олон гадаад хэл дээр орчуулагджээ. Энэ роман бол Монголын шинэ үеийн үргэлжилсэн үгийн зохиолын сор нь болжээ. Одоо энэ хэмжээний зохиол гарахгүй байна шүү дээ. Энэ зохиолыг Зөвлөлтийн зохиолч Михаил Шолоховын “Дөлгөөн Дон” гэдэг алдартай романтай их ижил болсон гэдэг юм. “Дөлгөөн Дон” романд социалист хувьсгал ялснаар Оросын нийгэм, жирийн орос хүний амьдралд гарсан их өөрчлөлтийг үнэнээр нь яруу сайхнаар дүрслэн бичсэн шүү дээ. Харин “Тунгалаг Тамир” романд 20-р зууны эхээр Монголд өрнөсөн их үйл явдлууд, нийгэмд болсон их өөрчлөлтүүд болон монгол хүний амьдралыг маш үнэн зөвөөр дүрслэн бичсэн юм. 1970-аад оны дундуур Михаил

Шолохов “Дөлгөөн Дон” романаараа Нобелийн шагнал хүртсэн шүү дээ.

1944 онд Монгол улсын их сургуулийн анхны төгсөлт болж, тэндээс хоёр хүн манай Лекторын товчоонд бас томилогдож ирсэн юм. Энэ хоёрын нэг нь Бадамын Лхамсүрэн, нөгөө нь Ц.Балдоо байсан юм. Б.Лхамсүрэн бол хожим МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүн, нарийн бичгийн дарга болсон хүн. Ц.Балдоо бол хожим он удаан жил МАХН-ын ТХ-ны дэргэдэх МАХН-ын түүхийн институтийн захиралын албыг хашсан хүн. Бас гадаад улсад Монголыг төлөөлсөн Элчин сайдын албыг хашиж байсан хүн. Эд нар хожим МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбалтай их найз болсон байх. Энэ хоёр хүн ирээд манай Лекторын товчоонд нийтдээ 10 орчим хүн ажиллах болсон юм.

Манай Лекторын товчоо МАХН-ын Төв Хорооны байранд байрладаг байлаа. МАХН-ын ТХ-ны байр одоогийн МАХН-ын шинэ байр байгаа яг тэр газар байсан юм шүү дээ. Лекторын товчооныхон бүгдээрээ нэг өрөөнд суудаг байлаа. МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбалын ажлын өрөө бидний суудаг өрөөний эсрэг талд байрладаг байв. Түүний суудаг өрөөний хаалга, манай Лекторын товчооны өрөөний хаалганы яг өөдөөс хардаг байлаа.

Ю.Цэдэнбал бол 1916 онд одоогийн Увс аймгийн “Давст” сумын нутагт төрсөн хүн. Сумынхаа бага сургуулийг төгсөөд Ховд аймагт дунд сургуульд сурч байгаад, ЗХУ-ын Улан-Үдэ хотод “Рабочий факультет”-д (товчоор Рабфак) суралцаж төгссөн юм билээ. Рабфак бол монголчуудад зориулсан, дээд сургуульд элсэн суралцах “бэлтгэл анги” юм. Энд Монголын олон залуучууд суралцаж, ЗХУ-ын дээд сургуулиудад орцгоож байлаа шүү дээ. Ю.Цэдэнбал Рабфакийг төгсөөд, Иркутск хотод Их сургуулийн эдийн засгийн ангид суралцсан юм билээ. Энэ сургуулийг төгсөж ирэхэд нь Х.Чойбалсан түүнийг Санхүүгийн техникумийн хичээлийн эрхлэгч, дараа нь Монгол банкны захирал, Сангийн яамны орлогч сайд, жинхэнэ сайд зэрэг өндөр албан тушаалд томилож байсан юм.

Ингээд 1940 онд хуралдсан МАХН-ын 10-р их хурлаас түүнийг МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн даргаар сонгожээ. 10-р их хурлаас өмнө МАХН-ын ТХ-нд “Ерөнхий нарийн бичгийн дарга” гэсэн албан тушаал байсангүй. Түүнийг энэ албан тушаалд сонгогдоход Ерөнхий сайд, маршал Х.Чойбалсан их үүрэг гүйцэтгэсэн гэдэг юм. Тэр үед Ю.Цэдэнбал 24 орчим настай залуу байж. Харин сүүлийн үед түүнийг энэ албан тушаалд сонгогдоход ЗХУ-ын Коммунист Нам оролцсон гэдэг яриа их гарах болжээ. Үнэн, худлыг тогтооход хэцүү л дээ.

Лекторын товчооны өрөө манай Ерөнхий нарийн бичгийн даргын өрөөтэй ийм ойрхон байсан болохоор бид нар түүнтэй ойртож танилцах

боломжтой байв. Тэр хэзээ, хэнтэй уулзсан, хаашаа, ямар ажлаар явсан зэрэг нь бүгд тов тодорхой байдаг байлаа. 20 гаруйхан насны, үе тэнгийн залуучууд нэг дор цугласан байлаа шүү дээ. Эхнэр авч, өрх гэр толгойлсон хүн бидний дунд бараг байгаагүй дээ. Сонирхол бол ижил л байсан байх. Манай Ерөнхий нарийн бичгийн дарга дээр төв, хөдөө, орон нутгийн МАХН-ын үүр, хороодын дарга нар, төрийн сайд нар, урлаг, соёлын зүтгэлтнүүд, хөдөлмөрийн сайчууд их ирдэг байлаа. Олон л хүн ирдэг байлаа. Тэдний дунд алдартай дуучин, жүжигчин, бүжигчин бүсгүйчүүд, одоогийн хэлдгээр бол “од”-ууд бас дуртай цагтаа ирдэг, орж, гардаг л байлаа.

Намайг Лекторын товчоонд ажиллаж эхэлсэн тэр жил манай их эрдэмтэн Бямбын Ренчингийн зохиолоор “Цогт тайж” гэдэг киног “Монгол кино” үйлдвэрт бүтээж эхэлсэн юм. Цогт хунтайж бол 17-р зууны үед амьдарч байсан их ухаантай, эрдэм номтой, Монголын төлөө гайхамшигтай зориг гарган тэмцсэн, цогтой эх оронч түүхэн, бодитой хүн байсан юм. Тэр бол Чингис хааны шууд удмын “цагаан ястай”, угсаа залгамжилсан тайж хүн байж. Энэ киноны Цогт тайжийн дүрд Монголын кино урлагийн их мастер, Ардын жүжигчин Цагааны Цэгмид тоглосон юм. Энэ кинонд түүнээс гадна манай нэртэй олон жүжин тоглосны дотор Лувсанжамцын Цогзолмаа орсон юм. Л.Цогзолмаа бол Монголын дуурийн дуучин, нэрд гарсан үзэсгэлэнтэй, сайхан бүсгүй байлаа. Би Л.Цогзолмааг анх тэр үед харсан байх. “Ю.Цэдэнбал, Л.Цогзолмаа хоёр гэрлэх юм гэнэ!” гэсэн яриа ч олны дунд явдаг л байлаа. Ер нь энэ үед Ю.Цэдэнбал ямар эхнэр авах вэ? гэдэг асуудал олны анхаарлыг их татаж байсан юм. Түүнийг монгол хүнтэй гэр бүл болохыг олон хүн хүсэн хүлээж байсан байж магадгүй. Гэвч энэ асуудлыг түүний хувь заяа өөрөөр шийдсэн юм.

1947 онд Ю.Цэдэнбал Оросын Рязань нутгийн алтан шаргал үстэй бүсгүй Анастасия Ивановна Филатоватай хувь заяагаа холбосон юм. Харин Ю.Цэдэнбалын орос эхнэр авсан явдлыг маршал Х.Чойбалсан илэрхий сайшаагаагүй юм. Ю.Цэдэнбал, А.И.Филатова хоёр Москвад хуримаа хийсэн юм. Тэд нар Монголд ирээд хуримын хүлээн авалт хийхэд нь Х.Чойбалсан очоогүй юм билээ. Ингэж Х.Чойбалсан тэр хоёрын гэрлэлтэнд дургүй байгаагаа илэрхийлсэн байх. Хүмүүжил муутай, бүдүүлэг зантай, орос эхнэрээ Ю.Цэдэнбал МАХН-ын удирдагч, Монголын төрийн өндөр албан тушаалд он удаан жил улиран суух хувийн зорилгодоо маш чадмаг ашиглаж байсан юм. Өөрийн эр нөхрийг хамгаалж, түүнийг өмөөрч А.И.Филатовагийн хэлсэн үг, хийсэн ажил болгон нь МАХН-тай олон жилийн зузаан найрамдалтай байсан ЗХУКН-аас хэлж байгаа үг, хийж байгаа ажил мэтээр олон түмэнд

ойлгогдож байсан юм. Ийм ойлголтыг төрүүлж болох нэг ч боломжийг Ю.Цэдэнбал алддаггүй байв.

Ю.Цэдэнбалыг он удаан жил МАХН-ын удирдагч хэвээр нь байлгаж байх сонирхол ЗХУКН-ын удирдагч нарт байсан болов уу? гэсэн асуулт өөрийн эрхгүй төрдөг юм. Тийм сонирхол ер нь байсан байж болох юм. Орос эхнэртэй Ю.Цэдэнбал оросуудын нүдэнд ямагт “өөрийн хүн” харагддаг байсан шүү дээ. Гэвч 1984 оны 8-р сард хуралдсан МАХН-ын ТХ-ны 8-р бүгд хурал Ю.Цэдэнбалыг бүх албан тушаалаас нь халах шийдвэр гаргасан юм. Түүнийг ингэж халах гол шалтгааныг энэ орос “Авгай” нь бэлтгэж өгсөн юм. Тэр бол тансаг хэрэглээ, бүдүүлэг, хачин ааш, зангаараа нэрд гарсан хүн байж билээ. “Ю.Цэдэнбал авгайнхаа хүүхэлдэй болсон!” гэдэг яриа бол ор үндэсгүй зүйл ч биш юм шүү. Ийм яриаг Ю.Цэдэнбалын удирдаж байсан МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүд өөрсдөө энд, тэнд очоод ярьж явсан баримт байдаг юм. Тэднийг энэ “Авгай” цуглуулаад, нөхрийгөө хамгаалаад, түүнийг өмөөрч, эрээ, цээргүй загнаж байсан баримт нь Монголын нийгэмд ам дамжин яригдаж байсан юм. Сүүлдээ МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүдийг ажлаас нь халж, тэндээс хөөж эхэлсэн нь түүний хачин зан, аашийг олон жил тэвчиж явсан Ю.Цэдэнбалын “Тойрон хүрээлэгчид”-ийн тэвчээрийг барсан хэрэг байж л дээ. Тэдний өмнө өөрсдөө хөөгдөх үү?, эсвэл “Авгай”-г хөөх үү? гэсэн асуудал босож ирсэн байна. “Авгай” болон МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүдийн хэн өрсөн нь нөгөөдхөө хөөх тийм эгзэгтэй байдал буй болсон байна. Ингээд МАХН-ын ТХ-ны УТТ-ны ТХ-ноос өөрийн “өгөөмөр тусламж”-аа үзүүлжээ. Нөхрийгөө хамгаалж, түүнийг өмөөрч, энэ “Авгай”-н хэлсэн үг, хийсэн ажил нь ЗХУКН-аас хэлж байгаа үг, хийж байгаа ажил мэтээр ойлгогдож байсан нь ЗХУКН-ын нэр хүнд монголын ард түмний дунд улам бүр унах шалтгааны нэг болж эхэлснийг тэнд хурдан ухаарч чадсан байна. Хэрвээ энэ тусламжийг цагт нь авч чадаагүй бол МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүд өөрсдөө хөөгдөх байж. Тэд нар “Авгай”-г ганцааранг нь биш түүний нөхөр Ю.Цэдэнбалтай нь хамт хөөхөөр шийджээ. Ю.Цэдэнбал ингэж эхнэрээсээ болж ажлаасаа хөөгдсөн юм.

“Өөд нь хаясан чулуу өөрийн толгой дээр унана!” гэж монголчууд бид ярьдаг шүү дээ. Эхнэрээ удирдаж чадахгүй байгаа хүн, улс орныг удирдах тухай ярих, бодохын ч хэрэггүй гэдэг нь ойлгомжтой шүү дээ. Ингэж МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн даргын 40 гаруй жилийн улс төрийн намтар шившигтэйгээр дууссан юм. Ингэж Ю.Цэдэнбалыг түүний өөрөө цуглуулж, олон жил өөрийгөө хамгаалуулж, тэжээж явсан “тойрон хүрээлэгчид” нь эхнэрийнх нь хамт хөөсөн “хачин түүх” эхэлсэн юм. “Тэжээсэн бяруу тэрэг эвдэнэ!” гэдэг нэг үг монголчуудын дунд байдаг

юм. Ю.Цэдэнбал ажлаасаа хөөгдөөд, “Авгайнхаа” асрамжинд, хүний нутагт яаж амьдарч байсныг монголчууд бид бүгдээрээ мэднэ. Энэ тухай түүний хүү Цэдэнбалын Зориг, Элчин сайд Д.Гүрбадам, сэтгүүлч Леонид Шинкарёв нар сүүлд тодорхой бичсэн юм.

Ажлаасаа ингэж хөөгдөхийн өмнө Ю.Цэдэнбалын бие эрүүл, саруул байсныг түүнтэй уулзаж байсан олон хүн гэрчилдэг юм. Харин “Ю.Цэдэнбалын бие нь муу байсан!” гэдэг яриа бол “Ю.Цэдэнбалын тойрон хүрээлэгчид”-ийн бодож олсон зохиомол хэрэг байсан юм. Түүнийг ажлаас нь халах өөр шалтгаан олон байсныг би 1956 онд хуралдсан МАХН-ын ТХ-ны 2-р бүгд хурал, 1964 оны 6-р бүгд хурлууд дээр тодорхой хэлж байсан билээ. Зөвхөн би ч биш Ю.Цэдэнбал улс орноо удирдаж чадахгүй байгааг олон хүн хэлж, түүнийг олон удаа шүүмжлэж байсан юм шүү дээ. Түүнээс хойш 20 жилийн дараа Ю.Цэдэнбалыг ажлаас нь халсан боловч үнэн шалтгааныг нь ард түмнээс ихээхэн нууцлаж байсан юм. Тэгээд ийм зорилгоор энэ хачин зохиомол зүйлийг бодож олсон юм. Түүгээр ч зогсохгүй энэ зохиомол хэргээ олон түмэнд итгүүлэхийг ихээхэн чармайн оролдож байсан юм. Энэ баримт бол Ю.Цэдэнбалын удирдсан МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүд дотор он удаан жил улс орныхоо эрх ашгийг эрхэмлэн хүндэтгэдэг, эрүүл саруулаар сэтгэн боддог, өөрийн бодолтой хүн цөөхөн байсныг бас дахин гэрчлэн харуулсан юм. Тэртэй тэргүй нас нь ахисан Ю.Цэдэнбал эрч, хүчтэй, эрүүл саруул байж чадахгүй шүү дээ. Энэ бол хэнд ч ойлгомжтой туйлын үнэн мөнөөсөө мөн.

Намайг “Лекторын товчоо”-нд ажиллаж байхад бид бүгдээрээ Ерөнхий сайд, маршал Х.Чойбалсангаас их айдаг байлаа. Түүний нэр хүнд ч ард түмний дунд их өндөр байлаа шүү дээ. Заримдаа Х.Чойбалсангийн дуудлага гэнэт ирнэ. Тийм үед бид нар дарга, даамал гэлтгүй, хамаг байдаг юмаа тэр чигт нь хаячихаад л хар хурдаараа харайлгацгаана шүү дээ. Амьдрал бол тийм л байлаа. Ийм байдлаар би тэнд бүтэн 6 жил ажилласан юм даа. МАХН-ын Төв Хорооны тэр байр нэг том хурлын танхимтай байсан юм. Тэнд МАХН-ын ТХ-ны бүгд хурал хуралддаг байв. Бид нар тэр үед хуралдсан бүх бүгд хуралд суусан юм. Бүгд хурал хуралдаж дууссаны дараа түүний шийдвэрийг амьдралд хэрэгжүүлэх их ажил өрнөдөг байлаа. Ер нь энэ үеэс эхлээд манай нийгэм, улс төрийн амьдралд МАХН-ын оролцоо улам бүр өсөн нэмэгдэх хандлагатай болж ирсэн юм. Улс орны хөгжил, ард түмний амьдралтай холбоотой бүхий л асуудлыг дан ганц МАХН-ын бодлогоор зохицуулдаг болсон юм.

Ингэж Монгол улсын төр, засгийн дээд талд нь аажмаар МАХН гарч ирсэн юм. Энэ үеэс эхлээд “Энхрий хайрт МАХН” гэдэг улс төрийн хэллэг аажмаар буй болж эхлсэн юм. МАХН-ын бүх албан бичиг баримтанд энэ хэллэг орсон. Энэ нь 1960 оны Үндсэн хуулиаар баталгаажсан юм. Энэ

бол манай 3 дахь Үндсэн хууль байлаа шүү дээ. Нэг дэхийг нь 1924 онд, 2 дахийг нь 1940 онд баталсан юм. Монгол улсын шинэ Үндсэн хуулийг баталж байсан 1960-аад оныг “Монгол оронд Социализмын материал-техникийн бааз байгуулж дуусгах үе” гэж МАХН-ын түүхэнд тэмдэглэдэг юм. “Социализмын материал-техникийн бааз гэдэг бол социалист-коммунист нийгмийг төгс байгуулж дуусахын өмнөх хөгжлийн үе шат юм. Энэ үе шатыг байгуулж дуусаад, манай улс социалист-коммунист нийгэмд бүрэн шилжинэ!” гэж тайлбарлаж байсан юм. Социалист-коммунист нийгмийг байгуулахын тулд эхлээд түүний “материал-техникийн бааз”-ыг байгуулах ёстой юм байж.

Манайхны дунд энэ “социализмын материал-техникийн бааз”-ын тухай олон жил нэг анекдот яригдсан юм. Тэр үед Их, дээд сургуулийн оюутнуудаас заавал “Социализм-коммунизмын тухай онол”-ын шалгалт авдаг байсан юм. “Нэг оюутнаас Социализмын материал-техникийн бааз гэж юу вэ? Хэмээн асуужээ. Гэтэл нөгөө оюутан бодож, бодож Социализмын материал-техникийн бааз гэдэг бол Толгойт хавьд байдаг том модон хашааг хэлдэг юм! гэж хариулжээ. Багш нь түүнд муу дүн тавьжээ!” гэсэн утгатай анекдот байсан юм. Манайхан тэр оюутныг шоолоод л инээлдээд байдаг юм. Уг нь “Социализмын материал-техникийн бааз гэдэг бол социалист-коммунист нийгмийг байгуулахын өмнөх хөгжлийн үе шат мөн!” гэсэн онолын хариултыг л өгөх ёстой байж л дээ. Онолын ийм том асуудлыг модон хашаатай андуурсан хүн “муу” авах нь ойлгомжтой шүү дээ. Гэхдээ манайхан түүнийг “Онол мэдэхгүй байна!” гэж ч шоолоогүй юм. Бас “Муу дүн авлаа!” гэж ч шоолоогүй юм. “Тэр оюутан маш зөв хариулсан байна шүү дээ!” гээд манайхан хөхрөлдөөд, шоолоод байдаг юм. Тэр оюутны ярьсан том модон хашаа бол үнэхээр Улаанбаатар төмөр замын “Толгойт” өртөөний ойролцоо байдаг юм. Түүнийг “Толгойт бараа бааз” гэж нэрлэдэг байв. Тэр хашаанд ЗХУ болон бусад орнуудаас ирсэн тусламжийн бараа, техник, тоног төхөөрөмжийг хадгалдаг байв. Гэтэл тэр оюутан “Социализмын материал-техникийн бааз” гэсэн онолын ойлголт, Толгойтод байдаг том модон хашаа хоёрыг андуурч явсан юм байж. Гадаадын хүн ойлгоход хэцүү байж магадгүй ч, манайхны инээгээд, шоолоод байдаг гол учир нь “Социализмын материал-техникийн баазыг монголчууд өөрсдөө биш, гадаадын зээл, тусламжаар байгуулах юм байна шүү дээ!” гэсэн утганд байдаг юм. 1960 оны Үндсэн хууль бол гадаадын зээл, тусламжинд тулгуурлаж социализм-коммунизмыг байгуулах МАХН-ын бодлогыг хуульчилж өгсөн онцлогтой юм.

КЮ: МАХН-ын ТХ-ны лекторын товчоо ямар ажил эрхэлдэг байсан юм

бэ?

Ц Л: Манай МАХН-ын ТХ-ны лекторын товчооны хийдэг гол ажил бол сурталчилгаа байсан юм. Бид нар тэнд ажиллаж эхэлсэн үе бол дэлхийн 2-р дайн дуусаагүй байсан үе шүү дээ. Манай сурталчилгааны ажил Германы фашизмтай байлдаж байгаа манай их хөрш, ах дүүгийн найрамдалт ЗХУ-ыг дайнд ялуулах, дэлхийн 2-р дайныг аль болохоор хурдан дуусгах, Монголын ард түмний дунд Зөвлөлтийн ард түмэнд туслах хөдөлгөөн өрнүүлэхэд чиглэгдэж байсан юм. Бид нар бас Зөвлөлт-Германы дайны цагийн фронтын мэдээг цуглуулж олон түмэнд хүргэдэг байсан юм. Үүний зэрэгцээгээр Англи, Америкийн зүгээс 2-р фронтыг нээж, Германтай дайн эхлүүлэх ажил хэрхэн, яаж явагдаж байгаа талаархи мэдээ бидний сурталчилгааны нэг гол сэдэв болж байсан юм.

Мөн Алс дорнод дахь дайны голомт болсон Япон улстай дайн хийхийн чухлыг сурталчилж, түүнд бэлтгэх ажил ямар шатандаа явж байгаа талаархи мэдээг олон түмэнд хүргэж байсан юм. Мөн дэлхийн 3-р дайныг гаргуулахгүй байх талаар дэлхийн олон улсуудын зүгээс гаргаж байгаа хүчин чармайлтын талаар олон түмэнд сурталчлан, таниулах ажлуудыг хийдэг байлаа. Тэгээд гол нь марксизмыг таниулах сурталчилгааныхаа ажлыг хийдэг байсан юм. Диалектикийн хуулиуд, түүхийн материализмыг тайлбарлан таниулах ажил хийдэг байлаа. “Капитализм бол ер нь цаашид хөгжих ирээдүй байхгүй нийгэм юм. Энэ нийгэм өөрийн хөгжих бүх бололцоогоо шавхаад дууссан, хүн төрлөхтөн удахгүй бүгдээрээ коммунист нийгэмд шилжиж орно. Англи, Америк, Япон зэрэг томоохон хөрөнгтөн орнуудад Коммунист намууд ажиллаж байна. Тэд нар өөрийн орны ард түмний тэмцлийг удирдаад, социалист хувьсгалыг ялуулна. Орон бүрт коммунизмын улаан туг мандах цаг ойрхон байна. Орон бүхний пролетарууд нэгдэж дэлхийн социалист хувьсгалыг ялалтад хүргэнэ. Хүн төрлөхтний гэрэлт ирээдүй бол коммунист нийгэм мөн!” гээд л сурталчилна шүү дээ.

Бид нар улсын үйлдвэр, албан газрууд, төрийн яам, тамгын газруудаар очиж “Улс төрийн дугуйлан” хийдэг байлаа. “Улс төрийн дугуйлан” бүр 1990-ээд он хүртэл манай нийгэмд оршиж байсан шүү дээ. Энэ ажил манай Лекторын товчооноос эхэлсэн юм. Цаг үеэ дагаад ярианых нь сэдэв өөрчлөгдөж байсан байх. Тэр үед бид нар голдуу ажил тарсны дараа оройн цагаар л “Улс төрийн дугуйлан”-гаа хийдэг байлаа. Бид нар сурталчилгаа хийх сэдвээрээ лекц бэлтгэдэг байлаа. Түүнийгээ Лекторын товчоогоороо хэлэлцүүлээд батлуулна. Манайхан Орос голдуу ном ашиглаж лекцээ бэлтгэдэг байв. Би Оросоор уншаад бага зэрэг л ойлгодог болсон байлаа. Манайд Орос хэлнээс материал орчуулах сайн

орчуулагч нар ажиллаж байсан юм. Сайн бэлтгэсэн лекцүүдийг эмхтгээд “Лекцийн эмхтгэл”-үүдийг хэвлэж гаргадаг байлаа.

Бид нар хөдөө их явж энэ лекцүүдээрээ сурталчилгаа хийдэг байлаа. Тэр үед би бараг бүх аймгаар явсан байх шүү. МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга нар, Засгийн газрын гишүүд, тусгай газрын дарга нар тэр үед хөдөө ажлаар их явдаг байсан юм. Тэд нартай хамт бид нар явдаг байлаа. Тэр үед ажил сайн зохион байгуулдаг, хурц, дайчин дарга нар их байлаа шүү дээ. Ялангуяа Сайд нарын Зөвлөл (СНЗ)-ийн орлогч дарга Ч.Сүрэнжав гуай байна. Их хурц дайчин, алдартай сайн зохион байгуулагч хүн байсан юм. Бас СНЗ-ийн орлогч С.Ламжав гэдэг хүн байлаа. Түүнийг “ажлаа сайн мэддэг, хүнтэй ажиллах чадвартай хүн” гэж маршал Х.Чойбалсан их өндөр үнэлдэг байлаа. Би хоёр ч удаа тэр хүнтэй хамт хөдөө явж байлаа. Энэ хоёр хүнийг Ерөнхий сайд, маршал Х.Чойбалсангийн “баруун, зүүн гарууд” гэж нэрлэдэг байлаа. Тэр үед ард түмний улс төрийн идэвхи их өндөр байлаа шүү дээ. Хөдөөгийн хөдөлмөрчид бидний яриаг их идэвхитэй сайн сонсдог байлаа. Тэр үед ард түмэн шинэ юмыг тусгаж авахдаа маш сайн байсан юм. Дайны жилүүдэд манай ард түмний дунд ах дүүгийн найрамдалт Зөвлөлтийн Улаан армид туслах хөдөлгөөн орон даяар өрнөсөн юм. Герман улс ЗХУ руу довтолж Зөвлөлтийн ард түмний аугаа эх орны дайн эхлэсний дараа 9-р сард Улаан армид туслах хөдөлгөөнийг удирдах “Бэлэглэлийн төв комисс” байгуулагдсан юм. Түүний салбарууд аймаг, сумдуудад байгуулагдаж байлаа. “Бүхнийг фронтод!”, “Бүгдийг ялалтын төлөө!” гэсэн уриа лоозонгууд гарч, ард олон энэ “Бэлэглэлийн төв комисс”-оор дамжуулаад Улаан армид бэлэг, хандив өргөдөг байсан юм. Ард түмэн өөрийн чадал чинээгээрээ алт, мөнгө, адуу малаа бэлэг болгон өгдөг байлаа.

Дайны жилүүдэд Монголын ард түмний хөрөнгөөр “Монгол ард” нисэх онгоцны эскадриль, “Хувьсгалт Монгол улс” танкийн цуваануудыг байгуулж байлдаж байгаа Зөвлөлтийн Улаан армид хүлээлгэн өгч байлаа. Ард олон өөрсдийн хийсэн дулаан нэхий дээл, бээлий, малгай, гутлыг байлдаж байгаа Улаан армийн дайчдад явуулж байсан юм. Ард түмний сайн дураараа бэлэглэсэн бэлгийн зүйлүүдээр тусламжийн цувааг зохион байгуулж, Ерөнхий сайд, маршал Х.Чойбалсан тэргүүтэй Монголын засгийн газрын төлөөлөгчид байлдаж байгаа Улаан армийн дайчдад хэд хэдэн удаа хүргэж өгсөн юм. Тусламжийн цувааг анх удаа хүргэж очсон Монголын Засгийн газрын төлөөлөгчдийг хүлээн авсан уулзалт дээр И.В.Сталин “Зовох цагт нөхрийн чанар танигдана!” гэдэг алдарт үгээ анх хэлсэн гэдэг юм. Зөвлөлт-Германы дайны үед Монгол улс дайнд оролцоогүй ч гэсэн өөрийн байдаг бүх бололцоогоо дайчлан ингэж туслаж, ЗХУ-ыг дайнд ялуулахын төлөө хүчин чармайлт гаргаж байсан

юм.

Энэ бол Монгол улс Харилцан туслах протоколоор хүлээсэн үүргээ биелүүлж байсан хэрэг юм. Харилцан туслалцах протоколд Зөвлөлт, Монголын засгийн газрын тэргүүнүүд 1936 онд Москвад гарын үсэг зурсан юм. Энэ протоколоор хоёр тал, тэр хоёрын аль нэг нь гуравдагч оронтой дайн хийсэн тохиолдолд бие биендээ тусламж үзүүлэх үүрэг хүлээсэн юм. 1939 онд Халх голын дайн эхлэхэд Зөвлөлтийн тал хүлээсэн үүргээ биелүүлж Монголд ирж бидэнд тусалсан юм шүү дээ. Халх голын дайнд оролцсон Зөвлөлтийн Улаан Армийн ангиудыг генерал Г.К.Жуков командлаж байсан юм. Г.К.Жуков бол дэлхийн 2-р дайны үеийн дэлхийн хамгийн алдартай жанжингуудын нэг юм. Монголчууд бид түүнийг ихэд хүндэтгэн, эрхэмлэж байдаг шүү дээ. Улаанбатарт түүний музей ажиллаж байна. Ер нь Зөвлөлт-Германы дайнд шалгарсан хамгийн гарамгай цэргийн гурван жанжны хувь заяа Монголтой холбоотой байсан юм. Энэ бол Г.К.Жуков, К.К.Рокосовский, Ф.Конев гурав юм. К.К.Рокосовский, Ф.Конев хоёр 20-оод оны үед Монголд байрлаж байсан цагаан цэргүүдтэй байлдаж байсан Улаан цэргийн командлагч нар байж. Халх голын дайны үед Монгол Ардын Хувьсгалт Цэргийн ерөнхий командлагч нь Х.Чойбалсан байсан юм. Түүний орлогчоор корпус командлагч Ж.Лхагвасүрэн ажиллаж байсан юм. Ж.Лхагвасүрэн бол Халх голын дайны үед байлдааны ажиллагааг шууд удирдаж, ялалтанд хүргэсэн Монголын талын цэргийн командлагч юм. Тэр бол цэргийн хамгийн авъяаслаг залуу жанжин байлаа. Түүний тухай ард түмний дунд дуу зохиогдон дуулагдаж байсан юм. Халх голын дайны ялалтын 50 жилийн ойгоор түүний хүрэл хөшөөг Улаанбаатарт босгож, дурсгалыг нь хүндэтгэсэн юм. Гэвч Ю.Цэдэнбал түүнийг олон жил дарагдуулж, хавчин гадуурхаж, тун зохисгүй харьцаж байсныг өөнөөдөр олон хүн мартаагүй байна. Япон улсад Халх голын дайны талаар энгийн хүмүүс маш бага мэдээлэлтэй байдаг гэж би сонссон юм. Дэлхийн хоёрдугаар дайны эхлэл гэж албан ёсоор зарлагдаагүй ч гэсэн Халх голын дайны үед богино хугацаанд маш том байлдааны ажиллагаа явагдсан юм. Энэ дайнд тэр үеийн хамгийн шилдэгт орж байсан нисэх онгоц, их буу, танк зэрэг цэргийн техникийг хамгийн өргөн ашигласан юм. Халх голын дайн Монгол улсын ялалтаар дууссан шүү дээ.

1941 онд Зөвлөлт-Германы дайн эхэлсэн нь Монголын эдийн засагт маш хүчтэй цохилт болсон юм. Тэр үед манайд аж үйлдвэр бараг хөгжөөгүй байлаа. 1934 онд Аж үйлдвэрийн комбинат байгуулагдаж ард түмний өргөн хэрэгцээний барааг бага зэрэг үйлдвэрлэдэг болсон боловч ихэнх хэрэгцээт бараагаа ЗХУ-аас импортоор авдаг байсан юм. Гэтэл манай гадаад худалдааны гол түнш орон болох ЗХУ-ын эдийн засаг

дайны байдалд орсон тул манайд бараа нийлүүлж чадахаа байсан юм. Ийм учраас манай засгийн газар өөрийн эдийн засгийг дайны байдалд зохицуулан удирдах бодлогыг боловсруулж эхэлсэн юм.

1941 оны төгсгөл, 1942 оны эхээр МАХН-ын Бүгд хурлууд удаа дараа хуралдаж манай эдийн засгийг дайны үеийн байдалд хэрхэн зохицуулах тухай асуудлуудыг авч хэлэлцсэн юм. Эдгээр бүгд хурлууд дотоод нөөц, бололцоогоо бүрэн дайчлаж урьд нь ЗХУ-аас авч байсан өргөн хэрэглээний барааг аль болохоор өөртөө үйлдвэрлэж байхаар шийдсэн юм. Ингээд “Гар үйлдвэрийн дээд зөвлөл”-ийг байгуулсан юм. Түүний даргаар нь Н.Дэмчиг гэдэг хүнийг сонгож байлаа. Энэ Гар үйлдвэрийн дээд зөвлөлийн салбарууд аймаг, сум бүрт байгуулагдаж байлаа. Н.Дэмчиг дарга бол их санаачлагатай, аж ахуйн ажлыг удирдан явуулах арга сайтай хүн байсан юм. Одооны хэлээр бол “менежмент” сайтай дарга байж л дээ. Хүмүүсийн дунд “Урт цагаан” нэртэй болчихсон Улаанбаатар хотын Үйлчилгээний төвийг анх Н.Дэмчиг дарга гар үйлдвэрлэл явуулах зорилгоор байгуулсан юм.

Тэр үед манайд европ хувцас бараг хийдэггүй байлаа. Төрийн алба хашиж байгаа сайд, дарга нарын хувцасыг оёдог нэг тасаг ажиллаж байсан юм. Тэр тасагт хувцасны размер гэдэг юмыг хэрэглэдэггүй, хийсэн бүх хувцас нь бүгд ижилдүү размертэй байсан юм. Заримд нь томдоод, заримд нь багадаад хачин л юм байна шүү дээ. Би 1950-аад оны дундуур Румынээс европ хувцасны размерын загварыг Н.Дэмчиг даргад авчирж өгч байсан юм. Түүний хийсэн анхных нь 48 размерийн костюм, пиджакийг би өөрөө хийлгэж өмсөж байлаа. Түүнээс хойш манайд европ хувцасыг хүний биеийнх нь хэмжээнд тохируулаад, размерээр нь хийдэг болсон юм.

Тэр хүн олон шинэ юмыг нэвтрүүлсэн дээ. Аж ахуйн ач холбогдол ихтэй янз бүрийн хөдөлмөрийн багаж зэрэг зүйлүүдийг хийдэг суурь машинуудыг гадаадаас худалдан авч ирээд хэрэглэдэг болсон юм. Тэр үед чинь манайд төрөл бүрийн төмөр эдлэлүүд, хадаасыг төрөл, төрлөөр нь хийдэг болсон юм шүү дээ. Бас төрөл бүрийн шил, толийг өөрсдөө хийдэг болсон юм. Эдгээрийг барилгын ажилд их хэрэглэж байсан юм. Аймгуудад байгуулагдсан гар үйлдвэрүүд арьс ширийг үйлдвэрийн аргаар элдэж, дээл, малгай, гутал зэрэг бусад өргөн хэрэглээний барааг хийдэг болсон юм.

Ингээд аажимдаа гадаадаас импортоор авдаг бэлэн бүтээгдэхүүний тоо цөөрч эхэлсэн юм. Гар үйлдвэрийн ажил ийм өөдрөг сайхан явж эхэлсэн учир Аж үйлдвэрийн яамыг байгуулсан юм. Сайдаар нь Д.Бавуудорж гэдэг хүнийг томилж байлаа. Д.Бавуудорж сайд урьд нь аймгийн дарга байсан хүн. Тэр айхтар дайчин, чадвартай хүн байсан юм. Ингээд Аж үйлдвэрийн яам байгуулагдсанаар гар үйлдвэр, аж үйлдвэр

хоёр зэрэгцээд хөгжих эхлэл тавигдаж байгаа юм. Энэ бүхэн чинь бүгд маршал Х.Чойбалсангийн санаачлагаар хийгдсэн ажлууд юм шүү дээ.

КЮ: Та маршал Х.Чойбалсантай уулзаж байсан уу?

Ц Л: Би маршалтай дотно сайн харилцаатай байгаагүй юм. Тэр үед залуу ч байж дээ. Базарын Ширэндэв даргын даалгавраар анх удаа уулзаж байсан юм. Тэр үед Б.Ширэндэв гуай МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүн, нарийн бичгийн дарга байсан юм. Би Б.Ширэндэв даргын даалгавраар суртал нэвтрүүлгийн ажлыг улсын хэмжээнд аймаг, сумдад зохион байгуулах ажлын төлөвлөгөө боловсруулсан юм. Энэ төлөвлөгөөгөө маршал Х.Чойбалсанд өөрөө танилцуулах даалгаврыг авсан юм. Маршал бол ард түмний дунд алдар нэр нь түгсэн, тахиж шүтүүлсэн хүн байлаа шүү дээ. Тийм хүний ажлын өрөөнд анх удаа ороход хэн боловч их сүрдэнэ шүү дээ. Би ч айж байлаа. Тэгээд л орлоо доо. Тэр өрөөнийхээ нэг буланд, их том ширээний ард сууж байлаа. Түүний өрөө нь ч их том юм. Тэр том ширээний араас маршал өөрөө их жижигхэн харагдаж байна. Өрөөнд нь өөрийн нь сууж байгаа ширээнээс гадна өнгийн даавуугаар бүтээсэн бас нэг урт ширээ байна. Маршалын сууж байгаа ширээний ард, хананд В.И.Ленин, Д.Сүхбаатар хоёрын зураг өлгөөтэй байна. Өөр юм байсангүй. Намайг орж ирэхэд Х.Чойбалсан ширээнийхээ араас босож ирээд :

-Сайн байна уу? гэж мэндлээд,

-Чамайг Б.Ширэндэв нааш нь явуулсан биз? гэж асууж байна.

Би түүнтэй хариу мэндлээд,

-Тийм. Б.Ширэндэв дарга явуулсан юм! гэж хэллээ.

Х.Чойбалсан:

-Аа, тийм үү. Чамайг хэн гэдэг вэ? гэж асуулаа.

Би түүнд өөрийн нэрийг хэлтэл тэр дахиад:

-Чи тэгээд ямар ажил хийж байна? гэж асууж байна.

-Лекторын товчоонд суртал нэвтрүүлэгчийн ажил хийдэг! гэж би хэллээ.

-Аа, тийм үү. Чи тэгээд аль зэрэг суртал нэвтрүүлж байна. Хөдөө явж, ард олонтой уулзаж байна уу? Ард олон одоогийн бидний яриад байгаа социализмыг ойлгож байна уу? гэж тэр дахин асуугаад:

-Чи нааш ир! Энд суу! Наад хийж ирсэн төлөвлөгөөгөө энэ ширээн дээр дэлгээд тавь! Тэгээд яаралгүй сайхан тайлбарла! гэж байна. Х.Чойбалсан өөрөө маш энгийн, надтай их сайхан харьцаж байсан юм. Гэсэн ч миний өвдөг чичрээд л байлаа. Тэгээд би түүнд өөрийн хийсэн төлөвлөгөөгөө тайлбарлаад баахан ярьлаа. Тэр үед чухам ямар төлөвлөгөө боловсруулаад, маршалд юу ярьсан юм бэ? Бүү мэд! Нэг мэдсэн чинь маршал:

-За болно! Би ойлголоо! гэж байна. Тэгснээ:

-Чи одоо Ч.Лодойдамбатай хамт ажиллаж байгаа юм байна шүү дээ! Цаад хүн чинь уран зохиол бичээд суучихаж мэдэх л хүн байгаа юм шүү дээ! Та нар илүү сайн ажиллах хэрэгтэй. Ард түмэнд бидний хийж байгаа ажлыг сайтар ойлгуулах хэрэгтэй! Энэ их чухал ажил шүү! гээд гараа өгч байна. Би түүнтэй гар бариад өрөөнөөс нь гарч явлаа. Ингэж би анх удаа маршалтай уулзаж байсан юм.

1952 онд намайг Москва хотод Коммунист Намын дээд сургуульд сурч байхад маршал Х.Чойбалсангийн бие нь муудаж, Москвад ирж эмнэлэгт хэвтээд, мэс засал хийлгэсэн юм. Гэтэл тэр мэс заслаа даалгүй, мэс заслын ширээн дээр нас барсан юм. Маршал Х.Чойбалсан ингэж нас барсан юм. Түүний шарилыг Москва хотод Зөвлөлүүдийн ордны Баганат танхимд байрлуулж, ЗХУКН-ын удирдагчид, Зөвлөлт төрийн тэргүүн, Засгийн газрын гишүүд, олон нийтийн төлөөлөгчид салах ёс үйлдсэн юм.

Би тэр үед маршал Х.Чойбалсангийн шарилын дэргэд хүндэт харуулд зогссон юм. Дараа нь түүний шарилыг галт тэргээр Монгол руу авч ирээд, оршуулсан юм. Бид нар Москвагийн Ярославын вокзал дээрээс түүний шарилыг байрлуулсан галт тэргийг нь үнсээд нутаг руугаа үдэж байлаа. Ер нь маршал бол их нэр хүндтэй хүн байсан юм. Түүний үйл ажиллагаа нь “нэг хүнийг дахин шүтэх явдал”-ыг дэвэргэж, олон гэмгүй хүнийг улс төрийн хилс хэрэгээр цаазалсан явдалтай холбоотой маш их буруу үйлдэлүүд байсан боловч нас барахад нь гашуудаж, нулимс гаргаагүй насанд хүрсэн монгол хүн бараг байгаагүй юм шүү. “Дэлхийн дайн дэгдсэн, их гүрнүүд хоорондоо дайтсан, хүнд үед Монгол улсын хувь заяаг маршал авч гарлаа! Маршалаас өөр хүн бол ийм зориг тэвчээр гаргаж, улс орноо удирдаж чадахгүй байсан!” гэж олон хүн боддог байсан юм. “Маршал бол улс төрийн олон алдаа гаргаж байсан боловч Монгол улсын хувь заяатай холбоотой ганц асуудал дээр ямагт зөв байр суурийг баримталж чадаж байсан!” гэж би боддог юм. Манай хоёр том хөрш чинь манайх шиг жижигхэн улсыг ер нь яавал ч яахаар л юм хийж, хэрэгжүүлж байсан түүх хуучраагүй байсан үе шүү дээ. Тийм үед төрийн жолоог залуурдана гэдэг бол асар их тэвчээр, зориг, ухаан, уян хатан байдлыг шаардах нь мэдээжийн хэрэг юм. “Маршал үүнийг хэнтэй ч зүйрлэхгүй чадамгай хэрэгжүүлж чадсан!” гэж би боддог юм.

Намайг МАХН-ын ТХ-ны лекторын товчоонд ажилаж байхад болсон МАХН-ын ТХ-ны бүх Бүгд хурлуудын бүгд дээр нь Х.Чойбалсан үг хэлсэн юм. Маршал нэг зүйлийг маш олон дахин ярьдаг байлаа. Энэ бол “Намын дотоод шүүмжлэл”-ийн асуудал юм. “Нам гэдэг бол идэвхтэй хүмүүсийн бөөгнөрөл юм. Энэ чинь бас нийгмийг удирдах үүрэгтэй улс төрийн байгууллага юм. Энэ байгууллагын үйл ажиллагааг байнга засаж,

залруулахгүй бол нийгмээсээ хоцорно. Түүнийг байнга засаж, залруулж байх хэрэгтэй юм. Ингэж засаж, залруулах хамгийн сайн арга бол намын дотоод шүүмжлэл юм. Дотоод шүүмжлэл л зогсох юм бол нам өөрийнхээ дутагдлыг ухаарахгүй болно. Өөрийн дутагдлыг ухаарагүй нам дордож, доройтоно. Шүүмжлэлийг дээд удирдлагын зүгээс болон намын хамт олны зүгээс явуулах ёстой. Бид нар бол намын дээд удирдлагад байгаа хүмүүс. Бид доод хүмүүсээ байнга шүүмжлээд, шаардлага тавиад байж болно. Харин намын хамт олны үг намд хамгийн чухал. Одоо Ю.Цэдэнбал бид хоёроос авхуулаад бусад сайд, дарга нарын ажил ямар байгаа талаар намын хамт олны үгийг сонсдог болъё! Бидний ажлын юу нь болоод, юу нь болохгүй байгааг сонсож байя!” гэж хэлдэг байлаа. Тэр үед, маршалыг нас барах хүртэл намын төв хэвлэлүүдэд тийм зарчмын шүүмжлэлүүд их гардаг байлаа. Харин маршал хов зөөж яваа хүнд их дургүй байсан юм. Тухайлбал, “Тэр хүн ажил хийхгүй байна!” гэх мэтийн хов живийн чанартай яриа сонсохдоо маш дургүй хүн байсан юм. Тийм яриа сонссон үедээ тэр олон үг хэлдэггүй юм. Дуугүй байж байгаад “Чёрт” гэж л нэг үг хэлнэ дээ. Бас долигносон, бялдууч хүнд их дургүй хүн байсан юм. Төрийн өндөр албан тушаалд шинэ хүнийг сонгож, томилохдоо дандаа урьд нь хийж байсан ажлынх нь үр дүнг хардаг байсан юм. Тухайлбал, “нэг багийн ажлыг сайн удирдсан хүнийг сумын даргаар дэвшүүлж болно, нэг сумын ажлыг сайн удирдсан хүнийг аймгийн даргаар дэвшүүлж болно, нэг аймгийн ажлыг сайн удирдсан хүнийг төрийн сайдаар дэвшүүлж болно, нэг яамны ажлыг сайн удирдсан хүнийг сайд нарын зөвлөлийн орлогч даргаар дэвшүүлж болно, сайд нарын зөвлөлийн орлогч даргын ажлыг сайн хийсэн хүнийг МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн даргаар дэвшүүлж болно!” гэж тэр үздэг байсан юм. Энэ бол боловсон хүчнийг сонгох их шалгарсан сайн арга гэж би боддог юм. Манайд Чингис хааны үед аравны дарга, зуутын дарга, мянганы ноёдыг бас иймэрхүү аргаар, цэрэг удирдсан туршлага, үр дүнг харж сонгож байсан түүх бий юм шүү. Х.Чойбалсангийн үеийн 13 яамны сайд нар бүгдээрээ аймгийн дарга байсан хүмүүс юм. Тэд нар өөрийнхөө аймгийн ажлыг сайн удирдаж байсан тул яамны сайд болцгоосон юм. Боловсон хүчний талаар маршалын барьж байсан энэ бодлого их зөв байсан гэж би боддог юм.

Ю.Цэдэнбал төрийн эрхийг барьж эхлээд боловсон хүчнийг шилж сонгох талаар маршалын барьж байсан энэ бодлогыг үндсээр нь өөрчилсөн юм. Ю.Цэдэнбал хүнийг шилж сонгохдоо хийж байсан ажлынх үр дүнгээр биш, харин амласан амлалтаар нь, төгссөн сургуулиар нь, нутаг усаар нь шилж сонгох буруу аргыг хэрэглэж эхэлсэн юм. Төрийн өндөр хариуцлагатай ажилд томилогдсон хүмүүсийг ийм аргаар сонгож авсан учир хэсэг хугацааны дараа манай бүх шатанд ажил унаж эхэлсэн

юм. Ингээд практик амьдрал, удирдлага хоёрын хооронд зөрчил үүсэж эхэлсэн юм. Удирдлага нь бодит амьдралаас урган гарч байгаа асуудлуудыг гүйцэж ойлгохоо байсан юм. Ингээд зөв шийдвэр гаргаж чадахаа больсон юм. Ингээд энэ зөрчил улам лавшраад эхэлсэн юм. Зарим үед энэ байдлаас гарах арга замыг хайдаг байсан боловч тусыг эс олсон учир манайд удирдлагаа ил, далд янз бүрийн хэлбэрээр шүүмжлэх нь хавтгайрч эхэлсэн юм. Манай улсын үйлдвэр, аж ахуйн газар ажиллагсад ажил хийдэггүй дарга нарынхаа үгийг сонсохоо байгаад, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэхээ болиод ирсэн юм. Дарга нар нь хөдөлмөрийн хамт олонтойгоо үг хэлээ олохоо байгаад, тэднийхээ бодол санаа, хүсэл эрмэлзлийг нь хүлээж авахаа болиод, ойлгохоо байгаад ирсэн юм. Ингэж хавтгайрсан үл итгэх байдал бий болсон юм. Ингээд бүх шатанд ажил зогсонги байдалд орж өдөр хоногийг өнгөрөөж эхэлсэн юм.

6 Ю.Цэдэнбал.

КЮ: МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбал гуай та хоёрын хувийн харилцаа ямар байсан бэ?

Ц Л: Бид нар ойр, сайхан харилцаатай байсан үе бий. Түүний дүү нартай ч сайхан харилцаатай байсан. Тэр нэг эрэгтэй дүү, нэг эмэгтэй дүүтэй хүн. Эмэгтэй дүүтэй нь би найз байсан үе бий. Намайг Москвад Коммунист намын дээд сургууль төгсөөд ирсний дараа болсон нэг үйл явдлын тухай би ярьж л даа.

Тэр үед манайхан Наадмаа их өргөн дэлгэр тэмдэглэдэг байлаа шүү дээ. Олон хоног амардаг байлаа. Наадмын ийм нэг амралтын өдөр Ю.Цэдэнбалын дүү охин бид хоёр Туул гол дээр очиж амрахаар тохирсон юм. Гэтэл биднийг Туул голд хүргэж өгөх машин байдаггүй. Ингээд машинтай хүн олохоор наадмын талбай орчмоор явж байлаа. Тэнд Наадам үзэхээр ирсэн олон хүн, машин цугласан байлаа. Гэтэл миний найз бүсгүй гэнэт “Хүүе! Энд манай ахын машин зогсож байна. Хоёулаа тэр машинаар явъя! Би жолоочийг нь сайн таньдаг юм!” гэж байна. Үнэхээр биднээс холгүй газар, Засгийн газар, МАХН-ын ТХ-ны удирдлагуудын машины зогсоол дээр олон машины дунд тас хар өнгөтэй, шив шинэ суудлын машин зогсож байна. Үнэхээр түүний ахын машин мөн байна. Жолооч нь дотор нь сууж байна. Бидний хүсэлтийг сонсоод тэр жолооч нэг их дуртай биш байна. Гэхдээ татгалзсангүй. “Наадам тарахаас өмнө заавал эргэж ирэх ёстой шүү!” гэж дахин давтан анхааруулж байлаа. Бид ч түүнд “Наадам тарахаас өмнө заавал ирнэ!” гэж амаллаа. Ингээд бид хоёр тэр машинд суугаад Туул голыг уруудаад давхилаа. Тэгээд

бургастай нэг сайхан газар оллоо. Хожим тэр орчимд “Сонгино” гэдэг нэртэй амралтын газар байгуулагдсан байна билээ. Жолоочтой гурвуулаа бургасны сүүдэрт суугаад, цай чанаж уугаад, бага хэмжээний “пикник” хийлээ. Халуун өдөр байсан болохоор жолооч бид хоёр усанд шумбалаа. Биднийг энд ирэхэд үд дөнгөж өнгөрч байсан болохоор наадам тарах болтол бас чиг их хугацаа байлаа. Үүнд тайвширсан жолооч бид хоёр усанд шумбаж дуусаад зөөлөн элсэн дээр хэвтээд, биеэ шарж байтал нам унтчихжээ.

Ингээд гурвуулаа сэрсэн чинь нар жаргах дөхчихсөн байна. Зуны өдөр нар орой жаргана шүү дээ. Наадам бол аль хэдий нь тарчихсан нь мэдээжийн хэрэг л дээ. Ингээд бөөн хэрэг мандах нь гарцаагүй болчихлоо. Ийм үед “Бүх үнэнээ хэлээд, түүний ахаас уйчлал гуйхаас өөр ямар ч аврал байхгүй!” гэдгийг бид хоёр ойлгож байлаа. Ингээд түүний ах дээр очлоо. Үнэнээ хэллээ. Уйчлал гуйлаа. “Дахин ийм хэрэг явдал гаргахгүй!” гэж амлацгаалаа. Ю.Цэдэнбал наадам тараад гарч иртэл машин нь байсангүй. Тэгээд тэр тэнд зогсож байсан нэг сайдын машинаар гэртээ хүргүүлсэн юм байж. Тэр үед манай орон их сайхан амгалан тайван орон байлаа шүү дээ. Одоогийнхтой адил биш. Төрийн тэргүүн, МАХН-ын удирдагчид, сайд нар гудамжинд энгийн хүмүүстэй адилаар явж байх нь элбэг байсан юм. Тэдэнд цаг байдаг л юм бол гудамжаар явж л байдаг байлаа. Миний найз бүсгүйн ах биднийг ийм хэрэг явдал өдөөснийг дуртай хүлээж аваагүй нь мэдээж шүү дээ. Гэхдээ их уурласан шинжгүй өнгөрч байлаа.

Ю.Цэдэнбалын эрэгтэй дүүг Ю.Аюуш гэдэг юм. Түүний авгайн аав Ж.Нансал гэдэг хүн байсан юм. Ю.Аюуш авгайгаа дагуулаад, эхнэр бид хоёр Цэдэнбал-Филатоватай хамт Ж.Нансал гуайн гэрт Эмэгтэйчүүдийн баяр, Шинэ жилийн баяр, Октябрийн баярыг хэд хэдэн удаа тэмдэглэж байсан юм. Ю.Цэдэнбалын дүү Ю.Аюушийн эхнэр, манай эхнэр хоёр чинь ураг төрлийн холбоотой, төрөл садангийн хүмүүс байгаа юм.

И Л: Ю.Цэдэнбал гуай ер нь ямар зан, ааштай хүн бэ?

Ц Л: Өө, зүгээрээ зүгээр. Ер нь зүгээр. Хээгүй, зөөлхөн, сайхан зантай хүн шүү дээ. Бид нар Ю.Цэдэнбалын хувийн дутагдлууд, ажлынх нь арга барил, түүний явуулж байгаа улс төрийн бодлого, чиг шугамыг нь л шүүмжлэж байсан юм шүү дээ. Ард түмний амьдралаас хөндий, тасархай хүн байлаа шүү дээ.

Энэ талаар би та нарт нэг жишээ ярья л даа. 1950-аад оны сүүлчээр бид нар Бор нуурын САА-д шинээр адууны аж ахуй байгууллаа. ЗХУ-аас сайн үүлдрийн их олон адуу авч ирсэн юм. Нэг өдөр Ю.Цэдэнбал намайг дууджээ. Би түүний ажлын өрөөнд явж ирвэл :

-Би маргааш та нарын яриад байгаа адууны аж ахуйг үзмээр байна! Чи хамт яваарай! гэж байна. Маргааш өдөр нь амралтын өдөр байв. Бид нар товлосон цагтаа Улаанбаатараас гарч явлаа. Ю.Цэдэнбалтай хамт хамгаалалтын албаныхнаас хүн бараг явсангүй. Бор нуурын САА ойрхон учир удаж төдөлгүй л ирчихлээ. Бид нар Улаанбаатараас гарахдаа адууны аж ахуй дарга нарт энэ тухайгаа хэлээгүй юм. Ингээд адууны аж ахуй дээр биднийг хэн ч угтаж авсангүй. Бүгд амар ч байгаа шүү дээ. Ганц манаач өвгөн л байв. Тэр гарч ирлээ. Амралтын өдөр чухам хэн ирээд байгааг тэр сайн ойлгохгүй л байх шиг байна.

Тэгээд :

-Сайн байна уу? гээд гараа өгч байна. Бид нар түүнтэй мэндлээд эхлээд Ю.Цэдэнбал, дараа нь би гар барилаа. Тэгээд манаач биднийг дагуулаад адууны хашаануудаар явлаа. Би Ю.Цэдэнбалд тэнд байгаа адуунуудын үүлдэр, угсааны талаар тайлбарлаж өгөв. Ингэж явсаар бид бүх хашааг дуусгалаа. Тэгээд бид нар тэндээс гарлаа. Нөгөө манаач өвгөн биднийг үдэж өгөөд :

-За. Баяртай! гээд гараа өгч байна.

-За. Баяртай! Баярлалаа! гэж бид нар түүнд хэлээд гарыг нь дахиад барилаа. Ингээд тус тусын машинд суухаар явцгаалаа. Би машиндаа суугаад хөдлөх гэтэл Ю.Цэдэнбалын машин хөдөлсөнгүй! Хотоос ирэхдээ түүний машин түрүүлж, миний машин араас нь дагаж явсан юм. Манай жолооч жаахан хүлээлээ. Хэсэг хугацааны дараа би юу болоод байгааг мэдэхээр машинаасаа буулаа. Гэтэл Ю.Цэдэнбал машиныхаа арын багажны хаалгыг онгойлгочихсон, том шилтэй, цэнхэр өнгөтэй спиртнээс цав цагаан даавуунд шингээж аваад хоёр гараа ээлжлээд арчиж байна. Ариутгаж байгаа юм байна л даа. Энэ агшинд миний уур маш их хүрч билээ. “Энэ хүн ард түмний амьдралаас ингэтлээ тасарчээ. Жирийн малчин өвгөнтэй гар барьснаас болоод өвчин тусахаас айж байгаа юм байна л даа. Энэ спирт, энэ цагаан алчуурыг түүнд орос эхнэр нь бэлтгэж өгсөн биз! Ю.Цэдэнбал гэж хэн юм бэ? Тэр ямагт ийм цагаан алчуураар гараа арчиж, ямагт ийм цагаан цамц өмсөөд, ийм цэвэр цэмцгэр явсан юм уу? Үгүй шүү дээ. Тэр өөрөө энэ малчин өвгөнөөс доор орчинд өссөн хүн. Түүний ч, миний ч, ер нь бидний монголчуудын амьдарч өссөн орчин ийм л байсан шүү дээ. Бүгд адилхан. Тэгээд одоо энэ хүн ямар зан, авир гаргаж байгаа юм бэ? Энэ хүн хэнийг доромжилж байгаа юм бэ? Энэ хаанахын ёс вэ? Энэ яавч манай монгол ёс биш!” гэсэн бодол надад төрөөд явчихлаа. Тэгээд би өөрийн машинд суугаад, эргэж харалгүй, шууд Улаанбаатарын зүг хар хурдаараа давхиж билээ. Тэр ингэж амьдралаас хол тасарсан хүн байв. Тэр орос эхнэрийнхээ нөлөөгөөр бүх зүйлийг орос маягаар хийхийг хичээдэг байв. А.И.Филатова Монголд 40 шахам жил амьдрахдаа нэг ч

удаа малчин айлын гэрт хонож үзээгүй, ганц ч монгол үг хэлж сураагүй нутаг буцсан юм шүү дээ. Тэд нар Славик, Зориг нэртэй хоёр хүүхдээ багад нь үеийн монгол хүүхдүүдтэй огт тоглуулдаггүй, тэд нар нь нэг ч монгол үг хэлж мэдэхгүй хорин нас хүрцгээсэн юм билээ. Тэд нар ийм л хүмүүс байсан юм. Ийм л хүмүүс бидэндээ зааж сургах гээд, биднийгээ залуурдаж, жолоодох гэж оролдоод нэг насаа барсан юм шүү дээ.

Энэ байдал нь ажил хийхэд их саад болдог байсан юм. Амьдралаас урган гарч ирсэн асуудлуудыг дэмждэггүй, тэр талаар бүрэн гүйцэд ойлголт муутай байдлыг нь л бид нар шүүмжилж байсан юм. Ажил, төрлийн шугамаар болон амин хувийн асуудлаар уулзаад: “Нэг л болохгүй байна шүү. Ард түмний амьдрал, улс орныхоо байдалтай сайн танилцах хэрэгтэй байна шүү!” гээд л олон хэлсэн дээ. Даанч засраагүй юм шүү дээ.

7 Би ЗХУКН-ын Дээд сургуульд сурахаар явлаа.

КЮ: Та хэзээ ЗХУ-д суралцахаар явсан юм бэ?

Ц Л: Би Лекторын товчоонд 1944 оноос 1950 хүртэл ажилласан юм. Намайг сайн суртал нэвтрүүлэгч гэж үнэлдэг байлаа. Тэр үед би орос хэлийг бие даагаад сурах гэж их оролддог байлаа. Шөнө 2 цаг хүртэл ажил дээрээ суугаад, орос ном уншиж, орчуулдаг байлаа. Тэр үед МАХН-ын ТХ-ны үзэл суртлын асуудал эрхэлсэн нарийн бичгийн дарга Н.Сосорбарам гэдэг хүн байсан юм. Тэр хүн орос хэл сурах гэж мэрийж байгаа намайг хараад бас нэг юм боддог байсан байх л даа.

1940-өөд оны сүүлчээр Москвагийн Коммунист намын дээд сургуульд Монголоос хүн явуулж суралцуулах асуудал яригдаж эхэлсэн юм. Тэр үед Зөвлөлт Холбоот Улсын Коммунист Нам социализмыг байгуулж эхлээд байсан орнууд болон цаашид социализмыг байгуулахаар сонирхож байгаа орнуудад боловсон хүчин бэлтгэж өгөхөд туслахаар шийдсэн юм байж. Ийм орнуудын тоонд Монгол багтаж орсон байна л даа. Эхний жил 4 хүн явлаа. Энэ бол Ц.Дүгэрсүрэн, С.Зундуй, Д.Цэдэндамба, Б.Энэбиш нар байсан юм.

Дараагийн жил нь дахиад 4 хүн явахаар боллоо. Тэр бол Д.Чойжамц, С.Дэлэг, Ц.Дагвасүрэн бид нар юм. Д.Чойжамц гуай бол МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга байсан хүн бөгөөд бидний дунд хамгийн ахмад нь байлаа. Ц.Дагвасүрэн бол МАХН-ын ТХ-ны гадаад харилцааны хэлтсийн дарга байсан хүн. Ц.Дагвасүрэн одоо Москвад амьдарч байгаа. Тэр орос эхнэр авсан юм. Бид гурав 27 орчим настай, үе тэнгийнхэн байлаа.

Биднийг очих үед Коммунист намын дээд сургууль Москва хотод

10 давхар саарал байшинд байсан юм. Энэ бол улсын маш их материалын хангамжтай, сургалт сайтай сургууль байсан юм. ЗХУКН-ын ТХ-ны Нарийн бичгийн дарга нараас эхлээд, хэлтсийн дарга нар, Засгийн газрын гишүүд, төрийн сайд, тусгай газрын дарга нар энэ сургуульд суралцаж төгсдөг байж. Мөн хөрөнгөтөн орнууд, тухайлбал АНУ, Франц, Англи зэрэг орнуудын Коммунист намын гишүүд ирж суралцдаг байж. Тэд нарын энд сурч байгаа асуудал бол ил тод биш, нууц байсан юм. Их цөөхөн ч хүн ирдэг байсан байх. Намайг сурч байхад тэр сургуульд Япон хүн ирсэн эсэхийг мэдэхгүй. Байсан бол бас нууц байдалд байсан байх.

Биднийг очих үед тэр сургуульд суралцагсад сард 1500 рублийн цалин авдаг байлаа. Гадаадаас ирсэн хүмүүс 500 рублийн нэмэгдэл авдаг байсан юм. Эхний жил өрөөндөө хоёулаа амьдардаг байлаа. Дараа жилээс нь эхлээд ганцаараа амьдарч болно. Манай байранд “Кремлийн хоолны газар”-ын салбар ажилладаг байлаа. Тэнд бид нар идэх хоолныхоо захиалгыг долоо, долоо хоногоор нь урьдчилаад өгчихдөг байлаа. Би Оросод сурсан 3 жилийнхээ хугацаанд төмс, талх хоёрыг бараг идээгүй ирсэн юм. Кремлийн хооны газраар үйлчлүүлдэг байсан болохоор өөрийн дуртай махан хоолыг л захиалдаг байлаа. Харин махыг бол янз бүрийн амьтны мах захиална шүү дээ. Галуу, тахиа, гахай, хонь, үхрийн мах захиалдаг байлаа. Тэр үед Кремлийн хоолны газар өөрийн хэрэгцээний махаа Францаас авдаг байсан юм. Галуу, тахиа хоёрыг бас л импортоор авч байсан байх. Харин гахайны мах бол Украйнаас ирдэг байсан байх. Бид нар хувцас хунараа бас шууд захиалгаар хийлгэдэг байлаа. Захиалгын хувцас хийдэг томоохон үйлдвэр ажиллаж байсан юм. Урлаг, соёлын бүх газарт очергүй орох эрхтэй байлаа. Сургуулийнхаа үнэмлэхийг үзүүлээд л шууд орно.

ЗХУКН-ын ТХ-ны бүгд хурлууд болон Октябрийн хувьсгалын ойн баярын хурал зэрэг хувьсгалын агуулгатай томоохон баяр ёслолын үед болдог хуралд биднийг урьж суулгадаг байлаа. Октябрийн баяраар Улаан талбайд хөдөлмөрчдийн баярын жагсаал болж дараа нь цэргийн парад болдог байлаа шүү дээ. Тэр үед ЗХУКН-ын удирдагчид, Зөвлөлт төрийн тэргүүнүүд Лениний мавзолейн бунхант индэр дээр зогсож, хөдөлмөрчдийн баярын жагсаал болон цэргийн парадыг хүлээн авдаг байсан юм. Бид нарыг Лениний мавзолейн яг дэргэд зогсоодог байлаа. Тэнд Засгийн газрын гишүүд, сайд нар, Гадаадын элчин сайд нар зогсоход зориулсан “тусгай зогсоол” байсан юм. Бид нар тэдэнтэй хамт зогсдог байлаа.

Манай сургууль их том номын сантай байсан юм. Бид нар В.И.Лениний нэрэмжит улсын төв номын сан, ЗХУКН-ын ТХ-ны дэргэдэх Марксизм-Ленинизмын институтийн номын сангаар үйлчлүүлдэг байлаа.

Яамдын сайд, тусгай газрын дарга нар, ажил нь их сайн явж байгаа үйлдвэр аж, ахуйн газрын дарга нар, хөдөлмөрийн баатрууд ирж бидэнд лекц уншиж, хийж байгаа ажлынхаа тухай болон амжилтанд хүрч байгаа арга, туршлагаасаа ярьдаг байлаа. Бид нар ч ажил сайтай байгаа үйлдвэр аж ахуйн газраар их очдог байлаа. Тэдний ажил байдалтай газар дээр нь танилцдаг байлаа. Ажлын туршлагыг нь судалдаг байлаа. Би тэнд суралцсан 3 жилийн хугацаанд их олон зүйлийг шинээр мэдэж, ойлгож авсан юм. Ялангуяа аж ахуйн ажлыг хөтлөн явуулж байсан арга, туршлага нь надад их зүйлийг бодогдуулдаг байлаа.

КЮ: Та нар Москвад чөлөөт цагаа яаж өнгөрөөдөг байсан бэ?

Ц Л: Би тэнд суралцсан 3 жилийнхээ хугацаанд Москвад байдаг бүх театрт орж юм үздэг байсан юм. Үүнтэй холбоотой нэг жижигхэн түүх би та нарт ярья л даа.

Бид нар анх сургуульдаа очихдоо орос хэл сайн мэддэггүй байлаа. Хүний ярьж байгааг бол бараг ойлгохгүй. Харин өөрсдөө ном сонин уншихаараа бага зэрэг ойлгоно. Тэгээд бидний өмнө “Явал орос хэлийг хурдан сурах вэ?” гэдэг асуудал маш хурцаар тавигдсан юм. Ингээд бид орос хэл хурдан сурах аргуудыг судлаж үзлээ. Тэгээд “Орос хэлийг сурах хамгийн хурдан арга бол орос бүсгүйтэй танилцах явдал юм байна! Энэ л хамгийн шилдэг сайн арга!” гэж бүгдээрээ санал нийлсэн юм.

Бид бүгдээрээ 27 орчим настай залуучууд явсан шүү дээ. Тэгээд бид гурав бидэнд орос хэл заах орос бүсгүйтэй танилцахаар шийдлээ. Тэр үед манай сургууль Москва төдийгүй, ЗХУ-ын хэмжээнд их нэр хүндтэй байлаа шүү дээ. Биднийг очих үед дайны ул мөр сайн арилаагүй байсан үе. Жирийн орос айл бол төмс, талх голдуу хоолтой байсан үе. Тэр үед орос эрчүүд архинд их ордог байлаа Үүний учрыг би хожим ойлгосон юм. Дайны үед оросын ажилчин хүн үдийн цайнаараа нэг зүсэм талх, нэг крушка пиво л уудаг байж. Тэр талх нь хар талх л даа. Тэр талхан дээрээ горчица түрхэж байгаад иднэ шүү дээ. Өөр идэх юм байхгүй. Ингээд талхаа идээд пиво уудаг байж. Пиво чинь архины төрлийн ундаа болохоор аажимдаа архинд орох замыг нь тавьдаг байж.

Тэр үед эр хүн их цөөрсөн байсан юм. ЗХУ дайнд их олон сая хүнээ алдсан юм шүү дээ. Ийм шалтгаануудын улмаас орос эмэгтэйчүүд хэн ч байсан хамаагүй, гадаадын хүнтэй суух сонирхолтой байсан байх. Ялангуяа, манай сургуулийнхантай танилцах сонирхол орос бүсгүйчүүдийн дунд их байсан байж магадгүй. Гэхдээ тэр үед орос эмэгтэй хүнийг гадаадын хүнтэй суухыг зөвшөөрсөн хуульгүй байсан юм. Энэ асуудал бүр 1950-аад оны сүүлч хүрч байж шийдэгдсэн юм. Бид гурав тийм

хууль ЗХУ-д байдаггүй талаар тэр үед мэдэж байсан уу, үгүй юу, бүү мэд. Харин Монголд бол орос эхнэртэй хүн байдгийг мэдэж байсан.

Ингээд бид нар манай сургуулийн ойролцоо нэг бүжгийн газар байгааг оллоо. Тэнд залуухан орос бүсгүйчүүд олноороо ирдэг болохыг нь мэдлээ. Тэгээд бүгдээрээ тэнд очиж бүжиг хийж байхаар болцгоолоо. Ингээд бид гурав тэнд очиж бүжгэнд ордог боллоо. Манай С.Дэлэг их сайхан бүжиглэдэг байлаа. Вальсийг бол сайхан эргэнэ шүү дээ. Тэр үед вальсаас өөр бүжиг хийдэггүй байсан юм. Одоогийн залуучуудын “Манго”, “Танго” зэрэг бүжгүүдийг хийдэггүй байсан юм. Бид хоёр бол С.Дэлэг шиг бүжиглэж чадахгүй л дээ. Гэхдээ бүжиглэх их дуртай байлаа. Оросууд бол сайхан бүжиглэнэ. Тэд нар нарийхан, өндөр гоолиг нуруутай болохоороо бүжиглэхээрээ их гоё харагдана. Ёстой л бүжиглэхийн төлөө төрсөн юм шиг санагддаг байлаа. Тэгээд нэг мэдсэн чинь бид гурав ч тэндээс салахаа байлаа. Бүжиг тарсны дараа хөгжим чихэнд сонгсогдоод, бүжиглэж байгаа хүмүүс нүдэнд харагдаад, хичээл дээрээ сууж чадахаа байгаад, орой унтахаа ч байлаа.

Ингэж явж байгаад бүгдээрээ нэг, нэг бүсгүйтэй танилцлаа. Миний танилцсан бүсгүй бол багш хүн байсан юм. Тэр ээжтэйгээ хамт хоёулаа Москва хотын захад амьдардаг байсан юм. Ээж нь нисэх онгоцны үйлдвэрт ажилладаг, өөрөө дунд сургуульд багшилдаг бүсгүй байлаа. Тэр их боловсролтой, ном уншиж, театр, музей үзэх их дуртай хүн байсан юм. Би тэр бүсгүйгээтэй танилцсаны буянаар 3 жилийн хугацаанд Москвад байдаг бүх театр, бүх музейг юм үзсэн юм. Москвад нийтдээ 33 том театр байдаг юм. Тэдний дотроос Их Театр, Бага театр, Вахтанговын нэрэмжит Драммын театр, Ермоловын нэрэмжит Драммын театр, Пушкиний нэрэмжит Драммын театр гэсэн хамгийн алдартай таван театр байдаг юм. Бид хоёр энэ 5 том театрт тавьдаг репертуарыг бүгдийг нь үзсэн юм.

Эхлээд надад хамгийн ойлгомжгүй зүйл бол сонгодог хөгжим байлаа. Миний найз хүүхэн Бетховен, Моцарт, Штраус, Шуберт, Шопен, Чайковский, Бах, Шостакович, Хачатурян нарын сонгодог хөгжмийн концертуудыг сонсохоор П.И.Чайковскийн нэрэмжит Москвагийн консерваторийн концертийн танхимд намайг дагуулаад очдог байлаа. Гэтэл миний нойр хүрээд, тоглолт эхлэнгүүт л сандал дээрээ унтаад өгсөн байдаг байлаа. Нөгөө найз хүүхэн маань хажуугаас чимхээд л сэрээнэ. Дахиад л унтчихна. Тэгсээр байтал аажимдаа сонгодог хөгжимийг бага зэрэг ойлгодог боллоо. Сүүлдээ бүр сонсох дуртай боллоо.

Тэгээд театраас гадна Москвагийн музей, зургийн үзэсгэлэнгүүдийг бүгдийг нь үзсэн юм. Заримдаа Ленинград явдаг байлаа. Ленинград бол дэлхийн хамгийн олон музейтэй хот шүү дээ. Бид нар хагас сайн өдөр хурдан галт тэргээр Ленинград орж юм үзээд, маргааш нь эргээд

ирдэг байлаа. Тэр үед Бүх Холбоотын радиогийн хэрэг эрхлэх газарт Москвагаас Монгол хэлээр явуулдаг нэвтрүүлгийн редакцид С.Дэлэг бид хоёр бас ажиллахаар болсон юм. Би лекторын ажил хийдэг байсан маань хэрэг боллоо. Сард бас 1000 рублийн цалин авдаг боллоо.

Бүх Холбоотын радиогийн хэрэг эрхлэх газрын амралтын газар нь Крымийн Хар далайн эрэг дээр байсан юм. Тэр нь хуучин Оросын эзэн хааны эзэмшилд байсан газар учир их сайхан байршилтай, сайхан байгальтай газар байсан юм. Би хавар сургуулийн амралт эхлэхээр орос бүсгүйгээ дагуулаад тэнд очиж 2 сар амардаг боллоо. Москвагаас машин, жолоочтой нь хөлсөлж аваад явдаг байлаа. Тэгээд амралтын газрынхаа ойролцоо байр аваад жолоочоо суулгачихдаг, өөрсдөө амралтынхаа байранд суудаг байлаа.

Хар далайн эрэг бол үзэх юм маш ихтэй, маш сайхан байгальтай газар шүү дээ. Бид нарын амардаг газраас баруун тийш холгүй Севастополь хот, зүүн тийш Кавказын уулс байдаг юм. Бид машинаараа тийшээ зугаалга зохиодог байлаа. Намар буцахдаа Кавказаас эсвэл Украйнаас олон төрлийн жимс аваад Москвад авч ирдэг байлаа. Манай найз бүсгүйн ээж нь бидний авч ирсэн жимсээр сайхан варень хийдэг байлаа. Бид нар ингэж амьдарч байлаа. Би тэр найз хүүхнийхээ ачаар хөгжим, театрыг ойлгодог болж, орос хэл сурсан юм.

Тэр үед би ном их авдаг байлаа. Бас алдартай симфони, оперийн дуунууд, зохиолын дуунуудын пластинка их авдаг байлаа. Би Москвагаас нэг ачааны машин номтой ирсэн юм. Тэнд ерөөсөө архи ууж, тамхи татаж сураагүй. Бүх цагаа сурахад, театр үзэх, хөгжим сонсоход зориулдаг байлаа. Долоо хоногий таван өдрийг бүгдийг нь сурахад зориулдаг байсан. Шөнө 2-3 цаг хүртэл ном уншдаг байлаа. “Надад дахиад сурах бололцоо олддохгүй учраас олдсон энэ бололцоогоо сайн ашиглая!” гэж боддог байлаа. Намайг Москвад сурч байхад манай МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга нар, төрийн том албаны хүмүүс хааяа Москвад очдог байлаа. Би МАХН-ын ТХ-нд ажиллаж байсан болохоор ихэнхтэй нь танил болсон байсан юм. Бид нар ирсэн хүмүүстэй уулзаж, нутаг орныхоо тухай сонин мэдээ сонсох дуртай байлаа.

И Л: Танай Коммунист намын дээд сургуульд сурч байсан гадаадын хүмүүсээс сургуулиа төгсөөд, нутагтаа очоод өөрийн орныхоо төрийн дээд удирдлагад орсон хүн байдаг уу?

Ц Л: Байдаг юм. Өөрийн орны засгийн газрын гишүүн, яамны сайдын албан тушаал хаших бол жирийн үзэгдэл. Харин улс орныхоо гол удирдагч болсон хүмүүсээс Румыний ерөнхийлөгч, Румыний Коммунист

намын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Николаэ Чаушескуг нэрлэж болох юм.

Н.Чаушеску бид нар хамт сурч байсан юм. Би 1956 оны 12-р сард Н.Чаушескугийн урилгаар МАХН-ын төлөөлөгчдийн тэргүүнээр Румыний Коммунист намын их хуралд оролцсон юм. Тэр үед би Коммунист намын дээд сургуулиаа төгсөөд ирсэн, Говь-Алтай аймгийн МАХН-ын хорооны нэгдүгээр нарийн бичгийн даргаар ажиллаж байсан юм. Тэр хуралд Хятадын Коммунист намын төлөөлөгчдийн тэргүүнээр БНХАУ-ын Батлан Хамгаалах яамны сайд Жү-Дэ ирсэн юм. ЗХУКН-ын төлөөлөгчдийг Украйны КН-ын нэгдүгээр нарийн бичгийн дарга тэргүүлэн ирж байсан юм. Тэр их хуралд олон орны КН-ын төлөөлөгчид ирсэн юм. Хурлын дараа Румыний ерөнхийлөгч Георгий Дээж, гадаадын төлөөлөгчдийг Бухарест хотын захад байдаг өөрийн ордондоо хүлээн авч уулзсан юм. Шинэ жил ч дөхсөн байсан. Тэгээд томоохон хүлээн авалт үдэшлэг зохиосон юм. Тэр хүлээн авалт үдэшлэг дээр хурлын төлөөлөгчид дугаар тогтоогоод, ерөнхийлөгч Георгий Дээжийн охинтой бүжиг хийж байлаа. Тэр бол мөнгөлөг цагаан үстэй, их царайлаг, сайхан охин байсан санагдаж байна. Ерөнхийлөгч Георгий Дээж өөрийн ордондоо охинтойгоо хоёулаа амьдардаг байсан юм билээ. Эхнэр нь нас барсан юм байж. Тэнд бидэнд ерөнхийлөгч Георгий Дээж нэг сонин юм үзүүлсэн юм. Бүжиг ид явагдаж байтал тэр:

-Одоо бүгдээрээ миний тоглоомын өрөөнд орно! гэж хэлэв. “Ерөнхийлөгчийн тоглоомын өрөө!” гэхээр би “Спорт тоглоомын өрөө!” гэж л ойлголоо л доо. Тэгээд бид ордны нэгдүгээр давхарт буулаа. Тэгтэл тэнд биднийг битүү хүүхдийн тоглоом өрсөн нэг өрөөнд оруулав. Хүүхдийн тоглоом бол ёстой янз бүрээрээ л байлаа. Маш их олон тоглоом өрсөн байлаа. Гэтэл тэр өрөө маань “Ерөнхийлөгчийн тоглоомын өрөө!” юм гэнэ. Ерөнхийлөгч оюуны хөдөлмөр хийгээд, их ядарсан үедээ тэр өрөөнд орж тоглодог юм гэнэ. Тэгтэл бидэнтэй хамт орсон гадаадын төлөөлөгчид нөгөө тоглоомуудаар өөрийн эрхгүй тоглож байна шүү. Тэр өрөөнөөс надад нэг сонин дурсамж үлдсэн юм. Тэр өрөөнд Хятадын КН-ын төлөөлөгчдийн тэргүүн, БНХАУ-ын Батлан хамгаалах яамны сайд, алдарт жанжин Жү-Дэ нөгөө тоглоомуудаар тоглоод л, үнэн голоосоо инээн, баясаж байсан нь одоо болтол мартагддаггүй юм. Үнэхээр насанд хүрсэн том хүн чинь хүүхдийн тоглоом харахаараа тоглох гээд байдаг юм билээ. Удаан хугацаанд оюуны хөдөлмөр хийж байгаа хүн, ийм аргаар ядаргаагаа тайлж болмоор санагдсан шүү. Их сонин арга олсон байгаа юм. Одоо бол “Стресс тайлна!” гээд янз бүрийн л арга хэрэглэж байна шүү дээ.

Тэр үед миний танил Николаэ Чаушеску маань Румыний Коммунист

намын ТХ-ны үзэл суртал хариуцсан нарийн бичгийн даргын алба хашиж байсан юм. Тэр Монголын төлөөлөгчдийг тусгайд нь хүлээн авч уулзаж байлаа. Энэ уулзалтан дээр Н.Чаушеску нэг зүйлийг ярьж байсан нь одоо болтол тод санагдаж явдаг юм. Румын улс бол байгалийн баялагаар ядуу орон боловч бага зэргийн нефтийн нөөцтэй юм байж. Тэгээд тэр “Нефтийнхээ нөөцийг Орос улсад алдахгүйг их хичээж байна!” гэж ярьж байсан юм. Ер нь Н.Чаушеску тэр үеэс л олон зүйлээр Зөвлөлт Холбоот Улсын Коммунист Нам (ЗХУКН)-тай санал зөрдөг, түүний үгийг сонсдоггүй, бие даасан бодолтой хүн байсан юм билээ. Бүх асуудлаа зөвхөн өөрсдөө шийддэг, ЗХУ-ын “зөвлөлгөө”-г авдаггүй байж. Сүүлд Н.Чаушеску Румынийн ерөнхийлөгч, КН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга болсон хойноо энэ байдлаа улам бататгаж чадсан юм билээ. 90-ээд онд дэлхийн социалист систем задран унахад, Румын улс ганцаараа гадаад өргүй социалист улс байсан шүү дээ. Бусад социалист орнуудын гадаад өр маш их болчихсон байсан юм. Харин түүний дотооддоо явуулж байсан бодлого нь зөв биш байсан байх. Түүний эхнэр Елена Чаушеску нөхрийнхөө өмнөөс төрийн хэрэгт оролцдог, төрийн сайд, дарга нарыг өөрийн дураар ажлаас нь халдаг, тансаг амьдралд хэтэрхий дуртай зэрэг маш их дутагдалтай байсан юм билээ. 1990-ээд онд Румынд Ардчилал, шинэчлэл маш огцом хэлбэрээр өрнөж, Николаэ Чаушеску, Елена Чаушеску хоёр баривчлагдаад, улмаар бүх дэлхийн нүдэн дээр цаазлагдсан шүү дээ. Ер нь гадаадын ч бай, дотоодын ч бай, эхнэр хүнийг төрийн хэрэгт оролцуулна гэдэг бол төрийн тэргүүнүүдийн хамгийн том алдаа юм л даа. Хувийн амьдрал, төрийн ажил хоёр заагтай л байх ёстой юм.

КЮ: Та Москвад Коммунист намын дээд сургуульд хэдэн жил сурсан юм бэ?

Ц Л: Гурван жил сурсан юм даа. Сургуулиа төгсөөд нутаг буцах боллоо. Нөгөө найз орос бүсгүйтэйгээ хамт буцахаар шийдлээ. Тэр маань ч хамт явна л гэдэг байлаа. Гэтэл орос эмэгтэй хүн гадаадын хүнтэй суух хууль байхгүй гэдэг том хэрэг босож ирлээ. Тэр үед хууль байхгүй ч Орос эмэгтэй хүн гадаадын хүнтэй суух асуудал нилээд гардаг байсан бололтой. Ийм тохиолдолд зөвшөөрлийг нь ЗХУ-ын Дээд Зөвлөл өгдөг байж. Тэр үед ЗХУ-ын Дээд Зөвлөлийн даргаар Климент Ефремович Ворошилов ажиллаж байсан юм. Тэгээд бид хоёр К.Е. Ворошиловтой уулзахаар шийдлээ. Кремельд бол энгийн хүнийг оруулахгүй шүү дээ. К.Ворошиловын хөдөлмөрчдийг хүлээн авдаг хуваарьтай тусгай өдөр байсан юм. Урьдчилж очоод тэр хуваарийн дагуу уулзах зөвшөөрөл авдаг байлаа. Гэхдээ Кремлийн “Хөдөлмөрчдийг хүлээн авах газар” нь

К.Е.Ворошиловтой уулзаад ярих асуудлыг нь судлаж үзээд, уулзуулах эсэхийг нь шийдэж, хариу өгнө шүү дээ. Бид нар хуваартай өдөр нь Кремлийн “Хөдөлмөрчдийг хүлээн авах газар”-г очлоо. Тэнд К.Ворошиловтой уулзах хүсэлтэй хүн маш олон байлаа. Бид нар бараг нэг бүтэн өдөр очерлоод тэнд орлоо. Тэгээд К.Е. Ворошиловтой уулзаад ярилцах асуудлаа хэлээд, зөвшөөрөл хүслээ. Ингээд хүлээгээд байлаа. Олон хоног хүлээлгэсний эцэст “Хүлээж авах боломжгүй!” гэсэн хариу өгсөн юм. Ингэж бид хоёрын хамтдаа Монгол явах хамаг төлөвлөгөө нурсан юм.

8 МАХН-ын ТХ-ны Марксизм-Ленинизмийн тасагт.

Ц Л: Ингээд би ганцаараа Монголдоо буцлаа. Намайг ирэх үед манай Лекторын товчоог өргөтгөж, томруулаад, МАХН-ын ТХ-ны “Марксизм-Ленинизмын тасаг” гэж нэрлэдэг болсон юм. Энэ шинэ тасгийн даргаар нь намайг томиллоо. ЗХУ-д 3 жил сурсан, орос хэлээр ярьдаг, бичдэг болсон, их урам зоригтой ажилдаа орж байлаа шүү дээ. Миний нас 30 хүрч байлаа. Энэ бол 1953 оны намар юм. Ингээд ажилдаа ороод, цаашид хийх ажлынхаа тухай бодлоо. Урьд нь бид нар дандаа лекц бэлтгээд, түүнийгээ олон түмэнд ярьж таниулж ирсэн билээ. Ажлын ийм арга барил нэг л хангалтгүй санагдаад байдаг боллоо. Тэгээд “Марксизм-ленинизмын онолын сайн бүтээл хийе!” гэдэг бодол төрдөг боллоо. Энэ талаар би тасгийнхаа ажилтнуудтай ярьж үзлээ. Тэгээд марксизм-ленинизмын 3 үндэс болсон “Диалектик материализм”, “Түүхийн материализм”, “Марксист улс төр, эдийн засгийн ухаан”-аар онолын ном бичихээр шийдлээ. Ингээд бүгдээрээ хамтарч бичээд энэ сэдвээр гурван ном хэвлүүлсэн юм. Энэ гурван ном маань олон жил манай Их, дээд сургуулиудын багш, оюутнуудын “ширээний ном” болж байлаа.

Тэр үед ЗХУ-ын Шинжлэх Ухааны Академи, Монгол улсын Судар бичгийн хүрээлэнтэй (сүүлд Монголын Шинжлэх Ухааны Академи /ШУА/ болж өргөжсөн-ред.) хамтраад Монголын түүхийн шинэ ном бичиж хэвлүүлэх ажил эхэлсэн юм. Энэ ажилд Монголын талаас Б.Ширэндэв гуайгаар ахлуулсан эрдэмтэд оролцож байлаа. Ингээд Монголын түүхийн нэг боть шинэ ном Мосвад орос хэл дээр хэвлэгдэн гарлаа. Манай марксизм-ленинизмын тасаг тэр номыг нэг сарын дотор орос хэлнээс орчуулж, монгол хэл дээр хэвлүүлж байлаа. Тэнд ажиллаж эхлээд байхдаа миний нэг байнга бодож явдаг байсан зүйл бол Монгол улсын цаашдын хөгжлийн асуудал байсан юм. “Монгол орон цаашдаа яаж хөгжих ёстой вэ?” гэдэг асуудлыг их боддог байлаа. Энэ талаар тэр үед МАХН болон төр, засгийн зүгээс баримталсан тодорхой бодлого, онолын чиг баримжаа

байгаагүй юм. Монгол орныг ирээдүйд ямар орон болгож хөгжүүлэх талаар яг тодорхой төлөвлөгөө, онолын чиг шугам хаана ч байсангүй. Бүх юм нэг л урсгалаараа яваад байдаг байлаа. “Бодит байдалд зөв үнэлэлт, дүгнэлт хийгээд, цаашдын хөгжлийн зөв чиг хандлагыг тогтоох хэрэгтэй!” гэж боддог боллоо. Тэгээд энэ сэдвээр олон хүнтэй ярилцаж үзлээ. Зарим хүмүүсээр шинэ санаа дэвшүүлсэн өгүүлэл бичүүлдэг боллоо. Тийм онолын өгүүлүүдээ “Үнэн” сонин болон “Намын амьдрал” сэтгүүлүүдэд хэвлүүлдэг боллоо. Гэтэл зарим үед бидний бичсэн өгүүлүүдийг сонин сэтгүүлүүдийн редакцийн газрууд хэвлэхээс татгалзах хандлага гаргаж эхэллээ. Тэд нар ийм өгүүлүүд хэвлэхээс айгаад, болгоомжлоод байдаг боллоо. Тэр үед МАХН-ын ТХ-ны Хэвлэлийн тасгийн даргаар Ц.Намсрай гэдэг хүн ажиллаж байсан юм. Энэ Хэвлэлийн тасгаас сонин, сэтгүүлүүдийн редакциуд, хэвлэлийн газруудад үүрэг, даалгаврыг шууд өгдөг байсан юм. МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга тэд нартай байнга уулзаж, ажлын чиглэл, үүрэг, даалгавар өгдөг байсан юм. Тэр үед хэвлэл бол хатуу хяналтанд ороод эхэлж байсан үе юм шүү. Хэвлэлийн эрх чөлөө энэ үеэс төгсгөл болсон юм. Хэвлэл дээр голдуу эрх барьж байгаа МАХН-ын бодлого, шийдвэр л гардаг байсан юм. Түүнээс өөр үзэл бодолтой өгүүлэл гарах ховор болоод ирсэн юм. Ингээд би энэ асуудлаар Ю.Цэдэнбалтай ярихаар шийдлээ. Ингээд нэг өдөр түүний өрөөнд орлоо. Би түүнтэй байнга уулздаг байсан юм. Харин ийм асуудлаар анх удаа орж байгаа юм.

Ю.Цэдэнбал :

-Чи ямар асуудал ярихаар ирэв? гэж асууж байна.

-Тантай ярих нэг чухал асуудал байна. Надад таны тусламж хэрэгтэй байна. Бид нар Монголын хэтийн хөгжлийн талаар санал дэвшүүлсэн онолын өгүүлүүд бичиж байгаа юм. Цаашдаа МАХН-аас манай орны хэтийн хөгжлийн хандлагыг тодорхойлох, түүний онолын үндсийг боловсруулахад хэрэг болох байх гэж бодсон юм! Гэтэл сонин, сэтгүүлийн редакцийн газрууд зарим өгүүлүүдийг маань хэвлэж өгөхөөс татгалздаг болоод байна! гээд ярилаа. “Ю.Цэдэнбал дарга миний ярьж байгаа асуудлыг дэмжих байх!” гэж би уг нь их найдаж байсан юм л даа. Гэтэл би шал эсрэг хариу авлаа.

-Чи энэ онолынхоо асуудлыг хойшлуулж бай! Энэ талаар манай намаас ярилцах цаг нь болоогүй байна! гэж тэр маш хүйтэн, хөндий хариулж байна. Энэ үгийг сонсоод миний оргилсон сэтгэл дээр ус хийсэн юм шиг санагдаж байж билээ. Тэгээд би:

-Манай нам улс орноо хөгжүүлэх ямар ч чиг баримжаагүй, бэлтгэлгүй, бусдыг дуурайгаад, бусдын үгээр ороод, харанхуйд төөрсөн юм шиг, очих газраа мэдэхгүй тэмтэрч явах болж байна уу? Онолгүй нам сохортой адил,

практикгүй нам хазгартай адил бус уу? гэж ширүүхэн асуулаа. Ингээд бид хоёрын яриа ч олигтой болсонгүй. Би тэндээс гарлаа. Гарахдаа үүдийг нь гаднаас нь чангахан хаачихлаа. Бид хоёрын зөрчил анх ингэж эхэлсэн юм.

Үүнээс хойш Ю.Цэдэнбал даргын энэ хариунд дурамжхан явдаг боллоо. Бидний хооронд ийм яриа болоод удаагүй байтал намайг Говь-Алтай аймаг дахь МАХН-ын хорооны нэгдүгээр нарийн бичгийн даргаар томилсон шийдвэр гарсан юм. Энэ бол намайг МАХН-ын онолын асуудлаас хөндийрүүлэх зорилготой шийдвэр гэж би одоо болтол боддог юм. Аймгийн намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга бол онолын асуудлаасаа илүү аж ахуйн ажилд анхаарах ёстой юм л даа. Ер нь Ю.Цэдэнбал гуай бол дэргэдээ марксизм-ленинизмын онолын мэдлэгтэй хүн байлгахаас их айдаг байсан нь сүүлд тодорхой болсон юм. Өөрөө энэ талын онолын системтэй мэдлэггүй хүн байсантай нь холбоотой байсан байж болох юм. “ЗХУКН-ын явсан замаар, хойноос нь л яваад байвал, алдаа гарахгүй!” гэсэн ганц л бодол түүнд амь бөхтэй оршсоор байсан юм. Болж байгаа үйл явдлуудад задлан шинжилгээ хийж, зөв үнэлэлт дүгнэлт өгөх онолын бэлтгэл муутай байсан явдал нь бусдын явсан замаар мухар, сохроор дагаж явах байдалд хүргэж байсан байж магадгүй.

1956 онд Венгерт, 1968 онд Чехословакад болсон үйл явдлууд, Ю.Цэдэнбалын энэ хаалттай, түгжигдмэл байдал улам лавшрахад хүчтэй нөлөөлсөн байж магадгүй. Уг нь энэ болсон үйл явдлуудад маш гүнзгий дүн шинжилгээ хийж, түүнээс гарсан сургамжуудыг өөрсдийнхөө цаашдын ажилд ашиглах хэрэгтэй байсан юм. Хэрвээ бид нар тэгж чадсан бол 1990 оны эхээр зах, зээлийн эдийн засгийн системд шилжих үйл явц эхлэхэд тэгтлээ “хөгөө хөлдөө чирэхгүй” ч байсан байж магадгүй. Болсон үйл явдлуудад Венгериин болон Чехословакийн засгийн эрх барьж байсан намууд зөв зүйтэй дүн шинжилгээ хийж, зөв зүйтэй үнэлэлт, дүгнэлтийг өгч, түүний сургамжийг өөрсдийн цаашдын үйл ажиллагаандаа ашиглаж чадсан учир эдгээр орнууд нэг хэсэгтээ зүүн европын социалист орнуудын дотроос өөрийн эдийн засгийг хамгийн хурдацтай хөгжүүлж чадсан шүү дээ. 1990-ээд онд дэлхийн социалист систем задран унаж, зүүн европын социалист байсан орнуудыг хамарсан эдийн засгийн хямралаас эдгээр орнууд хамгийн хурдан, хохирол багатайгаар гарч чадсан юм.

Ю.Цэдэнбал өөрөө онолын талын бэлтгэл тааруухан байсан болохоор энэ талаар сайн бэлтгэгдсэн хүмүүсийг ямагт дэргэдээ байлгаж, тэдний хүчийг нь ашигладаг байсан юм. Гэвч эдгээр хүмүүсийн хувь заяа ямагт муугаар төгсдөг байлаа. Ю.Цэдэнбал тэдний хүчийг нэг хэсэг ашиглаж байгаад, сүүлдээ элдэв шалтгаан олж, буруутгаад, заримыг нь албан тушаал бууруулж өөр ажилд томилоод, заримыг нь хугацаагүй цөллөгт явуулдаг байсан юм. Ийм маягаар цөлөгдсөн хүмүүсийн дотроос хамгийн

харамсал төрүүлдэг нь Д.Төмөр-Очир, Д.Цэнд нар байсан юм. Тэд нар эх орондоо ихийг бүтээж чадах хүмүүс байсан юм шүү. Тэдний амьдрал, хувь заяа нэн харамсалтайгаар төгссөнийг монголчууд бид бүгдээрээ мэднэ. Ийм маягаар цөлөгдсөн Төмөрбаатар, Лхамжав нар цэл залуугаараа нас барж байлаа. Төмөрбаатар нь Хөвсгөл аймагт цөллөгөнд байхдаа нас барсан юм. Лхамжав нь шоронд байж байгаад бас нас барлаа шүү дээ. Дандаа философийн ухаанаар эрдмийн зэрэг /Ph.D/ хамгаалсан хүмүүс байсан юм.

9 Би Говь-Алтай аймагт ирлээ.

Ц Л: Ингээд би 1954 онд өөрийн төрж, өссөн Говь-Алтай аймагтаа ирлээ. Би энэ болтол ерөөсөө аж ахуйн ажил хийж байсангүй. Анх удаа аж ахуйн ийм том ажил удирдах боллоо. Дадлага, туршлага байхгүй ийм нэг хүн л ирж байгаа юм. Маршал Х.Чойбалсангийн үед сайд, дарга нарыг дагаж хөдөө явж байхдаа зарим нэг ажлын хийх аргыг харж, ажиглаж байсан маань одоо хэрэг болж эхлэв. Маршал бол бусдаас шударга байхыг л шаарддаг байсан хүн. Бялдууч, долигонуур хүнд их дургүй хүн байсан юм. Миний өөрийн эцэг ч бас тийм зантай хүн байлаа. Энэ байдал надад тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байх. Говь-Алтай аймагт очоод шинэ ажлаа хүлээж авлаа. Аймгийн МАХН-ын хорооны ажилтнуудтай уузаж, танилцлаа. Тэгээд тэдэнтэй хийсэн уулзалт дээр би хэд, хэдэн зүйлийг онцлож ярьсан юм.

-Тус аймагт улсаас өгсөн аж ахуйн төлөвлөгөөт ажлуудыг цаг хугацаанд нь чанар сайтай биелүүлэхийн төлөө бүх бололцоогоо дайчлан ажиллана. Энэ чиглэлд бүгдээрээ эв, нэгдэлтэй хамтарч ажиллахыг хүсэж байна.

-Монгол улсын Үндсэн хууль болон бусад мөрдөгдөж байгаа хууль, дүрмийн хүрээнд бүх үйл ажиллагаагаа зохицуулж явуулна. Ямар нэгэн байдлаар хууль, дүрэм зөрчсөн үйлдэл гаргахгүй байхыг хүн бүр хичээн ажиллах хэрэгтэй. Хууль, дүрмийг санаатай болон санамсаргүй зөрчсөн хүн өөрөө хариуцлагаа бүрэн хүлээж байна. Энэ асуудал дээр нэг нутаг, ус, танил талын асуудал байж болохгүй.

-Хүн бүрийн ажлыг түүний үр дүнгээр нь үнэлэнэ. Хэн идэвхи санаачлагатай, сайн ажиллана тэр хүн төдий чинээ сайн үнэлгээ авна.

-Одоо ажиллаж байгаа ажилтнуудыг өөр ажилд шилжүүлэх, эсвэл өөр шинэ ажилтанг авах зэрэг өөрчлөлт хийхгүй. Бүгд өөрийн хийж байсан хуучин ажил, үүргээ гүйцэтгээд явах хэрэгтэй. Харин ажлын явцад үр дүнг нь харгалзаж, өөрчлөлт орж болох юм гэж ярьсан юм.

Энэ уулзалтын дараа би өөрөө аймгийнхаа сумдаар явж ажил байдалтай нь танилцахаар шийдлээ. Тэр үед Говь-Алтай аймаг 17 сумтай

байсан юм. Хөдөө аж ахуй (ХАА)-н нэгдэл арай байгуулагдаагүй байсан болохоор ардууд өөр өөрсдийнхээ хувийн малыг маллаад амьдарч байлаа. Малаас авах түүхий эдээ өөрсдөө боловсруулаад, хэрэгтэй зүйлээ өөрсдөө хийгээд, эсгийгээ хийгээд, сур аргамжаа элдээд, цагаан идээгээ боловсруулаад амьдарч байлаа. Энэ чинь манай хуучин уламжлалт амьдрал шүү дээ. Бид олон үеийнхээ туршид ийм л амьдралаар амьдарч ирсэн юм. Харин дайны жилүүдэд энэ амьдралд жаахан өөрчлөлт орсон юм.

Тэр үед “Албан журам” гэдэг шинэ зүйл гарч ирсэн юм. Ардууд өөрсдийн малаас авдаг арьс, шир, үс, ноос зэрэг түүхий эд болон сүү, мах, тосыг улсаас тогтоосон хатуу үнээр улсад худалддаг болсон юм. Үнэ нь ч их хямд л даа. Айл бүрт малынх нь тоо, толгойд тааруулаад “Албан журам” ноогдуулдаг байлаа. Ийм шинэ зүйл нэвтэрснээр хувийн малын өсөлт буурч эхэлсэн юм. Олон малтай болчихвол “Албан журам”-аар улсад худалдах зүйл нь нэмэгдэнэ шүү дээ. Энэ нь ардуудад их төвөгтэй ажил болж хувирсан байна. Үүний зэрэгцээ мал хээлтүүлгийн ажлыг улс хяналтандаа авсан юм. Мал хээлтүүлгийн ажлыг жилд нэг удаа зохиож байх журам мөрдүүлж эхэлсэн юм. Ингээд Говь-Алтай аймгийн мал 40-өөд оноос 50-аад оны дунд үеийг хүртэл өсөөгүй юм.

Тэр үед нэг аймгийн ажил нь сайн байна уу, муу байна уу гэдгийг нь малынх нь өсөлтөөр дүгнэдэг байсан юм. Говь-Алтай аймаг мал нь өсөхөө байсан болохоор улсын хэмжээнд ажил нь муу явж байгаа аймгийн тоонд ордог байлаа. Би Говь-Алтай аймгийн сумдаар явж байхдаа орон нутагтаа нэр хүндтэй, хуучин төр, засгийн ажил хийж явсан хүмүүстэй зориуд очиж уулздаг байлаа. Ингээд Д.Гончиг гэдэг хүнтэй уулзсан юм. Тэр хүнтэй аймгийн мал өсөхөө байсан шалтгааны тухай нилээд ярилаа. Гэтэл тэр хүн хэлж байна:

-Одоо мал өсөхгүй байна! гэж л ярих юм. Уг нь манай нутагт малыг жилд хоёр төллөдөг байсан юм шүү дээ! Мал хээлтүүлгийн ажлыг төр, засаг хяналтандаа авлаа. Хуц, ухныг нь тусгайд нь хариулдаг боллоо. Ард түмний мал өсөөд, олон болоод ирэхээр “Албан журам” нь нэмэгдээд байна. Урьдын малын зарлагаас одоогийн зарлага өндөр байна. Урьд бол зарлага байсан юм. Гэхдээ мал хоёр төллөж байсан болохоор нэг төллөлтөөр нь зарлагаа нөхдөг, нөгөө төллөлтөөр нь малын өсөлтийг нь хангадаг байлаа шүү дээ! гээд ярьж байна.

Энэ яриа надад их сонин сэтгэгдэл төрүүлсэн юм. Үнэхээр намайг бага сургуульд сурч байх үед манайх малаа хоёр төллөж байснаа саналаа. Хоёр дахиа төллөсөн хонины төлөөр эцэг малыг тавьдаг байснаа саналаа. Тийм мал чинь тэвчээртэй сайн мал байдаг юм л даа. “Малынхаа тоо, толгойд өсгөдөг, үржлийнх нь ажлыг зохицуулдаг ардын арга байсныг өөрчилсөн

нь мал өсөхгүй болох нэг шалтгаан болжээ!” гэж бодогддог боллоо. Тэгээд “Одооноос эхлээд аймгийнхаа малыг жилд хоёр удаа төллөвөл яадаг бол?” гэж боддог боллоо. Ингээд энэ асуудлыг аймгийн МАХН-ын хорооны зарим нөхөдүүдтэй ярьж үзлээ. Зарим хүмүүс хуучин хэрэглэж байсан арга учир зөвшөөрч байна. Харин зарим хүмүүс “Энэ талаар Хөдөө Аж Ахуйн Яам(ХААЯ)-наас албан ёсны зөвшөөрөл авах хэрэгтэй байх!” гэж их болгоомжилж байна. Ингээд санал хоёр хуваагдах янзтай байлаа.

Би энэ ажлыг ХААЯ-наас зөвшөөрөл авахгүйгээр хийхээр шийдлээ. Энд нэг учир байсан юм. Тэр үед ямар нэгэн шинэ ажил хийхийг хүсвэл энэ асуудлыг эхлээд тухайн салбарыг хариуцсан яаманд нь танилцуулах ёстой байв. Гэтэл манай яам, тамгын газрууд шинэ ажил хийх ямар ч санаачлагыг бараг хүлээж авдаггүй, дэмждэггүй байлаа шүү дээ. Төрийн яамдуудын дээд талд нь Төлөвлөгөөний комисс, түүний дээд талд нь Сайд нарын зөвлөл, түүний дээд талд нь МАХН-ын Төв Хороо оршиж байлаа. Энэ бүгдийн хамгийн дээд талд нь Улс Төрийн Товчоо байдаг, түүнийг Ерөнхий нарийн бичгийн дарга Ю. Цэдэнбал удирдаж байв. Ийм тогтолцоотой байлаа. Энэ бүх дамжлагыг бүгдийг нь дамжиж явж байж ямар нэгэн шийдвэр гардаг байв. Маш их удаж, хэдэн сар, жилээр хүлээлгэж байж нэг шийдвэр гарна. Гарсан шийдвэр нь нөгөө ажлын анхны төлөвлөгөөнөөс өөрчлөгдөөд, шал өөр төлөвлөгөө болоод эсвэл түүнийг хийхэд шаардлагатай төсөв хөрөнгө нь бүр хасагдаад, хийх ямар ч боломжгүй юм болоод гарч ирдэг байв. Ихэнхдээ зөвшөөрөл огт өгөхгүй, нөгөө оруулсан асуудлыг бүр хаачихдаг байв. Тэр ажлыг хийхээр санаачилж, төлөвлөсөн хүмүүс өөрсдийгээ хамгаалаад заавал хийх гэж зүтгэвэл, буруудаад бүр заримдаа шийтгүүлээд дуусдаг байв. Бүр цаашилбал улс төрийн том асуудал болоод шорон, гяндандаа хүрнэ шүү дээ. Ингэж сайн ажил санаачилсныхаа төлөө шийтгүүлээд, ажлаасаа халагдаад, хаягдсан маш олон хүн байсан юм. Тэр үед том, бага ямар нэгэн асуудлыг аль нэг яамны мэргэжилтэнд нь танилцуулбал дээрээ байгаа дарга, сайд нартаа танилцуулдаггүй, сайд, дарга нарт нь танилцуулбал мэргэжилтэндээ танилцуулдаггүй байлаа шүү дээ. Бүгд шийтгүүлэхээс айж байгаа юм. Хожим би “САА-нуудын удирдах” ажиллаж байхдаа ийм байдалтай алхам тутамдаа тулгарч байв. Маш хэцүү. Тэр үед би өөрийн санаачилсан, хийхийг зорьсон олон ажлаа олон янзын арга хэрэглэж Улс Төрийн Товчоогоор зөвшөөрүүлж байлаа. Олон жил ийм нөхцөлд ажиллахаар сүүлдээ ажил хийх ямар ч урам зориггүй болдог юм билээ. Энэ талаар би дараа ярья. Бид нар тэр үед Говь-Алтай аймгийн малыг жилд хоёр удаа төллүүлэх асуудлаар ХААЯ-аас зөвшөөрөл хүссэн бол бас л ийм түүх эхлэх байсныг би сайн мэдэж байсан юм аа. Бидний энэ ажил амжилтгүй болбол ямар том шийтгэл ирэхийг би бараг мэдэж

байсан. Харин амжилттай болбол юу болохыг сайн төсөөлөхгүй байв. Ямар ч байсан “Говь-Алтай аймаг ажил муутай!” гэдэг олон жил яригдсан ярианаас салах байх гэсэн найдвар бол байсан юм. Энэ бол миний өмнө тулгарсан анхны том сорилт байв.

Тэгээд би миний бодлыг дэмжиж байгаа хүмүүс бас байсан болохоор энэ ажлыг хийгээд үзэхээр шийдлээ. Тэгээд Аймгийн МАХН-ын бүгд хурлыг зарлан хуралдууллаа. Энэ хурлаар аймгийн малыг жилд хоёр удаа төллөж байх тухай албан ёсны шийдвэр гаргуулж авлаа. Харин аймгийн хангайн бүсэд багтаж байсан 3-4 сумын малыг энэ ажилд хамруулахгүй байхаар шийдлээ. Тэр сумдад намар эрт хүйтэрдэг учир мал төллөж дуусаагүй байхад цас орвол мал, хүн хоёрт бэрхшээл учирч, малын хорогдол нэмэгдэж болзошгүй байсан юм.

Ингээд бид нар хавар эрт хуц, ухнаа сүрэгтэйгээ нийлүүлээд тавьчихлаа. Тэр жил их сайхан зун боллоо. Мал сайхан зушлаа. Намар мал дахиад төллөж эхэллээ. Ингээд манай аймгийн мал жилийн эцсийн тооллогоор өссөн дүнтэй гарлаа. Бид энэ ажлыг цааш үргэлжлүүлэхээр шийдлээ. Гэхдээ сумдынхаа байршлыг харгалзаад, жил бүр биш нэг жил өнжөөд хийж байхаар боллоо. Энэ ажлын дүнд манай аймгийн мал жил дараалан өссөн дүнтэй гарлаа. Малаа өсгөх төлөвлөгөөг 3 жил дараалан биелүүлж, улсад 3 жил дараалан түрүүлээ. Ингээд тэргүүний ажилтай аймагт шилжин явдаг “Улаан туг”-ийг 3 жил дараалан авлаа. Засгийн газар манай аймгийн ажлыг өндөр үнэлэж, 300 мянган төгрөгөөр шагнаж байлаа. Хүмүүсийн идэвхи их сэргэж ирлээ.

Бид нар шагналынхаа мөнгөөр аймгийнхаа төвд 2 давхар музейн барилгыг босголоо. Тэр их сайхан музей болсон юм. Энэ бол манай улсын хэмжээнд анхны орон нутгийн музей боллоо. Би өөрөө музейн барилгын хар зургийг нь зурж байлаа. Энэ чинь 1956 оны хэрэг явдал шүү дээ. Бид орон нутагтаа үзмэр цуглуулах ажлыг зохион байгуулсан юм. Түүх, соёлын их ховор, сайхан үзмэрүүд цугларлаа. Бидний цуглуулга дотор “Зүүн гарын хаант улс”-ын хаан Галдан бошогтын хэрэглэж байсан эмээл орж ирсэн байлаа. Энэ мэт маш ховор үзмэрүүд олон цугласан юм. Одоо тэр музейд байгаа байх.

Аймгийнхаа сургууль, эмнэлэгийг уурын халаагууртай болголоо. Айл, өрхүүдийг төмөр зуух хэрэглэдэг болгох ажлыг зохион байгууллаа. Үүнээс өмнө манай аймгийн бүх айл тулгыг л хэрэглэдэг байсан юм. Төмөр зуух хэрэглэдэг болсноор нүүрсийг түлшинд хэрэглэх боломжтой болсон юм. Манай Алтай нутаг бол мод багатай учир түлшний асуудал маш хүнд асуудал болж байсан юм. Нүүрсийг огт хэрэглэдэггүй байлаа. Гэтэл Алтай бол чулуун нүүрсээр маш баян нутаг юм шүү дээ. Төмөр зуух хэрэглэснээр түлшний асуудлыг ингэж бүрэн шийдэж чадсан юм.

Бид нар бас аймгийнхаа төвд хиймэл нуур байгууллаа. Манай аймгийн төв бол их хуурайшмал агаартай юм. Хиймэл нуур хийвэл агаарын чийгшилтэнд эерэг нөлөө үзүүлж болохоор санагдсан юм. Бурхан Буудай уулнаас эх авсан Чацарганатын голыг Улаан бухын шуудуугаар урсуулж, Халиуны хоолойг усалдаг болголоо. “Улаан бухын шуудуу” гэдэг бол хуучин дарагдаад хэрэглэхгүй болсон суваг байсан юм. Манай нутаг өндөр уулын бүс учир морь, машинтай хүн явахад их хүндрэл учруулсан өндөр, өндөр даваа олонтой нутаг л даа. Тэгээд бид нар хэд хэдэн айхтар өндөр даваануудыг сэтлэж, намхан болгож, замыг нь засаад хүн явахад эвтэйхэн болголоо.

Манай нутагт “таана” гэдэг өвс их ургадаг юм. Намар ургац нь гүйцдэг, мал идэхэд тэжээл сайтай, сонгинолог ургамал юм. Түүнийг намар ид тэжээллэг байхад нь түүгээд давстай хольж хатаагаад, малын тэжээл хийдэг боллоо. Өвөл усанд дэвтээгээд, зутарсан малд өгдөг юм. Ийм тэжээлийг зутарсан малд маш жаахан өгөхөд л хурдан сэргэдэг юм л даа. Ийм тэжээлийг ард түмэн дээр үед өөрсдөө бэлтгэж авдаг байсан юм. Бид нар ийм тэжээлийг бэлтгэж авах ажлыг аймгийнхаа хэмжээнд зохион байгуулдаг боллоо. Ингэж нэгдсэн журмаар сайн зохион байгуулахгүй бол зарим хүн тэжээлээ хийгээд, зарим нь хийхгүй байж байгаад өвөл цас их орсон үед мал зутарч, хорогдол их гарна шүү дээ.

Манай аймаг байгалын урсгал усгүй юм. Усгүйгээс болоод малын бэлчээрт тохиромжтой их сайхан нутгуудыг ашиглаж чаддаггүй байлаа. Манай аймгийн хойд талаар Завхан гол, Байдрагийн гол гэсэн хоёр сайхан гол урсаад өнгөрдөг юм. Тэр хоёр голын дунд Гуулингийн тал гэдэг маш уудам, саруул сайхан тал нутаг байдаг юм. Тэнд гурван аймгийн ардууд адуугаа оторлодог байлаа. Харин урсгал ус байхгүй болохоор айл нутаглаж чаддаггүй байсан юм. Устай бол олон айл нутаглаж, олон мал оторлох боломжтой сайхан нутаг л даа. Би нэг удаа Дэлгэр суманд ажлаар явж байгаад нэг айлд хонох боллоо. Гэрийн эзэнтэй малын бэлчээр, усны тухай нилээд ярилаа. Тэр хүн нилээд юм мэддэг хүн шиг санагдсан юм. Тэр хүн надад нэг домог ярьж өгөв. “Яваандаа энэ Завхан гол, Байдрагийн голууд чинь Гуулингийн тал дундуур урсаад, Шалын хоолойд уулзаж, нэг гол болоод, Бэгэрийн хонхорт очиж тогтох юм гэнэ билээ!” гэж ард түмний дунд олон жил яригдсан домгийг ярьж өглөө. Түүнээс хойш надад энэ домгийн агуулга сонин санагдаад байдаг боллоо. Ер нь ард түмэн өнө эртнээс нааш Завхан гол, Байдрагийн голын усыг л энэ Гуулингийн тал дундуур урсуулахыг мөрөөдөж, энэ домгийг зохиосон юм шиг санагдаад байдаг боллоо. Ингээд ер нь энэ ажлыг “хийгээд үзвэл яадаг юм бол?” гэж боддог боллоо. Тэгээд энэ санаагаа аймгийн МАХН-ын хорооныхоо нөхдүүдэд ярьж үзлээ. Тэгтэл тэд нар ч ийм ажлыг хийгээд

үзэх сонирхолтой байгаа нь ойлгомжтой боллоо.

Ингээд Завхан голын усыг Гуулингийн тал дундуур урсуулах шуудуу малтах ажил эхэллээ. Тэнд ойрхон сумдын 18-45 насны бүх залуучуудыг цуглууллаа. Нийтдээ 3000 орчим хүн цугларлаа. Ингээд шуудуу ухах ажилдаа орлоо. Шуудуугаа ухаж дууслаа. Тэгээд Завхан голын усыг нь нэг газар боож байгаад, нөгөө шуудуугаараа урсууллаа. Ус бидний ухсан шуудуугаар 8 км урсаад нэг гүвээнд тулаад зогслоо. Түүнийг давуулж урсуулах гээд чадсангүй. Бид шуудуу ухах бүх ажлаа гар аргаар хийсэн болохоор ямар нэгэн техникийн горим алдагдсан бололтой. Биднийг ажлаа зогсоохоор шийдээд байтал Хөдөө Аж Ахуйн Яамнаас нэг мэргэжилтэн ирлээ. Бид нар түүнд бүх ажлаа танилцууллаа. Хаана ямар алдаа гаргасанаа сайн тогтоож чадахгүй байгаагаа ч хэллээ. Ингээд ажил зогслоо. Энэ ажлаа би сүүлд Хөдөө Аж Ахуйн Яамны нэгдүгээр орлогч сайд байхдаа гүйцээсэн юм. Тэр үед манай яамны сайд Н.Жагварал гуай байсан юм. Н.Жагварал гуай бид хоёр их сайхан харилцаатай байлаа л даа. Тэр миний хийж байгаа ажлыг ямагт дэмждэг, өндөр үнэлдэг байсан юм. Тэр өөрөө их нэр хүндтэй, мэдлэг боловсрол сайтай хүн байсан юм. Н.Жагварал гуай тэр үед МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүн байсан бөгөөд түүний хэлсэн үгийг УТТ-ны хурал дээр хүндэтгэн хүлээн авч сонсдог байсан юм. Тэр Москвад эдийн засгийн ухаанаар эрдмийн зэрэг /Sc.D/ хамгаалж ирээд, манай яамны сайд болсон юм. Тэр үед ХААЯ хоёр орлогч сайдтай байлаа. Би Сангийн аж ахуй (САА)-н асуудал эрхэлсэн нэгдүгээр орлогч сайд, нөгөө орлогч нь Хөдөө аж ахуйн нэгдлийн асуудал эрхэлдэг байсан юм. Энэ ажлыг Д.Балжинням хийдэг болоод байсан юм.

1958 оны үед манай ХАА-г хөгжүүлэхэд зориулж, ЗХУ-аас 30 сая рублийн буцалтгүй тусламж өгсөн юм. Н.Жагварал сайд Д.Балжинням бид хоёрыг нэг өдөр дуудаж уулзаад, энэ буцалтгүй тусламжийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах талаар саналаа боловсруулж ирэх үүрэг өглөө. Түүнээс хойш долоо хоног өнгөрөөд Н.Жагварал сайд бид хоёрыг дахиад дуудлаа. Бид нар сайдын өрөөнд ирж, өөр өөрсдийн саналыг түүнд танилцууллаа. Эхлээд Д.Балжинням өөрийн саналыг танилцуулав. Тэр энэ тусламжийн хөрөнгөөр трактор авч ХАА-н бүх нэгдлүүдэд өгөх санал боловсруулсан байлаа. Д.Балжинямыг саналаа хэлж дуусахаар, сайд миний саналыг асууж байна.

Би түүнд өөрийн саналыг хэллээ:

-Д.Балжинням трактор авах санал боловсруулсан байна. Энэ бол байж болох санал юм. Гэхдээ одоо манай улс гадаад худалдааны шугамаар олон трактор авч байгаа шүү дээ. Цаашдаа ч олныг авах боломж бий. ХАА-н нэгдлүүд урьд нь авсан тракторуудынхаа ашиглалтыг сайжруулж чадаагүй л байгаа шүү дээ. Түүн дээр дахин нэмж трактор авах нь аль

зэрэг зөв байдаг бол? ХАА-н нэгдлүүдэд трактор хэрэгтэй байгаа бол улсын САА-нуудаас хэдийг л бол хэдийг тийш нь шилжүүлэн өгч болно шүү дээ. Тусламжийн хөрөнгийг өөрөөр, үр, ашигтай зарцуулах санал надад байна. Завхан голын усыг Гуулингийн тал дундуур урсуулах шуудуу ухаж, суваг барихад энэ хөрөнгийг ашиглавал ямар вэ? Урьд нь бид нэг удаа ийм ородлого хийгээд үзсэн. Нутгийн ардууд үүнийг олон үеийн турш мөрөөдөж ирсэн зүйл. Үүнийг амжилттай шийдэж чадвал олон мал, олон хүн ундаалах устай болж, өргөн сайхан нутгийг ашиглах боломжтой болох юм шүү дээ! гэж өөрийн саналыг хэллээ. Гэтэл Н.Жагварал сайд миний хэлсэн үгийг их дэмжиж байна. Ингээд энэ асуудлыг МАХН-ын ТХ-ны УТТ-ны хуралд оруулж хэлэцүүлэхээр боллоо.

Тэр үед манайд Усны хайгуул шинжилгээний газар гэдэг байгууллага байсан юм. Түүнийг сүүлд Усны аж ахуйн яам болгон өргөтгөсөн юм. Бид энэ яамны саналыг бас асуулаа. Тэд нар бидний саналыг дэмжиж байна. Ингээд МАХН-ын ТХ-ны УТТ-ны хурал дээр Н.Жагварал сайдын оруулсан санал дэмжигдлээ. Ингээд дахиад Завхан голын усыг Гуулингийн тал руу урсуулах ажил эхэллээ. Усны аж ахуйн яам хайгуул шинжилгээ хийж, шуудуу ухах, суваг барих зураг, төслийг нь боловсрууллаа. Ингээд ажил жигдэрч шуудуу ухаж, суваг барих ажилдаа орлоо. Түүнээс хойш нэг жилийн дараа буюу 1959 онд инженерийн бүтэцтэй сувгийг ашиглалтанд оруулж байлаа. Ингэж Завхан гол маань Гуулингийн тал дундуур урсаж, нутгийн ардуудын олон үеийн турш мөрөөдсөн мөрөөдөл биеллээ олсон юм. Тэнд олон сумын олон мал отор, нүүдэл хийдэг сайхан нутаг болсон юм.

Одоо түүн дээр усан цахилгаан станц бариад цахилгаан гаргаж байгаа гэнэ билээ. Тэнд Гуулингийн тосгон гэдэг шинэ суурин ч бий болсон юм. Гуулингийн суваг байгуулагдсаны 40 жилийн ойгоор надад урилга ирүүлсэн байна билээ.

10 Намайг “САА-нуудыг удирдах газар”-ын даргаар томиллов.

КЮ: Та Говь-Алтай аймаг дахь МАХН-ын хорооны нэгдүгээр нарийн бичгийн даргаар хэдэн жил ажилласан юм бэ?

Ц Л: Гурван жил шахуу ажилласан юм. 1956 оны сүүлчээр намайг Сангийн аж ахуйнуудыг удирдах газрын даргаар томилсон юм. Энэ үед манай оронд “Атар газрыг эзэмших хөдөлгөөн” арай эхлээгүй байсан. Гэхдээ цаашдаа МАХН-аас атар газрыг эзэмших талаар том зорилт дэвшүүлнэ гэдэг нь тодорхой болсон байсан үе юм. Энэ үед ЗХУ-д атар газрыг эзэмших бүх ард түмний хөдөлгөөн ид өрнөж байлаа. Казахстаны

өргөн тал нутгийг бүхэлд нь хагалаад, тариан талбай болгож, үр тариа хүнсний ногоо, эрдэнэ шишийг урьд өмнө нь байгаагүй их хэмжээгээр тариалж байлаа. Манайд улсын САА-нуудын үндэс Богд хаант Монгол улсын үед буй болсон юм. Тэр үед Богд хаан болон түүний Засгийн газрын гишүүдийг хүнсээр хангах зорилготой нэг улсын аж ахуйн газрыг байгуулж байсан юм билээ. Сүүлд Ардын засгийн жилүүдэд “Өвс хадах морин станц” нэртэй улсын аж ахуйнууд байгуулагдаж байсан юм. Энэ аж ахуйнууд сайн үүлдрийн мал үржүүлэх, үр тариа, хүнсний ногоо тарилах, хадлан өвс хурааж авах, малын тэжээл бэлтгэх ажил эрхлэж байсан юм.

Бүр 20-оод оны дундуур манай улс Монгол хонины ашиг шим, ноосны гарцыг сайжруулах зорилгоор Австралиас 10 орчим мирёнус хонь худалдан авч байсан юм билээ. Бас “Сементал” үүлдрийн үхэр авч байсан юм. Гэтэл тэр мал бол дандаа суурингийн аргаар маллуулж сурсан мал байсан нь мэдээж шүү дээ. Өвөл, зуны ээлжийн байр, байнгын тэжээл шаардана шүү дээ. Тэжээл гэхэд л олон янзын тэжээл хэрэгтэй. Тэднийг байнга арчилж маллаж байх шаардлагатай. Манай бэлчээрийн малаас шал өөр мал байна шүү дээ. Гэтэл манайхан гадаадаас авч ирсэн өнөө малуудыг маллаж чадаагүй юм билээ. Энэ бүх шаардлагыг нь хангаж чадаагүй байх. Тэгээд тэд нар удалгүй өвчин тусаад өөрсдөө үхсэн гэдэг юм. Намайг Хэнтий аймгийн Баян-Уул суманд явж байхад үхсэн хуцны эврийг нэг газар бүгдийг нь овоолсон байж билээ. Бүгд хамуу өвчин тусаад үхсэн гэнэ билээ.

Дайны дараа манай зүүн талын аймгуудаар байрлаж байсан цэргийн ангиудыг татан буулгасан юм. Цэргийн ангиуд өөрийн цэргийг хоол, хүнсээр хангах зорилгоор томоохон аж ахуй эрхэлдэг байсан юм. Тэр ангиудыг татан буулгаад аж ахуйнуудыг нь улсын мэдэлд шилжүүлж өгсөн юм. Ингэж манайд улсын САА-нуудын үндэс тавигдаж байсан юм. Энэ САА-нууд бол бүгд улсын төсвөөс санхүүжиж байсан юм. Тэд нар ерөөсөө ашигтай ажилладаггүй байж. Улсын төсөвөөс санхүүждэг учир дандаа зарлага л гаргадаг байж. Бүгдийнх нь данс улайсан байсан юм. Нийт 20 орчим тийм САА-нууд байсан юм. Эд нар 10 хүрэхгүй га талбайд хүнсний ногоо тариалдаг байж. Зүүн хараагийн САА, Цагаан толгойн САА-нууд бага зэргийн улаан буудай тариалдаг байсан юм. Түүгээрээ бага хэмжээний гурил хийдэг байж. Тэгээд малын тэжээл, овъёос бага хэмжээгээр тариалдаг байсан байж. Тэр үед Хараа гол дээр хоёр усан цахилгаан станци бариад, ажиллуулж байсан юм.

Атар газрыг эзэмших хөдөлгөөн бол манайд ЗХУ-ын шууд нөлөөн дор явагдсан ажил шүү дээ. ЗХУ-д “Атар газрыг эзэмших бүх ард түмний хөдөлгөөн”-ийг эхлүүлсэн хүн бол Н.С.Хрущёв юм. Тэр хүн Украины Коммунист намын ТХ-ны нэгдүгээр нарийн бичгийн дарга байсан хүн.

1952 онд И.В.Сталиныг нас барсны дараа ЗХУ-ын Коммунист Намын ТХ-ны нэгдүгээр нарийн бичгийн дарга, ЗХУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга болжээ. Тэр үе бол Зөвлөлт-Германы дайн ЗХУ-ын ялалтаар дууссан, Зүүн Европын олон орон социализм байгуулах замд орсон нилээд онцлогтой үе байлаа. Тэр үеийг “Дэлхийн социалист систем бүрэлдэн тогтсон үе” гэж тодорхойлж байсан юм. “Социалист нийгмийн тогтолцоо нь хөрөнгөтний нийгмийн тогтолцоотой харьцуулбал харьцангуй олон давуу чанартай, хүний сайн сайхан амьдарах бололцоог илүү хангаж өгч чаддаг нийгмийн тогтолцоо юм. Үүнийгээ амьдрал дээр батлан харуулах ёстой!” гэсэн үзэл их газар авч байсан үе юм. Социалист нийгэм, хөрөнгөтний нийгэм хоёрын хооронд эхлээд байгаа эдийн засгийн уралдаан нь социализмын ялалтаар төгсөнө гэдэгт Н.С.Хрущёв бат итгэж байсан байх. “Хүн төрлөхтний гэрэлт ирээдүй болсон коммунист нийгэмд Зөвлөлтийн ард түмэн удахгүй орно!” гэж тэр ямагт ярьдаг, бичдэг байсан юм. “Коммунист нийгэм гэдэг бол баян ядуугүй, нийгмийн гишүүд бүгд ижил сайхан амьдралтай болж, соёл, шинжлэх ухааны хөгжил оргилдоо хүрч, мөнгө байхгүй болж, хүн чадлынхаа хэрээр хөдөлмөрлөж, хэрэгцээнийхээ хирээр авдаг нийгэм юм!” гэж сургаж байлаа. Ийм учраас социализм байгуулах замд орсон орнудын эдийн засгийн хөгжилтөнд энэ үеэс эхлээд илүү их анхаарах болсон юм. Н.С.Хрущёв өөрөө аж ахуйн ажилд их гаршсан хүн байж. Монголын эдийн засгийг хөгжүүлэх асуудалд тэр илүү анхаарал тавьж байсан юм.

Эхний үедээ манайхан атар газрыг эзэмших ажлыг юунаас эхлэхээ мэдэхгүй баахан цагаа барж байсан юм. Тэгээд ЗХУ-д томоохон төлөөлөгчид илгээж туршлага судласан юм.

Би энэ төлөөлөгчдийг ахлаж Москва хот очиж, ЗХУ-ын Хөдөө Аж Ахуйн яаман дээр хоёр сар гаруй ажилласан юм. ЗХУ-д шинээр байгуулагдсан атарын олон САА-нуудаар орж ажил байдалтай нь газар дээр нь танилцлаа. ЗХУ-ын ХААЯ ажлаа маш шуурхай, оновчтой сайн зохион байгуулдаг байлаа. Эдний сайд, дарга нар нь атарын САА-нуудруугаа дуртай үедээ онгоцоор нисдэг, ялангуяа атар газар эзэмших хөдөлгөөний төв болж байсан Казахстанд байнга очдог байв. Би тэдэнтэй хамт олон ч удаа, олон газар руу нисэж билээ. Газар хагалаж тариа тарих бүх ажлыг эхнээс нь аваад дуустал өөрийн нүдээр үзлээ. Их ч олон сайхан шинэ санаа, туршлага авлаа. Ажил төрлөө арван хуруу шигээ мэддэг олон сайхан хүнтэй танилцлаа. Атар газар эзэмшихэд зайлшгүй шаардлагатай хүчирхэг шинэ техникүүдийг нь үзлээ. Монголд Атар газар эзэмшихэд шаардлагатай бүх мэрэгжилтнүүд, техникүүдээ өөрөө сонгож авлаа. ЗХУ-ын ХААЯ-ны сайд миний ажилд үнэхээр сэтгэл гарган туслаж билээ. Тэр их сайхан хүн байв. Би түүнд үргэлж талархаж явдаг билээ. Хамгийн

сүүлд Монголдоо буцахын өмнөхөн би түүний өрөөнд нь орж уулзсан юм. Тэгээд сүүлчийнхээ хүсэлтийг түүнд хэллээ. “Та өөрийн яамны санхүүгийн хэлтсийн дарга Сергей Иванович Елизаровыг Монголд очиж ажиллах зөвшөөрөл өгөөч!” гэв. Намайг ийм хүсэлт тавина гэж тэр арай бодоогүй байх. Жаахан тулгамдсан байх. “Та жаахан хүлээж байгаарай! Бид шийдвэрлэж өгье!” гэж тэр хэлэв. Хэд хоногийн дараа тэр энэ асуудлыг үнэхээр шийдэж өгсөн юм. Гол нь Монголд шинээр байгуулагдаж байгаа САА-нуудыг хөл дээр нь босгоход эдийн засгийн өргөн мэдлэгтэй, шинээр байгуулах САА-нуудын эдийн засгийн асуудлыг мэддэг туршлагатай хүн надад хэрэгтэй байв. Монголд ирээд миний зөвлөхөөр 3 жил гаруй ажиллахдаа Сергей Иванович Елизаров надад маш их зүйлийг хийж өгч билээ. Тэр үед маш хэцүү нэг зүйл байсан юм аа. Ямар ч асуудлаар ажил хариуцсан бидний өөрсдийн үгийг сонсохоосоо илүү, ЗХУ-аас ирсэн мэргэжилтний үгийг л сонсдог байлаа шүү дээ. Тийм учраас Улс Төрийн Товчоонд оруулж хэлэлцүүлсэн олон асуудлыг шийдүүлэхэд С.И.Елизаров гуай надад үнэхээр их тус болж билээ.

Миний ажилд их тусалсан өөр нэг хүн бол ЗХУ-ын Гадаадтай эдийн засгийн талаар харицах улсын хорооны дарга Петр Иванович Старков юм. Энэ хүнээр дамжиж газар тариалангийн зориулалттай техникүүд Монголд ирдэг байв. Ер нь бид нар Атар газрыг эзэмших энэ том, шинэ ажлыг агротехникийн шинжлэх ухааны ололтонд тулгуурлан, шууд техникийн хүчээр хийсэн юм шүү дээ. Хуучин уламжлалт аргаар биш. Газар хагалах, үр суулгах, ургац хураах гээд газар тариалангийн бүх ажлыг техникийн тусламжтайгаар гүйцэтгэж байв. Хагалах газраа сонгох, газар хагалаж эхлэх, тариалах үрийг сонгох, үр суулгах, суулгасан үрийг арчилж, хамгаалж ургуулах, түүнийг услаж, арчилж, тордох бүх ажлыг тухайн үеийн агротехникийн шинжлэх ухааны ололтонд тулгуурлан зохион байгуулж байсан юм. Тийм учраас миний хариуцсан энэ шинэ том салбар богино хугацаанд өндөр амжилтанд хүрч чадсан юм. Манай амжилтын гол хүчин зүйл энд л байсан юм. Атар газарт шаардлагатай техникийн асуудлыг Монголын талд Гадаад худалдааны яамны сайд С.Гомбожав хариуцдаг байв. С.Гомбожав бид хоёр ажил төрлийн их сайхан харилцаатай, найзууд байлаа шүү дээ. 1964-ны 12-р сард хуралдсан МАХН-ын ТХ-ны 6-р бүгд хурал дээр тэр бусад хүмүүсийн адилаар Ю.Цэдэнбалыг хамгаалж, миний эсрэг үг хэлээгүй юм. Гэтэл энэ асуудал “Эсэргүү Лоохуузын хань хамсаатан байж магадгүй!” гэсэн хардалтыг төрүүлж, түүний байдал нэг хэсэг их эгзэгтэй болж байв.

Үүний дараа ЗХУ-ын ХААЯ-наас Ю.Старков гэдэг эрдэмтэн хүнээр ахлуулсан томоохон хэмжээний шинжилгээний ангийг ирүүлсэн юм. Энэ судалгааны анги Монгол орны хөрсний шинжилгээг иж бүрнээр нь

явуулаад, газар тариаланд ашиглаж болох нийт талбайн хэмжээ, газар тариалан эрхлэхэд тохиромжтой нутгуудыг тодорхойлсон юм. Энэ бүгдийг харуулсан газрын зураг зохиож өгсөн юм. Тэд нар “Монгол оронд 550 000 га атар газрыг тариалангийн талбай болгон ашиглах боломж бий!” гэсэн тодорхойлолт хийж өгсөн юм. Ю. Старковын ахалсан шинжилгээний ангийн хийсэн Монголын газар тариалангийн бүсийн газрын зураг миний ажлын өрөөнд өлгөөтэй байдаг байв.

Үүний дараа манайх хуучин ажиллаж байсан улсын САА-нуудыг өөрчлөн байгуулаад, заримыг нь хооронд нь нэгтгэж томруулаад, тариалангийн талбайд ашиглаж болох үржил, шимтэй хөрстэй газар шинээр САА-нуудыг байгуулсан юм. Угтаалын САА, Дарханы САА зэрэг үр тарианы чиглэлийн САА-нуудыг шинээр байгуулсан юм. Үүний дараа бүх САА-нуудад импортоор авсан трактор болон бусад ХАА-н техникүүдийг хувааж олгосон юм. “Атар газрыг эзэмших хөдлгөөн” ингэж гараагаа эхлэж байлаа.

Нийт САА-нуудын тоо сүүлдээ 30 гарсан юм. Газар хагалж, тарилалт хийх ажлыг хангай, ойт хээрийн бүсээс эхэлсэн юм. Энд газар тариалангийн ажилд тохиромжтой үржил, шимтэй хөрс бүхий газар элбэг байдаг юм. Эхний үед үр тарианы ургамлаас улаан буудайг голлоод, хүнсний ногооноос төмс, сонгино, манжин, лууван, байцааг тариалсан юм. Эхний жилүүдэд нэг га-гаас 10-15 центнер ургац хурааж байлаа. Үр тарианы ургамалын хувьд бол нэг онцлогтой байдаг юм. Бид авсан ургацынхаа бараг 2/3-ыг хог болгоод хаяхад хүрч байлаа. Энэ юу гэсэн үг вэ? гэвэл тарианыхаа үрийг нь салгаж авсны дараа цаана нь тарианы иш буюу соллом нь тэр чигээрээ хаядал, хог болж байгаа юм. Түүнийг малын тэжээл болгож ашиглах их ажил ундарсан юм. Малын тэжээлийн баазтай болчихвол малын үүлдэр угсааг сайжруулах, гахай, тахиа, үслэг анг тэжээж үржүүлэх боломж бүрддэг юм.

Атар газрыг эзэмшихээс өмнө манайх шар будааг Оросоос импортоор авч байсан юм. Харин бид бас шар будааг тариалдаг болсноор өөрийн бүх хэрэгцээг хангадаг болоод гадаадаас шар будаа импортоор авахаа больсон юм шүү дээ.

Жимс, жимсгэний төрлийн ургамалаас яблоког тариалсан юм. Шаамарын САА-д жимс, жимсгэний төрлийн ургамал тариалдаг болсон юм. Анхны яблоконы ургацыг Шаамарын САА-д авч байлаа. Сүүлд яблоконы модыг хойд талын бараг бүх САА-нуудад суулгаад, яблоконы ургац авч байлаа. Бас зүүн талын Халх голын САА-д жимс, жимсгэнэ тариаладаг болсон юм. Бид Халх голд яблоконы модыг онгоцоор зөөж аваачаад суулгаж байлаа. Баруун Алтай нутгийн Үенчийн гол, Булган голд түүнийг бас суулгасан юм. Энэ бол “Сибирийн яблоко” гэж

нэрлэгддэг тусгай сортын яблоко байсан юм.

КЮ: Анх газар хагалж тариа, ногоо тарихад ямар бэрхшээл гарч байв даа? Монголд ийм их хэмжээний тариа, ногоо тариалж байгаагүй шүү дээ.

Ц Л: Ер нь атар газрыг эзэмших асуудалд МАХН, манай төр, засаг маш их анхаарал тавьсан юм. Монголын эдийн засагт өөрийн бие даасан газар, тариалангийн салбар байгаагүй учир олон зуун жил Монгол улс газар тариалангийн бүтээгдэхүүнийг ямагт гадаадаас авч байсан юм. Хэрвээ бид олдож байгаа энэ боломжийг сайн ашиглаж чадвал манай орон газар тариалангийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг болох боломж нээгдэх байсныг бид сайн ойлгож байсан юм. Энэ бол манай орны эдийн засгийн хөгжилд үлэмж ач холбогдолтой зүйл болох байсан нь ойлгомжтой байсан юм. Тийм учраас МАХН энэ асуудлыг “Атар газрыг эзэмших бүх ард түмний хөдөлгөөн” болгон зохион байгуулсан юм. Монгол орны өнцөг булан бүрээс олон зуун мянган залуучууд шинээр байгуулагдсан атарын САА-нуудад ирж ажилласан юм. Энэ ажилд Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэл хошуучлагч болон оролцсон юм. Би өөрөө залуудаа МХЗЭ-ийн ажил хийж байсан болохоор атарт ирж байгаа залуучуудтай ойр дотно харилцаатай байсан юм. Залуучууд газар тариалангийн шинэ техникийг богино хугацаанд чадамгай эзэмшиж, атар газрыг хагалж, тариа тарих ажлыг хурдан сурч байсан юм. Бид нар “Тракторын жолооч бэлтгэх түр сургууль”-ийг олон аймагт байгуулж, тэнд залуучуудыг 45 хоногийн курст сургаад, “тракторын жолоочийн” үнэмлэх олгож байсан юм. Зөвлөлтийн мэргэжилтнүүд манай залуучуудын авъяасыг онцгой үнэлэж байсан юм. 1959 онд Атарын анхны “Хөдөлмөрийн баатар” төрөн гарлаа. Тэр бол тракторч Д.Бямбацогт байсан юм. Энэ хүн өөрт ноогдсон газар хагалах төлөвлөгөөг олон удаа давуулан биелүүлж ирсэн юм. Үүний дараа Архангай аймгийн Төвшрүүлэхийн САА-гаас Хөдөлмөрийн баатар Н.Туваан гэдэг хүн төрөн гарлаа.

Гэхдээ энд бэрхшээл байгаагүй биш их байсан юм аа. Ялангуяа шинээр байгуулагдсан САА-нуудад очиж ажиллах хүн хүчний асуудлыг шийдхэд их хүнд байв. Мал хариулж байгаа малчин хүн гэр орон, малаа орхиод газар хагалахаар ирэх нь ховор шүү дээ. Бараг байхгүй. Тэгээд ч манай монголчууд газар хагалахад угаасаа маш их дургүй шүү дээ. Газар хагалаж тариа тарина гэдэг бол юуны өмнө малын бэлчээрийг сүйтгэж байгаа хэрэг юм шүү дээ. Нөгөө талаар “газар хагалаж тариа тарина гэдэг бол маш ядуу хүний ажил. Амьдрах өөр арга байхгүй хүмүүс өлбөрч үхэхгүйн тулд газар хагалж, тариа тарьж, түүнийгээ идэж амьдарч байгаа юм!” гэсэн уламжлалт монгол сэтгэлгээ байдаг юм. Монгол хүний

толгойд хэдэн мянган жил оршсоор ирсэн энэ үзэл санааг давж гарах маш хэцүү байсан юм аа. “Энэ үзэл санааг давж гарахад орчин үеийн хүчирхэг техник, шинжлэх ухаан хоёр л тусалсан. Өөр юу ч туслаж чадахгүй байсан!” гэж би боддог юм. Монгол хүн чинь малаа бэлчээрийн аргаар малладаг учир байгаль дэлхийгээ их шүтдэг, түүнийг маш их хайрлан, хамгаалдаг уламжлалтай байлаа шүү дээ. “Бидний оршин амьдарч байгаа байгаль дэлхийд эзэн байдаг. Түүнийг лус савдаг гэдэг. Хэрвээ байгаль дэлхийд хайр гамгүй хандаж, түүнийг хагалаж эсвэл өөр замаар гэмтээвэл, лус савдаг догширч, ган, зуд болж, мал сүрэг хорогдож, өвчин эмгэг дэлгэрнэ!” гэж үздэг байв. Бид байгаль дэлхийн эзэн лус савдгийг аргадаж овоо тахидаг шүү дээ. Бид нар олон мянган жилийн ийм уламжлалтай байлаа юм шүү дээ. Манай нутагт намайг бага байхад тариа тарьж амьдардаг хүмүүс байсан талаар би ярьсан шүү дээ. Тариа тарьдаг айлууд газар хагалахдаа маш их журамтай байсан юм. Хаа дуртай газраа хагалах явдал огт байгаагүй юм шүү дээ. Малын бэлчээрт муу нөлөө үзүүлэхгүй, гол усандаа ойр тийм газарт л тариагаа тарьдаг байв.

Монголд атар газар эзэмшиж эхлэх үед ХАА-н нэгдлүүд байгуулагдаж, малаа нийгэмчлүүлсэн олон хүн малгүй болсны улмаас хот суурин газар бараадан амьдрах болоод байв. Ялангуяа залуучууд хот, суурин газар руу их явж байлаа шүү дээ. Сүүлийн үед манай шар, хар хэвлэлүүд тэр үеийн хүн амын энэ шилжих хөдөлгөөнийг “бага нүүдэл” гэх болсон юм шиг байна. 1990-ээд оноос хойш бас их олон хүн хот, суурин газар бараадаж нүүх боллоо шүү дээ. Энэ нүүдлийг манай хэвлэлүүд “Их нүүдэл” гэж нэрлээд байгаа юм уу даа. Уг нь аль нь их, аль нь багыг тогтоосон тоо байхгүй юм шүү дээ. ХАА-н нэгдэл байгуулагдаж байх үед олон хүн малаа нийгэмчлүүлээд амьдрах аргагүй болоод хот суурин газар бараадах болсон үйл явцыг тас нуучихсан юм. Энэ талаар албан ёсны статистик ерөөсөө байхгүй. 90-ээд оноос хойших хот суурин газрыг чиглэсэн нүүдлийн талаар ч бас л албан ёсны статистик одоо болтол алга. Ер нь манайд албан ёсны үнэн зөв статистик ер нь байгаагүй юм шүү дээ. Энэ чинь МАХН-ын үзэл суртлын асуудал болчихсон юм. Нийгмийн дотор гарч байгаа муу зүйлүүдийг олон нийтээс тас нуучихдаг, МАХН-аас явуулж байгаа бодлого, хийсэн ажлыг болохоор хэдэн арав дахин өсгөөд сурталчилчихдаг байв. Нийгмийн дотор болж байгаа үйл явцуудын үнэнийг мэдэж авах ямар ч боломж байгаагүй юм.

Малаа нийгэмчлүүлээд малгүй болоод хот, суурин газар бараадсан залуучуудад хийх ажил байхгүй л дээ. Гэсэн ч хөдөө очих гэхээр малгүй болчихсон байлаа шүү дээ. Тэр үед МХЗЭ-ийн Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн даргаар Ч.Пүрэвжав гэдэг хүн ажиллаж байв. Би энэ Ч.Пүрэвжавыг өөрийн ажилд их ашигладаг байв. Ёстой нөгөө “нусны

алчуур шиг ашиглана!” гэдэг ч билүү дээ? Нэг үг байдаг шүү дээ. Яг тийм л юм болж байсан юм. Тэр уг нь малын эмч хүн л дээ. Мэдэх, чадах юмаар тааруухан л даа, зайлуул. Дээд дарга нарт их бялдууч, ялангуяа Ю.Цэдэнбалтай их дотно харилцаатай, түүнд байнга хов зөөдөг, доод хүмүүст их ширүүн ханддаг, нэг тийм явуургүй зантай хүн байлаа шүү дээ, хөөрхий минь. Хот суурин газарт, ялангуяа Улаанбаатар хотод амьдарч байгаа ажилгүй залуучуудыг цуглуулж шинээр байгуулагдсан атарын САА-нуудад илгээх ажлыг хийх хэрэгтэй байв. Ю.Цэдэнбалтай ойр дотно харилцаатай байдал нь миний ажилд их хэрэг болсон юм. “МХЗЭ бол МАХН-ын дайчин туслагч, бэлтгэл хүчин!” гэдэг шүү дээ. Ингээд олон мянган залуучууд “МХЗЭ-ийн илгээлт”-ээр Атар газрыг эзэмших ажилд оролцож эхэлсэн юм. Энэ ажлуудыг зохион байгуулахад хөгтэй инээдтэй явдлууд ч их болж байлаа.

Газар тариалангийн ажил эрхлэн явуулахад нэг анхаарах зүйл бол ургацаа хурааж аваад хадгалах байр савыг нь зэрэг бэлтгэх ёстой юм билээ. Бид эхний үед ийм бэлтгэлийг хийж чадаагүй юм. Ургацаа хураагаад эхэлтэл түүнийг хадгалах байрны асуудал хурцаар тавигдаж эхэлсэн юм. Тэр үед ажиллаж байсан гурилын үйлдвэрүүдэд тийм их будааг агуулах байр бас байсангүй. Тэгээд эхний жилүүдэд үр тариаг наадам хийдэг стадионууддаа хураагаад, брезентээр бүтээгээд орхиж байлаа. Үүний дараа Хөвсгөл, Дорнод, Булган, Дарханд гурилын шинэ үйлдвэрүүд байгуулагдаж, тэнд үр тариаг хураах томоохон агуулах, байрнуудыг байгууллаа.

Хүнсний ногооны хадгалах горим нилээд онцлогтой байдаг юм. Түүнийг дунджаар 0-1 градус хадгалах ёстой юм. Газрын хөрсний хөлддөг хэсгээс дээш 1 градусын дулаантай байдаг шүү дээ. Үүнийг ашиглаад “нүхэн зoorь”-уудыг байгууллаа. Намар ургацаа хурааж аваад нүхэн зoorиндоо хийчихдэг боллоо. Хавар түүнийг нээхэд ногоо муудаагүй хэвээрээ байж байдаг юм. Ингэж бид хүнсний ногоо хадгалах аргыг олсон юм. Анхны ийм нүхэн зoorийг Батсүмбэрийн САА-д байгуулж байлаа.

Ийм нүхэн зoorийг Монголд амьдарч байсан Хятад хүмүүс дээр үед хэрэглэж байсан тухай яриа байдаг юм. Гэвч бид нар Хятад хүний байгуулсан нүхэн зoorийг олж үзээгүй юм. Ийм нүхэн зoorийг олноор нь байгуулах ажлыг яаралтай зохион байгуулах хэрэгтэй болсон юм. Энэ ажилд Ардын цэргийн ангиудыг дайчиллаа. Эхний жилүүдэд хураасан ургацаа хадгалах байр савны ийм том асуудал босож ирсэн юм. Харин дараа дараагийн жилүүдэд бид энэ асуудлыг аажмаар шийдэж чадсан юм. Ер нь ургац хураах ажил бол хугацаатай өрсөлдсөн, хүн хүч шаардсан маш хариуцлагатай ажил байдаг юм. Манай орны цаг уурын нөхцөл байдал

нь ургац хураах хугацааг яг зөв тодорхойлохыг шаарддаг юм. Хэрвээ ургац хураах хугацааг буруу тогтоовол, цаг агаарын гэнэтийн өөрчлөлтөд автаж, ургац алдах аюултай байдаг юм. Ийм учраас ургац хураах хугацааг зөв тодохойлж, энэ ажлыг богино хугацаанд гүйцэтгэх ёстой юм. Манай тариаланчид энэ ажлыг ямагт нэр төртэй гүйцэтгэж ирсэн юм. Хүн хүч шаардсан энэ ажилд Ардын цэргийн ангиудыг дайчлан ажиллуулдаг болсон юм.

Сүүлийн жилүүдэд монголчууд төмс, хүнсний ногоог хувиараа их тариалдаг болоод байгаа шүү дээ. Одоо айлууд хувьдаа нүхэн зоорь барьдаг болоод байна. Би өөрөө нийгмийн ухаанаар суралцсан хүн шүү дээ. Тэгээд САА-нуудын ажлыг удирдаж байгаагийн хувьд энэ бүгдийг судлаж, сураглаж олж мэдээд, амьдралд нэвтрүүлэх зайлшгүй шаардлага гарч ирдэг байсан юм. Бас манай САА-нуудыг удирдах газарт ЗХУ-аас ирсэн газар тариалангийн өндөр мэргэжлийн хүмүүс олноороо ажиллаж байлаа. 1959 оноос эхлээд манайх өөрөө үндэсний хөдөө аж ахуйн мэргэжилтэнгээ бэлтгэж эхэлсэн юм.

Намайг ажиллаж байх хугацаанд манай САА-нууд аж ахуйн тооцоо, цалин хөлсний шинэ системд шилжсэн юм. Энэ системийг нэвтрүүлснээр манай САА-нууд бүгд ашигтай ажиллаж, улайсан дансууд нь харлаж ирсэн юм. Улсын төсвөөс дотац авахаа байсан гэсэн үг шүү дээ. Өөрөө өөрийгээ санхүүжүүлдэг, аж ахуйн тооцооны энэ систем анх Монголын төмөр замд нэвтэрсэн юм. Хүмүүсийн хийж гүйцэтгэсэн ажлын хэмжээгээр цалин хөлсийг нь бодож олгодог систем юм. Өөрөөр хэлбэл хүн хэдий чинээ сайн ажиллана, төдий чинээ их цалин авна гэсэн үг шүү дээ. “Чиний хийж байгаа ажил чиний авах цалинтай шууд холбоотой юм шүү!” гэдгийг хүмүүст сайн ойлгуулах ёстой байсан юм. Хүн бүр сайн цалин авахыг бодож байдаг шүү дээ. Тэгвэл сайн ажиллах хэрэгтэй шүү дээ. Сайн цалингаар сайхан амьдарч болно шүү дээ. Хүмүүс ингэж бодож эхэлбэл ажил сайжрах ёстой юм. Манай эдийн засагт шинээр буй болж байгаа газар тариалангийн салбарт ийм систем нэвтрүүлэх зайлшгүй хэрэгтэй байсан юм.

Монголын төмөр замд цалин хөлс, аж ахуйн тооцооны ийм системийг Н.Дэмчиг гэдэг хүний удирдлагын дор нэвтрүүлсэн юм. Н.Дэмчиг бол сайн эдийн засагч хүн байсан юм. Тэр Төмөр замын удирдах газраас халагдаж гараад, бараг ажилгүй шахуу явж байсан юм. Би тэр хүнийг олж уулзлаа. САА-нуудад өөрөө өөрийгөө санхүүжүүлдэг, аж ахуйн тооцооны шинэ систем нэвтрүүлэх бодолтой байгаа тухайгаа ярьсан юм. Тэрээр “Энэ ажилд оролцоход татгалзах зүйл байхгүй !” гэж миний саналыг зөвшөөрсөн юм. Тэгээд бид нар түүнийг САА-нуудыг удирдах газартаа ажилд авлаа. Тусгай өрөө гаргаж өглөө. Тэгээд сайн цалин өглөө. Ингээд

улсын САА-нуудад мөрдөж байсан цалин хөлсний хуучин системтэй танилцууллаа. Энэ ажил “Атар газар эзэмших хөдөлгөөн” эхлэхийн өмнөхөн болсон юм. Ингээд Н.Дэмчиг энэ ажил дээр хоёр сар суугаад, нэг төлөвлөгөө боловруулж бэлэн болголоо. Би түүнтэй өдөр бүр энэ ажил дээр хамтарч суудаг байсан юм. Бид нар тэр төлөвлөгөөгөө Сангийн яаманд танилцууллаа. Манай Сангийн яам бидний хийсэн төлөвлөгөөг эхлээд маш их эсэргүүцсэн юм. Бид нар тэнд олон дахин очиж, олон удаа тайлбар хийв. Тэгээд эцэстээ Сангийн яам зөвшөөрлөө. Ингээд тэр төлөвлөгөөгөө Засгийн газрын хуралдаанаар оруулаад батлуулж авлаа. Бидний энэ төлөвлөвлөгөөг батлуулахад Сергей Иванович Елизаров гуай их тус болж билээ. Ингээд өөрийгөө санхүүжүүлдэг энэ систем САА-нуудад нэвтэрч эхэлсэн юм.

Энэ системээр хүн бүр “хөдөлмөрийн норм”-той боллоо. Хүн бүр хөдөлмөрийн нормоо биелүүлбэл цалингаа бүтэн авдаг боллоо. Нормоо давуулан биелүүлбэл илүү цалин авдаг боллоо. Нормоо биелүүлж чадаагүй бол цалин нь тэр хэмжээгээр хасагддаг боллоо. Ийм болохоор хүн бүр нормоо биелүүлэхийг хичээгээд эхэллээ. Норм биелүүлэхийн тулд хүн бүр өөрийнхөө хөдөлмөрийг сайн бодож, зохион байгуулдаг болоод ирлээ. Эхлээд юу хийх вэ? Дараа нь юу хийх вэ? Хэзээ унтах вэ? Хэзээ босох вэ? гээд хүмүүс хөдөлмөрөө өөрсдөө зохион байгуулаад эхэлсэн юм.

Хөдөлмөрийнхөө багаж, зэвсэгтэй зөв харьцаад эхэлж байгаа юм. Трактор, комбайн эвдэрвэл норм, төлөвлөгөөгөө биелүүлж чадахгүй болно шүү гэдгийг ойлгоод ирж байгаа юм. Тийм учраас түүнийг эвдэхгүй, ариг гамтай хэрэглэхийг хичээгээд эхэлж байгаа юм. Трактор, комбайныг өөрийнхөө төлөвлөгөөт ажлаасаа өөр юманд ашиглахаа больж байгаа юм. Бензин, шатахуундаа арвилан хэмнэлт гаргадаг болж байгаа юм. Ийм байдлаар бүх ажил зохион байгуулалтанд ороод ирлээ.

Төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэн САА-нууд өөрсдийн мэдлийн санхүүгийн эх үүсвэртэй боллоо. Тухайлбал, Жаргалантын САА жилд 20 сая төгрөгийн өөрийн мэдлийн санхүүгийн эх үүсвэртэй болсон байлаа. САА-н дарга нар энэ санхүүгийнхээ шинэ эх үүсвэрийг өөрсдөө мэдээд соёл, олон түмнийхээ ажилд зарцуулдаг боллоо. САА-нууд өөрсдийн соёлын ордон, улаан булангуудыг байгуулдаг боллоо. Ингээд яваандаа бүх САА-нууд өөрсдөө зарлагаа нөхдөг боллоо. Бүгд алдагдалгүй, ашигтай ажилладаг болоод ирлээ. Улайсан данстай САА байхгүй боллоо. Алдагдал гарсан үед САА-нууд бие биендээ туслаж алдагдлыг нь нөхдөг боллоо. Улсын САА-нуудын байршлаас хамаараад алдагдал нь их, бага янз бүр байдаг юм л даа. Тухайлбал, ойт хээрийн бүсийн үржил шимтэй, хар шороон хөрстэй нутгийн САА-нууд маш өндөр ашигтай ажилладаг юм. Харин Дорнод, Хэнтий зэрэг аймгийн тал хээрийн бүсэд байгаа

САА-нуудын алдагдал өндөр гардаг юм. Тэгээд ашиг ихтэй ажиллаж байгаа САА-нууд ашиг багатай ажиллаж байгаа САА-нуудын алдагдал зардлыг нь нөхдөг болсон юм.

Бас нэг анхаарах зүйл бол байгалийн аль бүсэд байрлаж байгаагийг нь харгалзаад САА-нуудын хэмжээг нь яг тохируулж өгөх хэрэгтэй байдаг юм. САА хэт жижигхэн бол ашиг, орлого нь бага болдог юм. Бас хэт том бол зарлага нь өндөр гардаг юм. Энэ бүгдийг нарийн тооцож аж ахуйгаа зохион байгуулах хэрэгтэй байдаг юм. Байгалийн хоёр өөр нөхцөлд ажиллаж байгаа САА-нуудад яг ижил даалгавар өгч болдоггүй юм. Тал, хээрийн бүсэд ажиллаж байгаа САА-нууд бол газар тариалангийн хажуугаар мал, аж ахуйдаа илүү анхаарах ёстой байдаг юм. Түүнээс илүү ашиг олдог юм. Харин байгалийн тохиромжтой бүсэд ажиллаж байгаа САА-нууд бол газар тариаландаа илүү анхаарах ёстой юм. Газар тариалан голлосон сангийн аж ахуйнууд, мал аж ахуй голлосон САА-нуудад малын тэжээл бэлтгэж өгч туслах ёстой. Ийм маягаар бүх ажлаа бид нар зохион байгуулж байлаа.

И Л: Улсын САА-нууд газар тариалан, мал аж ахуйгаас гадна өөр ямар аж ахуй эрхлэж байсан юм бэ?

Ц Л: Улсын САА-нууд газар тариалан, мал аж ахуйгаас гадна, гахайны, тахианы, туулайн зэрэг аж ахуйнуудыг эрхэлдэг болсон юм. САА болгон өөрийн барилгын бригадтай болсон юм. Гахай, тахианыхаа байрыг нь САА-нууд өөрсдөө барьчихдаг болсон юм. САА-нууд эдийн засгийн хувьд маш их бие даасан байдалтай болж чадсан юм. Бид нар Богд ууланд шинэ төрлийн аж ахуй эрхэлдэг Төрхурахын САА-г байгуулсан юм. Энд дандаа булга үржүүлдэг боллоо. Бид энэ САА-г байгуулахын тулд Хэнтийн уулнаас 300 гаруй булга бариулж авч ирж байлаа. Бас Сибирээс булга худалдан авч байлаа. Ингээд булга үржүүлдэг боллоо. Булганы арьс нь маш үнэтэй шүү дээ. Түүгээр дээд зэргийн чанартай өвлийн малгай, өвлийн пальтоны зах хийдэг юм. Монгол улс булганы арьсыг гадаад экспортонд гаргадаг болсон юм шүү дээ.

Мөн Богд ууланд мянган бугатай “Бугын аж ахуй”-г байгуулж байсан юм. Бид нар ЗХУ-ын Сибирийн бугын аж ахуйн туршлагыг судлаж ирээд энэ аж ахуйг байгуулсан юм. Сибирь бол маш олон бугын аж ахуйтай бүс нутаг шүү дээ. Бугын цусан эвэрийг эмчилгээний зориулалтаар ашигладаг юм. Энэ бол их өндөр үнэтэй түүхий эд юм. ЗХУ бугын цусан эвэрийг гадаадад, хатуу валютаар зардаг байсан юм. Бид нар бугын аж ахуйг цаашид нэмж 10-ыг байгуулахаар төлөвлөж байлаа. Эдийн засгийн тооцоо хийгээд үзэхэд бугын 10 аж ахуйгаас нэг жилд олж болох ашиг нь

Монголоос нэг жилд гаргаж байгаа малаас олох ашигтай тэнцэхээр байсан юм. Өөрөөр хэлбэл малаа амьдаар нь ЗХУ-д гадаад худалдааны шугамаар заралгүйгээр, тэр хэмжээний ашиг, орлогыг зөвхөн бугын цусан эвэрийг өөр оронд экспортлоод олж болохоор тооцоо гарч байсан юм.

Түүнээс гадна манай тал хээрийн бүсэд олон арван мянгаараа амьдардаг цагаан зээрийн аж ахуй байгуулах төлөвлөгөө байсан юм. ЗХУ-д цагаан зээрийн аж ахуй хэрхэн ажиллаж байгаа туршлагыг бид явж судлаад ирсэн юм. Тэнд зөвхөн бөхөн гөрөөсөөр байгуулсан аж ахуй хүртэл ажиллаж байлаа шүү дээ. Эдийн засгийн маш өндөр ашигтай аж ахуйнууд байсан юм. Зэрлэг амьтнаар аж ахуй байгуулахад тийм их төвөгтэй биш юм. Юуны өмнө зэрлэг амьтадад гэжээл өгч сургах, өвчин тусахаас урьдчилан сэргийлсэн арга хэмжээг цаг тухайд нь авч байх, бас үржилийнх нь ажлыг зөв зохион байгуулах шаардлагатай байдаг юм. Ийм зайлшгүй хийх ажлуудыг хийж чадвал бусад нь тийм түвэгтэй биш юм.

Бидний хийхээр төлөвлөсөн эдгээр саналууд бүгд МАХН-ын УТТ дээр очоод зөвшөөрөгдөөгүй юм. Зөвхөн энэ биш тэр үед ер нь миний хийхээр төлөвлөж, санаачилсан олон ажлууд МАХН-ын ТХ-ны УТТ дээр дэмжигдэхээ байгаад ирсэн юм. Ийм үед аяндаа цаашид ажиллах сонирхол буураад ирдэг юм билээ. Тэгээд би цаашид яах вэ? гэдэг талаар нилээд боддог болсон юм. Зарим нэг хүнтэй энэ асуудлаар санал солилцож үзлээ. Ингээд би ажлаасаа гарахаар шийдлээ. Энэ тухай МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбалтай ярилцахаар шийдсэн юм.

Намайг ийм шийдвэр гаргаж байх тэр үед улс төрийн нэгэн томоохон дуулиан, шуугиантай үйл явдал боллоо. 1962 оны 9-р сард хуралдсан МАХН-ын ТХ-ны 3-р бүгд хурал МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүн, нарийн бичгийн дарга Дарамын Төмөр-Очирыг “Намын эсрэг ажил явуулга үйлдсэн” гэж гүтгээд, тогтоол гаргаж бүх албан тушаалаас нь огцруулаад, нутаг зааж, цөллөгт явууллаа. Өргөн мэдлэгтэй, өндөр боловсролтой, ховорхон авъяастай энэ хүнийг ирээдүйд МАХН-ын удирдагч болох бүрэн боломжтой гэж олон түмэн үнэлж байсан юм. Маршал Х.Чойбалсан түүнд их найдлага тавьж байсан юм. МАХН-ын 10-р дугаар их хурал дээр Х.Чойбалсан “Ирээдүйд Монголд их хэрэгтэй, чадалтай” гэсэн 10 залуугийн нэрийг дурьдсан юм. Түүн дотор “одоогоор ЗХУ-д суралцаж байгаа Д.Төмөр-Очир” гэсэн нэр орж байсан юм.

Ю.Цэдэнбал МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга болсныхоо дараа ЗХУ-сурч байсан Д.Төмөр-Очирыг дуудаж ирүүлээд, МАХН-ын бүгд хурал, их хурал дээр хэлэх үг, илтгэлүүдээ бэлтгүүлдэг байсан юм. Ю.Цэдэнбалын дэргэд тусгай өрөө гаргаж өгдөг, тусгай хангамжтай байсан юм. Д.Төмөр-Очир илтгэлүүдийг нь бэлэн болгож өгөөд л буцдаг байлаа. Д.Төмөр-Очир орос хэл их сайн мэддэг хүн байсан юм.

Д.Төмөр-Очирыг ажлаас халах шийдвэр гаргасан МАХН-ын ТХ-ны 3-р бүгд хурлын ажиллагааг Ю.Цэдэнбал өөрөө шууд удирдаж, МАХН-ын ТХ-ны гишүүдээс нууцаар, хуйвалдааны журмаар зохион байгуулсан юм.

Д.Төмөр-Очир 1921 онд одоогийн Төв аймгийн Лүн сумын нутагт төрсөн хүн юм. ЗХУ-д Дорнодахины дээд сургууль, Москвагийн Улсын Их Сургууль, ЗХУКН-ын ТХ-ны дэргэдэх Нийгмийн ухааны академид суралцаж төгссөн юм. Тэрээр философийн ухааны доктор /Sc.D/ хүн. Сургууль төгссөнийхөө дараа Намын шинэ хүчний дээд сургуулийн тэнхимийн эрхлэгч, МАХН-ын ТХ-ны дэргэдэх МАХН-ын түүхийн институтийн захирал, МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүн, нарийн бичгийн дарга зэрэг алба хашиж явсан юм. Д.Төмөр-Очир МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга болсон үеэсээ эхлээд Ю.Цэдэнбалын ажлын арга барил, түүний хувийн дутагдлуудын талаар МАХН-ын бүгд хурлууд дээр хурц шүүмжлэл хэлдэг болсон юм. “Ю.Цэдэнбалын ажлын арга барил, хувийн дутагдлыг илрүүлж, шүүмжлэх нь МАХН-д их хэрэгтэй, маш чухал ажил!” гэж тэр олон удаа хэлж байсан юм. Д.Төмөр-Очир бол Монголд болж өнгөрсөн “Нэг хүнийг тахин шүтэх явдал”-ын хор уршгийг арилгах талаар ихээхэн санаачлага гарган ажиллаж байсан юм. “Х.Чойбалсангийн үед “Нэг хүнийг тахин шүтэх явдал”-ыг дэвэргэж, түүний улс төрийн хэлмэгдүүлэлт гаргах ажилд их, бага хэмжээгээр оролцож байсан хүмүүсийг шийтгэх хэрэгтэй!” гэж тэр ярьдаг байсан юм. Олон жил Х.Чойбалсантай хамт ажиллаж байсан Ю.Цэдэнбалд ч энэ шийтгэл ноогдох ёстой гэж Д.Төмөр-Очир бодож байсан байж магадгүй. Ямар ч байсан Х.Чойбалсангийн үеийн улс төрийн хэлмэгдүүлэлтэд Ю.Цэдэнбал яаж оролцсоныг Д.Төмөр-Очир өөрөө хамгийн сайн мэдэх хүний нэг байсан юм. Ю.Цэдэнбал ийм байдлаас гарах гарц хайж эхэлсэн байх. Ю.Цэдэнбал түүнийг ажлаас нь халах бас өөр нэг шалтгааныг олсон юм.

Ю.Цэдэнбал “Д.Төмөр-Очир үндэсний үзлийг дэвэргэсэн” гэж буруутгасан юм. 1962 онд Д.Төмөр-Очир МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүн, үзэл суртал хариуцсан нарийн бичгийн даргын хувьд “Чингис хааны мэндэлсний 800 жилийн ой”-г тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг удирдаж байсан юм. Тэр үед Чингис хааны тухай сэдэв хориотой байсан юм шүү дээ. Чингис хаан болон түүний үйл хэргийг залгамжлагч Монголын их хаадууд дэлхийн олон орныг, олон зуун жилийн турш өөрийн захиргаанд барьж байсан түүхийг бид бүгдээрээ мэднэ шүү дээ. Ингэж Монголын захиргаанд байсан орнуудын тоонд Орос орон багтаж байсан юм. Гэтэл ЗХУКН ийм түүх байсныг хүлээн зөвшөөрдөггүй байсан юм. Түүхийг хүлээн зөвшөөрөх үү, үгүй юү гэдэг асуудал бол байж болохгүй. Нэгэнт тийм түүх байсан юм чинь түүнийг арчиж, арилгаж чадахгүй нь мэдээжийн

хэрэг шүү дээ. Энэ бол зүгээр л коммунист үзэл суртал л явж байсан юм. Тухайлбал, “Чингис хаан бол даян дэлхийг байлдан дагуулсан их дайнч хүн, олон орныг эзлэн авч өөрийн боол болгож, олон соёлыг устгаж байсан хүн. ЗХУКН, МАХН бол энхийг эрхэмлэгч намууд, даян дэлхийд энх тайвныг тогтоохын төлөө, олон улсын хөрөнгөтнүүдтэй эвлэршгүй тэмцэл явуулж байгаа намууд учир Чингис хаан болон түүнийг залгамжлагчдын явуулсан дайнч үйл ажиллагааны талаар ярьж, магтаж болохгүй!” гэсэн үзэл суртлын номнол байсан юм. Өөрөөр хэлбэл “Чингис хаан бол их дайнч хүн байсан учир түүний тухай ярьж, бичиж болохгүй!” гэсэн үзэл суртал байсан юм.

Энэ коммунист үзэл сурталын цаана нэг маш чухал асуудал нуугдаж байдаг юм. Юу гэвэл, Хаант Орос улс казах, киркиз, узбек, туркмен гээд дундад азийн түрэг угсааны нүүдэлчид, монгол удамтай татарууд, сибирийн цөөн тооны үндэстнүүдийг өөртөө нэгтгэж авах бодлогыг олон зууны туршид шаргуу явуулсан юм. Энэ бодлогыг эдгээр үндэстэн угсаатнууд, ард түмэн маш хүчтэй эсэргүүцэж, олон үеэрээ зэвсэг барин тэмцэж байв. Эд нар бол Чингис хааны байгуулсан Их Монгол улсын бүрэлдэхүүн хэсэг болж байсан юм шүү дээ. Энэ тэмцэл эцсийн дүндээ тэдний ялагдлаар дууссан юм. Ингэж олон зуун жил цус урсган байж өөрийнхээ бүрэлдэхүүнд оруулж авсан өөр үндэстэн угсаатнуудыг Оросын хаант засаг зөвхөн зэвсгийн хүчээр л барьж байлаа. Тэднийг нэгдэж нийлүүлэн, Оросын улсын бүрэлдэхүүнд барьж байх өөр зүйл даан ч байсангүй. Социалист хувьсгал ялсны дараа үндэстний асуудал бол Орос орны нэн тэргүүнд шийдвэрлэвэл зохих асуудал болж тавигдсан юм. Их Монгол улсын бүрэлдэхүүнд багтаж байсан түрэг угсааны нүүдэлч удамтай эдгээр ард түмэн Зөвлөлт засгийн эсрэг, коммунизмын эсрэг тэмцэж эхлэхээс Коммунист намын удирдагчид их айж байв. Чингис хааны байгуулсан Их Монгол улсын шууд үргэлжлэл болсон цэцэглэн хөгжсөн, хэний ч харьяанд ороогүй, бие даасан Монгол улс бол тэр үед тэдний тэмцлийн гэрэлт нар болох бүрэн боломжтой байв. Зөвлөлтийн удирдагчид ганцхан үүнээс л амиа гартал айж байсан юм. Зөвлөлтийн удирдагчид ингэж айх шалтгаан үнэхээр байсныг 1990-ээд оны үйл явдлууд бүрэн баталлаа шүү дээ. ЗХУ задарч эдгээр үндэстэн, угсаатнуудын дийлэнхи олонхи нь бие даасан улс болсноо зарлалаа. Ийм учир шалтгааны улмаас тэдэнд Монгол улсыг хөгжүүлэх бодол санаа байх үндэсгүй юм. Урьдын их хүч нь алга болоод одоо бүр жижигхэн болчихсон буурай хөгжилтэй Монгол улсыг тэд нар зөвхөн өөрийн геополитикийн сонирхолын хүрээнд л барьж байх хүсэлтэй байсан нь хэнд ч ойлгомжтой шүү дээ.

Үнэн хэрэг дээрээ бол Чингис хааны байлдан дагуулал дэлхий

нийтэд олон шинэ дэвшилтэд зүйлүүдийг дагуулж ирсэн гэдгийг олон орны эрдэмтэд тэмдэглэдэг шүү дээ. Чингис хаан Их Монгол улсыг байгуулснаар энд, тэнд тархай бутархай, хоорондоо эв нэгдэлгүй байсан дэлхий ертөнц нэгэн захиргаанд орж, эв нэгдэлтэй болж, олон соёл өөр өөрийнхөө өнгө төрхийг хадгалан хөгжиж, улс хоорондын харилцаа цэцэглэн хөгжих үндэс тавигдсан гэдэг шүү дээ. Чингис хаан болон түүнийг залгамжлагчид олон шашинд тэвчээртэй хандах болсноор шашин хоорондын мөргөлдөөн гарахгүй байх нөхцөл бүрдсэн гэдэг юм. Гэтэл эдгээр асуудлууд өнөөдөрч ач холбогдлоо алдаагүй байна. Өнөөгийн дэлхий ертөнц эдгээр асуудлуудыг яаж шийдэж байна вэ? Яг үнэндээ бол шийдэж чадахгүй байна.

Д.Төмөр-Очир өөрөө Монголын түүхийн талаар өргөн мэдлэгтэй, энэ сэдвээр олон өгүүлэл нийтлүүлсэн хүн юм. Чингис хааны мэндэлсний 800 жилийн ойг тэмдэглэх санаачлагыг Д.Төмөр-Очир гаргаад, түүнийгээ Ю.Цэдэнбалаар өөрөөр нь зөвшөөрүүлж чадсан байгаа юм. Ингээд энэ ажлын хүрээнд Чингис хааны хөшөөг түүний төрсөн нутаг, одоогийн Хэнтий аймгийн Дадал суманд босгоод, Улаанбаатар хотод томоохон хэмжээний эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан юм. Монголын эрдэмтэд анх удаа энэ хурал дээр Чингис хаан болон түүний байгуулсан Их Монгол улсын түүхтэй холбоотой олон асуудлаар санал солилцож, олон сонирхолтой илтгэл хэлэлцүүлсэн юм. Энэ бол маш зөв сайхан ажил болсон юм. Гэтэл Ю.Цэдэнбалын зүгээс Д.Төмөр-Очирыг ажлаас нь халахдаа энэ ажил бол “Үндэсний үзлийг дэвэргэсэн” гэж буруутгасан юм. Ийм шалтгаануудын улмаас Д.Төмөр-Очир ажлаасаа халагдаад, нутаг заагдаад, цөллөгт явлаа.

Үүнээс хойш нэг жилийн дараа улс төрийн бас нэг дуулиан, шуугиантай томоохон үйл явдал болсон юм. 1963 оны 12-р сард хуралдсан МАХН-ын ТХ-ны 5-р бүгд хурал “Л.Цэнд намч биш ажил явуулга явуулсан” гэж гүтгээд, түүнийг ажлаас нь халж, нутаг зааж, цөллөгт явуулах тогтоол гаргасан юм. Энэ бүгд хурлын ажиллагааг мөн л Ю.Цэдэнбал МАХН-ын ТХ-ны гишүүдээс маш нууц байдалд, хуйвалдааны маягаар зохион байгуулсан юм. Л.Цэнд тэр үед МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүн, 2-р нарийн бичгийн даргын албыг хашиж байсан хүн. Тэр бол МАХН-ын дотор Ю.Цэдэнбалын дараагийн хүн байсан юм. Л.Цэнд 1922 онд Сэлэнгэ аймгийн Шаамар суманд төрсөн хүн.

Тэр ЗХУ-ын Плехановын нэрэмжит Эдийн засгийн дээд сургуульд эдийн засгийн ухаанаар эрдмийн зэрэг /Sc.D/ хамгаалсан хүн. Тэрээр Улаанбаатар Төмөр замд ажиллаж байсан ба Улсын төлөвлөгөөний комиссын дарга зэрэг өндөр албан тушаалуудыг нэр төртэй хашиж явсан хүн. Тэр зохион байгуулах их авъяастай, онолын өндөр бэлтгэлтэй хүн

байлаа. Аль ч талаараа МАХН-ын удирдагч болох боломжтой хүн гэж олон түмэн үнэлдэг байсан юм. Түүнийг тухайн үеийн МАХН-ын УТТ-н дотор олон хүн дэмждэг, Монголын сэхээтнүүд түүнийг хүндэлдэг байсан юм. Л.Цэнд МАХН-ын УТТ-ны хурал дээр Ю.Цэдэнбал улс орныг удирдаж чадахгүй байгаа талаар хэд хэдэн удаа гэмдэглэж хэлсэн юм. Ер нь Л.Цэнд бол үг, дуу цөөнтэй, хэлэх үгээ их боддог, өөрийнхөө санааг бусдад оновчтой үгээр илэрхийлж чаддаг, төлөв төвшин, ноён нуруу сайтай хүн байсан юм. Ю.Цэдэнбал түүнийг ажлаас халах бас өөр нэг шалтгаан хэлсэн юм. Энэ нь “Л.Цэнд албан тушаал хөөцөлдсөн” гэж буруутгасан юм. Өөрөөр хэлбэл, “Л.Цэнд нь МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга болох хүсэлтэй байсан төдийгүй, энэ хүслээ хэрэгжүүлэх алхмуудыг хийж байсан. Ю.Цэдэнбалыг ажлаас нь халах бэлтгэл хийж байсан!” гэх мэтээр түүнийг буруутгаж байсан юм.

Үнэхээр Л.Цэнд нь Ю.Цэдэнбалыг ажлаас нь халах бэлтгэл хийж байсан уу? гэсэн асуулт байдаг юм. Нэгэнт Ю.Цэдэнбал улс орныг удирдаж чадахгүй байгаа нь хэн бүхэнд тодорхой харагдаж байсан болохоор Л.Цэнд тийм бэлтгэл хийж байсан байж болох юм. Ямар ч байсан тэр “Одоо бид Ю.Цэдэнбалын эрх ашгийг бодохоосоо илүү улс орныхоо эрх ашгийг бодох цаг болсон! Бид ажлаа бодох хэрэгтэй байна!” гэсэн утгатай яриаг МАХН-ын ТХ-ны УТТ-ны зарим гишүүдэд ярьдаг байсан юм билээ. Энэ яриаг тэр зөвхөн МАХН-ын дотор биш ЗХУКН-ын ТХ-ны УТТ-ны гишүүн, 2-р нарийн бичгийн дарга Ф.Р.Козлов гэдэг хүнд бас ярьсан байдаг юм билээ. Ф.Р.Козлов бол ЗХУКН-ын ТХ-ны УТТ-ны гишүүд дотор Н.С.Хрущёвын дараагийн хүн байлаа. Тэрээр Л.И.Брежневтэй хамт ЗХУКН-ын ТХ-ны УТТ-нд орж ирсэн, их нэр хүндтэй, нөлөөтэй хүн байсан гэдэг юм.

Яагаад МАХН-ын ийм нарийн дотоод асуудлаар Л.Цэндийн зүгээс Ф.Р.Козловтой ярьж байсныг одоо таахад хэцүү л дээ. Ямар ч байсан Л.Цэнд, Ф.Р.Козлов хоёрын ярианы агуулга ЗХУ-ын Улсыг Аюулаас Хамгаалах Хороо (УАХХ)-ны (оросоор Комитет Государственной Безопасности /КГБ/—ред.) дарга Юрий Андроповын шугамаар Ю.Цэдэнбалын чихэнд хүрсэн юм билээ. Ингээд Ю.Цэдэнбалын зүгээс Л.Цэндийг ажлаас нь халахаар шийджээ. Ингэж МАХН-ын ТХ-ны удирдлагад байсан хоёр сайхан хүн ажлаасаа халагдаж, нутаг заагдан, цөллөгт явсан юм. Энэ хоёрыг ажлаас нь халсан явдал улс орны дотор ихээхэн дулиан, шуугианыг тарьсан юм. МАХН-ын шударга гишүүдийн дотор Ю.Цэдэнбалын нэр хүнд өсөөгүй нь мэдээжийн хэрэг юм.

Улс төрийн ийм хүнд нөхцөл байдлын дунд би ажлаасаа гарах хүсэлт гаргахаар шийдэж байсан юм. МАХН-ын дээд удирдлагад байдаг хүмүүсийн өөрсдийг нь мэдлэг, боловсрол багатай, ажлын туршлагагүй,

улс төрийн зориггүй, аж ахуйн үйл ажиллагааны ашиг, орлогын талаар ойлголт муутай, түүний шаардлагыг гүйцэд ойлгодоггүй байсан нь аяндаа ажилд саад болоод ирсэн юм. Тэд нар зөвхөн л ЗХУ-ын тусламжинд дулдуйдсан, өдөр, хоногийг өнгөрөөсөн бодлого явуулж байлаа шүү дээ. Ийм бодлого ерөөсөө явцгүй болох нь тов тодорхой харагдаад байсан юм. Тэр үед аж ахуй ажлын шаардлага урагшаа ямагт тэмүүлж байлаа шүү дээ. Олон шинэ зүйлийг хийж болохоор харагдаад байсан юм. МАХН-ын удирдлага энэ бүхнийг хүлээж авдаггүй, зөв удирдан чиглүүлж чадахгүй байсан юм. Өөрсдөө энэ бүх гарч ирж байгаа асуудлаас хоцроод, саад болоод байсан юм. Хоосон үзэл суртлаар ходоодоо тэжээхгүй шүү дээ. Аж ахуйн үйл ажиллагааны ашиг, орлогыг тэд нар бүрэн гүйцэд үнэлдэггүй, энэ талаар ойлголт муутай байсан юм. Тухайлбал, ашиг, орлоготой аж ахуйн шинэ салбарыг буй болгож, хөгжүүлэнэ гэдэг бол тэнд ажиллаж байгаа хүмүүсийн амьдарлыг нь дээшлүүлээд зогсохгүй, эцсийн дүндээ Монгол улсын эдийн засгийн өсөлтөнд шууд нөлөөлнө шүү дээ. Бусад оронд, бусад хүмүүс хийж болоод байгаа ажлуудыг бид өөрсдөө, өөрийнхөө оронд хийж болно биз дээ? Ийм бодит боломж бэлээхэн харагдаад байхад түүнийг огт зөв үнэлж чадахгүй байсан юм. Түүний оронд юм бүхнийг зээл, тусламжаар шийдэх гэсэн бүтэлгүй оролдлогуудыг хийгээд, хайран сайхан цаг, хүч, хөрөнгийг шал дэмий барж байсан юм.

Монголын эдийн засагт зээл, тусламж хэрэгтэй байсан уу? Хэрэгтэй байсан. Гэхдээ бүхнийг түүгээр шийдэж чадах уу? Чадахгүй шүү дээ. Бид өөрсдөө юм хийж байж, өөрсдөө хөдөлмөрлөж байж л, өөрсдийн толгойгоор улсаа хөгжүүлэнэ шүү дээ. Монголчуудын өмнөөс манай улсыг хөгжүүлээд, ард түмний амьдралыг өөд нь татаад өгөх нэг ч хүн, нэг ч улс байхгүй. Үүнийг монголчууд бид л өөрсдөө хийх ажил. Энэ бол манай түүхээр батлагдсан туйлын үнэн мөнөөсөө мөн. Ю.Цэдэнбал бид нарын гол зөрчилдөөн энд л байсан юм.

И Л: Одоо манайд газар тариалангийн салбар цаашид хөгжих боломж бий юу?

Ц Л: Манайд газар тариалан хөгжих боломж нь хязгаарлагдмал юм. Энэ нь газар тариалан эрхлэн явуулахад тохиромжтой, үржил шимт хар шороон хөрстэй нутаг нь хязгаарлагдмалтай холбоотой юм. Далайн түвшнээс 1000 метрээс дээш бол улаан буудай боловсрохгүй шүү дээ. Түүнээс доош байдаг талбайн хэмжээ бол манайд бага байдаг юм. Манай нийт нутгийн далайн түвшнээс дээших дундаж өндөр нь 1500 метр орчим юм. Энэ бол улаан буудай боловсроход тохиромжтой өндөр биш. Газар тариаланд хамгийн тохиромжтой гэж үздэг Сэлэнгийн бүс

нутаг далайн түвшнээс 900 гаруй метр өндөрт байдаг юм. Халх голын орчим нутаг бас энэ орчим өндөртэй байдаг юм. Алтайн цаад говьд бас ийм өндөртэй байдаг боловч тэнд газар тариаланд тохиромжтой хар шороон хөрс байхгүй, шар шаварлаг хөрстэй юм. Анх “Атар газрыг эзэмших хөдөлгөөн” эхлэхийн өмнө ЗХУ-аас ирсэн Ю.Старковын ахалсан судалгааны ангийн гаргасан тооцоо нь үнэн байдалд их ойртсон тооцоо гэж би боддог юм. Ю.Старковын ахалсан ажлын хэсэг бол ЗХУ-д “Атар газар эзэмших хөдөлгөөн” эхлэхээс өмнө газар тариаланд ашиглаж болох хар шороон хөрстэй бүс нутгийг тогтоох судалгааг хийсэн туршлагатай эрдэмтэд байсан юм шүү дээ. Тэд нар энд улаан буудайг тариалж болно, энд болохгүй гэдгийг нилээд нарийн тогтоож өгсөн юм. Тэд нар онгоцоор нисээд л бүс нутгийн далайн түвшнээс дээших болон дооших хэмжээг нь тогтоогоод л газар тариаланд ашиглаж болох эсэхийг нь тогтоож байсан юм.

Сүүлд 70-80-аад оны үед манайхан дахин атар газрыг эзэмшиж байгаа нэрээр их хэмжээний бэлчээрийн нутгийг сүйтгэлээ шүү дээ. Төв аймгийн Лүн сумаас нааш их хэмжээний газрыг хагалж, тариа тарьсан юм. Энэ нутаг бол тариа, ногоо ургах боломж багатай, маш муу хөрстэй нутаг юм шүү дээ. Бас Хэнтий аймгийн тал хээрийн бүсийн нутгийг бүхэлд нь хагалсан юм. Энэ бол шинжлэх ухааны үндэсгүй, сэтгэлийн хөөрлөөр хийсэн ажил юм. Эндээс хэзээ ч олигтой ургац авч чадаагүй юм. Одоо бүгд хаягдаад хэнд ч хэрэггүй нутаг болжээ. Хайран сайхан нутаг ингэж малын бэлчээрийн ач холбогдлоо алдлаа. Энэ газруудад одоо нөхөн сэргэлт явагдаж чадахгүй байна. Ийм газар мал билчдэггүй юм.

Бидний анхны хагалсан Орхон-Сэлэнгийн бэлчир, Булган аймгийн нутаг одоо ч өндөр ургац өгч байна шүү дээ. Бид тэр бүс нутагт нилээд шинжлэх ухааны үндэстэй сонголт хийсэн гэж боддог юм. Тийм учраас үнэ цэнээ олон жилийн туршид алдахгүй байна.

Бид нар САА-нуудыг удирдах газартаа бүх САА-нуудтайгаа холбоо барьж болох радио холбооны газрыг байгуулсан юм. Холбооны ийм системийг ЗХУ-ын Казахстаны Целиноградад анх нэвтрүүлсэн юм. Энэ бол онгоцонд хэрэглэдэг радио холбооны систем байв. Би өөрөө Казахстанд очоод холбооны энэ системийг авахаар тохироод, ачиж ирүүлсэн юм.

Тэгээд түүнийгээ байгуулах шийдвэрийг Сайд Нарын Зөвлөлөөс гаргуулахад маш их цаг, хүч хөдөлмөрөө зарцуулж билээ. Эхлээд Холбооны яамны сайд С. Дамдинжаваар зөвшөөрүүлэх хэрэгтэй байв. Тэр үед бид нар улсын холбоогоор нэг САА-тай холбоо барих гэвэл бараг бүтэн өдөр, заримдаа бүр хоёр гурван өдөр ч хүлээх хэрэгтэй болдог байв. Тэгж удаан хүлээсний эцэст нэг юм холбогдохоор хүний

яриа ерөөсөө дуулдахгүй. Хамаг байдаг хүчээ гаргаж хашгираад хоёр гурван үг хэлж чадвал чадна, эсвэл хэлж чадахгүй хоцордог байв. Монгол улс ийм холбоотой байсан юм. “Ийм холбоотой байхад ямар хөгжлийн тухай ярих юм бэ? гэж би байнга бодддог байв. Тэгээд том, жижиг ямар нэгэн шалтгаан гаргаад л С.Дамдинжав сайдтай уулздаг болов. Уулзах бүрийдээ л холбооны тухай яриа өдөөж, манай холбоо муу байгаа талаар бага багаар ярьж түүнд ойлгуулахыг оролддог болов. Тэгсээр байтал нэг өдөр тэр “Нээрэн, тийм шүү! Чиний хэлдэг үнэн шүү! Манай холбоо их муу ажиллаж байгаа юм!” гэж үг алдав. Би ингэж үг алдана гэдгийг хүлээж байсан болохоор би их бэлтгэлтэй очдог байв. Тэгээд “САА-нуудын удирдах газар” өөрийн холбооны системтэй болохоор төлөвлөөд байгаагаа танилцуулаад, өөрийн бэлтгэж орсон бичигт “Та энэ бичиг дээр гарынхаа үсгийг зурж өгөөч!” гэж хүслээ. Тэр хэрэг хаашаа эргэж байгааг ойлгосон бололтой жаахан бодолхийлснээ, дуугүйхэн гарынхаа үсгийг зурчихлаа. Одоо Сайд нарын Зөвлөлөөр оруулж хэлэлцүүлээд, тогтоол гаргуулах хэрэгтэй шүү дээ. Сайд нарын зөвлөл зөвшөөрөл өгөхгүй бол хамаг ажил нурах байв. Тэгээд олон сар энэ талаар бодож явлаа. Тэгээд аз мэдсэн хэрэг асуудлаа оруулахаар шийдлээ. Гэтэл үнэхээр миний аз таарчээ. Яг энэ асуудлыг хэлэлцэх Сайд нарын зөвлөлийн хурлыг Д. Моломжамц удирдахаар болсон байв. Д. Моломжамц бол Улс Төрийн Товчооны гишүүн, МАХН-ын эдийн засгийн асуудал хариуцсан нарийн бичгийн дарга шүү дээ. Ю.Цэдэнбал тэр үед ЗХУ-д богино хугацаагаар явсан юм байж. Ингээд Сайд нарын зөвлөлийн хурадаан товлосон өдрөө, товлосон цагтаа эхэллээ. Яамдын сайд нар, тусгай газрын дарга бүгд ирсэн байв.

Д. Моломжамц хурлаа нээгээд үг хэллээ. Тэгээд хэлэлцэх асуудлууддаа орлоо. Манай асуудлын өмнө хоёр асуудал хэлэлцсэн шиг санагдаж байна. Тэр асуудлууд дутуу боловсруулагдсан гэдэг шалтгаанаар буцчихлаа. Тэгээд манай асуудлыг хэлэлцэх боллоо. Хурлын дарга Д. Моломжамц манай асуудлыг танилууллаа. Тэгээд :

-Улсын холбоо байхад САА-нуудын удирдах газар өөрийн холбооны систем байгуулна гэж юу яриад байгаа юм бэ? Энэ чинь чинь юу гэсэн үг вэ? Улсын дотор дахиад нэг улс байгуулна гэсэн үг үү? Сайд С. Дамдинжав энэ асуудалтай танилцсан юм уу? Яагаад ийм асуудал оруулж ирэв? гээд их ширүүн асуулаа. Сайд С. Дамдинжав босоод :

-Энэ үнэхээр ойлгомжгүй асуудал байгаа юм. Би тантай санал нэг байна. Энэ Лоохууз л ийм асуудал яриад салахаа больчихоод байгаа юм шүү! Ямар учиртай юм бэ? Бүү мэд! гээд л ярилаа шүү. Гэтэл бусад сайд нар ч тэр хоёрын ярьж байгааг дэмжээд явчих шиг боллоо. “Манай асуудал ингээд нурлаа!” гээд миний дотор харанхуйлаад л явчихлаа. Тэгээд

зөвшөөрөл авалгүй шууд л босоод ярилаа.

-Юу болж байна гэж гайхаад, ойлгож ядаад байх юм энд ерөөсөө алга. Атар газрыг эзэмших асуудал бол бүх ард түмний үйл хэрэг. Энэ чинь манай энхрий хайрт намын бодлого. Түүнийг Монголын ард түмэн дэмжиж байна. Газар тариалангийн ажил бол цаг, минуттай өрсөлдөж, уралдаж, хийдэг ажил. Гэтэл бид нар нэг САА -тай холбоо барих гэж хэдэн өдрийг барж байна. Энэ Сайд нарын Зөвлөл гэдэг чинь ийм асуудлыг ойлгодоггүй ямар гээчийн газар болоод хувирчихсан юм бэ? Энэ сайд нар чинь хэлсэн ярьсандаа хүрэхгүй, яагаад ингэж эргэж буцаж байдаг болчихсон юм бэ? Энэ юу болж байна? Энэ асуудалтай сайд С.Дамдинжав танилцсан уу? гэвэл танилцсан. Зөвшөөрсөн үү? гэвэл зөвшөөрсөн. Д. Моломжамц даргын сая энд танилцуулсан төслийн танилцуулга дотор түүнийн зөвшөөрлийн гарын үсэг нь байж байгаа шүү дээ! гээд л ширүүхэн хэлчихлээ. Гэтэл сайд С.Дамдинжав таг дуугүй болчихлоо.

Хурлын дарга Д. Моломжамц дуу нь арай өөр болчихсон :

-Намын бодлого, ард түмэн дэмжсэн ажил гэдгийг ч бид ойлгож байна аа. Уг нь сайн ярилцах л байж л дээ. С. Дамдинжав та хоёр уг нь ярьсан юм байна л даа! гээд дуугүй болчихлоо. Өөр сайд нараас ч үг хэлсэнгүй. Ингээд Сайд нарын зөвлөлийн тогтоол гарлаа. Ингэж миний аз таарч бид нар өөрийн холбоотой болж байв.

Бид нар энэ радио холбоогоо 24 цаг ажиллуулдаг байлаа. Тэгээд газар тариалангийн ажлын явцын талаар улсын хэмжэний САА-нуудаас өдөр бүр мэдээ авдаг байлаа. Бүх САА-нуудын хагалсан газрын зураг миний ажлын өрөөнд байдаг байлаа. Хэдэн трактор хагалгаанд гарсан, хэдий хэмжээний газар өнөөдөр хагалсан зэрэг бүх мэдээг өдөрт нь авдаг байлаа. Тариа хураалтын үед бол хэдэн га-д ургац хураалт явагдаж байгаа зэрэг бүх мэдээг өдөрт нь авч байсан юм. Би ажлынхаа өрөөнөөс бүх САА-н дарга нартай “радио хурал” хийдэг байлаа шүү дээ. Цаг үеийн шуурхай ажлын шаардлага ийм байсан юм. Би өөрөө САА-нууд руугаа онгоцоор нисдэг байв.

Монголын Иргэний Агаарын Тээврийн газраас бид нар нэг онгоцыг хөлсөлж авдаг байв. Миний нисэгчээр сүүлд Монгол улсын гавьяат нисэгч болсон Ц. Даравгар ажилладаг байв. Манай САА- нууд ашигтай ажиллаад “САА-нуудыг удирдах газар”-ын даргын өөрийн мэдэлд 200 сая төгрөг хуримтлагдсан байв. Одоогийнхоор бол 2 сая ам. доллар юм л даа. Энэ мөнгийг юунд зарцуулахыг би өөрөө л шийднэ шүү дээ.

11 Би эрдмийн зэрэг хамгаалахаар болов.

КЮ: Та 1962 онд МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн даргад

өөрөө хүсэлт тавиад ажлаасаа гарчээ. Тэгээд хаашаа явсан бэ?

Ц Л: Би ажлаасаа гараад, дахиад ЗХУ-д явсан юм. Москвад байдаг Темерязовын нэрэмжит Хөдөө аж ахуйн академид очиж эрдэм шинжилгээний ажил хийсэн юм. Тэнд энэ ажлаараа эрдмийн зэрэг хамгаалахаар болсон юм. Миний эрдэм шинжилгээний ажлын сэдэв нь “Сангийн аж ахуйн суурин ба хагас суурингийн нөхцөлд мал аж ахуйн ашиг, орлогыг нэмэгдүүлэх арга, зам” гэсэн нэртэй байсан юм. Миний багш бол Сергей Лазо гэдэг хүн байсан. Тэр барууны оронд удирдлагын ухаанаар эрдмийн зэрэг хамгаалсан хүн байлаа. “Удирдлагын ухаан” гэдгийг одоо “Менежмент” гэдэг болсон юм шиг байна. Энэ сэдвээр эрдмийн ажил хийхэд надад төвөгтэй биш байсан юм.

Ер нь манай оронд малын үүлдэр угсааг сайжруулж, ашиг шимийг нь нэмэгдүүлэх оролдлого их хийдэг байсан юм. Тухайлбал, монгол хонийг нарийн ноостой болгох оролдлогууд хийгдэж байсан юм. Гэвч амжилт олоогүй юм. Ийм хонийг байнгын дулаан хашаа саравчинд, байнга тэжээж маллах ёстой юм. Ийм нөхцөл байхгүй бол нарийн ноостой хонь мал болж чадахгүй л дээ. Малыг бэлчээрийн уламжлалт аргаар маллаж байгаа нөхцөлд нарийн ноостой хонь гаргаж авах боломж байхгүй. Монгол мал бол олон зуун жил энэ бэлчээрийн аргаар малладаг аргадаа бие галбир нь зохицсон байдаг юм. Сангийн аж ахуйн нөхцөлд нарийн ноостой хонийг байнга тэжээгээд, дулаан хашаа саравчинд байлгах боломж бүрдэж байгаа юм. САА-нууд өөрсдөө тэжээлийн маш их нөөцтэй болсон юм шүү дээ. Яваандаа ХАА-н нэгдлүүд ч тариа, ногоо тарьдаг болоод, тэжээлийн ийм баазтай болчихвол нарийн ноостой хонийг маллаж үржүүлэх боломж бүрдэнэ гэж би боддог байсан юм. Нарийн болон нарийвтар ноостой хонины ноосыг үйлдвэрийн аргаар боловсруулаад олон зүйлийг хийж болдог юм. Харин Монгол хонины ноосыг үйлдвэрийн аргаар боловсруулах технологи тэр үед байсангүй. САА-н нөхцөлд Монголын хонины тодорхой хэсгийг нь нарийн болон нарийвтар ноостой болгож үүлдэр, угсааг нь сайжруулж, эдийн засгийнх нь үр ашгийг нэмэгдүүлэх боломж байна гэж би боддог байлаа. Малаас гадна гахай, тахиа зэрэг амьтадыг мөн ижил тэжээлийн баазтай болгох хэрэгтэй юм. Тэжээлийн баазтай бол гахай, тахианы аж ахуй бол маш их ашиг өгдөг аж ахуй байдаг юм л даа.

“Бээжингийн цагаан нугас” гэж та нар мэдэх байлгүй дээ. Бид нар Бор нуурын САА-д Бээжингийн цагаан нугас 100 мянгыг тэжээдэг боллоо. Тэндээс нугасны махыг Улаабаатарын гуанз, хоолны газруудад нийлүүлдэг байлаа. Бас өндгийг нь авна. Энэ аж ахуй маш их ашиг өгч байсан юм. Би өөрөө ийм ажлуудыг хийж байсан болохоор судалгааны

ажил надад төвөгтэй биш байлаа. Би ЗХУ-д 2 жил болохдоо өөрийн эрдмийн ажлын диссертацийг бичээд бэлэн болгочихсон байсан юм.

12 Ю. Цэдэнбалыг би ингэж шүүмжлэв.

И Л: Та 1956 онд хуралдсан МАХН-ын 2-р бүгд хурал дээр МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга, Ерөнхий сайд Ю.Цэдэнбалын ажлын арга барилыг анх удаа хурц шүүмжилсэн юм байна. “Үндэсний боловсон хүчнийхээ үгийг нь сонсохгүй байна!” гэж шүүмжлэж байсан юм билээ. Энэ талаар жаахан тайлбар хэлж өгнө үү?

Ц Л: Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал хоёрын өөрийн орны боловсролтой сэхээтнүүдэд хандах хандлага эрс өөр байсан юм. Х.Чойбалсан бол мэргэжилтэй залуу хүний үгийг нь их сонсдог, заримыг нь өөрөө дагуулаад хөдөө орон нутгаар явж, ард түмний амьдралтай танилцуулдаг, ажил хийх арга барилыг зааж сургадаг, тэднийг ямагт дэмждэг хүн байлаа. Гэвч тэр үед мэргэжилтэй залуу хүн их цөөхөн байлаа шүү дээ. Х.Чойбалсангаас хойш дотоод, гадаадын их, дээд сургуульд сурч төгссөн, мэргэжилтэй залуу хүний тоо аажимдаа өсөөд ирсэн юм. Тэд нар Монгол улсынхаа цаашдын хөгжлийн асуудлаар янз бүрийн санаа, оноо гаргадаг болсон юм. Залуучуудаас олон сайхан санаачлага гарч байсан юм. МХЗЭ-ийн ТХ-ны 1-р нарийн бичгийн дарга Дангаасүрэнгийн санаачлагаар Чингэлтэйн голын усыг боогоод Ногоон нуурыг байгуулж байсан юм. Энэ чинь хотыг усны үерийн аюулаас хамгаалахад их ашиг тустай ажил болж байсан юм.

Улаанбаатар хотын эрчим хүчний хангамжийг сайжруулах санал, санаачлага бас л залуучуудын зүгээс их гарч байсан юм. Олон төсөл, төлөвлөгөө явж байсан юм. Зарим нь бүр усан цахилгаан станц барих талаар ч яриад л явж байсан юм. Мэргэжил мэдлэгтэй, боловсролтой залуучууд олшроод ирэхээр Ю.Цэдэнбал улс орноо удирдаж чадахгүй байгаа нь улам бүр илэрхий болоод ирсэн юм. Ю.Цэдэнбалын хувийн дутагдал, улс төрийн алдаатай бодлогын талаар нийгэмд янз бүрийн яриа “хуурай өвсөнд тавьсан түймэр” шиг хурдан тархаж байсан юм. Ю.Цэдэнбал ийм яриануудыг “сэхээтний төөрөгдөл” гэж нэрлэсэн юм. Тэгээд түүнийг дарахаар шийдсэн юм.

Гэхдээ яг хэн гэдэг хүн, Ю.Цэдэнбал улс орноо удирдаж чадахгүй байгаа талаар юу гэж ярьж байгаа нь огт мэдэгддэггүй байж л дээ. Анх хэн, юу гэж ярьсан нь мэдэгдэхгүй ярианууд нийгэмд тархаад байсан байна л даа. Тэгээд тэр ийм яриа гаргаж байгаа эздийг нь олж тогтоохоор шийдсэн байна. МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга нар болон төрийн сайд, дарга нарыг үйлдвэр, аж ахуйн газрууд, төрийн яамдууд,

төр-олон нийтийн байгуулгуудад явуулж, хөдөлмөрчин олон түмэнтэй уулзалтуудыг зохион байгуулсан байна. “МАХН-ын удирдагчид, төрийн сайд, дарга нар бол хөдөлмөрчин олон түмний санаа бодлыг сонсоод, тэдний хүсэж байгаа зүйлүүдийг судлаад, дараа, дараагийнхаа хийх ажлын төлөвлөгөөнд тусгаад, хэрэгжүүлэх юм! Тийм учраас өөрсдийн бодол санаа, бодлыг чөлөөтэй, илэн далангүй сайн ярьцгаах хэрэгтэй! Та нарт айх аюул байхгүй!” гэж олон түмэнд тайлбарласан байна. “МАХН-ын удирдагчид, төрийн сайд дарга нар улс орны хөгжил, ирээдүйн талаар бидний санаа бодлыг сонсохоор ирлээ!” гэж олон түмэн итгэсэн юм. Ингээд тэд нар тэр уулзалтууд дээр Ю.Цэдэнбал улс орноо удирдаж чадахгүй байгаа талаар болон Монгол-Зөвлөлтийн найрамдалт харилцааны талаар, улс орныхоо хөгжил, ирээдүйн талаар өөрсдийн санаа, бодлыг чөлөөтэй ярьцгаасан юм. Ю.Цэдэнбал энэ уулзалтуудын материалд тулгуурлаад, түүний өөрийнх нь тухай болон Зөвлөлт-Монголын найрамдалын талаар шүүмжлэлтэй үг хэлсэн хүн бүгдийг ажлаас нь халж, МАХН-ын гишүүнээс хөөж, нутаг заан цөлж, амьдралаар нь хохироосон юм. Ингэж олон хүн “сэхээтний төөрөгдөл” гэдэг энэ зохиомол хэрэгт холбогдож, ажил, амьдралаараа хохирсон юм.

1956 оны бүгд хурал дээр би Ю.Цэдэнбалыг шүүмжилсэн нь огт шинэ зүйл биш юм. Би түүнд өмнө нь олон дахин хэлдэг байсан зүйлүүдээ дахин давтан хэлсэн юм. Ялгаа нь МАХН-ын бүгд хурал дээр хэлсэнд л байсан байх. Би тэр бүгд хурал дээр хэлсэн үгийнхээ гол санааг дараах байдлаар илэрхийлсэн юм.

- Үндэсний сэхээтнүүдийнхээ санал бодлыг сонсч, дэмжиж туслах ажил маш их доголдож байна. Үйлдвэрийн машин, техникийг хөдөлгөх, засах тухайд бол гадаад орноос инженер-техникийн мэргэжилтнүүдийг урьж ирүүлээд, заалгаж авч болох байх. Харин өөрийн орны хөгжлийн одоогийн түвшин, хэтийн төлөвийн талаархи онолын асуудлыг бид өөрсдөө л үндэсний сэхээтнүүдийнхээ хүчинд тулгуурлан боловсруулах ёстой биш үү? Энэ ажлыг өөр хэн ч бидэнд хийж өгөхгүй. Бид хүний заасан замаар яваад байж болохгүй. Энэ чинь хаана очихоо харж, мэдэхгүй яваа, хараагүй хүнтэй адил зүйл биш үү? Ер нь МАХН-ын үндсэн үүрэг бол онолын үйл ажиллагаа байх ёстой бөгөөд чухамдаа сэхээтнүүдийнхээ бүтээлч хүчийг зөв ашиглан байж энэ үүргийн гүйцэтгэх ёстой. Өөрийн орны сэхээтнүүдийн санал бодлыг үл тоомсорлож, чадал хүчийг нь чамлан басамжилж, түүгээрч зогсохгүй эх орныхоо хөгжил цэцэглэлтийн төлөө сэтгэл, санаа зовсондоо шулуун шударга, шүүмжлэлтэй үг хэлсэн, ярьсан хүмүүсийг хавчин гадуурхдаг боллоо. Энэ бол үнэхээр эрүүл биш байдал мөн. Ийм байдалтай хойшид хэрхэвч эвлэрч

болохгүй.

- Тус улсын гадаад бодлого идэвхтэй биш байна. Нэгдсэн Үндэстний Байгууллагад элсэн орох ба дэлхийн бусад олон улсуудтай харилцаа холбоогоо өргөжүүлэх талаар бие даасан гадаад бодлого алга байна! гэж хэлсэн юм.

Миний хэлсэн үг бүрэн эхээрээ МАХН-ын архивт байх ёстой. Түүнийг чинь олон түмэнд үзүүлэхээс айж, их нуудаг байлаа шүү дээ. Монгол улсын хөгжлийн хэтийн төлөвийн асуудлуудыг арав, арван жилээр дахин дахин засаж боловсруулж байх ёстой юм. Одоогийн арван жилд юу хийх ёстой вэ? гэдгээ тогтоод, дараагийн арван жилд нь хийх ажлынхаа ерөнхий чигийг нь гаргаад явах ёстой юм. Үүнийг чинь монголын урдаа барьдаг сэхээтнүүдийн хүчээр л хийх ёстой ажил шүү дээ. Өөр хаана ч байхгүй зөвхөн Монголын онцлог гэж байна шүү дээ. Үүнийг гадаадын ямар ч ухаантай, боловсролтой хүн ойлгодоггүй юм. Дайны үеэс эхлээд, дайнаас хойш манай бүх системд Зөвлөлтийн мэргэжилтнүүд ажиллаж эхэлсэн шүү дээ. ЗХУ-аас ирсэн мэргэжилтнүүдтэй санал зөрсөн, тэдний өгсөн зөвлөлгөөг хүлээн аваагүй, авч хэрэгжүүлэхээс татгалзсан, ЗХУ-ын талаар шүүмжлэлтэй үг хэлсэн хүмүүсийг шууд ажлаас нь халдаг эсвэл албан тушаал бууруулж өөр ажилд томилдог, зарим хүнийг хол газарт цөлдөг байлаа шүү дээ. Ийм залхаан цээрлүүлэх ажлуудыг Ю.Цэдэнбал өөрөө шууд санаачилдаг, удирддаг байсан юм. Ийм замаар Монголын олон сайхан хүн ажил амьдралаасаа салж, нийгмийн хог дээр хаягдаж байсан түүх өнөөдөр хуучраагүй байна.

Монгол-Зөвлөлтийн найрамдалт харилцаа хэрэгтэй юу? Маш их хэрэгтэй. Би өөрөө ЗХУ-д сургуульд сурч төгссөн, орос хүнтэй дотно сайхан найзлаж, нөхөрлөж явсан хүн шүү дээ. Орос хүмүүс бол гүндүүгүй, маш сайхан зантай, оюуны асар их хүчин чадалтай хүмүүс байдгийг би сайн мэднэ. Би энэ найрамдлыг хөгжүүлэх, өргөжүүлэхийн төлөө л байсан. Түүнийг ганц хамгаалагч нь, ганц хөгжүүлэгч нь Ю.Цэдэнбал ч биш байсан юм. Энэ найрамдлын эх үндсийг Ю.Цэдэнбалаас өмнө, манай халуун эх орнчид тавьсан юм. Бид бүгдээрээ энэ найрамдлыг бэхжүүлэхийн төлөө чадах болон чадахгүй бүхнийг хийж байсан шүү дээ. Гэхдээ энэ найрамдалд шүүмжлэлтэй хандах юм тэр үед их байсан юм аа. Та нар “мал туувар” гэж юу болохыг мэдэх байлгүй дээ. Баруун аймгаас мал тууж ирсэн малчдаас асуудаг “Сталины сахал хөдөлгөх гэж ирэв үү?” гэсэн шог асуулт байсан юм. Улаанбаатар төмөр зам ашиглалтанд орсноос хойш гарсан бас нэг шог яриа байсан юм. Галт тэрэг Москвагаас ирэхдээ “Өөх, тос, Өөх тос!” гэж дуугардаг, буцахдаа “Ханалаа, цадлаа, ханалаа, цадлаа!” гэж дуугардаг гэсэн яриа байсан юм. Ард түмэн манай хоёр орны найрамдалт харилцаанд тэгш биш, шудрага биш юм их байна гэдгийг

ийм маягаар, шог яригаар шүүмжилдэг байж. Ю.Цэдэнбалд өөрийн орныг хөгжүүлэх, өөрийн бодол, санаа байсан болов уу? гэсэн асуулт аяндаа төрөөд байдаг юм. Өөрийн орны эрх ашгийг ямагт хойш тавьж байсан түүнд тийм бодол, санаа байсан гэж хэлэхэд хэцүүхэн л юм даа.

Манайд хуучин “Төрийн хар хайрцагны бодлого” гэж байсан юм. Түүнийг чинь Монгол хүн өөрөө бодож боловсруулж байсан юм. Ийм бодлого байхгүй бол улс, үндэстэн байхгүй болно шүү дээ. Манай хоёр том хөрш Монголын төлөө олон жил хоорондоо тэмцэлдэж ирлээ шүү дээ. Орос бол Сибирийг бүхэлд нь өөрийн мэдэлд оруулснаас хойш манайхыг илэрхий сонирхож эхэлсэн юм. Тэд нар Буриадын нутгийг өөрийн болгосны дараа их идэвхжсэн юм. Монголын талаар явуулж байсан Орос улсын бодлого, Манж Чин улсын бодлого хоорондоо их ялгаатай байсан юм. Манж Чин улс Монгол хүнийг өөрийг нь цөөн болгох, түүнийг бүр байхгүй болгох сонирхолтой байсан юм. Ингэж чадвал Монгол нутаг аяндаа тэдний мэдэлд орно шүү дээ. Орос улс бол түүний эсрэгээр монгол хүнийг өөрийг нь олон болгох сонирхолтой байсан юм. Ингэж чадвал Монголын өргөн уудам нутаг аяндаа өөрөө Манж Чин улсаас хөндийрээд ирнэ шүү дээ. Орос улсын Төв Азид явуулсан геополитик нь Сибирийн төмөр замтай салшгүй холбоотой юм. Орос улс энэ замаас Манж Чин улсыг аль болохоор хол байлгах сонирхотой байсан юм. Энэ сонирхлоо хэрэгжүүлэхэд Монгол улсын нутаг дэвсгэрийн байршил нь Орос улсад маш их ашигтай байж. Орос улс өөрийн энэ сонирхолдоо хөтлөгдөөд маш идэвхитэй ажиллаж эхэлсэн юм. Гэтэл түүний энэ сонирхолд цаашид саад болох зүйл хоёр байгааг ойлгож эхэлсэн байна.

Энэ нь нэгдүгээрт Монголын нийгэмд асар их нөлөөлтэй Бурхны шашин, хоёрдугаарт “Монголын үндэсний үзэл” юм. Энэ хоёрын аюулаас яаж салах вэ? Бүрмөсөн салдаггүй юмаа гэхэд багасгах ямар боломж байгааг хайж эхэлсэн байна. Оросын хаадын олон зууны биелэшгүй мөрөөдөл, толгойны өвчин болоод байсан энэ асуудлыг Ленин тэргүүтэй Оросын коммунистууд /большевикууд/ өөрийнхөөрөө шийдэж эхэлсэн юм. В.И.Лениний үүсгэн байгуулж, удирдаж байсан Коминтерн Монголын урдаа барьдаг, мэдлэг боловсролтой, ухаантай эх орончдыг ямар ч шалтгаангүйгээр толгой дараалан устгаж эхэлснийг бид санаж байна. И.В.Сталин энэ ажлыг өөрийн гаршсан “террорист” аргаараа гүйцээсэн юм. Социализм-коммунизмын тухай яриа бол тэдний энэ зорилгоо хэрэгжүүлэх халхавч л байснаас өөр юу ч байгаагүй юм.

Энэ тал дээр Мао Зэ Дун, тэдэнтэй “усны дусал шиг” адилхан байсан юм. “Танайд бид 300 жилийн өр тавьчихсан юм. Түүнийгээ буцааж төлнө!” гэсэн утгатай, Мао Зэ Дунгийн хэлсэн үг байдаг юм. 1956 онд МАХН-ын ТХ-ны төлөөлөгчид шинээр байгуулагдаад удаагүй байсан

БНХАУ-д айлчлан очих үеэр Мао Зэ Дун энэ үгийг хэлсэн байдаг юм. Мао Зэ Дунгийн хэлсэн “Бид” гэж хэн бэ? 300 жилийн өмнө коммунист Мао Зэ Дун, түүний удирдсан Хятадын Коммунист Нам, улаан Хятад гурав байгаагүйг бид нар илүү мэднэ. Тэр үед Манжийн эзэн хаан, Манж Чин улс, Монгол гурав бол байсан юм”. Зөнөсөн коммунист Мао Зэ Дун бол Манжийн эзэн хаан ч биш, түүний албан ёсны залгамжлагч бол бүр ч биш гэдгийг түүх гэрчилнэ. Түүний шаахайны улан дор тарчлан зовж байсан улаан Хятад ч Манж Чин биш шүү дээ. В.И.Ленин, И.В.Сталин, Мао Зэ Дун нар түүхийн үнэнийг эрээ цээргүй гуйвуулагчид гэдгийг хүн төрлөхтөн өөрийн арьсаар мэдэрсэн юм. Түүх бол түүхээрээ үлдэх ёстой. Түүнийг хэн нэгэн хүн дураараа засварлаж, тайлбарлаж болдоггүй юм. Тэгж чаддаг ч үгүй юм.

Ю.Цэдэнбал засгийн эрх барьсан жилүүдэд монголчууд бид өөрийн үнэн түүхгүй, соёлгүй ард түмэн болж хувирсан юм шүү дээ. Ард түмний бүтээсэн агуу их түүх, түүний үлдээсэн гүн гүнзгий ул, мөрийг дэлхийн түүхээс арчин арилгаж, ард түмний бүтээсэн мөнхийн соёлыг хүн төрлөхтний соёлын их өв, сангаас гаргаж, устгаж, үгүйсгэж хэн ч чадахгүй л дээ. Гэхдээ цөөн тооны үндэстнүүдийн нэгэн адилаар, тэдний түвшинд бидний тухай ярьж, бичдэг боллоо шүү дээ. Энэ байдал ялангуяа монгол бичгийг кирилл бичгээр сольсноос хойш улам бүр газар авсан юм. Үндэсний бичиггүй, өөрийн түүхгүй, соёлгүй юм шигээр, цөөн тооны үндэстнүүдтэй нэгэн адилаар бидний тухай ярьж, бичиж эхэлсэн юм шүү дээ. “Ийм цөөн тооны үндэстнүүд биеэ даагаад коммунист нийгэмд ортлоо хөгжиж чадахгүй. Гийм учраас аль нэгэн “их үндэстэн”-ний хамтаар, түүний тусламжийг авснаар оршин тогтнож, өөрийгөө авч үлдээд, коммунист нийгэмд орох боломжтой юм! Тухайлбал, ЗХУ-ын бүрэлдэхүүнд орсон цөөн тооны үндэстнүүдийн нэгэн адил, “их Орос үндэстэн”-ийг түшиглээд, түүнтэй хамт “Зөвлөлт үндэстэн”-ийг бүтээлцээд, коммунист нийгэмд орвол хөгжлийн дээдийг олох боломжтой юм!” гэсэн үзэл их газар авч байсан юм.

Зөвлөлтийн эрдэмтэд, улс төрийн зүтгэлтнүүд ийм “онол”-оор ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж орсон цөөн тооны үндэстнүүд, олон нийтийн “тархийг угааж” байх үед түүнийг улам дэвэргэсэн, нэг хоосон цуурхал яриа гарсан юм. “Монгол улс ЗХУ-ын бүрэлдэхүүнд орж, түүний 16-р Бүгд найрамдах улс болох хүсэлтээ гаргасан!” гэдэг цуурхал яриа байсан юм. Ийм яриаг чухам хэн анх гаргасан нь одоогоор сайн тогтоогдоогүй байна. Ийм хоосон, цуурхал яриаг ЗХУКН-ын ТХ болон Улсыг Аюулаас Хамгаалах Хорооны зүгээс гаргаад, Монголын олон нийтийн санаа бодлыг туршиж байсан ч байж болохыг үгүйсгэх аргагүй юм. Монголд “Энэ яриаг гаргасан эзэн нь Ю.Цэдэнбал мөн!” гэж үздэг хүмүүс олон

байдаг юм. Бас энэ яриаг анх “Монголын нэг хэсэг эрдэмтэд, улс төрчид гаргасан!” гэсэн яриа ч байдаг юм. Энэ хоосон цуурхал яриа И.В.Сталиныг нас барсны дараа үеэс эхлэн мартагдаж эхэлсэн юм. Ю.Цэдэнбалын хийсэн үйлдэл бүр нь эцсийн дүндээ ийм байдалд биднийг оруулж байсан юм шүү дээ.

1940-өөд оны эцсээр Монгол улс НҮБ-ийн гишүүн болох асуудал их яригддаг болсон юм. Ерөнхий сайд, маршал Х.Чойбалсан энэ асуудалд онцгой ач холбогдол өгч байсан юм. Хар залуугаасаа Монголын төлөө өөрөөсөө хамаарах болон хамаарахгүй бүхнийг хийж, үхэхээс бусдыг үзсэн түүнд Монгол улс НҮБ-ийн гишүүн болох нь нэг насны мөрөөдлийн биелэл нь ч байсан байж магадгүй. Ингээд Х.Чойбалсан 1947 онд энэ асуудлыг шийдүүлэхээр Ю.Цэдэнбалыг Нью-Йорк руу илгээсэн юм. Ю.Цэдэнбал тэнд очоод НҮБ-ын чуулганд нэг удаа үг хэлснийг эс тооцвол юу ч хийгээгүй буцаж ирсэн юм билээ. Бусад орны төлөөлөгчидтэй уулзаж, өөрийн орныг сурталчлах, тэдний дэмжлэгийг авах талаар ямар ч ажил зохиогоогүй байдаг юм. Үүнээс үүдээд Ю.Цэдэнбалд Монгол улсыг НҮБ-ийн гишүүнд элсүүлэх сонирхол ер нь байсан болов уу? гэсэн асуулт төрдөг юм. Нью-Йорк хотод очоод, юу ч хийлгүй, өрөөнөөсөө ч гаралгүй хэдэн өдөр зүгээр суусан түүний хачин үйлдлийг юугаар ч тайлбарлах боломж олддоггүй учир яах ч аргагүй ийм асуулт төрдөг юм.

Гэхдээ түүнээс хойших Ю.Цэдэнбалын үйлдлийг ажиглахад тийм сонирхол түүнд байсан байж магадгүй гэсэн бодол төрүүлдэг ч гэсэн Монгол улс НҮБ-ийн гишүүнээр элсэх асуудал 1962 оныг хүртэл сунжирсан юм. 1962 онд Монгол улс НҮБ-ийн гишүүн болж, Байнгын төлөөлөгчийн газраа ажиллуулж эхэлсэн юм. НҮБ Монгол улсыг гишүүнээрээ элсүүлэн авах шийдвэрээ гаргаж байх тэр үед Ю.Цэдэнбал хөлөө хугалаад, Москва хотод эмнэлэгт хэвтэж байжээ. “Дургүй бол хүчгүй!” гэсэн нэг үг Монголд байдаг юм.

13 МАХН-ын ТХ-ны 6-р бүгд хурал.

И Л: Та 1964 онд хуралдсан МАХН-ын 6-р бүгд хурал дээр Ю.Цэдэнбалыг маш хүчтэй шүүмжилсэн юм байна. “Улс орныг хөгжүүлэх шинжлэх ухааны үндэстэй хэтийн төлөвлөгөө байхгүй байна!” гэх мэтээр шүүмжлэлээ өрнүүлжээ. Та энэ шүүмжлэлийнхээ талаар жаахан тайлбар хэлж өгнө үү?

Ц Л: 1964 он бол их онцлогтой үе л дээ. Энэ үе бол ЗХУКН-ын 20, 21, 22-р Их хурлууд хуралдчихсан байсан үе. Энэ хурлуудаар ЗХУКН-ын нэгдүгээр нарийн бичгийн дарга, Сайд нарын Зөвлөлийн дарга

Н.С.Хрущёв И.В.Сталины үеийн улс төрийн хэлмэгдүүлэлтийг хурцаар шүүмжлэж, нийгэм бүхэлдээ ихээхэн урам зориг орж, итгэл найдвар төрсөн үе байсан юм. Үүнийг түүхэнд “Н.С. Хрущёвын дулааралын үе” гэж нэрлэдэг шүү дээ. Би Москвад Темерязовын нэрэмжит ХАА-н академид эрдэм шинжилгээний ажил хийж байлаа. Бүгд хурал дээр надтай хамт шүүмжлэл тавьсан Б.Нямбуу Коммунист Намын дээд сургуульд сурч байлаа. Бид хоёр хоёулаа МАХН-ын ТХ-ны Бүгд хурлын гишүүн байлаа. Энэ хурал дээр шүүмжлэл тавих нэг шалтгаан байсан юм. Энэ бүгд хурал бол МАХН-ын 14-р их хурлаас хойш хуралдсан хамгийн сүүлчийн бүгд хурал байсан юм. Дараа жил нь МАХН-ын 15-р Их хурал хуралдаж, МАХН-ын ТХ-ны шинэ гишүүдийг сонгох ёстой байсан юм. Тийм учраас бидний бүгд хурлын гишүүн байх хугацаа үүгээр дуусаж байсан юм. МАХН-ын дүрмээр бол МАХН-ын ТХ-ны гишүүнийг МАХН-ын их хурлаар сонгож, баталдаг байсан юм. МАХН-ын ТХ-ны гишүүнийг сонгох сонгуульд нэр дэвших хүмүүсийн нэрийг эхлээд МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга өөрөө сонгож аваад, УТГ-ны хурлаар урьдчилан хэлэцэж батлаад, их хуралд оруулж ирээд, сонгууль явуулдаг байсан юм. Нэгэнт МАХН-ын УТГ-ны хурлаар хэлэлцээд баталсан бол Их хурал нэр дэвшсэн хүмүүсийг бараг зуун хувийн саналаар сонгодог байлаа. Бид нар Ю.Цэдэнбал болон түүний “тойрон хүрээлэгч” нарыг хэд хэдэн удаагийн бүгд хурал дээр шүүмжилж байсан юм. Тийм болохоор дараагийн их хурлаар дахин МАХН-ын ТХ-ны Бүгд хурлын гишүүнд бидний нэрийг дэвшүүлэхгүй нь ойлгомжтой байсан юм. Тэгээд бид нар бүгд хурлын гишүүн байгаа энэ боломжоо ашиглаад, намын хамт олны өмнө Ю.Цэдэнбалын ажлын арга барил, түүний явуулж байгаа алдаатай бодлогыг нь шүүмжлэн хэлж өгөхөөр шийдсэн юм.

Бид хоёр энэ талаар Москвад уулзаад ярилцдаг байсан юм. МАХН-ын дүрмээр бол МАХН-ын ТХ-ны Бүгд хурлын гишүүн хүн бол заавал бүгд хурлын ажиллагаанд биеэрээ оролцох ёстой юм. Тийм учраас бид хоёр бүгд хурлын ажиллагаанд биеэрээ оролцохоор шийдэж байсан юм. Гэтэл бид хоёр бүгд хурлын ажиллагаанд биеэрээ оролцохоор шийдэж байгаа мэдээ Ю.Цэдэнбалд хүрсэн байна. Бүгд хурлын өмнөхөн Ю.Цэдэнбал Москвад очсон юм. Ю.Цэдэнбалд Москвад очих өөр зорилго байсан байх.

Тэр үед бидэнтэй нэг уулзалт зохиосон юм. Тэр уулзалт дээр: “Одоогийн Бүгд хурал аж ахуйн чанартай асуудал хэлэлцэх юм. Та хоёрын сургуульд сурч байгаа байдлыг харж үзээд бид чөлөө олгохоор шийдсэн. Бүгд хурлын ажиллагаанд заавал биеэрээ очиж оролцох хэрэггүй!” гэж хэлж байсан юм. Тэр биднийг хуралд оролцуулахгүйг хичээж байгаа нь ойлгомжтой байсан юм. Бид хоёр МАХН-ын ТХ-ны Бүгд хуралд очвол заавал өөрийг нь шүүмжлэж эхлэнэ гэдгийг тэр өөрөө сайн ойлгож байсан

юм.

Тэр үед Ю.Цэдэнбалд мэдээ өгч, хов зөөдөг хүмүүс Москвад ажиллаж, амьдарч, сурч байсан хүмүүсийн дотор олон байсан юм. МАХН-ын гишүүд бие биенээ тагнадаг, сургуулийн оюутнууд бие биенээ тагнадаг тийм муу тогтолцоог буй болгосон байлаа шүү дээ. Ийм аргаар нийгэмд болж байгаа үйл явдлуудыг Ю.Цэдэнбал хяналтандаа барьдаг байсан юм. Ю.Цэдэнбалд хов хүргэж, олон дахин мэдээлэл өгсөн хүнийг өндөр албанд томилдог, мөнгө, төгрөгөөр шагнадаг боллоо шүү дээ.

Ингээд бид хоёр МАХН-ын ТХ-ны бүгд хуралд нууцаар ирэхээр шийдсэн юм. Бид хоёр энэ удаа Ю.Цэдэнбалыг анх удаа шүүмжлэх гэж байгаа биш юм. Түүнтэй уулзахдаа алдаа, дутагдлыг нь олон дахин хэлдэг л байсан юм. Энэ бол уг нь хүн айгаад байхаар шинэ зүйл биш юм. 1956 оны МАХН-ын ТХ-ны 2-р бүгд хурал дээр намын хамт олны өмнө анх удаа шүүмжилснээсээ хойш ажил, төрлийн болон амин хувийн шугамаар түүнтэй олон дахин уулзаж байсан юм. Уулзах бүрийдээ л “Тийм ийм алдаа байна шүү, тэгж ингэж хүмүүс ярьж байна, ингэж тэгж ажиллахгүй бол болохгүй нь байна шүү!” гээд л ярьдаг л байлаа шүү дээ. Энэ хооронд чинь 10 орчим жил өнгөрсөн юм шүү дээ.

МАХН-ын 6-р бүгд хурал 1964 оны 12-р сард хуралдсан юм. Энэ хурлаар “Нам улсын хяналт, шалгалтыг сайжруулах тухай” гэсэн нэртэй Ю.Цэдэнбалын илтгэлийг хэлэцсэн юм. Хуралд оролцож байгаа МАХН-ын ТХ-ны Бүгд хурлын гишүүд илтгэлтэй холбогдуулаад 15 минутын үг хэлэх ёстой байсан юм. Энэ Бүгд хурал дээр биднийг шүүмжлэл тавина гэж мэдэж байсан болохоор урьдаас маш нарийн бэлтгэсэн байсан юм. Хуралд үг хэлэх хүний нэрсийн жагсаалтыг гаргаад, хэн хэзээ үг хэлэхийг нь урьдчилаад тогтоосон юм билээ. Бид хоёрын өмнө хойно үг хэлэх хүний нэрийг тогтоогоод, хэлэх үгийг нь бэлтгэж өгсөн юм билээ. Тэр үг хэлж байгаа хүмүүсийн зорилго бол бидний шүүмжлэлийг няцааж, биднийг өөрсдийг нь шүүмжлэх явдал байсан юм. Энэ бүгд хурал дээр би Ю.Цэдэнбалыг хэд хэдэн асуудлаар шүүмжилсэн юм.

- Ю.Цэдэнбал МАХН-ын ТХ, Засгийн газрыг удаан хугацаагаар удирдаж ирсэн боловч хийсэн бүтээсэн нь үлэмж бага байна.
- Ю.Цэдэнбал Монгол улсын нутаг дэвсгэрийн нэг хэсэг, өөрийн төрсөн газар, шороогоо хүртэл гадаад оронд зүгээр найр тавин өгдөг болсон байна.
- Ю.Цэдэнбал манай гадаад бодлогод аюул учруулж байна. ЗХУ, Хятад гэсэн хоёр том гүрэн маргалдаж байна. Ю.Цэдэнбал энэ мэт дэлхийн ажилчны хөдөлгөөнд гарсан маргаан, зөрөлдөөнийг улам дэвэргэж байна.
- Ю.Цэдэнбал манай гадаад өрийг багасгах талаар ямар ч арга хэмжээ

авахгүй байна. Манай гадаад өр замбараагаа алдаж, улам бүр өсөн нэмэгдсээр байна.

- Ю.Цэдэнбал, түүний удирдсан МАХН-ын ТХ-нд өнөөдөр манай орны эдийн засгийг хөгжүүлэх жинхэнэ шинжлэх ухааны үндэстэй хэтийн төлөвлөгөө алга байна. Бүх ажил тодорхой зорилгогүй, төлөвлөгөөгүй, урсгалаараа, удирдлагагүй явж байна. Ийм байдлаас болоод манай эдийн засаг гадаадын зээл, тусламжинд дулдуйдсан, биеэ даах чадваргүй эдийн засаг болж хувирсан байна.
- Ю.Цэдэнбал МАХН-ын ТХ-ны бүгд хурлыг нууцаар, хуйвалдааны журмаар зохион байгуулдаг болсон байна. Ийм журмаар МАХН-ын сүүлийн Бүгд хурлуудыг зохион байгуулж, Д.Төмөр-Очир, Д.Цэнд нарын асуудлыг хэлэлцүүлж, тэднийг гүтгэж, ажлаас нь халж, цөлсөн байна.
- Ю.Цэдэнбал улс төрийн туршлага багатай залуучуудыг айлгаж, заримд нь хээл хахууль өгч зальхай муу арга хэрэглэн, шударга биш замаар сонгон авч байна. Тэд нар зөвхөн түүнийг өөрийг нь хамгаалахаас өөр хийсэн бүтээсэн зүйлээр бага байна.
- Ю.Цэдэнбал Дотоод яамны хүчийг үлэмж хэмжээгээр зузаатгасаар байна. Энэ юуны тулд хийж байгаа ажил вэ? 1937-1938 оны үеийн улс төрийн их хэлмэгдүүлэлтийг дахин давтан хийхийн тулд уу?
- Ю.Цэдэнбал Эх орныхоо ирээдүйн хөгжлийн төлөө санаа зовсон сэхээтэн, залуучуудыг “Монгол-Зөвлөлтийн найрамдалд хор учруулж байна!”, “Үндэсэрхэг үзэл гаргаж байна!”, “Дэмий юм чалчиж байна!” гэсэн үгээр зэмлэж, дарамталдаг, ажлаас нь халж, цөлдөг болсон байна.
- Ю.Цэдэнбалын хувийн дутагдал нь МАХН-ын болон төр, засгийн өндөр алба хашиж байгаа хүмүүст халдварласан байна. Түүний ойр орчинд байгаа зарим хүмүүс гэр бүлээрээ нийлээд улсын хөрөнгийг идэж, зарим нь албан тушаалд дэвших элдэв төлөвлөгөө зохиож суудаг болсон байна.
- Ю.Цэдэнбал МАХН-ын болон төр, засгийн хөрөнгө, хүчийг өөрийгөө МАХН-ын болон төр, засгийн өндөр албан тушаалд байнга байлгаж байхад л зэвсэг болгон хэрэглэж байна. Социализм байгуулах тухай түүний яриа бол зөвхөн энэ зорилгынх нь халхавч л болсон байна.
- Ю.Цэдэнбалыг удирдлагаас гаргавал, улс орныг удирдах өөр хүн манай намд байхгүй мэт яриаг тэр өөрөө гаргадаг болсон байна. Түүнийг энэ албан тушаалд он удаан жил байлгаж тахиж, шүтсэнээс болж манай нам их хохирч байна. Энэ асуудлыг одоо яаралтай шийдэх цаг нь болсон байна.

- Ю.Цэдэнбалыг би МАХН-ын эрх ашгийн үүднээс, түүний явуулж байгаа алдаатай бодлогуудыг засаж залруулахын тулд шүүмлэж байна. Миний ярьж байгаа зүйлүүд одоо биш юм аа гэхэд хэзээ нэгэн цагт заавал биелэлээ олох юм. Тийм учраас намайг энэ хурлын дараа яаж зэмлэж, яллахаас айхгүй байна.

Миний шүүмжлэлийн гол санаа бол ийм байсан юм. МАХН-ын архивт миний хэлсэн үг бүрэн эхээрээ байж магадгүй. Байхгүй ч байж магадгүй. Тэр бүгд хурал дээр Ю.Цэдэнбал “Манай ажил муу байгаагийн гол шалтгаан нь хяналт, шалгалт сул байгаагаас болсон!” гэсэн дүгнэлт хийсэн юм. Энэ бол маш буруу дүгнэлт байсан юм. Тэр үед манай ажил муу байгаагийн гол шалтгаан нь хяналт, шалгалт суларснаас биш, харин олон түмний идэвхи суларснаас болсон юм. Олон түмний хийж, бүтээх гэсэн их идэвхийг удирдан зохион байгуулж, чиглүүлж чадахгүй байсан юм. Ингэж удирдаж чадаагүй учир олон түмний идэвх аажимдаа суларч ирсэн юм.

Тэр үед аж ахуйн ажил урагшаа ямагт тэмүүлж байсан юм. Хийх ажлууд аяндаа харагдаад байсан юм. Ашиг орлогтой шинэ шинэ салбаруудыг буй болгож хөгжүүлэх нь амин чухал асуудал болчихоод байсан юм. Гэтэл МАХН-ын удирдлага энэ бүхнийг олж харж чадахгүй байсан юм. Шинэ сэтгэлгээтэй, санаачлагатай нэг хэсгийгээ элдэв шалтгаан зохиогоод, гүтгээд, нутаг заагаад цөллөгт хөөгөөд явуулчихсан юм. Олон түмний зүгээс санаачилсан, хийхээр төлөвлөсөн ажлуудыг дэмжихгүйгээр барахгүй “Дэмий юм чалчиж байна!” гээд дарамталдаг, хавчин гадуурхдаг болсон юм. Тэд нар өөрсдөө юм бодож, сэтгэж, санаачлаад хийж чадахгүй байсан юм. Ингээд яваандаа тэд нар аж ахуйн ажлаас хочроод, түүнийг ойлгохоо байгаад, ажилд саад болоод, гологдоод ирсэн юм. Тэд нар гадны хүний үгийг зүгээр л дагаж байдаг, тэдний үгийг шууд хуулбарлан дамжуулагч нар болж хувирсан юм. Монгол орны нөхцөл байдал их өөр шүү дээ. Түүнийг гадаадын хүн ойлгодоггүй юм. Ингээд манай МАХН-ын удирдагчид санаачлагаа алдаж эхэлсэн юм шүү дээ. Тэд нар үйл явдлын хойноос нь хөөж явдаг болсон юм. Түүнийг урьдчилж хараад зохион байгуулж чадахгүй байсан юм. Тэр Бүгд хурал дээр Ю.Цэдэнбалын хийсэн гол дүгнэлт бол “Хяналт, шалгалтыг сайжруулснаар бидний ажил сайжирна!” гэсэн дүгнэлт байсан юм.

“Тийм биш. Хяналт шалгалтыг сайжруулна гэдэг чинь “диктатур”-ыг чангатгана гэсэн үг шүү дээ. Диктатурыг чангатгаад аж ахуйн ажил хэзээ ч сайжирч байгаагүй юм. Диктатур чангарах тусам ард түмэн төр, засгийнхаа бодлогыг ойлгохгүй, дэмжихгүй болдог юм. Диктатур чангарах тусам нийгмийн дотор төр, засгийн бодлогод дайсагнах уур амьсгал бий болдог юм. Энэ бол манай дөнгөж саяханы түүхээр батлагдсан гашуун үнэн шүү дээ. Аж ахуйн ажлыг аж ахуйн сэтгэлгээтэй

байж, аж ахуйн аргаар л удирдах ёстой юм. Бас олон түмний идэвхийг нь сэргээх хэрэгтэй байдаг юм. Тэдний идэвх хэзээ сэргэх вэ? Хийж байгаа ажил нь өөрсдийнхөө амьдралыг өөд нь татахад шууд нөлөөлдөг болсон тэр цагт л сэргэнэ. Хий хоосон “Тэгэх хэрэгтэй, ингэх хэрэгтэй!” гэдэг үгээр олон түмний идэвхи сэргэдэггүй юм. Ийм үгийг олон түмэн хүлээж авдаггүй юм. Аж ахуйн ажлыг диктатурын аргаар удирдаж хэрхэвч болохгүй!” гэж би Ю.Цэдэнбалд хариу барьсан юм. Ийм санаагаар би түүнийг бүгд хурал дээр шүүмжилсэн юм.

И Л: 1964 онд МАХН-ын ТХ-ны 6-р Бүгд хурал хуралдаж байсан үе бол манайд ХАА-н нэгдлүүд байгуулагдаад удаагүй байсан үе юм. Нэгдлийн гишүүдийн амьдрал тэр үед ямаршуухан байсан бэ?

Ц Л: ХАА-н нэгдэл байгуулагдахын өмнөхөн хүмүүс малаа маллаж дийлэхээ байчихсан юм. Мал бол маш их байсан юм шүү дээ. Нэгдэл байгуулахын тулд малчдын малыг нь хүчээр нийгэмчлээд, өөрсдийг нь нэгдлийн гишүүн болгоод, нэгдлийн малыг хариулдаг болгосон юм.

1950-аад оны сүүлчээр байгуулсан ХАА-н нэгдлүүд бол 1930-аад оны эхээр олноор нь хүчээр байгуулж байсан хамтралуудын шууд үргэлжлэл юм. Тэр үед ард түмний бослого гарсан учир хамтралуудыг яаралтай тараасан шүү дээ. Энэ ажил бол ард түмний сэтгэлд маш гүнзгий шарх, сорви үлдээсэн ажил болсон юм. Ийм учраас 50-аад оны сүүлчээр бүх нийтийг нэгдэлжүүлэх ажлыг эхлүүлэхдээ маш их болгоомжилж байсан юм. 30-аад оны ард түмний бослого дахин давтагдах бүрэн үндэслэл байсан юм. Тийм учраас энэ ажлыг эхлүүлэхийн тулд урьдчилсан бэлтгэлийг маш удаан хугацааны туршид хийсэн юм. Эхлээд “Нэгдлийн гишүүдийн үлгэрчилсэн дүрэм”-ийг зохиож гаргасан юм. Ард түмний ХАА-н нэгдэлд элсэн орох гол зарчим бол “сайн дурын үндсэн дээр” гэж тайлбарлаж байсан юм. Өөрөөр хэлбэл сайн дурын үндсэн дээр ард олон өөрийн мал, хөрөнгийг нийгэмчлэх ёстой байсан юм.

Яагаад заавал нэгдэл, хамтралуудыг байгуулах ёстой байсан юм бэ? гэсэн асуулт байдаг юм. Энэ бол социалист нийгэм байгуулах “Лениний төлөвлөгөө”-гөөр хийгдсэн ажил юм. “Нийгэм эдийн засгийн формаци”-ийн тухай марксизм-ленинизмын онол байдаг юм.

“Хүн төрлөхтөн хөгжлийнхөө түүхэнд нийгэм-эдийн засгийн дөрвөн формацийг туулжээ. Энэ бол хүн нэгдлийн, боолын, феодалын, капиталист гэсэн нийгэм-эдийн засгийн формацууд юм. Тав дахь бөгөөд хамгийн сүүлчийн нийгэм-эдийн засгийн формаци бол социализм-коммунизм юм. Энэ бол хүн төрлөхтний төгс хөгжлийн үе юм. Нийгэм-эдийн засгийн формациудыг тодорхойлдог гол 3 хүчин зүйл байдаг юм. Энэ

нь нийгмийн үйлдвэрлэлийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн харилцаа бөгөөд тэр хоёрт тохирсон нийгмийн давхрага юм. Тухайн нийгэм ямар нийгэм юм бэ? гэдгийг тодорхойлогч гол зүйл бол үйлдвэрлэлийн хэрэгсэл юм. Өөрөөр хэлбэл үйлдвэрлэлийн хэрэгсэл хувийн өмч болж байна уу? эсвэл нийгмийн өмч болж байна уу? гэдгээр нь тухайн нийгмийн шинж чанарыг тодорхойлдог байна. Социализм-коммунизмаас өмнөх бүх нийгэм-эдийн засгийн формацид үйлдвэрлэлийн хэрэгсэл хувийн өмч болж байсан. Ийм нийгэмд баян хоосны ялгаа гарч, нийгмийн ангиуд үүсэж, хүн хүнээ дарлан мөлжих ёс ноёрхож, нийгмийн гишүүдийн тэгш биш байдал буй болдог. Ийм нийгэм байнгын дотоодын зөрчилд орж, ангийн тэмцэл явагдаж байдаг юм. Хүн төрлөхтний түүх бол ангийн тэмцлийн түүх юм. Ангийн тэмцлийн дээд хэлбэр нь нийгмийн хувьсгал юм. Аливаа хувьсгалын гол зорилго нь нийгмийн үйлдвэрлэлийн хэрэгслийг өмчилсөн хувийн өмчийн асуудлыг шийдвэрлэдэг. Үүний тулд засгийн эрхийг авах хэрэгтэй байдаг. 17-р зууны дундуур Англид болсон хөрөнгөтний хувьсгал, 18-р зууны төгсгөлийн үед Францад болсон хөрөнгөтний хувьсгалын үр дүнд засгийн эрх хөрөнгөтнүүдийн гарт шилжсэн. Социалист хувьсгалын үр дүнд засгийн эрх ажилчин, тариачны гарт шилжих ёстой. Ажилчин, тариачин анги хамтдаа зэвсэгт бослого гаргах замаар хөрөнгөтнүүдээс засгийн эрхийг булаан авах ёстой. Тэд нар засгийн эрхийг хөрөнгөтнүүдээс хүчээр булааж аваад, өөрсдийн диктатурыг тогтоох ёстой. Энэ диктатурыг “Пролетарийн диктатур” гэж нэрлэнэ. Учир нь социалист хувьсгалын үед хувьсгалын гол хөдөлгөгч хүч нь пролетари анги байдаг. Ингэж “Пролетарийн диктатур” тогтсоноор социалист хувьсгалын гол зорилт болсон үйлдвэрлэлийн хэрэгслийг өмчилсөн хувийн өмчийг устгаж, нийгмийн өмчийг буй болгож чадна. Үйлдвэрлэлийн хэрэгсэл нийгмийн өмч болсон цагт баян, хоосны ялгаа арилж, нийгмийн тэгш байдал тогтоно. Хүн хүнээ дарлан мөлжих ёс устаж, нийгмийн шударга ёс тогтоно!” гэж марксизм-ленинизм сургадаг юм.

1917 оны 10-р сард Орос оронд социалист хувьсгал ялсны дараа үйлдвэрлэлийн хэрэгсэлийг Оросын хөрөнгөтнүүдээс хүчээр булааж авсан юм. Үйлдвэр, завод, зам, гүүр, харилцаа холбооны хэрэгсэлүүд бүгд улсын өмч болсон юм. Үүнээс гадна газрыг бас үйлдвэрлэлийн хэрэгсэл гэж үзсэн юм. Ингээд томоохон хэмжээний газрын эздийн газрыг хүчээр булааж авсан юм. Ингэж газар бас улсын өмч болж эхэлсэн юм. Гэтэл асар их хэмжээний газар тариачдын өмч хэвээрээ байсан байна. Хэмжээ нь бага боловч тариачид газрыг хувьдаа өмчлөж байлаа шүү дээ. Энэ асуудлыг яаж шийдэх вэ? гэдэг асуудал босч ирсэн юм.

Энэ үед В.И.Лениний “Хоршооллын төлөвлөгөө” гэдэг бүтээл гарсан юм. В.И.Ленин энэ зохиолдоо “тариачдыг хоршооллох замаар социализм

байгуулах үйлсэд татан оролцуулах ёстой!” гэсэн онолын дүгнэлт хийсэн байна. Өөрөөр хэлбэл “тэдний хувийн өмчинд байгаа газрыг нь нийгэмчилж, нийгмийн өмч болгоод, хувийн өмчгүй болгох ёстой!” гэсэн онол гаргасан юм. 1930-аад оны үед “Лениний хоршооллын төлөвлөгөө”-г амьдарлд хэрэгжүүлэхээр Орос оронд эмгэнэлтэй үйл явдлууд болсон юм. Газраа булаалгаж, нийгэмчлүүлсэн хэдэн сая тариачид өлсгөлөнд нэрвэгдэж, үхсэн юм. Чинээлэг тариачид газраа нийгэмчлэхийг хүчтэй эсэргүүцсэн боловч И.В.Сталин түүнийг цус урсган, нухчин дарсан юм. Ингэж Орос оронд үнэн хэрэг дээрээ хувьдаа газар өмчилсөн тариачин анги байхгүй болсон юм.

Монголд байдал ямар байсан бэ? Монголд онолын хувьд хамгийн төвөгтэй нэг асуудал босож ирсэн юм. Монголын нийгэмд үйлдвэрлэлийн хэрэгсэл нь мал уу? газар уу? гэдэг асуудлыг эхлээд шийдэх хэрэгтэй болсон юм. Нэг хэсэг нь “Үйлдвэрлэлийн хэрэгсэл бол газар болох ёстой!” гэж байхад нөгөө хэсэг нь “Үйлдвэрлэлийн хэрэгсэл бол мал болох ёстой!” гэж маргасан байна. Онолын энэ асуудлыг шийдэж чадаагүй юм. Ингээд малыг нийгэмчлэхээр шийдсэн юм. 50-аад оны сүүлчээр эхэлсэн ард олны малыг нийгэмчлэх энэ ажил маш хүчтэй “далд эсэргүүцэл”-тэй тулгарсан юм. Ард түмэн малаа “сайн дурын үндсэн дээр” нийгэмчлэхийг хүсээгүй юм. “Сайн дурын үндсэн дээр” гэдэг үг бол зөвхөн “ХААн нэгдлийн үлгэрчилсэн дүрэм”-д бичигдсэн үг юм. Ард түмний малыг нь 30-аад оны хамтрал байгуулж байсан үе шиг хүчээр нийгэмчилсэн юм.

Ингээд Монголын нүүдэлч, малчид ХАА-н нэгдлийн гишүүн болж, нэгдлийн малыг малладаг болсон юм. Ингэж “нүүдэлчин” гэдэг үгийн сонгодог утга алдагдсан юм. Нэгдлийн гишүүдийн амины малын тоог “ХАА-н нэгдлийн үлгэрчилсэн дүрэм”-ээр хангайн бүсэд 50 толгой, говийн бүсэд 75 толгой байхаар тогтоож өгсөн юм. Жил бүр ХАА-н нэгдлүүд, улсын САА-нууд болон амины малыг тоолдог болсон юм. Энэ тооллогоор “ХАА-н нэгдлийн гишүүдийн үлгэрчилсэн дүрэм”-ээс илүү гарсан малыг нийгэмчилдэг болсон юм. Ингээд нэгдлийн малд мах, сүү, ноос, үсний норм, төлөвлөгөөг өгдөг болсон юм. Нэгдлийн гишүүд энэ норм, төлөвлөгөөг биелүүлэхийн тулд үнээгээ зуны турш сааж, сүүг нь тушаадаг болсон юм. Өөрсдөө цайгаа сүлэх сүүгүй хоцордог байлаа шүү дээ.

ХАА-н нэгдлийн малыг хариулж байгаа малчид өөрсдөө дураараа нутаг сэлгэн нүүж чадахгүй болсон юм. Хэзээ, хаашаа, ямар унаагаар нүүх зэрэг асуудлыг “Нэгдлийн Зөвлөл” шийддэг болсон юм. Нэгдлийн малын саалийн хугацааг тогтоох, үржил хээлтүүлгийн ажлыг зохион байгуулах, төл хүлээн авах, үс, ноос хяргах, отор хийх зэрэг бүх ажлыг улсаас хянадаг болсон юм. Малчин хүн өөрөө шийдээд хийх ямар ч ажилгүй болсон юм.

Энэ бүхнээс болоод нэгдлийн малыг “ялтай мал” гэж нэрлэх болсон юм. Мал бол яг ял эдэлж байгаа хоригдол шиг болсон гэсэн үг юм. Бүх юм хугацаатай хэмжээтэй болсон байлаа шүү дээ. Нөгөө талаар нэгдлийн малыг үхүүлж үрэгдүүлэх, улсаас өгсөн норм, төлөвлөгөөг биелүүлээгүй бол малчин хүн шийтгүүлж, шоронд ордог болсон юм. Ийм учраас мал нь ч “ялтай”, түүнийг маллаж байгаа хүн ч “ялтай” болсон юм. Ийм хэцүү байдалд орсон юм. Удалгүй нэгдлийн гишүүдийн хүүхэд, залуучууд нь хот, суурин газар сургуульд суралцах нэрээр хөдөөнөөс дайжаад, зугтаагаад явчихдаг болсон юм. Ингээд мал маллах хүнгүй болсон юм. Хэдэн хөгшин, хэдэн малтайгаа хоцорсон юм.

Ингээд хүмүүс аажимдаа энэ “ялтай мал”-аасаа салахын түүс болдог болсон юм. Хүмүүсийн амьдрал ингэж улам дордсон юм. Малаа нийгэмчлүүлсний дараа малчин хүн өөрийн гэсэн хөрөнгөгүй болсон юм шүү дээ. Монголчууд эхнэрээ төрөхөөр шинэ хонины шөл уулгаж, биеийг нь тэнхрүүлдэг шүү дээ. Малчин хүний гэрийн гадаа хот дүүрэн хонь байдаг боловч тэр нь өөрийнх нь биш, нэгдлийн хонь учир түүнээс нэгийг ч дураараа хэрэглэж болохгүй. Нэгдлийн даргаас заавал “зөвшөөрөл” авах ёстой байлаа шүү дээ. Нэгдлийн дарга “зөвшөөрөл” өгөөд, малчин хүн хонь авч хэрэглэвэл түүний үнийг өөрийн цалингаар төлөх ёстой. Хэрвээ төлж, өрийг барагдуулахгүй бол нэгдлийн мал дутаасан хэргээр шоронд орно шүү дээ. Нэгдлийн гишүүдийн амьдрал ийм болчихсон юм.

И Л: 1964 оны энэ бүгд хурал дээр та “Энэ өр, зээл замбараагаа алдлаа!” гэж хэлсэн билээ. Энэ талаар жаахан тайлбарлаж өгнө үү?

Ц Л: Тийм. Тэр үед өр, зээлийн асуудал бол замбараагаа алдаж байсан юм. Манайхан яагаад дандаа өр тавиад, зээл аваад байдаг юм бэ? Яагаад бид өөрийн төсвийг бүрдүүлж чадахгүй байна вэ? Энэ бол бодох асуудал шүү дээ. Өр тавихгүй байх, түүний хэмжээг багасгах боломж байсан уу? Ийм асуулт байнга гарч байсан юм. Тэр үед үйлдвэр, ХАА, эрүүл мэнд, боловсрол, соёл гээд улс ардын аж ахуйн бүх салбар улсын төвлөрсөн төсвөөс санхүүжиж байлаа. Улсын төсөв ийм том ачааллыг даах уу? Даахгүй нь мэдээж шүү дээ. Тэгээд л зээлийн тухай яриа гарч ирдэг байсан юм. Зээл бүр замбараагаа алдсан шүү дээ. Зээлийн өр нэмэгдээд байсан гол шалтгаан бол өөрийн нөөц бололцоог бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байсантай холбоотой юм. Манай эдийн засгийн гол салбар болсон ХАА-д өндөр ашиг өгдөг, шинэ, шинэ салбаруудыг буй болгож чадаагүй байсантай холбоотой юм. Өндөр ашиг, орлоготой, манай нөхцөлд тохирсон, өөрийн өртөг багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлж чадаагүйтэй холбоотой юм. Гадаад худалдаагаар

дандаа алдагдалтай наймаа хийж байсантай холбоотой юм. Тэр үед гадаад худалдааны алдагдал их өндөр байсан юм. ЗХУ-ын өөрийнх нь дотоодын зах зээлийн үнэнээс хэд дахин өндөр үнээр манайд бараа, бүтээгдэхүүнээ “шахдаг” байсан юм. ЗХУ-аас импортоор авч байгаа бараа бүтээгдэхүүний үнэ ийм өндөр байсан боловч чанар нь манай зах зээлийн шаардлагыг хангаж чадахгүй, гологдол бараа их байсан юм. Гологдол бараа их байсан учир манай хэрэглэгчид түүнийг худалдан авахаас эрс татгалздаг байсан юм.

Үүнтэй холбогдуулаад би нэг жишээ хэлье л дээ. Манайх цайны ургамал тариалдаггүй шүү дээ. Монгол орон цайг ямагт гадаадаас импортоор авч байсан юм. ЗХУ-аас өөрийн хэрэгцээний бүх цайг авч байлаа. Манайхан тэр цайг “дугуй булант” гэж нэрлэдэг юм. Гэтэл энэ “дугуй булант”-ын чанар манай хэрэглэгчдэд гологдоод, худалдаж авдаггүй байлаа. Гэтэл хүн авахгүй цайг худалдахын тулд түүний дотор нь эмэгтэй хүний гоёлын ээмэг, бөгж хийдэг байсан юм. Хүмүүс тэр ээмэг, бөгжийг нь аваад, цайг нь хаячихдаг байсан юм. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн хувьд хуучирсан, одоо хаана ч хэрэглэхээ байсан технологи, тоног төхөөрөмж их ирдэг байлаа. Зарим үед хэрэглээд, хуучирсан тоног төхөөрөмжийг будаад, шинэ мэт болгоод явуулсан тохиолдол гарч байсан юм. Бас манайд огт хэрэгцээгүй бараа, бүтээгдэхүүнийг, өндөр үнээр шууд тулгаж өгөх явдал их байсан юм. Тухайлбал гадаад худалдааны шугамаар манайхаас ямааны ноолуур, тэмээний ноос, малын арьс шир, хялгас зэрэг түүхий эд, амьд мал ЗХУ-д гарч байсан шүү дээ. Тэдгээрийг дэлхийн зах зээлийн үнэ, ханшнаас олон дахин доогуур үнэлдэг байсан юм. Түүний оронд ЗХУ-аас манайд огт хэрэгцээгүй зүйлүүдийг маш өндөр үнээр өгдөг байсан юм. Үүнтэй холбогдоод манайхны дунд хүүхдийн тоглоомон “резинин хонь”-ны тухай нэг яриа олон жил яригдсан юм. Өөрөөр хэлбэл манайхаас гадаад худалдааны шугамаар дээр дурьдсан бүтээгдэхүүнүүд гараад, түүний оронд нь хүүхдийн тоглоомон “резинин хонь” зэрэг зүйлүүд ирдэг байж л дээ. ЗХУ-ын дотоодын зах зээлийн үнэнээс хэд дахин өндөр үнээр, манай нэг амьд хоньтой тэнцэх үнээр шүү дээ. Ийм хүүхдийн тоглоомон “резинин хонь” манай эдийн засгийн өсөлтөнд ямар үүрэг гүйцэтгэж чадах вэ? Энэ асуултанд хамгийн зөв хариултыг олоход Ю.Цэдэнбалд түүний эзэмшсэн гээд байдаг “эдийн засагч” мэргэжил нь даанч тус болоогүй юм шүү дээ. Биднийг ийм “эдийн засагч” нар удирдаад, “Монгол улсыг хөгжүүлнэ!” гэж яриад их удсан юм. Ард түмний тэвчээр барагдаж байсан юм. Иймэрхүү байхад манай өр, зээл замбараагаа алдах нь ойлгомжтой биш гэж үү? Тэр үед Алтанбулаг, Эрэнцав, Хөвсгөлийн Ханх, баруун талын Цагаан нуурын дамжлага баазуудаар малаа хойш нь гаргадаг

болсон юм. Монголын зүүн талын 5 аймгийн мал Эрээнцаваар, Төв хэсгийн мал Алтанбулагаар, Хөвсгөл, Завхан зэрэг аймгууд Ханхаар, баруун талын аймгуудын мал Цагаан нуураар гарч байсан юм.

Манж Чин улсын үед ч бол монголын мал урагшаа гарч байлаа шүү дээ. Тэр үед тууварын аргаар урагш нь мал гаргадаг тусгай замууд байсан юм. Манай баруун Алтай бол баруун талынхаа хилээр гарч болдог юм. Тэнд урагш гардаг “Шар зам” гэдэг зам байсан юм. Ховдын Хар ус нуураас Хүйсийн говь, Шаргын говь, тэгээд Бигэрийн хоолойгоор урагшаа хил гардаг юм. Үүнийг “Баруун хоолой” гэдэг юм. Бас “Дунд хоолой” гэж байсан юм. Тэр нь Урд, Хойд Тамирын уулзвар, тэгээд Төвшрүүлэхийн Өргөөтийн тал, Хөшигний хөндийгөөр ороод, Хар Хорины Орхоны хөндийгөөс урагшаа яваад Зүйлийн хөндий дайраад Домбон Зээрэнгийн говиор урагшаа хил гарч байсан юм. Төв халхаар бас урагшаа гардаг гарц байсан юм. Хэрлэнгийн тал газраас эхлээд Нохой цангахын талаар ороод, Дорноговийн баруун тал, Сүхбаатарын баруун талаар хил гарч байгаа юм. Энэ гурван хоолойгоор урагшаа мал гаргадаг байсан юм. Энэ бол Манж Чин улсын үед шүү дээ. Энэ бол байгалийн их сонин зохицолдолгоотой хоолойнууд юм. Өөрөөр хэлбэл, малын бэлчээртэй, ундны устай сайхан хоолойнууд юм л даа. Малаа бэлчээрийн аргаар туугаад л хил давна гэсэн үг шүү дээ. Одоо зөвхөн Дорноговийн зүүн талынх нь хоолойг л ашиглаж байна. Бусдыг нь ашиглаагүй байна. Монгол орон энэ хоолойнуудаар урагшаа малаа гаргаж байсан түүх бол хуучрааргүй байна. Маш их түүхийн сургамжтай зүйл шүү.

Бид цаашид урд хөрштэйгөө харилцах, зам харилцааны асуудалдаа энэ гурван хоолойн асуудлыг анхаарч үзэх ёстой юм шүү. Одоо үед энэ хоолойнуудыг дагасан төмөр зам, машины зам тавьж болно шүү дээ. Энэ бол саад бэрхшээл байхгүй нам дор газар шүү дээ. Энэ гурван хоолойгоор тэмээн жин урдаас орж ирж байсан юм. Энэ хоолойнуудыг дагаад аян жингийн “Шар зам” гэж байгаа юм. Ховдын Хар ус нуураар дайраад л бүх тэмээн жингүүд өнгөрч байсан юм. Олон зуун жил энэ замаар тэмээн жин явсан хамгийн ойр дөт зам шүү дээ.

1950-аад оны дундуур Москва-Улаанбаатар-Бээжинг холбосон төмөр замыг ашиглалтанд оруулсан юм. Хятадын талаас ирсэн төмөр зам монголын нутагт орж ирээд манай замтай нийллээ. Энэ үйл явдалтай холбогдуулаад монголын талаас Ю.Цэдэнбалаар ахлуулсан засгийн газрын төлөөлөгчид, хятадын талын засгийн газрын төлөөлөгчидтэй хоёр талын төмөр зам нийлсэн тэр газарт уулзалт зохион байгуулсан юм. Монголын талын засгийн газрын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд их олон хүн орсон юм. Би ч бас түүнд багтаж орсон байв. Бас миний найз “Үнэн” сонин ерөнхий эрхлэгч С.Дэлэг явсан юм. Тэнд энэ үйл явдалтай

холбогдоод их том ёслол хийв. Хоёр талын төмөр зам уулзаж байгаа тэр хэсэгт замын рельсийг нь 4 ширхэг том мөнгөн хадаасаар холбож тогтоосон юм. Бид ингэж төмөр замаар урд, хойд хоёр их хөршдөө зорчих боломжтой боллоо. Энэ хоёроороо дамжаад бид цаашаа олон улстай харилцах боломжтой болсон юм. Энэ нь манай улсын түүхэнд томоохон үйл явдал болж байлаа шүү дээ. Энэ том арга хэмжээнд оролцоод буцах замдаа С.Дэлэг бид хоёр бусад төлөөлөгчдөөс салаад “нохой цангахын тал” гэдэг алдартай талаар зориуд явж үзэв. Тэгээд энэ гайхамшигтай уудам талаар явсан тухайгаа бичиж “Үнэн” сонинд нийтлүүж байлаа. Тэр үед энэ тал дундуур явахад надад маш сонин сэтгэгдэл төрж билээ. Олон зуун жил энэ уудам талыг гатлаж бараа ачсан тэмээн жингийн цуваа Монголд орж ирж байв.

Тэр үед төсвийн алдагдлыг багасгах, ашиг орлогыг нэмэгдүүлэх өөрийн хэрэгцээт зүйлээ өөрсдөө үйлдвэрлэх талаар МАХН-ын удирдагчид огт санаачлага гаргахгүй байсан юм. Ард түмэн энэ бүгдийг чинь мэдээд, яриад, шүүмжлээд байсан юм. Ялангуяа сэхээтнүүд бол энэ талаар их ярьдаг байлаа шүү дээ. 1964 оны бүгд хурал хуралдах үед нийгмийн уур амьсгал их хүнд байсан юм. Ард түмний бухимдал дээд цэгтээ тулсан байсан юм. Дотоодын үйлдвэрлэл бараг зогссон байлаа. Өөрийн хэрэгцээний юм үйлдвэрлэх боломжтой, ашиг орлого сайтай жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх асуудлыг бүр зогсоосон байлаа шүү дээ. ЗХУ, Хятад хоёрын хооронд томоохон хэмжээний маргаан дэгдээд байсан үе юм. Энэ маргаан манай эдийн засагт маш хүчтэй цохилт үзүүлсэн юм.

И Л: Та тэр Бүгд хурал дээр МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбалын боловсон хүчнийг сонгох аргыг нь шүүмжилсэн байна билээ. Үүнийгээ тайлбарлаж өгнө үү?

Ц Л: Ю.Цэдэнбал засгийн эрх барьж эхэлсэн жилүүдэд хүнийг ажил хэргийн чанраар нь үнэлж албан тушаалд томилохоо бүр больсон юм шүү дээ.

Ерөөс төрийн өндөр албан тушаалд томилогдсон хүмүүс бүгд л Увс аймгийнхан болж хувирсан юм. Увс аймаг бол Ю.Цэдэнбалын төрсөн нутаг шүү дээ. Увс аймагт л төрсөн бол төрийн өндөр албан тушаалд томилогддог, ямар ч албан газарт даргаар томилогддог болчихсон юм шүү дээ. Тэр хүмүүс албан тушаалд томилогдоод, нутгийнхаа хүмүүсээр өөрийгээ хүрээлүүлээд, таньдаг, таньдгаараа бие биенийгээ өөд нь татаад, ямар ч алдаа завхрал гаргасан хамаагүй, ажил хичнээн унаж байсан ч хамаагүй бие биенийгээ хамгаалаад суучихдаг болсон юм. Улсын ажил хувийн шинж чанартай болоод ирсэн юм. Энэ байдлыг засаж залруулахын

төлөө, ажлын төлөө санаа зовсон хүмүүсийг хавчин гадуурхаад, ажлаас нь халаад эхэлсэн юм. Олон түмэн энэ байдалд маш их дургүйцэж байсан юм. Энэ үед олны дунд “Дүрвэд хүн хүн биш, дөрвөн шийр мах биш!” гэсэн нэг шог үг хүртэл гарч байсан юм. Ингэж Монголын үндэстэн, ястнуудын ч гэмээр асуудлууд босож ирсэн юм. Монгол бол олон үндэстний улс биш. Бид бүгдээрээ ижил Монгол үндэстэн шүү дээ. Монгол үндэстний дотор олон жижиг ястнууд багтдаг юм. Тэд нар хоорондоо онцын ялгаа байхгүй. Хэл, яриа зан заншлын, нутаг нутгийн ялгааг эс тооцвол бүгд ижил юм. Гэтэл тэр үед чинь ингээд дүрвэд, халхаараа талцаад, маргалдаад эхэлсэн юм.

Жаахан хожуухан бол ЗХУ-д сургууль төгссөн хүнийг албан тушаалд томилдог болсон юм. Орос хэл мэддэг л бол амархан тушаал ахидаг болсон юм. Орос хэл мэддэг бол сайн л биз дээ. Гэхдээ энэ бол албан тушаалд тэнцэх, эсэхийн шалгуур байж болохгүй шүү дээ. Ийм маягаар албан тушаал дэвшсэн хүмүүс чинь ажил хийж чаддаггүй юм. Тэд нар улсаас байр, орон сууцаа үнэгүй аваад, гадаадад томилолтоор байнга явдаг болоод, өндөр цалинтай, тусгай хангамжтай болоод эхэлсэн юм. Та нар “дарга нарын дэлгүүр” гэж сонссон байх. Манай яамдын сайд нар, томоохон албан газрын дарга нар ийм тусгай дэлгүүрээр үйлчлүүлдэг байлаа шүү дээ. МАХН-ын ТХ-ны нууц тогтоол байсан юм. Тэр тогтоолоор МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүдийн эдлэх тусгай хангамж, болон бусад сайд нар, томоохон газрын дарга нарын хангамжийн асуудлыг зохицуулж байсан юм. Тэр тусгай дэлгүүрт энгийн хүн орж болохгүй. Хориотой байсан шүү дээ. Ард түмний өргөн хэрэглээний барааны хомсдол туйлдаа хүрч, хамгийн энгийн зүйлүүд хүртэл дэлгүүрт байхгүй болсон үе шүү дээ. Ийм маягаар өндөр албан тушаалд томилогдсон хүмүүс биеэ тоогоод, Ю.Цэдэнбалыг магтаад л, ЗХУ-ыг хамгаалаад л сууна шүү дээ.

Тэр үед тэд нар “Дүрвэд хүн төрийн тулгуур, дөрвөн шийр малын тулгуур” гэсэн үг хүртэл гаргаж байсан юм. Гэтэл ажлаа сайн мэддэг, олон жил ажилласан туршлагатай хүмүүс халагдаад, албан тушаал буураад явж байсан юм. Заримынх нь нэр төрийг гутаагаад, нутаг заагаад, цөлж байсан юм. Ийм явдлууд чинь нийгэмд их хортой юм л даа. Ийм болохоор улс хөгжих үндэс байхгүй. Ингээд бялдууч хүмүүс төрж байгаа юм. Ингээд МАХН-ын ч ажил, төр, засгийн ч ажил явахаа больсон юм. Ийм хүмүүс МАХН, төрийн аппаратад олшроод ирэхээр маш хэцүү байдал үүсэж байсан юм.

И Л: Та 1964 оны МАХН-ын ТХ-ны 6-р бүгд хурал дээр Ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбалын ажлын арга барил, алдаатай бодолгыг

нь шүүмжлэхдээ түүнийг энэ албан тушаалаас нь огцруулах зорилготой байсан уу?

Ц Л: Би түүнтэй олон удаа уулзаж, олон удаа түүний хийгээд байгаа буруу ажлууд, алдаатай бодлогынх нь талаар хэлж өгч байсан юм шүү дээ. Ю.Цэдэнбал миний хийж байгаа ажлуудыг дэмждэг, миний тавьсан асуудлуудыг сайхан хүлээж авдаг үе байсан юм шүү. Би САА-нуудыг удирдах газрын даргаар зургаан жил ажиллахдаа түүнтэй байнга л уулздаг байлаа. Миний хариуцаж байсан ажил бол үнэхээр чухал, Монголын ХАА-н цоо шинэ салбар, цаашлаад Монголын нийгэм-эдийн засгийн хөгжилд үлэмж ач холбогдолтой ажил байсан юм. Үүнийг бид хоёр сайн ойлгож байсан. Ийм түүхэн боломжийг алдахгүйг бид бүгдээрээ хичээж байсан.

Харин Ю.Цэдэнбал намайг ямар зорилготой надад ийм чухал, маш хvнд салбарыг хариуцуулсныг би мэдэхгүй. Энэ талаар би байнга бодож явдаг нэг үйл явдлын талаар ярья л даа.

-1956 онд Намайг Говь-Алтай аймгийн МАХН-ын хорооны нэгдүгээр нарийн бичгийн даргаар ажиллаж байхад гэнэт “Улаанбаатар хотод яаралт хүрч ир!” гэсэн дуудлага МАХН-ын ТХ-ноос иржээ. Ингээд би дуусан цагт нь МАХН-ын ТХ-н дээр ирлээ. Намайг Ю.Цэдэнбал өөрийн ажлын өрөөндөө хүлээж авлаа. Ингээд бид орон нутгийн ажил байдлын талаар жаахан ярилцлаа. Бид хоёр нэг хэсэг энэ сэдвээр ярьж суутал Ю.Цэдэнбал аажмаар ярианыхаа сэдвийг өөрчлөөд атар газрын тухай ярьж эхэллээ. Тэгснээ гэнэт:

-Бид чамайг САА-нуудын удирдах газрын даргаар томилохоор төлөвлөөд байна. Чи энэ ажлыг хийж чадах уу? гэж асуулаа. Би ийм асуудал яригдана гэж урьдчилан бодоогүй явсан болохоор жаахан тулгамдлаа. Тэгээд:

-Чадна! гээд л түс тас хэлчихлээ. Тэр миний үгийг сонсоод над руу нэг том харснаа суудлаасаа босоод цааш явлаа.

Ингэж явахдаа:

-Аа, тийм үү! Чи яасан их олон юм чаддаг хүн бэ? гэж бүдэгхэн хэлэхийг би сонссон юм. Түүний намайг занаж хэлсэн энэ үг надад одоо болтол бодогдож явдаг юм. Ю.Цэдэнбал үнэхээр өөр зорилготой энэ шинэ, том, маш хүнд салбарын ажлыг надад хариуцуулсан байж магадгүй. Энэ том, шинэ салбарын хүнд ажил өөдрөг сайн байгаад, богино хугацаанд өндөр амжилтанд хүрч чадаагүй бол тэр надтай яаж харьцахыг нь таахад амархан.

Би өөрт байсан бүх бололцоог дайчлаж, энэ салбарыг хөл дээр нь найдвартай зогсоохын төлөө, надаас хамаарах болон хамаарахгүй бүхнийг хийж байсан. Миний хичээл зүтгэл талаар болоогүй. Монголын ХАА-д

бие даасан нэг цоо шинэ салбар хөгжиж, Монгол орон түхэндээ анх удаа газар тариалангийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг, ургац сайтай жил экспортонд гаргадаг болсон юм. Энэ бол бид бүгдийн хичээл зүтгэлийн үр дүн, Монголын ард түмний хичээл зүтгэлийн үр дүн байсан юм. Би МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбалтай нэг машинд суугаад, нэг биш удаа хөдөө явж л байлаа. МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн даргын ажлын ачаалал үлэмж их байдгаас түүнтэй энгийн үед тухтай ярилцах цаг байхгүй тул бид нар машин дотроо шувт ажлаа яриад л явдаг байлаа.

Тэр үед газар тариалангийн ажилд машин-техникийн саатал их гардаг байлаа л даа. Тухайлбал, трактор, комбайны сэлбэг байхгүй тул ажилд гарч чадахгүй болох явдал олон тохиолдож байсан юм. Машин-техникийн саатал гарсан ийм үед би түүнтэй шууд л утсаар ярьдаг байлаа шүү дээ. Би тэр үед САА-нууд руугаа онгоцоор явдаг байсан гэж ярьсан шүү дээ. Тэгээд л онгоцны радио холбоогоор түүний өөрөө рүү нь шууд л ярина шүү дээ.

Нэг удаа тариа хураалтын ажил эхлэхийн өмнө шинэ комбайнууд ирсэн юм. Гэтэл тэд нар бүгд “гидрийн ремень”-ийн сэлбэггүй иржээ. Өөрөөр хэлбэл тэр комбайнуудыг залуурдаж, чиглүүлэн явуулж болохгүй болсон юм. Ингээд тэднийг ажилд гаргах боломжгүй боллоо. Энэ байдлыг Ю.Цэдэнбалд утсаар хэллээ. Гэтэл тэр шууд л Москвад ярилаа. Тэр үед Москвад манай Элчин сайдаар С.Лувсан ажиллаж байсан юм. Ю.Цэдэнбал “Яаралтай арга хэмжээ авч өг!” гэж С.Лувсанд үүрэг өглөө. Үнэхээр 5 хоногийн дараа нөгөө гидрийн ременийг нисдэг тэргээр авч ирээд, Дарханы САА-н орчим агаараас унагаж өгч байсан юм. Үүний ачаар тариа хураалтын ажил огт сааталгүй, хугацаандаа дуусч байлаа. Энэ мэтээр бид нар байнгын харилцаа, холбоотой ажиллаж байсан юм.

Гэвч түүний ажлын арга барил, алдаатай бодлогууд нь засраагүй юм. Засарвал засрах хугацаа хангалттай байлаа шүү дээ. Ердөө ч өөрчлөгдөөгүй юм. Тэгээд “Бодит байдлыг ойлгохгүй байгаа бол эндээс зайгаа тавьж өгөх хэрэгтэй байна. Энэ ажлыг хийж чадах хүн байна шүү дээ. Бид улсынхаа хөгжил, ирээдүйг нь бодъё. Ю.Цэдэнбал чи өөрийгөө боддог юм байгаа биз!” гэж л би түүнд хэлэх гээд байсан юм.

Надтай хамт түүнийг шүүмжилсэн Б.Нямбуу арай өөр бодолтой байсан. “Ю.Цэдэнбалыг ажлаас нь халаад хэрэггүй. Түүний оронд МАХН, төр, засгийг удирдаж чадах хүн одоохондоо байхгүй!” гэж байсан юм. Ю.Цэдэнбал бол авъяас билгээрээ бусдаас шалгарч, жинхэнэ ёсоороо том албан тушаалд дэвшсэн хүн биш юм шүү дээ. Түүнийг МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн даргаар сонгож байсан үе бол Монголын түүхэнд их эгзэгтэй, онцлогтой, хүнд үе байлаа шүү дээ. 1937-38 онд

манай боловсролтой, мэргэжилтэй, чадалтай боловсон хүчнийг Дотоод яам бараг толгой дараалан баривчлаад, бүгдийг нь цаазлаад, заримыг олон жилээр шоронд хорьсон байлаа шүү дээ. Боловсон хүчин ийм ховор байсан үед Ю.Цэдэнбал МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар сонгогдсон юм. Тэр ажил хийж сураагүй, 24 настай байхдаа томилогдсон хүн шүү дээ. Тэр өөрөө шууд хариуцаж, гардаж хийгээд амжилтанд хүргэсэн нэг ч ажил байгаагүй юм. Тэгээд бас нийгмийн ухааны онолын бэлтгэл муутай хүн байлаа шүү дээ.

Монгол улс геополитикийн хувьд ЗХУ болон Хятад гэсэн дэлхийн хоёр аврага том гүрнүүдийн дунд байдаг жижиг улс болохоор ямагт энэ хоёртойгоо сайн хөршийн харилцааг эрхэмлэх ёстой шүү дээ. 1940-өөд оны үед Хятад улсын өөрийнх нь дотоод хямралаас болоод Монгол-Хятадын харицааны хандлага тогтоогүй байсан үе юм. Ийм байдлын улмаас манай гадаад бодлогод ЗХУ онцгой байр суурийг эзлэж байсан юм. Бид ЗХУ-тай бүх талын найрамдалт харилцаатай байлаа. Ийм учраас манай төр засгийн удирдагч нарт орос хэлний мэдлэг амин чухал хэрэгтэй байсан нь ойлгомжтой. Харин тэдний дунд тийм хүн даан чиг цөөхөн байж дээ. Ийм үед Ю.Цэдэнбалын ЗХУ-д дээд сургууль төгссөн, орос хэл муугүй мэддэг зэрэг нь бусдаас ялгарах онцлог болсон байх. “Зуун чавганц уралдвал нэг нь түрүүлдэг!” гэсэн монгол ардын зүйр үг байдаг шүү дээ. Ю.Цэдэнбал МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар сонгогдсон цагаасаа хойш нэг хэсэг эрч хүчтэй ажиллаж байсан байж магадгүй.

Гэтэл тун их удалгүй л МАХН-ын ч, Монголын төрийн ч удирдагч хүнд баймааргүй арвин их дутагдлын эзэн болчихсон юм шүү дээ. Түүний хурдан эрч хүчээ алдаж, ажлын чадваргүй, идэвхи санаачлагагүй болж, өөрчлөгдөж, хувирсан талаар Д.Төмөр-Очир МАХН-ын ТХ-ны Бүгд хурлууд дээр хүртэл ярьж, шүүмжилж байсан юм. Би Ю.Цэдэнбалтай хувийн талаар ердөө муудалцаагүй юм шүү. Түүний ажлынх нь арга барил, алдаатай бодлогыг нь л шүүмжилж байсан юм.

Нянтайсүрэнгийн Лхамсүрэн, Базарын Ширэндэв нар бол маршал Х.Чойбалсанд их үнэлэгдэж байсан хүмүүс юм. Ер нь Х.Чойбалсангийн Ю.Цэдэнбалын талаархи бодол аажимдаа их өөрчлөгдсөн гэж би боддог юм.

Х.Чойбалсангийн бие муу байхад ЗХУ-д очиж эмчлүүлэх зөвлөлгөөг Ю.Цэдэнбал өгч, явахыг ятгаж байсан юм билээ. Х.Чойбалсан өөрөө Москвад очиж эмчлүүлэх дургүй байсан гэсэн нэг яриа байдаг юм. Энэ яриа ортой ч байж магадгүй. Х.Чойбалсан энэ үед И.В.Сталинд их муу ханддаг болоод байсан үе юм. И.В. Сталин, Х.Чойбалсан хоёр хэн нь түрүүлж улс төрийн тавцангаас бухаа хүлээж байсан байж магадгүй. Х.Чойбалсан бие нь муу байхдаа өөрийн маш нарийн бодол,

санаагаа Нянтайсүрэнгийн Лхамсүрэнд ярьсан юм билээ. Энэ тухай Ю.Цэдэнбал тагнуулын аргаар олж мэдсэн юм байгаа юм. Зөвхөн энэ яриа Н.Лхамсүрэнг МАХН-ын ТХ-ны УТТ-ноос гаргаж, МАХН-ын гишүүнээс хөөх шалтгаан болсон юм.

Н.Лхамсүрэнгийн эхнэр Намсрайжав бол Монголын анхны эрдэмтэн, ухаантай эмэгтэй байсан юм. Их сайхан ч хүүхэн байлаа шүү дээ. Ю.Цэдэнбал тэр хоёр бас муудалцсан юм шиг байна билээ. Н.Лхамсүрэн, Ю.Цэдэнбал хоёр ЗХУ-д хамт сурч байсан юм. Баруун аймгаас ирсэн учир Ю.Цэдэнбал Улаанбаатарт таних хүн байхгүй, нутаг хол учир зуныхаа амралтыг Н.Лхамсүрэнгийн гэрт өнгөрүүлдэг байсан юм билээ. Тэднийг их сайхан номын сантай айл байж л дээ. Тэгээд тэр хоёр зун сонин сайхан ном уншаад, амралтаа өнгөрөөдөг байж. Ю.Цэдэнбал тэр хоёрын өмсөх хувцас, идэх хоолыг нь Н.Лхамсүрэнгийнх бэлтгээд өгдөг байж. Ингэж тэр хоёр бүр хүүхэд наснаасаа үерхэж өссөн юм билээ. Н.Лхамсүрэн өөрөө агрономч мэргэжилтэй хүн байсан юм. Н.Лхамсүрэн ЗХУ-д очиж агрономынхоо чиглэлээр эрдэм шинжилгээний ажил хийхээр явсан юм. Н.Лхамсүрэнг эзэнгүй хойгуур энэ бүх хэрэг мандаж байжээ.

1990-ээд оны эхээр Н.Лхамсүрэн Монгол телевизэд өгсөн нэг ярилцлагадаа Ю.Цэдэнбалыг багынх нь нэрээр нэрлэсэн юм. Түүнийг багад нь Ю.Цэдэнпил гэдэг байж. Түүнийг ийм нэртэй байсныг Монголын олон нийт анх удаа ингэж мэдсэн юм. Тэр өөрөө үүнийг нууцлаж байсан байж магадгүй. Ямар ч байсан түүнтэй хамт олон жил ажилласан хүмүүс Ю.Цэдэнбал гэдэг нэр бол түүний жинхэнэ нэр нь биш гэдгийг мэдээгүй байсан гэдэг яриа их гарсан юм.

Н.Лхамсүрэнг ингэж ажлаас нь халж явуулсны дараа Ю.Цэдэнбалын зүгээс Б.Ширэндэвийг МАХН-ын ТХ-ны УТТ-ноос гаргаж өөр ажилд томилох ажлыг зохион байгуулсан юм. Б.Ширэндэв бол маш их чадвартай, өргөн мэдлэгтэй, орос хэлийг гарамгай сайн эзэмшсэн хүн байсан юм. Х.Чойбалсан өөрөө орос хэлээр ярьдаггүй хүн байлаа шүү дээ. Х.Чойбалсан, И.В.Сталин хоёрын уулзалтанд Б.Ширэндэв олон удаа орчуулагч хийж байсан юм. “И.В.Сталин орос хэлний мэдлэгийг минь үнэлж, миний төлөө хундага өргөж байсан!” гэж тэр дурсан ярьдаг байсан юм. Ю.Цэдэнбал, Б.Ширэндэв нар ЗХУ-ын Иркутск хотод хамт сурч байсан сайн найзууд юм. Тэрээр Монгол улсын Боловсролын яамны сайд, Монгол улсын их сургуулийн анхны захирал, Монголын Шинжлэх ухааны академийн анхны ерөнхийлөгч зэрэг ажлуудыг хийж байсан хүн. 1980-аад оны эхээр Ю.Цэдэнбал түүнийг Шинжлэх Ухааны Академийн ерөнхийлөгчийн ажлаас нь халсан юм. Энэ явдал манай нийгэмд маш их шуугиан тарьж байлаа.

Ер нь улс орныг удирдах чадвартай хүн их ховор байдаг юм билээ.

10 жилд л нэг, хоёр хүн төрдөг юм шиг байгаа юм. Х.Чойбалсангийн үед бол Н.Лхамсүрэн, Б.Ширэндэв хоёр шалгарч байсан юм. Дараачийн 10 жилд нь Д.Төмөр-Очир, Д.Цэнд нар шалгарч байсан юм. МАХН-ын ТХ-ны шинэ Ерөнхий нарийн бичгийн даргын асуудал яригдах бүрийд Ю.Цэдэнбал “Би орныхоо хүнийг бэлтгээгүй байна!” гэж хэлдэг байсан юм. “Миний оронд МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн даргын ажлыг хийж чадах хүн байхгүй. Ийм учраас би өөрөө энэ ажлыг урьдын адил хийж л байя даа!” гэсэн санаа юм. Түүний оронд тэр ажлыг түүнээс илүү хийж чадах хүмүүсийг бүгдийг нь зайлуулж, хөөж, цөлж чадсан болохоор тэгж ам бардам ярьдаг байсан байх. Энэ бол их хачин яриа шүү. Ийм ярианд олон хүн дургүйцэж байсан юм. Их чадвартай хүмүүсийг чинь байнга дэмжиж байдаг хүмүүс бас байдаг юм байна. Ю.Цэдэнбал эхлээд Н.Лхамсүрэн, Б.Ширэндэв нарыг дэмжиж байсан хүмүүсийг бүгдийг нь ажлаас нь халаад, амьдралгүй болгосон юм. Дараа нь Д.Төмөр-Очир, Л.Цэнд нарыг дэмжиж байсан хүмүүсийг бас бүгдийг нь цөлсөн юм. Ингэж их олон хүнийг ажил амьдарлгүй болгосон юм. Энэ чинь нийгэмд томоохон хортой давалгаа үүсгэж байсан юм. Энэ бүгдээс харахад Ю.Цэдэнбал хүн чанар тааруухан хүн байсан юм шиг байгаа юм. Хүнийг ашиглаж байгаад, ашиглаад дуусахаараа хог дээр шууд хаядаг хүн юм билээ. Олон хүнийг ингэж хог дээр хаясан шүү дээ.

Д.Төмөр-Очир, Л.Цэнд хоёр бол маш их чадвартай, ажлын эрч хүч сайтай хүмүүс байлаа шүү дээ. Тэр хоёр МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүн байх үед бүх ажил тэр хоёрын гарт орчихсон юм. Бүх ажлыг тэр хоёр хийдэг байлаа шүү дээ. Ю.Цэдэнбал өөрөө энд, тэнд баяр ёслолын хуралд оролцдог, эсвэл шагнал, урамшил гардуулж явдаг ажилтай болчихсон юм. Тэр үүнээс өөр ажлыг илүү сайн хийж чадах байсан болов уу? Мэдэхгүй. Тэр хоёрыг байхад Ю.Цэдэнбал ийм байдалд орчихсон юм шүү дээ.

Орос-Германы дайны үед “Доголон Төмөр хааны шарилыг онгойлгосоноос болж энэ дайн эхэлсэн!” гэдэг яриа их гарч байсан юм. И.В.Сталин өөрөө Гүрж нутгийн хүн байсан болохоор ийм яриа түүнд бага боловч нөлөөлсөн байж болох юм. Дайн дуусахын үед тэр Монголчуудад их хүндэтгэлтэй ханддаг болсон гэдэг юм. “Монгол гэдэг чинь Орос гэдэг улс буй болохоос өмнө дэлхийн хэмжээний эзэнт гүрэн байсан юм шүү!” гэж И.В. Сталин байнга хэлдэг болсон юм гэнэ билээ. Дэлхийн 2-р дайн дуусахын өмнөхөн 1945 оны 2-р сард “Гитлерийн эсрэг эвсэл”-д нэгдэж байсан АНУ, Англи, ЗХУ гэсэн гурван их гүрний төрийн тэргүүнүүд Ялтад (Крымд – ред.) бага хурал зохион байгуулаад, дайны дараах дэлхий ертөнцийн хэргийг авч хэлэлцсэн шүү дээ. Энэ уулзалт дээр И.В.Сталин Монгол улсыг хамгаалж, түүний “статус кво”-г тэднээр хүлээн зөвшөөрүүлж чадсан юм. И.В.Сталин бас Монголчууд бидний өмнө ийм

гавьатай үйл хэргийг бүтээж өгсөн хүн шүү.

Ю.Цэдэнбал өөрийгөө “Би Орост төрсөн хүн!” гэж ярьсан нэг яриа байдаг юм. Түүнд ингэж ярих нэг шалтгаан байсан юм. 1960-аад оны дундуур Ю.Цэдэнбал өөрийн төрсөн нутаг, Монгол улсын нутаг дэвсгэрийн нэг хэсгийг ЗХУ-д улаан цайм, зүгээр найр тавиад өгчихсөн нэг том хэрэг хийсэн юм. Ю.Цэдэнбал өөрөө Увс аймгийн Давст сумын хүн шүү дээ. Энэ сум бол хойд талаараа ЗХУ-тай хил залгадаг юм. ЗХУ-ын хилээс дотогш Ю.Цэдэнбалын өөрийнх төрсөн газар шороо болох Давст уул байдаг юм. Энэ бол их хэмжээний чулуун давстай уул юм. Энэ уулын өвөрт Ю.Цэдэнбал өөрөө төрж бага насаа өнгөрүүлсэн гэдэг юм билээ. Гэтэл ЗХУ-ын зүгээс энэ уулыг өөртөө нэгтгэж авахаар яриа гаргадаг болсон байна. Их давстай учир давсыг нь ашиглах бодолтой байсан байж магадгүй. Цаад талд нь давсны үйлдвэр байгуулсан гэдэг ч яриа байдаг юм.

Ийм яриа ид гарч байх үед В.М.Молотов ЗХУ-аас Монголд суух Элчин сайдаар томилогдож ирсэн юм. Түүнийг Монголд Элчин сайдаар томилсон нэг зорилго бол энэ Давст уулыг ЗХУ-ын бүрэлдэхүүнд оруулж авах явдал байсан гэдэг яриа ч байдаг юм. В.М.Молотов бол дэлхийн 2-р дайны өмнө, хойно И.В.Сталинтай хамт дэлхий ертөнцийг өөрийн дураар хувааж явсан туршлагатай хүн шүү дээ. Ингээд В.М.Молотов манай засгийн газартай Зөвлөлт-Монголын хилийн асуудлаар хэлэлцээр хийж эхэлсэн юм. Тэр үед манай Гадаад Явдлын Яамны сайдаар Содномын Аварзэд гэдэг хүн ажиллаж байсан юм. Сайд С.Аварзэд Давст уулыг ЗХУ-ын талд шилжүүлж өгөх В.М.Молотовын шаардлагыг хүлээж аваагүй байна. “Давст уул бол эртнээс нааш Монголын нутаг дэвсгэрийн бүрэлдхүүн хэсэг байсан. Цаашдаа ч байх болно. Энэ бол МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн даргын төрсөн нутаг” гэсэн утгатай үг хэлээд В.М.Молотовыг хэлэх үггүй болгож байсан гэдэг юм. МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн даргын өөрийнх нь төрсөн газар шороог “Энэ бол манай нутаг!” гэж В.М.Молотов хэлж, муйхарлаж арай чадахгүй байсан байх л даа. Зөвлөлт-Германы дайны өмнөхөн Балтийн тэнгис хавийн улсуудыг энэ муйхар орос дайрсаар байгаад ЗХУ-ын бүрэлдэхүүнд оруулж авсан түүх бий шүү дээ. Давст уул болон түүний орчмын нутгийг Монгол улсын нутаг дэвсгэрийн нэг хэсэг мөн гэдгийг батлах үүнээс өөр сайн баталгаа байгаагүй нь мэдээжийн хэрэг шүү дээ. Хэрвээ Давст уул Оросын нутаг юм бол Ю.Цэдэнбал аль улсын иргэн юм бэ? гэдэг асуудал босож ирнэ шүү дээ. Ингээд хэлэлцээр гацаанд ороод, олон хоног, сар өнгөрчээ. В.М.Молотов, сайд С.Аварзэдийн байр суурь Зөвлөлт-Монголын хилийн асуудлаар хөдлөшгүй хатуу байгаа талаар Н.С.Хрущевт илтгэсэн байх.

Энэ үед Ю.Цэдэнбал ЗХУ-д амарч явсан байна л даа. Удалгүй Ю.Цэдэнбал Улаанбаатарт эргэж ирээд, Сайд С.Аварзэдийг ажлаас нь халаад, МАХН-ын гишүүнээс хөөсөн юм. Ингээд В.М. Молотовтой хийж байсан Зөвлөлт-Монголын хилийн тухай хэлэлцээр гацаанаас гарч, Давс уул болон тэр хавийн бүх нутгийг ЗХУ-ын талд шилжүүлэн өгсөн юм. Энэ бол дэлхийн 2-р дайны төгсгөлд “Гитлерийн эсрэг эвсэл”-д нэгдсэн гурван гүрний төрийн тэргүүнүүдийн Ялтын бага хурал дээр тохирсон гэрээ, хэлэлцээг зөрчсөн хэрэг явдал байлаа шүү дээ. Ю.Цэдэнбал ийм хачин хэргийг барин тавин хийсэн хүн юм шүү дээ. Энэ явдалд ард түмэн маш их дургүйцсэн юм. Ийм хүнийг ямар эх оронч хүн гэж хэлэх вэ? Ийм хүн Монголын төлөө санаа тавьж чадах уу? Ийм асуултыг тэр үед монголчууд бие биендээ тавьж байсан юм. “Өөрийн төрсөн газар, шороог харийнханд найр тавин өгч байгаа юм чинь Монгол нутгийн аль ч хэсгийг хэнд ч өгч мэдэх юм байна!” гээд л ард түмэн ярьдаг байлаа. Сайд С.Аварзэд ажлаасаа халагдаад, МАХН-аас хөөгдөөд, олон жил ажилгүй явсан юм. Зарим үед таксины жолооч хийж хүртэл үзсэн байх.

1990-ээд оны үед тэр хүн учир битүүлэг шалтгаанаар нэн харамсалтайгаар амь насаа алдсан юм. Улаанбаатарын гудамжинд түүнийг нэг хэсэг үл мэдэгдэх залуучууд барьж аваад зодсоноос болж хүнд бэртэл авч, эдгэрэлгүй байж байгаад нас барсан юм. Монголын цагдаа тэр залуучуудыг эрин сурвалжилж, олох гэж хөөцөлдөөгүй орхисон юм билээ.

Энэ үед бас учир битүүлэг байдлаар Ерөнхий сайд, маршал Х.Чойбалсангийн орлогч байсан Ч.Сүрэнжав гуай нас барсан юм. 1952 онд Х.Чойбалсанг нас барсны дараа түүний оронд Ерөнхий сайдаар хэнийг томилох вэ? гэдэг асуудал их яригдсан юм. “Ю.Цэдэнбал Ерөнхий сайд болох хүн!” гэсэн ойлголт нийгэмд байгаагүй юм. Х.Чойбалсантай олон жил хамт ажилласан болохоор “Ч.Сүрэнжав гуай Ерөнхий сайд болох байх!” гэж олон түмэн хүлээж байсан юм. Гэтэл Ю.Цэдэнбал Ерөнхий сайд болсон хачин хэрэг гарсан юм. 1990-ээд оны эхээр Ч.Сүрэнжав гуайг Улаанбаатарын гудамжинд нэг машин дайрч алсан хэрэг гарсан юм. Түүнээс хойш удалгүй Тосонцэнгэл суманд цөллөгт сууж байсан Л.Цэнд Улаанбаатарт орж ирээд, амьдарч байгаад, “гэнэт” нас барлаа. Хөнгөн ханиад хүрээд эмнэлэгт хэвтэхийн өмнө түүний бие нь эрүүл саруул байсныг олон хүн гэрчилдэг юм.

МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүн, нарийн бичгийн дарга байсан Ц.Намсрай бас “гэнэт” нас барлаа. Ц.Намсрай бол олон жил МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн даргын туслах байсан хүн. 1984 онд Ю.Цэдэнбал ажлаасаа халагдсаны дараа Ц.Намсрай МАХН-ын УТТ-ны гишүүн болж, намын асуудал эрхэлсэн нарийн бичгийн дарга болсон юм. 1990 оны 3-р сард Сүхбаатарын талбайд Ардчилсан холбооноос

өлсгөлөн зарлаж, МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүдийг бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрох шаардлага тавьсан шүү дээ. Тэр үед МАХН-ын УТТ-ны гишүүдийн санал энэ асуудлаар хоёр хуваагдаж байсан юм билээ. Нэг хэсэг нь Ардчилсан холбооны шаардлагыг хүлээж аваад, бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрох саналтай байсан юм билээ. Харин нэг хэсэг нь энэ шаардлагыг хүлээж авахаас эрс татгалзаж, Сүхбаатарын талбайд болж байгаа өлсгөлөнг хүчээр хөөж, тараах саналтай байсан юм шиг байгаа юм. 1989 онд Бээжингийн Тянь-Ань-Минийн талбайд болсон хэрэг явдал бараг давтагдах байсан байж магадгүй. Ц.Намсрай Ардчилсан холбооны шаардлагыг хүлээн авч, МАХН-ын УТТ бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрох саналтай гишүүдийн талд баттай зогсож байсан юм билээ. Түүнээс хойш хуралдсан МАХН-ын ТХ-ны Бүгд хурлууд дээр түүний хэлсэн үг Монголын олон нийтийн анхаарлыг их татаж байсан юм. Монголын эдийн засагт үүссэн хүндрэлүүдийн талаар, олон намын тогтолцоог буй болгох зайлшгүй шаардлагын талаар болон олон урьгалч үзлийг хөгжүүлж, ил, тод байдлыг буй болгох талаар түүний хэлсэн үг, дэвшүүлсэн саналууд нь олны сайшаалыг хүлээж байсан юм.

Энэ үед Дотоод яамны орлогч сайд байсан генерал С.Жамсранжав бас “гэнэт” нас барлаа. Генерал С.Жамсранжав МАХН-ын ТХ-ны Хянан Шалгах Хороо (ХШХ)-ноос хянаж байсан Д.Төмөр-Очир, Л.Цэнд, Ц.Лоохууз, Б.Нямбуу, Б.Сурмаажав нарт холбогдох асуудлуудыг Дотоод яамандаа хариуцаж байсан юм. Тэр эдгээр зохиомол хэргүүдэд ихээхэн бодитойгоор хандаж байсан юм. Энэ тухай Б.Нямбуу өөрийн дурсамжийн “Эх орноо л гэсэн иргэн би” гэдэг номондоо дурсан ярьсныг үзэж болно.

Тэр үед Монголд ийм учир битүүлэг хүн амины хэргүүд олон гарсны дотор Монголын нийгмийг бүхэлд нь доргиосон хоёр хэрэг байдаг юм. Энэ бол 1985 оны “Д. Төмөр-Очирыг алсан хүн амины хэрэг”, 1998 оны “С.Зоригийг алсан хүн амины хэрэг” юм. Энэ хоёр хэрэг “Зохион байгуулалттай улс төрийн зорилготой аллага мөн!” гэдэг нь одоогоор мөрдөн байцаалтаар тогтоогдоогүй байна. Гэхдээ сэжиг төрүүлсэн хэд, хэдэн баримт байдаг юм. Энэ хэрэг хоёулаа 10-р сарын 2-ны өдөр болсон юм. 10-р сарын 2 бол Монголын түүхэнд “Их баривчилгаа” эхэлсэн “хар өдөр” болж орсон юм. 1937 оны 10-р сарын 2-нд Дотоод яамны тушаалаар олон мянган гэм зэмгүй монгол хүн баривчлагдаж, улс төрийн хилс хэргээр цаазлуулсан юм.

Өөр нэг баримт байдаг юм. Д.Төмөр-Очир амьдралынхаа сүүлчийн жилүүдэд Дархан хотод амьдарч байсан юм шүү дээ. Түүний цөөллөгийн хугацаа ч дуусч байсан юм билээ. Тэр Улаанбаатар хотод шилжин суух зөвшөөрөл хүссэн өргөдлөө МАХН-ын ТХ-нд өгсөн юм билээ. Түүний тавьсан хүсэлтийг МАХН-ын ТХ-ны ХШХ хүлээн аваад, Улаанбаатар

хотод шилжин суухыг зөвшөөрсөн юм билээ. Энэ мэдээг “МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүн Д.Моломжамцын даалгавраар, түүний туслах нь ч юм уу даа?, нэг хүн утсаар хэлсэн!” гэдэг нэг ам дамжсан яриа байдаг юм. Тэгээд тэр зөвшөөрлийг хүлээж авахаар Д.Төмөр-Очирын эхнэр Санжмятавын Нинжбадгар Улаанбаатар хот руу явсан юм байна л даа. С.Нинжбадгар бол их боловсролтой, эрдэмтэй, сайн зохион байгуулагч эмэгтэй юм. Тэр одон орны судлалын ухаанаар Москвагийн Улсын их сургууль дээр эрдмийн зэрэг /Sc.D/ хамгаалсан анхны монгол эмэгтэй юм. 1962 онд Д.Төмөр-Очирыг гүтгээд, нутаг зааж, цөллөгт явуулах шийдвэр гаргасны дараа МАХН-ын ТХ-ны ХШХ-оос “МАХН-ын ТХ-ны энэ шийдвэр С.Нинжбадгар чамд хамаарахгүй шүү. С.Нинжбадгар чи Улаанбаатар хотод үлдээд одон орон судлалынхаа ажлыг хийж байж болно!” гэж хэлсэн юм билээ. Тэр үед нь С. Нинжбадгар “Би Төмөр-Очиртой суусан болохоос биш, танай Төв Хороотой (МАХН-ын Төв Хороо–ред.) суугаагүй юм шүү!” гэж хэлээд, ажлаасаа гараад, нөхрөө дагаад цөллөгт явж байсан юм. Д.Төмөр-Очирын цөллөгийн бүх хугацаанд нь хамт байж, түүний үзсэн бүх доромжлол, хавчилт, зовлон, зүдүүрийг хамтдаа туулсан хатан зоригтой монгол бүсгүй, ухаант монгол эхнэр юм шүү. Ингээд С.Нинжбадгар Улаанбаатар хот руу МАХН-ын “зөвшөөрөл”-ийг авахаар явсан хойгуур Д.Төмөр-Очирыг гэртээ ганцаараа байхад нь алсан хүн амины хэрэг гарсан юм.

Д.Төмөр-Очирыг Дархан хот дахь Дотоод яамны салбарын ажилтан, хурандаа Дашдорж хянаж байсан юм билээ. Дархан хот дахь Дотоод яамны салбар Д.Төмөр-Очирыг хаана, хэзээ, хэнтэй уулзаж, юу ярьсан зэргийг цаг, минутаар нь бүртгэж, Дотоод яамны удирдлагад өгдөг байсан юм шүү дээ. Тийм учраас Д.Төмөр-Очирын гэрт 1985 оны 10-р сарын 2-ны орой хэн, ямар зорилгоор орсон, гэрт юу болсон зэргийг мэдэхгүй байх ёсгүй юм. Монголын ард түмэн ингэж ойлгодог юм. 2000 оны сонгуулиар дахин засгийн эрх авсныхаа дараа МАХН-ын одоогийн дарга Н.Энхбаяр, Дархан хот дахь Дотоод яамны салбарын ажилтан хурандаа Дашдоржийг хүлээн авч уулзаад, МАХН-ын өмнө түүний байгуулсан гавьяа, зүтгэлийг нь өндрөөр үнэлж, баяр хүргэж байсан юм. Энэ бол Монголын ард түмний нүдэн дээр болсон, чөлөөт хэвлэл дээр зураг, хөрөгтэйгээ гарсан үйл явдал шүү дээ.

1998 оны Монголын Ардчилсан хувьсгалын удирдагч С.Зоригийг алсан хүн амины хэрэг гарахад “Манай хүчний байгууллагуудын оролцоо байсан байж магадгүй!” гэсэн яриа олон түмний дунд тасардаггүй юм. Энэ хэрэг гарах үед Монголын Цагдаагийн газрын даргаар Монгол улсын гавъяат хуульч, хурандаа Д.Мөрөн гэдэг нэг гялалзсан сайхан залуу ажиллаж байсан юм. Хурандаа Д.Мөрөн үүний өмнө олон удаа

эрүүгийн хүнд гэмт хэргүүдийг илрүүлж байсан сайн мөрдөн байцаагч, сайн хуульч байсан юм. Тийм ч учраас тэр хамгийн залуугаараа Монгол улсын гавъяат хуульч болж, Монголын цагдаагийн байгууллагын хамгийн залуу удирдагч болсон юм. Энэ хэрэг гарсны дараа өдөр болсон хэвлэлийн бага хурал дээр хурандаа Д.Мөрөн “Хүн амины энэ хүнд гэмт хэргийг Монголын Цагдаагийн байгууллага илрүүлнэ!” гэсэн утгатай үг хэлж, “шок”-нд орсон олон түмнийг өөрийнхөө араас хуйлруулж байсан юм. 2000 оны сонгуульд тэр МАХН-аас Улсын Их Хурлын гишүүнд нэрээ дэвшүүлээд явж байхдаа “Ардчилсан эвсэл засгийн эрх барьж байгаа үед энэ хэрэг илрэхгүй!” гэсэн утгатай үг хэлээд олон түмнийг бас дахин өөрийнхөө араас хуйлруулж байсан юм. 2000 оны Улсын Их Хурлын сонгуульд МАХН үнэмлэхүй ялалт байгуулахад хурандаа Д.Мөрөнгийн хэлсэн энэ үг шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн гэж манай чөлөөт хэвлэлүүд дүгнэсэн юм. “Ардчилсан хөдөлгөөний удирдагчийг алсан хэргийг илрүүлж чадна!” гэж ард түмэн түүнд итгэж байсан юм шүү. Одоо түүний хэлсэн энэ үг “олон түмнийг төөрөлдүүлэх, хуурч, мэхлэх, тайвшруулах, нийгмийн сэтгэл зүйд нөлөөлөх зорилготой үг байсан” гэж олон хүн ойлгодог болсон юм. Ийм зорилготой үгийг тэр үед ганц хурандаа Д.Мөрөн ч хэлж байсан юм биш.

МАХН-аас нэр дэвшиж Монгол улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон Нацагийн Багабандийн хэлж байсан үг ч ийм зорилготой байсан байхыг үгүйсгэх аргагүй юм. “Би хүн амины ноцтой энэ хэргийг өөрийн онцгой хяналтандаа байлгана !” гэсэн утгатай түүний олон дахин хэлсэн үгийг өнөөдөр Монголын ард түмэн мартаагүй байна. Ерөнхийлөгч Н.Багабандийн тамгын газрын дарга Санжийн Баяр Монголын нэгэн чөлөөт хэвлэлд өгсөн нэг ярилцлагадаа, Монголын Ардчилсан хөдөлгөөний удирдагч Санжаасүрэнгийн Зоригийн 1998 оны 10-р сарын 2-ны өдөр хийсэн бүх ажлууд, уулзсан бүх хүмүүсийг нь өглөөнөөс эхлээд цаг, минутаар нь мэдэж байснаа ярьсан байдаг юм. Энэ санаатай яриа юу? Санамсаргүй ам алдсан хэрэг үү? Бүү мэд! Энэ хоёр хэргийн учир шалтгааныг хэзээ илрүүлж, гэмт этгээдүүдийг хэзээ, яаж шийтгэхийг Монголын ард түмэн өнөөдөр хүлээсээр л байна.

14 Манайх гэдэг айл.

КЮ: Одоо танай гэр бүлийн талаар ярилцах уу?

Ц Л: Манай эхнэрийг Жамбалын Буянжаргал гэдэг. Аав нь “Хэцүү Жамбал” гэж нэрлэгддэг, нутаг усандаа алдартай хүн байсан юм. Ээжийг нь Намдаг гэдэг байлаа. Тэд нар 80 хол гартлаа өндөр насалсан юм.

Манай эхнэр ээжийнхээ 50 насан дээр төрсөн юм. Хоёр эгч, хоёр ахтай хүн. Манай Говь-Алтай аймгийн Наран сумын хүн шүү дээ. Бид хоёр 1955 онд анх танилцсан юм. Би тэр үед Говь-Алтай аймгийн МАХН-ын хорооны нэгдүгээр нарийн бичгийн даргаар томилогдоод ажиллаж байлаа. Би нэг удаа хавар Наран суманд мал төллөлтийн явцтай танилцаад явж байсан юм. Тэр өдөр цасан шуурга шуурч, их хүйтэн байлаа. Тэгээд жаахан дулаацах санаатай нэг айлд орлоо. Тэр айлд нэг залуухан бүсгүй байна. Ээж нь байж байна. Аав нь байхгүй, гадагшаа малд явсан бололтой юм. Өөр хүн байсангүй. Тэр эмэгтэй надад сүүтэй, өтгөн цай хийж өгч байна. Би түүний цайнаас уугаад, ээжтэй нь ойр зуурын юм яриад нилээд суулаа. Тэгж байтал аав нь ирлээ. Бид нар Наран сумын мал төллөлтийн байдал болон нутаг орны талаар ярьж суулаа. Ингэж байтал цасан шуурга ч зогслоо. Би явахаар боллоо. Тэгээд түүнээс хойш тэр айлын бүсгүйд сэтгэл татагдаад, аятайхан санагдаад, тэднийхээр дахин дахин ирдэг боллоо. Аав, ээжтэй нь сайн танилцаж авлаа. Ингэж явсаар байгаад, тэр бүсгүйтэй сууж, гэр бүл болохоор шийдсэн юм.

Манай аав тэр үед намайг “Эхнэр авч, гэрлэх хэрэгтэй!” гэж их шаарддаг байлаа л даа. Би 30 гаруй настай л байсан юм. Ингээд нэг өдөр аавдаа танилцсан бүсгүйнхээ тухай ярилаа. Миний аав “Та хоёрт насны зөрөө байна. Гэхдээ энэ хамаагүй. Харин тэр бүсгүй чинь ямар удамтай юм бэ?” гэж асууж байна. Тэгээд би танилцсан бүсгүйнхээ аав, ээжийнх нь удмыг сонирхлоо. Аав нь тайж удамтай юм. Манай нутагт “Бодь тайжийнхан” гэдэг хэсэг төрөл хүмүүс байсан юм. Тэднийхэнтэй холбоотой юм байж. Ингээд миний аав “Гэрлэж болох юм байна!” гэж надад зөвшөөрөл өгсөн юм. Ингээд бид хоёр Говь-Алтай аймгийн төв Алтай хотод гэр бүл боллоо. Тэр үед аймгийн МАХН-ын хороо зохион байгуулаад хурим хийлээ. Ингэж бид хоёр гэрлэлтээ албан ёсоор бүртгүүлсэн юм. 1956 оноос хойш одоо 49 жил өнгөрчээ. Манайх дөрвөн хүүхэдтэй. Хоёр хүүхэд маань өргөмөл хүүхэд юм.

Бид хоёр хуримаа хийсэн тэр жил манай авгайн төрсөн ахынд нэг хүү төрсөн юм. Тэр хүү төрснөөс хойш удалгүй, миний ажлын байдлаас болоод бид нар Улаанбаатарт очиж амьдрах боллоо. Бид хоёр өөрсдийн хүүхэдгүй байсан юм. Ингээд авгайн ахынд төрсөн тэр хүүг авч явахаар боллоо. “Улаанбаатарт хүн таньж мэдэхгүй, хүүхэдтэй явъя !” гэж ярьж байсан юм. Тэр хүү маань 5 нас хүртэл манайд хүүхэд төрсөнгүй. Ийм болохоор надтай хамт ажиллаж байсан миний талын төрлийн Дашзэвэг гэдэг айлаас дахиад нэг охин өргөж авлаа. Ингээд манайх хүү, охин хоёртой боллоо.

Ингэж байтал манай эхнэрийн 35 насан дээр нэг хүү төрөөд, 40 насан дээр нь нэг охин төрсөн юм. Ингэж манайх 4 хүүхэдтэй айл болсон юм.

Энэ дөрвөн хүүхэд одоо дээд тал нь тав, доод тал нь хоёр хүүхэдтэй, манайх 13 зээтэй болоод байна.

Манай эхнэр нутагтаа байхдаа бага сургуулийн 3-р анги төгссөн юм. Улаанбаатарт ирээд оройн сургуульд сурч 8-р анги төгсөв. Тэгээд нэг жил эм найруулагчийн курст суралцаж эм найруулагч болсон юм. Ингээд цаашдаа их, дээд сургуульд орж суралцах хүсэлтэй байсан боловч өөр учир шалтгааны улмаас цаг хугацааны боломж олдоогүй юм. Эм найруулагч болоод Улаанбаатар хотод 2-р эмнэлэгт ажил хийдэг байлаа. Тэнд эм найруулаад, биохимийн лабораторид ажиллаж байлаа. Манай хүний бие нэг хэсэг их муудсан юм. Уушиг муутай юм. Тэгээд Бээжин явж мэс засал хийлгэсэн юм. Эм найруулагчийнхаа ажлыг насаараа хийлээ. Одоо тэтгэвэртээ гарсан. Нэг хэсэг энэ ажил тасалдсан. Би МАХН-ын ТХ-ны 6-р Бүгд хурал дээр шүүмжлэл тавьж, МАХН-аас хөөгдөөд, нутаг заагдаж, хөдөө амьдрах болсноос болоод нэг хэсэг ажил нь тасалдсан юм.

15 Атар газрыг эзэмшиж эхлэв.

И Л: Анх трактороор газар хагалж, ёслол үйлдэн атар газар эзэмших ажил эхэлсэн газар хаана байдаг юм бэ?

Ц Л: Манайд атар газрыг эзэмших ажлыг хариуцаж байсан Сангийн аж ахуйнуудыг удирдах газрын даргаар би 6 жил ажилласан гэж ярьсан шүү дээ. 1957, 1958, 1959 онуудад хуралдсан МАХН-ын ТХ-ны бүх Бүгд хурлуудаар газар тариалангийн асуудал яригдсан юм. Улсын төлөвлөгөөний комиссын дарга Л.Цэнд бид хоёр бүгд хурлын бэлтгэл ажлыг хийсэн юм. Монгол орон бол дээр үеэс Алтайн нурууны наад талаар бага хэмжээний тариа тарьдаг байсан юм. 20-р зууны эхээр Хараа, Ерөө голын саваар тариа тариалах болсон юм. Энэ үеэс Монголд хятад хүн тариа тарих ажил нилээд ихэссэн юм. Энэ бол улсын эдийн засагт ямар ч нөлөө байхгүй, зөвхөн хувь хүмүүсийн амьдралд нь нэмэр болохуйц бага хэмжээний тариа байсан юм. Манай улс атар газрыг эзэмших замаар үр тарианы үйлдвэрлэлийг эрс нэмэгдүүлж, өөрийн орны үр тарианы хэрэгцээг бүрэн хангах зорилт дэвшүүлсэн юм. Энэ бүх ажил бол манайд хуучин байгаагүй шинэ ажил юм л даа.

Эхний жил сайн ургац авч чадаагүй юм. Хоёр дахь жилээс нь сайн ургацтай болсон юм. Ингээд удалгүй эх орны үйлдвэрийн гурил худалдаанд гарч эхэлсэн юм. Ингэж манай улс анх удаа дотооддоо гурил үйлдвэрлэж эхэлсэн юм. Энэ бол олон зуун жил Монголд байгаагүй цоо шинэ ажил шүү дээ. Энэ үед ЗХУ-аас 300 гаруй мэргэжилтэн ирж ажилласан юм. ХАА-н техникийн мэргэжилтнүүд, агрономууд,

хөрсний мэргэжилтнүүд, усалгааны мэргэжилтнүүд, малын үүлдэр, угсаа сайжруулах зоотехникүүд бүх САА-нуудад ажиллаж байсан юм. Энэ бүх ажил САА-нуудыг удирдах газар дээр төвлөрч байсан юм. Тэр үед бидэнд хамгийн бэрхшээлтэй зүйл бол ХАА-н бүх төрлийн машин-механизмын хангамж, сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээ, шатахуун түлшний асуудал байсан юм. ХАА-н машин механизмын мэргэжилтэй хүн цөөхөн байлаа. САА-нуудад ХАА-н машин механизмын граж, засвар үйлчилгээний газруудыг маш яаралтай байгуулсан юм. Засварын мэргэжилтнүүдийг Зөвлөлтийн мэргэжилтнүүдийг дагалдуулан сургаж байсан юм. Ажлын явцад гарч ирсэн аливаа асуудлыг бид цаг алдалгүй, хурдан шийдэж өгч байсан юм. Тийм зарчмыг бид баримтлан ажиллаж байсан учир ажил урамтай, хурдан урагшилж байсан юм. Зөвлөлтөөс ирсэн мэргэжилтнүүдийг САА-нууд өөрсдөө байр орон сууцаар хангаж байсан юм. Цалин хөлсийг нь ч өөрсдөө дааж байсан юм. Сайн ажиллавал цалин хөлсөө бүтэн авна, муу ажиллавал цалин хасагдана. Цалин хөлсний тийм систем ЗХУ-аас ирсэн мэргэжилтнүүдэд бас үйлчилж байсан юм.

Бид анхны хагалгааны ажлыг ойт-хээрийн бүсийн үржил шимтэй, хар шороон хөрстэй Орхон-Сэлэнгийн билчирээс эхэлсэн юм. Баруун аймгууд, говийн аймгууд, зүүн талын аймгуудад эхний жил хагалгаа тийм их явагдаагүй юм. Тэнд хагалгаа хийж болох үржил шимтэй, хар шороон хөрстэй талбайн хэмжээ бага байдаг юм. Хэнтий, Дорнод аймагт мөн ижил хар шороон хөрстэй нутаг бага хэмжээтэй байдаг юм. ЗХУ-ын Чита мужтай хил залгадаг Эрэнцавын САА-д бол жаахан бий. Түүнээс наана Хэрлэнгийн САА, Баян-Уулын САА-д жаахан хагалгаа хийсэн юм. Хөвсгөл аймгийн Тариалангийн САА, Архангай аймгийн Төвшрүүлэхийн САА, Өвөрхангай аймгийн Хархорины САА-нуудад их хэмжээний атар газрыг хагалсан юм. Сэлэнгэ аймгийн Зэлтэрийн САА, Цагааннуурын САА, Цагаан толгойн САА, Алтанбулагийн САА, Ерөөгийн САА болон Дарханы САА, Төв аймгийн Жаргалантын САА-д их хэмжээний газар хагалсан.

Хамгийн анх шинэ газар хагалж эхлэх ёслолын ажилгааг Дарханы САА-н Цайдамын хөндий гэдэг газар хийсэн юм. Тэнд анхны анжисыг тавьж байлаа. Энэ ёслолд Ю.Цэдэнбал, Ж.Самбуу, Н.Жагварал зэрэг МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүд ирж оролцож байсан юм.

Манай Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн дарга Ж.Самбуу гуай бид хоёр түүнээс хойш олон удаа хамтдаа САА-нуудаар явж, ажил бадалтай нь газар дээр нь танилцаж байлаа. Би хөдөө САА-д очоод Ерөнхийлөгчид САА-н ажлуудыг танилцуулж, хөдөлмөрчидтэй уулзах уулзалтан дээр хэлэх үгийг нь бэлтгэж өгдөг байсан юм.

Түүнтэй хамт ийнхүү хөдөө явдаг байхад тохиолдсон нэг үйл явдлын

талаар би та нарт ярьж өгье л дөө. Хэдийгээр их олон жил өөрийн орныг төлөөлж гадаад оронд Элчин сайдаар сууж байсан боловч манай ерөнхийлөгч Ж.Самбуу гуай ер нь жинхэнэ монгол ёс заншлыг эрхэмлэдэг хүн байлаа шүү дээ. Бүх л ажлаа монгол маягаар явуулдаг байв. Түүний идддэг хоол, уудаг цай бүгд л монгол байв. Түүний татдаг тамхи нь л гадаадынх байсан байх. Тэр ЗХУ-д үйлдвэрлэсэн “Казбек” гэдэг тамхийг л татдаг байв. Манайхан тэр тамхийг хайрцаг дээр байдаг зургаар нь “Хар морьт” гэдэг юм. Тэр үед бид нар манай малын ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор үйлдэр угсааг нь сайжруулах талаар их ажил зохиодог байв. Тэгээд эрдэмтэн С.Аюурзанааар ахлуулсан хэсэг эрдэмтэд, зоотехникчид Монгол хонийг гадаадаас авсан хоньтой эрлийзжүүлэх замаар нарийвтар ноосны “Орхон” үүлдрийн хонь гаргаж авчээ. Хамгийн гол нь энэ бол нарийвтар ноос гаргадаг ноосны чиглэлийн хонь байсан юм. Махны чиглэлийнх биш. Энэ бол манай эрдэмтэд мэргэжилтнүүдийн олон жилийн шаргуу хөдөлмөрийн дүнд буй болсон яах аргагүй маш том амжилт байв. Энэ чинь их том үйл явдал болж байгаа юм шүү дээ. Бид өөрсдийнхээ хүчээр манай нөхцөлд тохирсон, ноосны чиглэлийн цоо шинэ үүлдрийн хонь гаргаж авлаа шүү дээ. Тэгээд бид нар энэ үйл явдлыг ёслол тэмдэглэхээр болоод энэ арга хэмжээндээ Ерөнхийлөгчийг урьсан юм. Ерөнхийлөгч ч бидний урилгыг хүлээж аваад ирэхээр болов. Ингээд бид нар тусгай гэр бариад тэндээ ерөнхийлөгчийг хүлээж авахаар бэлтгэлээ. Манай урдаа барьдаг эрдэмтэд бүгд ирсэн байв. Бас ХАА-н дээд сургуулийн багш, аспирант оюутнууд ирсэн байв. “Орхон” үүлдрийн хониноосоо нэгийг төхөөрлөө. Махыг нь чаналаа. Ингээд ерөнхийлөгч ирлээ. Бид түүнийг нөгөө тусгай зассан гэртээ орууллаа. Тэр бүх хүнтэй мэндлээд бидний зассан ширээнд суулаа. Цай уулаа. Тэгээд хонины махнаас огтлоод идлээ. Тэр хоёр огтолсноо больчихлоо.

Тэгснээ:

-Нохой сүүлтийн мах юм уу? гээд цааш нь түлхээд орхичихлоо.

Миний дотор харанхуйлаад л явчихлаа. Манайхан гадаадын эрлийз хонийг “нохой сүүлт” гэдэг юм. Эрлийз хонины сүүл нь нохойны сүүл шиг унжиж явдаг болохоор тэгж нэрлэдэг болсон байж магадгүй. Монгол хонины сүүл чинь таваг шиг том дугуй юм байдгийг та нар мэдэх байлгүй дээ. Манайхан хүүхдээ нялх байхад нь хонины сүүл бариулж хөхүүлдэг шүү дээ. Хүүхдийн эрүүл мэндэд сайн, маш их уураг, тэжээлтэй хоол байдаг юм. Багадаа ингэж хонины сүүл хөхөж өссөн хүн чинь бие бялдар том, эрүүл чийрэг, ухаан санаа саруул болдог юм. Ер нь хонины сүүл хөхөж өсөөгүй монгол хүн байхгүй байх шүү. Хүүхдэд хөхүүлэх сүүл байхгүй, мах нь амтгүй болохоор манайхан эрлийз хонинд дургүй л дээ. Үнэхээр ч бэлчээрийн монгол хонины махыг эрлийз хонины мах

амт чанараараа яагаад ч гүйцэхгүй л дээ. Олон мянган жил энэ байгаль орчиндоо дасан зохицсон бэлчээрийн монгол малын мах гэдэг чинь хаана ч байхгүй тансаг хүнс юм шүү дээ. Тэгээд ч монгол хүн ер нь бүх малын махан дотроос хонины махыг хамгийн амттай нь гэдэг шүү дээ. “Хонины мах шиг сайхан амттай!” гэж аливаа амттай юмыг түүнтэйгээ харьцуулдаг юм. Гэхдээ Ерөнхийлөгчийн энэ хэлсэн үг миний сэтгэлийг маш их гонсойлгож билээ. Даан ч харамсалтай гоомой үг байсан даа. Бид олон жил ярьсан ажлаа дөнгөж биелүүлээд, бүгд л баяр хөөртэй байлаа шүү дээ. Зөвхөн би ч биш тэнд байсан бүх хүн л өөр өөрсдийнхөөрөө нэгийг бодсон байх. Бүгд л толгойгоо гулдайлгасан, ямар ч урамгүй болчихсон зогсож байхыг би харсан. Ерөнхийлөгч зөвхөн монгол хонины мах иддэгийг бид мэдэж байсан уу? гэвэл мэдэж байсан. Гэхдээ энэ чинь хонины махны амтандаа биш юм л даа. Би хэд хоног сэтгэлээр их унасан явж билээ. Нэг ийм үйл явдал болсон юм.

Ерөнхийлөгч өөрөө шатар тоглох их хорхойтой хүн байсан юм. Улаанбаатарт амралтын өдрүүдээр тэр намайг ихэнхдээ гэртээ дуудаж, бид хоёр шатар тоглодог байлаа. Түүний гэргий Нямаа гуай бид нарт монгол сүүтэй цай чанаж өгөөд л, бид нар шатар тоглоод л өдрийг өнгөрөөдөг байлаа. Нямаа гуай бол маш энгийн, жирийн сайхан хүн байж билээ. Намайг “намаас арга хэмжээ авхуулаад” Өвөрхангай аймгийн Сант суманд Дотоод яамны хатуу хяналтын доор хонь хариулж байхад, Нямаа гуай надад дээл хийх үйтэн хуар торгоор бэлэг ирүүлж байсан билээ.

Манайд атар газрыг эзэмшиж эхэлсэн эхний үед “Газар тариалан гэдэг юу юм бэ? Ямар онцлогтой ажил юм бэ?” гэдэг талаар УТГ-ны гишүүдэд мэргэжилтнүүд тусгай хичээл заадаг байсан юм. Монгол мэргэжилтэн энэ хичээлийг заадаг байлаа. Гэхдээ тэр үед агрономич мэргэжилтэй Монгол хүн цөөхөн, бараг байгаагүй юм. ЗХУ-аас ирсэн нэг эрдэмтэн гол хичээлийг нь зааж байсан юм. Би өөрөө бас тэр хичээлд сууж байсан юм байна шүү. Байгалийн халуун хүйтэн, газрын гадаргын өндөр нам, хөрсний сайн муу зэрэг нь газар тариаланд ямар үүрэгтэй юм бэ? гэх мэтээр анхан шатны мэдлэгүүдийг өгч байсан юм. Манай хөрс бол ерөөсөө тариа тариалж байгаагүй учир маш тэжээлтэй сайн хөрс юм шүү дээ.

Тэр үеийн цаг агаарын байдал одоогийнхоос нилээд өөр байсан юм шүү. Хавар, зуны эхэн үед хур бороо элбэгтэй байсан юм. Наадмаас хойш үер, борооны үе эхэлдэг байлаа. Хангайн бүсэд бороо их орно шүү дээ. Намар 9 сард ургац гүйцнэ. Ургацаа дандаа техникээр хурааж байлаа. Тэр үед ЗХУ-аас СКА-3, СКА-4 гэдэг комбайнууд ирж байлаа. Тэр үед ЗХУ ХАА-н машин механизмаа бүгдийг нь шинэчилсэн, техник нь шинэ загвартай, хүчтэй, хүрэлцээтэй байсан юм. Бид нар ХАА-н машин

механизмаар тийм их дутаагүй. Сэлбэг хэрэгсэл дутах явдал их гарч байсан боловч бид энэ асуудлыг цаг тухайд нь яаралтай шийдэж чадаж байсан юм.

1959 онд Хөдөө Аж Ахуйн дээд сургуулийн агрономын ангийн төгсөлт болсон юм. Бүр урьдчилсан төгсөлт болсон юм. Төгсөгчид шууд атарын САА-нуудад очиж ажилласан юм. ЗХУ-ын Темерязовын нэрэмжит ХАА-н академийг төгссөн хүмүүс манайд цөөхөн байсан юм. Мэргэжилтний хүрэлцээ ер нь их муу байлаа. Нэг САА-д 7-8 агрономич ажиллах ёстой байсан юм. Бүгдийг биш гэхэд ихэнхэд нь мэргэжилтэн өгсөн. САА-н дарга нарын хувьд жаахан бэрхшээл байсан юм. Мэргэжилтэй хүн бага байсан болохоор зохион байгуулах чадвартай, ерөнхий мэдлэгийн хүрээ сайтай, олон түмэнтэй нийцтэй хүмүүсийг САА-н даргаар томилж байлаа. Хуучин удирдах ажил хийж байсан ажлын туршлагатай тийм хүмүүсийг томилж байсан юм. Өөр арга байсангүй. Зөвлөлтийн мэргэжилтнүүд тариалалт хийх, ургац хураах ажилд туслаж байсан юм.

Газар тариалангийн бүх ажлыг технологийн горимын дагуу явуулж байлаа. Тариалалт хийх, ургац хураах зэрэг технологийн горимыг яг таг мөрдөж байлаа. Хөрсийг амраах, ээлжлэн тариалах тенологийн горимтой байсан юм. Тухайлбал, улаан буудайг нэг хөрсөн дээр 2-3 жил ээлжлэн тариалж болно. Цаашид хөрс өгөрч, муудах учир түүнийг нэг жил өнжөөх ёстой. Улаан буудай тарьсны дараа малын тэжээлийн овъёос ч юм уу өөр зүйл тариалж, сэлгэх ёстой. Ингэж тарьсны үндсэн дээр хөрсний чанар мууддаггүй, ургацын хэмжээ буурдаггүй юм. Ийм горимыг хатуу мөрдөж байлаа. Бид химийн бордоог их хэмжээгээр ашиглаж байгаагүй. Харин тариалангийн талбайн хогийн ургамалыг нь устгах зорилгоор хэрэглэж байсан. Нэг гектараас 10 центнер ургац авч байлаа. Зарим хөрс сайтай газар ургац 20-25 центнер хүрч байсан юм. Улсын дундаж бол нэг гектараас 8-12 центнер ургац байсан юм.

“Атар газар эзэмшснээр Монголын ХАА-д хувьсгал гарлаа!” гэж ярьж байсан юм. Атар газрыг эзэмшснээр манай улс гурилын хэрэгцээгээ өөрөө бүрэн хангаад зогсоогүй, манай уламжлалт амьдралын хэв маягт ихээхэн өөрчлөлт орсон юм. Газар тариалангийн салбарт ажиллаж байгаа хүмүүс суурин болон хагас суурин амьдарлд шилжиж эхэлсэн юм. Газар тариаланг дагаад урьд нь Монголд огт байгаагүй шинэ аж ахуйнууд үүссэн юм. ХАА-н салбарт хүмүүс бөөгнөрч төв, суурин газрууд бий болсон юм. Соёл, боловсролыг хөгжүүлэх боломж нээгдсэн юм. САА-н төвүүд нь томоохон соёлын төвүүд болсон юм. Сургууль, цэцэрлэг, ясли, хүн эмнэлэг, харилцаа, холбооны газар, соёлын ордон зэрэг газрууд САА-н төвүүдэд бий болсон юм. Энэ бол асар том дэвшил байсан юм. Олон зуун хүн ХАА-н мэргэжилтэй боллоо. ХАА-н Хөдөлмөрийн баатрууд,

хөдөлмөрийн сайчууд олноороо төрөн гарлаа. Газар тариалан Монголын ХАА-н бие даасан салбар болж, бусад салбарт хүчтэй нөлөө үзүүлсэн юм. Энэ бүх ажлыг удирдаж байсны хувьд намайг Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнаж байлаа.

Хожим Монгол оронд ардчилал, шинэчлэл эхэлснээс хойш, 1999 онд Атар газар эзэмшсний 40 жилийн ойгоор манай Хөдөө аж ахуйн яам санаачлаад, намайг “Монгол улсын хөдөлмөрийн баатар” цолоор шагнуулах саналыг дэвшүүлсэн юм. Тэр үед бидний хийсэн ажил ард түмний нүдэн дээр ил, үр өгөөжөө өгсөн ажил байсан болохоор тэр цолыг авах юмсан гэсэн хүсэл надад байдаггүй юм. Тэртэй тэргүй ард түмэн мэдэж байна, харж байна шүү дээ. Ажил хийсэн хүнд л олгодог юм бол тэр цол надад ирнэ шүү дээ. Гэхдээ энэ цолыг олгоход үзэл суртал хүчтэй үүрэг гүйцэтгэдэг юм. Одоо ч тийм л байна. Ерөнхийлөгч Н.Багабанди ч шагнах шийдвэр гаргаагүй байна билээ.

САА-нуудыг удирдах газар нэг хэсэг ХААЯ-тай нэгдэж, би ХААЯ-ны нэгдүгээр орлогч сайд болсон юм. Манай сайд Нямын Жагварал намайг их дэмжиж байсан юм. Бугын аж ахуй, загасны аж ахуй, галуу, нугасны аж ахуй байгуулах ажлыг тэр их дэмждэг байлаа. Бид нар тоног төхөөрөмжийг нь ЗХУ-аас худалдан авч ирээд “Шувуу фабрик”-ийг байгуулсан юм. Энэ шувуу фабрикийг байгуулах зөвшөөрөлийг Улс Төрийн Товчооноос авахад нэг инээдэмтэй яриа болсон юм. Энэ асуудлыг хэлэлцсэн хурлыг Ю. Цэдэнбал өөрөө удирдаж байв. Тэр энэ асуудлыг хуучин зангаараа хойш тавих байх гэж болгоомжилж байсан тул би хуралд Сергей Иванович Елизаров гуайг дагуулж оров. Ю. Цэдэнбал дарга энэ асуудлыг танилцууллаа. Тэгээд :

-Манай хүн ам одоо дөнгөж нэг сая л хүрч байна. Энэ Лоохуузын байгуулах гээд байгаа тэр “Шувуу фабрик” нь сая гаран өндөг үйлдвэрлэх юм байна. Ийм их өндгийг хэн авах юм бэ? Энэ арай хэтэрч байна. Ийм зарчимгүй юм байж болохгүй! Энэ чинь юу гэсэн үг вэ? гэж хэллээ. Гэтэл хуралд сууж байсан УТТ бусад гишүүд: “Нээрэн тийм шүү! Хэтэрхий олон байгаа юм биш үү?” гээд ам амандаа яриад, түүний хэлснийг дэмжээд явчихлаа. “Манай асуудал нурлаа!” гэж бодоод миний дотор харлаад л явчихлаа. Тэгээд миний хажууд сууж байсан С.И.Елизаров гуайг “Бос!” гээд тохойгоороо нударлаа. Тэр босоод л тахианы өндгийг бүтнээр нь чанаж хэрэглэхээс гадна юунд хэрэглэж болох талаар баахан ярьлаа. Гэтэл Ю. Цэдэнбал түүний үгийг сонсож байна шүү. Ер нь тэр Зөвлөлтийн мэргэжилтний үгийг л сонсдог байв шүү дээ. Тэгээд их зөөлрөөд ирлээ. Зөвшөөрөх янзтай болоод ирэв. Тэгэхээр би нэмээд :

-Дарга аа! Манай Дэмүүл аварга чинь нэг суудал дээр 100 ширхэг бууз иддэг юм шүү дээ! Түүн шиг иддэг бөх цөөнгүй байна. 100 өндөг бол

тэдэнд юу ч болохгүй л дээ! гээд хэлчихлээ. Миний үгийг сонсоод УТТ-ны бусад гишүүд хөхрөлдөөд явчихлаа. Ингээд бөөн наргиан болоод манай асуудал шийдэгдэж байв. Монголд одоо ганцхан энэ “Шувуу фабрик” л ажиллаж байна.

“Каракуль хонины аж ахуй” гэж том аж ахуйг бид байгуулсан юм. 10.000-20.000 каракуль хоньтой байсан юм. Тэнд каракуль арьс бэлтгээд экспортоор гадаадад гаргадаг байлаа. Энэ каракуль хонь бол маш сайхан арьстай мал шүү дээ. Ийм арьсаар цэргийн дараг нарын өвлийн малгайг хийдэг юм. ЗХУ-ын Цэргийн генерал, дарга нар каракуль хонины арьсаар хийсэн сайхан хувцас өмсдөг шүү дээ. Их сайхан арьс юм. Ингээд манай цэргийн дарга нар бас өөрийн каракуль хонины арьсаар хийсэн хувцас өмсдөг болсон юм. Хар, саарал өнгөтэй сайхан арьс бэлтгэдэг байлаа. Бид булганы арьс, туулайны арьс хүртэл ЗХУ-д экспортоор гаргадаг болсон юм. Дотоодынхоо хэрэгцээг бол бүрэн хангасан шүү дээ.

Тэр үед би ЗХУ-аас ирсэн мэргэжилтнүүдтэй их ажилладаг байлаа. Тэр үеийн ЗХУ-ын хэвлэлүүдийг би их сонирхож уншдаг байлаа. Бас өөрөө ЗХУ-д очиж, Сибирийн аж ахуйн газруудтай их танилцаж байлаа. Сибирь бол цаг уурын нөхцлийн хувьд манайтай илүү ойролцоо шүү дээ. Өвөл бол харьцангуй хүйтэн л дээ. Бид нар Сибирийн аж ахуйн туршлагыг өөрсдийн ажилд нэвтрүүлэхийг их боддог байлаа.

Гэхдээ ганц ЗХУ-аас туршлага судлаад байсан ч юм биш. Ер нь тэр үеийн социалист орнуудтай их өргөн харилцаж байв. Намайг нэг удаа Болгарын ХААЯ-ны сайд Болгарт ирж амрахыг урьсан юм. Тэнд очоод би Хар тэнгисийн эрэг дээр сайхан амарлаа. Намайг урьсан Болгарын ХААЯ-ны сайдыг Иван Примов гэдэг байв. Тэр надад нэг машин гаргаж өглөө. Ингээд би амарч байх хугацаандаа Болгарын ХАА-н зарим ажилтай танилцлаа. Би наран ургах зүгээс гараад наран шингэх зүгт Болгарын бүх нутгаар нь явлаа. Болгарын бүх нутаг нь манай Говь-Алтай аймагтай ойролцоо юм шүү дээ. Болгар бол ХАА их сайн хөгжсөн орон шүү дээ. Намайг явахын өмнө Иван Примов гуай хүлээн авч уулзлаа.

Тэр :

-Танд ямар хүсэлт байна? гэж асуув.

-Бид танай туршлагаар Монголд гахайны аж ахуй хөгжүүлэх сонирхолтой байна! Та энэ талаар бидэнд туслаач! гэж хэллээ.

-Болно шүү! Бидний зүгээс ямар ч асуудал байхгүй! Та нутагтаа очоод гахайны ямар аж ахуй байгуулахыг сонирхож байгаа талаараа бидэнд төслөө ирүүлээрэй! хэлсэн юм. Ингээд би Улаанбаатарт ирсний дараа энэ асуудлаар өөрийн мэргэжилтнүүдтэй ярилцлаа. Гахайны аж ахуй байгуулахад хамгийн чухал зүйл бол тэжээлийн асуудал байдаг юм. Ингээд Улаанбаатар хотын Гурилын комбинатын ойролцоо гахайныхаа

аж ахуйг байгуулахаар боллоо. Бид нар хийсэн төслөө Болгар руу явууллаа. Манай мэргэжилтнүүд очоод 1000 гахай авахаар тохироод ирлээ. Ингээд гахай ч ирлээ. Улаанбаатар хотын Гурилын комбинатын орчимд гахайны аж ахуй байгуулсан нь маш зөв болжээ. Манай гахайнууд маш хурдан өслөө. Ер нь гахай их хурдан өсдөг амьтан шүү дээ. Удалгүй манайх 10 мянган гахайтай болов. Энэ ажил ийнхүү их амжилттай боллоо.

Би энэ хооронд Хятадад нилээд хэдэн удаа очсон юм. Хятадын газар тариалангийн салбарт их сонин өвөрмөц арга туршлага байхыг харсан юм. ЗХУ-д бол томоохон гол, мөрний усыг тариалангийн талбай услахад их ашигладаг юм. Гэхдээ заавал шуудуу ухаж, суваг барьж усыг нь урсуулаад тариалангийн талбайгаа усалдаг байлаа. Хятадад үүнээс өөр арга хэрэглэж байхыг харлаа. Хятадууд Хөх мөрөн, Шар мөрний усыг олсонд шингээгээд, их хэмжээгээр татаж авч байхыг үзлээ. Маш нарийн арга бодож олсон байгаа юм. Манай монголчууд “Орос хүн оюунтай, Ази хүн аргатай!” гэж ярьдаг шүү дээ.

Бас жорлонгийн бохир зүйлийг исгээд, хийн түлш /газ/ гаргаж авч байхыг үзлээ. Миний очсон өмнөд нутгийн Гуанжоу мужийн айл бүр ийм хийн түлш хэрэглэж байхыг үзлээ. Ийм хийн түлш надад маш сонин санагдаж билээ. Тэгээд энэ технологийг Монголд нэвтрүүлэх хүсэл төрөөд байлаа. Монголд буцахынхаа өмнө Бээжинд Бүх Хятадын Түлш, эрчим хүчний яаманд би очлоо. Тэгээд энэ төхөөрөмжийнхээ зургийг өгөөч гэсэн хүсэлт тавилаа. Тэнд миний хүсэлтийг шууд хүлээн аваад, хавтсанд хийсэн олон зураг өгсөн юм. Би Монголд иргэж ирээд, түүнийг Хятад хэлнээс орчуулуулах ажлыг эхлүүлээ. Ингээд Монголын энэ чиглэллийн бүх мэргэжилтнүүдийг цуглууллаа. Тэдэнд орчуулсан зураг төслөө танилцуулаад, яаж энэ төхөөрөмжийг барих талаар саналыг нь сонслоо. Олон хүн олон санал хэлсэн юм. Тэднээс гарсан саналыг үндэслээд Амгалангийн САА-д барихаар шийдлээ. Тэгээд л ажлын хэсэг томилоод л барих ажилдаа шууд л орчихлоо. Төхөөрөмж ч удалгүй баригдлаа. Түүнийг ажилууллаа. Айлууд хийн түлш хэрэглэж эхэллээ. Зуны дулаан улирал байсан болохоор манайханы барьсан төхөөрөмж сайн ажиллаж байлаа. Ингээд зун ч дууслаа. Дулааны эрч буураад ирлээ. Төхөөрөмжийн ажиллагаанд хүндрэл үүсэж эхэллээ. Агаарын температура хасах болсон нөхцөлд манай төхөөрөмж ажиллах боломжгүй юм л даа. Ингээд 10-р сарын сүүлчээр бид төхөөрөмжөө аргагүйн эрхэнд зогсоож байсан юм. Одоо САА-нуудыг удирдах газрын архивт энэ материал байх ёстой юм шүү.

16 Бидний зөв.

Ц Л: Намайг ажиллаж байх хугацаанд улсын хэмжээгээр их хэмжээний ургацыг хадгалалт муугаас болж муутгаж, ашиглах боломжгүй болгож байсан тохиолдол байхгүй. Зарим нэг САА-д ургац хураах хугацааг алдаж тогтоосноос ургац алдах, үрийн дутагдал гаргах тохиолдлууд гарч байсан юм. Гэвч САА-нуудын нэг хэсэг нь ургац алдахад, нөгөө хэсэг нь нөхөж чаддаг байсан юм. Манай нэг онцлог бол нутаг дэвсгэр их өргөн уудам учир нутаг, нутгийн зун өөр болдог юм. Баруун аймгуудаар бороо багатай байхад зүүн аймгууд нь бороо элбэгтэй байх, өмнө зүгийн аймгуудад ган болж байхад хойд талын аймгуудаар бороо хуртай сайхан зун болж байх жишээтэй. Ингээд ургац нь харилцан адилгүй байна. Ургац алдсан нутгийн алдагдлыг ургац сайтай газрууд нь нөхөөд явчихна шүү дээ. 50-аад оны сүүлчээр МАХН-ын удирдлагад Л.Цэнд, Д.Төмөр-Очир зэрэг сайн удирдагчид ажиллаж байсан юм. Тэд нарын хүчинд энэ шинэ ажлыг амжилттай хэрэгжүүлж чадсан юм. Тэднийг бид нар их дэмжиж байсан юм.

Гэтэл Д.Төмөр-Очирыг эхлээд, дараа нь Л.Цэндийг “МАХН-ын эсрэг үйл ажиллагаа явууллаа!” гэж гүтгээд, ажлаас нь халж, хол газар цөллөгт явууллаа. Энэ үеэс эхлээд МАХН-ын ТХ, түүний УТТ-нд шинэлэг санаатай хүн эрс цөөрсөн юм. Танил тал харсан, зусар бялдууч, долигонуур хүмүүсийн тоо олширсон юм. Энэ явдал олон хүний дургүйцлийг төрүүлж эхэлсэн юм. Миний хийж байсан ажил дэмжигдэхээ байсан юм. САА-н ажил дээр би нилээд шинэ санаа оноонууд гаргаж хэрэгжүүлж байсан юм. Ялангуяа “Өндөр ашиг, орлого өгдөг шинэ, шинэ салбаруудыг байгуулах нь зүйтэй юм!” гэж бодож байсан юм. Ю.Цэдэнбалын урдур ороод ажилд садаа болоод байсан зусар, бялдууч хүмүүс олон болсон нь ажил хийх сонирхолыг маань бууруулсан юм.

Ингээд би 1962 оны намар тариа хураалтын ажил дуусаад Ю.Цэдэнбал дарга дээр орсон юм. Би ажлаасаа гарахаар шийдэж, энэ тухай түүнтэй ярихаар орсон юм. Энэ үед газар тариалангийн ажил үндсэндээ жигдэрсэн байсан. Шинээр хийх юм огт байхгүй болсон үе байлаа. Би түүнийг хэд хэдэн удаа МАХН-ын ТХ-ны бүгд хурал дээр шүүмжилсэн байсан. Тэр надад хөндий ханддаг, бид хоёрын хооронд бие биедээ үл итгэх байдал бий болсон байлаа. Ажлаасаа гарах миний хүсэлтэд тэр яаж хандахыг би мэдэж байсан юм. Тэр намайг өөрөөсөө холдуулах шалтгаан хайж байгааг би мэдэж байсан. Тийм учраас миний хэлснийг тэр шууд зөвшөөрнө гэж би бодож байсан юм.Тэр:

-Чи тэгээд сургуульд явах юм уу? гэж надаас асуусан.

Би ийм асуулт гарч ирнэ гэж бодож байсан болохоор “Тийм!” гэж

хариулсан юм. Ю.Цэдэнбал цаашид хамтарч ажиллахгүй хүнээ сургуульд явуулах, хөдөө газар өөр ажилд томилох, бас холын оронд элчин сайдаар томилох зэргээр өөрөөсөө аль болохоор холдуулдаг байсан юм. Би уг нь “Нийгмийн ухааны академид суралцаж болох юм!” гэж дотроо бодож явсан юм. “Говь-Алтай аймгийн МАХН-ын хороонд 2 жил, САА-нуудыг удирдах газар зургаан жил нийтдээ бараг 8 жил аж ахуйн ажил хийлээ. Одоо нийгмийн ухаанаар өөрийгөө жаахан ч гэсэн цэнэглэх болсон!” гэж бодож явсан юм.

Гэтэл тэр шууд:

-Чи САА-д олон жил ажиллаа! Тэгэхээр үүнийгээ цаашид боловсронгуй болгох хэрэгтэй! Чи Темерязовын нэрэмжит Хөдөө аж ахуй академид явж судалгааны ажил хийх хэрэгтэй! гэж тэр хэлсэн юм. Ингэж би эрдэм шинжилгээний ажил хийхээр болсон юм. Түүний ийм шийдвэрт бас л намайг нийгмийн ухааны ажлаас маань хөндийрүүлэх зорилго агуулагдаж байсан юм. Ингээд би Темерязовын нэрэмжит ХАА-н академид очоод, удирдлагын ухаанаар судалгааны ажил хийж эхэлсэн юм. Миний эрдэм шинжилгээний ажлыг Сергей Лазо гэдэг профессор удирдсан гэж ярьсан шүү дээ. Тэр үед Герман, Франци хэлнээс орчуулагдсан ном их уншиж, ашиглалаа.

Темерязовын нэрэмжит ХАА-н академи их том номын сантай байсан юм. Тэнд би дандаа суудаг байлаа. Тэнд сууж ХАА-н зохион байгуулалт, улс ардын аж ахуйн удирдлагын арга барилын талаар ном уншдаг байлаа. Би урд нь өөрөө аж ахуйн ажил олон жил удирдсан болохоор энэ судалгааны ажил надад төвөгтэй биш байсан юм. САА-нуудын жишээн дээр Монголын ХАА-н ашиг, орлогыг нь нэмэгдүүлж, товарын үйлдвэрлэлийг өсгөх арга замын тухай сэдвээр диссертац бичиж эхэлсэн юм. Би судалгааны ажлын диссертацаа нэг жил гаруйн дотор бэлэн болгочихсон байсан. Ингээд арай хамгаалаагүй байтал МАХН-ын ТХ-ны 6-р Бүгд хурал хуралдсан юм.

Энэ хурал дээр Ю.Цэдэнбалыг шүүмжилснээс болоод би “намаас арга хэмжээ авхуулаад”, эрдмийн ажлынхаа диссертацийг хамгаалж, дипломоо авч чадаагүй юм. Тэр үед Москвад суралцаж байсан хүмүүсийн дотор МАХН-ын ТХ-ны удирдлагыг шүүмжилсэн, тэдний ажиллах арга барилыг голсон уур амьсгал их байсан юм. МАХН-ын удирдлага үнэхээр их хоцрогдсон байлаа. Шинэ юм саначилдаггүй, шинэ юм хийх хүсэлтэй байгаа, эрч хүчтэй залуу хүмүүсийг дэмждэггүй, ад үзэж, “Дэмий юм чалчиж байна!” гээд хавчин гадуурхдаг болсон байлаа. Манай хөгжил үнэхээр удаан явж байсан юм. Улс орны ирээдүй туйлын бүрхэг байлаа. Бүх ажил урсгалаар, ирээдүй рүүгээ хандсан ямар ч төлөвлөлтгүй, өдөр хоногийг арай хийж өнгөрөөсөн байдалтай явж байлаа. Ард түмний

амьдрал муу байсан юм. Бид нар улс орныхоо байдлын талаар хоорондоо байнга ярьдаг байлаа. Удирдлагын арга барил нийгэм, эдийн засгийн шаардалагаас хоцорсон байлаа.

Тэр үед Б.Нямбуу Коммунист намын дээд сургуульд сурч байсан юм. Бид хоёр долоо хоног бүр уулздаг байлаа. Тэр үед Москвад сурч байсан хүмүүсийн дотор бид хоёр л МАХН-ын ТХ-ны гишүүн байсан юм. Бид нар шатар их тоглодог байлаа. Шатар тоглож байхдаа улс орондоо болж байгаа үйл явдлууд, улс орныхоо хөгжлийн талаар байнга ярьдаг байлаа. Бид нар “Манай ажил муу байгаагийн хамаг буруу нь Ю.Цэдэнбалд байна. Дээд хүний ажлын арга, барил доод хүмүүст муу үлгэр болж байна! Энэ байдлыг засаж, залруулахгүй бол болохгүй байна! Манай ажлыг Ю.Цэдэнбалын ажлыг сайжруулахаас эхлэх хэрэгтэй!” гэж ярьдаг байлаа. “Булгийн ус ундарга нь цэвэр бол урсах ус нь цэвэр байна!” гэсэн ардын зүйр үг байдаг юм. Бүгд хурал эхлэхийн өмнө би шалгалтаа өгөөд дууссан байлаа. Улаанбаатар явахын өмнө Темерязовын нэрэмжит ХАА-н академийн захиргаанд орж, МАХН-ын ТХ-ны бүгд хуралд оролцохоор нутаг буцах болсон тухайгаа хэлж, чөлөө авсан юм. Улаанбаатарт ирээд Бүгд хурал дээр хэлэх үгээ бэлтгэлээ. Би хэлэх үгэндээ эдийн засгийн өсөлт, сааралтыг харуулсан банк, санхүүгийн мэдээнүүдийг ашигласан юм. Энэ бүгдийг тэнд ажилладаг таньдаг хүмүүсээс авсан. Москвад аспирантурт сурч байсан Жамбаа, Тогтох гэдэг сайн эдийн засагчидтай танил байсан. Тэд нар тусалсан. Би тэднээс эдийн засгийн тоо баримтуудыг авсан.

Бүгд хурал хуралдахын өмнө бидний талаар МАХН-ын ТХ-ны УТТ-ны хурал дээр ярьсан юм билээ. “МАХН-ын ТХ-ны гишүүн Ц.Лоохууз, Б.Нямбуу нар шүүмжлэл тавихаар бэлтгэж байна. Бид үүнд яаж хандах вэ?” гээд ярилцсан юм билээ. УТТ-ны зарим гишүүд “Тэр хоёроор үг хэлүүлэхгүй!” гэсэн санал хэлсэн юм билээ. “МАХН-ын ТХ-ны Бүгд хурлын гишүүн хүн МАХН-ын ТХ-ны Бүгд хурал дээр үг хэлэх эрхтэй учир энэ эрхийг нь хязгаарлаж болохгүй!” гэж нэг хэсэг нь татгалзсан юм билээ. Тэгээд “Үг хэлэхийг зөвшөөрье! Харин тэднийг хариуд нь өөрсдийг нь шүүмжлье!” гэж тохирсон юм билээ. Д.Төмөр-очир, Л.Цэнд нарыг огцруулахдаа өөрсдөд нь хэлэхгүй байж байгаад, олон хүн тал талаас нь гэнэт шүүмжлээд, балмагдуулаад, огцруулдаг туршлагыг хэрэглэхээр шийдсэн байгаа юм.

Ингээд Бүгд хурлыг тусгай зохион байгуулалтанд оруулсан байгаа юм. Бид хоёрыг шүүмжлэл хэлэх гэж байгаа тухай мэдээ хот, хөдөөнөөс ирсэн МАХН-ын Бүгд хурлын гишүүдийн дунд тархсан байгаа юм. Биднийг олон хүн дэмжиж байсан юм. Нийгэм бүхэлдээ энэ Бүгд хурал яаж төгсөхийг хүлээсэн байдалд орсон юм. Хүмүүс радио хүлээн

авагчаа сонсож, хэвлэл дээр гарах мэдээг тэсэж ядан хүлээж байсан юм. Ю.Цэдэнбал болон түүнийг “тойрон хүрээлэгчид” хурлын уур амьсгалыг өөртөө ашигтайгаар эргүүлэх бүх бололцоогоо дайчлаж байсан юм. Биднийг дэмжиж байсан хүмүүст айх сэтгэгдлийг төрүүлж чадсан юм. Тэд нар үгээ хэлж чадалгүй аргагүй байдал орсон юм. Ю.Цэдэнбалыг дэмжигчдийн дотор ч цаагуураа биднийг дэмжиж байсан хүмүүс байсан юм. Гэвч үгээ хэлж бидэнтэй нийлж чадаагүй юм. Бид энэ бүхнийг сөрж дийлээгүй. Ингээд хурал дууссан. Бидний МАХН-ын гишүүний батлахыг хурааж, МАХН-ын ТХ-ны Бүгд хурлын гишүүнээс хөөлөө.

Миний МАХН-ын гишүүний батлахыг хурааж авахад нь би сүүлчийнхээ үгийг хэллээ. “Манай МАХН, түүнийг анх байгуулсан хүмүүсийн үзэл санаанаас ухарчээ. Манай МАХН яваандаа шинчлэгдэнэ. Д.Сүхбаатар, Х.Чойбалсангийн байгуулсан нам шиг болсон үед нь би МАХН-ын батлахыг эргүүлж авна. Одоо МАХН-ын архив, сейфэнд хадгалуулчихъя!” гэж хэлээд өглөө.

Үүнээс хойш миний “эсэргүү Лоохууз”-ын амьдрал эхэлсэн юм. 1920-1930 аад оны үед МАХН-ын удирдлагын явуулж байгаа бодлогыг шүүмжлэж, түүнтэй санал нийлээгүй хүмүүсийг “ангийн дайсан”, “хувьсгалын эсэргүү” гэж нэрлээд, баривчлаад, цаазлан устгаж байсан шүү дээ. Намайг бол үүнээс ч аюултай этгээд, одоо юу гэдэг юм бэ? “эсэргүүгийн цаад талын эсэргүү” ч гэдэг юм уу? нэрлэж байсан юм. Нийгэмд тийм ойлголт төрүүлэхийн тулд бүх бололцоогоо дайчлан ажиллаж эхэлсэн юм. Би энэ нэрнээсээ 25 жилийн дараа л салсан юм.

И Л: Ц.Лоохууз, Б.Нямбуу, Б.Сурмаажав нарын Намын эсрэг бүлэглэсэн явуулгын талаар гарсан МАХН-ын ТХ-ны 6-р Бүгд хурлын тогтоолд “...МАХН-ын Төв Хорооны тус бүгд хурал дээр намын эсрэг дээр дурьдсан этгээдүүд, намын жанжин шугамыг эсэргүүцэн гарч ирэв!... Манай нам социализмын ялалтын төлөө ард түмнийг жолоодох чадваргүй жижиг хөрөнгөтний нам болон хувирсан мэтээр ор үндэсгүй зүйл ярив!” гэж тэмдэглэсэн байна. Та энэ дүгнэлтийн талаар тайлбар хэлж өгнө үү?

Ц Л: Тэр үед МАХН үнэхээр удирдах чадвараа алдсан байсан гэж би боддог юм. Онолын сэтгэлгээ байхгүй, дээр нь ард түмний хүсэн хүлээж байсан аж ахуй үйл ажиллагааг зөв удирдан чиглүүлж чадахгүй байсан нь үүнийг яруу тодоор гэрчлэж байгаа юм. Шинэ сэтгэлгээтэй, эрүүл саруул бодолтой намын гишүүдээ түшихгүй, зусар бялдууч хүмүүсээ түшвэл нам ямар байдалд орох вэ? Энэ чинь нам удирдах чадваргүй болсныг харуулж байгаа юм. Энэ чинь нам зорилгоосоо ухарч байгаагийн шинж шүү дээ. Ийм илэрхий баримт байсан учир бид нар энэ үгийг зоригтой хэлж байсан

юм.

Бүгд хурал дээр би нэр зааж МАХН-ын жанжин шугамыг шүүмжлээгүй юм. Харин миний хэлсэн үгэнд намын жанжин шугамын үзэл санаатай таарахгүй үг, өгүүлбэр олон байсан байж болох юм. Намын жанжин шугамыг хэрэгжүүлж ирсэн 40 жилд ард түмний магнай тэнийх юу хийсэн бэ? Ямар үйл явдал болсон бэ? гэсэн асуулт зүй ёсоор гарч ирэх байх. Харин зовсон зүдэрсэн нь бол тоолж барахгүй олон байсан гэж хэлж болох байх. Байдал ийм байхад дахиад диктатураа чангалах тухай яриа байж болох уу? Ю.Цэдэнбал бол “Диктатур суларснаас болоод бидний ажил муу байна!” гээд байсан юм. Диктатурыг чангалж ерөөсөө болохгүй! Гэтэл ингэж хэлсний төлөө, ертөнцийн хамаг болохгүй, бүтэхгүй бүхнийг цуглуулаад, бүгдийг нь надад хамааруулж муу хэлээд, нутаг зааж цөлөөд, одоо баримтлахаа больсон хуучин хуулиар шийтгэл оногдуулаад, шоронд суулгаад, бүх насаар хавчин гадуурхах болсон юм шүү дээ.

И Л: Бүгд хурал дээр шууд Ю.Цэдэнбал гуайг шүүмжилсэн хүн хэд байсан юм бэ? Та хоёроос өөр хүн шүүмжлэл хэлсэн юм уу?

Ц Л: Бүгд хурал дээр шууд Ю.Цэдэнбалд хандсан шүүмжлэлийг Б.Нямбуу бид хоёр л хэлсэн юм. Өөр түүнд шууд хандсан шүүмжлэл хэлсэн хүн байгаагүй юм. Бүгд хурлын тогтоол “Ц. Лоохууз, Б.Нямбуу, Б.Сурмаажав нараас намын эсрэг бүлэглэсэн явуулга хийсэн тухай” гэсэн нэртэй гарсан юм. МАХН-ын дүрмээр бол Бүгд хурлаас гаргах тогтоолын төслийг Бүгд хурлын гишүүд хэлэлцээд, санал хураалт явуулж, олонхийн саналаар батлах ёстой юм. Гэтэл тэр Бүгд хурал дээр бидний талаар ямарч тогтоолын төсөл бүгд хурлын гишүүд хэлэлцээгүй, санал хураалт явуулаагүй, ямар ч тогтоол батлаагүй юм.

Харин хэд хоногийн дараа “Бүгд хурлын гишүүд санал нэгтэй батлав!” гэсэн үгтэй тогтоол хэвлэл дээр гарсан юм. МАХН-ын дүрмээр бол энэ нь хүчин төгөлдөр тогтоол биш юм шүү дээ. Энэ тогтоолд “бүлэглэсэн” гэдэг үгийг сонгож авсан байгаа юм. Үнэхээр намын эсрэг бүлэг байсан уу? Үгүй юу? гэсэн асуулт байдаг юм. Тийм ”бүлэг” байгаагүй юм. Бид нар “бүлэг” байгуулж зохион байгуулалтанд ороогүй юм шүү дээ. Шүүмжлэл хэлсэн биднийг “Намын эсрэг бүлэглэсэн явуулга хийсэн” гэж тодорхойлсон нь биднийг их хүчтэй бүлэглэл болгож харагдуулах зорилгоор хийсэн тодорхойлолт юм. Өөрөө хэлбэл “Улс оронд их аюултай, хүчтэй бүлэглэл ажиллаж байсан, тэр бүлэглэлийн хортой үйл ажиллагааг илрүүлж, үйл ажиллагааг нь таслан зогсоолоо!” гэсэн ойлголт төрүүлэх зорилгыг агуулж байсан юм.

Аюултай, хүчтэй бүлэглэлийг илрүүлж, улс орноо аварсан хүмүүс

чинь өөрсдөө их хүчтэй, их сайн хүмүүс байна биз дээ? Уг нь хоёр хүний үйлдлийг “бүлэглэл, бүлэг” гэж нэрлэдэггүй юм. Бүлгийг 3 ба түүнээс дээш хүнээр байгуулж болдог юм. Олон улсад тогтосон ийм жишиг байдаг байх. Ингээд “Их аюултай, хүчтэй бүлэглэлийг илрүүлж, дарлаа!” гэж харагдуулах гэтэл бид нар хоёулхнаа байж байдаг. Тэгээд тэр тогтоолыг төлөвлөгчид хүнд байдалд орсон байх. Ингээд энэ байдлаас гарах гарц хайгаа биз. Ингээд бид хоёр дээр Б.Сурмаажавыг нэмээд 3 хүн болгосон юм. Гурван хүний үйлдлийг бол “бүлэглэл, бүлэг” гэж тодорхойлж болно шүү дээ. Б.Нямбуу бол Б.Сурмаажавын авгайн нагац ах нь юм. Тийм учраас түүнийг “үзэл санаа нэгтэй” гэж бид хоёртой нэг бүлэгт оруулахад амархан байсан.

Б.Сурмаажавыг гүтгэх бас өөр нэг шалтгааныг тэр олсон юм. Ю.Цэдэнбал ЗХУ-д төр, засаг өөрчлөгдөхөд хамгийн түрүүнд очиж шинэ удирдлагуудтай нь уулздаг байсан юм. Энэ бол уламжлал болсон зүйл байсан юм. Тэр үед “ордны хуйвалдаан”-аар Н.С.Хрущёвыг ЗХУКН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга, Сайд нарын Зөвлөлийн даргын ажлаас нь огцруулж, хуучны талыг бримтлагч Л.И.Брежнев ЗХУКН-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар сонгогдсон юм. Ю.Цэдэнбал Л.И.Брежневтэй очиж уулзсан юм. Буцаж ирээд манай засгийн газрын гишүүдэд энэ уулзалтынхаа талаар ярьсан юм. Ю.Цэдэнбал тэр хоёрын уулзалт дээр, Л.И.Брежнев “...ЗХУ цаашид аж үйлдвэрээ үлэмж хөгжүүлнэ. Бид Монголд хэрэгтэй аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг бүгдийг нь нийлүүлж байх болно. Иймд Монголчууд өөрсдөө аж үйлдвэр, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх шаардлага байхгүй. Харин мал аж ахуйгаа хөгжүүлэх хэрэгтэй. Малыг чинь бид хуучнаараа гадаад худалдааны шугамаар авч байна!” гэсэн утгатай зүйл ярьсан юм байж. Үүний дараа Л.И.Брежневийн ийм бодлогод зохицуулж Ю.Цэдэнбалын зүгээс МАХН-ын баримтлах бодлогод өөрчлөлт оруулж эхэлсэн юм. Тэр үед МАХН-ын ТХ-ны Аж үйлдвэрийн хэлтсийн даргаар Б.Сурмаажав ажиллаж байсан юм. Ю.Цэдэнбал энэ үеэс эхлээд Б.Сурмаажавын ажлыг дэмжихээ бүр зогсоосон юм. Б.Сурмаажав бол ашиг, орлого сайтай, зардал багатай, Монголын нөхцөлд тохирсон жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх талаар маш их санаачлагатай ажиллаж байсан хүн. Ялангуяа малын гаралтай түүхий эдийг боловсруулах чиглэлээр их ажил хийж байсан юм. Ю.Цэдэнбал түүнийг МАХН-ын ТХ-ын Аж үйлдвэрийн хэлтсийн даргын ажлаас удалгүй халсан юм. Хожим түүнийг Үндэсний Статистикийн газрын даргаар томилсон юм. Б.Сурмаажав 1964 оны 6-р бүгд хурал дээр үг хэлсэн юм. Түүний хэлсэн үгийн гол санаа нь “МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, Сайд нарын Зөвлөлийн даргын албан тушаалыг Ю.Цэдэнбал ганцаараа давхар гүйцэтгэж байгаа нь буруу байна. Энэ

хоёр албан тушаалыг тус бүрийг нь өөр өөр хүн хаших ёстой. Ийм чухал хариуцлагатай, хоёр албан тушаалыг нэг хүн хавсарч хийснээр ажил их хохирч байна!” гэсэн утгатай шүүмжлэл хэлсэн юм. Ю.Цэдэнбал үүнд маш дургүйцсэн юм. Ингээд түүнийг бидэнтэй нэг “бүлэг” болгохоор шийдсэн байх. Б.Нямбуу бид хоёр бол ямар ч “бүлэглэл, бүлэг” биш зүгээр л гадаадад сурдаг оюутнууд байсан юм шүү дээ. Энэ бол муухан бодож олсон зохиомол хэрэг байсан юм шүү дээ.

КЮ: 1920-1930-аад оны үед бол МАХН-ын бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэхээс татгалзаж, түүнийг шүүмжилсэн хүн шууд баривчлагдаж, цаазлуулж байсан шүү дээ. Та нарт ч гэсэн ийм юм тохиолдож болох байсан уу? Ийм зориг гаргаж, эрсдэлд орох зайлшгүй шалтгаан байсан уу?

Ц Л: 1930-аад оны үед бол МАХН-ын баримтлаж байгаа бодлого, түүний гаргасан шийдвэрийг эсэргүүцэх, түүнийг шүүмжлэх, ямар нэгэн байдлаар санал нийлэхгүй байх зэрэг тохиолдолд баригдах нь гарцаагүй байсан юм. Цаазлагдах нь ч гарцаагүй байлаа шүү дээ! Биднийг шүүмжлэлээ хэлж байхад арай өөр үе эхэлсэн байлаа шүү дээ. МАХН-ын Их хурлуудаар “Нэг хүнийг тахин шүтэх явдал”-ын хор уршгийг хатуу шүүмжлэж, улс төрийн хилс хэргээр цаазлуулсан хүмүүсийг цагаатгаад эхэлсэн байлаа шүү дээ. “Баригдана!” гэдэг ойлголт бол хол сонсогдож байсан юм. Гэхдээ бидэнд тийм юм болж магадгүй гэсэн болгоомжлол бол байсан юм шүү. Ер нь биднийг баривчлах тухай асуудал Дотоод яаманд яригдаж байсан юм билээ. Гэтэл тэр үеийн хуулийн байгууллагуудын зарим нэг удирдлага “Эдгээр хүмүүсийг баривчлах хуулийн заалт байхгүй!” гээд татгалзсан юм билээ. Бид нар манайд тухайн үед мөрдөж байсан ямар ч хуулийг зөрчөөгүй юм шүү дээ. МАХН-ын ТХ-ны Бүгд хурлын гишүүн хүн, МАХН-ын бүгд хурал дээр үг хэлж шүүмжлэл хэлэх дүрмийн заалт байдаг юм. Энэ бол МАХН-ын гишүүний дүрмээр зөвшөөрөгдсөн асуудал юм.

Харин бид хоёрыг шүүмжлэлээ хэлснээс хойш төр, засгийн хариуцлагатай албан тушаалд томилогүй, “намын сахилга бат алдсан” гэх мэтийн тайлбар хийгээд, албан тушаал бууруулж, өөр ажилд томилох байх гэсэн бодол байсан юм. “МАХН болон улс оронд аюултай Ю.Цэдэнбалын муу дутагдлууд, алдаатай бодлогуудын талаар намын хамт олонд хэлэхгүй байж болохгүй. Заавал хэлж, засаж залруулах ёстой! Ингэж шүүмжилсний төлөө биднийг МАХН-аас хөөх байх. Хөөгдсөн ч яахав! Ийм ноцтой дутагдлуудыг хэлж, шүүмжилчихээд, Налайхын уурхайд очиж ажил хийхэд болохгүй юм алга!” гэж бид хоёр ярьдаг байсан юм. Нас 41, 42 л хүрч байлаа. Залуухан ч байж, халуухан ч байж дээ. Тэр үед “намаас арга хэмжээ авхуулсан” хүнийг Налайхын уурхайд уурхайчингаар

томилж, албан тушаалыг нь бууруулдаг байсан юм. “Биднийг ч бас ингэж л шийтгэх байх!” гэж бодож байсан юм. Гэтэл санаснаас шал өөр шийтгэл болж хувирсан юм. Биднийг цөллөгөнд явуулахаар шийдсэн байлаа. Яагаад цөллөгт явуулж байгаа талаар ямар ч тайлбар хийсэнгүй. Тэр цөллөг нь хугацаагүй, насаараа хавчигдаж, гадуурхагдах тийм цөллөг болж хувирсан юм.

17 “Эсэргүү Лоохууз”.

И Л: Бүгд хурлын дараа та нарын асуудлыг МАХН-ын ТХ-ны Хянан Шалгах Хороо шийдсэн үү?

Ц Л: Тэгсэн. МАХН-ын ТХ-ны Хянан Шалгах Хорооны даргаар тэр үед С.Лувсанравдан ажиллаж байсан юм. Тэр хүн биднээс ямар нэгэн гэмт хэргийн ул, мөрийг олох гэж тун ч их хичээсэн юм даа. “Ямар, ямар ажил хийхээр төлөвлөж байсан, хаана, хэнтэй, хэзээ уулзаж, юу ярьж байсан бэ!” “МАХН-ын удирдлагыг өөрчилснийхөө дараа хэн хэнийг ямар албан тушаалд томилохоор бэлтгэж байсан бэ?” гээд л байцаадаг байлаа. Хийгээгүй юмыг хийсэн болгож тулгахын тулд есөн шидийн юм асууж, байцаадаг байлаа. Биднийг МАХН-ын ТХ-ны Хянан Шалгах Хороон дээр сар шахуу байцаалаа. Тэд нар юу ч олоогүй юм. Ингээд байцаалт дууслаа. Биднийг “нутаг зааж суулгах” шийдвэр гарлаа.

Монгол орон өргөн уудам болохоор биднийг хоорондоо уулзаж чадахгүй хол, хол нутгуудыг сонгож авсан байлаа. Намайг Өвөрхангай аймгийн говийн бүсэд байдаг Сант суманд хоньчиноор, Б.Нямбууг Дорнод аймгийн Эрэнцавын САА-д үхэрчингээр томиллоо. Б.Сурмаажавт арай зөөлөн хандаж байсан байх. Түүнийг Бэрхийн уурхайд тоо бүртгэгчээр томилсон юм. МАХН-ын ТХ-ны Хянан Шалгах Хороо ийм шийдвэр гаргалаа.

Бид нар энэ шийдвэрийг нь эсэргүүцлээ. “Бид нар МАХН-ын гишүүнээс хөөгдсөн учир МАХН-ын шийдвэр бидэнд хамаагүй. Бид хаана амьдрах, юу хийхээ Монгол улсын иргэний хувьд өөрсдөө шийднэ!” гэж хэллээ. Тэд нар биднийг МАХН-ын гишүүнээс хөөх ажлаа яаравчилж хийсэн нь том алдаа болсныг ойлгож эхэлсэн байх. Тэгээд удалгүй Сайд нарын Зөвлөлийн тогтоол гарлаа. Сайд нарын Зөвлөлийн тогтоол бол бидэнд хамаатай шүү дээ. Ингээд бид явах нь гарцаагүй боллоо. Тэгээд явахынхаа өмнө ХШХ-ны дарга С.Лувсанравдангийн өрөөнд орцгоолоо. “Бид нар явлаа. Биднийг ямар хугацаатай явуулж байгаа юм бэ?” гэж асуулаа. Тэр “Ямарч байсан 3 жил явна шүү. 3 жил болоод бид нар энэ удаагийн шийдвэрээ дахин хянаж үзэж болох юм!” гэж хэлсэн юм. Бид

нар “Хөдөө 3 жил ажиллаад, ямар нэг өөрчлөлт орох юм байна!” гэсэн ойлголтой болоод явсан юм.

Биднийг явах үед өвлийн 1-р сар болж байлаа. Нэг сар гэдэг бол Монголын хамгийн хүйтэн үе шүү дээ. Монголын хамгийн хүйтэн үе наян нэг хоног үргэлжилдэг юм. Түүнийг монголчууд ес, ес хоногоор нь хувааж нэрлэдэг юм. Хамгийн хүйтэн үе нь эхний гурван есөн хоног байдаг юм. Түүнийг “Идэр гурван ес” гэж нэрлэдэг юм. 1-р сар бол яг “Идэр гурван ес” явж байгаа үе юм. Ийм үед хүйтний эрч “Гунан шарын эврийг хуга хөлдөөнө!” гэж манайхан ярьдаг юм. Ийм үед хөдөөний малчид нүүдэггүй юм. Монголын бүх нутаг зузаан цасанд дарагдсан, өдөр бүр цасан шуурга тавьсан үе шүү дээ.

Намайг Өвөрхангай аймгийн Сант суманд хүргэж өгөх асуудлыг ХААЯ-нд даалгасан юм. ХААЯ нэг ачааны машин бэлэн болголоо. Тэр үед манай хоёр хүүхдийн нэг нь 8 настай, нэг нь хоёр настай байсан юм. Надтай хамт миний эгч, миний хойд ээж хамт явахаар боллоо. Тэр хоёр хоёулаа 70 гарсан настай байлаа. Ийм бүрэлдэхүүнтэй, ийм үед хөдөө нүүхээр боллоо. Улаанбаатар хотод манайх 3 өрөө байранд амьдарч байсан юм. Би их номтой байлаа. Тэр номыг Улаанбаатарт орхиод явах ямар ч боломж байсангүй. Гэтэл манайхыг тэр байрнаас “Яаралтай гар!” гээд бас хөөлөө. Тэр үед орон сууц бүгд улсын өмч байсан юм. Хувийн орон сууц байгаагүй юм. МАХН-ын ТХ-ны Хянан шалгах Хороо орон сууцаар биднийг бас дарамтлаж эхэллээ. Ер нь энэ үеэс эхлээд бид нар МАХН болон төр, засгийн байнгын дарамтанд орсон юм.

Биднийг манай Дотоод яам маш хатуу хяналтандаа авсан юм. “эсэргүү Лоохууз” хаана, юу хийж байна? Хэнтэй, хэзээ, ямар зорилгоор уулзав? Хэнд юу гэж хэлэв? гэдгийг цаг тухайд нь Дотоод яамны шугамаар ХШХ-нд очоод, тэндээс Ю.Цэдэнбалд мэдээлж байсан юм. Бүгд хурлын ажиллагаа дууссан тэр үеэс эхлээд бүх орон даяар хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр Ц.Лоохууз, Б.Нямбуу, Б.Сурмаажав нарын “намын эсрэг бүлэглэсэн явуулга”-ын тухай, улс оронд ямар аюултай, хортой үйл ажиллагаа явуулж байсан талаар мэдээлж байсан юм. “эсэргүү Лоохууз” хэзээ, хэнтэй, хаана уулзаж, МАХН-ын удирдлагыг хэрхэн өөрчлөж, ямар хүмүүсийг ямар албан тушаалд томилохоор яаж бэлтгэж байсан талаар минут тутамд мэдээлж байлаа.

Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр цацагдаж байсан тэр зүйлүүдэд нэг ч үнэн юм байгаагүй юм. “Намын эсрэг бүлгийн удирдагч Лоохууз бол хятадын эрлийз! Түүний эцэг бол Хятадын Шинжан-Уйгурын нутгаас Монголд орж ирсэн хятад хүн байсан!” гээд л ярьж байлаа шүү дээ. Бүгд худлаа. Гэхдээ итгэдэг хүн байсан байх. Арай л “Лоохууз Японы тагнуул!” гэж хэлээгүй байх. 30-аад оны үед бол “Японы тагнуул” гээд гүтгэчихнэ

шүү дээ. Манай улсын хоёр Ерөнхий сайдыг Японы тагнуул гэж гүтгээд, цаазалсан түүх хуучраагүй байлаа шүү дээ. Тэгж гүтгэсэн хүмүүс нь, тэдний ажиллаж байсан Дотоод яам нь урьдынхаараа байж л байсан үе юм л даа.

Манайх улсын орон сууцыг хурдан чөлөөж өгөхийн тулд хөдөө нүүх ажлаа түргэвчлэх хэрэгтэй боллоо. Хөдөө очоод амьдрах нэг гэр би хүнээс гуйж авлаа. Бүрээс дулаалга муутай гэр байсан даа. Тэгээд хөдөө өмсөх өвлийн хувцас бас бэлтгэх хэрэг боллоо. Тэр үед монгол гэр, монгол дээл зардаг дэлгүүр Улаанбаатар хотод байгаагүй юм шүү дээ. Ийм ажил хийвэл шоронд хийчихнэ шүү дээ. Хүмүүс зөвхөн өөртөө хэрэгтэй зүйлүүдийг л өөрсдөө хийж хэрэглэдэг байв. Илүү гарах юм ердөө байхгүй. Ийм учир улсын дэлгүүрт өвлийн монгол дээл, хувцас зардаггүй байлаа шүү дээ. Хотод өвөл өмсдөг европ маягийн хувцастайгаа хөдөө явж болохгүй. Хөдөө нутагт европ хувцас огт тохирдоггүй юм. Тэнд монгол хувцас л хамгийн тохиромжтой байдаг юм. Би Хөдөө аж ахуйн системд ажиллаж байсан болохоор танил тал олонтой байсан юм. Миний танил хүн бүр дулаан хувцас хунараар тусаллаа. Тэр үед Амгаланд ХАА-н техник хангамжийн бааз байсан юм. Тэр баазын дарга С.Чулууныг би сайн таньдаг байсан юм. Тэр хүн ХААЯ-ны коллегийн гишүүн байсан юм. Тэр хүн намайг Өвөрхангай аймгийн Сант суманд хүргэж өгөхөөр болсон юм. Бас миний зээ дүү намайг хүргэж өгөхөөр болсон юм. ХААЯ-наас өгсөн ачааны машин дээр гэр орныхоо эд хогшлыг ачлаа. Зээ дүү маань ачааны машиндаа суугаад явахаар боллоо. С.Чулуун өөрийн хэрэглэдэг албаны УАЗ-469 машинаар намайг хүргэж өгөхөөр боллоо. Шөнийн 3 цагийн үед С.Чулуун манай гадаа нууцаар ирлээ. Би тэр машинд эхнэр хүүхдүүд, нөгөө хоёр хөгшнөө суулгаад нууцаар хөдөлж байлаа. Өвөрхангай аймгийн дарга нь миний хуучин таньдаг хүн байсан юм. Би Улаанбаатараас гарахын өмнө түүнтэй утсаар ярьсан юм. Тэр “Чиний тухай сонсож байна! Хүрээд ир! Говийн бүсэд яаж явуулахыг би мэдье!” гэж хэлсэн юм. Тэр надад үнэхээр тусалсан юм. Тэгээд нутаг заагдсан Сант сумандаа ирлээ. Сант сумаас цааш Богд сум, Төгрөг сум гээд говийн бүсийн сумдууд байдаг юм. Манай эхнэр эрүүл мэндийн салбарын хүн болохоор Улаанбаатараас гарахдаа Эрүүл мэндийн яамнаас “Өвөрхангай аймгийн нэгдсэн эмнэлэгт ажиллаж болно!” гэсэн бичиг авсан юм. Түүнийгээ үзүүлээд “Аймгийн эрүүл мэндийн газраас нэг бичиг авлаа. Эхнэр сумын төв дээр ажиллах зөвшөөрөлтэй тул гэрээ сумын төвд буулгахаар шийдлээ. Гэтэл аймгийн төвөөс, Дотоод яамны хэлтсээс утас ирж, “Гэрээ сумын төв дээр барьж болохгүй! Заавал мал хариулах газраа барь!” гэж шаардлаа. Ингээд хөдөө явахаар боллоо.

Гэтэл хүүхдийн сургууль тасрах асуудал гарч ирэв. Энэ суманд

сургуулийн дотуур байр байхгүй юм байж. Хүүхдээ орхих танил айл энэ суманд байсангүй. Ямар ч байсан хүүхдийнхээ сургуулийг таслахгүй байх арга олох хэрэгтэй боллоо. Ингээд сумын захиргааны хүмүүстэй уулзлаа. Гэтэл тэд нар хүүхдийг байлгах айл олж өгөхөөр боллоо. Ингээд хөдөө очиж, гэрээ барилаа.

Сант сумын нэгдүгээр бригадын хоньчин, МАХН-ын гишүүн хүний хариуцсан хонины суурьт “туслах хоньчин” боллоо. Тэр үед нэг хүн 100 толгой хонь маллах нормтай байсан юм. Ингээд би ч бас 100 толгой хонь авлаа. Хонь маллах надад тийм төвөгтэй ажил биш л дээ. Ер нь хонь хариулж өсөөгүй монгол хүн бараг олдохгүй шүү. Тийм хүн бараг байхгүй дээ. Бүгд л хонь, хурга хариулж өсөөд, зарим нь сургууль дамжиж явсаар хотод суурьшиж байлаа шүү дээ, тэр үед.

Улаанбаатар хотод байнга оршин сууж байсан болон яг өөрөө гардаж хийж байгаагүй зэрэг шалтгаануудаас болоод ч юм уу даа, би баахан хөндийрсөн байлаа. Суурийн ахлагч бид хоёр хонио ээлжлэн хариулдаг боллоо. Би нэг өнжөөд хонио хариулдаг боллоо. Өөрийн төрсөн нутагт, бага хүүхэд байхдаа хийж байсан ажил болохоор хөдөө, хээр ганцаараа хонь хариулаад явж байх их сайхан байлаа.

Ингэж хонио хариулаад явж байтал нэг сар өнгөрлөө. Монголын цагаан сар ч дөхөөд ирлээ. Манайх хотоос гарахдаа мөнгөө нилээд ширүүн зарсан тул мөнгө дууссан байлаа. Ингээд нэг сар хонь хариулсан цалин буухыг хүлээж байсан юм. Цалин буух хугацаанаасаа нилээд хоцорлоо. Бид нар олон хоног хүлээлээ. Удтал хүлээлгэсний эцэст цалин буулаа. Гэтэл 100 толгой хонь нэг сар хариулсан ажлын хөлс 17 төгрөг 50 мөнгө өгч байна. Энэ бол миний бүх цалин юм гэнэ. Монголын эдийн засгийг нуруун дээрээ үүрч яваа, мал аж ахуйн үйлдвэрлэл дээр ажиллаж байгаа хүний нэг сарын цалин шүү дээ. 100 хонь нэг сар хариулаад авч байгаа цалин нь энэ юм гэнэ.

Бэлчээрийн мал аж ахуй бол өнө эртнээс нааш монгол хүний эрхэлдэг аж ахуйн гол хэлбэр нь байсан юм. Дэлхийн далай, тэнгисээс алслагдмал Төв Азийн энэ үлэмж хуурайшмал уур амьсгалтай бүс нутагт үүнээс өөр аж ахуйн үйл ажиллагаа явуулах боломж туйлын хязгаарлагдмал юм л даа. Бид олон үеийнхээ турш энэ аж ахуйг эрхлэж, түүгээр амьдралаа залгуулж ирсэн юм. Бид хамгийн хүчирхэг, дэлхийн хэргийг захиран шийтгэж явахдаа хүртэл буянт малаа, бэлчээр, усаа шүтэж явсан биш бил үү. “Монголын нууц товчоо”-ны үг, өгүүлбэр болгоноос тал нутгийн үнэр, буянт малын үнэр ханхалдаг бус уу? Гэтэл монгол хүний амин сүнс болж ирсэн бэлчээрийн мал аж ахуй ингэж ад үзэгдэж, муу хэлэгдэж, түүнээс хурдан салахыг мөрөөдөх болцгоосон юм. Энэ бол ухаантай хүний ажил яв ч биш л дээ.

Ю.Цэдэнбалын ажлын арга барил, алдаатай бодлогыг нь шүүмжилсэн хүнийг хоньчин болгож шийтгэж байна шүү дээ. Монгол хүн бид бүгдээрээ хоньчин, бүгдээрээ хонь хариулж өссөн биш юм уу? Ю.Цэдэнбал өөрөө хоньчин биш юм уу? Гэтэл хоньчин болох, хонь хариулах нь шийтгэл юм гэнэ. Ийм нөхцөлд Монголын ард түмнийг барьж байхад түүнд диктатураас өөр юу ч тус болохгүй л дээ. Тийм учраас тэр “хяналт, шалгалт”-ыг, өөрөөр хэлбэл “диктатур”-аа чангатгах тухай байнга мөрөөдөж, Дотоод яамныхаа хүчийг хэдэн арав дахин зузаатгаж байсан байх.

Тэр үед цалингаас өөр ямар ч мөнгөний эх үүсвэр надад байсангүй. Манайх өөрийн нэг ч малгүй байлаа шүү дээ. Энэ байдал надад их юм бодогдуулж байлаа. Ийм цалингаар амьдрана гэж байхгүй шүү дээ. Манайх ам бүл олонтой байсан юм. Би сард 1500-1700 төгрөгийн цалинтай, 10 гаруй жил амьдарсан хүн шүү дээ. Тэр үед цалингаа аваад хэдийг нь юунд хэрэглэх талаар огт боддоггүй байж. Мөнгөний ямар ч асуудал байсангүй. Энэ авсан цалингийн 17 төг 50 мөнгийг дараагийн цалин буутал хэрэглэх болж байгаа юм. Тэгэхээр түүнийг юунд зарцуулах вэ? гэдгийг бодох хэрэгтэй болж байгаа юм. Тэгээд авах юм аа бодлоо. Эхлээд одоо манайд байгаа юм, байхгүй юмаа нарийн тогтоолоо. Мах бол жаахан байсан. Сүүний хувьд бол мал маллаж байгаа юм чинь сүү олодох байх гэж бодлоо. Тэгээд гурил будаа, цайнд л мөнгө хэрэгтэй болж байгааг ойлголоо. Би хоёр хөгшинтэйгээ хамт ирсэн тул цай их хэрэглэнэ шүү дээ. Тэр хоёрыг цайгаар тасалдуулж болохгүй. Ингээд хүртээмжтэй, хүнсний хямд зүйл бол шар будаа юм гэж бодлоо. Шар будаа бол арвин байхад их хэрэгтэй юм гэж бодлоо. Хүн танихгүй газар ханиад хүрээд, өвчин тусвал их аюултай байдал үүсэж болох юм гэж бодлоо. Хоёр хөгшин ханиад хүрч болно шүү дээ. Ийм үед заавал мөнгөтэй байх хэрэгтэй гэж бодож байгаа юм. Ингээд цалингийнхаа 5 төгрөгийг эм авахад зориулж тас хадгалахаар шийдлээ. Түүнийг МАХН-ын ТХ-ны 6-р Бүгд хурал дээр хураалгасан, МАХН-ын гишүүний батлахны уутанд хийгээд кармандаа хийж, сүлбээр зүүгээр хатгаж хадгаллаа. Хаяхгүйн тулд шүү дээ. Манайхан МАХН-ын гишүүний батлахыг даавуугаар уут хийгээд, хаяхгүйн тулд маш нандигнан хадгалдаг байсан юм. МАХН-ын гишүүний батлахыг хаявал том асуудал босдог байлаа. “Намын гишүүний сахилга батыг зөрчсөн !” гээд том асуудал босч, “намаас арга хэмжээ авхуулахад” хүрдэг байлаа. “МАХН-ын гишүүний дүрэм”-д “Намын гишүүний сахилга бат”-ын талаар маш хатуу, олон заалт байсан юм. МАХН-ын гишүүн хүний амьдралын бүхий л асуудлыг энэ дүрмээр зохицуулах гэж оролдож байсан юм.

Энэ талаар манайхан дотор олон жил яригдсан нэг шог үг байсан

юм. “МАХН-ын хороо байхад чи, бид хоёр амархан салахгүй шүү!” гэсэн үг байдаг юм. Тэр үед Монгол улсын иргэний гэр бүлийн асуудал хуулиар зохицуулагдаж байснаас гадна, МАХН-ын гишүүн хүний гэр бүлийн асуудал бол МАХН-ын хороогоор хэлэлцэгддэг шийдэгддэг асуудал байсан юм. Эхнэр, нөхөр хоёрын гэр бүл салах асуудал бол ёс суртахууны асуудал гэж үздэг байсан юм. МАХН-ын дүрэмд “намын гишүүн хүн өндөр ёс суртахуунтай байх ёстой!” гэсэн утгатай заалт байдаг юм. Эхнэрээс юм уу нөхрөөс салж байгаа хүнийг “ёс суртахууны хувьд доголдолтой хүн!” гэж үздэг байсан юм. Эхнэр юм уу, нөхрөөсөө салж ёс суртахууны доголдол гаргасан МАХН-ын гишүүнийг “Намын сахилга бат алдсан!” гэж үздэг байсан юм.

Ийм хүнийг МАХН-ын гишүүнээс хөөх хүртэл арга хэмжээ авна шүү дээ. МАХН-ын гишүүнээс хөөгдсөн хүний хувь заяа бол тэгээд дуусаж байсан юм. Тэр хэзээ ч дахин нэр хүнд олж, нийгэмд байр сууриа эзлэж чадахгүй болж байсан юм. Тэр ямагт ад үзэгдэж, байнгын дарамтанд амьдарч байсан юм. Тийм хүнийг хаана ч ажилд авахгүй шүү дээ. Хүн хувиараа хөдөлмөр эрхлээд, амьдрал ахуйгаа өөд нь татаад, аваад явах ямар ч боломж байгаагүй юм. Бүх юм хориотой байлаа. Ийм байдалд орохгүйн тулд МАХН-ын гишүүн эхнэр, нөхөр хоёр гэр бүлээсээ салах явдлыг аль болохоор гаргахгүйг хичээдэг байсан юм. Нөгөө талаар “МАХН-ын гишүүд бүгд өндөр ёс суртахуунтай байдаг!” гэсэн сурталчилгаа хийдэг байсан юм. Тийм учраас МАХН-ын гишүүд гэр бүлээсээ салж, ёс суртахуунгүй үйлдэл хийж болохгүй. МАХН-ын гишүүдэд гэр бүлээсээ салах асуудал бол хориотой асуудал байсан юм. МАХН-ын гишүүн хүн гэр бүлээсээ салахаар шийдсэн бол энэ асуудлыг эхлээд МАХН-ын хороогоор авч хэлэлцээд, түүнд зөвшөөрөл өгдөггүй байсан юм. Тийм учраас “МАХН-ын хороо байхад чи, бид хоёр амархан салахгүй шүү!” гэсэн үг гарсан юм. Ингэж МАХН-ын гишүүн хүний хувийн амьдралыг хүртэл “МАХН-ын гишүүний дүрэм”-ээр зохицуулахыг оролдож байсан юм.

Зөвхөн гэр бүлийн асуудал биш МАХН-ын гишүүн хүний амьдрал нь бүхлээрээ МАХН-ын хорооны хяналтанд байсан юм. МАХН-ын гишүүд бие биенийхээ “Намын сахилга батын зөрчил”-ийг илрүүлэхийг хичээж байлаа шүү дээ. Хэн нэг хүний, ямар нэг зөрчлийг мэдвэл шууд МАХН-ын хорооныхоо нарийн бичгийн даргад хэлдэг байлаа. Олон хүний олон зөрчлийг илрүүлсэн хүн “МАХН-ын үлгэр жишээч, их сайн гишүүн” хэмээн магтагдаж, шагнуулдаг байлаа. МАХН-ын хорооны дарга “намын сахилга бат”-ын зөрчлөөр нь гишүүдээ барьцаалж, дарамталдаг байсан юм. “Чи төдийд, тийм юм хийж намын сахилга батын зөрчил гаргасан шүү!” гэж хэлээд л МАХН-ын гишүүн хүнийг дарамталдаг байлаа шүү дээ.

Ингэж бүх нийгмийг бүхэлд нь байнгын дарамт, хяналтанд барьж байсан юм. Бид ийм нийгэмд амьдарч байсан юм шүү дээ.

Тэр үед МАХН-ын гишүүн биш хүнд бүх нийгэм бүхлээрээ хаалттай байсан гэж хэлж болно. Хүн өөрийн олж авсан боловсрол, эзэмшсэн мэргэжилд тохирсон ажил хийж, нийгэмд өөрийн байр суурийг эзлэж хэвийн амьдралаар амьдрахыг хүсэж байгаа л бол энэ намын гишүүн болохоос өөр зам байгаагүй юм. МАХН-ын гишүүн биш л бол шууд нийгэмд гадуурхагдаж эхэлдэг байсан юм. Түүнийг хэзээ ч удирдах албан тушаалд дэвшүүлэхгүй шүү дээ. Улсын үйлдвэр, албан газрууд ажилд шинэ хүнийг авахдаа хүртэл МАХН-ын гишүүн бол нэгдүгээр ээлжинд авдаг байсан юм. Ийм хэцүү байдалын дунд бид ажиллаж амьдарч байсан юм шүү.

Ингээд нэг сар хонь хариулаад авсан цалингаа би хэрхэн хуваасан тухай яриандаа эргэж орцгооё. Би эм авахад зориулсан 5 төгрөгнөөс бусад төгрөгийг дараах байдлаар хуваалаа: 10 кг шар будаа, 2 кг 2-р гурил, дугуй булантай цай талыг, 1 хайрцаг ёотон авахаар төлөвлөлөө. Үлдсэн мөнгө маань ийм зүйлүүдийг авахад дөнгөж л хүрч байна. Ингээд сумын төвийн дэлгүүрт очлоо. Хуваарийн дагуу нөгөө зүйлүүдийг авлаа. Тэр өдөр бас хүүхдээ орхисон айлд очоод, жаахан цагаан идээ, ааруул, эзгий өглөө. Манайх сумын төвөөс 25 км-ын зайтай байсан юм. Цаг өглөөний 11 орчим болж байсан байх. Бүх хүн ажилдаа явсан, сумын төв эл, хуль оргисон, нэг тиймэрхүү л байлаа. Би тэмээ унаж ирсэн юм. Тэгээд гэртээ харихаар явж байтал нэг залуухан хүүхэн замд тааралдлаа. Тэр:

-Та харих гэж явна уу? Таних хүнгүй хэцүү байгаа биз дээ? Та манайд ороод цай уугаад явах уу? гэж хэллээ. Тэгээд би дуртай зөвшөөрөөд, түүнтэй хамт тэдний гэрт очлоо. Тэр айл нилээд тохитой, чинээлэг айл юм. Тэр хүүхэн надад цай, хоол хийж өглөө. Тэр өөрөө цагаан хурганы арьсаар дээл хийж байна. Би:

-Цагаан сарынхаа гоёлыг хийж байгаа юм уу? гэж асуусан юм.

-Нөхөртөө дээл хийж өгч байгаа юм. Хурганы арьс элдүүр муутай, таарч өгөхгүй хэцүү байна! гэж тэр хүүхэн ярьж байна.

Тэгээд би:

-Танай энд элдээгүй хурганы арьс ямар үнэтэй байдаг юм бэ? гэж асуулаа.

-Элдээгүй хурганы арьс нэг төгрөг байдаг. Зарим үед 2-3 төгрөг хүрдэг юм. Манай энд арьс элддэг хүнгүй болчихсон юм. Элдсэн арьсыг бол 15 төгрөгөөр авдаг юм! гэж тэр хүүхэн ярьж байна.

-Тэгвэл өөрт чинь сайхан элдсэн хурганы арьс авч ирээд өгвөл 15 төгрөгөөр авах уу? гэж асуулаа.

-Авалгүй яахав! Би хийж байгаа энэ дээлэндээ тааруулж авна шүү! гэж байна.

-Танай нөхөр ямар ажил хийдэг юм бэ? гэвэл

-Сумын ерөнхий нягтлан бодогч хийдэг! гэж байна. Нягтлан бодогч бол хаана ч очсон тогтмол цалинтай ажил шүү дээ. Манай аав маш сайн элдүүрчин байсан юм. Манай хойд ээж, эгч хоёр аавын дэргэд байсан болохоор арьс элдэхийг түүнээс маш сайн сурсан юм. Би өөрөө элдэж байгаагүй ч түүний ерөнхий технологийг нь сайн мэддэг байсан юм. Энэ бүхэндээ найдаад, нөгөө хүүхэнд:

-Чамд элдсэн хурганы арьс авч ирж өгье! Чи бусад юмаа хийж бай! гэж хэлээд, түүний дээл хийж байгаа хурганы арьснаас жаахан өөдөс авлаа. Ямар янзын үстэй, ямар янзын элдүүртэй арьс хэрэгтэй байгааг нь жишээ болгож авсан юм.

Ингээд энэ өөдсөө бариад нэгдлийн нярав дээр очлоо.

-Ийм үстэй хурганы арьс хэрэгтэй байна. Нэг арьс өгөөч! гэж гуйлаа л даа. Тэгсэн тэр:

-Тэр хаалгыг тат даа! гээд нэг хаалга зааж байна. Тэр хаалгыг татаж, онгойлгоод харвал арьсыг таазанд нь тултал хураасан өрөө байна. Захаас нэг хурганы арьс авлаа.

Нярав:

-За наадах чинь болж байгаа бол та ав л даа! гэж байна.

Тэгээд би:

-Зүгээр авч болохгүй! гэж хэлээд, эм авахаар хадгалсан 5 төгрөгөө өглөө. Гэтэл тэр их гайхаад:

-Би наадхаар чинь яах юм бэ? Авахгүй! гэж байна.

Би түүнд “Ав! Ав!” гээд мөнгөө хүчээр өглөө. Тэгээд тэмээгээ унаад гүйлгэсээр байгаад харилаа. Тун богино хугацаанд тэр арьсыг элдэж бэлэн болгох ёстой шүү дээ. Нэг арьс элдээд өгвөл нэг сар, нэг зуун хонь хариулахтай ижил хэмжээний мөнгө авч байна шүү дээ. Манай эхнэр нөгөө арьсыг дор нь дэвтээгээд, угаагаад өглөө. Арьсыг 3 дамжлагатай элддэг юм. “Далхах”, “Цулгуйлах”, “Өнгөлөх” гэсэн 3 дамжлага байдаг юм. Энэ гурвыг хийж байж арьсны элдүүр нь гүйцдэг юм. Сүүлчийн дамжлага дээр арьс торго шиг л сайхан зөөлөн болдог юм. Нэг өдрийн дараа миний арьсны элдүүр гүйцээд ирлээ. Тэр үед манай гэрийн залуучууд, бид нар дандаа хярам уудаг байлаа. Цайгаа хэмнээд шүү дээ. Өглөөний 10 цагийн орчим хярмаа уучихаад, элдсэн арьсаа аваад, нөгөө айлдаа очлоо. Замдаа хүнээс нуугдасхийж явлаа. Тэгээд арьсаа нөгөө хүүхэнд өгвөл: “Ёстой сайхан элдсэн байна. Бүгдээрээ ийм байсан бол сайхан дээл болох байж!” гээд 15 төгрөг өгч байна. Ингээд 15 төгрөгөө аваад, нэгдлийн нярав дээр дахин очлоо. Түүнд 15 төгрөгөө бас хүчээр өгөөд 3 хурганы арьс өөрөө сонгож авлаа. Түүнд мөнгө өгөхөөр тэр их гайхаад, учрыг нь ерөөсөө олохгүй байх шиг л байлаа. Ингээд нөгөө 3

арьсаа бас хурдан элдээд, нөгөө хүүхэндээ 45 төгрөгнөөс өгч байгаа юм. Дахиад нэгдлийн няраваас 45 төгрөгөөрөө 9 арьс авлаа. Энэ мэтээр 20 хоногийн дотор арьс элдэж зараад, 800 төгрөгтэй боллоо.

18 Монголын уламжлал.

Ц Л: Манайх Улаанбаатар хотод амьдарч байхдаа мөнгийг шууд зарлагаддаг байж. Хэмнэх, хадгалах гэсэн ойлголт ердөө байсангүй. Одоо мөнгөө маш хямгатай зарцуулдаг болж эхэллээ. Ийм маягаар олсон мөнгөө юунд зарцуулахаа урдаас сайн боддог болж байгаа юм. Үүнээс хойш бидний ойр орчимд амьдарч байгаа хүмүүсийн амьдралыг судлаж үзлээ. Тэдний амьдралд юу их хэрэгтэй байна вэ? гэдгийг судаллаа. Тэгтэл тэд нар бүгд морь унаж байна. Морийг зүгээр унахгүй, заавал эмээл тохож байна. Эмээлэнд заавал гөлөм хэрэглэж байна. Эмээлэнд хамгийн их хэрэгтэй зүйл бол гөлөм юм. Гэтэл гөлөмийг угаасаа дэлгүүрт зардаггүй юм байна л даа. Түүнийг хийгээд зардаг хүн байсангүй. Энэ нь юуны өмнө түүнийг хийж чаддаг хүн бараг байсангүйтэй холбоотой юм. Гөлөм маш амархан урагддаг, дахиад авах гэхээр олддоггүй юм байна. Нутгийн хүмүүс бас гоё гөлөм авах сонирхолтой байдаг юм байна. Монголчууд унаж яваа мориороо гоёх дуртай, морио гоё эмээл, хазаараар гоёх дуртай, гоё эмээлээ гоё гөлмөөр гоёх дуртай шүү дээ. Гэтэл гоё, бас бөх гөлөм хаана ч байсангүй. Ингээд гөлөмний эрэлт хэрэгцээ маш их байгааг мэдлээ. Тэр нутгийнхан дээр үед булигаараар гөлөм хийдэг байж. Ингээд булигаар нь ховордсон байна л даа. Сумын дэлгүүрт хааяа л ирнэ. Маш ховор зүйлийн нэг болсон байна. Нэг булигаар 100 орчим төгрөгийн үнэтэй юм байна. Нэг булигаараар хоёр гөлөм хийх боломжтой юм. Энэ чинь бүтэн үхрийн шир шүү дээ. Булигаарыг дээр үед манай Аж үйлдвэрийн комбинатад хийдэг байж. Сүүлийн үед Хятадаас жаахан авдаг болсон юм байна. Жирийн нэг гөлөм бол 600 төгрөгийн үнэтэй, бүтэн угалзтай гоёлын гөлөм 1000 төгрөгний үнэтэй юм. Энэ бол орон нутагт тогтсон үнэ ханш шүү дээ.

Тэр нутагт гөлөм хийж чаддаг ганцхан хүн байгааг олж мэдлээ. Түүнийг Ренчин гэдэг байлаа. Манай гэрээс холгүй нутаглаж байгааг нь оллоо. Тэгээд сумын дэлгүүрт үлдсэн нэг бүтэн булигаар худалдаж аваад, Ренчин гуайнд очлоо. Тэгээд түүнээс “Гөлөм хийдэг аргаа зааж өгөөч !” гэж гуйлаа. Үүний хөлсөнд нь “Өвлийн идэш хийх мал өгнө!” гэж амаллаа. Тэгээд тэр хүнд шавь орж байгаа юм. Тэр хүн надад дуртай тусалж өгсөн юм. Нөгөө булигаараар Ренчин гуай хоёр гөлөм эсгэлээ. Гөлөмний эмжээр, угалз гэж байдаг юм. Түүнийг нь хийдэг аргыг заалгалаа. Ингээд гөлөм оёдог бүх аргыг нь заалгаж мэдлээ. Тэгээд түүний гөлөм хийхэд

хэрэглэдэг бүх багажийг нь түр зээлж авлаа. Ингээд өөрөө бие дааж гөлөм хийх ажилд орлоо.

Би олон жил өндөр цалинтай ажил хийж байсан болохоор өөрөө өөрийнхөө гараар ерөөсөө юм хийж байсангүй. Юм хийдэг хөдөлмөрийн багаж, зэвсэг надад нэг ч байсангүй. Ренчин гуай ч манайхаар байнга ирдэг боллоо. Тэгээд би түүгээр заалгаад хоёр гөлөм өөрөө хийлээ. Миний өөрөө хийсэн анхны бүтээл тэр боллоо. Тэгтэл хүмүүс манайхаар ирээд гөлөмөө зарах уу? Ямах үнэтэй юм бэ? гэж асуугаад эхэллээ. Тэгээд “Нэгийг нь 600 төгрөгөөр ав л даа!” гэж хэлдэг боллоо. Ингээд хоёр хүн миний хийсэн гөлөмнүүдийг дор нь худалдаж аваад явлаа. Нэг зуун төгрөгөөр авсан булигаар 1.200 төгрөг боллоо шүү дээ. Арав дахин өссөн байгаа биз дээ. Ингээд их ч баярлалаа. Их урам орлоо. Ингээд булигаар 4-5 боодлыг олж аваад, гэр бүлээрээ бүгдээрээ гөлөм оёдог боллоо. Ингээд дадлага, туршлагатай болоод амархан хийдэг боллоо. Хонь хариулж явахдаа эсгэдэг, наадаг, оёхоос бусдыг нь хийчихдэг боллоо. Ингээд олныг хийдэг боллоо. Нэг сард 10-20 гөлөм хийдэг боллоо. Ингээд түүнийг авахаар маш олон хүн манайхаар ирдэг боллоо. Олон танилтай боллоо. Манай орлого хонь хариулаад авдаг цинггаас хэдэн арав дахин өслөө.

Ингээд мөнгөөр дутахаа байлаа. Амьдрал ахуй маань сайжирч ирлээ. Гэрээ дулаан эсгий бүрээс, цагаан даавуун бүрээстэй болголоо. Тэгээд тэр үед ЗХУ-аас импортоор орж ирдэг байсан 3 дугутай “Урал” гэдэг мотоцикль авлаа. Монголчууд түүнийг “Шаахайт” гэж нэрлэдэг юм. Дайны үед Германд энэ мотоциклийг цэргийн зориулалтаар үйлдвэрлэж байсан юм билээ. Ийм мотоцикль унасан Герман цэргүүд бүх л Европыг байлдан дагуулсан юм шүү дээ. Маш сайн мотоцикль байв. Ёстой техникийн нэгэн төрлийн гайхамшиг юм даа. Дайн дууссаны дараа оросууд тэр үйлдвэрийг нь аваад өөртөө байгуулсан байх.

Нэг жилийн дараа Польш улсад үйлдвэрлэсэн “Варшав” гэдэг суудлын машин Оросын элчин сайдын яамнаас 18.000 төгрөгөөр авлаа. Ингээд өөрийн олон малтай боллоо. Манайх Улаанбаатараас хов хоосон ирсэн шүү дээ. Жил болгон 15 гүү саадаг боллоо. 20 орчим үхэртэй боллоо. 100 гаруй хоньтой боллоо. Малыг бүгдийг нь худалдаж авлаа. Өсгөж олон болгохын тулд эхлээд дандаа охин хурга авч байлаа. Бэлчээрийн аргаар малыг маллаж байгаа нөхцөлд хонь бол 300 орчим байж сая ашиг, орлого өгдөг юм. Өөрийн хэрэгцээг хангаад, товарлаг болдог юм. Эзэн өөрөө хэрэглээд, цааш нь зах зээлийн ханшаар зарах боломжтой болдог юм. Ийм хэмжээ байдаг юм.

Миний очсон Сант сумын гөлөмний хэрэгцээг 100 хувь хангадаг болоо. Тэгээд Сант сумтай ойрхон Баян-өндөр, Баян гол, Өлзийт, Бүрд сумын хүмүүс бие биенээсээ мэдээд, манайхаас гөлөм ирж авдаг боллоо.

Тэгээд гоёлын гөлөм хийж туршиж үзлээ. Гоёлын гөлөм бол 1.200 төгрөгт хүрсэн үнэтэй байлаа. Тийм гоёлын гөлөмтэй, мөнгөн хэрэглэлтэй эмээл 6.000 төгрөгний үнэтэй байсан юм. 6.000 төгрөгөөр Чехословак улсад үйлдвэрлэсэн “Ява” гэдэг мотоциклийг авах боломжтой юм. Манай хөдөөнийхөн, хот суурингийнхан “Ява”-г их унадаг байлаа. Аав ээж нь хүүдээ өв, хөрөнгөө өгөх гэж байгаа айл байх юм л даа. Хүүхэддээ мөнгө хайрлахгүй, чанартай сайн юм авч өгөх гэж бодоод хайгаад байдаг юм байна. Тэгээд мөнгөн хэрэглэлтэй гоёлын эмээлийн захиалга ирдэг боллоо. Ингээд жилд нэг гоёлын эмээл хийдэг боллоо. Сүүлдээ жилд 2-ыг хийдэг болоод, дараа нь 4-ийг хийдэг боллоо. Зун хоёр эмээл, өвөл хоёр эмээл хийдэг боллоо. Улам дадлага сууж байна шүү дээ. Дандаа захиалгаар хийнэ шүү дээ. Дөрвөн эмээл 24.000 төгрөг болж байгаа юм. Эмээлээс олох жилийн орлого маань 24.000 төгрөг болж байгаа юм. Гоёлын эмээл хийхэд эмээлийн мод, мөнгөн хэрэглэл буюу “арван цагаан”, гөлөм гэсэн эд ангиуд хэрэгтэй байдаг юм. Эмээлийн модыг нь худалдаад авчихна. “Арван цагаан”-ыг нь дархан хүнд захиалга өгч хийлгэдэг юм. Бусдыг нь өөрөө хийдэг байлаа. Хүнээс авч байгаа зүйл болон захиалгаар хийлгэж байгаа зүйлийнхээ мөнгийг нь төлнө. Энэ бол нилээд мөнгө шаардана л даа. Тэр дархан хүнээр хийлгэж байгаа зүйлүүдээ өөрөө хийдэг болчихвол их ашиг гаргахаар харагдаад байгаа юм.

Ингээд өөрөө дархны ажил сурахаар шийдлээ. Дархан хийж чаддаг хүн маш ховор, бараг байгаагүй юм. Дархан хийж чаддаг нэг настай өвгөн сумын төвд амьдарч байсныг оллоо. Тэднийд очиход нөгөө өвгөн маань дандаа ганцаараа л юмаа хийж байдаг байлаа. Түүнд туслах хүн байсангүй. Тэгээд би түүнд тусладаг боллоо. Түүнтэй сайхан танил боллоо. Ингээд дарханы хийдэг аргуудыг бага ч гэсэн мэдэж авлаа. Тэгээд дархны ажил хийхэд хэрэглэдэг багажууд, бусад зүйлүүдийг нь мэдэж авлаа. Ингээд өөрөө бас хийж үзэхээр шийдлээ. Тэгээд өвгөний багажуудыг гуйж авлаа. Ингээд хийгээд үзсэн чинь болох янз байна шүү. Тэгээд бага багаар хийсээр байтал хийж чаддаг боллоо. Тэр өвгөний хийдэг арга бол “цохиж хийх арга” юм. Харин аймгийн төв дээр “цутгаж хийх арга”-ыг мэддэг нэг хүн байгааг мэдлээ. Энэ арга нь бага хугацаанд, их олныг хийж болдог арга юм л даа. Тэр хүнийг “Ногоон Дамба” гэдэг юм байж. Ингээд түүнтэй уулзаад, танилцлаа. Ингээд бас л түүний хийх аргаас нь суралцлаа. Шавь орлоо. Тэр бол хийх юмныхаа хэвийг нь аваад л цутгачихдаг арга юм. Ингээд л засаад өнгөлөөд л болчихно доо. Их хялбар арга юм. Ийм маягаар өөрөө бараг бүгдийг нь хийдэг боллоо. Эмээлээс олох жилийн орлого маань 40.000 төгрөг боллоо.

Тэр үе ЗХУ-д үйлдвэрлэсэн суудлын “Волга” машин 30.000 төрөг орчим үнэтэй байсан байх. Тэр үед монгол төгрөгийн рубльтэй харьцах

харьцааг Монгол банкнаас 1 рубль нь 5 төгрөг, Америк доллартай харьцах харьцааг 1 доллар нь 4 төгрөг гэж тогтоодог байсан юм. Жинхэнэ зах зээлийн харьцаа биш л дээ. Тэр үед манайд хувьдаа “Волга” машинтай хүн бараг байгаагүй юм. Ер нь хувийн машинтай хүн ховорхон байлаа шүү дээ. Харин төр засгийн тэргүүнүүд, яамдын сайд нар бүгд хар өнгийн “Волга” машин хэрэглэдэг байсан юм. Тэр үед Засгийн газрын авто баазад “Волга”-гаас өөр машин байгаагүй байх. Би САА-нууды удирдах газрын дарга байхдаа “Волга” машиныг тэндээс хэрэглэдэг байсан юм. “Их сайн машин!” гээд л магтаад л унадаг байлаа шүү дээ. Одоо хүнсний “Хүчит Шонхор” захын “махны чэнж”-үүд л “Волга” машиныг мах ачихын тулд хааяа хэрэглэдэг болоо шив дээ. Манайхан түүнийг тоохоо байжээ.

Тэр үед манай гэрт холын тээврийн жолооч нар их ирдэг байлаа. Би тэд нартай бол их найзлана шүү дээ. Тэдэнд айраг, цагаа идээ байнга өгнө. Өвлийн идэш өгнө. Би мал маллаж байхдаа нэг л удаа тэмээгээр нүүсэн юм. Тэгээд дандаа Улаанбаатар хотын холын тээврийн жолооч нарын машинаар нүүдэг байлаа. Тэр үед аймаг болгон өөрийн авто тээврийн баазтай байсан юм. Улаанбаатар хотод холын тээврийн авто бааз олон байсан юм. Манайх жилд хавраас намар болтол 10-15 удаа нүүдэг байлаа. Хэдий олон нүүж бэлчээрээ солино, төдий чинээ мал тарга хүчээ сайн авдаг юм. Нэг газар удаан суувал малын тарга хүчинд муугаар нөлөөлнө. Зуны нөхцөлд малаа дээд зэргээр таргалуулж чадвал өвөл ажил багатай болдог юм. Ингэж чадвал мал сайн төллөнө, мал өвчин эмгэг бага тусна, малын үхэл багасдаг юм. Ингэж чадаагүй мал туранхай болж олон бэршээл гарч ирнэ. Малын өвчин элбэгшинэ, төл хорогдоно, том малын хорогдол ч их гардаг юм. Эх мал төлөө тэжээж чадахгүй болно, малаас авдаг ашиг шим бүгд буурна. Энэ бол бэлчээрийн мал аж ахуйн “алтан дүрэм” юм шүү дээ. Ийм учраас хавраас намар болтол малыг дээд зэргээр таргалуулах хэрэгтэй байдаг юм. Үүний тулд өвс ногоо сайтай газар руу ойрхон, ойрхон нүүж, бэлчээрээ байнга сольж байх хэрэгтэй. Үүний тулд өөрөө байнга явж бэлчээрээ сонгох хэрэгтэй. Бэлчээр муудахаар мал гэрээсээ хол явж бэлчдэг болно. Мал бол дандаа өвсний шинэ соргогийг нь иддэг юм. Малын хөлөөр талхилагдсан өвс идэх дургүй. Мал гэрээсээ хол явж бэлчвэл малын явдал ихдээд, тарга хүч авахад нь муугаар нөлөөлнө. Мал гэрээсээ 5-10 км-ын л зайд байвал тохирч байгаа юм. Үүнээс хол явбал малын явдал их болохоос гадна эзэн өөрөө хол явж малаа эргэж тойроход цаг их орно. Бусад ажил хэцүү болно. Гэрийн ойр байвал хугацаа бага орно шүү дээ. Шинэ бэлчээр дээр ирэхэд мал гэрээсээ хол явдаггүй юм. Гэрийнхээ ойр л байна. Тарга хүч сайн авбал тэр хэмжээгээр ашиг шим нь нэмэгдэнэ. Энэ хамгийн чухал. Би жолооч нарт “Манайхыг нүүлгэж өгөөрэй!” гээд захиана даа. Тэд нарт төвөг байхгүй.

Ирээд л нүүлгээд өгнө.

Миний гөлөм хийдэг булигаар ховор байлаа шүү дээ. “Сарьс” гэдэг юм байдаг юм. Түүнийг гөлөм хийхэд хэрэглэдэг юм. Өвөрхангай, Архангай хавийн дэлгүүрт энэ хоёр их ховор ирдэг юм. Түүнийг жолооч нарт захичихна шүү дээ. Холын аймаг явж байгаа жолооч нар ирэхдээ аваад ирдэг юм. Жолооч нар их хол явна шүү дээ. Дорнод, Хэнтий аймагт байгаа Б.Нямбуу, Б.Сурмаажав нарын тухай мэдээ сонсоод ирнэ. Тэр үед харилцаа холбоо, утас муу ажиллаж байлаа. Жолооч нар л тийм мэдээг сонсоод ирнэ шүү дээ.

Тэр үед Монгол улсад авто тээврээс өөр тээврийн хэлбэр байсангүй. Хол, ойрын бүх тээврийг зөвхөн авто машинаар гүйцэтгэж байлаа шүү дээ. Бүр дээр үед бол тэмээн жингээр бүх холын тээврийн ажлыг гүйцэтгэж байсан юм. Ойрын тээврийг бол үхэр тэргээр гол нь гүйцэтгэж байсан юм. Зарим газар морин тэрэг жаахан хэрэглэж байсан байх. Дээр үед айл нүүхдээ голдуу үхэр тэрэг хэрэглэж байсан юм. Говийн аймгуудад бол тэмээгээр нүүдэг байлаа. Сүүлд ХАА-н нэгдэл, САА-нууд нилээд бэхжээд ирсэн үед машинаар нүүж, суудаг болсон юм. Монгол орон бол өргөн уудам нутагтай учир одоо цагийн шаардлагыг тэмээ, үхэр хангахаа байсан юм.

Тэр үед Б.Нямбуу, Б.Сурмаажав бид нар өөрсдөө хот орохоор бол өөрсдийн амьдарч байгаа аймгийн Дотоодыг хамгаалах газарт энэ тухайгаа мэдэгдэж “зөвшөөрөл” авдаг журамтай байсан юм. Энэ “зөвшөөрөл” Улаанбаатарт байдаг Дотоод ямаар дамжаад, МАХН-ын ТХ-ны Хянан Шалгах Хорооноос ирдэг байсан юм. Хянан Шалгах Хороо МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн даргад бидний хүсэлтийг танилцуулах ёстой байсан юм. Би тэр журамд ерөөсөө захирагдаагүй юм шүү. Сардаа хэд, хэдэн удаа хот орно шүү дээ. Жолооч нар байнга явж байлаа шүү дээ. Хагас сайн өдөр нэг жолоочийн машинд суугаад, нууцаар Улаанбаатар хот орчихно. Бүтэн сайн өдөр “Барааны зах”-аар явж, ажлаа амжуулаад, нэг дэх өдөр нэг жолоочийн машинд суугаад буцаад ирнэ. Манайхаас намайг хаашаа явсныг асуусан хүн ирвэл “Малд явсан! Мал алдагдсан!” гээд хэлчихнэ дээ. Намайг хот ороод ирснийг хэн ч мэдэхгүй өнгөрнө. Жолооч нар миний нууцыг сайн хадгалаж чаддаг байсан юм. Ийм маягаар уулзах хүнтэйгээ уулзана.

Гэхдээ байнга мэдээлдэг хүмүүс бас байсан юм. Тэр үед миний тухай мэдээ өгөх Дотоод яамны даалгавартай хүн олон байсан юм. Тэдэнд аль болохоор харагдахгүй газраар явна. Хотод амьдардаг, яам тамгын газар ажилладаг, хамт ажиллаж байсан хүмүүс дотор Дотоод яамны “нууц мэдээлэгч” нар олон байсан юм. Тэд нар миний тухай байнгын мэдээг дээш нь өгч байдаг юм. Ер нь тэр үед зөвхөн намайг биш, бүх хүнийг

Дотоод яамны “нууц мэдээлэгч” нар байнга хянадаг байсан юм. Улсын албан газар бүрт Дотоод яамны “нууц мэдээлэгч” нар ажилладаг байлаа шүү дээ. Хэн, хэзээ, хэнд юу гэж хэлэв? Хэн, ямар хувцас өмсөж, юу хэрэглэж байна? гээд бүгдийг нь Дотоод яаманд мэдээлдэг байсан юм. Хэрвээ үнэтэй, гоё сайхан юм хэрэглэвэл том асуудал босно шүү дээ. Энэ хүн ийм үнэтэй зүйлийг хаанаас, хэнээс авсан бэ? Түүнийг авах мөнгийг түүнд хэн өгсөн бэ? гээд шалгаж эхлэнэ шүү дээ. Гэхдээ намайг бол маш олон “нууц мэдээлэгч” нар хянаж байсан юм.

Мал маллахад хамгийн их ажил нь хавраас намарт байдаг юм. Малаа сааж, цагаан идээгээ хийнэ шүү дээ. Ийм үед нь би Улаанбаатар хотод амьдардаг, хамаатан садангийнхаа хүүхдүүдийг дуудаж ирүүлээд туслуулна шүү дээ. Эмэгтэй нь мал саана, эрэгтэй нь хонь, мал хариулна. 7-8, заримдаа 10 хүүхэд ирнэ. Нэг, нэг жолоочийн кабинд суугаад ирнэ. Намар цагаан идээ өгөөд бас нэг, нэг машины кабинд суулгаж өгөөд явуулчихна. Тэд нар чинь манайд байх хугацаандаа мал сааж, хонь хариулж сурна. Ер нь ажил хийж сурна. Ингэж хүүхдүүдийг багаас нь ажил хийлгэж сургах хэрэгтэй юм. Аливаа ажлыг хийхэд эвийг нь олох хэрэгтэй байдаг юм. Тэгж ажлын эвийг олж, хийж сурах хэрэгтэй юм. Хүүхдүүд манайд ирээд огт хийж үзээгүй ажлын эвийг нь олж хийдэг болж байгаа юм. Одоо тэр хүүхдүүд “Танайд очоод ажил хийж сурсан нь зах зээлийн өнөө үед амьдралд хэрэг болж байна!” гэж ярьж байна.

И Л: “Эсэргүү Лоохууз”-ыг анх очиход нутгийн хүмүүс яаж хүлээж авсан бэ?

Ц Л: Нутгийн хүмүүс надад сайн хандаж байсан. “Энэ хүн төр, засгийн аль л болохгүй, бүтэхгүй байгаа зүйлүүдийг нь шударгаар шүүмжилсэн юм. Өөр буруу юм хийгээгүй юм!” гэж хүмүүс мэдэж, хүлээж авсан юм. Гэвч түүнийгээ тэд нар шууд ил гаргаж болохгүй шүү дээ. Олон түмэн цаагуураа намайг их дэмжиж байсан юм. Намайг ингэж цөлсөн явдлыг цаагуураа их эсэргүүцэж байсан юм. Хүмүүс ийм хандлагатай байсан болохоор би өөрийгөө “Буруу юм хийжээ!” гэж ердөө ч зэмлэдэггүй байлаа.

Ер нь хүн өөрийнхээ үзэл бодлыг хамгаалж явах хэрэгтэй юм. “Миний хэлсэн үг бол цаашдаа манай МАХН-д хэрэгтэй юм! Би буруу юм хийгээгүй учир хэзээ нэгэн цагт цагаадна!” гэж боддог байлаа. Ерөөсөө сэтгэл санаагаар унаагүй. Ажил төрлөө хийх, хариуцаж авсан нэгдлийнхээ малыг сайн маллахыг л бодож байлаа. Тэгээд нэгдлийн 250 орчим хоньтой боллоо. Тэр үед нэгдлийн гишүүдийн амины малын тоог хангайн бүсэд 50 толгой, говийн бүсэд 75 толгой гэж тогтоосон байсан

юм. Гэхдээ түүнээс олон малтай хүмүүс байсан юм. Би нэгдлийн гишүүн биш учир надад энэ журам хамаагүй шүү дээ. Гэтэл бас л “Энэ журмыг дагах хэрэгтэй!” гэж шаарддаг байлаа. Тэр үед энэ тогтоосон тооноос илүү малтай нэгдлийн гишүүд өөрийн илүү малыг өөр хүний нэр дээр тоолуулдаг байсан юм. Манайх 400-500 малтай байсан. Тэгээд энэ малаа өөр хүний нэр дээр тоолуулаад, тэр хүнээрээ маллуулчихдаг байлаа.

Сант суманд ирээд манайх 6 жил боллоо. Манай хүүхэд дунд сургуулийн 8-р анги төгсөв. Тэгээд 9-р ангид сурах боллоо. Гэтэл Сант суманд 10 жилийн дунд сургууль байсангүй. Ингээд өөр суманд шилжин суух хэрэгтэй боллоо. Хоёр настай очсон охин маань бас сургуульд сурах болчихсон юм. Хамт очсон нөгөө хоёр хөгшин маань 80 наслаад, насыг барлаа. Манай эхнэр жирэмсэн байсан. Би нэгдлийн хонь, өөрийнхөө малыг маллаж дийлэхээ байлаа. Ингээд өөр суманд шилжин суух тухай хүсэлтээ МАХН-ын ТХ-ны Хянан Шалгах Хороонд олон удаа явууллаа. Хариу ирдэггүй. Тэгээд зарим дарга нартай өөрийн биеэр уулзаад, муудалцаж ч үзлээ. Удаан хүлээлгэсний эцэст Хар Хорины САА-д шилжиж болно!” гэсэн зөвшөөрөл ирлээ.

Ингээд би хангайн бүсэд зөвшөөрөгдсөн 50 толгой малаа үлдээгээд, бусад малаа зарчихлаа. Тэр нилээд их мөнгө боллоо. Ингээд Хар Хорины САА-д шилжиж ирлээ. Эхнэр маань эмийн санд эм найруулагчийнхаа ажлыг хийдэг боллоо. Том хүү маань 9-р ангид орлоо. Нэг хүүхэд маань 1-р ангид орлоо. Тэнд би гахай, тахианы бригадын тоо бүртгэгч гэдэг ажилд орлоо. Сард 320 төгрөгийн цалин авахаар боллоо. Ингээд ажиллаж байлаа. Тэгээд гахайн тоорой хоёрыг хүнээс худалдан авч, өөр хүнээр маллуулдаг боллоо. Сүүлдээ өөрийн гахайны байртай, олон гахайтай боллоо. Гахай бол маш өндөр ашиг өгдөг аж ахуй юм шүү дээ. Гахайны арчилгаа маллагаа, эдийн засгийн ашиг, орлогын талаар би олон ном олж уншлаа. Хар Хорины САА бол гурилын үйлдвэр, махны үйлдвэртэй газар юм шүү дээ. Би гурилын үйлдвэрийн хаягдал авч гахайгаа тэжээдэг боллоо. Энэ хаягдал гахайны маш сайн тэжээл болдог юм. Гурилын үйлдвэр хаягдлаа надад үнэгүй өгдөг байсан юм. Гурилын үйлдвэр хаягдлаа өөрөө огт ашигладаггүй байлаа. Түүнийг авч ашигладаг газар ч байсангүй. Гурилын үйлдвэрээс хаягдал маш их гарна шүү дээ. Надад машин машинаар л өгдөг байлаа. Нэг гахай нэг удаа 10-14 тоорой гаргана. Жилд 2-3 төллөнө. Тооройнуудаа бүгдийг нь энэ хаягдлаар бордож, тэжээгээд намар хоёр гахайгаа үлдээгээд, бусдыг нь нядлаад, махыг нь зардаг боллоо. Тэр үед Зөвлөлтийн цэргийн анги Өвөрхангайд, Хар Хорины САА-гаас ойрхон байрлаж байсан юм. Би нэг кг гахайны махыг 8 төгрөгөөр бөөнд нь энэ цэргийн ангид зардаг боллоо. Зөвлөлтийн цэргийн анги мах байхгүй учир маш дуртай авдаг боллоо. Оросууд

гахайн маханд дуртай шүү дээ. Монголд 1969 оноос эхлээд ЗХУ-ын цэргийн ангиуд байрлаж эхэлсэн юм. Ийм ангиуд олон газар байсан юм. Зөвлөлтийн цэргийн ангиуд манай Засгийн газрын хүсэлтээр орж ирсэн гэдэг юм. Тэдгээр ангиуд М.Горбачёвын “өөрчлөн байгуулалт”-ын давалгаан дор, 1989 онд Монголоос бүрмөсөн гарч дууссан юм.

Би Хар Хорины САА-д ирээд, бас нэг шинэ юм хийж сурлаа. Энэ бол монгол гутал юм. Энд дээр үед Эрдэнэ зуу гэдэг том хийд байсан юм. Монголын Бурхны шашны анхны том хийд юм шүү дээ. Бурхны шашин Монголын албан ёсны шашин болсон нь 16-р зууны төгсгөлийн үе гэж эрдэмтэд тэмдэглэдэг шүү дээ. Халхын Абтай сайн хаан Эрдэнэ зуу хийдийг анх байгуулах шийдвэрийг гаргасан юм гэнэ билээ. 20-р зууны эхэн үед Бурхны шашин Монголын нийгэмд аср их нөлөөлтэй болсон байлаа шүү дээ. Энэ үед Монголд 700 гаруй сүм, хийд үйл ажиллагаагаа явуулж байсан гэдэг юм. Тэдгээрт олон мянган лам нар шавьлан суудаг байж. Монгол айлын нэг хүүхэд нь заавал лам болж байсан гэдэг юм. 20-р зууны эхэн үед Эрдэнэ зуу хийдэд 1000 гаруй лам байсан юм билээ. 1937-38 оны “Их хэлмэгдүүлэлт”-ийн үед Дотоод яам эндхийн лам нарыг бүгдийг нь баривчлаад, буудаж алсан юм. Энэ үед зөвхөн Эрдэнэ зуу хийд ч биш Монголын бараг бүх сүм, хийдийг эвдэж нураагаад, шатаахыг нь шатаагаад, лам нарыг нь буудаж хороосон юм шүү дээ. Монголын ард түмний олон зууны туршид бүтээсэн соёлын өв ингэж устаж үгүй болох замдаа орсон юм. Коммунист үзэл суртал Монголд ийм аюултай зүйлүүдийг хийсэн юм шүү. Эрдэнэ зуу хийдийн лам нараас зарим нэг нь олон жил шоронд сууж байгаад, суллагдаж гарч ирсэн байдаг юм. Би Хар Хорины САА-д ирсний дараа тэдний заримыг нь таньдаг болсон юм. Тэд нар бол монгол гутлаас өөр гутал өмсөхгүй шүү дээ. Гэтэл монгол гутал хийж чаддаг хүн бараг байхгүй болсон байлаа. Лам байсан хүмүүсийн дотор монгол гутал хийж чаддаг хүн мэр, сэр байсан юм. Ингээд монгол гутал сайн хийдэг нэг өвгөнтэй би танилцаад, гутал хийдэг аргыг заалгалаа. Түүний хийсэн гутал чанартай сайн гутал байдаг тул сонирхсон хүн шууд авдаг юм байж.

Гутал оёх арга нь гөлөм оёхтой бараг ижил юм. Харин хийх арга нь арай өөр юм. Тэр хүн гутал хийх материалаа өөрөө олоод, хийсэн гутлаа өөрөө зардаг байсан юм. Энэ бол амархан ажил биш л дээ. Тэгээд би түүнд гутал хийх материалыг нь олж өгдөг боллоо. Гутал хийхэд булигаар, сарьс хоёр их ордог юм. Бас түүний хийсэн гутлыг зарах ажлыг нь хариуцдаг боллоо. Би их олон хүнтэй танил болохоор надад төвөгтэй биш ажил байсан. Ингээд нөгөө өвгөн, өөрийн эмгэнтэйгээ, манай эхнэр гутлаа оёдог боллоо. Би өрөө бас оёж сурлаа. Ингээд олон хүн оёхоор, гутлыг хурдан хийдэг болж байгаа юм. Бид нар сард нэг гутал хийдэг

боллоо. Монгол гутал хийнэ гэдэг чинь бас тийм амар ажил биш л дээ. Маш их ажиллагаа орно шүү дээ. Өвгөн сүүлдээ зөвхөн гутлаа эсгээд, улладаг ажлыг нь хийдэг болов. Бид нар бусад оёх ажлыг нь хийдэг боллоо. Ингээд сард 3-4 гутал хийдэг болж байгаа юм. Өөрөөр хэлбэл бид нар чинь хоршоолол маягийн юм болж байгаа юм. Өвгөн урьд нь ганцаараа хийдэг байсан бол одоо хамтраад, миний чадахгүй юмыг өвгөн хийгээд, өвгөний чадахгүй юмыг нь би хийдэг болсон юм. Ийм зохион байгуулалтанд орсон тул сард олон гутал хийх боломжтой болсон юм.

Тэр үед хоршоолол байгуулах асуудал хуулиар хориотой байсан юм шүү дээ. Хувийн үйлдвэрлэл явуулах нь хуулиар хориотой байсан юм. Хэрвээ ийм ажил хийвэл хуулиар шийтгэж, шоронд хийдэг байсан юм. Ингээд Хар Хорин, Хужирт гээд тэр хавийн сумдад монгол гутлаа зараад, байнгын орлоготой боллоо. Нэг гутлыг 3000 төгрөгөөр зарна шүү дээ. Гутал өмсөх сонирхолтой хүн нь нилээд байсан боловч түүнийг хийж чаддаг хүн нь ховорхон байсан юм.

Ийм маягаар би Хар Хоринд 5 жил амьдарлаа. Би хувьдаа суудлын машинтай, мотоцикльтэй, том хашаа, байшинтай байлаа. Бас олон малтай байлаа. Их чинээлэг амьдарч байлаа шүү дээ. Гэтэл энэ байдал тэр САА-н удирдлагад таалагдсангүй. Манай Хар Хорины САА-н дарга намайг энд ирсэн цагаас эхлээд хавчиж, дарамтлах бодлого барьж байсан юм. Тэр бол намайг юу хийж байгааг, яаж амьдарч байгааг дээш нь Дотоод яаманд байнга мэдээлж байсан биз. Тэгээд тэндээс надад яаж хандах талаар бас даалгавар авч байсан биз. Би түүнтэй зөөлөн харьцаагүй нь бас миний буруу ч байсан байж магадгүй. Би түүнтэй зохицоогүй, ширүүн харьцсан байж болох юм. Ингээд бид хоёрын хоорондын зөрчил их хурцадлаа. Тэр хүн бол “Эсэргүү Лоохууз”-ыг сайн харж, бас нэр хүнд олох гээд их чармайж байгаа шүү дээ. Би түүнийг нь сайн ойлгож байсан юм. Тэгээд тэр хүн энэ бодолдоо дийлдээд “Дамын наймаа хийдэг, хувийн үйлдвэрлэл явуулдаг!” гэсэн үндэслэл гаргаад, намайг шалгуулахаар прокурорт мэдэгдэл өгчээ. Энэ асуудал прокуророор дамжуулаад Ю.Цэдэнбалд хүрсэн байх. Ю.Цэдэнбал намайг шууд шийтгэх үүрэг өгсөн байх. Прокурор миний “хэрэг”-ийг хянаж үзлээ. Тэгээд “Үнэхээр хувийн үйлдвэрлэл явуулсан байна. Олон мал зарж, дамын наймаа хийсэн байна!” гэж үзжээ. Ингээд шүүхэд шилжүүлжээ.

19 Шоронд.

Ц Л: Шүүх намайг шоронд 6 жил хорих шийдвэр гаргасан юм. Би шүүх хуралд өмгөөлөгчгүй оров. Би өөрөө өөрийгөө өмгөөлөхөөр шийдсэн юм. “Ер нь намайг надаас өөр хэн сайн өмгөөлөх юм бэ?” гэж боддог байлаа.

Тэр үед манай шүүхийн практикт өмгөөлөгчийн үүрэг маш сул, бараг байхгүйтэй л адил байсан юм шүү дээ.

Тэгээд миний бүх хөрөнгийг шүүхийн шийдвэрээр хураалаа. Гэр, байшин, машин, мотоцикль, мал, гахай бүгдийг нь хурааж улсын орлого болголоо. Давж заалдах эрхгүйгээр хэрэг тасаллаа. Уг нь ямар ч хүн давж заалдах эрхтэй байдаг шүүдээ. Ингээд би Зүүн Хараа дахь Бэрлэгийн шоронд орсон юм. Тэнд очиход намайг бусад хоригдлуудтай хамт ажилд гаргадаггүй байлаа. Тэгээд цахилгаан ток гүйлгэсэн өргөст торны цаана байнга байдаг боллоо. Би ганцаараа тэр өргөст торны цаана 5 жил гаруй болсон юм. Бусад хоригдлууд бол гадагш гарч ажил хийнэ шүү дээ. Шоронгийн журам их хатуу байлаа. Хүнтэй уулзуулахгүй шүү дээ. Уулзах хэрэг гарвал уулзахаар ирсэн хүнийг судлана. Тэгсний дараа зөвшөөрөл өгнө. Энэ бол хатуу дэглэмтэй “улс төрийн хоригдол” болж таарч байгаа юм. Нэг удаа би шар өвчин туссан юм. Шоронгийн эмч нар намайг “Төвийн эмнэлэгт явуулж эмчлүүлэх хэрэгтэй!” гэж үзэж байсан юм. Тэгтэл дээрээс Дотоод яам зөвшөөрөөгүй юм. Энэ асуудалд Ю.Цэдэнбал оролцсон л байлгүй дээ. Би бол “улс төрийн хэрэг хийсэн” гэж албан ёсоор шийтгэгдээгүй ч гэсэн надад “улс төрийн хоригдол” маягаар хандаж байлаа шүү дээ.

Манайд баримтлаж мөрдөж байсан эрүүгийн хуулиудыг би маш сайн мэддэг байсан юм. Ер нь намайг шоронд хийх боломжийг их хайсан юм шүү дээ. Би өөрөө янз бүрийн ажил хийж байгаа учир “энэ ажлуудаар далимдуулаад, намайг шоронд хийж магадгүй !” гэж боддог байсан юм. Тэгээд би хуулиудийг сайн судлаж үзсэн юм. Прокурор намайг “Дамын наймаа хийсэн!” гэсэн дүгнэлт гаргаж байсан боловч би “дамын наймаа” огт хийгээгүй юм шүү дээ. Би өөрийнхөө хөдөлмөрөөр бүтээсэн зүйлүүдийг л зарж байсан юм. Хүмүүст миний хийсэн тэр зүйлүүд хэрэгтэй байсан юм. Тэдэнд тийм хэрэгтэй зүйлүүдийг авах өөр газар байгаагүй юм. Түүнийг хийж чаддаг өөр хүн ховор байсан юм. Би өөрөө хийсэн болохоор түүнд улсын тогтоосон үнэ байгаагүй юм. Би хүмүүстэй тохиролцоод нутгийн ханшаар зарж байсан юм. Үүнийг “дамын наймаа” гэж үзэх үндэс байхгүй юм. Манай хуулиар бол улсаас тогтоосон үнэтэй юмыг хүмүүст илүү үнээр зарсан бол “дамын наймаа” гэж үздэг юм. Би улсын тогтоосон үнэтэй юм зараагүй шүү дээ. Намайг “олон мал зарлаа!” гэж буруутгасан юм. Энэ хонийг чинь би өөрөө өсгөж олон болгосон юм. Би Улаанбаатараас нутаг заагдаад, цөлөгдөж энэ нутагт анх ирэхдээ нэг ч малгүй ирсэн шүү дээ. Би хүнээс олон хонь аваад, өөр хүнд ашиг гаргаж зараагүй юм. Би өөрөө хөдөлмөрлөж байж л хонио ийм олон болсон юм. Би өөрийнхээ амины малыг хэнд ч, хэдэн ч төгрөгөөр зарж болно шүү дээ. Ийм, ийм юмаар намайг хууль зөрчсөн гэж үзэх ямарч үндэс байгаагүй

юм. Би “Манайд одоо мөрдөгдөж байгаа хуулиар бол намайг шийтгэж чадахгүй юм байна!” гэж мэдэж байсан. Өөр хууль байгаагүй л юм даа.

Би Улаанбаатар хотын алдартай урьдчилан хорих төв Ганц худгийн шоронд далан зургаан хоног сууж байцаагдсан юм. Тэр Ганц худгийн шоронг Зүүн Герман улс барьж өгсөн юм. Дэлхийн 2-р дайны үед Герман олон шорон барьж их туршлага хуримтлуулсан байх л даа. Тэр туршлагыг нь Зүүн Герман улс өвлөж авсан байх. Освенцим, Бухенвалд гээд Германы фашистуудын барьсан алдартай, алдартай шоронгууд байсан шүү дээ. Фашистууд эдгээр шоронгууддаа олон хүнийг, ялангуяа еврей нарыг үй олноор нь шатааж алдаг байсан юм билээ. Манайд Зүүн Германы барьж өгсөн Ганц худгийн шорон тэдний хэмжээнд хүрэхгүй байсан байх л даа. Гэхдээ л хатуу шорон шүү дээ. Намайг Тогоонтөмөр гэдэг мөрдөн байцаагч шалгаж байсан юм. Би түүнтэй сүүлдээ танил болоод илэн далангүй ярьдаг боллоо. Тэр хүн: “Та бол улсын дэлгүүрийн сүлжээгээр зарж байсан улсаас тогтоосон хатуу үнэтэй барааг авч илүү үнээр зараагүй байна шүү дээ! Хэрвээ дэлгүүрийн барааг өндөр үнээр зарвал дамын наймаа болно шүү дээ!” гэж хэлж байсан юм. Мөрдөн байцаагч Тогоонтөмөр Өвөрхангай аймаг яваад, миний амьдарч байсан газруудаар очоод, шалгаж үзсэн байна. Олон хүнтэй уулзсан байна. Тэгээд “дамын наймаа” хийсэн баримт олоогүй байна л даа. Миний зарсан юм бол дандаа миний өөрийн хийсэн юмнууд байсныг тогтоосон байна. Бас миний зарсан мал бол өөр хүнийх биш, миний өөрийн мал гэдгийг тогтоосон байна. Ингээд намайг шийтгэх хуулийн заалт олсонгүй, мухардалд оржээ. Тэгээд байцаагч Тогоонтөмөр: “Таныг шийтгэж болохгүй юм байна. Шийтгэх хуулийн зүйл анги, байхгүй юм!” гэж хэлж байсан юм.

Тэгж байтал байдал гэнэт өөрчлөгдөөд явчихлаа. Дээрээс, Дотоод яамнаас намайг “Заавал шийтгэ!” гэсэн үүрэг даалгавар ирсэн байна. Одоо мөрдөж байгаа хуулийн зүйл, ангиар биш бүр дайны дараахан, 1945-1950 оны хооронд мөрдөж байсан, Сайд нарын Зөвлөлөөс гаргасан нэг тогтоол байсан юм байна. Тэр тогтоол сонин дээр тэр үед гарсан юм байж л дээ. Би түүнийг огт уншаагүй явсан юм байж. Тэр тогтоол нь “Импорт, экспортын бүтээгдэхүүнээр ямар нэгэн хэрэгцээний юм хийх, түүнийгээ худалдахыг хориглосугай!” гэсэн гол утга санаатай байсан юм байж. Тэр тогтоолоор бол булигар, сарьс хоёр импортын бараа болж таарч байгаа юм. Экспортын барааны тоонд малын арьс, шир цөм багтаж байгаа юм. Энэ тогтоолоор бол юм хийсэн хүн болгон шорон орохоор байгаа юм. Энэ чинь Монгол хүнийг л юм хийхийг нь хориглосон гэсэн үг шүү дээ. Ийм маш харгис тогтоол гарч байсан юм байна л даа. Тэгээд мөрдөхөө аль эрт больсон энэ харгис тогтоолыг олоод, дахин гаргаж ирээд, намайг шийтгэж байгаа юм. Энэ бас их шударга биш юм болж

байгаа юм шүү дээ. Одоо мөрдөгдөхөө больсон, хаа хамаагүй мартагдсан, тийм тогтоолыг олж ирээд шийтгэж байгаа юм. Ингээд давж заалдах эрхгүйгээр шийтгэж байгаа юм. Ингэж би шоронд орохоос өөр арга байхгүй болсон юм.

Би шоронд байхдаа орих ангийн тогооч боллоо. Зарим үед сувилагч болж ч үзлээ. Хоригдлууд өвчин тусвал би тариа хийж өгдөг байсан юм. Манай хорих анги бол дандаа мод хийдэг байсан юм. Мод огтлоод, гуалин бэлтгэнэ дээ. Их хүнд ажил шүү дээ. Шоронд байх хугацаагаа ашигтай өнгөрөөх гэж би их боддог байлаа. Сангийн яамны орлогч сайд байсан Д.Тангад гэдэг хүн миний бүл дүү юм. МАХН-ын ТХ-ны 6-р Бүгд хурлын дараа түүнийг “Эсэргүү Лоохуузын хамсаатан” гээд ажлаас нь халж, МАХН-ын гишүүнээс хөөсөн юм. Ер нь тэр үед “Ц.Лоохууз, Б.Нямбуу, нарын намын эсрэг бүлгийн хань хамсаатан!” гэж олон сайхан хүнийг ажил, амьдралгүй болгосон юм шүү дээ.

Бидний хэрэгт маш олон хүн хамрагдсан юм. Монголын нийгмийг бүхэлд нь донсолгосон их халаа, сэлгээ явагдсан юм. Ямар ч гэмгүй байж, зөвхөн надтай танил байсныхаа төлөө “Эсэргүү Лоохуузын хань, хамсаатан” гэж гүтгэгдээд, МАХН-ын гишүүнээс хөөгдөж, ажлаасаа халагдаж, амьдралаараа хохирсон хүн олон байсан юм. Д.Тангад Зүүн хараагийн төмөр замын модны үйлдвэрийн даргаар ажиллаж байсан юм. Тэр үйлдвэрт орос мэргэжилтнүүд их байсан юм л даа. Ойрхон учир Д.Тангад над дээр байнга ирдэг байлаа. Тэр надад ЗХУ-ын хэвлэлүүд, унших ном авч ирж өгдөг байлаа. Би тэр хэвлэл, номуудыг байнга уншдаг байлаа. Би өөрөө бас транзистор радиотой байсан юм. Түүнийгээ байнга чагнадаг байлаа. Ийм маягаар таван жил боллоо.

Надтай хамт дандаа хууль зөрчсөн эрүүгийн гэмт хүнд хэрэгтнүүд хоригдож байсан юм. Надтай ижил хуулиар шийтгэгдсэн хүн байгаагүй юм. Байх ч үндэсгүй юм. Ийм хуулиар ганцхан намайг л шийтгэсэн юм л даа.

Би тэгээд үе, үе хоригдлуудад “Шинжлэх ухаан, техникийн ололт амжилт” гэсэн сэдвээр яриа хийж өгдөг байлаа. Хоригдлууд түүнийг сонсох дуртай байдаг юм. Тэд нар их ядардаг юм л даа. Тэгээд хоолонд орсны дараа би яриагаа хийх цагийн хуваарьтай байсан юм. Хоригдлууд ядарч байсан ч гэсэн миний яриаг чагнах дуртай байсан юм. Би хоригдлуудын ядаргааг тайлах хоол, ундыг өөрөө санаачлаж их хийдэг байлаа. “Хярамцаг” гэж сайхан юм байдгийг та нар мэдэх байх. Түүнийг шар будаатай холиход их сайхан хоол болдог юм. Хоригдлууд идэх их дуртай байсан юм. Ядарсан хоригдлуудад ийм хоол өгөхөөр ядаргаа нь амархан тайлагддаг юм. Ерөө гол загас ихтэй шүү дээ. Намар бид нар загас их барьдаг байлаа. Том, том тулнуудыг Ерөө голоос шуудай,

шуудайгаар нь барина шүү дээ. Би хорих ангийн гал тогооны шалан доогуур нүхэн зоорь хийсэн юм. Тэндээ загасаа хадгалдаг байлаа. Их ядарсан хоригдлуудад загасны шөл өгнө. “Ядарсан үед загас ядаргаа сайн тайлдаг!” гэж монголчууд ярьдаг шүү дээ. Тогооч хүнд ном унших цаг байдаг юм. Янз бүрийн хоол хийх аргын талаар ном захиж авчруулдаг байлаа. Тэгээд тэдгээр хоолнуудыг өөрөө хийгээд сурчихна шүү дээ.

Би шоронд байхдаа ном уншиж хоол хийхээс гадна бөгж хийдэг байсан юм. Хоолны халбага сэрээг зэвэрдэггүй гангаар хийдэг юм. Бас хоёрдугаар хоолны тавагийг ийм материалаар хийдэг юм. Манай хорих ангид халбага, сэрээ, таваг их гэмтэж хэрэгцээнээс гардаг байсан юм. Ингэж хэрэгцээнээс гарсныг нь байсхийгээд актлаад, хаядаг байлаа. Би ингэж хэрэгцээнээс гарч, актлагдсан халбага, сэрээнүүдийг хаяхаас нь өмнө авдаг байв. Ингээд тэр зэвэрдэггүй гангаар нь бөгж хийдэг болсон юм. Би төмрийн хайч, гагнуурын алх, гагнуур хийхэд хэрэгтэй кислота, цагаан тугалга зэргийг захиад авсан юм. Ингээд хайчаараа хайчлаад бөгжөө эсгэчихнэ. Түүний яг дээр нь хоёр хунгийн дүрс гаргана. Тэр хоёр хүзүүгээрээ нийлсэн байна шүү дээ. Цэнхэр фоноор шигтгээ хийнэ. Зэвэрдэггүй ганг өнгө оруулахаар шил шиг тунгалаг, хаанаас нь харсан ч нүүр харагдахаар болдог юм. Ийм бөгж хийж байлаа. Түүнийгээ 25 төгрөгөөр зардаг боллоо. Шоронд хоригдож байгаад, хугацаа нь дуусаад, суллагдаад гарч байгаа хүмүүс миний хийсэн бөгжийг авдаг байлаа.

Хоригдлууд цалин авдаг шүү дээ. Сайн ажиллавал мөнгө их авна. Тэгээд хоригдлуудаас надад бөгжний захиалга ирдэг боллоо. Тэр хорих ангийн харгалзагч нар бас миний хийсэн бөгжийг авдаг боллоо. Ингэж би шоронд байсан ч мөнгөөр тасрахгүй боллоо. Манай эхнэрт жилд хоёр удаа надтай уулзах зөвшөөрөл өгдөг байсан юм. Тэр хоёр хүүхдээ хөтлөөд жилд хоёр удаа ирдэг байлаа. Надад өөр хүнтэй уулзах зөвшөөрөл өгдөггүй байсан юм. Би эхнэрээ ирэх болгонд нь 1000 төгрөг өгдөг байлаа.

КЮ: Таныг Бэрлэгийн шоронд хоригдож байхад танай эхнэр, хүүхдүүд чинь хаана амьдарч байсан юм бэ?

Ц Л: МАХН-ын 6-р бүгд хурал дээр би МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн даргын хувийн дутагдал, алдаатай бодлогыг нь шүүмжлээд, “намаас арга хэмжээ авхуулж” цөллөгт явсан энэ шийтгэл миний нэр дээр гарсан боловч хамгийн их зовсон, амьдралаараа хохирсон хүмүүс бол манай эхнэр, хүүхдүүд юм шүү дээ. Энэ бүх хугацаанд тэд нар л хамгийн их зовж, тэд нарын амьдрал л хамгийн их хохирсон юм. Би бол зовоогүй, юугаар ч хохироогүй юм. Миний эрх чөлөө хязгаарлагдмал, Дотоод

ямны байнгын хяналт, дарамтанд байсан боловч би ард түмнийхээ дунд амьдарч явсан. Намайг шийтгэх шийдвэрийг шүүхээс гаргаад, манай эд хөрөнгийг бүгдийг нь хураасан гэж би хэлсэн шүү дээ. Ийм учир манай эхнэр, хүүхдүүд Улаанбаатар хотод ирээд, дахин хашаа байшин авсан юм.

Хүүхдүүдээ Улаанбаатар хотод сургуульд оруулах хэрэгтэй байсан юм. Том хүү аравдугаар анги төгслөө. Би шоронд орохоосоо өмнө МАХН-ын ТХ-ны Хянан Шалгах Хорооноос хүүхэддээ дээд сургуульд суралцах “зөвшөөрөл” авч өгсөн. Тэр үед миний хүүхдийг жирийн хүүхдээс онцгой үздэг байлаа шүү дээ. “Эсэргүү Лоохууз”-ын хүүхдүүд жирийн хүний хүүхэд шиг дээд сургуульд орж болохгүй, хориотой байсан юм. Тэгээд би хүүхдээ дээд сургуульд оруулах гэж МАХН-ын ТХ-ны Хянан Шалгах Хороо хүртэл явсан юм. Тэнд надад хүүхдээ дээд сургуульд суралцуулах “зөвшөөрөл” өгсөн юм. Болгар улсын Цэргийн барилгын сургуульд явах зөвшөөрөл өгсөн юм. Тэр үед “эсэргүү Лоохууз”-ын талаар Дотоод Яаманд мэдээлэл өгч, нэр хүнд олж авах гэж манай МАХН гишүүд болон төрийн албан хаагчид их өрсөлддөг байлаа шүү дээ. Тэд нарыг ийм болтол нь дампууруулсан юм. Тийм хүмүүс миний хүүхдийг сургуульд явуулаагүй юм. “Эсэргүү Лоохууз”-ын хүүхдийг сургуульд явуулахаас нэг хэсэг нь айгаад, нэг хэсэг нь нэр хүнд олох гэж гүйгээд, тэгээд үүний золиос болоод миний хүүхэд сургуульгүй хоцорч байлаа. “Эсэргүү Лоохууз”-ын хүүхдийг дээд сургуульд оруулбал нэг хэсэг нь түүний “хань, хамсаатан” гэж үнэхээр хардагдах аюултай байсан юм. Дотоод яамны нэг ийм хардалтанд орвол тэр хүний амьдрал, хувь заяа тэгээд дуусгавар болсонтой ижил юм. Тийм учраас нэг хэсэг нь үнэхээр надтай холбогдохоос айж байсан юм. Ингээд миний хүү сургуульд явж чадалгүй, цэргийн албанд татагдаад, цэрэгт явсан юм. Цэргийн хугацаат албаа хааж дуусгаад халагдаад ирлээ. Тэгээд Улаанбаатар хотын 3-р цахилгаан станцд ажилчин болсон юм. Тэнд 20 орчим жил ажилласан даа.

Монгол улсын Үндсэн хуулиаар 16 нас хүрсэн Монгол хүн бүр иргэний паспорт авах эрхтэй байдаг юм. Гэтэл манай хүүхдүүдэд ерөөсөө иргэний паспорт өгдөггүй байлаа шүү дээ. 16 нас хүрсэн ч иргэний паспорт өгөөгүй юм. Нэг охин маань их сурлага сайтай хүүхэд байсан юм. 10-р ангиа төгслөө. Шалгалтын дүнгээр бол гадаадын сургуульд явах боломжтой болсон юм. Шалгалтын комисс бас тийм шийдвэр гаргалаа. Гэтэл иргэний паспорт байдаггүй. Иргэний паспортгүй бол гадаад паспорт авч чадахгүй шүү дээ. Тэгээд манай эхнэр багш нартай нь нийлээд нэг арга бодож олжээ. Тэд нар манай хүүхдийн төрсний гэрчилгээнээс нь эхлээд бүх бичиг баримтыг нь өөрчлөхөөр шийдсэн байна. Энэ бол маш хэцүү ажил шүү дээ. Бараг бүтэхгүй ажил. Тэгээд багш нар нь хамжсан болохоор шинэ бичиг баримт авахаар болсон байна. Түүндээ овгоо сольж

бичсэн байна. Ингээд өөр овогтой болж байж сая гадаад паспорт авсан юм. Ингээд ЗХУ-ын Украины Львов хотод Улсын их сургуульд геологийн мэргэжлээр суралцаад, төгсөөд ирсэн юм. Ингэж миний охин нууцаар сургуульд явж төгссөн юм.

Энэ охиноос бусад нь дээд сургуульд орж чадаагүй юм шүү дээ. Охин төгсөж ирээд геологийн ажлаар хөдөө их явдаг байлаа. Сүүлдээ гэр бүлтэй болоод, хүүхэдтэй боллоо. Одоо хувиараа хөдөлмөр эрхлэгч болсон. Тэр охин одоо 4 хүүхэдтэй. Түрүүчийн хүүхдүүд нь Монгол Улсын Их сургуулийг төгсөх болж байна. Дараачийн хоёр хүүхэд нь бас дээд сургуульд дөнгөж ороод байна. Хувийн сургуульд Япон, Англи хэл үзэж байгаа юм. Нэг хүү нь миний дархан, мужааны ажлыг өвлөж авсан. Их сайн хийдэг болсон. Монгол гутал сайн хийнэ шүү. Бас цагаан мөнгөөр их юм хийнэ шүү.

И Л: Та Бэрлэгийн шоронгоос хэдэн онд гарсан бэ?

Ц Л: Би шоронгоос 1982 онд гарч ирсэн. Шоронгоос гарахдаа би “Шорон доромжилсон хэрэг”-т орж бараг л дахин шоронд орох дээрээ тулсан нэг явдал болов. Энд нэг ийм юм болсон юм. Би шоронгоос суллагдах дөхөөд ирэх үедээ гэрийнхэндээ “Надад минжин малгай, даавуун дээл, угалзтай монгол гутлыг минь авч ирээрэй!” гэж захидаг байв. Тэд нар ч миний хүслээр сайхан өвлийн минжин малгай, битүү угалзтай монгол гутал, герман даавуугаар хийсэн дээл авч иржээ. Би түүнийгээ өмсөөд шоронд хамт байсан хүмүүсээ хоёр өдөр тарган хонины мах, сайхан хоолоор ханаж, цадтал дайллаа. Тэгээд тэдэнтэйгээ салах ёс гүйцэтгээд л шоронгийн дарга нарт “баяртай” гэж хэлээд л яваад өглөө.

Гэтэл удалгүй “Лоохууз Монголд байхгүй үнэтэй малгай, угазтай монгол гутал, дээл өмсөж, хоригдлуудыг хоол хүнсээр дайлж, баян тансагаараа гайхуулж, социалист шоронг доромжилсон!” гэсэн яриа гарч, том хэрэг боссон юм байх аа. Ийм яриаг чухам хэн гаргасан юм бэ? Бүү мэд. Минжин малгай, битүү угалзтай монгол гутал, герман даавуун дээл гурав бол Монголд байхгүй ховор, их үнэтэй зүйлүүд гэдэг нь ч үнэн л дээ. Тэр үед шоронд байтугай, гадуур чөлөөтэй яваа, сайд даргын ажил хийж байгаа хүмүүс хүртэл олж хэрэглэж чаддаггүй тансаг зүйлүүд байв. “Санаа байвч сачий нь хүрэхгүй!” гэж нэг үг монголд бий дээ. Энэ яриа яахав дээ, тэгээд дарагдсан л даа. Гэхдээ болгоомжлох зүйл мөн гэдгийг би дахин мэдэрсэн юм.

Би шоронгоос гараад шууд Улаанбаатарт ирж чадаагүй юм. Анх намайг шийтгэсэн шүүхийн тогтоол “Шоронгоос суллагдсаны дараа Хар Хоринд 3 жил сууна!” гэсэн заалттай байсан юм. Энэ яах аргагүй улс

төрийн агуулгатай зүйл юм шүү дээ. Намайг Дотоод ямаар дамжуулан Ю.Цэдэнбалд хов хүргэж, шоронд явуулсан Хар Хорины САА-н дарга, намайг шоронд орсны дараа их том шагнал авчээ. Ю.Цэдэнбал түүнд “Монгол улсын хөдөлмөрийн баатар” цол олгосон байгаа юм. Намайг шоронгоос гарч ирэхэд, тэр дарга надаас их айсан байх. Тэр хүн “Би Лоохуузыг Хар Хоринд хүлээж авахгүй!” гэж татгалзсан юм. Тэгээд манай Дотоод яам шүүхийн шийдвэрийг гэнэт өөрчлөөд намайг Хөвсгөл аймаг явуулахаар шийдсэн юм. “Шүүхийн шийдвэрийг дураараа өөрчилж болохгүй!” гэж би эсэргүүцсэн боловч дийлсэнгүй.

Ингээд Хөвсгөл аймаг явахаар боллоо. Хөвсгөл аймагт Дархадын хотгор гэдэг газар очлоо. Энэ чинь Хөвсгөл аймгийн Баянзүрх сум юм. Сэлэнгэ мөрний эх шүү дээ. Тэнд би туслах аж ахуйн бригадын дарга гэдэг ажилтай боллоо. Энэ бол гуанз, зочид буудал, модны ажил хийж сумын төсөвт орлого оруулах ажил юм. Тэнд би ганцаараа 3 жил болсон юм. Энэ хооронд манай гэр бүлийнхэн Улаанбаатар хотод амьдарч байсан юм. Би амралтаа аваад хотод ирдэг байлаа. Манайхан над дээр очно. Ийм маягаар 3 жил боллоо.

Би тэнд Хөвсгөлийн хүмүүстэй их сайхан танил боллоо. Энд дархад ястан амьдардаг юм шүү дээ. Эндхийн ард түмэн бол сайхан зантай, их ажилсаг хүмүүс шүү дээ. Сайхан яриа хөөрөөтэй, их шогч хүмүүс юм. Дээр үеийн Монгол ёс заншлаа сайн мэддэг, сайхан хадгалсан тийм нутаг юм даа. Энэ нутаг их уулархаг учир сарлаг ихтэй. Цагаан идээ сайтай, их ч хийнэ дээ. Мужааны ажил сайн хийдэг, модоор сийлбэр их хийнэ. Бүх эрчүүд нь бүгд мужааны ажил хийнэ.

Би тэнд 12 хүний нийтийн халуун усны газар байгууллаа. Японы “Хонда” мотороор усаа халаадаг боллоо. Югославид хийсэн шүршүүрүүд тавьчихлаа. Бас хөрөө рам гэдэг жижиг мужааны цех байгуулсан юм. Тосонцэнгэлийн модны үйлдвэрт хийж байсан ширээ сандлын зургаар ширээ, сандлыг тэр хавийн сумдын дунд сургууль, эмнэлэг, соёлын ордны захиалгаар хийж өгдөг боллоо. Тийм модон эдлэлүүдийг хийж өгөхөөр их өндөр үнээр авдаг байлаа. Тэгээд Баянзүрх сумынхаа төсөвт их орлого оруулдаг боллоо. Тэнд шинэлэг юмнуудыг олныг нэвтрүүллээ. Сумандаа их нэр хүндтэй боллоо.

Тэгж байтал 1985 онтой золголоо. Миний бүрэн суллагдах хугацаа боллоо. Энэ үед Дотоод яам дахиад намайг оролдож эхэлсэн юм. Тэд нар надад Хөвсгөлийн паспорт өгөх гэж оролдож байлаа. Хэрвээ би Хөвсгөлд паспорт авбал хотод амьдарч чадахгүй болно шүү дээ. Тэр үед хөдөөний хүнийг хотод орж амьдрахыг зөвшөөрдөггүй байсан юм. Хэрвээ хүн хөдөөнөөс хотод орж ирээд амьдарахаар шийдсэн бол “тусгай зөвшөөрөл” авдаг журамтай байсан юм. МАХН хүн, амын шилжин суух хөдөлгөөнийг

хатуу хянадаг байлаа шүү дээ. Чанга дэглэмтэй байсан юм шүү дээ. Хөдөөний хүн хотод бол ямар ч бичиг баримтгүй нууцаар л амьдрахаас өөр аргагүй байлаа шүү дээ. Тэгээд би ийм үйл ажиллагаа явагдаад байгааг эсэргүүцээд байлаа. “Миний хаана амьдрах нь миний өөрийн эрх. Одоо та нар надад заахгүй. Би хаана амьдархаа өөрөө шийднэ!” гэж хэлээд байлаа. Ингэж тэмцээр байгаад цөллөгийн хугацаа дуусаад Улаанбаатарт ирлээ.

Гэтэл Улаанбаатарт амьдрах “зөвшөөрөл” бас өгдөггүй. Тэр үед МАХН ын ерөнхий нарийн бичгийн даргаар Ж.Батмөнх, СнЗ-ийн даргаар Д.Содном ажиллаж байсан юм. Тэд нар намайг “Заавал хөдөө амьдар!” гээд байсан юм. Тэгэхээр нь “Би ганцаараа хөдөө явж амьдарна. Миний эхнэр хүүхэд Улаанбаатарт амьдарна!” гэсэн нөхцөл тавилаа. Надаас болоод тэдний хэн нь ч иргэний паспорт байхгүй байлаа шүү дээ. Гэтэл энэ нөхцөлийг бас зөвшөөрөөгүй юм. Тэгээд эхнэр бид хоёр ийм байдлаас гарах гарцын талаар ярилаа. Тэгээд “Гэрлэлтээ албан ёсоор цуцлуулаад, хүүхдүүдээ эхнэртээ шилжүүлбэ!” гэж шийдлээ. Ингээд бид хоёрын гэрлэлтийг албан ёсоор цуцлаж өгөх хүсэлт тавьсан өргөдлийг шүүхэд гаргалаа. Гэтэл шүүх гэрлэлтийг цуцлаж өгөхгүй их удлаа. Үнэхээр салж байна уу? Үгүй юу? гэдгийг судлаж байсан юм болов уу даа. Цаанаа бас өөр зорилго ч байсан байж болох юм. Тэгээд бид хоёр “Үнэхээр салж байна!” гэж л ярьж, тайлбарласаар байгаад арай гэж гэрлэлтээ цуцлууллаа. Тэгээд шүүхийн тогтоолоор бүх хүүхдийг авгайд шилжүүлээ. Үүний дараа би Дотоод яаманд Говь-Алтай аймгийн Чандмань суманд суух хүсэлтэй байгаагаа хэллээ. Миний энэ хүсэлтийг Дотоод яам шууд зөвшөөрлөө. Ингээд би 1985 оны эцсээр өөрийн төрсөн Чандмань суманд дахин ирсэн юм. Тэгээд тэнд ганцаараа амьдарч байлаа.

Мал маллах, мөнгө олох аргыг мэддэг байсан болохоор тэнд очоод малтай боллоо, мөнгөтэй ч боллоо. Тэр үед би Монгол дээлийн мөнгөн товч хийж байсан юм. Тэр нутагт дээлийн мөнгөн товч хийдэг хүн бас л байгаагүй юм. Гэхдээ хэрэглэх сонирхолтой хүн нилээд байсан юм шүү дээ. Ингээд хүмүүс надаас мөнгөн товч авахаар ирдэг боллоо. Бас олон захиалга ирдэг болов. Тэр үед би хонины нэхийгээр гутал хийдэг аргыг сурсан байсан юм. Хонины нэхийгээр хийгээд модны будгаар буддаг юм. Би өөрөө нэг тийм гутал өмсөөд Улаанбаатараас ирсэн чинь хүмүүс их сонирхож байна. Тэгээд түүнийгээ дахиж хийгээд сонирхсон хүмүүст өгдөг боллоо. Хүмүүс түүнийг 250 төгрөгөөр авдаг боллоо. Ингээд мөнгөөр дутагдах зүйлгүй боллоо. Малынхаа тоог өөрийн маллаж чадах хэмжээнд тогтоочихно шүү дээ. Ийм байдлаар амьдраад хотод байгаа эхнэр хүүхэддээ өвлийн идэш, цагаан идээ, мөнгө, төгрөг өгч явуулдаг боллоо.

Ингэж байтал 1985 онд ЗХУ-д М.С.Горбачёвын “Өөрчлөн

байгуулалт” эхэллээ. Би сонин, хэвлэл их захиалдаг, мэдээ, мэдээллийг сайн уншдаг, сонсдог байлаа. Тэгээд “Бидний амьдралд томоохон өөрчлөлт орох гэж байна!” гэдгийг мэдэрч эхэлсэн юм. Манайд өөрчлөн байгуулалтын анхны шуурга шуурч эхэллээ. Ингээд 1989 онд Улаанбаатар хотод эргэн ирсэн юм.

20 Хорин жилийн дараа Ю. Цэдэнбалыг халжээ.

И Л: 1984 оны 8-р сард хуралдсан МАХН-ын ТХ-ны 8-р Бүгд хурал МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбалыг бүх албан тушаалаас нь халах шийдвэр гаргаж байхад та Хөвсгөл аймагт байсан юм байна шүү дээ. Энэ Бүгд хурлын мэдээг яаж сонсов.

Ц Л: Би тэр үед туслах аж ахуйн бригадын дарга гэдэг ажилтай байлаа шүү дээ. Манай бригадынхан их сайхан хүмүүс байсан юм. Их сайхан яриа хөөрөөтэй, наргианч зантай хүмүүс л дээ. Тэгээд нэг өдөр ажлынхаа байранд ороод ирсэн чинь манайхан хоёр талаар эгнээд зогсчихсон, алга ташаад, надад баяр хүргээд гар бариад л байна. Би эхлээд юу болж байгааг нь мэдсэнгүй.

-Та нар юу болоод надад баяр хүргээд байна аа? гэж гайхаж асуулаа.

Тэгтэл:

-За таны нөгөө яриад байдаг Ю.Цэдэнбалыг ажлаас нь халсан байна шүү дээ! гэж байна. Би жаахан болгоомжиллоо. Манайхан дотор бас намайг тагнадаг нууц мэдээлэгч байгаа шүү дээ. Тэдний явуулга ч байж болно шүү дээ. Тэгээд өөрөө радиогоор Бүгд хурлын албан ёсны мэдээ сонслоо. Ю.Цэдэнбалыг бүх албан тушаалаас халсан байна. МАХН-ын ерөнхий нарийн бичгийн дарга Ж.Батмөнх болсон байна. Тэгээд бага сургуульд сурч байх үедээ тогтоосон нэг үгийг саналаа. Нэг дээр нэгийг нэм хоёр л болно шүү дээ. Харин нэмэгдэхүүний байрыг нь сольсон ч тэр бол хоёр л байна шүү дээ. “Ю.Цэдэнбалдын оронд Ж.Батмөнх болоод онцын өөрчлөлт гарахгүй! Гэхдээ яахав ээ. Ю.Цэдэнбалыг ажлаас нь халсныг бол тэмдэглэхчье. Шампанск аваад ир!” гэж нөхдүүддээ хэллээ. Манай бригадын нэг нөхөр гарч гүйгээд, сумын төвийн дэлгүүрээс нэг шил шампанск авч ирлээ л дээ. Ингээд нөгөөхөө задлаад бригадынхантайгаа хувааж уулаа.

Ингэж Ю.Цэдэнбалыг түүний өөрөө буй болгосон “тойрон хүрээлэгч” нар нь бүх албан тушаалаас нь халсныг мэдсэн юм. Ийм юм хэзээ нэгэн цагт болно гэдгийг би мэдэж байсан. 1964 оны бүгд хурал дээр үг хэлэхдээ, би бас энэ санаагаа хэлж байсан юм шүү дээ. Энэ бол дэндүү оройтсон шийдвэр байсан юм. Ю.Цэдэнбалыг ажлаас нь халсан тухай мэдээг

сонссон хөдөөгийн хүмүүс сонсоод харамссан юм ерөөсөө ажиглагдаагүй. Ажил амьдралд нь ямарч өөрчлөлт ороогүй юм. Х.Чойбалсанг нас барахад байдал их өөр байсан юм шүү. “Улс орныг удирдах хүнгүй боллоо!” гэж олон хүн харамсаж байсан юм. Манай монголчуудад нэг сайхан зан бий. Нэг зүйлийг харж байгаад яг зөв дүгнэлт хийдэг. Тэгээд энэ дүгнэлтээ тэр болгон ил гаргаад байдаггүй юм. Яг хэрэгтэй үед л гаргадаг юм. Дүгнэхдээ бол яг л зөв дүгнэнэ шүү дээ.

1985 онд манай хүүхдийг паспортгүй гэдэг шалтгаанаар ажлаас нь халж байсан юм. Эхнэр бас паспортгүй гэдэг шалтгаанаар ажлаасаа халагдаж байлаа. Би 1989 онд Улаанбаатарт буцаж ирээд, өөрийнхээ жижиг гэрийг бариад дарханы ажил жаахан хийлээ. Нөгөө цутгуурын дархан шүү дээ. Хийхэд амар ажил л даа. Бурхны хэрэглэл, зулын цөгц, бурхан, хүрд, сангийн бойпор зэргийг хийдэг байсан юм. Ийм зүйлүүдийг зочид буудлуудад тавибал гүйлгээ сайтай байдаг юм. Нэгийг нь 50-100 төгрөгөөр зардаг байлаа. Иймэрхүү маягаар амьдарч байтал 1990 онтой золголоо. Ардчилсан хөдөлгөөн үүслээ.

1990 оны 3-р сарын эхээр Ардчилсан хөдөлгөөний хэсэг залуучууд Сүхбаатарын талбайд өлсгөлөн зарлалаа. Эдний тавьсан шаардлагаар 3-р сарын хоёрдугаар хагаст МАХН-ын ТХ-ны УТТ бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорлоо. Ардчилсан хөдөлгөөний шахалт, шаардлагаар төр, засаг ингэж өөрчлөгдөж эхэлсэн юм. Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга, Сайд нарын Зөвлөлийн дарга нар өөрчлөгдөж, Засгийн газар огцорлоо. Ингээд шинээр байгуулагдсан Ардын Их хурлын Тэргүүлэгчид Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, түүний үндсэн дээр Ардын Их Хурлын сонгуулийн товыг зарлалаа. Энэ сонгуулиар Ардын Их Хурлын депутатад бидний нэрийг дэвшүүллээ.

Тэр үед Ардын Их Хурлын депутатад нэрээ дэвшүүлэх санал надад 4 газраас ирсэн юм. Би Говь-Алтай аймгийг сонгож авлаа. Ардын Их хурлын сонгууль товлосон ёсоороо 1990 оны 7-р сарын 29-ний өдөр амжилттай болж өнгөрлөө. Энэ бол Монгол улсын анхны ардчилсан сонгууль байсан юм. Би өөрийн тойрогтоо ялалт байгууллаа. Би Ардын Их хурлын депутат боллоо. Ингэж би 25 жилийн дараа улс орныхоо улс төрийн амьдралд дахин оролцож эхэлсэн юм. Энэ хооронд их юм өөрчлөгдсөн байлаа.

КЮ: МАХН-ын шийтгэлийг яасан бэ?

Ц Л: 1990 оны 3-р сард МАХН-ын Онц их хурал хуралдсан юм. Тэр Их хурлаар Д.Төмөр-Очирын “Намын эсрэг үйл ажиллагаа” болон “Ц.Лоохууз, Б.Нямбуу, Б.Сурмаажав нарын намын эсрэг бүлэглэсэн

явуулга”-ын хэрэгт холбогдсон хүмүүсийг бүгдийг нь цагаатгасан юм. МАХН-ын гишүүнчлэлийг нь дахин сэргээж өгсөн юм. Тэр үед бас Монгол улсын Дээд шүүхийн бүгд хурал хуралдаж намайг шийтгэсэн шүүхийн тогтоолыг хүчингүй болгож, намайг цагаатгалаа. Тэгээд бидэнд улс төрийн хилс хэргээр хэлмэгдсэний нөхөн олговор өгсөн юм. Бас намайг шүүхээр шийтгэж, хурааж авсан эд, хөрөнгийг прокурорын шийдвэрээр дахин үнэлээд эргүүлэн төлж өгөхөөр болсон юм. Намайг шүүхээр шийтгэж, хурааж авсан эд хөрөнгийг бүгдийг нь үнэлээд зарсан юм билээ. Миний машины үнийг маш их бууруулж 6.000 төгрөгөөр зарсан байдаг юм. Энэ бол хуулийнхан өөрсдөө хууль зөрчсөн хэрэг юм л даа. Тэдний танил тал нь хямд авсан байх. Бас 3 дугуйтай “Урал” мотоциклийг маань нэг мянган төгрөгөөр зарсан байгаа юм. Ер нь тэр үед төрийн албан хаагчид ихээхэн моралийн эвдрэлд орсон байсан юм даа. Өөрийн хариуцаж байгаа төрийн ажил албыг үнэнчээр гүйцэтгэдэг хүн цөөхөн болсон юм. Голдуу танил тал, ах дүү, нутаг ус, төрөл садангийн шугамаар төрийн албанд орсон байдаг нь үүний гол шалтгаан нь болж байсан юм. Надаас хураагдсан бүх зүйлийг прокурорын шийдвэрээр дахин үнэлээд, төлж өгсөн юм.

И Л: Саяхан болтол хүмүүсийн дунд яригддаг нэг сонин яриа байдаг л даа. Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн нэгдүгээр орлогч дарга С.Лувсан гуайг Өвөрхангай аймагт очиход нь “Эсэргүү Лоохууз” бүр нударган баян болчихсон, маш үнэтэй 3 дугуйтай мотоцикль уначихсан, замыг нь тосон очиж уулзсан гэнээ!” гэсэн яриа байдаг байх аа.

Ц Л: МАХН-ын түүхэнд “нударган баян” гэсэн нэр томъёо байдаг юм. Энэ бол 1950-аад оны сүүлчээр, ард түмний өмч болсон малыг нийгэмчилж ХАА-н нэгдлүүдийг байгуулах үеэр гарсан нэр томъёо юм. Тэр үед өмч, хөрөнгө сайтай чинээлэг иргэдийг нударган баян гэж нэрлэдэг болсон юм. Тэд нар өөрийн өмч, хөрөнгө болсон малаа нийгэмчлэхийг хүчтэй эсэргүүцэж байсан юм. Тийм учраас тэднийг ингэж нэрлээд, тэдний эсэргүүцлийг дарах тусгай бодлого явуулсан юм. Би тэр үед өөрийн өмч хөрөнгө сайтай, олон малтай байсан шүү дээ. Энэ байдал олон хүний дургүйг хүргэж, нударган баян шиг харагдаж байсан байж болох юм. Ард түмэн бол нударган баянд дургүй байгаагүй юм шүү дээ. Эд нар чинь өөрсдийн хүч, хөдөлмөрөөр л өөрийн өмч, хөрөнгийг бий болгосон, нэг үгээр хэлбэл ажил хийж чаддаг, аливаа юмны эвийг нь олж чаддаг, өөрсдөө бодож, сэтгэж чаддаг л хүмүүс шүү дээ. Ажил хийхгүй залхуураад, юмны эвийг олохгүй муйхарлаад л байвал өмч, хөрөнгө өөрөө бий болохгүй шүү дээ. Хаана ч, хэзээ ч ийм л байдаг шүү дээ. Миний уулзсан

хүн бол С.Лувсан биш л дээ. Би Дундговьд явж байгаад Цагаанламын Дүгэрсүрэнгэй уулзсан юм. Ер нь тэр үед албаны хүмүүс надтай уулзахаас бүгд айдаг байсан юм. Надтай уулзвал “Эсэргүү Лоохуузын хань хамсаатан!” гэж үзээд бас л шийтгүүлнэ шүү дээ. Тийм учраас бүгд надаас зугатаадаг байсан юм. Би Өвөрхангай аймгийн Сант суманд очоод 6 жил боллоо. Тэгээд тэндээс шилжмээр байдаг. Зөвшөөрдөггүй. Нэгдлийн мал хариулж байсан болохоор түүнийг хүлээж авдаггүй. Орхиод явчихвал бас том хэрэг босно шүү дээ.

Тэр үед Ардын Их Хурлын сонгууль болж байлаа. Дундговь аймгийн тойргоос Ардын Их хурлын депутатад Цагаанламын Дүгэрсүрэнгийн нэр дэвшсэн юм. Тэгээд тэр өөрийн тойргийн сонгогчидтойгоо уулзахаар ирж байгаа тухай би дуулсан юм. Тэр үед би 3 дугуйтай мотоциклоороо хол, ойр их явдаг байлаа. Тэр үед би аргамж сур хийж, Дундговийн хойд талын сумаар зардаг байсан юм. Нэг үхрийн ширээр нэг нь 12 алд 50 ширхэг аргамж сур хийдэг юм. 5 аргамж сураар нэг унагатай гүү сольдог байсан юм. Үнэтэй эд шүү. Би нэг бүтэн үхрийн ширээр аргамж сур хийгээд, Дундговийн хойд талын сумаар ороод 12 унагатай гүү, хоёр тэмээнээс сольчихоод явж байлаа. Миний очсон яг тэр суманд Ц.Дүгэрсүрэн ирэх ёстойг бас мэдэж байлаа. Тэгээд тэр сумаас төрсөн аймгийн аврага малчин Д.Пүрэвжав гэдэг айлд Ц.Дүгэрсүрэнг хүлээлээ. Яг тэднийд ирнэ гэдгийг ч бас мэдэж байсан юм.

Тэгээд Д. Пүрэвжав бид хоёр шимийн архи жаахан уугаад сууж байлаа. Тэгж байтал Ц.Дүгэрсүрэн давхиад ирлээ. Түүнийг дагаад олон хүн иржээ. Аймгийн удирдлагууд бүгд ирсэн байна. 10 гаруй УАЗ-469 ирсэн байж. Түүнийг угтах гээд Д.Пүрэвжавын гэрийнхэн бүгд л гарлаа даа. Би ч гарсангүй. Сайхан хонины цагаан элгийгээр хийсэн ширмэл ширдэг дээр завилаад сууж байлаа. Тэгтэл Ц. Дүгэрсүрэн гэрт ороод ирлээ. Тэр намайг харчихаад:

-Чи яагаад энд байж байгаа юм бэ? Чиний байх ёстой газар чинь энэ биш шүү дээ! гэж их ууртай асууж байна. Бид хоёр Москвад Коммунист Намын дээд сургуульд хамт сурч байсан юм. Бие биенээ сайн мэднэ л дээ. Уулзаагүй нилээд удсан байна.

-Би хаана байх чамд хамаагүй шүү! Би бол МАХН-ын ТХ-ны “томилолтоор” ирсэн малчин хүн. Малчин хүн, малчин найзындаа ирээд амарч байна! Миний хаана байх нь чиний хариуцах асуудал биш! гэж түүнд хэллээ. Тэгээд:

-Харин чи энэ олон машин, хүн дагуулаад, энэ хөдөө газар юу хийж яваа юм бэ? Чамд ийм газар хийж чадах нэг ч ажил байхгүй шүү дээ! гэж нэмж хэллээ. Тэгсэн тэр:

-Миний юу хийж чаддагийг чи шүүхгүй шүү! Би удахгүй Ардын Их

Хурлын депутад болох гэж байна. Одоо сонгогчидтой уулзах гэж ирлээ! Би чамтай бол уулзах гэж ирээгүй! Энэ бол чамд хамаатай асуудал биш! гэж хэгжүүрхэж байна. Бид хоёр иймэрхүү хэгжүүн, хэрүүлийн, ширүүхэн үг солилцож байтал түүнтэй хамт яваа хүмүүс нь гэрт орж ирлээ. Тэр орчмын малчин ардууд ч гэрт цугларч ирлээ. Тэгээд Ц.Дүгэрсүрэн сонгуулийнхаа сурталчилгааны яриагаа эхэллээ. Тэр босоод, шууд намайг заагаад:

-Та нар энэ Лоохуузыг таних уу? Энэ бол Монгол-Зөвлөлтийн найрамдлын эсрэг ханддаг, Зөвлөлтийн ард түмний их тусламжийн ач холбогдлыг үнэлдэггүй, МАХН-ын удирдан жолоодох их хүчийг үгүйсгэдэг, социализм байгуулж байгаа манай улсын хөгжлийн их ололт амжилтыг голж, чамладаг, манай намын эсрэг бүлэглэсэн явуулга хийгчдийн толгойлогч юм шүү! гэж намайг тодорхойлж байна. Тэгэхээр нь би босоод бас үг хэллээ:

-Энэ малчин ардууд Ц.Дүгэрсүрэн чи бид хоёроос илүү ном, сонин уншиж, радио чагнадаг хүмүүс. Намайг хэн болохыг эд нар чамаар заалгахгүй сайн мэднэ. Харин чамайг мэдэхгүй, танихгүй байх. Одоо би чамайг эд нарт танилцуулж өгнө! гэж би түүнд хэллээ. Тэгээд гэрт сууж байсан хүмүүст хандаж:

-Энэ Ц.Дүгэрсүрэн гэдэг хүнтэй би Москва хотноо Коммунист Намын дээд сургуульд нэг багшаар ном заалгаж, нэг тогооноос олон жил орос хоол идэж явсан эртний сайн танилууд юм. Оросын хоолыг олон жил идсэн, миний энэ сайн нөхөр орос хэл сурсангүй, харин архи, пивоноос өөр онцын сурсан зүйлгүй Монголдоо эргэн ирсэн хүн дээ. Орос бүсгүйн гэрт очоод, архиа хэтрүүлээд, тасраад түмпэнд толгойгоо дүрсэн хэвтэж байхад нь бид нар олж, Монголынхоо нэрийг бодож, усанд оруулж, хувцасыг нь сольж өгч, хүн болгон авч байсан явдал олон бий. Өнөөдөр энэ хүн МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүн болсон гэж ханхалзаад, та нарын саналыг авч, Ардын Их Хурлын депутад болох санаатай яваа юм байна. Та нарт их том хүн харагдаж байгаа байх. Гэвч үнэн хэрэгтээ энэ хүн хэзээ тэндээс хөөгдөхөө мэдэхгүй яваа өчүүхэн хүн шүү дээ. Та нарт юу гээд ч ярьж мэдэх нөхөр шүү! гэж хэллээ. Гэтэл тэнд цугларсан хүмүүс яаж ч чаддаггүй юм байна. Тэд нар их гайхаж байна. Ц.Дүгэрсүрэнгийн царай нь минчийж улайгаад хэцүү байх шиг байна. Тэгээд тэр хурал ч олигтой хурал болсонгүй тарлаа. Ц.Дүгэрсүрэн өөрөө их цайлган сайхан хүн шүү дээ. Хурлын дараа тэр над дээр ирээд “Чи надтай уулзаж юу ярих гэсэн юм бэ?” гэж асууж байна.

-Би чамтай л уулзах гэж энд хүлээж байсан юм. Намайг анх намаас арга хэмжээ авахдаа Намын Хянан Шалгах Хороо 3 жилийн хугацаатай хөдөө явуулсан шүү дээ. Гэтэл түүнээс хойш 6 жил боллоо. Өргөдөл олон удаа өгсөн боловч хариу ирэхгүй байна! гэж түүнд хэллээ.

Тэгтэл тэр:

-Аа, тийм үү. Би Улаанбаатарт очоод Ю.Цэдэнбал даргатай уулзаад, чиний асуудлыг хэлээд үзье! гэж байна. Тэгээд бид хоёр гар бариад салсан юм. Тэр Улаанбаатарт очоод Ю.Цэдэнбалтай энэ асуудлаар ярьсан биз. Харин Ю.Цэдэнбал зөвшөөрөөргүй өнгөрсөн биз ээ.

21 Монголд ардчилал, шинэчлэл өрнөж эхэллээ.

Ц Л: 1990 оны 9-р сарын 3-нд Ардын Их Хурлын чуулган Улаанбаатар хотод ажлаа эхэллээ. Шинээр байгуулагдсан Ардын Их Хурал анхдугаар чуулганаараа Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх асуудлыг авч хэлэлцлээ.

Ингээд МАХН-аас Пунсалмаагийн Очирбатын нэр дэвшлээ. Бусад улс төрийн намууд түүний нэрийг дэмжлээ. Бас миний нэр дэвшлээ. Ингээд бид хоёр Монгол улсын Ерөнхийлөгч болохоор өрсөлдөх боллоо. Энэ үед надад олон юм бодогдож байна. “Ерөнхийлөгч болж болно. Улсын Монгол улсын төрийн тэргүүн бол хариуцлагатай ажил. Миний нас 70 гарч явна. Бас олон жил хөдөө мал хариулж амьдарлаа, шоронд олон жил суулаа. Өнөөгийн нийгмийн амьдралаас хоцорлоо. МАХН-ын хуучин их хүч, нөлөө нь хэвээрээ шахуу байж байна. Би түүнийг сөрж ганцаараа зогсоод 20 гаруй жил боллоо. Одоо би түүнийг нурааж чадах, эсэх нь тодорхой биш байна. Дөнгөж эхлээд байгаа энэ өөрчлөлт, шинэчлэлт эргэлт буцалтгүй үйл явц гэдэг бас тодорхойгүй байна. Түүхийн хурд хаашаа эргэхийг хэлж мэдэхгүй байна. Энэ ажлыг эрч хүчтэй, нөлөөтэй, залуу хүн хийсэн нь дээр!” гэсэн бодол төрөөд байлаа. Тэгээд өрсөлдөхгүй байхаар шийдлээ. Ингээд П.Очирбат Монгол улсын анхны Ерөнхийлөгчөөр сонгогдлоо. Тэр үед нийгмийн сэтгэл зүй их өөр байлаа шүү дээ. Би зүтгээд байсан бол ерөнхийлөгч ч болж болох байсан байж магадгүй. Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолын үеэр би Пунсалмаагийн Очирбатад баяр хүргэлээ.

Ингээд үүний дараа Улсын Бага Хурал, Засгийн газрыг байгуулах ажилд орлоо. Харин би Монгол улсын шинэ Үндсэн хуулийг батлах Ардын Их Хурлын орлогч даргаар ажиллахыг зөвшөөрсөн юм шүү. Монгол Улсын шинэ Үндсэн хуулийг 1992 оны 1-р сарын 13-ны өдөр баталсан юм. Ингэж Монгол улс ардчилал, шинэчлэлийн замд тууштай орсон юм. 1990 оноос хойш манай улсын амьдралд маш их өөрчлөлт орлоо. Энэ дотор сайн юм их боллоо. Түүний хажуугаар саар юм ч бишгүй дээ л гарлаа. Бид чинь будилсаар яваад 1996 онтой золголоо шүү дээ. Ардчилал, зах зээл гэдгийг амьдрал дээр мэддэг хүн байсангүй. МАХН-ынхан бол бүр мэдэхгүй. Ардчилсан хөдөлгөөнийхөн дотор онол уншсан хүн байсан байх. Гэтэл түүнийг чинь хийх хэрэгжүүлэх гэтэл олон

бэрхшээл тулгарлаа. МАХН эсэргүүцээд, “ингэдэггүй юм, тэгдэггүй юм!” гэж зөрүүдлээд, алийг нь алдуулж байлаа шүү дээ. 5 жил гаруй ёстой нэг будилж гарлаа даа. 1996 оны Улсын Их хурлын сонгуулиар “Ардчилсан Холбоо” эвсэл ялалт байгуулж, засгийн эрх барих боллоо. Энэ үеэс л ардчилал, зах зээлийн эдийн засаг тууштай хэрэгжиж эхэллээ шүү дээ. ХАА-н нэгдлүүдийг тараагаад, малыг эзэнд нь олгосон нь зөв боллоо. Дараа нь орон сууцыг бас хувьчлаад эзэнтэй болголоо. Энэ чинь зөв ажил шүү дээ.

Намайг анх Өвөрхангай аймгийн Сант суманд очиход тэр сум тариа, ногоо огт тарьдаггүй байлаа. Нэгдлийн гишүүд нь мал малаад л амьдарч байлаа. Суманд өөр үйлдвэрлэл ердөө байсангүй. Сумын төсвийг шууд улсын төвлөрсөн төсвөөс хуваарилдаг байлаа. Тэр сум өөрөө ашиг, орлоготой ерөөсөө ажиллаж байсангүй. Данс нь ямагт улайсан байдаг байж. Ингээд улсаас дотаци аваад л өдөр хоногийг өнгөрөөдөг байлаа. Хувийн худалдаа, наймаа огт байсангүй. Ер нь бүх ХАА-н нэгдэл нэг ийм дүр зурагтай байсан юм шүү дээ. Тэгээд би тэр суманд өөрийн хийж байсан ажлынхаа туршлагыг ашиглаад туслах гэж бодлоо. Тэгээд жолооч нарт захиад Улаанбаатар хотоос сонгино, төмсний үр авч ирүүлээ. Тэгээд тэр сумын Царгийн бригадад хөрс, ус сайтай газар талбай сонгож аваад, хашаа бариад ногоо тарьж эхэлсэн юм. Өөртөө биш тэр нэгдэлд туслах гэж л бодсон юм. Би өөрийнхөө тэмээгээр 40-ийн бидоноор ус зөөгөөд тариан талбайгаа усалдаг байлаа. Сонгино их сайхан ургаж байлаа. Би сумын МАХН-ын хорооны дарга болон нэгдлийн дарга нарт хийж байгаа ажлаа танилцуулсан юм. Ямар зорилготой ийм ажил хийж байгаагаа ч сайн хэлдэг байлаа л даа. Тэгтэл миний тарьсан сонгино, ногоо сайхан ургаад эхлэж байтал, намайг эзгүй хойгуур хашаанд нь хурга, ишиг, нохой ороод, тарьсан зүйлүүдийг маань гишиглээд, идэхийг нь идээд хаячихдаг боллоо. Би хашааныхаа үүдийг сайн боогоод л явдаг, дахиад л орчихдог боллоо. Тэгээд гайхаад судлаад үзсэн чинь тэр сумын МАХН-ын хорооны дарга ийм ажлыг зориуд зохион байгуулдаг байж л дээ. Тэгээд: “Би эд нарт туслах гээд байдаг. Эд нар ийм юм миний эсрэг хийж байна. Энэ бол намайг нийгэм өөрөө хүлээж авч чадахгүй байгаагийн илрэл юм! Нэгэнт нөхцөл байдал ийм байгаа болохоор өөрийгөө бодсон нь дээр юм байна!” гэж би боддог болсон юм.

Ингэж би зөвхөн өөрийнхөө төлөө хөдөлмөрлөдөг болсон юм. Ерөөсөө манай нийгэмд ийм атмосферийг буй болгочихсон юм. “Лоохууз бол эсэргүү хүн! Бүр эсэргүүгийн цаад талын эсэргүү хүн!” гэдэг тийм ойлголтыг нийгэмд буй болгосон юм. Нөгөө талаар ХАА-н нэгдэл зэрэг нь өөрсдөө аж ахуйгаа өөд татаад, өөрөө өөрийгээ санхүүжүүлээд явах ёстой байтал дандаа дээрээс ирсэн тушаалыг л биелүүлдэг, өөрсдөө бодож

сэтгэдэггүй, юм хийдэггүй байдалд сургачихсан юм. Ийм учраас манайд тэр үед ашиг орлогтой ажилладаг ХАА-н нэгдэл бараг байсангүй шүү дээ. Дандаа улсаас дотаци авдаг байлаа шүү дээ. Аж ахуйн тооцоо, ашиг, орлого гэдэг юмыг огт мэддэггүй байсан юм. Тэгээд мэддэг юм нь үзэл суртал байлаа шүү дээ.

Сант суманд очсоны дараа би өөр бас нэг юм хийсэн юм. Өвөл хүнсний ногоогоо яаж хадгалах талаар арга бодож олсон юм. Монгол гэрт байнга гал түлдэг шүү дээ. Тийм учир би зуухныхаа доор нүх ухаад, нүхэн зoorь шиг юм хийгээд, түүндээ төмсөө хадгалдаг болсон юм. Гадаа их хүйтэн учир төмс хөлдөнө шүү дээ. Зуухны доор ухсан нүхэнд бол төмс хөлддөггүй юм. Ингээд өвлийн турш төмстэй хоол иддэг байлаа. Хөдөөний айлууд дандаа аргал түлнэ шүү дээ. Аргалаас үнс их гардаг юм. Байнга үнсийг нь асгаж байхгүй бол гал асдаггүй юм. Байнга үнс асгана гэдэг чинь бас их ажиллагаатай зүйл юм л даа. Би өвлийн гэр барихаас өмнө зуухныхаа доор нүх ухаад тийшээ үнс унаж байхаар болгосон юм. Тэгээд нөгөө унасан үнс дүүрээд ирэхээр нь гэрийн гадна хаяагаараа нөгөө үнсийг нь татаж аваад байхаар болгосон юм. Манайхны ажлыг их хөнгөвчилсэн юм шүү дээ. Ингэж Монгол гэрийн дулаалгын ситемийг сайжруулах оролдлого хийж байлаа.

Би Сант суманд байхдаа бас уламжлалт гар аргаар цагаан эсгий олныг хийсэн дээ. Тэр үед эсгийний хэрэгцээ их байсан боловч эсгий хийхээ больсон байсан юм. Үйлдвэрийн аргаар хийсэн эсгий улсын худалдааны шугамаар ирдэг боловч их ховор байлаа. Хөдөөний малчид гэрээ дулаалах гээд эсгий хайгаад олдохгүй их асуудал босдог байсан юм. Хөдөө мал хариулаад амьдарч байгаа хүнд ер нь эсгий их хэрэгтэй эд шүү дээ. Гол нь эсгий хийх ноос нь их ховор байсан юм. Малчид хониныхоо ноосыг хяргаад бүгдийг нь улсад тушаадаг байсан болохоор эсгий хийх ноос байхгүй болсон юм л даа. Гэхдээ сайн ажиллавал эсгий хийх ноос гардаг юм. Манайх 400 гаруй хоньтой байлаа шүү дээ. Тэр хониныхоо ноосыг нь бүгдийг нь улсад тушаах ёстой. Гэхдээ түүнээс жаахан ноос илүү гардаг байсан юм. Малаа сайн таргалуулаад, ноосыг нь цаг алдалгүй хяргаж авах ёстой юм. Ингэж чадвал ноос жаахан илүү гардаг юм. Ингэж чадсан айлууд улсад нормтой ноосоо тушаагаад жаахан ноос илүү гардаг байлаа. Гэхдээ зарим айлын ноос норм, төлөвлөгөөндөө хүрэхгүй их дутна шүү дээ. Тийм үед жаахан ноос илүү гарсан айлаас ноос мөнгөөр худалдан авч дутсан ноосоо гүйцээдэг байсан юм. Би ийм илүү гарсан ноосыг айлуудаас цуглуулж худалдаж аваад, эсгий хийдэг боллоо. Нэг жилд нилээд хэдэн эсгий хийж байлаа. Тэгээд уламжлалт гар аргаар хийсэн цагаан эсгийг хүмүүс 500 төгрөгийн үнээр авдаг байлаа.

Тэнд байхад “Ременин гөлөмний эцэг Лоохууз” гэсэн нэг яриа гарсан

юм. Би “ременин гөлөм” хийж зарсан юм. Налайхын нүүрсний уурхайд нүүрсийг газрын гүнээс дээш нь татаж гаргадаг өргөн хавтгай ремень байдаг юм. Түүний өнгөн тал нь хаймар, дунд нь брезент байдаг юм. Тэр хаймарыг нь хуулах сайн арга олдвол сайхан гөлөм болох юм байна гэж би боддог байлаа. Тэгээд тэр ременийг халуун зуухан дээр хүчтэй халаагаад үзсэн чинь хаймар нь амархан хурч байна. Хаймарыг нь хуулах арга олсон учир ременээр гөлөм эсгээд, хаймар дээр нь гөлөмний угалз зураад, түүнийгээ хурц хутгаар дагуулаад зүслээ. Тэгээд ременээ халаагаад, нөгөө зүссэн хаймараа хуулахаар сайхан угалз гарч байгаа юм. Ингээд угалзныхаа нүднүүдийг нь будгаар будчихна л даа. Маш бөх гоё гөлөм болж байгаа юм. Ингээд тэр хавийн бүх сумдын малчид ременин гөлөмтэй болж байгаа юм. Сүүлдээ ийм гөлөмийг Монгол улс даяараа малчид хэрэглэдэг болсон шүү дээ.

Буурцагтай мөнгөн цагаан товчийг Өвөрхангайхан их хэрэглэдэг юм. Би Говь-Алтайн Чандман суманд 1985 онд очоод, тийм товч хийсэн юм. Хийхэд их амар боловч их гоёлтой сайхан товч л доо. Дээр үед хүмүүс их хэрэглэдэг байгаад сүүлдээ хэрэглэхээ больсон юм. Манайд чинь үндэсний хувцас, гоёл чимэглэлийг чинь МАХН-ын бодлогоор хэрэглэхийг нь болиулсан юм шүү дээ. Бүр 20-оод оны үед хот хөдөөгүй үндэсний алт, мөнгө, шүр сувдаар хийсэн эмэгтэй, эрэгтэй хүний гоёл чимэглэлийг хэрэглэхийг нь хорьсон юм.

Дээр үеэс монголчууд алт, мөнгө, шүр сувдан гоёл чимэглэл их хэрэглэдэг байсан юм. Цаг агаар дулаан мал ихтэй байгаа үедээ монголчууд ийм үнэтэй алт, мөнгөн эд, хэрэглэлийг хийгээд хадгалчихдаг юм. Тэгээд цаг уур хүйтрээд зуд болоод мал хорогдсон үед эдгээр зүйлүүдээ зараад мал авдаг байсан юм. Монгол орон өргөн уудам учир нэг газар зуд болж мал хорогдож байхад нэг газар өнөтэй сайхан өвөл болж мал өсч байдаг юм. Эрэгтэй хүн үнэтэй чулуун хөөрөг, хаш чулуун соруултай гаанс, алт, мөнгөн чимэглэлтэй хэт хутга, том, том мөнгөн товчтой дээл өмсөж, хэрэглэдэг байж. Хөөрөгний толгойг нь шүрээр хийж, алтан, мөнгөн нуух тавьдаг байсан юм. Бас том, том мөнгөн аяганд цай уудаг байлаа. 20-оод оны сүүлчээр дарлагч ангийн хөрөнгийг хураах үед ийм зүйлүүдийг хурааж аваад улсын орлого болгоод, ийм зүйл хэрэглэхийг хорьсон юм. Тэгээд үнэтэй материалаар хийсэн сайхан ур хийцтэй гоёл чимэглэлийн зүйлс хэрэггүй болж үрэгдэж алга болох замдаа орсон юм. Зарим хүмүүс тийм үнэтэй зүйлүүдээ маш нууц хадгалсан, зарим нь огт хадгалалгүй хүүхэд тоглуулж байсан гэдэг юм. Хэлхээтэй шүр, сувд тэр үед хүүхдийн тоглоом болж байсан гэдэг юм. Энэ чинь Монголын ард түмний уламжлалт соёлыг устгах замыг нээж өгсөн маш буруу ажил байлаа л даа. Аажмаар тийм гоёл чимэглэлийн зүйл хийдэг дархан хүн байхгүй болоод,

хийдэг арга технологиуд нь мартагдаж ирсэн байгаа юм.

Тэгээд 60-70 аад оны үед зарим хүмүүс тийм хуучны хэлбэр хийцтэй зүйлүүдийг сонирхож эхэлсэн юм. Гэхдээ тийм өргөн хүрээтэй биш. Бага зэрэг товч энэ тэрийг сонирхдог болсон юм. Их үнэтэй юм хэрэглээд ирвэл бас болохгүй. Асуудалд орно. Хаанаас, хэнээс авсан гээд Дотоод яам байцаагаад эхлэнэ шүү дээ. Дотоод яамны хараанд орно. Аймаг болгонд Дотоод яамны салбар ажиллаж байсан юм.

Монгол улсын Шинэ үндсэн хууль батлагдсаны дараа, түүний дагуу шинэ Их Хурлыг сонгох сонгууль эхэлсэн юм. Би дахин Их хурлын гишүүнд нэрээ дэвшүүлээгүй юм. Ингээд тэтгэвэрээ тогтоолгож авлаа. Нас өндөр боллоо. Зах зээлийн харилцааны анхны алхмууд хийгдэж эхэллээ. Юмны үнэ ханш өдрөөс өдөрт өөрчлөгдөж, хуучин амьдралаар амьдрах боломжгүй болж ирсэн. Намайг шүүхээр шийтгэж миний хөрөнгийг хураах үед хурааж авсан машины оронд нэг хуучин машин өгсөн юм. Тэр үед хувийн машинтай хүн бараг байсангүй.

Тэр үеэс эхлээд Монгол хүн гадаадад их явдаг боллоо. 1990 оноос өмнө Монгол хүний гадаадад зорчих асуудал бас хориотой байсан шүү дээ. Монгол хүн гадаадад явах нь бүү хэл Монголд амьдарч, ажиллаж байгаа гадаадын хүнтэй уулзаж юм ярих нь хориотой байсан шүү дээ. Манай Дотоод яам энэ асуудлыг хатуу хянаж байсан юм. 1990 оноос эхлээд манайхан Бээжин, Москва руу голдуу галт тэрэг, онгоцоор явдаг боллоо. Их бараа зөөж авч ирдэг боллоо. Том, том цүнхэнд хийсэн ачааг манайхан “гахай” гэж нэрлэдэг юм.

Энэ үед би Дамбадаржаад газар авлаа. Тэр үед газар хувьчлагдаагүй байсан. Хямдхан байлаа. Гагцхүү хотын захиргааны л зөршөөрөл хэрэгтэй байсан. Ингээд хотын захиргаанаас зөвшөөрөл аваад хашаа барьж, түүн дотроо байшин барилаа. Тэндээ хэдэн үнээтэй, ногооны талбайтай боллоо. Говь-Алтай аймагт байхдаа би 100 гаруй малтай байсан юм. Тэднийхээ хагасыг нь зараад, хагасыг нь Улаанбаатарт аваад ирсэн юм. Хотын орчим Баянцогт суманд хүнээр маллуулдаг байлаа. Гэтэл Улаанбаатарын орчим мал маш зохимжгүй зүйл болох нь мэдэгдлээ. Мал их алдагдана. Тэжээл их хэрэглэнэ. Зарлага их гарна. Ашиг багатай юм.

Сүүлийн үед хүмүүс хөдөөнөөс малтайгаа хот орчимд их нүүж ирж байна шүү дээ. Энэ ерөөсөө буруу. Хот орчимд ирвэл малгүй л ирэх хэрэгтэй. Малаа зарж мөнгө болгоод гахай, тахиа маллах хэрэгтэй юм. Гэтэл үүнийг мэдэхгүй малтайгаа Улаанбаатарын орчим ирээд, сүйрч байж сая ойлгож байна шүү дээ. Төрөөс хийж байгаа ямарч зохицуулалт алга. Хэлж өгдөг газар алга байна шүү дээ. Ингээд сөнөсөний дараа сая буруу юм хийснээ ухаарч байна. Би өөрөө энэ замыг туулсан болохоор мэдэж байна л даа.

1990-ээд оны дундуур “Шувуу фабрик”-г миний танилууд олон байлаа л даа. Ингээд би малаа бүгдийг нь зараад, тахиа авлаа. 200 гаруй тахиатай боллоо. Маш олон өндөг авдаг боллоо. Оросын цагаан тахиа бол олон өндөг гаргана шүү дээ. Тэр үед өндөг бас ховор байлаа. 200 тахианаас хоногт 100 өндөг авна гэсэн үг шүү дээ. Нэг өндгийг 100 төгрөгөөр зарж болно. Ингээд томоохон гуанз ресторанууд манайхаас бөөнөөр нь 70-80 төгрөгөөр өндөг авдаг боллоо. Нэг тахиаг 2 жил болгоод нядалгаанд оруулсан нь дээр байдаг юм. Нядлахынхаа өмнө ангаахайгаа авчихна л даа. Тахиагаа нядалгаанд оруулахаар чинь бөөн мах болно шүү дээ. Тахианы махыг гуанзууд дуртай авна.

Сүүлийн үед гадаадаас өндөг, тахианы мах чөлөөтэй орж ирдэг болоод, зах зээлийн өрсөлдөөн ширүүн болж байна. Манай төр, засаг өөрийн зах зээлийг хамгаалахгүй байна. Гахай, тахианы аж ахуй бол манайд зайлшгүй хэрэгтэй зүйл шүү дээ. Гахайны аж ахуйг эрхлэхэд гол анхаарах зүйл бол тэжээлийн асуудал л байдаг юм. Үүнийг л шийдчих юм бол өндөр ашигтай байдаг аж ахуй л даа. Гахайны махаар хиам хийдэг юм. Гадаад орнуудад гахай, тахианы тэжээлийн тусгай үйлдвэр ажиллаж байна. Олон төрлийн витаминтай тэжээл бэлтгэж өгч байна.

Манайд жижиг бизнес эрхлэгчдэд их бэрхшээл байдаг юм. 1990-ээд оны эхээр манайхан Хятад яваад хямд, чанаргүй бараа аваад, түүнийгээ Орост аваачаад зардаг байлаа шүү дээ. Ийм маягийн бизнес бол ямар ч ашиг өгөхгүй л дээ. Сүүлийн үед өөрсдөө ямар нэгэн зүйл хийж, бүтээхээр чармайдаг болсон байна. Энэ бол зөв тал руугаа орж байна гэсэн үг юм. Олон хүн өргөн хэрэглээний янз бүрийн жижиг зүйл хийдэг болсон байна. Олон хүн гуанз, дэлгүүр байгуулсан байна л даа. Өрсөлдөөн их боллоо.

Сүүлийн үед жижиг бизнес эрхлэгчид “Урбанек” салатыг Польш улсаас импортлож байна. Монголчууд түүнийг “Алаг салат” гэдэг юм. Их амттай сайхан салат шүү дээ. Үүнийг бүр социализмын үед манай улс Польшоос улсын худалдаагаар импортоор авч байсан юм. Гэхдээ Дархан-Сэлэнгийн газар тариалангийн бүсийн тариаланчид “Алаг салатыг бүр тэр үеэс гэрийн аргаар хийдэг технологийг нь мэддэг байсан юм. Би түүнийг одоо гэрээрээ хийж байна. Миний гэрээрээ хийсэн салат, импортоор орж ирсэн салат хоёрын хооронд ганц л ялгаа бий. Импортын “Урбанек” давс ихтэй байдаг бол минийх давс багатай байдаг юм. Бусад нь яг ижил юм. Польшууд бол нийтийн худалдаа болон экспортонд зориулж хийдэг учир муудахаас нь хамгаалж давсыг нь ахиухан хийдэг бол би түүнийг удаан хадгалах шаардлагагүй учир давс багатай хийдэг юм. Би түүнийг хийсэн шилэн дээр өөрийн гар утас, нэр, эхнэрийнхээ нэр, гэрийн хаягаа бичээд наачихдаг юм. Хүнсний зах дээр гарсан өдөртөө дуусаж байна. Тэгээд түүнийг авсан хүмүүс дахин авахаар миний гар утсаар

захиалга өгч байна. Гэрийн нөхцөлд хийсэн болоод ч тэрүү, давс багатай болоод ч тэр үү, манай хэрэглэгчид миний салатанд илүү дуртай байдаг юм. Үнэ нь ч бага шүү дээ.

Монголд мөөг их ургадаг нутаг байдаг юм. Түүнийг түүгээд “Мөөгний консерв” хийж болно шүү дээ. Бас “Махан консерв” байна. Тэднийг чинь бүгдийг нь гэрийн нөхцөлд бага хэмжээгээр хийж болдог юм. Би бүгдийг нь гэрийн нөхцөлд бага, багаар хийж үзсэн. Сайхан болж байна билээ. Харин нэг анхаарах зүйл бол ариун цэврийн асуудал байдаг юм. Хүнсний зүйл гэрийн нөхцөлд хийхэд гол анхаарах зүйл бол энэ байдаг юм. Үүнийг л шийдэх хэрэгтэй байдаг юм. Бусад нь технологийн хувьд төвөгтэй биш.

Манай Баян-Өлгийн казах ястангууд адууны махаар “каз” гэдэг сайхан хүнс хийдэг шүү дээ. Би залуу байхдаа Баян-Өлгийд очдог байсан юм. Тэр үед “каз” идэж үзсэн юм. Их сайхан амттай зүйл шүү дээ. Би одоо өөрөө “каз” хийж байна. Яг казахуудын өөрсдөө хийдэг уламжлалт аргаар нь хийж байгаа. Давс, сонгино, перец, чинжүү зэрэг хоол амталдаг ногоонуудыг усанд хийж буцалгаад, хөргөдөг юм. Хөрсний дараа тэр уусмалдаа дан адууны хавиргыг хийгээд хонуулна. 24 цаг орчим болгоно гэсэн үг шүү дээ. Энэ хооронд нөгөө сонгино саримс зэрэг ногоонууд, давсны амт адууны хавирганд бүрэн шингэж байгаа юм. Ингээд нэг хоногийн дараа сайхан амт орсон хавиргануудыг адууны олгой, бүдүүн гэдэс зэрэгт нэг нэгээр нь хийдэг юм. Тэгээд утаанд утдаг юм. Хамгийн хэцүү нь утаагаар утах нь байдаг юм. Аргалын утаанд утвал их сайн. Ер нь адууны мах өөрөө их амттай, чанартай мах шүү дээ. Аргалын утаагаар утахаар бүр сайхан болно доо. Казахууд түүнийг утахын тулд гэрийнхээ хананы толгойноос дүүжилчихдэг юм. Ингэж дүүжилсэн адууны мах утаандаа болчихдог юм. Ингэж утсан махыг шууд идэж болно. Хүнсний зах дээр нэг килограм “каз” 5000 төгрөг хүрч байна. Тэгвэл нэг килограм адууны мах 1100-1200 орчим төрөг байгаа шүү дээ. Жижиг бизнес эрхлэгчдэд маш ашигтай бизнес дээ. Сүүлийн үед түүнийг хэрэглэгчид их өсч байна. Казах, монгол бүх хүн хэрэглэдэг болж байна. Бас монголд амьдарч байгаа гадаадын хүмүүс их авдаг болсон байна шүү дээ.

Монголд дээр үед уламжлалт аргаараа хуурай сүү хийдэг байсан юм шүү дээ. Манай гүүний айраг, ингэний сүү, ингэний хоормог зэрэг маш амттай, олон төрлийн витамин агуулсан, хүний эрүүл мэндэд сайн нөлөө үзүүлдэг, байгалийн цэвэр шинж чанараа хадгалсан уламжлалт хоол, хүнсний зүйлүүдийг зах зээлийн эргэлтэнд оруулах хэрэгтэй байна. Тэднийг хийдэг уламжлалт арга, технологийг нь судлаж сурталчлах хэрэгтэй байна. Тэднийг хийх шинэ техник, технологийг нэвтрүүлэх хэрэгтэй байна. Сүүлийн үед энэ талаар ном мэр, сэр гарч байна. Би тийм

номыг зориуд аваад уншиж байна. Заримыг нь хийж чаддаг хүнээс очиж асууж заалгаж авч байна.

Би Хөвсгөл аймагт нутаг заагдан сууж байхдаа загас давслаж, хатааж сурсан юм. Манай Хөвсгөл нуур их цэвэр устай, загас маш элбэгтэй нуур шүү дээ. Түүний ус, Байгал нуурын уснаас цэвэр юм. Байгал нуурын хөвөөн дээр Оросууд целлюлезийн үйлдвэр барьснаас ус нь их бохирдож байна. Харин Хөвсгөл нуурын орчим ямар ч үйлдвэр байхгүй шүү дээ.

И Л: Та Ардчилсан намын лидерүүдтэй хир зэрэг танил байна вэ?

Ц Л: Би АН-ын Үндэсний Зөвлөлийн гишүүдтэй бараг бүгдтэй нь танил. Лидерүүдийг нь бол бүгдийг нь танина. Тэдэнтэй байнга холбоотой байдаг юм. АН-ын хурал очиж суудаг юм. Сүүлийн хоёр ч хурал дээр би нилээд шүүмжлэлтэй үг хэлсэн. АН-ыг өөрийг нь цэвэрлэх хэрэгтэй гэсэн санаа хэлсэн юм. “АН-ын дотор янз бүрийн ашиг сонирхолтой хүмүүс их орсон байна. Ёс суртахуунгүй, хариуцлагагүй хүмүүсээсээ салах хэрэгтэй байна. АН-ын нэр хүндийг ийм хүмүүс унагаж байна. Ийм хүмүүс ашиг олох, төрийн өндөр албан тушаалд орох гэсэн хувийн өчүүхэн зорилгодоо үндэсний хэмжээний энэ том намыг ашиглаж байна. Үүнийг одоо таслан зогсоох болсон. АН-ыг ийм хүмүүсээс цэвэрлэж, намын нэрийг ариун байлгая! Өөр нэг хийх ёстой зүйл бол АН өөрийн хийсэн алдаагаа хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. 1990-ээд оноос хойш АН олон алдаа гаргалаа. Одоо энэ алдаагаа хүлээн зөвшөөрөөд ард түмнээсээ уучлалт гуйх хэрэгтэй. Тэгээд цашид алдаа гаргахгүйн төлөө намын жирийн гишүүдээс эхлээд, дээд удирдлагаа хүртэл бүх хүч чадлаа дайчлан ажиллацгаая!” гэж хэлсэн юм.

Нөгөө талаар АН-ын удирдлагыг төвлөрүүлэх хэрэгтэй байгаа юм. Өөрөөр хэлбэл АН-ыг нэг удирдлагатай болгох хэрэгтэй байгаа юм. Одоогийн байдлаар бол АН-ын удирдлагын арга барил нь их буруу байна. “Бүгд ижил, тэгш эрхтэй!” гэдэг нэрийн дор эмх замбраагүй байдлыг буй болгож байгаа юм. Зөв зүйтэй үг хэлсэн хүнийхээ үгийг сонсохгүй, түүнийг хүлээн авч ажил хэрэг болгохгүй байна. Энэ байдлыг нэн даруй таслан зогсоох хэрэгтэй гэж би боддог юм. Намын дотоод ардчилалд шүүмжлэл чухал үүрэгтэй. Шүүмжлэлийг хааж боогдуулалгүй, чөлөөтэй байлгах нь чухал.

Гэтэл шүүмжлэлийг чөлөөтэй байлгаж байгаа нэрийн дор эмх замбраагүй, дээр дооргүй шүүмжлэл болгож хувиргаад байгаа юм. Нэг хүн зөв зүйтэй шүүмжлэл хэлдэг, гэтэл тэр хүнийг өөрийг нь шүүмжлээд эхэлдэг. Ингээд эхний шүүмжлэл, дараагийн шүүмжлэл хоёулаа үнэ, цэнээ алддаг болсон байна. Ийм байж хэрхэвч болохгүй. Зөв зүйтэй

шүүмжлэл тавьсан хүний үгийг хүлээцтэй, гэвчээртэй сонсож хүлээж авч байх хэрэгтэй юм. Би энэ бүхнийг 2000 оны Их Хурлын сонгуулийн өмнө болсон хурал дээр хэлсэн юм. Гэтэл АН сонгуульд том ялагдал хүлээлээ. Сонгуулийн дараа дахиад АН-ын хурал боллоо. Би түүн дээр дахиад өөрийн шүүмжлэлийг хэллээ.

“Сонгуулийн өмнө болсон хурал дээр та нар миний үгийг сонсох дургүй байсан. Үйл явдал яг миний хэлснээр өрнөж байна. Бид ялагдаж болно. Одоогийн ялагдлаас бид сургамж авч, өөрт байгаа дутагдлуудыг арилгах ёстой. Тэгсэн цагт ирээдүйн ялалтын суурийг тавьж чадна. Хэрвээ энэ ялагдлаас сургамж авч дутагдлаа засч чадахгүй бол бид хэзээ ч ялалтанд хүрэхгүй!” гэж хэлсэн юм.

Ер нь бол АН-д хүчтэй удирдагч үгүйлэгдээд байгаа юм. Бүгд л ижилхэн байна шүү дээ. Боловсрол нь ч ижил, чадал нь ч ижил, ажлын туршлага, дадлага нь ч ижил, нас нь ч ижил бүх юм нь ижил болчихсон. Хэн хэнээсээ илүү гарах зүйл байхгүй. Тийм болохоор бие биенийхээ үгийг сонсдоггүй. Бүгдийг араасаа дагуулаад явах хүчтэй удирдагч байхгүй байна. Энэ их хэцүү байдлыг үүсгэж байгаа юм. Ийм байдлаас яаж гарах вэ? Энэ талаар л бодох ёстой юм. Миний бодлоор ийм байдлаас гарах хамгийн сайн арга бол өөрсдөө дотроосоо нэг хүнээ “лидер” гэж хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Тэгээд бүгдээрээ түүнийхээ үгийг нь сонсож сурах хэрэгтэй. Тэр хүн алдаа гаргаж болно. Тийм үед түүндээ тал талаас нь туслаж алдааг нь хамтаараа засч байх хэрэгтэй. Тийм лидер ч бүхнийг ганцаараа шийдэж болохгүй, бусдынхаа үгийг ямагт сонсож байх хэрэгтэй. Ингэсэн цагт одоогийн хямралт байдлаас гарч чадна. Хэрвээ ингэж чадахгүй бол АН байнгын дотоод тэмцлээ зогсоож чадахгүй. Ийм намд ард түмэн итгэл хүлээлгэхгүй. Ялагдал бол ямагт тэдний талд байна шүү дээ.

Та нар одоогийн АН-ын хуралд сууж байсан уу? Би олон удаа сууж байгаа болохоор сайн мэдэж байна. Аливаа хурлын дэг, жаяг гэж нэг юм байдаг биз дээ. Тэгвэл АН-ын хуралд тийм юм ерөөсөө байхгүй. Ямар ч дэг, жаяг байхгүй. Маш замбараагүй байдалд хуралдаж байгаа юм. Тийм хурал бол Монголын үндэсний хэмжээний улс төрийн том намын хурал биш харин “Нарантуул” барааны зах дээр наймаа хийж яваа юм шиг сэтгэгдэл төрүүлж болохоор байгаа юм.

Би Д.Дорлигжав, Р.Гончигдорж хоёрыг нэр заагаад шүүмжиллээ. АН-дарга Д. Дорлигжавт би хэлсэн: “Нарантуул” зах дээр бол наймаачид үнэ, ханшийг яг, таг сайн мэдэж байх ёстой байдаг юм. Хэрвээ тэгж чадахгүй бол өрсөлдөгчдөө ялагдах нь гарцаагүй болдог юм. Гэтэл чи энэ хурал дээр яригдаж байгаа зүйлүүдийн юу нь, ямар үнэ ханштай байгааг огт мэдэхгүй байна!” гэж хэлсэн.

Би АН-ын шинэ дарга Р.Гочигдоржид хэлсэн: “Чи сайн эрдэмтэн, математикч байж болно. Гэхдээ эрдэмтэн, доктор байх нэг хэрэг, улс төрч байх өөр хэрэг шүү. Чи улс төрөөр оролдох гэж байгаа бол тууштай байх хэрэгтэй. Энэ хоёрын дунд байж ерөөсөө болохгүй. Улс төр бол тоглоомын хатуу дүрэмтэй. Тэр дүрмээр тоглоод дийлж гарвал улс төрч болдог юм. Чи нийгмийн ухаанаар толгойгоо цэнэглээгүй байна. Чи бүхнийг математикч хүний нүдээр л харахыг хүсч байна. Тэгж ерөөсөө болохгүй. Нийгэм бол улс төрчдийн өмнө том хэмжээний асуудлыг тулган тавиад, тийм хэмжээний шийдлийг шаарддаг юм!” гэж хэлсэн. Түүнээс хойш Р.Гончигдорж их өөрчлөгдсөн шүү.

АН ч зохион байгуулалтын хувьд их өөрчлөгдсөн. Чингис хааны үеэс “Эхнэрээ зөв сонгож чадаагүй хүнээр цэрэг удирдуулж болохгүй!” гэсэн нэг үг яригддаг юм. Тэр чинь нэг эхнэрийн асуудлыг шийдэж чадаагүй бол нэг хэсэг цэргийг удирдаж, нийтийн үйлсийн төлөө зүтгэх чадваргүй гэсэн үг шүү дээ. “Нэг эхнэрийн асуудлыг шийдэж чадаагүй бол нийтийн хэргийг бас л шийдэж чадахгүй!” гэдэг бол үнэн үг. Манай саяханы түүхээр энэ үг яаж батлагдахыг бид харлаа. Сонгуулийн үед гарч байгаа маргаануудыг АН-аас нийтийн том үйлсд захируулах ёстой юм. Гэтэл тэр болгоныг хий товойлгоод л, түүнтэйгээ ноцолдоод байдаг. АН-ыг төлөөлөн сонгуульд нэр дэвшиж байгаа хүмүүс бүгд нэг зорилготой байх хэрэгтэй юм. Нэг том зорилгод бүгдийг захируулах хэрэгтэй шүү дээ. Тэгээд тэр зорилгынхоо төлөө бүгдээрээ нийлээд тууштай тэмцэх хэрэгтэй юм.

Сүүлийн үед их хэлэмгий боловч өөрөө юм хийж чаддаггүй хүмүүс сонгуульд амжилт олж байна. Тухайлбал, Н.Багабанди бол өөрөө юм хийгээгүй байтлаа П.Очирбатыг ялсан юм. Н.Энхбаяр байна. Баахан л юм ярьдаг. Ярьсан юманд нь ямар ч систем байхгүй. Зүгээр л яриад байдаг, өлгөөд авах ганц бүтэн өгүүлбэр байдаггүй. Хэлэх үгээ бодож, цэгцтэй хэлдэг байх хэрэгтэй. Үглэсэн, чалчаа хүнээс ухаан гардаггүй юм. Сүүлийн үед ийм хүмүүс сонгуулиар амжилт олж байна.

Сонгуульд амжилттай оролцсон хүмүүсийн дотор ажил дээр амжилт гаргасан хүн бараг байхгүй байна. Би энэ асуудлаар 1990 онд Ерөнхийлөгч П.Очирбаттай хэд, хэдэн удаа ярилцсан юм.

-Ардчилсан зарчимаар сонгууль явуулж аль нам төрийн эрх барихыг нь шийдвэрлэх болж байгаа нь маш зөв байна. Гэхдээ энд нэг аюултай муу тал байна. Тухайн намд ямар ч хамаагүй хүмүүс зөвхөн төрийн өндөр албан тушаалд очихын тулд сонгуульд орж эхэллээ. Энэ бол маш аюултай. Тухайлбал МАХН-д ямар ч хамаагүй, түүний явж ирсэн түүхийг мэдэхгүй, түүний үзэл бодлыг ойлгодоггүй хүмүүс энэ намын нэр дээр сонгуульд ороод ялалт байгуулаад, төрийн өндөр албан тушаалд очиж болох юм.

Энэ бол маш аюултай. Энэ бол Монгол улсын цаашдын хувь заяанд их хортой үр дагаварыг авч ирж болох юм. МАХН-ын хүч ойрын хэдэн жилдээ сулрах шинж алга. Төрийн эрх барьсан хэвээрээ л байх янзтай байна. Ийм учраас энэ намыг одоо хурдан татан буулгах хэрэгтэй. Тэгвэл энэ намд байгаа шинэ, хуучин бүх муу хүмүүс нь алга болно. Хуучин муу үзэл суртлаасаа ангижирна. Тэр цагт энэ намыг дахин шинээр байгуулаад бусад намуудтай адилаар сонгуульд оролцож болно шүү дээ! гэж би түүнд хэлдэг байв. Тэр миний үгийг сонсоогүй л дээ. Гэтэл өнөөдрийн амьдрал миний хэлснийг батлаж байгаа юм шиг үйл явдлууд өрнөсөөр байна. Энэ намын Монголын ард түмний өмнө тарьсан балаг, байгуулсан гавьяанд огт хамаагүй хүмүүс энэ намын нэрээр сонгуульд орж ялалт байгуулаад, төрийн өндөр албан тушаалд томилогдоод эхлэв. Өөрийн үзэл бодолгүй, зөвхөн албан тушаал авахыг зорьсон ийм хүмүүс маш аюултай зүйлүүдийг хийх боллоо. Энэ их авилагын хэрэг, эх орны эрдэс баялагийг “хөрөнгө оруулалтыг дуудах” нэрээр гадаадынханд худалдсан энэ үйл явдлууд бол ийм хүмүүсийн л хийж байгаа ажил шүү дээ. Нам нь өөрөө гишүүдэсээ авилга нэхэж авдаг, тэр хөрөнгөөрөө шинэ гишүүн элсүүлдэг, сонгогчдын саналыг худалдаж авдаг болжээ. Энэ маш аюултай.

Бизнес эрхлээд амжилтанд хүрч байгаа цөөн тооны хүн байна. Тэд нар аажимдаа улс төрд орж ирж байна. Энэ бас бодуштай асуудал. Тэдэнд төр, засгийн дэмжлэг дутаад байгаа юм. Ийм дэмжлэг дутахаар тэдний бизнес нь явахаа больж байна. Тэгээд тэд нар өөрсдөө улс төрд ороод ирж байна. Тэд нар улс төрд дуртайдаа биш, бизнест нь төр, засгийн дэмжлэг дутаад, түүнийг олж авахаар улс төрд орж ирж байгаа юм.

Иймэрхүү том бизнес эрхлэж байгаа хүмүүс өөрийн бодол санаагаа нийгэмд ойлгуулж байх хэрэгтэй юм. Зарим асуудал дээр тийм хүмүүс маш хүлээцтэй хандаж, буулт хийж байх хэрэгтэй. Тэгэхгүй бол түүнд дэмжлэг олддохгүй шүү дээ. Бизнес эрхлэж байгаа хүн зөвхөн өөрийнхөө ашиг, орлогын төлөө явбал нийгмийн зүгээс түүнд дайсагнах хандлага бий болоод ирдэг юм. Манайд “АПУ” (Архи, Пиво, Ундаа – товчлол) гэдэг том компани байна. Энэ чинь социализмын үед улсын үйлдвэрийн газар байсан юм. Хувьчлагдаад удаагүй байна. Түүнийг хувьчлахад ширүүн маргаан гарсан шүү дээ. Шинэ эзэд нь түүний тоног төхөөрөмжийг нь шинэчлээд, өргөтгөл хийгээд Германы технологээр шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг боллоо. Нэр хүнд нь өсөж ирлээ. Нийгэмд түүний нэр хүнд өсөхөд, шинэ технологосоо илүү энэ компанийн нийгмийн хандлагатай бодолого нь их үүрэг гүйцэтгэж байна. “АПУ”-гийн удирдлагууд нийгмийн хамгийн эмзэг бүлгийхэн рүү чиглэсэн олон арга хэмжээ зохион байгууллаа. Улсын төсөвт төлж байгаа татвараасаа гадна тэд нар их хэмжээний хөрөнгийг нийгмийн эмзэг бүлгийнхэнд зориуллаа. Үүнийг ард

түмэн харж байна. Зөв бодлого барьж байна гэж үнэлэж байна.

“Нарантуул” гэж том компани байна шүү дээ. Тэр маш их ашигтай ажиллаж байгаа компани шүү дээ. Түүний захирал Сайхансамбуу бол бас алсын хараатай хүн. Энэ мэтийн үндэсний хэмжээний бизнесменүүдийг аль болохоор хурдан төрүүлэх хэрэгтэй юм л даа. Үндэсний хэмжээний бизнесменүүд маш их хэрэгтэй байна. Өөрөөр хэлбэл ажил хийж үзсэн, ажлын амтанд нь орсон тийм хүмүүс олон байх тусмаа сайн байна. Ер нь хүн ажил хийгээд ирэхээр аяндаа цаашид хийх юм нь өөрөө тодроод ирдэг юм.

Манай Ю.Цэдэнбалын гол дутагдал бол ерөөсөө өөрөө ажил гардаж хийж үзээгүй хүн юм шүү дээ. Дандаа л хүний хийсэн ажлыг л харж явжээ. Тийм учраас ажил хийдэг хүний ярьж байгаа зүйлийг ойлгохгүй байгаа юм. Энэ чинь зүгээр нэг компанийн ажил биш, улс орны хэмжээний том ажил шүү дээ. Өөрөө хийж үзээгүй болохоор тийм том, том ажлуудын учрыг нь олохгүй байгаа юм. Тэгээд л зүгээр хий хоосон “Тэгэх хэрэгтэй, ингэх хэрэгтэй!” гэж яриад байдаг болж байгаа юм. Тэр нь ажилд тус болохоосоо илүү саад болж байгаа юм. Төрийн удирдагч хүн бүхнийг өөрөө мэддэг чаддаг, хүнээс ангид хүн байж чадахгүй шүү дээ.

Ард түмэн удирдагчаасаа нэг л зүйлийг хатуу шаарддаг юм байна. Тэр нь шударга байх явдал юм. Ард түмэн бол төрийн эрх барьж байгаа хүнээс ганц ийм л юмыг шаарддаг юм байна. ЮНЕСКО-гоос Чингис хааныг “Мянганы суут хүн” гэж зарлалаа шүү дээ. Чингис хаанд өнөөдрийн энэ дэлхий ертөнцөөс ийм алдар хүртэх ямар шинж байсан бэ? Чингис хаан төрийн хэрэгт хамгийн шударга байж чадсан байж магадгүй юм. Тэр төрийн хэрэгт хамгийн шудрага байж чадсан учраас олон зууныг даван өнөөдрийг хүртэл амьдарч чадсан байх. Тийм учраас одоо түүнтэй өрсөлдөх нэг ч хүн байхгүй байгаа байх. Тийм учраас төрийн хэргийг гагцхүү шударга явуулж чадах хүнд л өгөх хэрэгтэй юм. Төрийн хэрэгт танил тал, ах дүү, амраг садан, эхнэр, хүүхэд, нутаг, ус огт хамаагүй. Төрийн хэргийг тэднээс аль болохоор хол байлгах ёстой юм. Чингис хаан ингэж тэднийг төрийн хэргээс хол байлгаж чадсан хүн байж магадгүй.

Монголчууд бидний амьдарч байгаа байгаль орчин маань бас их онцлогтой орчин юм. Төв Азийн их хуурайшмал цаг агаартай энэ орчинд ургамал, амьтан нь хүртэл их онцлогтой шүү дээ. Тухайлбал, манайд ургамал их тачирхан ургадаг. Гэтэл энэ тачирхан ургамал нь маш их амт шүлттэй, олон төрөл, нэг үгээр хэлбэл маш өндөр чанарлаг байдаг юм. Эндхийн ургамал нь халуун дулаан чийглэг уур амьсгалтай орны ургамалаас хавьгүй илүү амт, чанартай, тэжээллэг байдаг юм. Монгол хүн энэ байгаль орчиндоо үеийн үед амьдарч дассан, илүү чанартай, илүү оюунлаг байж магадгүй гэж би боддог юм. Бид зөөлөн дулаан уур

амьсгалтай орны хүн ард шиг зөөлөн, намуун ааш зангүй байж болох юм. Эрс шийдэмгий, хурц ширүүн догшин, зан ааштай байж болох юм. Тэр хэмжээгээр бидний дунд хурц оюун бодолтой хүн олон байдаг байж магадгүй. Оюун бодлоороо одооны биднээс хол түрүүлсэн хүмүүс бидний дунд олон байх шиг байна. Тэр хүмүүсээ бид дэмжиж, тэднийгээ хүрээлж явах хэрэгтэй болж байна.

Сүүлийн үед ийм оюунлаг Монгол хүмүүс гадаадад их явж байна. Америк явж байна. Орос явж байна. Герман явж байна. Өшөө хаашаа, хаашаа гэнэ вэ? яваад л байна. Энэ их буруу юм болж байна. Энэ бол аюултай эхлэл юм. Одоо манайд хүн амын өсөлт, хөгжилт, хөдөлгөөний талаар төрийн зөв, хатуу бодлого хэрэгтэй байна. Бидний дэргэд миллиард илүү хүн амтай аврага том гүрэн байж байна. Тэнд хүн амын өсөлт хөгжилт, хөдөлгөөний талаар хатуу бодлогыг явуулаад удаж байна, болж байна.

Манайд хатуу бодлого зайлшгүй хэрэгтэй байна. Бид хүүхэд, эхчүүдээ онцгой анхаарал тавьж чадахгүй байна. Одоо манай уламжлалт нүүдлийн соёл иргэншил маань хаашаа явж байна вэ? гэдгийг бодох цаг болсон. Мал дагадаг хүн улам бүр цөөрөөд байна шүү дээ. Цаашдаа бид юугаар амьдралаа залгуулах вэ? Бид юу бүтээж чадах вэ? Монголын одоо байгаа ийм цөөхөн хүн ам суурин амьдралд шилжиж огт болохгүй. Хот руу чиглэсэн энэ эмх замбраагүй их нүүдлийг зогсоох төрийн бодлого хэрэгтэй болоод байна.

Балдандоржийн Нямбуу

- | | |
|--|--|
| 1 Төрсөн нутаг. | 9 “Нэг хүнийг тахин шүтэх явдал”. |
| 2 Зөвлөлтийн цэргийн цуваа орж ирлээ. | 10 “Сэхээтний төөрөгдөл”. |
| 3 Их хэлмэгдүүлэлт. | 11 Ю. Цэдэнбал. |
| 4 Лам нарын шүүх хурал. | 12 МАХН-ын ТХ-ны 6-р бүгд хурал. |
| 5 Дотоод яамны баривчилгаа. | 13 Шүүмжлэлийн хариу. |
| 6 Би байлдааны нисэгч болов. | 14 МАХН-ын ТХ-ны томилолтоор ирсэн малчин. |
| 7 Өмнөговь аймгийн МАХН-ын хорооны 1-р нарийн бичгийн дарга. | 15 Ю. Цэдэнбал халагдав. |
| 8 Х. Чойбалсан, Ю.Цэдэнбал хоёр. | 16 Л.Цэнд, Д. Төмөр-Очир хоёр. |
| | 17 Монголын ардчилал, шинэчлэл. |

1 Төрсөн нутаг.

Конагая Юүки (цаашид **КЮ**): Тантай уулзаж байгаадаа бид баяртай байна. МАХН-ын дотор оршиж байсан бусармаг явдалтай шударгаар тэмцэж явсан 20-р зууны Монголын хамгийн алдартай улс төрчдийн нэг гэж таныг Монголын олон нийт үнэлдгийг бид дуулж байсан. Энэ удаагийнхаа ярилцлагыг таны бага насны дурсамжаас эхэлбэл ямар вэ? Та хаана, хэдэн онд төрсөн болон өөрийн аав, ээж, ах, эгч, дүү нарынхаа тухай, өөрийн бага насныхаа тухай бидэнд ярьж өгнө үү?

Балдандоржийн Нямбуу (цаашид **БН**): Тэгье. Би өөрийн бага насныхаа тухай ярианаас эхлье. За, би 1922 онд Түшээт хан аймгийн Дархан чин ван Пунцагцэрэнгийн хошууны нутаг Шархайн хөндий гэдэг газар төрсөн хүн. Манай хошуу сүүлд засаг захиргааны шинэ хуваариар Төв аймгийн Сэргэлэн сум болж өөрчлөгдсөн юм. Одоо би 83 нас хүрч байна. Манайхан бол удам угсаагаараа, эцэг, өвгөдийн үеэсээ, олон үе дамжиж Шархайн хөндийд амьдарч ирсэн юм гэнэ билээ. Манайхан бол дан ганц мал аж ахуйгаа эрхэлэн амьдарч ирсэн, малчин удамтай хүмүүс юм.

КЮ: Танайх олон малтай айл байсан уу?

Б Н: Манайх баян биш удамтай, ядуувар айл байсан юм. Манай эцгийн эцэг, түүний эцэг гээд эцгийн тал бол малгүй шахам байж. Харин эхийн тал бол мал сайтай байж. Миний эцэг 1888 оны үед мөн тэр Шархайн хөндийд төрсөн гэдэг. Тэр бол айлын гурав дахь хүүхэд нь байж. Бага наснаасаа эхлээд дан мал маллаж явсан хүн.

Манай эцэг хорин настайдаа гэрлэсэн юм билээ. Манай ээж тэр үед 17 настай байж. Тэр хоёр ганц цагаан морьтой, ганц хоёр үнээтэй, хэдэн бог малтай, өөрийн мал багатай айл гэр болж байж. Манай эцэг малынхаа хажуугаар ан хийж, тарвага агнадаг байж. Ер нь тарваганы ангаар л амьдарч, амьдралаа өөд нь татсан гэж ярьдаг юм. Манай эцэг монгол бичгээр сайхан бичиж, уншдаг хүн байсан юм. Хуучин засгийн үед хорин настайгаасаа эхлээд нэг хэсэг бага тушаалын түшмэлийн алба хашиж явсан юм билээ. Ийм хүмүүсийг “Хар зайсан” гэж нэрлэдэг байсан гэдэг юм.

Иймэрхүү байдалтай амьдарч яваад 1921 оны Ардын хувьсгалтай золгожээ. Ардын хувьсгалын эхний жилүүдэд тэр малаа малаад амьдарч байж. Ардын хувьсгалаас хойш 1920-оод оны сүүлч, 1930-аад оны эхээр МАХН-ын гишүүн болсон байна. Ингээд нэг хэсэг бас баг, сумын захиргаанд алба хааж явжээ. Сүүлдээ энэ ажлаасаа гарч, малаа маллаад амьдарч байж. Манайх олон малтай болж, сумандаа баян айлын тоонд орох болсон юм байж.

Манайх жил бүр л хурдан морь уядаг байлаа. Би багадаа аавынхаа уясан хурдан морийг унаад уралддаг байлаа. Бид иймэрхүү амьдралаар амьдраад байж байтал 1938 онд аавыг Дотоод яам баривчилсан юм.

КЮ: Яагаад?

Б Н: Яагаад гэж үү? Мэдэхгүй. Миний аавыг яагаад баривчилснаа манай Дотоод яам ерөөсөө тайлбарлаагүй юм шүү. Миний аавыг баривчилсан шалтгааныг би тэр үед Монгол оронд өрнөж байсан улс төрийн үйл явдлуудыг хөөж, хожим өөрөө л тайлбарлахыг оролдсон юм. Зөвхөн миний аавыг биш Монголын олон мянган аав нарыг ингэж баривчилсан юм. Олон мянган аав нар буцаж ирэлгүй, жижигхэн хүүхдүүд, залуухан эхнэрүүдээ үүрд орхиод цаазын тавцан дээр гарцгаасан юм. Монголд ийм хэмжээний эмгэнэл, гамшгийг дагуулж ирсэн он бол 1937 он юм. Энэ бол “Их баривчилгаа” эхэлсэн он шүү дээ.

1937 оны 10-р сарын 2-нд “Бүрэн эрхт онцгой комисс”-ын шийдвэр гарч, олон мянган монгол хүн улс төрийн хилс хэргээр цаазлагдсан юм. Их хэлмэгдүүлэлт ингэж эхэлсэн юм. Бүрэн эрхт онцгой комисс бол 1937 оны сүүлчээр байгуулагдсан юм. Түүнд Дотоод яамны сайд Х.Чойбалсан, МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга Д.Лувсаншарав зэрэг хүмүүс орсон байж. Энэ Бүрэн эрхт онцгой комиссын шийдвэрээр баривчлагдсан хүмүүсийг шууд цаазалдаг байж.

Дотоод яам манай аавыг ямар учир шалтгаанаар баривчилсан, хаана хорьж байгаа талаар хэнд ч, юу ч хэлээгүй юм шүү дээ. Бид нар аавыгаа

амьд байгаа эсвэл алагдсан талаар огт юу ч мэдэхгүй байв. Манай ээж аавын хойноос яваад хэнээс ч, юу ч олж сонсож чадалгүй эргээд ирж байлаа. Гэтэл нэг хэсэг хугацааны дараа манай аавын тухай “Амьд байгаа гэнэ! Шоронд хоригдож байгаа гэнэ! Арван жилийн ял оноосон гэнэ!” гэсэн яриа гарсан юм. Зөвхөн манай аавын тухай биш аавтай хамт баригдсан манай нутгийн хүмүүсийн тухай ам дамжсан ийм яриа явж байсан юм. Гэвч энэ бүх яриа ор үндэсгүй зүйл байсан юм билээ.

Би аавынхаа тухай бүх үнэнийг Монголд ардчилсан хөдөлгөөн өрнөснөөс хойш л олж мэдсэн юм. 1990-ээд оны эхээр би Дотоод яамны архиваас аавынхаа холбогдолтой материалыг шүүлгээд, авч үзлээ. Энэ архивын материалд манай аавыг “1938 оны 8-р сард баривчилсан!” гэж тэмдэглэсэн байна билээ. Ингээд түүнийг нэг сар орчим шоронд хорьж байгаад 1938 оны 9-р сард мөрдөн байцаалт хийж эхэлжээ. Манай ааваас хоёр удаа мэдүүлэг авсан байгаа юм. Эхний удаад нь аав “Би ямар ч хувьсгалын эсэргүү хэрэг хийгээгүй. Тийм зүйл надад байхгүй. Энэ талаар надад ярих зүйл байхгүй!” гэж хэлсэн байдаг юм. Хоёр дахь байцаалтан дээр тэр “Би Богд Жавзандамба хутагтын тойвон Ваанжил гэдэг хүний удирдсан хувьсгалын эсэргүү байгууллагад элссэн нь үнэн. Бид нар энэ засгийг устгаж, хуучин засгийг эргүүлж байгуулах зорилготой байсан. Би энэ ажилд оролцож, өөрийн үүрэг хүлээж байсан. Би энэ байгууллагад өөрөөсөө гадна өөрийн нутгийн таван хүнийг элсүүлж өгсөн!” гэх мэтээр мэдүүлсэн байдаг юм. Түүнээс хойш 1938 оны 11-р сарын 10-ны өдөр Онцгой комисс түүнд цаазаар авах ял оноожээ.

Тэр үед Онцгой комиссын шийдвэрийг яг тэр өдөр нь гүйцэтгэдэг журамтай байж. Тэгэхээр миний аавыг 1938 оны 11-р сарын 10-ны орой цаазалсан байх. Тэр үед Онцгой комиссын шийдвэрээр цаазаар авах ёстой хүмүүсийг хэсэг, хэсгээр нь машинд ачиж “Цаазын газар” авч ирээд, эсвэл буутай харгалзагч нар явган тууж тэнд авч ирээд, ухсан нүхний аман дээр буруу харуулан зогсоож байгаад, араас нь яг толгой руу нь бууддаг байсан юм билээ. Миний аав бас л яг ийм маягаар цаазлагдсан байх. Онцгой комиссын шийдвэрийг яаж гүйцэтгэсэн тухай баримтыг би Дотоод яамны архиваас олоогүй юм. Ер нь тийм баримт байдаггүй байх. 1990 онд Дотоод яам миний аавын “хэрэг”-ийг цагаатгаж өгсөн юм. Би түүний хоёр дахь мэдүүлэгтээ дурьдсан зүйлүүдийг шалгаж үзсэн юм. Тэр мэдүүлэгт дурьдагдсан “Богд Жавзандамба хутагтын тойвон Ваанжил гэдэг хүний удирдсан хувьсгалын эсэргүү байгууллага” гэдэг нь огт байгаагүй юм билээ. Бас “Богд Жавзандамба хутагтын тойвон Ваанжил” гэдэг хүн ч ерөөсөө байсангүй. Миний аавын “Хувьсгалын эсэргүү байгууллагатаа нутгийн таван хүнийг элсүүлсэн!” гэж мэдүүлсэн тэр таван хүн нь ч манай нутагт байсангүй. Энэ мэдүүлэгт дурьдагдсан зүйлд үнэн юм нэг

ч байсангүй. Энэ бол жинхэнэ “зохиомол хэрэг” байж.

Тэр үед миний аавыг Дотоод яамны ажилтан Д.Батхүү гэдэг хүн байцааж байсан юм билээ. Одоо тэр хүн амьд сэрүүн байна. Би тэр өвгөнтэй уулзаж аавынхаа тухай асуулаа. Гэтэл тэр хүн “Балдандорж гэдэг хүний нэр, хэдэн онд хаана төрсөн зэрэг нь л үнэн. Бусад нь цөм худал зүйл шүү. Түүний өгсөн хоёрдахь мэдүүлгийг бид өөрсдөө зохиож бичсэн юм. Тэгээд тэр хүнээр өөрөөр нь гарын үсэг зуруулсан юм. Эхлээд гарын үсэг зурахаас эрс татгалзсан юм. Тэгэхээр нь бид нар хэдэн өдөр ээлжлээд зодсон юм. Эцэстээ зөвшөөрч бидний өөрсдөө зохиож бичсэн хуурамч мэдүүлэгт гарынхаа үсгийг зурсан юм. Тэр үед гарын үсэг зурахаас татгалзсан бүх хүнийг зодож, зовоох аргыг хэрэглэж хуурамч мэдүүлэг авдаг байсан юм шүү!” гэж хэлж байлаа.

КЮ: Та аавыгаа баривчлагдах үед хэдэн настай байсан бэ?

Б Н: Тэр үед би 15 орчим настай байсан юм болов уу даа. Миний хоёр ах нэг дүү, ээж бид нар үлдсэн юм. Аавыг яг баригдах тэр үед би нэг ахтайгаа хамт Улаанбаатар хотод байсан юм. Гэртээ миний дүү, нэг ах ээж гурав байсан юм.

Би ер нь арван таван нас хүртлээ гэртээ мал маллаад амьдарч байсан юм. Манай нутагт тэр үед бага сургууль байсангүй. Бага сургууль бүр 1940 он хүрч байж байгуулагдсан юм шүү дээ. Миний эцэг өөрөө бичиг үсэг сайтай хүн байсан болохоор намайг 8-9 настай байхад монгол бичиг өөрөө зааж сургасан юм. Би хоёр жил орчим ааваараа монгол бичиг заалгаад, уншиж бичиж чаддаг болсон юм.

Тэр үед манай нутагт гэлэн санваартай Лувсанцэрэн гэдэг лам хүн байсан юм. Тэр хүн түвд, хятад хэл сайн мэддэг, түвд эм залдаг их нэр хүндтэй хүн байлаа л даа. Аав намайг тэр хүний шавь болголоо. Би тэр хүнээр түвд хэл заалгаж эхэлсэн юм. Бас тоо бодлого, монгол бичгийг үргэлжлүүлэн заалгасан юм. Би өглөө морио унаад тэдний гэрт очоод номоо заалгаад, орой нь эргээд ирдэг байлаа. Хоёр жил орчим өвлийн улиралд би тэр багшийн гэрт нь суусан юм. Би өөрөө төвд бичигт их дургүй байлаа. Лам болох дургүй байсан юм. Харин монгол бичиг, тоо бодлого сурахад их дуртай байлаа. Энэ талаар хуучин цагийн тал бичээч юм уу, эсвэл бичээчийн хэмжээний ажил хийж чадахаар мэдлэгтэй болсон байх.

2 Зөвлөлтийн цэргийн цуваа орж ирлээ.

Б Н: Манайх 1930-аад оны үеэс эхлээд л Улаанбаатарт ирж наадмаар

морь уралдуулдаг болсон юм. Олон жил ирсэн дээ. Манай нутаг Улаанбаатараас 100-150 км-ын зайнд байдаг юм. Зарим үед Улаанбаатарт маш ойртож ирээд, Богд уулын өвөр хавиар нутагладаг байлаа.

1936 онд би Улаанбаатарт ирж Холбооны техникумд орсон юм. Тэр үед Улаанбаатарт таван техникум байлаа. Намайг тэр сургуульд миний аавын таньдаг хүн оруулж өгсөн юм. Би өвөл ирж сургуульдаа суучихаад, хавар зун гэртээ харьдаг байлаа.

1937 оноос эхлээд би байнга Улаанбаатарт амьдарч байсан юм шүү. Тэр үед улс орны гадаад, дотоод байдал их хүнд байлаа шүү дээ. 1935 оноос эхлээд Монголын зүүн хил дээр хилийн будлиан байнга гарч байлаа. Булан дэрс, Халх гол орчмоор Японы цэргүүд хил зөрчих явдал их гарч байлаа. 1936 онд Москва хотноо Зөвлөлт-Монголын харилцан туслах протоколд хоёр засгийн газрын тэргүүнүүд гарын үсэг зурсан юм.

1937 оны зун би амралтаа хөдөө гэртээ өнгөрөөгөөд 8-р сарын сүүлчээр аавыгаа дагаад, тэмээ унаад Улаанбаатарт орж ирсэн юм. Бид хоёр нар жаргасанаас хойш бүрэнхий болж эхлэх үед Яармагийн дэнж рүү орж иртэл цуварсан маш олон гэрэл харагдаж эхэлсэн юм. Тэр гэрэл маш их урт, цуварсан байдалтай, ярайгаад харагдаж байсан юм. Миний аав бид нар урд нь тийм юм огт харж байгаагүй болохоор маш их гайхаад, ердөө учрыг нь олсонгүй. Тэгээд бид явдлаа түргэтгээд тэр цувсан олон гэрэлд ойртож ирээд харвал дандаа Орос цэрэг суулгасан машины урт цуваа явж байлаа. Хоёр машины хоорон дахь зай нь бараг 20 орчим метр байсан байх. Орос цэргүүд буугаа бариад, хэдэн үе болоод, машин дээр суусан байлаа. Энэ цуваа хаана, эхлээд хаана дуусч байгаа нь мэдэгдэхгүй их урт байсан юм. Тэр машины цуваа Улаанбаатар хотын дундуур баруун талаасаа орж ирээд, зүүн тийшээ гарч явж байлаа. Аав бид хоёр цуваа дуусахыг хүлээгээд зогсоод байлаа. Бид тэр цувааны хойд талд гарах ёстой байсан юм. Гэтэл тэр дуусдаггүй. Намрын шөнө болсон тул бид хоёр даарч эхэллээ. Цуваа шөнөжин үргэлжилээ. Өглөө үүр цайж байхад сая цуваа дууссан юм. Цуваа дуусахаар бид хоёр Улаанбаатарын хойд талд гарсан юм. Түүнээс хойш хэдэн удаа, үдэш болохоор л мөн тийм Орос цэргийн цуваа үргэлжилсэн юм. Миний аав, бид хоёрын үзсэн Орос цэргийн цуваа бол Харилцан туслалцах протоколоор хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор ЗХУ-ын засгийн газраас Монголд илгээсэн цэргийн ангийн цуваа байсан юм байж. Ингэж би ЗХУ-ын цэргийн маш том анги Монголд орж ирсэн үйл явдлыг өөрийн нүдээр харсан юм.

3 Их хэлмэгдүүлэлт.

КЮ: Ер нь Монголд өрнөсөн улс төрийн хэлмэгдүүлэлт хэзээнээс эхэлсэн

юм бэ?

Б Н: Монгол дахь улс төрийн хэлмэгдүүлэлт 1920-оод оны үеэс эхэлсэн юм шүү дээ. Тэр үед Монгол улсын Ерөнхий сайдаас авхуулаад, төр, засгийн өндөр алба хашиж байсан олон хүнийг цаазласан юм. Улс төрийн хилс хэрэгт гүтгэж хэлмэгдүүлэх явдал 1990-ээд оныг хүртэл үргэлжилсэн юм. Монголд Ардчилсан хөдлгөөн үүсэж эхэлсэн тэр үеэс л улс төрийн хэлмэгдүүлэлт зогссон байх. 1930-аад оноос эхлээд “нэг хүнийг тахин шүтэх явдал” газар авч олон гэмгүй хүнийг хэлмэгдүүлж, цаазалсан юм. Үүний гол хариуцлагыг нь Х.Чойбалсан хүлээх ёстой гэж МАХН-ын түүхэнд тэмдэглэдэг юм. 1950-1960-аад он, түүнээс хойших улс төрийн хэлмэгдүүлэлт бол Х.Чойбалсангийн үеийнхээс нилээд ялгаатай байсан юм.

1920-оод оноос эхэлсэн улс төрийн хэлмэгдүүлэлт 1930-аад оны дунд үеэс эхлээд их өргөн хүрээтэй болж ирсэн юм. 1930-аад оноос эхлээд улс төрийн хилс хэрэгт гүтгэж, маш олон хүнийг цаазалсан юм. Тэдний дундаас хамгийн анхных нь “Лхүмбийн хэрэг” юм. Түүний дараагийнх нь “Жигжиджавын хэрэг” байсан юм.

Жигжиджав бол 20-оод оны эхээр Ардын түр засгийн газрын Ерөнхий сайдын албыг нэг үе хашиж байсан хүн шүү дээ. Лхүмбэ бол ЗХУ-д суралцаж, Дорно дахины хөдөлмөрчдийн коммунист их сургуулийг (оросоор Коммунистический Университет Трудящихся Востока (КУТВ –ред.) төгссөн хүн юм. Тэндээс ирээд Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Төв Зөвлөлийн даргаар томилогдож байсан юм. Тэндээсээ шууд МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн даргаар сонгогдсон юм билээ. 1932 онд Монголын баруун хязгаарт гарсан “Хувьсгалын эсэргүү хөдөлгөөн”-ийг дарахад оролцож явсан хүн. 1917 онд Орос оронд ялсан Октябрийн социалист хувьгалаас зугатаж, Байгаль нуур орчмоос маш олон тооны буриадууд манай Хэнтий, Дорнод аймгийн нутагт нүүдэллэж ирсэн юм. Тэд нар бүгд Дорнод, Хэнтий аймгийн хойд талаар амьдарч байсан юм. Тэд нар иргэншлийн хувьд бүгд Монгол улсын иргэн болсон байв. Лхүмбэ МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн даргын хувьд тэр нүүдэллэж ирсэн буриадуудын асуудлыг хариуцаж байсан юм. Лхүмбэ 1930-аад оны дундуур нэг хоногийн албан томилолтоор Хэнтий аймагт очсон юм билээ. Тэнд очоод Хэнтий аймгийн МАХН-ын хорооны даргатай уулзсан юм байж. Тэгээд нэг хоноод Хэнтий аймгийн МАХН-ын хорооны ажилтан М.Ренчин гэдэг хүний хамтаар Улаанбаатарт буцаж ирсэн юм байж. Тэднийг Улаанбаатарт ирэх үед Хэнтий аймгийн Дадал сумын харьяат Мархайн Цэвээн гэдэг хүнийг Дотоод яам баривчилсан байгаа юм. Мархайн Цэвээн бол МХЗЭ-ийн ТХ-ны орлогч дарга буюу

Улаанбаатар хотын МХЗЭ-ийн хорооны даргын албыг хашиж байсан хүн юм. Мархайн Цэвээнийг баригдахаас өмнө Хэнтий аймагт хоршооны даргын ажилтай байсан Цэвэгжав гэдэг хүн баригдсан юм байж. Энэ Мархайн Цэвээн, Цэвэгжав хоёр бол нэг нутгийн хүмүүс байж, харин бие биенээ таньдаг байсан эсэхийг хэлэхэд хэцүү юм. Дотоод яам Мархайн Цэвээнийг баривчлаад мэдүүлэг авчээ. Түүнийг Хэнтий аймагт хоршооны даргын ажилтай хувьсгалын эсэргүү Цэвэгжавтай холбоотой байсан гэж гүтгэжээ. Мархайн Цэвээн энэ гүтгэлэгийг хүлээж аваагүй юм байна. “Би Д.Цэвэгжавтай ямар ч холбоо байхгүй!” гэдэг байж л дээ. Тэгээд Дотоод яам түүнийг зодож, зовоогоод өөрсдийн зохиосон хуурамч мэдүүлэгт гарын үсэн зуруулсан байна. Тэр хуурамч мэдүүлэгт нь “Д.Цэвэгжавтай холбоотой байсан нь үнэн. Бид нар хамгийн сүүлд Лхүмбээр дамжуулж холбоо барьсан. Лхүмбийг Хэнтий аймагт албан томиллолтоор явах гэж байгааг бид мэдэж байсан. Лхүмбэ Хэнтий аймагт очоод Д.Цэвэгжавтай уулзаад, миний захиаг түүнд өгөөд, түүнээс надад хариу захиа авч ирж өгсөн!” гэх зэргээр зохиож бичсэн юм байж. Ингээд энэ хуурамч мэдүүлгийг үндэслээд Лхүмбийг баривчилсан юм. Тэгээд түүнд “Хувьсгалын эсэргүү Мархайн Цэвээн, Д.Цэвэгжав нартай холбоотой байсан!” гэсэн гүтгэлэгийг тулгасан байгаа юм. Лхүмбэ нэг жил гаруйн хугацаанд энэ гүтгэлэгийг хүлээж аваагүй юм билээ. Дотоод яам түүнийг зодож, зовоож, тамласаар байгаад нэг жилийн дараа бас өөрсдийн зохиосон хуурамч мэдүүлэгтээ гарын үсгийг нь зуруулж чадсан байгаа юм. Тэгээд энэ хуурамч мэдүүлгийг нь үндэслээд, түүнийг буудаж алсан юм шүү дээ.

Тэр үед Дотоод яамны шоронд өөрсдийн зохиосон хуурамч мэдүүлэгтээ баривчлагдсан хүнээр өөрөөр нь гарын үсэг зуруулахын тулд хэрэглэдэг байсан маш харгис хэрцгий аргуудыг зөвлөлтийн мэргэжилтнүүд нэвтрүүлсэн байх. Энэ бол ЗХУ-ын Дотоод яамнанд хэрэглэдэг байсан арга юм. Түүнийг ЗХУ-ын Дотоод яамны сайд байсан А.В.Вышинский гэдэг хүн анх санаачласан юм билээ. А.В.Вышинский И.В.Сталин хоёр 1917оны Октябрийн социалист хувьсгалаас өмнө Оросын хаант засгийн шоронд, нэг өрөөнд хоригдож байжээ. Хувьсгал ялсны дараа И.В. Сталин ЗХУ-ын Коммунист намын Ерөнхий нарийн бичгийн дарга, Сайд нарын Зөвлөлийн дарга зэрэг өндөр албан тушаалыг хаших болсныхоо дараа А.В.Вышинскийг ЗХУ-ын ерөнхий прокуророор томилжээ. А.В.Вышинский энэ аргаа хэрэглэж Орос оронд Октябрийн социалист хувьсгалыг ялалтанд хүргэсэн В.И.Лениний хамтран зүтгэгч жинхэнэ коммунистуудыг (большевикууд – ред.) бүгдийг алсан юм билээ. В.И.Ленины хамтран зүтгэгч Н.Бухарин, Улаан цэргийн нэртэй зүтгэлтэн М.Тухачевский, V.Блюхер зэрэг хүмүүсийг ийм аргаар тамлан зовоож,

хуурамч мэдүүлэгт гарын үсэг зуруулаад, түүнийг нь үндэслээд буудаж алсан юм билээ. Ер нь ийм маягаар буудуулсан маш олон хүн бий л дээ. Тэнд болж байсан улс төрийн хэлмэгдүүлэлт бол манайхаас маш их өргөн хүрээтэй, маш олон хүнийг хамарсан, маш их харгис, хэрцгий байсан юм. Оросын их ард түмнийг айдас хүйдэст авхуулж, цусан далайд живүүлсэн юм. И.В.Сталин ийм харгис “улаан террорист” арга хэрэглээгүй бол “Октябрийн социалист хувьсгал” гэгч нэг хоног ч оршин тогтнож чадахгүй нь ойлгомжтой шүү дээ.

Манайд 1936 онд Х.Чойбалсан Дотоод яамны сайдаар томилогдсоноос хойш яг энэ аргыг хэрэглэж эхэлсэн байгаа юм. Ямар ч хэрэг хийгээгүй хүнийг өөр хүний хуурамч мэдүүлгээр баривчлаад, бас хуурамч мэдүүлэг авахын тулд хатуу харгис аргаар зодож, зовоон тарчлаадаг байсан юм. Х.Чойбалсан Дотоод яамны сайд болохынхоо өмнө Сайд нарын Зөвлөлийн нэгдүгээр орлогч болсон юм. Хэмжээгүй эрх мэдэл түүний гарт аажим аажмаар төвлөрч эхэлсэн юм. Х.Чойбалсан бол 1921 оны Ардын хувьсгалын удирдагчдын нэг шүү дээ. Ардын хувьсгал ялсны дараа нэг үе түүнийг хариуцлагатай албан тушаалд томилдоггүй байсан юм билээ. Энэ бол түүний хувийн зан чанартай холбоотой байсан байх. “Улс төрийн маш их болчимгүй алхамуудыг хийж болзошгүй хүн!” гэж олон хүн түүнээс болгоомжилж байсан байх. Зарим үед тэр ажилгүй ч болж үзсэн байх. “Лхүмбийн хэрэг”-т холбогдуулаад олон хүнийг баривчилсан юм. Х.Чойбалсан ч бас баригдаж байсан түүх бий юм шүү. Тэр үед баривчлагдсан хүмүүсийн заримыг нь манай Дотоод яам Сибирьт цөллөгт явуулдаг байж. Ингэж цөлөгдсөн хүмүүсийн дотор Х.Чойбалсан орж байж. Тэр үед Орос руу цөлөгдсөн хүмүүс эргэж ирээгүй юм. Харин Х.Чойбалсан удалгүй эргээд ирсэн байгаа юм. Чухам ямар учир шалтгаанаар түүнийг суллаж, нутаг буцаасан талаар одоо болтол тодорхой баримт байдаггүй юм. ЗХУ-ын Улсын Аюулаас Хамгаалах Хороо (Комитет Государственной Безопасности - КГБ-ред.) “Х.Чойбалсантай цаашид хамтарч ажиллах боломжтой хүн!” гэж үзсэн байж магадгүй. Тэд нар Х.Чойбалсанг цаашид өөрсдийн зорилгод ашиглах төлөвлөгөөтэйгөөр Монголд буцаасан байж болох юм. Х.Чойбалсан ЗХУ-аас буцаж ирээд л улс төрийн гялалзсан карьер хийсэн байдаг юм. Дотоод яамны сайд, Мал, тариалангийн яамны сайд, Батлан хамгаалах яамны сайд, Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга гээд л том, том албан тушаалд ядах юмгүй дэвшиж эхэлсэн байдаг юм. Түүнийг хэн ингэж том албан тушаалд дэвшүүлээд байсан бэ? гэдэг нь их сонирхол татсан асуулт юм л даа.

Энэ үед манай Ерөнхий сайдаар П.Гэндэн ажиллаж байсан юм. Энэ бол түүний хийсэн ажил яавч биш гэдэг нь ойлгомжтой юм. П.Гэндэн бол

их омголон зантай, Монголынхоо эрх ашгийг тууштай хамгаалдаг, хурц дайчин хүн байсан юм. Тэр удаа дараа ЗХУ-д албан ёсны айлчлал хийж, ЗХУКН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга И.В.Сталин болон Зөвлөлт төрийн бусад удирдагч нартай уулзаж байсан юм. Тэд нартай хоёр улсын хамтын ажиллагааны талаар их яриа өрнүүлж, засгийн газар хоорондын хэлэлцээ хийж байсан юм. Тэр үед Монголын нийгэмд бурхны шашин их хүчтэй нөлөөлтэй байлаа. Монголын бурхны шашин, сүм хийд, лам нарын асуудлаар П.Гэндэн ЗХУКН-ын удирдлагуудтай санал солилцож байсан юм билээ. И.В.Сталин нар “Монголын бурхны шашин, сүм, хийд, лам нар бол хувьсгалын эсэргүү хүч мөн!” гэж үзэж байсан юм байж. Тийм учраас “Монголын бурхны шашныг Дотоод яамны хүчээр устгах хэрэгтэй!” гэсэн байр суурьтай байсан юм. Манай ерөнхий сайд “Монголын бурхны шашны эсрэг Дотоод яамны хүчийг хэрэглэж хэрхэвч болохгүй!” гэсэн байр суурьтай байсан юм байж. Энэ асуудлаар хоёр талын байр суурь ийм зөрөөтэй байсаар удсан юм байна л даа. П.Гэндэн И.В.Сталин хоёрын хооронд энэ асуудлаар хүчтэй маргаан үүсэж байсан юм билээ. “П.Гэндэн И.В.Сталиныг заамдаж аваад, алгасан!” гэдэг нэг яриа байдаг юм. Үнэхээр тийм явдал болсон байж магадгүй. Ямар ч байсан манай ерөнхий сайд П.Гэндэн И.В.Сталины бүдүүлэг авирт бууж өгөөгүй, өөрийн байр суурийг хамгаалаад гарч ирсэн юм билээ. Бурхны шашны асуудал бол Монголын өөрийн дотоодын асуудал шүү дээ. Энэ асуудалд Бурхны шашны гүн ухааны талаар өчүүхэн ч ойлголтгүй, “бүдүүлэг большевик”, цуст зандалчин И.В.Сталиныг оролцуулах ямар ч шаардлага байхгүй нь хэнд ч ойлгомжтой энгийн зүйл шүү дээ. Ер нь И.В.Сталин бол ямар ч боловсрол эзэмшээгүй хүн юм шүү дээ. Тэгсэн хирнээ “Олон улсын ажилчин ангийн их багш, суут удирдагч” гэсэн олон янзын тодотголтой байсан юм.

Зарим Орос хүн И.В.Сталины харгис хэрцгий, адал балмад үйл ажиллагааг онолын үүднээс тайлбарлах гэж оролддог байх. Энд ямар ч онол хэрэггүй. И.В.Сталин бол зөвхөн өөрөө төрийн эрх мэдлийг барьж байхын тулд Оросын их ард түмнийг цусан далайд хутгасан хүн юм. Түүний ямар ч боловсрол эзэмшээгүй, бүдүүлэг, харанхуй байдал нь ямар ч аргаар хамаагүй, зөвхөн өөрөө л төрийн эрх мэдлийг барьж байх хүсэл, шуналд нь нөлөөлсөн байх. Зөвхөн энэ зорилгодоо хүрэхийн тулд тэр ямар ч гэмгүй үй олон хүнийг алсан юм. Боловсролтой, соёлтой хүнээс ийм үйлдэл хэзээ ч гарахгүй шүү дээ. Энэ бол хүн төрөлхтний түүхээр батлагдсан зүйл. Харин яагаад ийм хүн төрийн эрхэнд гарсан юм бэ? гэдэг бол өөр асуудал юм. Тэгэхээр ер нь аливаа нийгмийн хувьсгал гэдэг бол хүсээд байх зүйл биш юм л даа. Төрийн эрх мэдлийг барьж байгаа хүний хувийн зан чанар, боловсрол мэдлэгийн түвшнээс улс орон, ард түмний

хувь заяа их хамааралтай байдаг юм байна.

И.В.Сталин тэргүүтэй ЗХУКН-ын удирдлагууд Монголын бурхны шашны асуудлаас болоод Монголд бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэхээс татгалзаж эхэлсэн юм байна. Энэ бол И.В.Сталины хийж чадах ганц ажил байсан байж магадгүй. Манай хоёр улсын харилцаанд ийм бэрхшээл үүссэн тул МАХН-ын дотор П.Гэндэнгийн энэ байр суурины талаар бас шүүмжлэлтэй хандах хандлага гарч ирсэн байна. Монголын бурхны шашин сүм, хийд лам нарын асуудлаар ЗХУКН-ын баримталж байгаа байр суурьт зарим нэгэн буулт хийх бодолтой хүмүүс МАХН-ын удирдлагад байсан байна. Тэднийг МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга Лувсаншарав, Элдэв-Очир, Х.Чойбалсан нар тэргүүлж байсан байна. Гол нь Х.Чойбалсан байсан юм. 1936 онд эд нар хүч хавсарч байгаад П.Гэндэнг Ерөнхий сайдын албан тушаалаас нь огцруулжээ. Ингэж П.Гэндэнг огцруулсан нь Монгол дахь улс төрийн их хэлмэгдүүлэлтийн эхлэлт болсон юм. Тэр үед ЗХУ-аас Монголд суугаа элчин сайд нь Смирнов гэдэг хүн байв.

П.Гэндэнг огцруулсны дараа Дотоод яам Монголын төр, нийгмийн нэртэй зүтгэлтэн 114 хүнийг баривчлаж авсан юм. Үүнийг “зуун арван дөрөвийн хэрэг” гэж нэрлэдэг юм. Эднийг баривчлахад гол саад болж байсан хүн нь П.Гэндэн байсан юм байж. П.Гэндэн огцорсны дараа Монголын засгийн газарт түүнтэй ижил байр суурьтай цөөхөн хүн байсны нэг нь М.Дэмид юм. М.Дэмид бол МАХН-ын ТХ-ны тэргүүлэгч гишүүн, Батлан хамгаалах яамны сайд, Бүх цэргийн жанжин зэрэг алба тушаалыг хашиж байсан их нэр хүндтэй хүн байлаа шүү дээ. Ер нь улсын доторхи хоёрдугаар хүн байсан юм. МАХН-ын удирдлагад орсон Х.Чойбалсан нарын хүмүүс П.Гэндэнг огцруулсны дараа М.Дэмидийг огцруулах ажлыг хийж эхэлсэн юм. Энэ хэрэг явдал дараах байдлаар өрнөсөн юм.

1937 оны 8-р сар ЗХУ-ын Улаан армийн 20 жилийн ойн баярт оролцох урилгыг К.Е.Ворошиловоос М.Дэмид хүлээж авсан байна. Тэр үед К.Е.Ворошилов ЗХУ-ын Батлан хамгаалах яамны сайд байсан юм. М.Дэмид Монгол улсын Батлан хамгаалах яамны сайд, Бүх цэргийн жанжны хувьд энэ уригыг хүлээж аваад, тэр ойд оролцохоор Москва руу явжээ. Тэр үед манайд төмөр зам орж ирээгүй байлаа. Москва орохын тулд эхлээд Улаан-Үд хүртэл машинаар яваад, тэндээсээ суудлын галт тэргэнд суудаг байлаа. М.Дэмид Улаан-Үд хүрээд суудлын галт тэргэнд суусан байна. Тэр ойн баярын арга хэмжээнд оролцохоор явж байгаа тул эхнэрээ дагуулж явсан юм байна. Эхнэрээс нь гадна Батлан хамгаалах яамны нилээд хэдэн хүн түүнтэй хамт явсан юм билээ. Тэд нар галт тэргэнд суугаад хэсэг явж байтал Улаанбаатараас “Яаралтай ажил гарсан тул М.Дэмид жанжин та буцаж ирнэ үү!” гэсэн дуудлага ирсэн

юм байна л даа. Ингээд М.Дэмид Сибирийн нэг өртөөн дээр буугаад, буцаад Улаан-Үдээрээ дайраад Монголд ирсэн юм байна. Түүний эхнэр болон хамт явсан хүмүүс нь тэр чигтээ Москва явсан юм байна. М.Дэмид Улаанбаатарт эргээд иртэл түүнийг дуудах онцын шаардлага ч байгаагүй, бараг хэн дуудсан нь мэдэгдэхгүй шахам л байж. Ингээд тэр хэд хоноод дахиад Улаан-Үдээрээ дайраад Москва руу явсан байна. Улаан-Үдээс тэр суудлын галт тэргэнд суух ёстой байж. Гэтэл түүнийг суудлын галт тэргэнд суулгасангүй. Түүний оронд ачааны галт тэрэгний араас хоёр суудлын нэмэгдэл вагон залгаад, түүндээ суулгажээ. Түүний аялалыг хариуцаж байсан Зөвлөлтийн талын хүмүүс “Суудлын галт тэрэгний хуваарь таарахгүй байна!” гэж энэ үйлдлээ түүнд тайлбарласан гэдэг юм билээ. М.Дэмидтэй хамт манай Батлан хамгаалах яамны Их бууны газрын дарга Д.Жанцанхорлоо гэдэг хүн явсан юм байна. Мөн Монголд суугаа ЗХУ-ын Элчин сайдын яамны зөвлөх ажилтан С.Доржаев гэдэг буриад хүн эхнэртэйгээ хамт явсан юм байна. Түүнээс гадна Москвад суугаа манай Элчин сайдын яамны ажилтан Д.Гомбосүрэн гэж хүн явжээ. Бас ЗХУ-д сурч байсан Р.Дагзмаа гэдэг нэг оюутан явсан юм билээ. Энэ Дагзмаа бол Д.Гомбосүрэнгийн төрөл байсан байж магадгүй. Ийм хүмүүс тэр нэмэгдэл вагонд суужээ. Тэр нэмэгдэл вагонд вагон-ресторан байсангүй. Тэр вагонд нэг том дугуй ширээ байж. Тэд нар бүгдээрээ тэр ширээг тойрч суугаад өглөө орой, өдрийн хоолоо иддэг байж. Тэдэнд хоол ундыг нь зөвлөлтийн талын хүмүүс бэлтгэж өгдөг байсан юм байж л дээ. Тэгээд Улаан-Үүдээс цааш Сибирийн “Тайга” гэдэг өртөөн дээр ирсэн юм байна л даа. Тэнд тэд нарт үдийн хоол өгсөн юм билээ. Эхлээд шөлтэй хоол өгөөд дараа нь банш өгсөн юм шиг байгаа юм. Тэд нар тэр баншийг идээд л бүгд ухаан алдаад унасан юм шиг байгаа юм. Энэ тухай хожим тэдэнтэй хамт явж байсан Дагзмаа ярьсан байдаг юм. Түүний яриагаар бол Дагзмаа ч ухаан алдаад унасан байна. Тэгээд хэсэг хугацааны дараа ухаан ороод харсан чинь М.Дэмид жанжин, их бууны газрын дарга Д.Жанцанхорлоо хоёр байхгүй, бусад нь бүгд ухаангүй хэвтэж байсан байна л даа. Тэгээд галт тэрэг ч зогссонгүй тэднийг тэр чигт аваад л Москва явсан байгаа юм. Москвад очоод тэднийг эмнэлэлт хэвтүүлээд эмчилгээ хийжээ. Тэдэнд “Хоолны хордлого болсон!” гэсэн онош тавьсан юм байна. Тэднийг эмчилгээ хийлгэж байхад “М.Дэмид жажин, Д.Жанцанхорлоо хоёр нас барлаа!” гэсэн мэдээ ирсэн байна. Ингэж тэр өөртэй нь хамт явсан М.Дэмид жанжин, Д.Жанцанхорлоо хоёр нас барсныг мэджээ. Тэр үед М.Дэмид жанжны эхнэр Москвад байсан шүү дээ. “М.Дэмид жанжин нас барлаа!” гэдэг мэдээг аваад, тэр шууд Сибирийн “Тайга” өртөөн дээр ирсэн байна. Тэнд ирээд М.Дэмид жанжны цогцсыг түүнд үзүүлэхийг шаардсан байна. Гэтэл М.Дэмид жанжны цогцос нь их зодуулсны ул

мөртэй, бие нь бүхэлдээ их хүрэн няц болсон байж. Түүнд энэ талаар хэн ч тайлбар хийсэнгүй.

Тэгээд М.Дэмид, Д.Жанцанхорлоо нарын шарилыг Монгол руу явуулсан байна. М.Дэмид, Д.Жанцанхорлоо нарын шарил Улаанбаатарт ирэх үед болж байсан үйл явдлуудыг би өөрийн нүдээр харж байлаа. Энэ чинь 1937 он шүү дээ. “М. Дэмид жанжин нас барлаа!” гээд ард түмэн маш их гашуудсан юм. Сонин, хэвлэл дээр М.Дэмид жанжны нас барсан тухай мэдээнүүд гарлаа. Улс орон даяар уй гашуудал зарлалаа. Ер нь их сүр, дуулиантай үйл явдал болж байлаа. Энэ байдал арав гаруй хоног л үргэлжилсэн байх. Ингээд түүнийг манай төрийн тэргүүн, сайд дарга нар, нэр хүндтэй хүмүүсийг оршуулдаг Алтан өлгийд оршууллаа. Тэнд түүний хүрэл хөшөөг босголоо.

Ингээд хэд хонож байтал гэнэт нэг өдөр “М.Дэмид хувьсгалын эсэргүү байжээ!” гэсэн яриа гараад л бөөн шуугиан дэгдлээ. Сонин, хэвлэл дээгүүр “Гэндэн, Дэмид нарын хувьсгалын эсэргүү бүлэг ажиллаж байсан!” гээд л баахан юм бичдэг боллоо. Тэднийг муу хэлж, харааж зүхсэн зүйлүүд хэвлэлээс ер нь салахаа байлаа. Тэр үед хүмүүсийн сэтгэл санаа маш их тогтворгүй, улс орон даяар түгшүүрийн байдалд орсон байлаа шүү дээ. Үнэн худалыг ялгаж ойлгоход хэцүүхэн л юм болж байлаа. Тэр үед ийм юм болж байлаа. М.Дэмид жанжны нас барсан шалтгаан бол эхнээсээ эхлээд бүгд зохион байгуулалттай хийгдсэн зүйл гэдэг нь ойлгомжтой шүү дээ. Ингэж “Гэндэн, Дэмид нарын хувьсгалын эсэргүү бүлгийн хэрэг!” гэдэг бас нэгэн “зохиомол хэрэг” буй болсон юм.

4 Лам нарын шүүх хурал.

Б Н: 1937 оны зун намайг хөдөө нутагтаа байх хугацаанд дуулиан, шуугиантай үйл явдлууд болсоор л байсан юм. “Ензон хамба Лувсанхайнчиг, дэд хамба Дамдин, манзушир хутагт Цэрэндорж нарыг Дотоод яам баривчиллаа!” гээд л яригдаад байлаа. Манайхан тэр үед их шүтлэгтэй байсан болохоор энэ үйл явдлуудад их зочирдож байсан юм. “Багшийг барьчихсан байна!” гээд л ам амнаас дамжуулаад л яриад байлаа. Маш их яриа болж байлаа шүү дээ. Гэхдээ энэ яриаг сэмхэн шивэр авир хийсэн маягтай л яриад байсан юм. Хүмүүс өөрсдөө бас баригдахаас айгаад, дургүйцлээ ердөө ил гаргаж хэлдэггүй байдлаа шүү дээ. Монголын нийгэм бүхэлдээ айдас, хүйдэст автсан юм. “Юу болдог бол? Яадаг бол?” гэж битүү санаа зовсон хүмүүс л байсан юм. Маш их түгшүүртэй байлаа.

Би зуны амралтаа дуусгаад Улаанбаатарт орж ирэхэд энэ яриа улам бүр их болж байсан юм. Хүн болгон амандаа сэмхэн нэг юм шивнэж явдаг байлаа. Тэр намар намайг Улаанбаатарт орж ирснээс хойш нэг их удалгүй

баривчлагдсан том лам нарын хэргийг таслан шийтгэх шүүх хурал боллоо. Тэр хурал одоогийн манай Засгийн газрын ордон байгаа газарт байсан “Бөмбөгөр ногоон” театрт болсон юм. “Бөмбөгөр ногоон” театр хожим шатаж утсан юм. Чухам түүнийг зориуд шатаасан уу? Эсвэл санамсаргүй байдлаас гал гарсан уу? Бүү мэд. Тэнд Дотоод яаманд баривчлагдсан олон том лам нарыг улс төрийн хилс хэрэгт гүтгэж, шүүх хурал явуулж байсан болохоор зориуд шатаасан байж болох юм. Тэр барилга ид шатаад гал нь дүрэлзэн асаж байхад нь “Сайхан шатаж байна шүү!” гэж хүмүүс хэлж байсан гэдэг нэг яриа байдаг юм. Үнэхээр түүнийг шатаах сонирхолтой хүмүүс байсан байж болох юм.

Одоогийн Сүхбаатарын талбай тэр үед их чулуутай том талбай байсан юм. Сүхбаатарын хөшөө байгаа яг тэр газарт нэг модон индэр байсан юм. Баяр болохоор тэнд хөдөлмөрчдийн цуглаан болдог, МАХН-ын удирдагчид тэр индэр дээрээс хөдөлмөрчдөд хандаж үг хэлдэг байсан юм. Тэр үед “Хөдөлмөрчдийн баярын жагсаал” болдоггүй байсан юм. Тийм жагсаалыг хожим хийдэг болсон юм шүү дээ.

Тэр шүүх хурлын ажиллагаа эхлэх үед тэр модон индрийн хоёр талд хоёр өндөр бүдүүн шон зоогоод, түүн дээрээ хоёр том чанга яригч байрлуулсан юм. Тэгээд “Бөмбөгөр ногоон” театр дотор болж байгаа шүүх хурлын ажиллагааг тэр чанга яригчаар дамжуулж байсан юм. Тэр хоёр чанга яригч дээр залуухан, маш олон лам нар цуглараад л шүүх хурлын ажиллагааг чагнадаг байсан юм. Тэр чанга яригчийг зарим үед тасалчихдаг байлаа. Би тэр Бөмбөгөр ногоон театрын хойд талд, ойрхон газарт нутгийн айлд суудаг байсан юм. Би хичээлээ тараад харих замдаа тэр талбайг дайрч гардаг байлаа л даа. Шүүх хурал олон хоног үргэлжилсэн юм. Ёнзон хамба Лувсанхаймчиг гэдэг чинь түвд хүн байсан юм. Нөгөө чанга яригчаар түүний ярихыг би сонсож байсан юм. Тэр түвд хүн болохоор Монголоор тийм сайн ярьж чадахгүй л дээ. Хэл нь сайн ойлгогдохгүй шүү дээ. Би хүүхэд байсан болохоор надад хачин хоолойгоор нэг хүн яриад л байсан шиг санагдаж байна. Чухам юу ярьж байсныг нь би огт ойлгодоггүй байлаа. Нэг өдөр урьдын адилаар нөгөө талбай дээгүүр харих гээд явж байтал Бөмбөгөр ногоон театрын баруун талд маш олон тооны залуухан лам нар цугласан байна. Би юу болж байгааг үзэхээр очлоо. Гэтэл тэнд нэг том модон хайс барьсан байна. Тэр модон хайсыг дагаад л маш олон залуу лам нар зогссон байна. Тэр модон хайсан дотор цэргийн хувцастай хоёр хүн зогсож байна. Нэг нь цэргийн дарга боллоотой юм. Нөгөө нь цэрэг л байсан байх. Тэр цэрэг гартаа нэг пулемёт барьчихсан байна. Тэр модон хайс дагаад зогссон залуу лам нар руу пулемётоо эргүүлээд “Буудна шүү! Буудлаа шүү!” гээд л чанга, чанга хашгрич байна. Би лам нарын хоорондуур орж явсаар модон хайсанд тулж

ирлээ. Гэтэл нөгөө цэргийн хүний пулемётны ам нь над руу чиглээд ирэх шиг л боллоо. Тэгтэл тэр цэргийн хүн “Буудлаа шүү! Буудна шүү!” гээд л дахиад чанга хэлж байна. Надад хандаж хэлж байгаа юм шиг л санагдаад, бие хүйт оргиод л явчихлаа. Тэр модон хайсыг дагаад зогссон залуу лам нар “Одоо Ёнзон хамба ярьж байна! Одоо хурал тарах болж байна!” гээд л хоорондоо ярьж байна. Бөмбөгөр ногоон театр баруун тийшээ харсан нэг хаалгатай юм. Тэр хаалганы яг дэргэд нь том жижиг хоёр автобус зогсож байна. Тэр том, жижиг хоёр автобусны арын хаалгыг нь онгойлгоод Бөмбөгөр ногоон театрын хаалганд яг тулгаад тавьсан байна. Шүүх хурал дуусахаар тэр хоёр автобусанд нөгөө том лам нарыг ачаад явах ёстой байсан юм байжээ. Тэднийг Бөмбөгөр ногоон театраас гараад ирэхээр нь тэнд байсан залуу лам нар булааж авахаар зэхэж байсан юм байж. Хэрвээ том лам нараа булаахаар модон хайсанд дайрч орж ирвэл, залуу лам нар руу гал нээх зорилгоор тэнд пулемёт байрлуулсан юм байж л дээ. Би пулемётноос нь айгаад модон хайснаас нилээд холдоод зогсож байлаа. Тэнд зогсож байсан залуу лам нар хоорондоо шивэр, авир гээд юм яриад л байх юм. Хурал ч тарахгүй юм. Ингээд нилээд хугацаа өнгөрлөө. Пулемёт барьсан цэргийн хүн үе үе “Зүгээр л байгаарай! Болохгүй бол шууд л шүршчихнэ шүү!” гээд л чанга чанга хэлэх юм. Гэнэт тэнд зогсож байсан залуу лам нар хашгиралдаад л урагшаа гүйлдлээ. Би ч тэднийг дагаад л гүйлээ. Гэтэл шүүх хурлаас шийтгүүлсэн том лам нарыг Бөмбөгөр ногоон театрын цаад талын хаалгаар гаргаад, өөр автобусанд ачаад аваад явсан юм байж л дээ. Баруун талын хаалган дээр байсан хоёр автобус бол зөвхөн анхаарал сарниулах зорилготой байсан юм байж. Тийм маягаар том лам нарын шүүх хурал болж байсныг би үзсэн юм. Ард түмэн их харамсан гашуудаж байсан даа.

Түүний өмнө 1938 оны 9-р сарын 10-ны өдөр манай Засгийн газар, цэргийн дээд удирдлагын 65 хүнийг Дотоод яам баривчилсан баримт байдаг юм. Тэднийг баривчлахдаа эхлээд Дотоод яаман дээр дуудаж ирүүлдэг байж. Тэгээд Дотоод яамны сайд Х.Чойбалсангийн ажлын өрөөнд оруулдаг байж. Х.Чойбалсан ирсэн хүнд “Таныг баривчиллаа!” гэж хэлдэг байж. Х.Чойбалсанг ингэж хэлмэгц тэнд байдаг Дотоод яамны ажилтнууд ирсэн хүний гарыг нь гавлаад л аваад явдаг байж. Нэг шөнийн дотор 65 хүнийг ийм маягаар баривчилсан байгаа юм. Түүний маргааш нь олны дунд олон янзын яриа гарч байсан юм. “Төрийн эргэлт болж байгаа юм болов уу? Төрийн эргэлт л болж байх шиг байна!” гээд л хүмүүс ярьдаг байлаа. Нилэнхүйдээ айдас, хүйдэст автаж байлаа шүү дээ. Энэ баривчилгаа бүр 9-р сарын 30 хүртэл л үргэлжилсэн юм. 9-р сарын 30-ны өдөр бас 70 орчим хүнийг баривчилсан баримт байдаг юм билээ. Энэ 70 хүний дотор Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга, Бүх цэргийн

жанжны орлогч Д.Самбуу гэдэг хүн орж байсан юм. Бас Батлан хамгаалах яамны орлогч сайд С.Дарьзав, Жанжин штабын дарга Ж.Малж, Цэргийн эмнэлэгийн дарга С.Дэндэв, Батлан хамгаалах яамны 3-р газрын дарга Ч.Очирбат, Гэгээрлийн яамны сайд Р.Баттөр, Улсын бага хурлын дарга Ц.Ламжав, Дорнод аймгийн дарга Ч.Шагдар нар орж байсан байгаа юм. Эдний дундаас арван дөрвөн хүний хэргийг шүүх хурлаар тусгайлан тасалсан юм.

Би тэр шүүх хурлууд болж байгаа “Бөмбөгөр ногоон” театрын хаалгаар байнга очиж сонирхдог байлаа. Түүнд МАХН-ын гишүүн, үнэмлэх бичигтэй хүмүүс л голдуу орж байсан юм. Үүдэнд нь буу барьсан цэргийн харуул хамгаалалт байнга зогсдог байлаа. Мөн л нөгөө чанга яригчаар “Бөмбөгөр ногоон” театр дотор болж байгаа хурлын ажиллагааг нэвтрүүлдэг байлаа. Тэр арван дөрвөн хүний хэргийг авч хэлэлцсэн шүүх хурал арав илүү хоног үргэлжилсэн юм. Тэгээд л шүүхийн шийдвэр гарсан. Бүгдийг нь цаазаар авах ял оноож байсан юм. Тэднээс хоёр хүн Улсын бага хуралд өргөдөл гаргаж давж заалдсан юм. Тэр үед Улсын бага хурлын даргаар Л.Догсом гуай ажиллаж байлаа. Л.Догсом гуай бол 1921 оны Ардын хувьсгалын нэртэй зүтгэлтэн, Д.Сүхбаатарын хамтран зүтгэгч хүн шүү дээ. Тэр хоёрын хэргийг Улсын бага хурал авч хэлэлцээд, цаазаар авах ялыг нь өөрчлөж байсан юм. Энэ хоёр бол Дорнод аймгийн дарга Ч.Шагдар, Улсын бага хурлын дарга асан Ц.Ламжав нар юм.

Ц.Ламжавын хүү Л.Ванган бол сүүлд манай соёл, урлагийн алтан үеийн маш том зүтгэлтэн болсон хүн шүү дээ. Түүний хүү Л.Нацаг ч бас л соёлын зүтгэлтэн болсон юм. Ц.Ламжав гуай бол ер нь ийм хүүхдүүдийнхээ хүчээр өршөөгдсөн юм даа. Энэ хоёр хүн өршөөгдөөд, бусад арван хоёрыг нь Дотоод яам цаазаар авсан юм.

1990 онд улс төрийн хэлмэгдэлд өртсөн хүмүүсийг цагаатгах ажил эхэлсэн шүү дээ. Энэ цагаатгах ажлын хүрээнд манай Дотоод яам улс төрийн хилс хэрэгт холбогдсон хүмүүсийг буудаж алдаг байсан цаазын газарыг нь олж тогтоосон юм. Тэр болтол Дотоод яамны цаазын газар маш нууц байлаа шүү дээ. Улаанбаатар хотын баруун урд талд байдаг Сонгино хайрхан уулын ард нэг том жалга байдаг юм байна. Тэр бол Дотоод яамны цаазын газар байж. Тэнд улс төрийн хилс хэрэгт гүтгэгдсэн бүх хүмүүсийг буудаж алсан юм байж. Энэ арван хоёр хүнийг 10-р сарын 24-ны шөнө буудаж алсан юм байна. Тэр буудаж алах ажиллагаанд МАХН-ын удирдагчид өөрсдөө оролцсон байдаг юм. Тэнд А.Амар, Л.Догсом, Х.Чойбалсан нар ирсэн байна. Цаазаар авах ёстой хүмүүсийн гарыг ард нь хүлээд, аманд нь алчуур чихсэн байж. Тэгээд бүгдийг нь ухсан нүхний аман дээр буруу харуулаад, өвдгөөр нь сөхрүүлэн суулгаж байгаад л буудсан юм байна. Ингээд хоёр хүнийг буудаад байтал А.Амар

гуай шууд яваад, машиндаа ороод суучихсан юм байна л даа. Тэр шөнө хүйтэн ч байсан юм байна. Гэтэл Дотоод яаны сайд Х.Чойбалсан “Амар яагаад машиндаа суугаад байна? Сул нүх байна уу? Амрыг ч гэсэн буудчихъя!” гэж хашгирч байсан байгаа юм. Х.Чойбалсан Дотоод яамны цаазын газар МАХН-ын удирдагч олон хүнийг тэр өдөр хүчээр авч ирсэн нь тэднийг айлган сүрдүүлэх зорилготой байсан нь тодорхой шүү дээ.

1990-ээд оны эхээр энэ арван хоёр хүний шарил байгаа цаазын газрыг олж тогтоогоод, түүнийг ухаж, тэнд байгаа шарилыг нягтлаж үзсэн юм. Гэтэл тэндээс арван гурван хүний цогцос гарсан байна. Дотоод яамны шийдвэрээр арван хоёр хүнийг л тэнд буудсан шүү дээ. Яагаад нэг хүн илүү байгаагийн учрыг олох гээд нилээд ажил болсон юм. Гэтэл ийм хэрэг болсоныг нь тогтоосон юм. Тэр шөнө тэнд олон хүн, машин ирээд, бууны дуу гарч, их чимээ шуугиан дэгджээ. Тэр орчимд нутаглаж байсан нэг малчин айлын 17-18 орчим насны нэг хүү, тэр газарт нууцаар дөхөж ирээд, тэнд юу болоод байгааг харсан байна. Гэтэл түүнийг Дотоод яамны ажилтнууд барьж аваад, нөгөө хүмүүстэй хамт буудаж алсан байна. Энэ бол Дотоод яам өөрийнхөө үйлдсэн аймшигт хэргийн гэрчийг үлдээхгүй тулд хийсэн ажил байж.

1990-ээд оны эхээр тэр цаазын газарт улс төрийн хилс хэрэгт гүтгэгдэж цаазлуулсан хүмүүсийн дурсгалд зориулж хүрэл хөшөө босгосон юм. Тэр хөшөөн дээр буудуулсан хүмүүсийн нэрийг нь бичээд (12+1=13) гэсэн бичиг хийсэн юм.

1937 оны намар намайг аавтайгаа Улаанбаатарт орж ирснээс хойш л ер нь тасралтгүй баривчилгаа явагдаж байсан юм шүү дээ. Өдөр болгон л бөөн бөөн хүмүүсийг баривчилсан тухай мэдээ сонсогддог байлаа. Лам нарыг ч бөөн бөөнөөр нь бариад л эхэлсэн юм. Тэгээд л бүгдийг нь цаазлаж байсан юм.

Тэр үед Улаанбаатарт ажиллаж байсан бүх, сүм дуганууд хаагдсан юм шүү дээ. Том лам нарыг нь баривчлаад цаазлаад л, жижиг залуу лам нар нь сүмээсээ гарч хар хүн болж байлаа. Хаагдсан сүм, дугануудын бурхан тахил нь энд тэндгүй хөглөрөөд л, хог болоод хэвтэж байдаг байлаа шүү дээ. Шатааж болохыг нь овоолж байгаад л шатаадаг байлаа. Ном, судрыг энд, тэнд овоолж байгаад л бөөн бөөнөөр нь шатааж байсан юм. Улаанбаатарын гудамжаар ном, судрын шатаж дуусаагүй хуудаснууд хийсээд л, хярвас, хэншүү үнэртгээд л, хар утаа суунаглаад л их эвгүй байж билээ. Сүм, дуганы барилгуудыг нь бол шууд л шатааж байсан юм.

Саяхан “Хамбын овоо” гэдэг газар барилгын ажил хийж байсан компани олон хүний араг яс байгаатай тулгарчээ. Тэгээд түүх судлалын олон хүн тэнд очиж шинжилгээ хийсэн байна. Тэд нар “Энэ бол лам нарыг буудаж алсан цаазын газар мөн!” гэж тогтоосон байна. Тэндээс

олон зуун хүний гавлын яс гарсан бөгөөд бүгдээрээ сумны нүхтэй байсан байна. Энэ баримтыг МАХН нуухыг их оролдлоо шүү дээ. Энэ ажлыг сурвалжилж, олон нийтэд мэдээлж байсан сурвалжлагч, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийг МАХН-ын одоогийн удирдлагын зүгээс дарамталсан байгаа юм. Тэд нар “сонгуулийн өмнө энэ аймшигт хэрэг илэрч, сонгогчдын сэтгэл зүйд нөлөөлнө!” гэж айж байсан юм.

Манай Гандантэгчинлин хийд дээр Өндөр Жанрайсаг гэдэг сайхан бурхан байлаа шүү дээ. Тэр үед энэ бурхныг бас буулгаж эхэлсэн юм. Түүний хажууд олон ижил хэмжээтэй цагаан авдрууд л байгаад байсан юм. Тэр авдруудад буулгасан бурхнуудыг л хийгээд байж. Энэ ажил олон хоног үргэлжилсэн дээ. Тэгж байгаад тэр авдрууд нэг л өдөр алга болчихсон юм. “Тэднийг Орос улс руу аваад явсан гэнэ!” гээд л хүмүүс шивэр, авир ярьж байсан юм. 1990-ээд оноос хойш Монголын Соёлын сангийн шугамаар тэр бурхнууд Оросын хаана байгааг нь олж тогтоох оролдлогыг хийсэн юм. Оросын тал “Зөвлөлт-Германы дайны үед тэр бурхнуудыг хайлуулаад их бууны сумны хонгио хийхэд ашигласан байх!” гэсэн тайлбар хийдэг юм билээ. Ингээд тэр бурхнууд олдоогүй юм. Би тэр үед залуу, хүүхэд шахуу байсан болохоор энэ бүх болж байгаа үйл явдлуудын учрыг сайн ойлгодоггүй байсан байх л даа. Тэр үед өдөр болгон л нэг үйл явдал болдог байлаа. Тэгээд л бид нар хүүхдүүд сонирхоод л гүйгээд очдог байлаа шүү дээ. Нас ахимаг хүмүүс сэтгэл санааны гүн хямралд орж байсан юм шиг байгаа юм. Хүмүүс бие биенээсээ айгаад л гэр орноосоо ч гарахаа байсан юм шүү дээ. Хүүхэд, залуучууд л гадуур явдаг байлаа. Өглөө босоход л нэг шинэ мэдээ дуулддаг байлаа. “Тийм газрын дарга, тийм яамны сайдыг баривчилсан гэнэ!” гээд өглөө бүр нэг шинэ мэдээ сонсогддог байлаа. Ийм байдал 1939 он дуустал үргэлжилсэн юм.

5 Дотоод яамны баривчилгаа.

Б Н: Би Холбооны техникумаа төгсөөгүй байлаа. 3-р ангид сурч байхад бидний дундаас нилээд хэдэн хүүхдийг сонгож аваад Харилцаа холбооны түр сургуульд оруулж, “морз” дамжуулах аппарат дээр дадлага хийлгэсэн юм. Биднээс өмнө нь тэнд ажиллаж байсан хүмүүсийг баривчлаад бүгдийг нь цаазалсан юм гэнэ. Тэгээд тэнд ажиллах хүнгүй болоод биднийг авч түр сургууль хийлгээд, тэнд ажиллуулах болсон юм.

1938 онд би тэнд очоод удаагүй байлаа. Нэг шөнө жижүүрт гарлаа. Ажлынхаа байранд бид жижүүрлээд хонох ёстой байлаа. Жижүүрт долоон хүн гардаг журамтай байсан юм. Бид нар шөнө ажил дээрээ байж байлаа. Би нойр хүрээд л зүүрмэглэх гээд л байна. Тэвчээр гаргаад л

зүүрмэглэхгүйг хичээгээд сууж байлаа. Гэтэл аргагүйн эрхэнд нэг минут орчим зүйрмэглэсэн байх. Гэнэт л бидний ажлын байр руу гаднаас олон хүн шууд л ороод ирлээ. Тэдний дунд цэргийн хувцастай хүн нэг ч байсангүй. Бүгд энгийн хувцастай байсан юм. Би тэднийг энгийн хувцастай ч Дотоод яамныхан байна гэдгийг шууд ойлголоо. Дотор арзас хийгээд л явчихлаа. Миний хажууд надаас хоёр гурав ах нэг залуу суудаг байсан юм. Түүнд Дотоод яамныхан нэг бичиг өгөөд уншуулж байна. Миний нөгөө талд Д.Ядамсүрэн гэдэг нэг залуу суудаг байсан юм. Түүнд бас нэг бичиг өгөөд уншуулж байна. Манай тасгийн дарга хорин хоёр настай өндөр тэгшхэн нуруутай сайхан залуу байсан юм. Түүнд нэг бичиг өгөөд уншуулаа. Тэр Дорнодод харилцаа холбооны ажил хийж байсан хүн л дээ. Тэд нарыг бичгээ уншаад дуусмагц “Ойлгосон уу?” гэж асууж байна. Бүгд “Ойлгосон!” гэж хэлэх шиг л болсон. Тэр орж ирсэн хүмүүсийн нэг нь “Бос!” гээд л цэргийн хүнд команд өгч байгаа юм шиг командлаж байна.

Тэднийг баривчилж байна гэдгийг би шууд ойлголоо. Надад бас бичиг өгөх байх гээд би хүлээж байлаа. Манай хүмүүсийн өмнө байсан бичигтэй хуудаснуудыг бүгдийг нь сөхөж хараад, урт нарийхан утас гаргаж ирээд бүгдийг нь багцлаад баглачихлаа. Тэгээд л Дотоод яамны ямар хэлтэс ч гэнэ вэ, мэдэхгүй, лац тавиад л тамга дарчихлаа.

Тэгээд тэр бичигнүүдийг аваад л, нөгөө гурван хүнийг туугаад л гарлаа. Би өөр нэг эрэгтэй, бас хоёр эмэгтэй бид дөрөв байрандаа үлдлээ. Бүгд айсандаа болоод үг ч дуугарч чадахгүй шахам л байлаа. Хэсэг хугацаа өнгөрөхөд ухаан ороод л бүгд цонхон дээрээ очоод, хаалттай хөшигнийхөө завсраар харлаа. Манай хашаан дотор Дотоод яам хүн баривчлахдаа хэрэглэдэг “М-пикап” гэдэг хоёр машин зогсож байна. Манай гурван хүнийг тэр машинуудын урд талын нь машинд суулгаж байгаа нь харагдлаа. Хойд талынх нь машинд Харилцаа хобооны газар ажилладаг хүн, бас Шуудангийн газрын хүн суусан харагдлаа. Ингээд машинууд хөдлөөд, шөнийн харанхуйд уусаад алга боллоо.

Хэдэн өдрийн дараа шинэ тасгийн дарга ирлээ. Тэр ирээд л “Бидний дунд хувьсгалын эсэргүүчүүд шургалсан байж. Та нар сонор сэрэмж муутай байснаас тэднийг мэдээгүй байна. Цаашдаа сонор сэрэмжтэй байх хэрэгтэй!” гэж яриад л сүртэй байлаа. Хэд хоноод дахиад л өнөө шинэ дарга маань өөрөө баригдаад л явлаа. Энэ маягаар ердөө амар заяа үзсэнгүй. Энэ баривчилгаанд цэргийнхэн их өртсөн юм шүү дээ. 1937 оны 9-р сараас 1939 оны 4-р сар хүртэл цэргийнхний баривчилгаа үргэлжилсэн юм. Баривчлах тэр бичиг нь дандаа Дотоод яамны сайд Х.Чойбалсангийн гарын үсэгтэй байсан юм. Цөөхөн тохиолдолд орлогч сайд нь гарын үсгээ зурдаг байж.

Манай гэр “Бөмбөгөр ногоон” театрын ойрхон байсан шүү дээ. “Бөмбөгөр ногоон” театрын баруун талд нь хэдхэн алхамын цаана Дотоод яам байлаа шүү дээ. Тэр үед хүмүүсийг ихэвчлэн шөнө л баривчилдаг байлаа. Заримдаа өдөр баривчлана л даа. Би Дотоод яам баривчилсан хүмүүсээ авч ирж байхыг олон удаа харсан юм. Том ачааны машиныг ногоон брезентээр бүтээгээд, кузовынх нь дөрвөн өнцөг дээр нь буутай дөрвөн хүн суусан байдаг юм. Тийм машинд баривчлагдсан хүмүүсийг ачиж ирээд л Дотоод яамны хашаанд оруулдаг байлаа. Баривчлагдсан хүмүүс ийнхүү орж байх нь харагддаг боловч гарах нь огт харагддаггүй байлаа. Тэднийг шөнөөр хаа нэг газар аваачаад бууддаг байж. Заримдаа баригдсан хүмүүсийг жагсаачихсан бөөн бөөнөөр нь буутай харгалзагч нар туугаад л явж байдаг байлаа. Тэд нар бол Дотоод яамны хашаанд ороогүй, цаазаар авах ял оноогдоогүй хүмүүс юм.

Нэг удаа би тийм бөөнөөрөө туугдаад явж байгаа хүмүүсийн хажуугаар гарч явтал тэдний дотор манай тасагт хамт ажиллаж байсан Д.Ядамсүрэн явж байхыг харсан юм. Тэр намайг олж харсангүй. Би түүнийг таньсан юм. Тэр арай л цаазлагдаагүй явсан бололтой байсан. Их өөр болсон байж билээ. Түүний тэр явж байгаа төрх, байдал одоо хүртэл мартагддаггүй, миний нүдэнд харагдаад байдаг юм.

Тэр үед маш хачин юм их болж байсан юм. Би олны дунд яригддаг байсан нэг жишээг ярья л даа. Сэлэнгэ аймагт Дотоод яамны төлөөлөгчөөр З.Дорж гэдэг хүн ажиллаж байж л дээ. Түүнд Дотоод яамнаас хоёр машин өгөөд “За, чи яваад хувьсгалын эсэргүү нарыг бариад ир! Чиний барьсан хувьсгалын эсэргүү нар энэ хоёр машиныг заавал дүүргэх ёстой шүү!” гэсэн даалгавар өгчээ. З.Дорж хойд зүгт явж, дандаа буриадууд амьдардаг нутагт очжээ. Тэгээд замдаа тааралдсан хүн болгоныг л барьж аваад, машиндаа ачаад байж. Хэд хоног ийм маягаар баривчилгаа хийсэн боловч хоёр машин нь дүүрсэнгүй гэнэ. Өөр баривчлах хүн даан ч байсангүй. Ингээд буцаад Дотоод яаман дээрээ иржээ. Түүнийг ирэхэд нь Дотоод яам “Чамайг хоёр машин дүүрэн эсэргүү бариад ир! гэж явуулсан шүү дээ. Чи яагаад тушаал биелүүлсэнгүй вэ?” гэж асуужээ. З.Дорж нилээд шазруун зантай, ааш муутай хүн байж л дээ. Тэр “Энэ л хувьсгалын эсэргүү байж магадгүй гэсэн бүх хүнийг л баривчиллаа. Өөр баривчлах хүн үлдсэнгүй шүү!” гэж хариулжээ. Даалгавар биелүүлээгүй түүнд дарга нь уурлажээ. Тэгээд З.Доржийг өөрийг нь баривчлаад нөгөө барьж ирсэн хүмүүстэй нь хамт Улаанбаатарт хүргэж ирээд, гурав хоногийн дотор цаазалсан гэнэ!” гэсэн яриа байсан юм. Энэ яриа магадгүй жаахан дэгсдүүхэн байж болох боловч үнэн байдалд их ойрхон яриа юм.

Тэр үед Дотоод яамныхан чинь “хувьсгалын эсэргүү” нарыг

баривчлах тогтоосон төлөвлөгөөтэй ажиллаж байжээ. Дотоод яамны байцаагч нарт өдөрт хэдэн хүний хэргийг шийтгэж дуусгах төлөвлөгөө өгчихдөг байж шүү дээ. Тэгээд л тэр төлөвлөгөөнийхөө дагуу л нэг байцаагч өдөрт 5 хүн ч гэдэг юм уу цаазалдаг байсан байгаа юм. Нэг байцаагч шүү дээ. Тэнд олон байцаагч ажиллана шүү дээ. Уг нь тэд нар баривчлагдаад ирсэн хүн бүрийн хэргийг нь шалгаад, үнэн худлыг тогтоох ёстой юм. Өөрөөр хэлбэл хувьсгалын эсэргүү мөн үү, биш үү гэдгийг нь тогтоох ёстой юм. Гэхдээ тэр үед нэгэнт л баривчлагдсан бол “хувьсгалын эсэргүү мөн!” гэж үзэж байж. Хүнийг тэр үед ямар үндэслэлээр баривчилж байсан бэ? Голдуу ямар ч үндэслэл байхгүй, “хувьсгалын эсэргүү” л гэсэн нэг ерөнхий үндэслэлээр баривчилдаг байж. Ийм үндэслэлээр хэнийг ч барьж болдог, цаазалж болдог байж. Байцаагч нарын хийх ажил бол баривчлагдсан хүнээр өөрөөр нь “Би хувьсгалын эсэргүү мөн! Хувьсгалын эсэргүү тийм тийм ажил хийж байсан!” гэсэн хуурамч мэдүүлэг авах явдал болсон байна. Ийм мэдүүлгийг байцаагч нар өөрсдөө зохиож бичээд түүн дээрээ баривчлагдсан хүнээр гарын үсэг зуруулдаг байж. Тэр зохиомол мэдүүлэгт гарын үсэг зурахаас татгалзсаныг нь зодож, тамлаж байгаад зуруулдаг байж. Өдөрт олон хүн баривчлагдаж ирнэ шүү дээ. Тэднийг байцаагч нар хуваагаад л авдаг байж. Бүгдээр нь өөрсдийн зохиосон мэдүүлэгтээ гарын үсэг зуруулж аваад л цаазалдаг байсан байна. Баривчлагдаад ирсэн хүмүүсээр өөрсдийн зохиосон мэдүүлэгт гарын үсэг зуруулж чадахгүй бол төлөвлөгөө нь тасрана шүү дээ. Харин төлөвлөгөөгөө биелүүлбэл магтагдаж сайшаагддаг байж. Олон “эсэргүү”-гийн хэргийг хурдан шийдсэн нь “сайн байцаагч” хэмээгдэж албан тушаалд дэвшдэг байж л дээ. Тийм учраас өөрсдийн төлөвлөгөөг биелүүлэхийг тулд тэд нар их чармайдаг байж. Байцаагч нарын хувьд бол баривчлагдсан хүмүүс бол “дайсан этгээд, хувьсгалын эсэргүү” шүү дээ. Тийм болохоор тэднийг хайрлана гэсэн ойлголт ердөө ч байсангүй! Миний аав яг ийм маягаар цааздагдсан байж магадгүй.

Тэр үед зарим аймагт баривчлагдсан хүмүүсийг хонуулах шорон хүрэлцэхгүй болсон байна. Тэгээд бүгдийг нь нэг гэрт чихэж нэг хонуулдаг байж. Багтахгүй бол хөлөөрөө түлхэж чихээд оруулдаг байж. Нэг шөнө 10-20 хүн, заримдаа түүнээс ч олон хүн бүтэж үхдэг байж. Үлдсэнийг нь өглөө нь аваачаад бууддаг байж. Гэрт багтаагүй хүмүүсийг машинаас нь буулгалгүй шууд хээр аваачаад бууддаг байж. Ийм хэрэг явдал бүх аймагт л гарч байсан юм шүү дээ. Тэр үед ийм маягаар 30 мянган хүн цаазлуулсан баримт байдаг юм. Энэ бол албан ёсоор гаргасан тоо шүү дээ. Энэ тоонд бүрэн итгэхэд хэцүү. Яг үнэнээрээ бол түүнээс хавьгүй их тоо гарах байх. МАХН энэ тоог их нууцлаж байсан юм. Одоо болтол Дотоод яамны архив бүрэн ил болоогүй байна.

6 Би байлдааны нисэгч болов.

Ичинхорлоогийн Лхагвасүрэн (цаашид **ИЛ**): Та Холбооны сургуулиасаа морз нэвтрүүлэгч болсон юм байна. Тэгээд л тэндээ ажиллаад байсан уу?

Б Н: Үгүй. 1939 оны 5-р сард намайг тэр нэвтрүүлэгчийн ажлаас халчихсан юм. Миний аавыг 1938 оны 8-р сард Дотоод яам барьсан шүү дээ. Тэгээд намайг “хувьсгалын эсэргүүгийн хүүхэд” гэсэн шалтгаанаар тэр ажлаас халчихсан юм. Тэр үед ер нь баривчлагдаж, цаазлуулсан хүний хүүхдүүдийг бүгдийг нь ажлаас нь халдаг байсан юм. Нэгэнт эцэг нь юм уу эх нь “хувьсгалын эсэргүү” гэдэг нь тодорхой болсон тул төрийн байгууллагад ажиллах ёсгүй гэж үздэг байсан юм. Би ажлаасаа халагдаад нутагтаа буцаад ирлээ. Тэгээд малаа маллаад амьдарч байлаа. Тэр үед насанд хүрсэн хүмүүст бичиг үсэг заадаг “бүлгэм” ажилладаг байсан юм. Би тийм бүлгэмд сайн дураараар ажиллаж, насанд хүрсэн хүмүүст бичиг үсэг заадаг боллоо. Нэг үгээр хэлбэл сайн дурын багш боллоо.

Ингээд ажиллаж байтал 9-р сард манай Төв аймгийн Боловсролын хэлтсээс нэг бичиг ирсэн юм. Тэр бичиг нь намайг Улаанбаатар хотын Багшийн техникумд явж суралцахыг зөвшөөрсөн бичиг байж. Ингээд би Багшийн техникумд сурахаар дахиад Улаанбаатар явлаа. Тэр үед Багшийн техникумыг гурван жил сураад төгсдөг байсан юм. Манай Багшийн техникум тэр үед их нэр хүндтэй сургууль байлаа шүү дээ. Тэнд их нэр хүндтэй багш нар ажиллаж байлаа. Тэр сургуулийн захирал нь Ж.Цэдэв гэдэг хүн байсан юм. Хожим төрийн өндөр албан тушаалд дэвшин ажиллаж байсан юм. Улсын бага хуралд ч алба хашиж байсан байх.

Би энэ сургуульд сурч байхдаа анх удаа Ю.Цэдэнбал даргыг харсан юм. Тэр ЗХУ-д сургууль төгсөж ирээд Санхүүгийг техникумд хичээлийн эрхлэгчээр томилогдоод байсан юм. Манай захирал Ж.Цэдэв тэр хоёр их сайн танилууд байсан юм. Ю.Цэдэнбал залуудаа сайхан залуу байлаа шүү дээ. Манай сургууль дээр байнга ирдэг байсан юм. Ингэж ирэхээрээ манай захирал Ж.Цэдэвтэй л голдуу уулздаг байлаа. Санхүүгийн техникумын захирал нь С.Лувсан гуай байсан юм. Би багшийн сургуульд 3 жил суралцаад төгслөө. Тэгээд Гэгээрлийн яамны шийдвэрээр Хэнтий аймгийн төвийн бага сургуульд багшаар томилогдлоо. Тэнд 1940-1941 оны хооронд нэг жил ажиллаа.

1941 оны 6-р сард Зөвлөлт-Германы дайн эхэлсэн шүү дээ. Тэгээд би өөрийн нутаг Төв аймагтаа багшлах хүсэлтэй байгаагаар илэрхийлж Гэгээрлийн яаманд өргөдөл бичсэн юм. Манай аймгийн Сэргэлэн суманд 1940 онд бага сургууль нээгдээд ажиллаж байсан юм. Гэгээрлийн яам миний хүсэлтийг авч үзээд, нутагтаа шилжихийг зөвшөөрсөн юм. Ингээд

би 1941 оноос Сэргэлэн сумын бага сургуульд багш боллоо. Би 18 настай Хэнтийд очоод 19 настай болоод Сэргэлэн сумандаа эргэж ирсэн юм. Манай Сэргэлэн сумын бага сургууль ердөө хоёр гэрт багтаж байсан юм.

Тэр үед Сэргэлэн сумын төв нь Тасгийн давааны ард Ганц худаг гэдэг газар байсан юм. Би хоёр сар хүртэл багшийнхаа ажлыг хийгээд байж байлаа. Гэтэл хоёр сард засаг захиргааны сонгууль боллоо. Намайг Сэргэлэн сумын захиргааны тэргүүлэгч гишүүн, сумын даргаар сонгочихлоо. Ингээд би 20 настай сумын засаг дарга болчихлоо. Би сумынхаа засаг дарга болсны дараахан анх удаа маршал Х.Чойбалсантай уулзсан юм. Тэр ажлаар явж байгаад манай сумаар дайраад өнгөрсөн юм байж. Х.Чойбалсан надаас олон юм асуугаагүй юм. “Ямар сургууль төгссөн бэ? Хэдэн настай вэ?” гэх мэтийн л зүйл л асуусан. Би сумын засаг даргын ажлыг удаан хийгээгүй юм. Тэр үед улсын хэмжээнд олон сургууль шинээр байгуулагдаад багш хүрэлцээ муутай байлаа. Зарим газар сумын даргаар сонгогдсон залуу багш нарыг эргүүлээд багш болгож эхэлсэн юм.

Би эргээд багш болоогүй юм. 1942 оны 6-р сард намайг Нисэхийн сургуульд оруулсан юм. Тэр үед дайны үеийн түргэвчилсэн байдлаар нисэгчдийг бэлтгэж эхэлсэн юм. 5 нисэгч, 15 техникчийн түр сургуулийг Улаанбаатарт нээсэн юм. Тэр сургуульд би нэг жил суралцаад төгслөө. Дайнд оролцуулах зорилгоор манай нэг нисэх эскадрилийг Хэнтий аймагт төвлөрүүлсэн юм. Тэнд хорооны штаб, дивизийн штабаас хүн очсон юм. Манай нэгдүгээр нисэх эскадриль “Ил-2” гэдэг онгоцоор нисдэг байлаа. Бид энэ онгоцоор дайнд орохоор бэлтгэл хийх болсон юм.

ЗХУ-ын агаарын цэргийн нисэх хүчний генерал И.В.Зайсановын тушаал гарч манай эскадриль зөвлөлтийн нисэх ангиудтай хамт дайнд оролцохоор болсон юм. Манай эскадрилийн ахлах нисэгчдэд дайны бэлэн байдалд байх тушаал ирлээ. Бид өдөр бүр л парашютаа өмсчихөөд л дохио хүлээгээд л онгоцондоо суудаг байлаа. Гэтэл манай эскадрильд дайнд оролцох команд ирсэнгүй. Харин тагнуулын байдлаар хоёр, гурван удаа нислэг хийлээ. Бидний дайнд оролцсон нь ердөө энэ л боллоо. Ингээд дайн дууслаа. Би 1942 оноос 1948 он хүртэл цэргийн нисэх хүчинд ахлах нисэгч, нисэх эскадрилийн улс төрийн газрын орлогч дарга зэрэг ажил хийж байсан юм.

7 Өмнөговь аймгийн МАХН-ын хорооны 1-р нарийн бичгийн дарга.

Б Н: Ингээд 1948 онд Батлан хамгаалах яамны улс төрийн газрын шийдвэрээр Намын шинэ хүчний сургуульд орсон юм. Тэнд 3 жил суралцаад 1951 онд тэр сургуулиа төгслөө. 1951-52 онд МАХН-ын ТХ-нд

ажиллаж байлаа. 1952-1956 онд Улаанбаатар хотын МАХН-ын хороонд Үзэл сурталын хэлтсийн эрхлэгч, нарийн бичгийн даргаар ажилласан юм. 1956 оноос эхлээд би Өмнөговь аймгийн МАХН-ын хорооны нэгдүгээр нарийн бичгийн даргаар ажилласан юм.

Тэр үед аймгийн МАХН-ын хороо бол голдуу л аж ахуйн ажил хийж байлаа шүү дээ. Намын байгууллага аж ахуйн бүх ажилд хутгалдан ордог байлаа. Үүнийгээ удирдах гол ажил гэж үздэг байлаа. Тэнд миний хийх гол ажил бол бүх нийтийг нэгдэлжүүлэх ажил байсан юм. Хувийн малтайгаа байсан малчдын малыг нь нийгэмчлээд, нэгдлүүдийг байгуулаад, шинэ нэгдэлдээ гишүүн элсүүлээд, нэгдлийн гишүүдээр нэгдлийн малыг нь маллуулах л ажил байлаа. Малчдын малыг нь хурааж авахын тулд эхлээд малчид хэдэн малтай байх ёстойг нь тогтоосон юм. Ингээд түүнээс илүү гарсан малыг нь хураагаад авсан юм. Малаа хураалгасан хүмүүс нэгдлийн гишүүн болж, нэгдлийн малыг хариулдаг болж байгаа юм. Энэ ажил тааламжтай ажил байгаагүй юм. Нэг төрлийн хэлмэгдүүлэлт, завхрал болж байлаа шүү дээ.

Нэгдэлд элсэхийн өмнө манай малчид их малтай байсан юм. Малчид дан ганц малаараа амьдарч байсан юм. Тэдний амьдралын эх булаг нь мал байсан юм. “Нэгдэлжих хөдөлгөөн” өрнөснөөр бүх хүнийг нэгдэлд элсүүлсэн юм. Нэгийг ч үлдээгээгүй юм. Нэгдэлд орохоос татгалзсан хүмүүс их гарч байлаа. Тэдэнд олон янзын даралт, хавчилт, шахалт үзүүлээд, хүчээр оруулсан юм. Энэ ажлаас болоод Монголын хөдөө аж ахуйд том хямрал үүссэн юм. Хүчээр хурааж авсан малыг хариулж маллах хүн олдохоо байсан юм. Нэгдэлд элссэн хүмүүст албан хүчээр тулгаж өгөөд, тэр малыг маллуулдаг байлаа шүү дээ.

Малчид нэгдлийн малыг “ялтай мал” гэж нэрлэдэг болсон юм. Яагаад гэвэл тэр малаас чинь нэгийг ч хэрэглэх эрх малчин хүнд байгаагүй юм. Тэр малын мах, сүү, арьс шир гээд малын ашиг шимийг хэрэглэх эрх малчин хүнд байгаагүй юм. Тэр малын бүх ноос, хялгасыг нь нэгдэлд тушаах ёстой байлаа шүү дээ. Нэгдлийн малаас дураараа хэрэглээд, мах, сүүний төлөвлөгөө, норм зэргийг нь биелүүлэхгүй бол малчин хүн өөрөө шоронд ордог болсон юм.

Малчин хүн мал хариулаад өөрт нь ямар ч өгөөжгүй болсон юм. Уг нь монгол малчин хүн өөрийнхээ амьдаралд хэрэглэхийн тулд малыг өсгөж үржүүлдэг шүү дээ. Нэгдлийн хонь хариулсан хүнд цалин өгөх ёстой юм. Гэтэл мал хариулсан хүний цалинг хэзээ ч хугацаанд нь өгч байсангүй. Тэгээд маш бага цалин өгнө шүү дээ. Нэгдлийн 500 хонь хариулсан хүн сардаа найман төгрөг авч байсан юм. Ийм байсан учир малчид ихэнх нь маш хурдан хугацааны дотор ядуурсан юм. Ингээд малчдын ихэнх нь хөдөөнөөс дайжаад Улаанбаатар зэрэг төв, суурин газрууд руу явчихдаг

болсон юм шүү дээ.

Энэ байдал одоо хүртэл үргэлжлээд байна шүү дээ. Одоо хүмүүс хот руу их нүүх болсон байна л даа. Энэ чинь тэр үед эхэлсэн юм. Тэр үеийн нөлөө одоо болтол зогсоогүй байна л даа. Хүмүүс цаг үе өөрчлөгдөхөөр “урьдынх шигээ амьдрал хэцүү болж ядуурал эхлэх гэж байна!” гэж бодоод хот газар бараадаад байгаа юм. Одоо ирж байгаа цаг үе маань ямар цаг үе билээ? гэдгийг мэдэхгүй байгаа учир ийм байдал үүсэж байгаа юм. Нэгдэл байгуулахаас өмнөх шиг цаг үе рүүгээ явж байна гэдгийг одоохондоо мэдэхгүй байна. Нэгдэл байгуулагдсанаар хүмүүсийн зан ааш эрс өөрчлөгдсөн юм шүү дээ. Үнэнч шударга ёс алдагдаж эхэлсэн юм. Хүмүүс үнэнчээр хөдөлмөрлөж, хөдөлмөрийнхээ үр шимийг үзэхгүй болсон юм. Бүх юманд хуурамчаар хандах хандлага газар авч эхэлсэн юм. Нэгдлийн малаас авч аминдаа хэрэглээд, “энэ мал үхсэн!” гэж хэлдэг болсон юм. Сүү саалийг нь хувьдаа ашигласан бол бас өөр нэг шалтгаан хэлээд сууж байх жишээтэй. Малчид маань маш хэцүүхэн байлаа шүү дээ. Малынхаа бүх ноос ноолуурыг нь нэгдэлдээ өгөх ёстой байлаа. Тэр бүгдийн норм төлөвлөгөөг нь гүйцээж чадахгүй бол төлбөрт л орно шүү дээ. Мал үхүүлж дутаасан бол бас төлөх ёстой байлаа.

Малчин хүн нэгдлийн малыг үхүүлсэн бол оронд нь яг тийм ижил мал өгөх ёстой байсан юм. Гэтэл малчин хүн өөрөө амины малгүй болчихсон юм. Дандаа нэгдлийн үхсэн малын оронд нь өөрийнхөө малыг өгөөд дуусдаг байсан юм. Нэгдлийн гишүүдийн амины малын тоог говийн бүсэд 75 толгой мал, хангайн бүсэд 50 толгой гэж тогтоосон юм. Нэгдлийн гишүүдийн малын тоог “Нэгдлийн гишүүдийн үлгэрчилсэн дүрэм” гэдгээр зохицуулж байсан юм. Энэ бол хууль биш дүрэм юм. Гэтэл түүнийг яг хууль шиг хатуу мөрдүүлдэг байлаа шүү дээ.

1990 он болж ирэхэд Монголын малчин ардууд бүгд гуйлгачин болчихсон байсан юм шүү дээ. Нэг л мэдэхэд бүгд л гуйлгачин болчихсон юм. Малчин болгон нэгдэлд өртэй, нэгдэл болгон улсад өртэй, улс нь гадаадад өртэй байлаа. 1990 он хүртэл ийм байсан юм. Тэр үеийн байдал нэг иймэрхүү л дүр төрхтэй байлаа шүү дээ. Ард түмэн маш хүнд нөхцөлд л ажиллаж амьдарч байлаа. Үнэн хэрэг дээрээ бүх зүйл ЗХУ-аас хамааралтай байлаа шүү дээ. Яг л хараат орон шиг. Манайхыг “ЗХУ-ын хараат орон” гэж албан ёсоор зарлаагүй л дээ. Гэхдээ яг л тийм байсан юм. Бүх зүйлийг орос загвараар хийдэг байсан юм. Бүх юмыг яг Оросыг дуурайгаад л хийдэг байлаа.

Ю.Цэдэнбал бол орос эхнэртэй хүн. Тэр байдал нь түүний улс төрийн бодлогод хүчтэй нөлөөлдөг байсан байж болох юм. Тэр хүн зөвхөн Зөвлөлт-Монголын найрамдлын тухай л ярих дуртай байлаа шүү дээ. Энэ найрамдлыг хамгаалдаг, үүний төлөө бүхнийгээ зориулдаг байлаа.

Сүүлдээ зөвхөн өөрийнхөө л албан тушаалыг манаад суудаг болсон юм. “Намайг огцруулчих вий дээ!” гээд л эргэн тойрныхоо хүмүүсийг хардаад л сууж байдаг болсон юм. Ийм байдалд орчихсон юм. Ю.Цэдэнбалын өөрийнх нь байдал ч их хүндэрсэн шүү дээ.

50-аад оны сүүлч 60-аад оны эхээр бид нар хамт ажиллаж байлаа. Ю.Цэдэнбалын эрч хүч мэдэгдэхүйцээр огцом муудсан юм. Бүр энгийн зүйлийг мэдэхгүй, ажил төрлийн учрыг бүр олохоо байсан юм. Бид нар “Ю.Цэдэнбал яагаад ийм амархан эрч, хүч нь харьж, ажлын чадваргүй болчихсон юм болов оо?” гээд л бодоцгоодог боллоо шүү дээ.

Би Өмнөговь аймгийн МАХН-ын хорооны нэгдүгээр нарийн бичгийн даргаар ажиллаж байлаа. Хэдэн сар хөдөө байж байгаад Улаанбаатарт ирдэг байлаа. Биднийг байхгүй хооронд тэр эрс дордсон байдаг байж билээ. Хэдхэн хоногийн өмнө ярьсан, тохирсон зүйлүүдийг огт хайхралгүй, тэр чигт нь орхичихсон, хаячихсан байдаг байж билээ. Ажил бол ердөөсөө явахаа байсан юм.

Энэ байдал үргэлжилсээр байгаад 1984 онд түүнийг ажлаас нь халсан юм шүү дээ. Өөр ямар ч арга байгаагүй юм. МАХН-ын ТХ-ны УТТ энэ хүнийг яах вэ? гэдэг асуудал дээр нилээд удаан бодсон юм. Тэр үед МАХН-ын ТХ-ны УТТ-нд ажиллаж байсан бүх хүн, бүгдээрээ Ю.Цэдэнбалын өөрийнх нь дэмжлэгээр төрийн том албан тушаалд томилогдсон хүмүүс юм шүү дээ. Тийм болохоор тэд нар Ю.Цэдэнбалын талаар хурдан, түргэн, алдаатай шийдвэр гаргахаас маш их болгоомжилж байсан юм. Тэд нар Ю.Цэдэнбалд их хүлээцтэй хандаж, их тэвчээр гаргасан юм шүү. Даан ч тэр хүн үнэхээр засараагүй юм. Ингээд МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүд энэ намыг 40 гаруй жил удирдсан удирдагчаа огцруулах шийдвэр гарсан юм.

8 Х. Чойбалсан, Ю.Цэдэнбал хоёр.

Б Н: ЗХУ-д дээд сургууль төгсөөд ирэхэд нь Ю.Цэдэнбалыг Санхүүгийн техникумын хичээлийн эрхлэгч, Сангийн яамны орлогч сайд, Монгол банкны захирал зэрэг өндөр албан тушаалд томилож байлаа шүү дээ. Тэр үед МАХН-ын ТХ-нд С.Лувсаншарав, Т.Элдэв-Очир, Л.Баасанжав зэрэг нарийн бичгийн дарга нар ажиллаж байсан юм. Элдэв-Очир бол МАХН-ын ТХ-ны дарга нь байсан юм. Тэр 1938 онд өвчний улмаас нас барсан юм. Түүний дараа С.Лувсаншарав МАХН-ын ТХ-ны ажлыг ерөнхийд нь удирдаж байлаа. Түүнийг дараагийн хүн нь Баасанжав байсан юм.

1939 оны 7-р сард хуралдсан МАХН-ын ТХ-ны бүгд хурлаар Өмнөговь аймгийн МАХН-ын хорооны нэгдүгээр нарийн бичгийн

даргаар ажиллаж байсан Дашийн Дамба МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн даргаар сонгогдсон юм. Д. Дамба гуай 1939 оны 7-р сарын 8-наас эхлээд шинэ ажилдаа орж байсан юм билээ. Д. Дамба гуай МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн даргын ажилдаа орсны дараа 7-р сарын 10-ны өдөр МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга Д. Лувсаншарав, Улсын бага хурлын дарга Д. Догсом, орлогч дарга Д. Лосол нарыг Дотоод яам баривчилсан юм. Улсын бага хурлын дарга Д. Догсом, орлогч дарга Д. Лосол нар чинь Д.Сүхбаатартай хамт 1921 оны Ардын хувьсгалыг ялалтанд хүргэсэн манай нэртэй хувьсгалчид, эх орончид юм шүү дээ. 1940 оны 2-р сард МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга Б. Баасанжав бас баривчлагдсан юм.

Б. Баасанжавыг баривчлагдах үед Д. Дамба гуайг бас баривчлах оролдлого хийсэн байдаг юм билээ. Дотоод яаман дээр Д. Дамба гуайг дуудсан байна л даа. Түүнд “Таныг Дотоод яаман дээр Х.Чойбалсан дуудаж байна!” гэсэн зар бичиг ирсэн байна. Д. Дамба гуай тэр зар бичгийг аваад “За, ингээд баривчлагдлаа!” гэж бодсон байгаа юм. Тэгээд л Дотоод яаман дээр хүрч очоод Х.Чойбалсангийн өрөөнд оржээ. Тэнд Дотоод яамны орлогч сайд С.Жамбалдорж, дайчлан баривчлах хэлтсийн дарга Д.Самбууням хоёр байж. С.Жамбалдорж бол улс төрийн хэлмэгдүүлэлтээр алдаршсан хүн. Маш олон хүнийг баривчилж, улс төрийн хилс хэрэгт холбогдуулж, хэлмэгдүүлсэн хүн. Том албан тушаалын хүмүүсийг яг ийм маягаар Х.Чойбалсангийн өрөөнд дуудаж ирүүлээд, энэ хоёр баривчилдаг байж. Д. Дамба гуай “Баривчлагдах нь гарцаагүй боллоо!” гэж бодоод л сууж байсан байна. Түүнийг гаднаас орж ирэхэд Х.Чойбалсан огт мэндлээгүй гэнэ. Бас өөдөөс нь ч эгцлээж харахгүй байна гэнэ. Тэгээд Х.Чойбалсан “Цаад нөхрөө оруулаад ир!” гэж тушааж байна гэнэ. Тэгээд Д.Самбууням гараад явсан байна. Удалгүй толгой дээгүүрээ дээлээ нөмөрсөн нэг хоригдлыг тугаад тэр орж ирсэн байна. Тэгээд “Чи наад дээлээ буулга!” гэж нөгөө хүнд тушааж байна гэнэ. Гэтэл сахал нь их ургасан, эцэж турсан маш их зовсон хүний нүүр харагдсан байна л даа. Д. Дамба гуай эхлээд тэр хүн хэн болохыг таньсангүй гэнэ. Тэгээд хэсэг хором өнгөрхөд “МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга Б. Баасанжав мөн!” гэж таньжээ. Тэгтэл Х.Чойбалсан суудлаасаа босож ирээд, Баасанжавт хандаад “За чи энэ Дамбын талаар ямар мэдүүлэг өгдөг билээ? Түүнийгээ одоо дахиад нэг хэл!” гэж гэнэ. Гэтэл Баасанжав “Би ямарч буруу хэрэг хийгээгүй. Танай яамны энэ ажилтнууд намайг зодож, зовоогоод би гэсвэрлэж чадахаа байсан юм. Тэгээд Дамба бол миний хамсаатан мөн гэж би хэлсэн юм. Дамба бол ямарч буруу юм хийгээгүй хүн шүү. Би ч буруу юм хийгээгүй. Миний өгсөн мэдүүлэг бол бүгд худал, зохиомол зүйл шүү. Танай ажилтнууд намайг гүтгээд байх юм. Би

үнэнчээр ажлаа хийж явсан. Надад хийсэн хэрэг байхгүй. Миний бие одоо их муудаж байна. Эд нар намайг алах гэж байна. Намайг өршөөж, эндээс суллаж өгөөч!” гээд л ярьж байна гэнэ.

Тэгтэл Х.Чойбалсан “Чиний энэ ярьж байгаа чинь үнэн биз?” гэж асууж байна гэнэ. “Үнэн. Үнэн. Дамба бол ямар ч буруу юм хийгээгүй хүн шүү!” гэж Баасанжав хэлж байна гэнэ. Тэгээд Х.Чойбалсан “Энэ нөхрийг аваад гар!” гэж байна гэнэ. Тэгээд л Баасанжавыг аваад гарсан байна. Түүнийг гарсны дараа Х.Чойбалсан “Энэ Баасанжав өгсөн мэдүүлэгтээ чамайг өөрийн хань хамсаатан мөн!” гэж мэдүүлсэн юм. Гэтэл тэр нь худал мэдүүлэг юм байна. Бид ойлголоо. Чи одоо явж болно!” гэжээ. Ингээд Д. Дамба гуай баривчлагдаагүй үлдсэн юм гэнэ билээ.

Д. Дамба гуай бол их ухаантай, ард түмний амьдралыг сайн мэддэг, ой сайтай хүн байлаа л даа. Цэргийн газар их удаан жил ажиллсан хүн л дээ. Харин Оросод сургууль төгсөөгүй хүн юм. Ер нь тэр Монголд ч ямар нэгэн сургуульд сурч байгаагүй юм билээ. Бүгдийг өөрийн авъяасаар өөрөө сурсан юм билээ.

1940 онд МАХН-ын 10-р их хурал хуралдахад МАХН-ын ТХ-нд Дамба гуайгаас өөр нарийн бичгийн дарга байгаагүй юм. Энэ их хурлын бэлтгэл ажлыг Х.Чойбалсан, Д.Дамба гуай хоёр хийсэн юм. Ю.Цэдэнбал энэ их хурал дээр “Монголын мал аж ахуй, түүний хөгжлийн хэтийн төлөвийн талаар” илтгэл хэлэлцүүлсэн юм. Ийм сэдвээр илтгэл тавих даалгаврыг түүнд Х.Чойбалсан өгсөн юм. Энэ их хурлаар Ю.Цэдэнбалыг МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн даргаар нь сонгосон юм.

Тэр үед Ю.Цэдэнбал 24 настай залуу байж. МАХН-ын ТХ-ны хоёрдугаар нарийн бичгийн даргаар С.Сүрэнжав гуайг сонгосон юм. С.Сүрэнжав, Ю.Цэдэнбал нар чинь ингэж МАХН-ын ТХ-нд зэрэг орж ирсэн юм. Үүнээс жаахан хожуухан Нянтайсүрэнгийн Лхамсүрэнг МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн даргаар сонгосон юм. МАХН-ын 10-р их хурал Дамба гуайг Улаанбаатар хотын МАХН-ын хорооны нарийн бичгийн даргаар сонгосон юм. Үүний дараа 1943 онд түүнийг дахиад МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн даргаар сонгосон юм шүү дээ. Түүнээс хойш МАХН-ын ТХ-ноос гараагүй юм.

1953 онд маршал Х.Чойбалсанг нас барахад Дамба гуай МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга, Ч.Сүрэнжав гуай Сайд нарын Зөвлөл (СнЗ)-ийн орлогч дарга болсон байлаа. Х.Чойбалсангийн орлогч байсан юм. 1954 онд Дамба гуайг МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар сонгосон юм.

Х.Чойбалсанг нас барсны дараа түүний оронд СнЗ-ийн даргыг томилолгүй удсан юм. Тэр үед манай нийгмийн доторхи уур амьсгал бол Х.Чойбалсангийн оронд “Ч.Сүрэнжав СнЗ-ийн дарга болно!” гэсэн

хандлагатай байсан юм. Ч.Сүрэнжав бол олон жил Х.Чойбалсангийн орлогчоор ажилласан, нилээд туршлагатай болсон хүн байлаа шүү дээ. Ард түмний дунд түүний нэр хүнд ч муугүй байсан юм. Олон нийтийн санаа бодол иймэрхүү хандлагатай байсан юм. Ингээд удахгүй СнЗ-ийн дарга болох хүний нэр тодрох ёстой байлаа. Гэтэл энэ асуудал ихээхэн будлиан, хуйвалдааны замаар шийдэгдсэн юм. Энэ үед болсон үйл явдлуудыг би өөрийн нүдээр харж, өөрийн чихээр сонсож, зарим үйл явдалд нь оролцсон юм. Би тэр үед МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга Д.Сосорбурамын туслахаар ажиллаж байсан юм шүү дээ. МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүд хэдэн өдөр дараалан хуралдлаа. Би хурал болж байгааг мэдэж байсан боловч ямар асуудал хэлэлцэж байгааг нь мэдээгүй юм. Би жаахан гайхаж байлаа. Заримдаа шөнө орой болсон хойно ч хурал таралгүй үргэлжилж байлаа.

Ингэж хэд хоносны дараа Нянтайсүрэнгийн Лхамсүрэн гуай, манай Д.Сосорбурам даргатай хамт түүний өрөөнд суугаад нэг юм хийгээд байдаг боллоо. Тэр хоёр юу хийж байгааг би мэдсэнгүй. Гаднаас нь харахад их л чухал ажил хийж байгаа юм шиг байлаа. Д.Сосорбурам гуай “Өнөөдөр гадны хүн хүлээж авахгүй. Би ажилтай байна!” гэсэн даалгавар өгдөг болов. Тэр хоёр үе үе намайг МАХН-ын ТХ-ны архив руу явуулдаг боллоо. МАХН-ын ТХ-ны архиваас голдуу л МАХН-ын ТХ-ны бүгд хурлын материал захиалаад авдаг байв. Бас МАХН-ын ТХ-ны номын сангаас хуучин сонин авдаг байв. Тэр хоёрын авч байсан сонингуудад голдуу л социалист орнуудын төрийн эрх барьж байсан ажилчны намуудын дотор гарч байсан зөрчлүүдийн тухай материал нийтлэгдсэн байдаг байв. Мөн улс төрийн алдаа гаргаад, ажлаасаа халагдсан эдгээр намын зарим удирдагч нарын тухай материал нийтлэгдсэн байдаг байв. Ийм үл ойлгогдох үйл явдлууд болж байлаа. Тэр үед над шиг МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн даргын туслахын ажил хийж байсан зарим нэг хүн: “МАХН-ын УТТ-ны гишүүд Ерөнхий сайдын асуудлыг хэлэлцэж байх шиг байна!” гэж ярьж байсан юм.

Ийм байдал хэд хоног үргэлжилсний эцэст Н.Лхамсүрэн гуай, Д.Сосорбурам гуай хоёр нэг өдөр: “МАХН-ын ТХ-ны орос хэлний бичээчийг дуудаж ирүүл! Машиныг нь бас миний өрөөнд авч ир!” гэж надад тушаасан юм. Би ч Д.Сосорбурам даргын даалгаврыг тэр дорно биелүүллээ. Н.Лхамсүрэн гуай, Д.Сосорбурам гуай хоёр орос хэлний бичээчтэй өрөөндөө суугаад нэг юм бичиж эхэлсэн юм. Тэд нар нилээд удсан байх. Тэгээд Д.Сосорбурам дарга өрөөнөөсөө гарч ирээд “Орос хэлний бичээчийг хүргэж өг!” гэж надад далгавар өглөө. Би түүнийг өрөөнд нь бичгийн машинтай нь хамт хүргэж өглөө. Намайг эргэж ирэх үед Д.Сосорбурам дарга, Н.Лхамсүрэн гуай хоёр Ю.Цэдэнбалын өрөө

рүү явлаа. Явахынхаа өмнө надад баахан ноорог цаас өгөөд “За, чи энэ цааснуудыг нэг нэгээр нь шатаа!” гэсэн үүрэг өглөө. Би тэр цааснуудыг нь төмөр саванд нэг нэгээр нь хийгээд л шатааж эхэллээ. Түүнийг шатах хооронд унших боломжтойг нь уншиж үзлээ. Бүгдийг нь орос хэл дээр бичсэн байна л даа. Дандаа л Ч.Сүрэнжав гуайн тухай л бичсэн материал байсан юм. Ингээд МАХН-ын ТХ-ны УТТ-ны хурлаар Ч.Сүрэнжавын тухай асуудал хэлэлцэж байгааг нь би мэдсэн юм. “Ч.Сүрэнжав гуайг л огцруулах бэлтгэл хийж байна!” гэсэн таамаглал надад төрсөн юм.

Тэр өдрийн дараагийн өдөр нь ажил тарахын өмнөхөн Дамба дарга өөрийн туслах М.Пэлжээд “Маргааш 10 цагт МАХН-ын УТТ-ны гишүүдийн хуралтай. Чи тэдэнд энэ зарыг одоо хүргэ! Хурал Ю.Цэдэнбалын өрөөнд болно. Харин Ч.Сүрэнжавт энэ талаар хэлээд хэрэггүй. Түүнд би өөрөө хэлнэ!” гэсэн даалгавар өгчээ. М.Пэлжээ бид хоёр их найз байсан юм. Маргааш өглөө нь яг 10 цагт МАХН-ын УТТ-ны гишүүдийн хурал Ю.Цэдэнбалын өрөөнд эхэллээ. Хурал эхэлсэн боловч МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүн Ч.Сүрэнжавыг хуралд оруулсангүй. Ч.Сүрэнжав гуай хурал болж байгаа өрөөний үүдний хүлээлгийн өрөөнд сууж байна. Түүнтэй хамт Дотоод яамны сайд Дамдингийн Батаа гэдэг хүн сууж байна. Д.Батааг ч мөн хуралд оруулсангүй. Тэр Ч.Сүрэнжав гуайн хажууд дуугүй суугаад л байх юм.

Хурал ажлаа эхлээд нэг их удалгүй Д.Батааг дуудаж орууллаа. Д.Батаа удалгүй л царай нь барайсан гарч ирээд, дуу шууч үгүй л яваад өглөө. Түүнийг Дотоод яамны сайдынх нь ажлаас халсан юм байж. Тэгээд л удалгүй Ч.Сүрэнжав гуайг хурал болж байгаа өрөөнд орохыг урилаа. Ч.Сүрэнжав гуай ороод их удсан ч үгүй л гараад ирлээ. Бид нар “Ч.Сүрэнжав гуай огцорчихлоо!” гээд л бодож байлаа. Гэтэл түүнийг огцруулсангүй, харин СнЗ-ийн даргын албан тушаалаас өөрөөр нь татгалзуулсан юм байж.

Ч.Сүрэнжав гуайд өөрт нь Ерөнхий сайд болох бодол бас байсан юм шиг байгаа юм. Бас МАХН-ын УТТ-ны зарим гишүүд дэмжсэн юм байна. Гэтэл үүнийг нь Ю.Цэдэнбал “албан тушаал булаацалдлаа!” гэж буруутгасан юм байна. МАХН-ын бусад нарийн бичгийн дарга нар Ю.Цэдэнбалынхаа талд ороод л Ч.Сүрэнжавыг шүүмжилсэн юм байна л даа. Ю.Цэдэнбал “Ч.Сүрэнжав бол СнЗ-ийн дарга болоход тохирохгүй, маш их хувийн дутагдалтай хүн!” гэж шүүмжилсэн юм байна. Ч.Сүрэнжав гуай энэ байдалд дүгнэлт хийгээд Ю.Цэдэнбалын ярьсан “хувийн дутагдал” гэдгийг нь хүлээн зөвшөөрөөд, хурдан бууж өгчээ. Ингэж Ч.Сүрэнжав гуай СнЗ-ийн дарга болох бодлоосоо татгалзсан юм.

Тэр үед МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга нарын хувийн хэрэг бүгд Д.Сосорбурам гуай дээр байдаг байсан юм. Хурлын дараа

Д.Сосорбурам дарга нэг хэсэг бичиг надад өгөөд “Үүнийг Ч.Сүрэнжавын хавтаст хэрэгт хийгээрэй!” гэж хэллээ. Би тэр бичгийг унших гэж оролдсон боловч Д.Сосорбурам дарга байсан болохоор уншиж чадсангүй. Тэгээд л өнгөрлөө.

Ю.Цэдэнбал ер нь анх ингэж Сайд нарын зөвлөлийн дарга болох замаа зассан юм шүү дээ. Тэр СнЗ-ийн даргын албан тушаал иймэрхүү хуйвалдааны журмаар түүний талд шийдэгдсэн юм. “Ю.Цэдэнбал Монголын төрийн эрхийг дөчин дөрвөн жил барьсан!” гэж бичдэг шүү дээ. Үнэн хэрэг дээрээ бол тийм биш юм. 1940 онд тэр МАХН-ын ерөнхий нарийн бичгийн дарга болсон боловч Х.Чойбалсан СнЗ-ийн даргынхаа ажлыг хийж байлаа. Ю.Цэдэнбал төр, засгийн ажилд оролцдоггүй, зөвхөн намынхаа л ажлыг хийдэг байсан юм. 1954 онд Ю.Цэдэнбал СнЗ-ийн даргаар томилогдсон юм. Ийм учраас МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар Дамба гуайг сонгосон юм. Дамба гуай энэ ажлыг 1958 он хүртэл хийсэн юм. Дамба гуай МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга болоод намын ажлыг Ю.Цэдэнбалд хүргэхгүй ганцаараа хийдэг байсан юм. Дамба гуай бол их айхтар сүрхий хүн байсан юм шүү дээ. Тэр МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга байхдаа ажлыг ёстой сайн хийж байсан юм. Бүх ажлыг зангидаж, чиглүүлж чадаж байсан юм.

9 “Нэг хүнийг тахин шүтэх явдал”.

Б Н: 1956 онд ЗХУКН-ын 20-р их хурал хуралдлаа. ЗХУКН-ын 20-р их хуралд Ю.Цэдэнбал, Д. Дамба, Д.Төмөр-Очир гурав МАХН-ыг төлөөлж оролцсон юм. Энэ хурал анх удаа “нэг хүнийг тахин шүтэх явдал”-ын хор уршгийн тухай асуудлыг авч хэлэлцсэн юм. Өөрөөр хэлбэл, И.В.Сталиныг тахин шүтэж, хууль ёсыг завхруулж, олон мянган гэмгүй хүмүүсийг улс төрийн хилс хэргээр цаазалсан явдлыг буруушаасан юм. ЗХУКН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Н.С.Хрущевын тавьсан энэ асуудлыг Д. Дамба гуай ихээхэн дэмжиж байсан юм. “Монгол оронд нэг хүнийг тахин шүтэх явдлыг газар авхуулж, улс төрийн хилс хэргээр олон хүнийг хэлмэгдүүлсэн хүмүүсийг илчилж, гэдэнтэй улс төрийн хариуцлага тооцох хэрэгтэй!” гэж Д. Дамба гуай үзэж байсан юм. Д. Дамба гуай МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн даргын хувьд улс төрийн ийм байр суурийг хатуу баримтлаж эхэлсэн юм.

Энэ асуудлаар Ю.Цэдэнбал тэс өөр байр суурьтай байсан юм. Ю.Цэдэнбал бол “Монголд улс төрийн хэлмэгдүүлэлт байсан боловч түүний цар хүрээ нь ЗХУ-ынхаас эрс бага байсан!” гэх мэтээр нэг хүнийг тахин шүтэх явдлын хор уршгийг аль болохоор багасгахыг оролдож байсан юм. “Ю.Цэдэнбал өөрөө Х.Чойбалсантай он удаан жил хамт

ажиллаж байсны хувьд Монголд өрнөсөн нэг хүнийг тахин шүтэх явдлын хариуцлагыг нь хуваалцах ёстой! Олон хүнийг улс төрийн хилс хэрэгт холбогдуулж цаазалсан хариуцлагаас Ю.Цэдэнбал өөрөө мултарч гарах ёсгүй!” гэж олон хүн үзэж байсан юм. Дамба нэг хүнийг тахин шүтэхийн хор уршгийн асуудлыг МАХН-ын ТХ-ны бүгд хурлаар нухацтай авч хэлэлцэх саналтай байсан юм билээ. Гэтэл энэ асуудлыг хэлэлцэхэд Ю.Цэдэнбал саад болоод ямар нэгэн арга саам олоод хойшлуулаад байсан юм билээ. Ю.Цэдэнбал Х.Чойбалсанг өмөөрөөд, хамгаалаад байсан юм. Ю.Цэдэнбалын хувьд Х.Чойбалсанг хамгаална гэдэг бол үнэн хэрэгтээ өөрийгээ хамгаалахтай утга ижил байсан юм.

Тэр үед МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүд дотор энэ асуудлаар Дамба гуайн байр суурийг дэмждэг олон хүн байсан юм. Д.Төмөр-Очир бас “нэг хүнийг тахин шүтэхийн хор уршгийг уудлан илрүүлж, түүнийг дэвэргэж байсан хүмүүстэй улс төрийн хариуцлага тооцох хэрэгтэй!” гэж үздэг байсан юм. Гэсэн хийдий ч Ю.Цэдэнбал аажмаар өөрийн байр суурийг бэхжүүлж чадсан юм. Тэр энэ хүнд байдлаасаа гарах гарцыг уйгагүй хайсны эцэст ерөөсөө Дамбыг МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн даргын албан тушаалаас нь огцруулахаар шийдсэн байх. Тэр МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн даргын хувьд намын ажлыг гарамгай сайхан зохион байгуулж байсан юм. Би тэр үед Өмнөговь аймгийн МАХН-ын хорооны нэгдүгээр нарийн бичгийн даргын албыг хашиж, Дамба даргын удирдлагын дор ажиллаж байсны хувьд үүнийг сайн мэдэж байсан юм.

Ю.Цэдэнбал хүнийг ажлаас халахдаа ямагт нэг шалтгаан олоод л түүнийгээ дэвэргэж, их том асуудал болгодог шүү дээ. Дамба гуай бол оросоор ярьдаггүй, ер нь системтэй боловсрол эзэмшээгүй зэрэг дутагдалтай хүн байсан юм. Түүний энэ сул тал дээр нь Ю.Цэдэнбал тоглож эхэлсэн юм. Ю.Цэдэнбал энэ асуудлыг “Дамба бол үзэл суртал, онолын талаар сул зэвсэглэгдсэн учраас зохих байр сууриа эзэлж чадахгүй, дан ганц явцуу практик ажлаар хөөцөлдөөд, жинхэнэ коммунист зарчимтай байгаагүй!” гэж томъёолсон юм.

1958 оны 11-р сард хуралдсан МАХН-ын ТХ-ны 2-р бүгд хурлаар Дамбын асуудлыг гэнэт хэлэлцсэн юм. Бүгд хурал хэлэлцэх ёстой асуудлаа хэлэлцэж дуусаад тарах гэж байлаа. Гэтэл Ю.Цэдэнбал гэнэт Дамбыг МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн даргын ажлаас чөлөөлөх асуудлыг оруулж ирсэн юм. Нэгэнт энэ асуудал 2-р бүгд хурлын хэлэлцэх асуудал биш байсан тул бүгд хурлын гишүүд түүнийг хэлэлцэхээс татгалзсан юм. Олон хүн “Дамбыг энэ ажлаас нь чөлөөлөх шаардлагагүй!” гэж үзэж байсан юм. Энэ хурлын протоколыг үзвэл маш тодорхой байгаа. Дамбын оронд МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар хэнийг сонгох вэ? гэдэг нь бас их чухал асуудал байсан юм. Гэтэл түүний оронд

Ю.Цэдэнбал МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар сонгогдох бодолтой байсан юм байж. Бүгд хурлын гишүүд “Ю.Цэдэнбал өөрөө үзэл суртал, онолоор бүрэн зэвсэглэгдсэн хүн юм уу? Энэ хоёр том албан тушаалыг тэр ганцаараа хавсран хашиж чадах юм уу? Хийх ажил бол их байгаа, бид их том зорилт дэвшүүлсэн шүү дээ!” гэх мэтээр ярьж байсан юм.

Би тэр бүгд хурал дээр “Дамбыг ажлаас нь өөрчлөх үндэслэл нь тодорхой биш байна. Манай ажил муу байгаа нь түүнийг ажлаас нь өөрчлөх үндэслэл биш. Ажил муу байгаагийн хариуцлагыг Ю.Цэдэнбал ч хамтдаа хүлээх ёстой. Дамбыг өөрчилснөөр ажил сайжрахгүй. Энэ асуудлыг яагаад урьдчилаад бүгд хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулаагүй юм бэ? Энд нэг л булхай байна даа? “гэж хэлсэн юм. Дамба гуай ч өөрөө босоод үг хэллээ.

“Ю.Цэдэнбал улс орны цаг үеийн байдлыг дүгнэж үг хэллээ. Энэ шаардлагын дагуу би МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн даргынхаа албан тушаалаас өөрчилж өгөхийг хүсэн юм. МАХН-ын УТТ санал нэгтэй шийдвэрлэсэн юм!” гэсэн утгатай үг хэлсэн юм.

МАХН-ын ТХ-ны УТТ-ны хурал дээр Д.Дамба гуай “МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн даргы ажлыг би өөр хүнд шилжүүлээд өгч болно. Ийм асуудал тавигдаж байгаа нь улс орны нийт ажил муу байгаатай холбож болохгүй. Надад дутагдал байгааг би хүлээн зөвшөөрнө. Харин улс орны нийт ажил муу байгаагийн гол хариуцлагыг би хүлээхгүй. Ажил муу байгаагийн хариуцлагыг Ю.Цэдэнбал өөрөө бас хүлээх ёстой!” гэсэн утгатай үг хэлсэн юм билээ. Ингээд 1958 оны 11-р сард хуралдсан МАХН-ын 2-р бүгд хурал Ю.Цэдэнбалыг МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар дахин сонгосон юм. Ю.Цэдэнбалын шахалтаар Д.Дамба гуайг ажлаас нь өөрчлөөд, МАХН-ын ТХ-ны 2-р нарийн бичгийн дарга болгосон юм.

Үүний дараа 1959 оны 3-р сард хуралдсан МАХН-ын ТХ-ны бүгд хурлаар Ю.Цэдэнбал Дамба гуайг ажлаас бүр халсан юм. Ю.Цэдэнбал ийнхүү Дамбыг Монголын улс төрийн тавцангаас шахан зайлуулснаар нэг хүнийг тахин шүтэх явдлыг дэвэргэж, олон гэмгүй хүнийг улс төрийн хилс хэргээр цаазалсан явдлын улс төрийн хариуцлагаас мутарч гарах жаахан ч гэсэн боломжтой болсон юм.

Ю.Цэдэнбал МХЗЭ-ийн ТХ-ны нарийн бичгийн дарга Магсар, бас Балганжав нарын зэрэг хүмүүсийн өөрийхөө ажлын өрөөнд дуудаж ирүүлээд Дотоод ямаар баривчлуулж байсан юм. Ю.Цэдэнбал энэ маягаар олон хүнийг улс төрийн хилс хэрэгт гүтгэж, баривчлуулахад оролцсон байдаг юм. Түүний шууд оролцоотойгоор улс төрийн хилс хэргээр Дотоод яаманд баривчлагдсан хүний тоо 1400 орчим болж

байсан гэдэг юм. Эдний дотроос олон хүн цаазаар авхуулсан юм. Улаанбаатар хотын МАХН-ын хорооны дарга Лувсаннаваан, СнЗ-ийн орлогч дарга Доржпүрэв, Жамсран гэх мэтийн хүмүүс бол Ю.Цэдэнбалыг МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн даргаар сонгосноос хойш баривчлагдсан юм. Д.Дамба гуай бол Ю.Цэдэнбал ийм маягаар улс төрийн хэлмэгдүүлэлтийг дэвэргэж байсныг сайн мэдэж байсан юм. Улс төрийн хилс хэрэгт олон мянган хүнийг холбогдуулж цаазалсан явдлын улс төрийн гол хариуцлагыг Х.Чойбалсан үүрэх ёстой юм. Харин Ю.Цэдэнбал хэрэг явдалд орлцож байсан, түүнийг дэвэргэж байсан нь үнэн. Гэхдээ гол хариуцлагыг нь Х.Чойбалсан үүрэх ёстой юм.

Д.Дамба гуайн баримтлаж байсан байр суурийг МАХН-ын ТХ-нд олон хүн дэмжиж байсан юм. Гол нь Ю.Цэдэнбал улс төрийн хилс хэрэгт олон хүнийг хэлмэгдүүлэхэд оролцож байсандаа биш, ер нь түүний гарт эрх мэдэл төвлөрөхөөс олон хүн болгоомжилж байсан байх. ЗХУ-ын талыг хэт баримталсан түүний гарт төрийн эрх мэдэл төвлөрвөл “улс, орныг аюултай байдалд оруулна!” гэж олон хүн болгоомжлож байсан байх. Тэр үед Ю.Цэдэнбалын гаргасан улс төрийн олон шийдвэрүүд нь “өөрийн орны эрх ашигийг хамгаалахаасаа илүү ЗХУ-ын эрх ашигт илүү үйлчилж байна!” гэдгийг олон хүн олж харж чадсан байх. Д.Дамба гуайн дараа Ч.Сүрэнжав гуайг ч МАХН-ын ТХ-ноос гаргасан юм шүү дээ.

10 “Сэхээтний төөрөгдөл”.

КЮ: “Сэхээтний төөрөгдөл” гэдэг нэрийн дор Монголд ямар үйл явдал болсон юм бэ?

Б Н: Ю.Цэдэнбал Монголын сэхээтнүүдийн эсрэг явуулсан залхаан цээлүүлэх ажиллагаагаа “сэхээтний төөрөгдөл” гэж нэрлэсэн юм. 1950-аад оны эхний үеэс Х.Чойбалсанг нас барсны дараахнаас эхлээд манай нийгмийн амьдарал ихээхэн тогтворгүй болж ирсэн юм. Ард түмэн улс орныхоо хөгжил, дэвшил, цаашдын хувь заяаны талаар их санаа зовж эхэлсэн юм. “1921 оны Ардын хувьсгалаас хойш Монгол орон социализм байгуулахын тулд дан ганц ЗХУ-тай харьцаж ирлээ. Түүнээс хойш 20-30 жил өнгөрлөө. Улсын эдийн засаг өсөж, ард түмний амьдрал дээшилсэнгүй. Ийм учраас бид одоо өөр оронтой харилцагаа өргөжүүлэх хэрэгтэй байна. Манай улс бие даасан гадаад, дотоод бодлогыг тууштай явуулах хэрэгтэй байна. ЗХУ-аас өөр орнуудтай худалдааны болон бусад харилцааг өргөжүүлэх хэрэгтэй байна!” гэсэн яриа Монголын сэхээтнүүд дунд газар авч байсан юм. Би энэ үед Улаанбаатар хотын МАХН-ын хорооны нарийн бичгийн даргын албыг хашиж байсан юм. Ийм

яриа жирийн хүмүүсээс эхлээд л төрийн өндөр алба хашиж байгаа бүх хүмүүсийг хүртэл хамарч байсан юм.

Тэр үед хэвлэл, мэдээллийн хэрэгсэл МАХН-ын хатуу хяналтанд байсан юм. Энэ талаар хэвлэл дээр нэг ч үг гараагүй юм. Гэхдээ л Монголын нийгэм бүхэлдээ ийм шүүмжлэлийн байр сууринд орсон юм. Хүмүүс ийм шүүмжлэлийн сэдэвтэй яриаг бие биендээ ярихаас гадна, энэ сэдэвээр ухуулах хуудас маягтай зүйлийг хийгээд тараадаг байж. Намайг Улаанбаатар хотын МАХН-ын хороонд ажиллаж байх тэр үед МАХН-ын ТХ-ны Хянан Шалгах Хороо болон Дотоод яамнаас байнга л “нууц даалгавар” ирдэг байлаа. Тэр нь “Хэн нэгэн хүн Ю.Цэдэнбалын баримталж байгаа улс төрийн бодлого болон Зөвлөлт-Монголын найрамдлыг шүүмжилсэн нууц бичгийг олноор нь үйлдээд нийгэмд тараасан байна. Тэр нууц бичгийг бичсэн эзнийг нь яаралтай ол!” гэсэн даалгавар байдаг байсан юм. Бид нар тэр “нууц бичиг” бичсэн хүнийг яаж олох вэ? гэсэн асуудалтай тулгардаг байлаа. Тэр нууц бичгийг монгол бичгээр гараараа бичээд тараасан байдаг юм. Тийм учир хамгийн сайн арга бол нууц бичиг бичсэн бичгийн хэвтэй ижил хэвээр бичдэг хүн байгаа эсэхийг тогтоох явдал боллоо. Үүний тулд бид өөрийн бүх ажилтнуудынхаа бичгийнх нь хэвийг шалгаж үздэг боллоо. Ингээд бөөн ажил болдог байлаа. Ийм аргаар бид нэг ч хүнийг олж тогтоож чадаагүй юм.

Сүүлдээ Ю.Цэдэнбал болон түүний баримталж байгаа улс төрийн бодлого, ЗХУ-ыг шүүмжилсэн яриа тасрахаа байгаад улам бүр өргөжөөд, ихээхэн задгайрч эхэлсэн юм. Ийм үед 1956 онд манай Улаанбаатар хотын МАХН-ын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Д.Дамдин гуайг Ю.Цэдэнбал дуудаад “Улаанбаатар хотод ЗХУ-тай байгуулсан найрамдалт харилцааны талаар эрүүл биш яриа их газар авч байна. Энэ яриаг таслан зогсоох талаар Улаанбаатар хотын МАХН-ын хороо арга хэмжээ авч ажил зохиохгүй байна. Одооноос эхлээд энэ талаар дорвитой ажил зохиож, энэ яриаг таслан зогсоох хэрэгтэй!” гэсэн үүрэг өгсөн юм.

Д.Дамдин гуай Ю.Цэдэнбалтай уулзаж ирээд намайг өөрөөндөө дуудлаа. Би Улаанбаатар хотын МАХН-ын хорооны үзэл суртал хариуцсан нарийн бичгийн дарга болохоор гол хариуцах хүн нь болж байгаа юм. Тэгээд бид хоёр энэ чиглэлд хийх ажлаа зөвлөж ярилцлаа. Юуны өмнө Улаанбаатар хотын МАХН-ын хороодын бүх дарга нарыг цуглуулаад “Ю.Цэдэнбал болон ЗХУ-ын талаар гарч байгаа шүүмжлэлтэй яриануудыг зогсоох, эздийг нь илрүүлэх талаар зөвлөмж өгөх хэрэгтэй. Мөн суртал ухуулагчдын зөвлөлөгөөн хийх хэрэгтэй!” гэж тохирлоо. Бид хоёр энэ ярьж тохирсон ажлуудаа маш шуурхай хийж гүйцэтгэсэн юм. Гэсэн ч нийгэмд нэгэнт газар авсан тэр яриа зогссонгүй, зогсох хандлага

ч гарах янзгүй байгаа нь удахгүй тодорхой болсон юм.

Ийм үед МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүд өөрсдөө төрийн томоохон яамдууд, томоохон улсын үйлдвэрийн газрууд, Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Төв Зөвлөл (МҮЭТЗ –ред.), МХЗЭ-ийн Төв хороо, Монгол Улсын Их Сургууль зэрэг газруудад томилолтоор ажилласан юм. Ингэж томилолтоор ажилласан хүмүүсийн тоонд Дамба гуай, Б.Ширэндэв, Л.Цэнд, Д.Төмөр-Очир, Ж.Самдан нар орж байсан юм. Тэд нар очсон газар бүртгээ олон нийтийн хурлыг зохион байгуулсан юм. Тэр хурлууд дээр “Ю.Цэдэнбал болон ЗХУ-ын талаар эрүүл саруул биш, хорт яриа Улаанбаатар хотод их байна. Бид тийм яриа гаргаад байгаа хүмүүсийг зэмлэж, шийтгэх зорилготой ирээгүй! Харин ЗХУ-тай байгуулсан найрамдалт харилцааны талаар гарч байгаа санал, шүүмжлэлийг сонсож, цаашдын ажилдаа тусгаж, алдаа дутагдлыг засаж залруулах зорилготой ирлээ! Та бүхэн өөрсдийн санаа бодлоо бидэнд илэн далангүй ярих хэрэгтэй байна!” гэж ярьсан юм. Хүмүүс ч тэдний хэлсэн үг, ирсэн зорилгод үнэмшсэн юм.

Ер нь тэр үед МАХН-ын ТХ-ны удирдах хүмүүс жирийн хүмүүстэй уулзалт зохиох явдал бараг байдаггүй байсан зүйл юм. Ийм учраас энэ олдож байгаа завшааныг ашиглаад хүмүүс өөрсдийн бодол, санаагаа чөлөөтэй илэрхийлэхийг хүссэн байгаа юм. Хүмүүс “Нам засгийн удирдагчид бидний санаа бодлыг сонсохоор ирлээ!” гэж хүлээж авсан юм. Тэр хурлууд дээр хүмүүс Монгол-Зөвлөлтийн харилцаанд байгаа бүх муу зүйлүүдийг тоочин ярьсан байдаг юм. Тухайлбал:

-Зөвлөлтийн тал Монголын талын санаа бодол, санаачлагыг огт хүлээж авахгүй, зөвхөн өөрийн бодолыг тулгаж байна.

-Зөвлөлтийн тал нь гадаад худалдаанд онцгой эрх эдлэж байна.

-Өөрийн барааны үнийг хэтэрхий өсгөж байна.

-Чанрын шаардлага хангаагүй бараа бүтээгдэхүүн өгч байна.

-Манай бүтээгдэхүүний үнийг хэт доогуур үнэлж байна!

гэх мэтээр хүмүүс ярьсан байдаг юм. “Манай төр, засаг энэ бүх байдлыг харсаар мэдсээр байж засаж, залруулах талаар ажил зохиохгүй байна. Харин түүнийг байх ёстой энгийн зүйл мэтээр олон түмэнд ойлгуулахыг хичээж байна. Энэ бол эцсийн дүндээ Ю.Цэдэнбалын үйл ажиллагаатай холбоотой юм. Монгол-Зөвлөлтийн найрамдалт харилцаа гэдэг сайхан үгээр халхавч хийж энэ бүхнийг өөгшүүлэн дэвэргэж байна!” гээд л хүмүүс Ю.Цэдэнбалыг шүүмжилсэн байдаг юм. “Монгол улс бие даасан улс учир өөрөө өөрийнхөө гадаад, дотоод бодлогыг бие дааж явуулах хэрэгтэй байна. Одоо манай гадаад, дотоод бодлого ЗХУ-ын хяналтын доор байна. Бид нар өөрсдөө биеэ даагаад социалист бусад орнуудтай харилцаж баймаар байна. Цаашлаад хөрөнгөтөн орнуудтай худалдааны

харилцаатай больё. Бид урд, хойд хөрштэйгээ тэгш эрхтэйгээр хамтарч ажиллая. Аль нэгийг нь илүүд үзэж, нөгөөдхийг нь шоовдорлож болохгүй!” гэж ярьсан байдаг юм.

Монголын шинэ үеийн сэхээтнүүдээс гарч байсан эдгээр саналууд буруу биш, харин ч ажил хэрэгтээ удирдлага болгомоор сайхан саналууд байсан юм л даа. МАХН-ын ТХ-ны УТТ-ноос томилогдсон хүмүүс Ю.Цэдэнбалд хөдөлмөрчидтэй хийсэн уулзалтуудынхаа тайланг танилцуулсан юм билээ. Гэтэл Ю.Цэдэнбал тэр тайланг нь үндэслэж, сэхээтнүүдийг “залхаан цээрлүүлэх” ажил хийсэн юм. Сэхээтнүүдийн дунд байсан ийм үзэл бодлыг “сэхээтний төөрөгдөл” гэж нэрлэсэн юм.

“ЗХУ-аас бид их тусламж, дэмжлэг авч байна. ЗХУ манайд Халх голын дайны үед ихээхэн дэмжлэг үзүүлж, өөрийн цэргийг илгээж, манай нутаг дэвсгэрийг хамгаалж өгсөн. Одоо тэр дайнд үрэгдсэн орос цэргүүдийн шарил манай нутаг дэвсгэр дээр байж л байна. Ийм байхад ЗХУ-ын эсрэг элдэв яриа гаргаж, дэмий юм чалчиж байна. Бид ЗХУ-тай байгуулсан найрамдалт харилцаагаа сулруулах л юм бол өөр хөрөнгөтөн орны хараанд орно!” гэсэн сөрөг тайлбарыг Ю.Цэдэнбал хийсэн юм.

Тэгээд МАХН-ын ТХ-ны УТТ-г хуралдуулж, Ю.Цэдэнбал, Монгол-Зөвлөлтийн найрамдлын талаар шүүмжлэлтэй яриа гаргасан өндөр албан тушаал хашиж байгаа зарим нэг хүмүүсийг авч хэлэлцээд, ажлаас нь халах ажлыг зохион байгуулсан юм. МАХН-ын ТХ-ны УТТ-ны энэ хурал 1956 оны 10-р сард хуралдсан юм. Манай Улаанбаатар хотын МАХН-ын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга М.Дамдин гуай тэр хуралд оролцсон юм. М.Дамдин гуай тэр хуралд намайг дагуулж очсон юм. Миний үүрэг бол энэ хурлаар авч хэлэлцэх хүмүүсийг хуралд танилцуулах явдал байсан юм. Өглөө эхэлсэн хурал бүр шөнө болтол үргэлжилсэн юм. Тэр хуралд МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүдээс гадна нарийн бичгийн дарга нар оролцсон юм. Тэр хуралд оролцсон бүх хүн өдөржин дуугүй суусан бөгөөд ганц ярьдаг хүн нь Ю.Цэдэнбал болж байсан юм. Ю.Цэдэнбал хуралд дуудагдаж ирсэн хүмүүстэй их ширүүн харьцаж, өндөр чанга дуугаар тэднийг загнаж байсан юм. Хамгийн сүүлд МХЗЭ-ийн ТХ-ны хэлтсийн дарга Т.Жамцыг дуудах үүргийг надад өглөө. Т.Жамц бид хоёр МАХН-ын Шинэ хүчний сургуульд хамт сурч, төгссөн юм. Тэр яагаад энэ хэрэгт холбогдсоныг би мэдсэнгүй. Би шөнийн 3 цагт түүний гэрт нь очлоо. Тэгээд л дагуулж ирээд л хуралд орууллаа. Түүнийг мөн л Ю.Цэдэнбал ганцаараа л загнаад эхэллээ. “Чи ЗХУ-ын эсрэг үзэл бодолтой гэнэ ээ. Халхын голд Зөвлөлтийн цэргийн олон мянган шарил байгааг чи өөрөө сайн мэднэ шүү дээ. Тэд нар манай орныг хамгаалж Япон улсын цэрэгтэй байлдаад тэнд нас барсныг чи бас мэдэж байгаа. Чи тэгээд яагаад зөвлөлтийн эсрэг ханддаг юм бэ? Бид одоо зөвлөлтийн

дэмжлэг туслалцааг их авч байна. Чи намын ажилтан байсан хүн. Чи яагаад өөрийн намын бодлогын эсрэг хандаад байгаа юм бэ?” гээд л ярих юм. Т.Жамц ч дуугүй л сугаад байх юм. Тэгж байгаад хурал дууслаа.

Тэгээд Ю.Цэдэнбал “Ер нь байдал их хүнд байгаа юм байна. Энэ гол гол хүмүүс дээр арга хэмжээ авахгүй бол болохоо байсан юм байна. Энэ элдвийн юм яридаг хүмүүст цохилт өгөх хэрэгтэй байна. МАХН-ын ТХ-ны тусгай тогтоол гаргах хэрэгтэй юм байна. Тэр тогтоолын төслийг Б.Ширэндэв, Д.Төмөр-Очир, С.Самдан гурав бэлтгэж бэлэн болгох хэрэгтэй. Та гурав Нүхтэд очоод, тогтоолын төслийг яаралтай бэлэн болгох хэрэгтэй!” гэж хэлсэн юм.

Би тэр тогтоол гарахаас өмнө Өмнөговь аймгийн МАХН-ын хорооны нэгдүгээр нарийн бичгийн даргаар томилогдоод явсан юм. Намайг явсан хойгуур тэр тогтоол гарч, олон хүнийг ажлаас нь халж, амьдаралгүй болгосон юм. Ийм тогтоолын төсөл боловсруулах ажилд Б. Ширэндэв гуай оролцохоос татгалзсан юм билээ.

Тэдний дотор МХЗЭ-ийн ТХ-ны нэгдүгээр нарийн бичгийн дарга М.Дангаасүрэн, Т.Жамц, эрдэмтэн Ц.Дамдинсүрэн, Дорнод аймгийн МАХН-ын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга З.Содномцэрэн, МАХН-ын түүхийн хүрээлэнгийн судлаач Ж.Төмөрбаатар, Д.Лхамжав, эдийн засгийн ухааны доктор Ш.Бат-Очир нарын зэрэг олон хүн орж байсан юм. Заримыг нь шоронд ч суулгасан байх. МАХН-ын ТХ-ноос гаргасан тогтоолд эд нарын нэрийг нь дурьдсан юм. “Сэхээтний төөрөгдөл” гэж ийм үйл явдлыг хэлдэг юм.

Ю.Цэдэнбал болон Монгол-Зөвлөлтийн найрамдалт харилцаанд шүүмжлэлтэй хандсан олон хүнийг ингэж залхаан цээрлүүлсэн боловч олон түмний дунд яригдаж байсан яриа бол дарагдаагүй юм. Тэр яриа бүр улам лавшраад л үргэлжлээд л яваад байсан юм. Харин гарах хэлбэр нь арай өөр болсон юм. Тийм яриаг ил тод ярихаа байгаад гэр орондоо, эсвэл үзэл санаа нэгтэй хүмүүс хоорондоо нууц байдалд ярьдаг болсон юм. Энэ яриа далдлагдмал байдалд орчихсон юм.

Ю.Цэдэнбалыг өөрийг нь болон ЗХУ-тай байгуулсан найрамдалт харилцааг шүүмжилсэн хүнийг Дотоод яамны шугамаар баривчилж эхэлсэн юм. Ажлаас нь шууд л халдаг болсон юм. Ер нь манай нийгэм бүхлээрээ анх Ю.Цэдэнбалыг улс төрийн тавцан дээр гарч ирэхэд ингэж дургүйцэж, эсэргүүцэж байсан юм л даа. Ю.Цэдэнбалыг эсэргүүцэж, тэр эсэргүүцлийг нь Ю.Цэдэнбал өөрөө хүчээр нухчин дарах оролдлого хийсэн юм.

Ийм үед Ю.Цэдэнбалыг анх удаа Ц.Лоохууз МАХН-ын ТХ-ны бүгд хурал дээр шүүмжилсэн юм. Ц.Лоохууз “Ю.Цэдэнбал хэтэрхий дураараа байна. Юм бүгдийг ганцаараа шийдэж байна. Ард түмнээс хол

хөндийн байна. Ард түмний амьдралыг мэдэхгүй байна. Улсын зардлаар гадаадад их явж байна. Амрахдаа хүртэл гадаадад явж байна. Зөвлөлтөд болж байгаа үйл явдлуудыг сармагчин мэт дуурайж байна. Өөрийн бодол санаа байхгүй байна. Түүнтэй хамт ажиллаж байгаа УТТ-ны гишүүд Ю.Цэдэнбалын алдаа дутагдлыг хэлж, засаж залруулахын оронд түүнийг магтан сайшааж, алдаа тутагдлыг нь улам дэвэргэж байна!” гэж шүүмжилсэн юм. Энэ бол 1956 оны МАХН-ын ТХ-ны 2-р бүгд хурал дээр хэлсэн үг юм шүү дээ. Тэр үед МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга байсан Дамба гуай Ц.Лоохуузын шүүмжлэлийг маш их дэмжиж байсан юм.

11 Ю. Цэдэнбал.

Б Н: Ю.Цэдэнбал бол хүний хувьд бол их сайн хүн юм шүү дээ. Уур уцаар их багатай хүн шүү дээ. 1940 онд МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга болсныхоо дараа Ю.Цэдэнбал нэг хэсэг их эрч хүчтэй ажиллаж байсан байх. Тэр үед олон түмэн ч түүнийг дэмжиж байсан юм. Тэгээд л яваандаа идэвхи нь сулраад л аажмаар ажил нь муудаад эхэлсэн юм. Х.Чойбалсан нас барсан үеэс эхлээд л тэр мэдэгдэхүйцээр муудаж, идэвхи санаачлагагүй болсон юм. Тэр байдал нь түүнтэй ойрхон ажиллаж байсан хүмүүст илэрхий мэдэгддэг байсан боловч олон нийтэд ердөө мэдэгддэггүй байсан юм. Намайг Уланбаатар хотын МАХН-ын хороонд ажиллаж байхад бид нарт мэдэгдэж байсан юм.

1954 онд Ю.Цэдэнбал 38 настай л байсан юм. Түүнтэй хамт ажиллаж байсан хүмүүс түүний энэ байдлыг нь мэддэг байсан юм. Уг нь бол их дайчин, хурц ухаантай, мэдлэг чадалтай хүн ч бас биш л дээ. Юмыг их удаан ойлгодог хүн байсан юм шүү дээ. Нэг үгээр хэлбэл “жаахан маанагдуу юм уу даа!” гэж хэлмээр хүн байлаа шүү дээ. Түүний дэргэд Д.Дамба гуай чинь ёстой гялалзсан, сэргэлэн сайхан хүн байлаа шүү дээ. Ю.Цэдэнбал бол Д.Дамба гуай болон Х.Чойбалсан нарын дэргэд тэдний далбаан дор дарагдаад явдаг байсан байж магадгүй. Тэгээд Х.Чойбалсангаас хойш ил гарч ирсэн байж болох юм. Х.Чойбалсан Дамба нар байхгүй үед түүний муу талууд дутагдлууд нь илүү их тод харагдаж ирсэн байж болно. Тэдний дэргэд болхоор түүний муу талууд нь дарагдаад ил гарч ирдэггүй байсан байж болох юм. Намайг Улаанбаатар хотын МАХН-ын хороонд байхад л илэрхий муудсан юм.

Би заримдаа уулздаг л байлаа. Хурал, зөвлөлгөөний үед ч л уулзаад ажил байдлын талаар ярилцдаг л байлаа. Надад аажмаар “ийм чадваргүй хүн МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга болчихсон юм уу!” гэж бодогдох болсон юм шүү. Би түүнийг залуудаа маш их шүтэж байлаа.

Манай сумын нэг малчин хүн “Сайн малчдын улсын зөвлөлгөөн”-д оролцсон юм. Тэр эргэж ирээд “Ю.Цэдэнбал гэдэг чинь хиртэй гараар хүрмээргүй, хялар нүдээр хармааргүй, цэмцийсэн сайхан залуу байна!” гэж магтаж байсан юм. Би тэгээд л “Монголын ард түмний удирдагч!” гээд бурхан юм шиг л бодож явлаа. Тэгтэл ажил төрлийн шугамаар ойр холбоотой болоод ирсэн үед ялангуяа “сэхээтний төөрөгдөл” гэдэг тэр үйл явдлын үеэс эхлээд л миний түүний тухай бодол өөрчлөгдөж эхэлсэн юм. Нэг л биш байсан юм даа.

Яг тулаад ойрхноос харсан чинь маш их хоцрогдсон, аминчхан, чадвар муутай, авгайнхаа эрхшээлд бүрэн орчихсон, Зөвлөлтийн эрхшээлд бүрэн орчихсон хүн байв. Түүний боддог юм нь албан тушаалдаа эцсээ хүртэл үлдэх юмсан, Зөвлөлтийн талд нэр нүүр олох юмсан, Зөвлөлтийн талд үнэн ч гэдэгээ харуулах юмсан гэдэг л бодол байсан юм. Зөвлөлтийн талд үнэнч гэдгээ харуулахын тулд үе, үе аль болохоор олон хүнийг “үндэсний үзэлтэн” гэдэг шалтгаанаар ажлаас нь халж, хөөж туухыг боддог болчихсон байв. Улс орноо хөгжүүлэх тухай бодол түүний толгойд байсан гэхэд тун эргэлзээтэй дээ.

Түүнийг ЗХУ-д сурч байхад нь Ж.Самбуу гуай Х.Чойбалсанд танилцуулсан юм билээ. Ж.Самбуу гуай тэр үед ЗХУ-д манай орныг төлөөлсөн элчин сайд байлаа шүү дээ. Тэгээд Х.Чойбалсан түүний улс төрийн карьерийн эхлэлийг нь тавьсан юм. Ю.Цэдэнбал ЗХУ-ын Эрхүү хотод Санхүү, эдийн засгийн сургууль төгссөн юм. Түүний өмнө Буриадын Улан-Үд хотод Рабфакийг төгссөн юм билээ. Рабфак бол ЗХУ-ын дээд сургуульд суралцахаар ирсэн монголчуудад зориулсан орос хэлний бэлтгэл анги юм.

Түүнтэй хамт ЗХУ-ын Эрхүү хотод Нянтайсүрэнгийн Лхамсүрэн сурч байсан юм билээ. Н.Лхамсүрэн гуай хожим тэр үеийн тухай сонин дурсамж ярьдаг юм. Ю.Цэдэнбал тэр хоёр ер нь ойр дотно найзалдаг байж л дээ. Сургууль төгсөхөөс нэг хоёр жилийн өмнөөс Ю.Цэдэнбал их өөрчлөгдсөн байна. Тэр нэг л их халдашгүй дархан эрхтэй болоод л ирсэн гэнэ. Сургуулийн захиргаанаас түүнд онцгой анхаарал тавьдаг болсон гэнэ. Тэгээд үе үе алга болчихдог болсон гэнэ. Түүнийг хаана юу хийж явааг нь хэн ч мэддэггүй байж л дээ. Тэгж нэг хэсэг алга болж байгаад л гарч ирдэг гэнэ. Тэгж гарч ирэхдээ их гоё хувцас өмссөн, хачин тансаг хүн болсон байдаг байж л дээ. Хаана, юу хийж яваад ирснээ тэр хэнд ч хэлдэггүй, сүүлдээ хамт сурч байсан хүмүүс нь түүнээс энэ талаар асуухаа ч больсон гэнэ. Бүр хожим зарим хүмүүс түүний энэ байдлыг нь “Ю.Цэдэнбал тэр үеэс л ЗХУ-ын Улсыг Аюулаас Хамгаалах Хороотой холбоотой (Комитет Государственной Безопасности–КГБ) болсон! Тэндээс мөнгө авдаг, бас даалгавар авдаг байсан!” гэж тайлбарладаг байсан юм. Энэ яриа үнэн бол

түүнийг анх Х.Чойбалсан Монголын улс төрд оруулж ирсэн биш ЗХУ-ын Улсыг Аюулаас Хамгаалах Хороо оруулж ирсэн болж таарч байгаа юм. Тэр ЗХУ-аас ирэхдээ маш том тодорхойлолттой ирсэн байдаг юм билээ.

Х.Чойбалсан түүнийг эхлээд Санхүүгийн техникумын орлогч захирлаар ажиллуулаад дараа нь Монгол банкны захирал, Сангийн яамны орлогч сайдын албан тушаалд томилож байсан юм шүү дээ. Тийм залуу хүнийг тийм хурдан өндөр албан тушаалд ээлж дараалан томилох нь Х.Чойбалсангийн арга барил биш л дээ. Гэхдээ тэр үед Монголд мэргэжилтэй боловсон хүчин их ховор байлаа шүү дээ. 30-аад оны сүүлчээр манайх улс төрийн хилс хэргээр ихэнх мэргэжилтэй боловсон хүчнээ хэлмэгдүүлдээ, цаазлахыг нь цаазлаад, шоронд суулгаад дууссан юм. Ю.Цэдэнбал шиг санхүү, эдийн засгийн мэргэжилтэй, орос хэлийг сайн эзэмшсэн залуу хүн их ховор байлаа. Манай төр, засаг, МАХН-ын удирдлагад Ю.Цэдэнбал шиг хүн маш хэрэгтэй байсан байх. Тийм учир Ю.Цэдэнбалыг тэр үед хурдан албан тушаал дэвшүүлж байсан нь тийм ч их буруу үйлдэл байгаагүй гэж би боддог юм.

Тэр үед Ю.Цэдэнбалаас гадна Б.Ширэндэв, Н.Лхамсүрэн, Ч.Сүрэнжав гэх мэтийн цөөхөн хүн хүн байсан юм. Энэ хүмүүс Х.Чойбалсангийн үед түүнтэй маш их ойрхон ажиллаж байсан юм. Эд нарын дотроос чухам хэнд нь Х.Чойбалсан өөрийнхөө ажлыг өгөх байсан бол? гэсэн нэг асуулт байдаг юм. Зарим хүмүүс Н.Лхамсүрэнд илүү итгэж байсан гэсэн яриа байдаг юм. Олон нийт бол “Ч.Сүрэнжав л түүний ажлыг залгамжлах ёстой!” гэж боддог байсан байх. Харин “Х.Чойбалсангийн залгамжлагч Ю.Цэдэнбал болно!” гэсэн яриа ер нь байгаагүй юм.

Ю.Цэдэнбал Н.Лхамсүрэн хоёр нэг хэсэг их найз байсан юм. Н.Лхамсүрэн гуай эхлээд Хөдөө Аж Ахуйн Яам (ХААЯ)-ны сайдаар томилогдсон юм. Дараа нь МАХН-ын ТХ-ны үзэл суртал эрхэлсэн нарийн бичгийн даргаар сонгогдсон юм. Нэг хэсэг Гадаад харилцааны яамны сайдын албыг ч хашиж байсан юм. Ю.Цэдэнбал, Н.Лхамсүрэн хоёр сүүлдээ их муудалцсан юм билээ. Тэгээд Н.Лхамсүрэнгээ Ю.Цэдэнбал нь ажлаас нь халаад, МАХН-ын ТХ-ны УТТ-ноос хөөсөн юм. Энэ хоёрын маргаан нь цэвэр хувийн шинж чанартай байсан юм. Тэр хоёрын маргааны шалтгааныг би тэр үед бүдэг бадаг ойлгож байсан юм. Н.Лхамсүрэнийг эхнэр нь анагаах ухааны доктор, их чадалтай хүн байсан юм. Бас их сайхан ч хүүхэн байлаа. Түүний нэр нь Намсрайжав юм. Ю.Цэдэнбалд Намсрайжав таалагддаг байсан байж магадгүй. Ю.Цэдэнбал түүнийг огт зүгээр байлгасангүй л дээ. Ингээд сүүлдээ Намсрайжавын тэвчээр нь барагджээ. Тэр Ю.Цэдэнбалд нилээд сүрхий хатуу үг хэлдэг болсон юм байж. Хатуу үг хэлээд зогссонгүй, Намсрайжав Ю.Цэдэнбалын энэ шалиг үйлдлийн талаар МАХН-ын ТХ-ны УТТ-ны зарим гишүүдэд хэлээд,

түүний энэ шалиг үйлдлийг зогсоохыг тэднээс шаардсан юм байж.

Гэтэл Ю.Цэдэнбал үүнд нь маш их уурлажээ. Тэгээд тэр “Намсрайжавыг МАХН-аас хөө!” гэсэн даалгаварыг өгсөн юм байж. МАХН-аас хөөх даалгаврыг Улаанбаатар хотын МАХН-ын хорооны дарга М.Дамдин гуайд өгчээ. Ю.Цэдэнбалаас ийм даалгавар авсан М.Дамдин гуай Улаанбаатар хотын МАХН-ын хорооны товчооны гишүүдийг цуглуулсан юм. Товчооны гишүүн байсан Р.Лувсанравдан, Б.Лувсанчойнбол, Д.Дангаа зэрэг хүмүүс цугларсан юм. Би товчооны гишүүний хувьд тэр хуралд очлоо. Эхлээд бид нар энэ хурлаар ямар асуудал хэлэлцэхийг нь мэдээгүй юм. Хурал болох тухай зар ажил тарснаас хойш гэнэт ирсэн юм.

Уг нь бол Товчооны гишүүдийн хурал болох зар хоёр хоногийн өмнө ирдэг, хэлэлцэх асуудлаа бидэнд урьдчилаад танилцуулдаг журамтай байлаа. Бас хэлэлцэх асуудлаар гаргах тогтоолын төслийг хүртэл урьдчилаад танилцуулдаг байлаа. Гэтэл энэ удаагийн хурал тийм бэлтгэл хийсэнгүй, шууд л эхэллээ. Товчооны гишүүд М.Дамдин даргын өрөөнд сууж байлаа. М.Дамдин гуай бидэнд хандаж ямар нэгэн юм хэлсэнгүй. Тэнд байгаа бүх хүн дуугүй л сууцгааж байлаа. Тэгж байтал гаднаас Намсрайжав орж ирээд суулаа. Бид нар их гайхаж байлаа. Ингээд хурал эхэллээ. М.Дамдин гуай босоод :

-За энэ удаагийнхаа хурлын ажиллагааг эхэлье. МАХН-ын ТХ-ны УТТ-ноос бидэнд даалгавар ирсэн. Манай Намын хорооны товчооны гишүүдийн энэ удаагийн хурлаар бид нөхөр Намсрайжавтай холбоотой нэг зарчимгүй асуудлыг авч хэлэлцэнэ. Нөхөр Намсрайжав манай МАХН-ын удирдагчийг хэл амаар доромжилсон юм байна. Манай намын удирдагчийн талаар элдвийн худал, цуурхал тарааж, түүнийг гүтгэсэн байна. ТХ-ны эв нэгдлийг эвдэхийг оролдсон байна. Ийм учир бид нар энэ асуудлыг авч хэлэлцээд, Намсрайжавын энэ үйлдлийг таслан зогсоож, түүнийг МАХН-ын эгнээнээс хөөх хэрэгтэй байна! гэсэн утгатай үг хэлээд суучихлаа. Бид нараас дуу гарах хүн байсангүй. Бүгд л дуугүй сууж байлаа. Тэгтэл Намсрайжав өөрөө босоод үг хэллээ.

-Та нарын хэнтэй ч ярих хүсэл надад алга байна. Би олон дахин давтагдсан үйл явдлын талаар хэлэх ёстой газарт нь үнэнээр нь хэлсэн. Би ийм явдлыг хэзээ ч тэвчиж чадахгүй. Би ямар ч худал цуурхал тараагаагүй, хэнийг ч гүтгээгүй. Би хэнийг ч хэл амаар дайрч доромжлоогүй. Би гэр бүлтэй хүн. Та нар намайг МАХН-аас хөөх гэж байгаа бол хөөж болно. Би МАХН-ын өмнө буруу хэрэг хийгээгүй учир надад хүлээх хэрэг байхгүй. Би ямарч буруугүй! Харин түүний оронд хүмүүжилгүй, бүдүүлэг, шалиг удирдагч нараа эндээс хөөж байвал та нарын нэр хүндэд чинь тустай хэрэг болно шүү! гэсэн утгатай үг хэлээд суучихлаа.

Манай Дамдин дарга нэг ч үг хэлж чадсангүй. Тэр таг дуугүй л сууж байлаа. Тэгж байснаа

-За, за ойлголоо. Та нар тарцгаа! гээд биднийг тараачихлаа. Энэ хэрэг ингээд л өнгөрсөн юм. Би сүүлд М.Дамдин даргаасаа энэ асуудлын талаар асуусан юм. М.Дамдин дарга тэр үед Ю.Цэдэнбалаас даалгавар авснаа хэлсэн юм. МАХН-аас Ю.Цэдэнбал ингэж Намсрайжавыг МАХН-ын гишүүнээс нь хөөж чадаагүй юм. Тэгээд түүний нөхрийг нь зайлуулах арга хайж эхэлсэн юм байж.

Н.Лхамсүрэнгийн аав нь 1920-оод оны үед нэг хэсэг Монголд орж ирсэн Оросын цагаан цэрэгт алба хааж байсан тухай нэг яриа байдаг юм. Эсвэл тэр яриаг анх Ю.Цэдэнбал өөрөө зохиосон юм уу? Бүү мэд. Тэгээд “Октябрийн хувьсгалаас зугатаасан цагаан цэрэгт алба хааж байсан хүний хүүхэд МАХН-ын удирдах бүрэлдэхүүнд байж болохгүй!” гэсэн үндэслэл гаргаж ирээд, Н.Лхамсүрэнг бүх албан тушаалаас нь халаад, намаас хөөчихсөн юм. Н.Лхамсүрэн ингэж Монголын улс төрийн тавцангаас буусан юм. Тэр дахин улс төрд орж ирсэнгүй.

Харин 1990-ээд оноос Монголд ардчилал, шинэчлэл эхэлснээс хойш Монголын чөлөөт хэвлэлд хэд хэдэн удаа маш сонирхолтой ярилцлага өгсөн юм. Тэр Ю.Цэдэнбалтай багын найз байсан тухайгаа их тодорхой ярьсан байдаг юм. Бас ЗХУ-д тэр хоёр хамт сурч байх үеийнхээ тухай сонирхолтой дурсамжийг өгүүлсэн байдаг юм. Н.Лхамсүрэн уг нь миний багш юм шүү дээ. Намайг Намын шинэ хүчний сургуульд сурч байхад надад багшилдаг байсан юм. Тэр сургуульд бас Д.Төмөр-Очир, С.Жалан-Аажав нар багшилж байлаа. Тэнд Дамба гуай хааяа, хааяа ирж яриа хийдэг байсан юм. Тийм болохоор би Н.Лхамсүрэн гуайтай эртний танил юм л даа. Тэр албан тушаалаасаа бууснаас хойш Зүүн-Хараад амьдарч байсан юм. 1990-ээд он эхлэхээс өмнөхөн тэр бид хоёр нэг удаа зун санамсаргүй уулзалдлаа л даа. Тэгээд тэр намайг гэртээ урилаа. Би очлоо. Түүний эхнэр нь нас барсан, ганцаараа амьдарч байсан юм. Тэгээд тэр надад маш их түүх ярьлаа. Тэр үед Ю.Цэдэнбалтай хэрхэн муудалцсанаа ярьж байсан юм.

Бас “Ю.Цэдэнбал өөрөө Монгол улсыг ЗХУ-тай нэгтгэж, түүний нэг Бүгд найрамдах улс нь болгох санаатай байсан юм шүү!” гэж ярьсан юм. Манай хэсэг сэхээтэн, улс төрчдөд Ю.Цэдэнбал даалгавар өгөөд, ЗХУ-тай нэгдэх хүсэлт гаргуулж байсан юм байна л даа. Н.Лхамсүрэн гуай тэр бичгийн анхны эх бичгийг нь надад өгсөн юм. Ю.Цэдэнбалын өөрийнх нь даалгавраар манай хэсэг сэхээтнүүд тэр бичгийг бичээд гарынхаа үсгийг зурсан юм билээ. Тэд нар Сонгинын амралт дээр хэд хоног сууж, тэр бичгийг үйлджээ. Тэр бичгийг би сайн уншиж үзсэн юм. Түүний гол агуулга нь “Социализмыг байгуулах Лениний төлөвлөгөөр

бол аливаа улс орнууд эхлээд хүнд үйлдвэрийг хөгжүүлэх ёстой. Гэтэл манай оронд хүнд үйлдвэрийн салбар ерөөсөө хөгжөөгүй байна. Иймд эх орондоо социализмыг төгс байгуулахын тулд ЗХУ-ын хүнд үйлдвэрийг түшэглэж ЗХУ-ын бүрэлдэхүүнд орвол социализмыг хурдан байгуулах боломжтой юм!” гэсэн санааг илэрхийлсэн байна билээ. Тэр бичигт “Монгол улс ЗХУ-ын бүрэлдэхүүнд орё!” гэж шууд бичээгүй л юм байна билээ шүү. Тэнд олон асуудал хөндөгдсөн байна билээ. Нөгөө “сэхээтний төрөгдөл”-ийн үед яригдаж байсан асуудлаас зарим нь орсон байсан юм. Тухайлбал Монгол улсыг яаж хурдан хагжүүлэх вэ? зэрэг асуудлыг л хөндсөн байгаа юм. Н.Лхамсүрэн гуай тэр бичгийг надад өгөхдөө “Энэ бичгийг гадна талаас нь харахад манай нэг хэдэн сэхээтэн өөрсдийн санаа бодлоо илэрхийлж байгаа юм шиг байгаа биз! Харин энэ бичгийг үйлдэх даалгаврыг Ю.Цэдэнбал өөрөө өгсөн юм. Энэ бол түүний өөрийнх нь бодол юм шүү дээ! Ю.Цэдэнбал өөрөө орос эхнэртэй хүн болохоор ЗХУ-д нэгдэх бодолтой байсан байх!” гэж хэлж байсан юм.

Ю.Цэдэнбал “Нэгдэлжих хөдөлгөөн бол 1921 оны Ардын хувьсгалтай дүйцэх их том үйл явдал!” гэж ярьдаг байв. Үнэн хэрэг дээрээ бол энэ хөдөлгөөн Монголд ямар ч ашиг тусыг өгөөгүй шүү дээ. Ард түмний амьдралд ямар ч нэмэр болоогүй, харин улам доройтуулсан юм шүү. Уг зорилго нь бол хамтарч хөдөлмөрлөөд л амьдрал ахуйгаа өөд нь татах явдал байсан байх л даа. Гэтэл тэр нь бүр эсрэгээр эргэсэн юм. Ард түмний амьдрал үнэхээр доройтоод ирсэн юм. Монгол улсыг ёстой элгээр нь хэвтүүлсэн юм шүү. Нэгдэлд ажиллаад “Хөдөлмөрийн баатар” болсон хүмүүс бий л дээ. Энэ бол маш цөөхөн хүн шүү дээ. Нэг, хоёр л хүн байгаа. Харин нийт ард түмний амьдрал бол улам дордоод л байлаа шүү дээ. Ажил нь сайн явж байгаа нэгдэл байсан юм. Гэхдээ их цөөхөн байсан даа.

12 МАХН-ын ТХ-ны 6-р бүгд хурал.

И Л: Та 1964 оны 12-р сард хуралдсан МАХН-ын 6-р бүгд хурал дээр гадаад зээлийн өр өсч байгаа асуудалд их шүүмжлэлтэй хандсан юм байна. Энэ зээлийн өр өсөх болсон шалтгааны талаар та тодруулж ярина уу?

Б Н: Тийм. Тэр үед зээлийн өр маш их болсон байсан юм. Энэ өр дайнаас хойш улам өсөх хандлагатай болоод ирсэн юм. Зээлийн хөрөнгө юунд зарцуулагдаж байсан бэ? Түүнийг маш үр ашиг багатай зүйлд голчлон зарцуулж байсан юм. Өөрсдөө хийгээд бүтээгээд, өөрсдийнхөө хэрэгцээг хангах боломжийг ашиглаж чадахгүй байсан юм. Тэгээд л яльгүй энгийн зүйлийг хүртэл зээлийн хөрөнгөөр авч байлаа шүү дээ. Тэнд бас их шударга биш явдал болж байсан юм.

Банкны ханшаар нэг рубль бол дөрвөн төгрөг арван хоёр мөнгө байсан юм. Гэтэл бид нар зээлээ дандаа “шилжих рубль”-ээр авдаг байлаа. Нэг шилжих рублийг найман төгрөгөөр бодож байсан юм. Ийм нөхцөлд зээлийн өр өндөр хурдтай өсөх нь гарцаагүй зүйл шүү дээ. Шилжих рублийн төгрөгтэй харьцах харьцаа ийм өндөр байснаас болоод бид нар чинь төлж барахгүй их өртэй болж байсан юм. Гэтэл Ю.Цэдэнбал тэргүүтэй МАХН-ын удирдлагууд зээлийн өрийг багасгах талаар огт санаачлага гаргахгүй байсан төдийгүй, түнийг улам өсгөсөн алхамуудыг хийгээд байсан юм.

Тэр зээлийг ЗХУ-аас Монголыг хөгжүүлэхийн төлөө өгч байгаагүй гэдэгт би эргэлзэхгүй байна. Харин энэ зээлийн өр биднийг улам бүр ЗХУ-ын хараанд оруулж байсан юм. Монголын сэхээтнүүдийн дунд яригдаж байсан яриануудын талаар ЗХУ-ын Улсыг Аюулаас Хамгаалах Хороо бүрэн гүйцэд мэдээлэлтэй байсан шүү дээ. Тэр чинь манай нийгэмд болж байгаа үйл явдлуудын талаархи мэдээллийг маш олон сувгаар авч байсан юм. Бид биеэ даагаад аливаа ажил хийх болоход ЗХУ-д тэр нь таалагдахгүй бол тэр зээлийнхээ өрөөр барьцаалаад биднийг дарамтлаж эхэлэнэ шүү дээ. Бид нар энэ зээлийн өрөөр дамжаад яалт ч байхгүй ЗХУ-ын хараанд орж эхэлсэн юм.

Улс төрийн ийм хортой үр дагаварыг энэ зээл дагуулж ирэх нь тов тодорхой байсан юм. Энэ зээл бол бас өөр нэг улс төрийн зорилго агуулж байсан юм. Энэ зээлээр дамжаад ЗХУ манай нийгмийн харилцааг яг өөрийн загварт оруулсан юм. Манай уламжлалт нүүдлийн нийгмийн өөрийн онцлогийг үл харгалзаад Монголын нийгмийг бүхэлд нь Зөвлөлтийн маягтай болгох бодлого явж байсан юм. Энэ зээлийг дагаад ЗХУ-аас маш олон тооны мэргэжилтнүүд Монголд орж ирсэн юм. Тэд нар голчлон Монголын хот суурин газар амьдарч, тусгай хангамжаар хангагдаж байсан юм. Тэд нар “улсын доторхи улс” болж байлаа шүү дээ. Монголд өргөн хэрэглээний барааны хомсдолтой байгаа байдлыг далим болгоод өөрийнхөө дэлгүүрээр дамжуулаад бараагаа маш өндөр үнээр зардаг байсан юм.

Манай Монгол орон чинь мал аж ахуйн орон шүү дээ. Тэгтэл дэлгүүрт мах ховорхон байлаа шүү дээ. Бараг байхгүй дээ. Тэгтэл манай мах нөгөө оросын дэлгүүрүүдэд бол овоолоотой байж байдаг л байлаа. Бид нар чинь эхлээд оросын дэлгүүрийг махаар хангаад дараа нь өөрийнхээ дэлгүүрт мах өгдөг болсноос ийм байдал үүссэн юм. Монголд ажиллаж байсан орос мэргэжилтнүүдийг чинь дагаад л тэдний гэр бүл, ах дүү нар нь ирнэ. Тэд нар чинь Монголын хот суурин газрыг бүхэлд нь эзэгнэчихсэн байлаа шүү дээ. Орон сууц бол бүгд тэдний мэдэлд байлаа. Манай улс ардын аж ахуйн бүх салбарт орос зөвлөх-мэргэжилтэн ажиллаж байлаа. Тэд

нар юу хийж бүтээсэн юм бэ? Энэ асуултанд хариулахад их хэцүү л дээ. Өөрөөр хэлбэл юу ч хийж бүтээгээгүй болохоор хариу байхгүй. Энэ зөвлөх мэргэжилтнүүд маш өндөр хангамжтай, маш өндөр цалин авч байсан юм. Яг адилхан ажил хийж байгаа монгол мэргэжилтнээс 3-4 дахин их цалинтай байсан юм. Тэдний цалин, орон сууц, гэрэл цахигаан зэрэг ахуйн хэрэгцээний бүх зардлыг манайх хариуцаж байсан юм.

Үйлдвэр аж ахуйн газруудад манай өөрийн мэргэжилтнийг дагалдуулаад заавал нэг орос мэргэжилтэн өгдөг байлаа шүү дээ. Тэнд орос мэргэжилтэн ажиллах ямар ч шаардлагагүй байхад шүү дээ. Ийм хачин байсан юм. Тэр зөвлөх мэргэжилтнүүд нь яамр ч үүрэг, хариуцлага хүлээдэггүй байсан юм. Гэхдээ маш их өндөр эрхтэй, маш их дураараа загнадаг байсан юм. Нэг хүн 2-3 жилийн хугацаагаар ирдэг байлаа. Зарим нь хугацаагаа сунгаад л суугаад байна шүү дээ. Тэд нарын ахуйн хэрэгцээний бүх зардлыг манай тал хариуцаж байсан болохоор тэд нар маш их үрэлгэн амьдарч байсан юм. Ерөөсөө цахилгаан, ус зэрэг ахуйн хэрэглээний зүйлийг ямар ч хязгаарлалтгүй хэрэглэдэг байсан юм. Маш дураараа байлаа. Тэдэнд Монголын хууль үйлчилдэггүй байсан юм. Тухайлбал голын усны загасыг барихдаа тэд дэлбэлэх аргыг хэрэглэдэг юм. Монголд ийм аргаар загас барихыг хориглодог юм. Гэтэл зөвлөх мэргэжилтэнд хууль зөрчсөн ийм үйлдлийнх нь төлөө хэн ч, хэзээ ч, ямар ч шийтгэл ноогдуулж байсангүй. Энэ мэргэжилтнүүд Монголын эдийн засагт үнэхээр хүнд дарамт учруулж байсан юм.

И Л: Та Өмнөговь аймгийн МАХН-ын хорооны даргын албыг хашиж байгаад ЗХУКН-ын дээд сургуульд явж суралцсан уу? Тэр үед энэ сургуульд ямар хүмүүсийг, ямар шалгуураар явуулдаг байсан юм бэ?

Б Н: Тэгсэн. Би Өмнөговь аймгийн МАХН-ын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга байхдаа ЗХУКН-ын дээд сургуульд явсан юм. Ер нь тэр үед аймгийн захиргаанд алба хашиж байгаа хүмүүс, бас аймгийн МАХН-ын хороонд ажиллаж байгаа хүмүүсийг голчлон энэ сургуульд явуулдаг байсан юм. Энэ сургуульд явуулдаг гол шалгуур бол өөрийн хариуцаж байгаа ажлынх нь үр дүн байсан юм. Хариуцсан ажлаа сайн хийж байгаа хүмүүсийг бол нэгдүгээр ээлжинд явуулдаг байлаа. Тэгээд бас олон юм харна л даа. Тэр үед чинь МАХН-ын ажилтан хүнд чинь маш их хатуу олон шаардлага тавьдаг байлаа шүү дээ. Аль нэг байдлаараа, ямар нэгэн доголдол гаргасан хүн МАХН-ын ажилтан бараг болдоггүй л байлаа шүү дээ. Ялангуяа МАХН-ын бүх шатны удирдах ажилтанд бол маш өндөр шаардлага тавьдаг байсан юм. Тэр бүгдийг давж гарсан хүн л МАХН-ын бүх шатанд удирдах ажил хийдэг байлаа. Тийм хүмүүс дотроос сонгож

ЗХУКН-ын дээд сургуульд явуулдаг байлаа. Тэр сургуульд явахын тулд гол нь өөрөө эхлээд энэ тухай хүсэлтээ МАХН-ын ТХ-нд гаргах ёстой юм. Тэр хүсэлтийг нь МАХН-ын ТХ-ны боловсон хүчний хэлтэст авч хэлэлцдэг байсан юм. Тэндээс МАХН-ын ТХ-ын нарийн бичгийн дарга нарын хурлаар орж хэлэлцэгдээд, шийдвэр гардаг байсан юм. Энэ бүх давааг давж чадахгүй, хасагдах явдал бол их байсан л даа. Үзэл суртал, улс төрийн олон шалгуураар оруулна шүү дээ. Хүсэлтээ гаргасан хүн бүгд энэ сургуульд явж чадахгүй л дээ. 1962 онд бидний 20 хүн тэр сургуульд явсан юм.

И Л: Тэнд суралцаж байсан хүмүүс улс орондоо болж байгаа үйл явдлуудын талаар ер нь их ярьдаг байсан юм шиг байна л даа. Та энэ талаар жаахан дэлгэрүүлж ярина уу?

Б Н: Сургуульд явахын өмнө МАХН-ын болон аймаг, орон нутагт хариуцлагатай ажил хийж байсан хүмүүс голчлон тэр сургуульд очдог байсан болохоор ярих ярианы сэдэв бол их өргөн байсан байж магадгүй. Олон сэдвээр их ч яриа болдог байлаа. Ер нь ярианы гол сэдэв бол Монгол орны хөгжлийн хандлагын асуудал байсан юм. Тэнд сурч байсан ихэнх хүмүүс тэр үеийн Монгол орны хөгжлийн хурдцад их сэтгэл дундуур байсан юм. ЗХУ-д очоод өөрийн орны байдлыг тэдний байдалтай харьцуулж харах боломжтой болсон юм. Тэр үед манай хоёр орны хөгжлийн хурд эрс ялгаатай байсан юм. Тэдний төр засгаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд түргэн шуурхай, маш далайцтай, цаг үеэ олсон юм шиг санагдаж байлаа шүү дээ. Тэдний эдийн засаг, нийгэм манайхтай харьцуулашгүй том шүү дээ. Хүн ардынх нь боловрол, мэдлэгийн түвшин ч шал өөр л дөө. Гэхдээ л бид олон зүйлийг харьцуулж харах боломжтой байсан юм.

И Л: Та 1964 оны 12-р сард хуралдсан МАХН-ын 6-р бүгд хурал дээр МАХН-ын дотор байгаа бусармаг явдал, ялангуяа МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбалын зүгээс гаргаж байсан шударга биш үйлдлүүдийг маш тодорхой баримттайгаар шүүмжилсэн билээ.

Б Н: Миний сурч байсан ЗХУКН-ын дээд сургуулийг гурван жил суралцаад төгсдөг юм. Би хоёр жил хагас суралцсан байхад 1964 оны 12-р сард МАХН-ын ТХ-ны 6-р бүгд хурал хуралдсан юм. Би сургуулиа төгсөхөд хагас жилийн хугацаа үлдээд байлаа. МАХН-ын Бүгд хурал дээр түүний удирдагч болон энэ намын дотор байгаа бусармаг явдлуудыг

шүүмжлээд “сайнаа үзэхгүй!” гэдгийг би мэдэж байсан юм. Би Монголын улс төрд нилээд хэдэн жил ажилласан, багагүй хашир суусан хүн байлаа шүү дээ. Би хамт сурч байсан хүмүүстээ МАХН-ын ТХ-ны бүгд хуралд очиж оролцоод, Ю.Цэдэнбалыг шүүмжлэхээр шийдсэн тухайгаа огт хэлээгүй юм шүү дээ. Нэг, хоёрын зэрэг хүнд бүдэг бадагхан зүйл хэлсэн юм. Тэд нар намайг Москвагийн онгоцны буудал дээрээс гаргаж өгсөн юм. Тэдний нэг нь онгоцны билет авч өгч тусалсан юм.

1964 оны 12-р сард хуралдсан МАХН-ын 6-р бүгд хурлаар уг нь “МАХН болон улсын хяналт шалгалтыг сайжруулах тухай асуудал” хэлэлцсэн юм. Ийм сэдэвтэй илтгэлийг МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбал тавьсан юм. Тэр энэ илтгэлээ 3 цаг уншсан юм. Бас Төлөвлөгөөний комиссын Т.Рагчаа илтгэл тавьсан юм. Бид нар энэ хуралд ирж оролцоод, Ю.Цэдэнбал болон МАХН-аас явуулж байгаа бодлогыг шүүмжлэлэх гэж байгаа тухай мэдээг МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүд авсан юм билээ. Тэр үед Москвад суралцаж байсан хүмүүсийн дотор “мэдээ дамжуулагч” нар олон байсан юм. МАХН-ын УТТ-ны гишүүд бидэнд “намын эсрэг бүлэг” гэж нэр өгөөд, маш хүчтэй залхаан цээрлүүлэх арга хэмжээ авахаар шийдвэрлэсэн юм билээ. Энэ нь зөвхөн биднийг биш цаашид МАХН-ын дотор өөр үзэл санаатай хүн байлгахгүй, одоо байгаа хүмүүст гашуун сургамж өгөх зорилготой байсан юм.

Ер нь Ю.Цэдэнбалын улс төрийн чиг бодлого, ажлын арга барил, Монгол-Зөвлөлтийн найрамдлын талаар бүр “сэхээтний төөрөгдөл”-ийн үеэс гарч байсан шүүмжлэлтэй ярианууд тасраагүй, энэ ярианууд нийгэмд оршсоор байсан юм. Тэгээд энэ бүгд хурлаар энэ ярианд эцсийн цэг тавихаар төлөвлөсөн байгаа юм. “Намын эсрэг бүлэг” гэж нэрлэсний учир нь МАХН-ын дотор “намын эсрэг бүлэг” ажиллаж байна. Тэд нар МАХН-ын үйл ажиллагаа болон түүний удирдагчийн тухай элдэв гүтгэлэгийн шинжтэй яриаг зориуд зохион байгуулалттайгаар нийгэмд тарааж, намын эв нэгдлийг эвдэх, түүний удирдан чиглүүлэх үйл ажиллагааг таслан зогсоох зорилготой байсан!” гэсэн ойлголтыг нийгэмд төрүүлэх зорилготой байсан юм.

Тэр үед ЗХУ-д Н.С.Хрущёвыг ЗХУКН-ын ТХ-ны нэгдүгээр нарийн бичгийн даргын ажлаас хуйвалдааны замаар огцруулаад хуучныг баримтлагч Л.И.Брежнев ЗХУКН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга болсон юм. Улс төрийн ийм эгзэгтэй үед энэ бүгд хурал хуралдсан юм. Н.С.Хрущёвтэй тохиолдсон үйл явдал Монголд гарах магадлал өндөр байсан юм. Энэ хурлын уур амьсгал Ю.Цэдэнбалын эсрэг чиглэлд өөрчлөгдөх бүрэн боломжтой байсан юм. Монголын нийгэмд “Ю.Цэдэнбалаас салъя!” гэсэн хандлага хүчтэй оршсоор байсан юм. Ийм учир Ю.Цэдэнбал энэ хуралд маш ултай суурьтай бэлтгэсэн юм.

“Б.Нямбуу, Ц.Лоохууз хоёр бол гарцаагүй намайг шүүмжлэх юм байна!” гэж Ю.Цэдэнбал мэдсэн юм байна. Тэгээд тэр өөрийгөө хамгаалах арга хэмжээнүүдийг авсан юм байна. Тэгээд Ю.Цэдэнбалыг хамгаалж үг хэлэх хүмүүсээ сонгож тогтсон юм байна. Бүгд хурлын албан ёсны илтгэлийг уншиж дуусмагц МАХН-ын ТХ-ны Хянан Шалгах Хороо (ХШХ)-ны дарга С.Лувсанравдан, Улаанбаатар хотын МАХН-ын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Б.Алтангэрэл хоёр үг хэлэх ёстой байж. Тэр хоёр хурлын уур амьсгалыг Ю.Цэдэнбалд ашигтайгаар эргүүлэх зорилготой байж. Тэд нар Д.Төмөр-Очир, Л.Цэнд нараар жишээ татаж байгаад л биднийг шүүмжлэсэн юм. “Энэ мэтийн хоосон чалчигчидтай манай нам хатуу тэмцэл явуулна!” гэх мэтээр ярьсан юм. Нийтдээ Ю.Цэдэнбалыг хамгаалж, биднийг шүүмжилж хорин дөрвөн хүн үг хэлсэн юм.

Энэ хуралд маш их хүчтэй бэлтгэж байгаа талаар бид нар ч мэдээлэл авч байсан юм. Бид нар энэ бүгд хурал дээр түүнийг шүүмжлэх гэж байгааг Ю.Цэдэнбал мэдээд ихээхэн тэвдэн сандарч, ямар ч үнээр хамаагүй эрх мэдлээ авч үлдэхийн тулд бүх хүч бололцоогоороо өдөр шөнөгүй ажиллаж байгаа нь бидэнд бас мэдэгдсэн юм. Нянтайсүрэнгийн Лхамсүрэн гуай энэ талаар надад Б.Жамц гэдэг хүнээр дамжуулж нууцаар мэдээлсэн юм. Тэр бүгд хуралд оролцсон бүгд хурлын гишүүдийн дотор Ю.Цэдэнбалын бодологод дургүй, шүүмжлэлтэй ханддаг хүн олон байсан юм.

Хэрвээ Ю.Цэдэнбал энэ хурлыг ингэж сайн зохион байгуулж хариу арга хэмжээ аваагүй бол хурлын үйл ажиллагаа шууд Ю.Цэдэнбалын эсрэг эргэх бүрэн боломжтой байсан юм. Бүгд хуралд оролцож байсан МАХН-ын ТХ-ны бүгд хурлын гишүүд энгийн хүмүүсээс маш их захиа, аман захиас авсан байдаг юм билээ. Энэ бүгд хурлаар “Ю.Цэдэнбалыг зайлуулах нь зүйтэй!” гэсэн утгатай захиа шүү дээ. Бүгд хуралд орсон хүмүүсийн ихэнх нь хоёр бодолтой байсан байх. Ю.Цэдэнбалын асуудал шийдэгвэл, эсвэл Ю.Цэдэнбал хэвээрээ үлдвэл гэсэн хоёр бодолтой байсан байх. Гэтэл Ю.Цэдэнбал хурлыг урьдаас сайн зохион байгуулсан тул хурлын уур амьсгалыг өөртөө ашигтайгаар эргүүлж чадсан юм. Хурал дээр үг хэлэх хүсэлтэй хүн маш олон байсан боловч Ю.Цэдэнбал тэдэнд боломж олгоогүй юм. Ю.Цэдэнбал зөвхөн өөрийгөө хамгаалагч нарт л үг хэлэх боломж олгосон юм.

Үг хэлэх хүмүүсийн нэрсийн жагсаалтанд миний нэр арван хоёрт, Лоохуузын нэр арван есөд, Сурмаажавын нэр долоо дээр бичигдсэн байсан юм. Санжийн Батаа, Б.Дэжид гээд Ю.Цэдэнбалын хамгаалагч нарын нэр бол бидний өмнө, хойно бичигдсэн байсан юм. М.Даш, Ч.Пүрэвжав, Ц.Пунцагноров, С.Жалан-Аажав, Ц.Дүгэрсүрэн гээд

Ю.Цэдэнбалын хамгийн ойр дотны хүмүүс биднийг шүүмжлэж Ю.Цэдэнбалыг хамгаалсан юм. Тэд нар биднийг “Намын жанжин шугамыг эсэргүүцэгчид, Зөвлөлтийг үзэн ядагчид, Л.Цэнд, Д.Төмөр-Очир нарын зэрэг МАХН-ын эсрэг үйл ажиллагаа явууладаг дайсан этгээдүүдийн хань хамсаатнууд, улс төрийн наймаачид!” гэх мэтээр шүүмжилсэн юм. Би энэ хурал дээр хэлсэн үгийнхээ гол санааг доорхи байдлаар илэрхийлсэн юм.

-Эрх баригч намын хувьд МАХН-ын гол анхаарах зүйл бол манай улсын эдийн засаг байх ёстой. Гэтэл Ю.Цэдэнбал тэргүүтэй манай МАХН-ын удирдагчид зээлийн хөрөнгөөр социализм байгуулах тухай ярьдаг болоод удаж байна. Энэ эрүүл биш үзэл бодлыг нэн даруй таслан зогсоох хэрэгтэй байна.

-Одоо манай улс Зөвлөлт улсаас өөрийн хэрэгцээт бүх зүйлийг дуртай цагтаа зээлээр авчихаад, өөрсдөө зүгээр идэж суудаг улс болоход хүрсэн байна. Энэ байдал цаашид үргэлжилбэл улс, орон үлэмжийн аюултай байдалд ороход бэлэн болсон байна. Энэ байдалд Ю.Цэдэнбал дүгнэлт хийж чадахгүй байна.

-Өргөн хэрэглээний барааний үнийг байн байн, сэмхэн сэмхэн нэмж байгаа нь ард түмний амьдралыг үлэмж хэмжээгээр доройтуулахад хүргэж байна. Эргэн тойронд зөвхөн гачигдал, зовлон тоочсон яриа л сонсогдох боллоо. Ард түмний идэвхи санаачлага үлэмж хэмжээгээр уналаа. Ю.Цэдэнбал үүнд өчүүхэн ч санаа нь зовсон шинжгүй сууж байна.

-Ю.Цэдэнбал гадаадад дэлхийн ажилчны хөдөлгөөнд нэр хүнд олох гэж их хичээлээ. Гэвч өөрийн арчаагүй ялзарсан, хоцрогдсон байдлаараа гадаадад ямар ч нэр хүндгүй боллоо. Ю.Цэдэнбал Зөвлөлт-Монголын найрамдлыг хамгаалдаг, түүнийг ганц хөгжүүлэгч гэсэн ойлголтыг олон түмэнд төрүүлэхийг оролддог. Гэтэл энэ найрамдал Ю.Цэдэнбалгүйгээр харин зөв замдаа орох боломж байна.

-Ю.Цэдэнбал чухам хэн болоо вэ? Ю.Цэдэнбал бол МАХН-ын удирдагч биш, социализм байгуулж байгаа орчин үеийн Монголын ард түмний удирдагч биш, жижиг хөрөнгөтний дампуурсан бие төлөөлгч болсон байна. Би Ю.Цэдэнбалд хувийн дутагдлаа засахыг олон удаа хэлж байсан. Гэтэл энэ хүн засарсангүй. Тэр бүх талаараа дээд цэгтээ хүртэл ялзарсан этгээд болсноо харууллаа.

-Ю.Цэдэнбал бол зөвхөн нам улсын сахилга бат, ажлын хариуцлага алдсан хүн биш, харин улсын өмнө гэмт хэрэг үйлдсэн хүн мөн. Ю.Цэдэнбал хүмүүсийн гачигдал, эрэлт хүсэлтийг харж үздэг энэрэнгүй хүн болох гэж улсын хөрөнгийг хамаа намаагүй бүрэлгэн сүйтгэсээр байна.

-Ю.Цэдэнбал гэм дутагдлаа шударгаар хүлээж байсан тохиолдол

нэг ч байхгүй. Харин гэмээ нуун дарагдуулж, хар амиа хамгаалахын тулд хэнийг ч, хэзээ ч, ямар ч цөллөгт явуулахаас буцахаа байсан хүн. Л.Цэнд, Д.Төмөр-Очир нарын асуудлыг хэлэлцсэн МАХН-ын ТХ-ны бүгд хурлуудыг Ю.Цэдэнбал шууд удирдаж, хуйвалдааны журмаар бэлтгэж, тэднийг цөллөгт явуулсан байна. Нам бол хүмүүжүүлэгч байгууллага бөгөөд намын удирдагчид бол хүмүүжүүлэгчид байх ёстой. Гэтэл түүнд ийм шинж огтхон ч алга. Харин түүний оронд боловсон хүчнийг гэндүүлж байгаад ажлаас нь халдаг, цөлдөг маш халгаатай хүн болсон байна.

-Ю.Цэдэнбал нам, төрийн удирдлагад байсан цагт манай ажил сайжирч чадахгүй. Ю.Цэдэнбал хичнээн чармайсан ч, ямар ч арга хэрэгэллээ ч гэсэн манай ард түмний итгэл найдварыг дахин хүлээхээсээ өнгөрсөн.

-Ю.Цэдэнбал одоо энэ хурал дээр юу бодож суугааг би мэдэж байна. Тэр яавал энэ удаа өөрийн албан тушаалаа хадгалж үлдэх вэ? гэдгээ л бодож суугаа. Энэ хурлыг даваад гарчих юм бол дараагийн хурал болтол зай ч байна, лай ч байна гэж л бодож суугаа. Ю.Цэдэнбалыг МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн даргын ажлаас өөрчлөх асуудал ярих үед тэр МАХН, төрийн удирдлагад ажиллах хүн байхгүй байна гэж ичих ч үгүй хэлдэг хүн. Ю.Цэдэнбал шиг арчаагүй хүнийг буюу Ю.Цэдэнбалтай нийлж дүйх бузар явдалтныг манай намын дотроос олоход хэцүү байж болох юм. Харин МАХН, төрийн удирдлагад ажиллахад бэлтгэгдсэн, шалгарсан боловсон хүчин манай намд олноороо байна. МАХН-ын ТХ Ю.Цэдэнбалын энэ байдалд дүгнэлт хийж ард түмнийхээ хүсэл эрмэлзэлд тохирсон шийдвэр гаргах цаг нэгэнт болсон байна.

Миний хэлсэн үг бүрэн эхээрээ 2004 онд хэвлэгдэж гарсан шүү дээ. Та нар уншсан байх гэж би бодож байна. Би Ю.Цэдэнбалын талаар МАХН-ын ТХ-ны бүгд хурал дээр үүнээс өмнө хоёр удаа шүүмжлэл хэлсэн байсан юм. 1964 онд гурав дахь удаагаа шүүмжилсэн юм шүү дээ. Хамгийн анх удаа 1959 оны бүгд хурал дээр шүүмжилсэн юм. Дараа нь 1962 онд хоёр дахь удаагаа шүүмжилсэн юм. “Ю.Цэдэнбал танаас Монгол орны хувь заяа ихээхэн шалтгаалж байна шүү. Та өөрийн дутагдлууд, ажлын арга барилаа яаралтай засах хэрэгтэй байна. Ард түмэндээ ойртож, тэдний үгийг нь сонсох хэрэгтэй байна!” гэсэн санаагаар анх удаа шүүмжлэж байсан юм.

Би Ю.Цэдэнбалтай өөртэй нь олон удаа уулзаж байсан юм. Уулзах бүрээдээ л түүнд алдаа дутагдлуудынх нь талаар хэлдэг байсан юм. “Бид өөрийн Монгол улсынхаа эрх ашгийг нэгдүгээрт тавих хэрэгтэй байна. ЗХУ-ын эрх ашиг бий. Бас социалист орнуудын эрх ашиг бий. Энэ бүгдээс юуны өмнө Монгол улсын эрх ашгийг л бодох хэрэгтэй юм. Бид өөрийн орны эрх ашгийг умартаад, харин ЗХУ-ын эрх ашиг, социалист

лагерийн орнуудын нийтийн эрх ашгийг л нэгдүгээрт тавиад явах шиг байна шүү. Бид өөрсдөө өөрийн орны эрх ашгийн төлөө тэмцэх хэрэгтэй байна шүү. Бид нар хоёр том гүрний хооронд оршиж байна. Аль аль нь биднийг боломж л гарвал идэхийг бодож байгаа шүү дээ. Тийм учир аль алинтай нь тэгш харилцаатай л байх хэрэгтэй юм. Аль нэгийг нь ад үзээд байвал бидэнд өөрсдөд л муу нөлөөлөл болно. Аль алинтай нь эрх тэгш харилцаатай байвал бидэнд үр өгөөж нь их байна шүү дээ!” гээд л ярьдаг байлаа шүү дээ. “Таны хувийн үлгэр жишээ их муудаж байна шүү. Та хувийнхаа дутагдлуудыг яаралтай засах хэрэгтэй байна. Ялангуяа гэр бүлийн талаар их анхаарах хэрэгтэй байна. Намын удирдагч хүнд баймааргүй үйлдүүдийг их хийж байна. Намын гишүүд, удирдах ажил хийж байгаа хүмүүст их алаг цоог, ялгавартай хандаж байна. Ийм байдал гаргаж хэрхэвч байж болохгүй!” гээд л ярьдаг байлаа.

Ингээд 1964 оны бүгд хурал дээр түүнийг шүүмжилсэн явдал бол миний хэлсэн ярьсан зүйлүүдээс нэгийг нь ч тэр хүлээж аваагүй, өөрийн дутагдлуудыг засах талаар өчүүхэн ч чармайлт гаргаагүйтэй хобоотой юм. Би тэр үед “Энэ хүн огт засрахгүй юм байна!” гэсэн дүгнэлтийг хийсэн юм.

Түүний өмнө Д.Төмөр-Очир нэг удаа хурал дээр түүнд: “Ю.Цэдэнбал чи одоо болих хэрэгтэй. Хэрвээ чи энэ янзаараа зүүгдээд, ажиллах ч биш, байх ч биш байвал энэ улс оронд их балаг тарина шүү. Чи ажилд их саад болж байна. Одоо хор хохирол бага байгаа дээрээ чи энэ ажлаа өөр хүнд шилжүүлэх хэрэгтэй!” гэж шууд хэлж байсан юм.

Тэр өөрийнхөө талаар бидний хэлж байсан үгнүүдийг хүлээж авч чадахгүй нэг шалтгаантай байсан юм. Түүнийг нь ч бид нар сайн мэдэж байсан юм л даа. Энэ бол түүний орос эхнэр нь шүү дээ. Тэр өөрөө энэ орос “авгай”-н гарт орчихсон хүн байлаа шүү дээ. Ер нь эхнэртээ захируулсан эр хүнийг чинь ямар эр хүн гэж хэлэх юм бэ? Монголд ийм хүнийг “хүүхэд, нохойн доог болсон хүн!” гэдэг юм. Ю.Цэдэнбалын хувийн амьдрал нь ийм “хүүхэд, нохойн доог болсон!” байхад тэр “Монголын төрийн хэргийг удирдана!” гээд зүтгээд байсан юм шүү дээ. Энэ орос эхнэр бол ЗХУ-ын Улсыг Аюулаас Хамгаалах Хороотой холбоотой байсан гэдэг нь ойлгомжтой. Тэр “авгай”-тай Ю.Цэдэнбал гэрлэсэн явдал ч ЗХУ-ын Улсыг Аюулаас Хамгаалах Хорооноос зохион байгуулсан ажил шүү дээ.

И Л: Тэр хурал дээр таны хэлсэн үгэнд “Ю.Цэдэнбал хүмүүсийг өөртөө татахын тулд башир арга хэрэглэдэг, хээл хахууль өгдөг!” гэсэн үг байсан шүү дээ. Ийм явдал үнэхээр байсан юм уу?

Б Н: МАХН болон Монгол улсын хэрэг явдлыг удирдах чадал чансаа

үнэндээ Ю.Цэдэнбалд байгаагүй юм. Монголчуудын дунд нэг үг байдаг юм. “Санаа байвч, сачий нь хүрэхгүй!” гэсэн үг юм л даа. Ю.Цэдэнбал МАХН болон улсын өмнө тулгарч байгаа ажлыг хичээгээд, хийхийг бүх чадлаараа чармайж байсан ч түүнд тийм ажлуудыг удирдах чадал нь хүрэхгүй байсан юм. Тийм учраас аар саар зүйлээр хөөцөлдөн будилж мунгинасан, бусдын амыг харж аялдан дагасан, хэрэг болохуйц үг ч хэлж чадахаа байсан арчаагүй хүн болж хувирсан юм. Ю.Цэдэнбал өөрийгээ хамгийн хоцрогдсон хүмүүсээр хүрээлүүлж, МАХН болон улсын эрх ашгийг үлэмж ихээр хохируулж байсан юм. Тэд нар нь найзархаг, нөхөрсөг юм шиг мөртлөө атаа жөтөө, хов живтэй, бие биенийгээ далдуур муулж явдаг хүмүүс байсан юм. Хавтгайрсан архидалт зохион байгуулдаг, мөрийтэй тоглодог, албан тасалгаандаа шалиглаж, завхайрдаг, олон түмний нүдэн дээр “хөгөө хөлдөө чирсэн” үйлдлийг өдөр тутам гаргадаг хүмүүс байсан юм. МАХН болон төрийн өндөр алба хашиж байсан 10 хүрэхгүй хүнд Ю.Цэдэнбал өөрөө шууд “нэмэгдэл мөнгө” нэртэй давхар нууц цалинг сар дугам сэмхэн өгч байсан юм. Тэд нарт улсаас албан ёсоор маш өндөр хангамж тогтоож өгсөн байлаа шүү дээ. Энэ “нэмэгдэл мөнгө” бол тэдний үндсэн цалин, улсаас авч байсан бусад хангамжаас гадуур өгч байсан мөнгө юм шүү дээ. Ю.Цэдэнбал заримыг нь одон медалаар шагнаана. Улс, эх орон, ард түмэнд харагдаж танигдахаар ямар ч ажил хийгээгүй байхад одон медалаар шагнаад л сууж байдаг байлаа шүү дээ. Улс төрийн туршлагагүй хүмүүсийг өндөр албан тушаалд томилоод, өндөр хангамж өгнө. Гадаадын үнэтэй амралт сувилалын газарт явуулна. Энэ мэтээр өөрийгөө хамгаалагч нарыг бэлтгэдэг байлаа шүү дээ.

Д.Төмөр-Очир зэрэг хүмүүс “нэмэгдэл мөнгө” олгохыг их эсэргүүцэж байсан юм. Би энэ талаар Ю.Цэдэнбалд хувиараа хэд хэдэн удаа хэлсэн юм. Гэтэл тэр “МАХН-ын удирдлагад ажиллаж байгаа хүмүүст ийм “урамшил” олгож байх ёстой юм. Ийм явдал зөвхөн манай намын дотор байгаа юм биш. Бусад орны намын удирдлагад байдаг үзэгдэл юм шүү дээ! Энэ мөнгийг намын удирдлагыг эв нэгдэлтэй байлгахын төлөө өгч байгаа юм!” гэж улаан цайм хэлдэг байсан юм. Өөрөөр хэлбэл тэдний “эв нэгдэл” гэгчийг мөнгөөр худалдан авч байгаа юм байж. Мөнгийг нь авсан хүмүүс түүний өмнөөс үг хэлэхгүй, түүний алдаатай буруу үйлдлүүдийг шүүмжлэх ёсгүй юм байж л дээ. Нэг удаа “нэмэгдэл мөнгө” олгох явдлыг болиулах талаар МАХН-ын ТХ-ны УТТ-ны хурлаар авч хэлэлцэхээр тогтоод, тэр хурлаас гаргах нэг тогтоолын төсөл буй болсон юм. Өөрөөр хэлбэл “намын эв нэгдлийг хангахын тулд нэмэгдэл мөнгө өгдөг явдлыг зогсоох” тогтоолын төсөл шүү дээ. Тэр тогтоолын төсөлтэй УТТ-ны гишүүд танилцаад, бүгд зөвшөөрөөд, гарынхаа үсгийг зурсан юм. Гэтэл Ю.Цэдэнбал ганцаараа гарын үсэг зураагүй юм. Тэр өөрөө гарын үсэг

зурахгүй бол ямар ч тогтоол гарч чадахгүй шүү дээ. Ингэж тэр тогтоол гараагүй юм.

Тэр үед дугтуйнд хийсэн мөнгө Ю.Цэдэнбалаас авах явдал түгээмэл үзэгдэл болсон юм шүү дээ. Тэр үед МАХН-ын удирдлагад ажиллаж байсан хүмүүс, тэдний гэр бүлийнхэн гадаадад явж амрахад зардлыг нь улс төлдөг байв. Ю.Цэдэнбал дарга өөрөө бол 7-р сарын дундуур, наадам өнгөрөөд ЗХУ-д очиж амардаг байв. Жил бүр ингэж явдаг байлаа шүү дээ. Ингэж яваад 10 сар, заримдаа 11 сарын үед л эргэж ирдэг байв. Бүх зардлыг нь улс төлдөг байлаа. МАХН-ын УТГ-ны бусад гишүүд, нарийн бичгийн дарга нар, СнЗ-ийн дарга, орлогчид бас явна. Тэд нар амралтын хугацаа дуусаад л эргээд ирдэг байсан юм. Харин зардлыг нь бол мөн ижил улс төлдөг байсан юм.

И Л: Та “Ю.Цэдэнбал гуай бол хувийн харьцаан дээр бол их зөөлөн хүн шүү дээ!” гэж хэлж байсан шүү дээ. Та энэ талаар жаахан тодруулж ярина уу?

Б Н: Тийм. Ю.Цэдэнбал бол хувийн харьцаан дээр бол тийм их хатуу хахир хүн биш юм шүү дээ. Хувь хүний тухайд бол их сайхан хүн юм шүү дээ. Их зөөлөн зантай, уур уцаар багатай хүн юм. Харин ажлын арга барил, хувийн дутагдал нь л тэр хүнийг аргагүй шүүмжлэлд хүргээд байсан юм л даа. Шүүмжлэхээс ч өөр арга байгаагүй юм. ЗХУ-ын эрх ашгийг хэтэрхий хамгаалдаг, өөрийн орны эрх ашгийг хамгаалж чаддаггүй, орос авгайн гарт орсон, өөрийн төрсөн нутаг, Монголын газар нутгийн нэг хэсгийг ЗХУ-д найр тавин өгсөн зэрэг олон олон буруу ажлуудыг тэр өөрөө хийж байсан юм. Энэ талаар үг хэлсэн, эх орныхоо хувь заяанд санаа зовж, түүний буруу үйл ажиллагааг шүүмжилсэн хүмүүсийг хайр найргүй залхаан цээрлүүлж байсан зэрэг нь ийм байдалд түүнийг оруулсан юм.

13 Шүүмжлэлийн хариу.

И Л: Та нарыг яагаад “намын эсрэг бүлэг” гэж нэрлэсэн юм бэ?

Б Н: “Намын эсрэг бүлэг” гэж ерөөсөө байгаагүй юм шүү дээ. Гэхдээ МАХН-ын бүгд хурлын дараа “Үнэн” сонинд хэвлэгдсэн “МАХН-ын ТХ-ны 6-р бүгд хурлын тогтоол” гэгчид биднийг “намын эсрэг бүлэг” гэж нэрлэсэн юм. Тэр “тогтоол” гэгч бол МАХН-ын ТХ-ны 6-р бүгд хурлаас баталсан тогтоол биш юм. Уг нь бол МАХН-ын ТХ-ны бүгд хурлаас гаргах тогтоолын төслийг бүгд хурлын гишүүдэд танилцуулдаг журамтай

байсан юм. Бүгд хурлын гишүүд тэр төсөлтэй танилцаад уг тогтоолыг гаргаж болох эсэх талаар саналаа хэлдэг юм. Тэгээд санал хураалтаар тогтоолын төслийг баталдаг журамтай байсан юм. Гэтэл тэр бүгд хурал тарахаас өмнө бидэнд ямар ч тогтоолын төсөл танилцуулаагүй юм. Бүгд хурлын гишүүд ямар ч тогтоолын төсөл хэлэлцэж, түүнийг батлах талаар санал өгөөгүй юм шүү дээ.

Ю.Цэдэнбалыг шүүмжилсэн Ц.Лоохууз бид хоёртой холбоотой хоёр асуудал тэр бүгд хурал дээр хэлэлцсэн юм. Нэгд нь Ц.Лоохууз бид хоёрыг МАХН-ын гишүүнээс хөөх, хоёрт нь бид нараар ЗХУ-д суралцсан хугацааныхаа зардлыг төлүүлэх асуудал байсан юм. Энэ хоёр асуудлаар бүгд хурлын гишүүд саналаа өгсөн юм. Бидэнтэй холбоотой өөр ямар ч асуудлаар бүгд хурлын гишүүд санал хураалтад оролцоогүй юм.

Тэр бүгд хурал 1964 оны 12-р сарын 21-ний өглөөний 9 цагт ажлаа эхлээд 12-р сарын 22-ны өглөөний 6 цагт ажлаа дуусгасан юм. Бид нар шөнжин хуралдсан юм. Гэтэл бүгд хурал тарснаас хойш 4 хоногийн дараа “Үнэн” сонин дээр “Бүгд хурлын гишүүд санал нэгтэй батлав” гэсэн тодотголтой “МАХН-ын ТХ-ны 6-р бүгд хурлын тогтоол” гэгч гарч ирсэн юм. Энэ бол бүгд хурлын нэрээр гаргасан хуурамч “тогтоол” юм. МАХН-ын дүрмээр бол хүчин төгөлдөр тогтоол биш юм л даа. Бүгд хурлын гишүүдэд бүгд хурлаас гаргах тогтоолын төслийг танилцуулахгүйгээр тогтоол гаргана гэдэг бол МАХН-ын үйл ажиллагааны дүрмээр зөвшөөрөгдөөгүй үйлдэл юм.

Бүгд хурлын гишүүдийн нэрийг барьж тэдний нэрийн өмнөөс тогтоол гаргана гэдэг бол Ю.Цэдэнбалаас өөр хүн бол хэзээ ч, ямар ч тохиолдолд хийхгүй, хийж болохгүй, зөвшөөрөгдөөгүй үйлдэл юм л даа. Ийм улаан цайм шударга биш үйлдлийг намын удирдагч хүн гаргана гэдэг бол тэр нам үнэндээ дампуурч байгаагийн шинж юм. МАХН-ын дотор бол ийм ажлыг ганцхан Ю.Цэдэнбал л хийдэг байсан, тэр олон ч удаа ийм үйлдлийг хийж байсан юм. Тэр бол ийм муу юмандаа гаршсан хүн шүү дээ. Заримдаа түүний хийсэн ийм муу үйлдлүүдийг харахад, ийм муу аргуудыг олох ухаан түүний хаанаас нь гарч байна вэ? гэж бодогдмоор байдаг юм. Жирийн хийх ёстой ажил, амьдрал дээр бол түүнээс ямар ч арга, ухаан гардаггүй хүн шүү дээ. Муу юм болохоор хэний ч санаанд ормооргүй зүйлүүдийг санаад, сэдээд олчихсон байдаг юм. Ёстой гайхмаар хачин юм шүү.

Тэр үед бүгд хурлаас гаргах тогтоолын төслийг бүгд хурлын гишүүдэд танилцуулсан бол бүгд хурлын гишүүдээс олон янзын санал гарах байсан байх. Бүгд хурал тарснаас хойш “Үнэн” сонин дээр гарсан тэр “тогтоол” гэгч шиг юм ч арай гарахгүй байсан байж магадгүй. Ю.Цэдэнбал бүгд хурлын гишүүдээс айсандаа тэдний нэрийн өмнөөс, тэдэнд өөрсдөд нь

үзүүлэлгүйгээр бүгд хурал тарсны дараа, тэр хуурамч “тогтоол” гэгчээ гаргасан юм.

КЮ: Та бүгд хурлаас гарч ирэхдээ баривчлагдах байх гэж айсан уу?

Б Н: 1964 оны 12-р сарын 22-ны өглөөний 6 цагт МАХН-ын ТХ-ны 6-р бүгд хурал хуралдсан Төрийн ордны их танхимаас гарах хаалган дээр С.Рагчаа миний “МАХН-ын Бүгд хурлын гишүүний үнэмлэх”-ийг хурааж авлаа. “Дөнгөж гармагц баривчлах байх! Одоо энэ хаалганы цаана намайг баривчлаад, суулгаад авч явах Дотоод яамны машиныг тулгаад зогсоосон байгаа байх!” гэж бодоод хаалгаар гарлаа. Гэтэл тэнд ямар ч машин байсангүй. “Ямар ч байсан гэртээ харих юм байна!” гэж бодлоо.

Гэртээ ирээд сууж байтал, миний ах Арилдий “Шөнө Дотоод яам ачаад явсан байх гэж бодлоо шүү!” гэсээр орж ирлээ. Хамт ажиллаж байсан хүмүүс, найз нөхдөөс утас тасралтгүй ирж байлаа. Зарим нь манай гэрт ирцгээв. Тэд нар миний сэтгэлийг засах сайхан үг хэлж, гуниж гутрахгүй явахыг захиж байв. Би тэднийг “Та нар одоохон эндээс явцгаа! Эсэргүү Нямбуугийн хань хамсаатан болгочихно шүү!” гэсээр байгаад тэднийг явууллаа. Бүгд хурал тараагүй байхад зарим хүмүүс “Эд нарыг одоохон баривчилъя! Эд нар шүүхийн өмнө бөхийгээд сууж байхыг нь харъя!” гэж хэлж байсан юм шүү.

Бүгд хурлын явцад нэг том завсарлага болсон юм. Тэр завсарлагаанаар МАХН-ын ТХ-ны УТТ-ын товчооны гишүүд хуралдсан юм билээ. Энэ тухай Баянхонгор аймгийн дарга Я.Сүхбат гэдэг хүн надад ирж хэлсэн юм. “Сая УТТ-ны гишүүд хуралдлаа. Тэд нар та нарын асуудлыг ярьсан байна. Олон хүн та нарыг баривчлах санал гаргасан байна. Тэгээд Улсын прокурор Д.Ёндондүйчирыг дуудсан байна. Улсын прокурор Д.Ёндондүйчир та нарыг баривчлахаас татгалзсан байна. МАХН-ын ТХ-ны бүгд хурлын гишүүн хүн бүгд хурал дээрээ үг хэлж, шүүмжлэл хэлэх эрхтэй шүү дээ. Хэлсэн үг, шүүмжлэл нь бүх хүнд таалагдах ёстой биш шүү дээ. Эд нар эх орноосоо урвасан ч юм уу, өөр баривчлах үндэслэл болохоор үйлдэл хийгээгүй байна. Баривчилдаг юм аа гэж бодоход тэднийг ямар хуулиар шийтгэх юм бэ? гэж хэлээд тэр татгалзсан байна шүү!” гэж тэр надад сэмхэн хэлсэн юм.

Улсын прокурор Д.Ёндондүйчир, Дээд шүүхийн дарга Х.Дамдин, Дотоод яамны орлогч сайд Я.Гүнсэн нар бараг ижил бодолтой байсан юм билээ. Тэд нар Ю.Цэдэнбалд “Эд нарыг баривчлах хуулийн зүйл анги байхгүй байна! Эд нар гэмт хэрэг үйлдсэн гэдгийг нь нотлох баримт байвал баривчлах асуудлыг хэлэлцэж болох юм!” гэсэн утгатай хариу өгсөн юм билээ. Дотоод яамны сайд Б.Жамбалсүрэн бас биднийг

баривчилахаас татгалзсан байгаа юм. “Бидэнд хүнийг улс төрийн хилс хэргээр хэлмэгдүүлж байсан гашуун туршлага бий. МАХН-ын ТХ-ны бүгд хурал дээр шүүмжлэл хэлсэн хүнийг ямар үндэслэлээр баривчлах юм бэ? Шүүмжлэл нь буруу юу? Зөв үү? гэсэн асуудал бол байж болох юм!” гэсэн утгатай үг хэлсэн юм шиг байгаа юм.

Бүгд хурал тарснаас хойш бидний асуудлыг МАХН-ын ТХ-ны Хянан Шалгах Хороо (ХШХ) авч хэлэлцсэн юм. Бидний асуудлыг энд бараг хорь гаруй хоног хэлэлцсэн юм. Тэр ХШХ-ны хурал дээр би “Намайг малчнаар томилож байгаа юм байна. Би бол малчин хүний хүүхэд. Мал хариулж өссөн хүн. Би одоо мал хариулахад ямар ч бэрхшээл байхгүй. Гэхдээ нэг юмыг надад тодруулж хэлэх хэрэгтэй байна. Намайг малчингаар томилно гэдэг чинь шийтгэл юм уу? Яагаад намайг шийтгэж байгаа юм бэ? Намайг МАХН-ын гишүүнээс хөөсөн. Би бас шалтгааныг нь мэдээгүй! Энэ чинь МАХН-ын ТХ-ны бүгд хурлын гишүүн хүн МАХН-ын ТХ-ны бүгд хурал дээр намын удирдагчийн алдаа, түний хувийн дутагдлыг шүүмжилсний төлөө шийтгэж байгаа юм уу? Ю.Цэдэнбалын буруу ажиллагаа, хувийн дутагдлыг шүүмжилсний төлөө намайг шийтгэж байгаа бол би хүлээн зөвшөөрөхгүй!” гэж хэлсэн юм. Гэтэл ХШХ-ны дарга Р.Лувсанравдан “МАХН-ын бүгд хурал дээр шүүмжлэл хэлсэн гэж шийтгэж байгаа юм биш. Та тэгж бодож байгаа бол эндүүрч байна шүү. Өөр юм байж болно шүү дээ!” гэж байна. “Намайг шүүмжлэл хэллээ гэж шийтгээгүй юм байна. Тэгвэл тэр өөр юм аа хэлчих. Би түүнийг чинь өөрөө сонсоё. Тэр чинь үнэн байвал би буруугаа хүлээе! Шийтгүүлье! Би гэмт хэрэг хийсэн бол намайг шүүхэд шилжүүлэх хэрэгтэй. Би МАХН-ын ТХ-ны бүгд хурлын гишүүн хүний хувьд МАХН-ын ТХ-ны бүгд хурал дээр шүүмжлэл хэлсэн. Би МАХН болон ард түмнийхээ эсрэг үг хэлээгүй! Ю.Цэдэнбалыг бол шүүмжилсэн. Энэ үнэн! Миний шүүмжлэл бол маш зөв, шударга шүүмжлэл, улс оронд хэрэгтэй шүүмжлэл гэж би өөрөө үзэж байна! Үүнийг хэн ч үгүйсгэж чадахгүй!” гэж хэлсэн юм. Тэгтэл Лувсанравдан дуу гарч чаддаггүй. Бусад хүмүүс нь дуугарч чаддаггүй. Тэгж байгаад Лувсанравдан “Асуудлыг та тэгж тавьж байгаа бол таныг шүүхэд шилжүүлж болно шүү!” гэж байна. Тэхээр нь би “Тэгвэл би шүүхэд очиж учраа олно!” гэж хэлээд тэр хурлаас гараад явчихсан юм. Тэр хурлаас гараад гэртээ шууд ирлээ.

Манай гэрт миний ээж, ах, дүү зэрэг хүмүүс ирчихсэн намайг хүлээгээд сууцгааж байна. Тэд нар намайг баривчлагдаагүй эргээд ирсэнд их баярлаж байна. Тэгээд би “МАХН-ын ТХ намайг Дорнод аймгийн Эрэнцавын Сангийн аж ахуй (САА)-д малчнаар томилсон байна! Харин би зад эсэргүүцээд, тэр хурал шиг юмыг нь хаячихаад гараад ирлээ!” гэж тэдэнд хэлэв. Тэд нар намайг баривчлагдаагүйд бөөн баяр болж

байна. Тэгснээ “Юуны чинь зад эсэргүүцэх вэ? Одоохон Дорнод аймаг явцгаая!” гэж байна. Манай ах их ууртай “Чи баривчлагдаагүй чинь л болсон байна. Одоохон Эрэнцав руу явж малаа хариул! Дотоод яам нэг л өдөр баривчилчихна шүү дээ!” гэж байна. Тэд нар намайг Дотоод яам баривчилчихна гээд айгаад байсан юм шүү дээ. Тэр өдрөөс хойш би гэртээ хийх юмгүй боллоо. Тэгээд л ном уншаад л суугаад байдаг боллоо. Гэтэл нэг өдөр манай ах бас л их ууртай “Чи мөн дүүрчихсэн хүн шүү! Ийм үед ном уншаад чи юуг нь ойлгодог юм бэ? Ингэж байхын оронд явах бэлтгэлээ хийгээд, хурдан явах газраа явах хэрэгтэй шүү дээ!” гэж байна. Би түүний үгийг тоосон ч үгүй. Гэтэл тэр нэг том үстэй дээл, нэг том эсгий гутал авч ирээд манайд тавьчихлаа. Түүнийг “Дотоод яам баривчилсан үед өмсөөрэй!” гэж байна.

Миний нас дөнгөж дөч шүргэж л байлаа шүү дээ. Залуухан ч байж, халуухан ч байж дээ. Гэртээ ном уншиж сууж байгаад гадагшаа гарахад манай гэрийн орчмоор Дотоод яамны тагнуулууд бужигнаж байдаг байж билээ. Намайг хэнтэй уулзах нь вэ? Юу хийх нь вэ? гээд л тагнаад байсан юм байлгүй дээ. Миний араас дагаад л явцгаана. Би ч тоохгүй л яваад байна. Заримдаа тэднээр баахан даажигнана л даа. Тэд намайг тагнаж байна гэдгийг бол би сайн мэдэж байна. Би тэднийг таниж байгааг тэд нар мэдэхгүй л дээ. Өөрсдийгээ анзаараагүй л гэж боддог байлгүй. Миний хойноос дагаад л яваад байна. Тэгэхээр нь би гэнэт зогсоод, эргээд тэдний эгц өөдөөс нь яваад хажуугаар нь яваад өнгөрнө шүү дээ.

Манай байрны урд талд гурван давхар нэг байшин байсан юм. Тэр байшингийн нэг өрөөнд нь намайг тагнах зорилготой зургаан хүнтэй “тагнуулын групп” байрлуулсан юм байж л дээ. Би гэрийнхээ цонхоор тэд нарыг байнга ажигладаг боллоо. Өглөө болгон л тэдний ээлж нь солигдож, шинэ хүмүүс ирж байгаа нь харагдана шүү дээ. Бас тийш нь ямар нэгэн техник хэрэгсэл оруулж байгаа нь харагдана. Тэгээд нэг өдөр өөрийн гэрийнхээ нэг хүнд тэр байшингийн хаалгыг нь зааж өгөөд “Одоо би гэрээсээ гараад явна. Тэр байшингаас хэдэн хүн миний араас гарч ирэхийг хараад байгаарай!” гэж хэлээд өөрөө гэрээсээ гараад явлаа. Манай байшинд нэг арк байсан юм. Би дөнгөж тэр арканд оронгуутаа зогсоод, эргээд тэр хаалга руу байшингийнхаа булангаар нуугдаад харлаа. Нөгөө байшингаас зургаан хүн гарч ирээд миний хойноос гүйж байна. Би тэдэнд харагдахгүй аркан дотроо зогсоод л байлаа. Гэтэл тэд нар намайг харалгүй хажуугаар гүйлдэж байна. Нэг нь харчихаад зог тусаж байна. Тэгээд би тэдний хажуугаар гараад шууд Дотоод яам руу явлаа. Араас тэд нар дагаад явж л байна.

Тэнд очоод Дотоод яамны сайд Б.Жамбалсүрэнгэй уулзах зорилготой ирснээ хэллээ. Сайд Б.Жамбалсүрэн намайг хүлээж авах эсэх нь

мэдэгдэхгүй нилээд удлаа. Тэгж байгаад дотогш орох зөвшөөрөл ирлээ. Би Б.Жамбалсүрэнг нилээд сайн таньдаг байсан юм. Би Өмнөговь аймгийн МАХН-ын хорооны нэгдүгээр нарийн бичгийн даргаар томилогдоод явахдаа Улаанбаатар хотын МАХН-ын хорооны үзэл суртал хариуцсан нарийн бичгийн даргын ажлаа түүнд хүлээлгэж өгч байсан юм. Намайг түүний өрөөнд ороход тэнд түүнтэй хамт орлогч сайд Я.Гүнсэн байлаа. Би түүнд шууд:

-Та нар намайг тагнах санаатай юм уу? Тэгвэл ингэж тагнадаггүй юм. Та нарт намайг тагнах зайлшгүй шаардлага байгаа юм бол тэр хүмүүсээ манай гэрт оруулаад л суулгачихсан нь дээр биш үү? Би та нарт хэрэгтэй мэдээллүүдийг тэдэнд чинь хэлж өгөөд явуулж байж чадна шүү!” гэж ширүүхэн хэллээ.

Гэтэл Б.Жамбалсүрэн, Я.Гүнсэн хоёр зэрэг, зэрэг:

-Бид нар чамайг тагнаагүй шүү дээ! гэсэн утгатай юм хэлж байна.

-Та нар намайг тагнаагүй юм уу? Тэгвэл ямар хүмүүс намайг тагнаад байгааг тогтоогоод өг! Намайг өдөр шөнөгүй хэсэг хүмүүс тагнаад байна. Хэн тагнаж байгааг та нар тогтоож өгөх үүрэгтэй шүү дээ! гэж хэллээ.

Гэтэл Жамбалсүрэн:

-Чамайг тагнаж байгаа хүн үнэхээр байгаа ч юм уу? Үгүй ч юм уу? Бид яаж мэдэх вэ? Чи зүгээр л намайг тагналаа гэж хардаж байгаа байх л даа. Чи бол хэзээний манай яаманд дургүй хүн шүү дээ. Би үүнийг сайн мэднэ! гэж байна.

Тэгж хэлэхээр миний ч уур нилээд хүрч байна. Тэгээд:

-Тэгж байгаа бол намайг тагнаад байгаа танай тэр ажилтнуудыг чинь би та нарт заагаад өгье! гэлээ. Тэгтэл тэр:

-Бидэнд чамайг дагаад гудамжаар явж байх зав алга! Чи л тэд нарынхаа учрыг өөрөө олно биз! гэж байна шүү .

-Жамбалсүрэн, чи хэзээ энэ яаманд дуртай болчихсон юм бэ? Бид нар намын ажил хийж байхад, чи бид нар юу гэж ярьдаг байлаа? Чи Дотоод яаманд ирээд түүнийгээ мартчихаа юу? Чиний ухаан тийм богинохон юм бол би чамд чиний өөрийн чинь ярьсан яриануудыг сар, өдөртэй нь сануулаад өгч чадна шүү! Чи бидний тэр үед ярьдаг байснаас өөр зүйлийг би яриагүй. Харин ярьсан газар нь өөр байж болно. Би Ю.Цэдэнбалыг тэр яриануудаас илүү гарч шүүмжлээгүйг чи мэдэж байгаа. Би МАХН, Монгол улсын эсрэг юм яриагүй! гэж түүнд хэллээ. Тэгсэн чинь тэр таг дуугүй болчихлоо.

Орлогч сайд Д.Гүнсэн бидний яриаг чагнаад жуумалзаад сууж байна. Ингээд би тэндээс гараад, Дотоод яамны тагнуулчдаа дагуулаад гэртээ харилаа. Ер нь Дотоод яам биднийг тагнах ажлаа огт зогсоогоогүй юм. Намайг хөдөө яван явтал тагнасан. Бас хөдөө тэр тагнуулууд нь ажиллаж

байсан юм.

Түүнээс гадна МАХН-ын 6-р бүгд хурал тарсан тэр өдрөөс эхлээд л Ц.Лоохууз, Б.Нямбуу нарын “намын эсрэг бүлэг”-ийнхний тухай хэвлэл, мэдээллийн бүх хэрэгслүүдээр өдөр, шөнөгүй муу хэлж байсан юм. Тэр хэвлэл дээр гарсан зүйлүүдийг би бараг уншдаггүй, радиогоор ярьсан зүйлүүдийг бараг чагнадаггүй байлаа. “Тэнд үнэн юм байхгүй!” гэдгийг нь мэдэж байсан юм. Ерөөсөө тоодоггүй байлаа. Бүх эрх мэдэл МАХН-д байсан болохоор тийм худал, хуурмаг зүйлийг хийх нь хэнд ч ойлгомжтой шүү дээ. Бидний ярьсан зүйл бүү хэл улсынхаа түүхийг хүртэл гуйвуулаад биччихдэг шүү дээ. Ард түмэн тийм суртал ухуулгыг бүр ойлгодог болчихсон, огт итгэдэггүй болчихсон байлаа шүү дээ. Манайхны дотор “Радио шиг чалчиж байна!” гэсэн нэг үг байдаг юм. Энэ бол худлаа суртал ухуулга хийсээр байгаад түүнд нь хүмүүс итгэхээ байсныг илэрхийлсэн үг юм.

МАХН-ын 6-р бүгд хурал тармагц их, дээд сургууль, төрийн болон олон нийтийн байгууллагууд сэхээтнүүдийн дунд “намын эсрэг бүлэг”-ийн хань хамсаатнууд, талархан дэмжигчдийг илрүүлэх их ажиллагаа эхэлсэн юм. Энэ ажлыг Н.Лувсанравдан тэргүүтэй МАХН-ын ТХ-ны Хянан Шалгах Хороо, Дотоод яам Ю.Цэдэнбалын шууд удирдлагын доор хийж гүйцэтгэж байсан юм. Москвад ЗХУКН-ын дээд сургуульд надтай хамт суралцаж байсан хүмүүс дотроос “эсэргүү” Нямбуугийн хань хамсаатныг илрүүлэх ажлын хэсэг очсон юм. Тэднийг Б.Ламжав, Ж.Жамъян, Г.Иш нар толгойлж байв. Тэд нар Б.Нямбуутай хамт сурч байсан хүмүүс бүгд мөнгө нийлүүлж Нямбууд цаг бэлэглэж байсан, Нямбуугийн эхнэр хүүхэд Монгол руу буцахад төмөр замын билет авч өгсөн, Москвагийн төмөр замын өртөөн дээр тэднийг үдэж гаргаж өгсөн зэрэг “хэрэг”-ийг илрүүлснээ сүр дуулиантайгаар зарлаж байсан юм. Тэд нар “Эсэргүү Нямбуугийн хань хамсаатнууд улс орныхоо хөгжлийг чамлаж голдог, ард түмний амьдрал муу, ядуурч доройтсон мэтээр чалчдаг, “Америкийн дуу хоолой” радиогийн нэвтрүүлгийг тогтомог чагнадаг!” зэрэг “хэрэг”-үүдийг илрүүлснээ зарлаж байлаа. Ийм “хэрэг”-үүдээ үндэслэл болгоод ЗХУКН-ын дээд сургуульд надтай хамт сурч байсан хүмүүсийг сургуулиас нь хөөсөн юм.

МАХН-ын 6-р бүгд хурал дээр зарим хүмүүс “ЗХУКН-ын дээд сургуульд сурч байгаа оюутнууд бүгд Б.Нямбуугийн хань хамсаатан нь юм байна. Тэд бүгдээрээ Б. Нямбуу шиг үзэл бодолтой хүмүүс юм. Өөрсдийгөө төлөөлүүлж Б.Нямбууг нааш явуулсан байна!” гэсэн утгатай шүүмжлэл хэлж байсан юм.

Миний сайн таньдаг танил маань намайг Уланбаатар руу МАХН-ын 6-р бүгд хуралд оролцохоор явах үед Хар далайд амрахаар явсан

юм. Гэтэл түүнийг эргээд ирэх үед нь нөгөө “Эсэргүү Нямбуугийн хань хамсаатныг илрүүлэх ажлын хэсэг” Москвад ирсэн байж л дээ. Тэгээд тэд нар түүнээс “Та тэр үед яах байсан бэ? Нямбууд бас цаг авч бэлэглэх байсан уу?” гэсэн асуулт тавьсан юм билээ. Гэтэл өнөө нөхөр чинь “Өө, тэгэлгүй яахав ээ. Бусад нөхдүүд маань юу хийнэ би бас тэдэнтэй л адилхан байх байсан шүү дээ!” гэсэн утгатай үг хэлсэн байдаг юм. Тэгж хэлснийх нь төлөө түүнийг бас сургуулиас нь хөөсөн байдаг юм. Бас нэг нөхөр дуу дуулаад хөөгдсөн байдаг юм. Дуулсан дуу нь монгол ардын дуу юм л даа. Их түгээмэл дуу юм. Тэр дуунд:

Хадны завсар хавчуулагдсан

Халиуны зулзага хөөрхий еэ хөө

гэсэн үг байдаг юм. Тэр нөхөр энэ дуугаа дуулах үедээ жаахан архи уусан, халамцуу байсан юм билээ. Гэтэл түүнийг дуудаад байцаасан байна л даа. “Чи ямар санаатай ийм дуу дуулсан бэ? Тэр хадны завсар хавчуулагдаад байгаа халиуны зулзага чинь хэн юм бэ?”, “Тэр хавчаад байгаа хад чинь хэн юм бэ?” гээд л байцаасан байдаг юм. Тэгээд л түүнийг сургуулиас нь хөөсөн байдаг юм.

14 МАХН-ын ТХ-ны томилолтоор ирсэн малчин.

Б Н: Хөдөө намайг очиход хүмүүс шал өөрөөр хүлээж авсан юм шүү. Манай эхнэр чинь эмч хүн шүү дээ. Тэр Москвад ординатурт суралцаж байсан юм. Бид нар Москвад хамт амьдарч байсан юм. Манай гурван хүүхэд их нялх байсан даа. Намайг Дорнод аймгийн Эрээнцавын САА-д үхэрчингээр явахад түүнийг МАХН-ын ХШХ бас дуудаж ирүүлсэн юм. Тэгээд бид хамт явсан юм. Дорнод аймгийн Эрүүлийг хамгаалах газар манай эхнэрийг Эрээнцавын САА-н эмнэлэгт их эмчээр томилсон юм. Эрээнцавын САА-н эмнэлэг нь их эмчгүй юм байж л дээ. Тэгтэл манайхыг Эрээнцавын САА-д нүүж ирэхэд, олон хүн цуглачихсан, манай гэрийг барьж өгөөд, зарим нь хонины мах, цайны сүү авч ирсэн байж билээ. Уг нь хүмүүс “Б.Нямбуу ганцаараа ирнэ!” гэж л бодож байсан юм шиг байгаа юм. Намайг эхнэр хүүхдүүдээ дагуулаад ирэхэд хүмүүс их баяртай байсан юм. Ингэж манайх гэдэг айл Эрээнцавын САА-д ирээд, энд арван нэгэн жил амьдарсан юм даа.

Анх малчин болох томилолттой очсон юм. Тэнд очоод нэг айлын туслах хоньчин боллоо. Миний хонь хариулах суурь бол сумын төвөөс холгүй байв. Эхнэр САА-н эмнэлэгт эмчийн ажилдаа орсон тул манайх гэрээ эхний үед сумын төвд барихаар шийдэв. Гэр сумын төв дээр байгаа тул би хонио хариулахаар суурь дээрээ ирээд, суурийн ахлагчийн гэрт хонодог байв. Тэгээд хонь хариулах ээлжгүй өдөр сумын төвд байгаа

гэртээ буцаад ирдэг байв. Ийм маягаар амьдарч байтал, хол газар хүний бие муудсан дуудлага манай эхнэрт их олон ирдэг боллоо. Тийм үед эхнэр маань тэр хүний биеийг үзэхээр явах шаардлага гарч ирдэг боллоо. Ингэж явах үед хүүхдүүдээ яах билээ? гэдэг асуудал гарч ирэв. Тэр үед манай хүүхдүүд их бага настай байв. Эхлээд яаж ийгээд эвийг нь олж зохицуулах гэж оролдлоо. Гэвч ерөөсөө болохгүй байлаа. Эрэнцавы САА-н эмнэлэгт манай эхнэрээс өөр эмч байгаагүй юм шүү дээ. Ингээд энэ байдлын тухай би МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбалд захиа бичлээ. Түүнд “Намайг сумын төвд суух зөвшөөрөл өгөөч!” гэсэн хүсэлт тавьсан юм. Ю.Цэдэнбал миний хүсэлтийг хүлээж аваад намайг сумын төвд суухыг зөвшөөрсөн хариу өгсөн юм. Энэ хариу МАХН-ын ТХ-ны ХШХ-ны дарга С.Лувсанравдангаар дамжаад ирсэн байлаа. Ингээд би гурван сарын дараа туслах малчныхаа ажлаас чөлөөлөгдлөө. Ингээд сумын төв дээр ажил олж хийхээр боллоо.

Надад “300-400 төгрөгөөс илүү цалинтай ажил өгч болохгүй!” гэсэн Дотоод яамны даалгавар байсан юм билээ. Тийм хатуу даалгаврыг Дотоод яам орон нутгийн засаг захиргаанд өгдөг байсан юм байж. Тэгээд сумын захиргаа надад олигтой ажил өгч чадахгүй байсан юм.

Тэд нар надад аль болохоор туслахыг л боддог байсан юм шүү. Дотоод яамны зааврыг зөрчөөд надад сайн ажил өгвөл сумын захиргааны дарга нар өөрсдөө ажлаасаа халагдах аюултай байсан юм. Ингээд худгийн моторчин, сантехникийн засварчин, түлхүүр багажны нярав, бригадын тоо бүртгэгч, барилгын техникч, хадлангийн бригадын ахлагч зэрэг ажлуудыг хийж явлаа. Эрэнцавын САА-н дарга нэг удаа Дотоод яамнаас зөвшөөрөл авалгүй өөрөө мэдээд 600 төгрөгнөөс илүү цалинтай ажил надад өгсөн юм. Гэтэл энэ мэдээ Дотоод яамаар дамжаад МАХН-ын ТХ-ны ХШХ-нд хүрсэн юм байх. Тэндээс хүн ирээд миний байдлыг газар дээр нь шалгалаа.

Эрэнцавын САА-н дарга нь хүчирхэг буриад хүн байсан юм. Тэр: -Би Б.Нямбууд ийм ажил өгөхдөө түүний ажил хийх чадварыг нь харсан юм. Б.Нямбуугаас өөр энэ ажлыг хийж чадах хүн манай САА-д байхгүй. Хэрвээ та энэ ажлыг сайн хийж чадах хүн надад өгөх юм бол би Б.Нямбууг ажлаас нь халахад бэлэн байна! гэж хэлсэн юм билээ. Манай буриадууд ч өөрсдийнхээ үзэл бодлыг хамгаалахдаа ч сайн шүү дээ. Бууж өгнө гэж бол ердөө байдаггүй юм. Заримдаа жаахан хэтэрдэг байж магадгүй. Тийм учир “буриадууд бол буруу ишилсэн сүх шиг зөрүүд!” гэсэн үг гарсан байх.

Намайг хөдөө очоод удаагүй байтал Москвад сурч байсан зардлаа төлөх нэхэмжлэл ирлээ. Энэ асуудлыг МАХН-ын ТХ-ны 6-р бүгд хурал дээр ярьсан шүү дээ. Би 24 мянган төгрөг төлөхөөр болсон байлаа. Тэр

үеийн төгрөгийн ханшаар бол энэ чинь маш их мөнгө юм шүү дээ. Миний авч байгаа цалингаар бол хэзээ ч төлж дуусахгүй мөнгө л дөө. Москвад суралцсан зардлыг төлөх асуудлыг шүүхийн журмаар шийдсэн юм. Дорнод аймагт шүүх хурал нь болов. Би тэр шүүх хурал дээр үг хэллээ. “Би Москвад суралцаж байсан. Би тэнд суралцах л үүрэгтэй очсон. Би үүргээ сайн биелүүлж байсан. Би их сайн сурч байсан. Би сургуулиа өөрөө орхиогүй! Миний суралцах явдлыг МАХН-ын ТХ-ноос хууль бусаар таслан зогсоосон. Би буруугүй! Тийм учир би энэ төлбөрийг төлөх явдлыг зөвшөөрөхгүй!” гэж хэлсэн юм. Гэтэл аймгийн шүүхээс Москвад сурч байсан зардлыг заавал төллүүлэх шийдвэр хүчээр гаргалаа. Би цалингаас өөр орлогогүй хүн шүү дээ. Тэгээд цалингаараа төлөхөөр боллоо. Миний туслах малчны сарын цалин бол нэг зуу орчим төгрөг байлаа л даа. Тэгээд тэр нэг зуун төгрөгнийхээ тавин төгрөгийг нь энэ өрөндөө өгөөд, тавин төгрөгөөр нь амьдрах хэрэгтэй боллоо. Би хэдэн жил тавин төгрөг төлөөд тэр өрийг төлж дуусгах вэ? Гэтэл Дорнод аймгийн шүүхээс тэр өрийг “6 сарын дотор төлж барагдуулах хэрэгтэй!” гэсэн шийдвэр ирлээ. Тэгээд манай гэрийн эд хөрөнгийг бас битүүмжилсэн юм. Надад тэр өрийг 6 сарын дотор төлж барагдуулах ямар ч боломж байхгүй шүү дээ. Энэ бол намайг хавчиж, дарамтлах зорилготой хийсэн үйлдэл юм л даа.

Миний амьдралд ийм хүндрэл үүссэн учир би Ю.Цэдэнбалд дахиад захиа бичихээр шийдлээ. “Би Москвад суралцсаны төлбөрийг төлнө. Гэхдээ Дорнод аймгийн шүүхийн шийдвэр дэндүү хатуу байна. Төлбөрийг удаан хугацаанд цалингаасаа суутгаж төлөх зөвшөөрөл олгож өгөөч!” гэсэн хүсэлтийг би түүнд тавьсан. Тэр үед манай хүүхдүүд сурлага сайтай, их сайн сурч байв. Гэвч сургуулийн захиргааны зүгээс хүүхдүүдийг хавчиж, дарамтлах хандлага гаргаад байв. “Эсэргүү Б.Нямбуугийн хүүхэд!” гээд бусад хүүхдүүдээс өөрөөр хандаж байлаа. Энэ асуудлыг зохицуулж өгөхийг би Ю.Цэдэнбалаас хүссэн юм.

Тэгээд удалгүй миний амьдралд үүссэн эдгээр хүндрэлтэй асуудлуудыг газар дээр нь шийдвэрлэхээр МАХН-ын ТХ-ны ХШХ-ноос нэг хүн ирлээ. Түүнийг Донойн Пүрэв гэдэг юм. Тэр хүн бол нэг хэсэг Шүүх яамны сайд байсан хүн л дээ.

Тэр хүн ирээд:

-Таны бичсэ захиаг МАХН-ын ТХ-ны ХШХ-н дээр бид нар судлаж үзсэн. Өрийг төлж барагдуулахад хугацаанд хавчигдах ёсгүй юм шүү. Та энэ өрийг удаан хугацаанд цалингаасаа суутгах замаар төлж болно. Хүүхдүүдийг сургуулийн захиргааны шугамаар дарамтлах явдлыг ердөө гаргаж болохгүй. Та бол жирийн иргэн хүн шиг л байх ёстой! гэсэн үг хэлсэн юм. Тэр энэ үгээ бас Дорнод аймгийн удирдах хүмүүст хэлсэн байх. Тэр үед Дорнод аймгийн удирдлага надад их муу хандаж байсан юм. Тэд

нар ямар нэгэн шалтаг олоод, намайг байнга дарамтлах хандлага гаргаж байсан юм. Энэ үеэс эхлээд миний байдал арай дээр болсон юм шүү.

И Л: Та Шарын голд хэзээ ирсэн юм бэ?

Б Н: Би тэнд 1976 онд ирсэн юм. Тэр үед би МАХН-ын ТХ-нд бас нэг захиа өргөдөл бичсэн юм. 1964 оны 12-р сард хуралдсан МАХН-ын ТХ-ны 6-р бүгд хурал хуралдахын өмнө хурлын бэлтгэл ажил хэрхэн явагдаж байгаа талаар би хэд хэдэн хүнээс захиа авсан юм. Өөрөөр хэлбэл бүгд хурал дээр бидний эсрэг ямар хүмүүс үг хэлэхээр бэлтгэж байгааг би яг мэдэж байсан юм. Энэ байдалд хурлыг зохион байгуулагчид их гайхсан байх. Тэгээд хурал тарсны дараа энэ хурлын зохион байгуулалтын талаар надад мэдээлэл өгсөн тэр хүнийг олох гэж их хичээсэн байх. Гэвч тэд нар олоогүй юм л даа. Харин надад мэдээлэл өгсөн хүмүүс өөр шалтгаанаар бүгд ажлаасаа халагдацгаасан юм.

1976 онд би дахиад өргөдөл бичлээ. Тэгтэл надад хариу маш хурдан ирсэн юм. Надад ирүүлсэн хариу бичигт Дотоод яамны сайд Бугын Дэжид гарын үсгээ зурсан байлаа. Тэр намайг Улаанбаатарт ирж уулзахыг хүссэн байна. Ингээд би Улаанбаатарт ирлээ. Тэр бид хоёрын уулзалт Дотоод яамны байшингийн урд талын олон давхар байшингийн гурван давхарт боллоо. Намайг ороход Б.Дэжид өөрөө сууж байсан. Ширээн дээрээ тавагтай чихэр, жимс тавьсан байсан. Тэр:

-Ю.Цэдэнбал гуайгаас би даалгавар авсан. Тантай уулзаад, таны ярих хүсэлтэй байгаа зүйлийг сонсоод ирэхийг надад даалгасан юм! гэж тэр хэлж байна. Би түүгээр дамжуулаад Ю.Цэдэнбалд нэг хүсэлт тавьсан юм. “Манайх олон хүүхэдтэй айл! Хүүхдүүд зарим нь ЗХУ-д сургуульд явлаа. Би Москвад сурсан зардлаа төлж дууслаа. Одоо намайг Улаанбаатар хотын ойролцоо ч юм уу, төмөр замын дагуу жижиг хотод амьдрах зөвшөөрөл олгож өгөөч!” гэсэн хүсэлт тавьсан юм.

Бугын Дэжид миний энэ хүсэлтийг Ю.Цэдэнбалд танилцуулсан байх. Тэр яриа болсон өдрөөс хойш нэг их удалгүй, би түүний хүсэлтээр дахиад түүнтэй уулзав. Тэр “Таны хүсэлтийг Ю.Цэдэнбал гуай зөвшөөрч байна. Энэ асуудлаар бид тантай дараа дахин холбоо барья!” гэж хэлсэн юм. Ингээд би Дорнод аймаг руугаа буцлаа. Б.Дэжид хэлсэн үгэндээ хүрч тэр ярианаас хойш удалгүй манайхыг Шарын голд шилжин суухыг зөвшөөрсөн хариу ирсэн юм. Шарын гол бол шинэхэн ашиглалтанд ороод байсан манай улсын чулуун нүүрсний томоохон олборлох үйлдвэр юм. Тэнд багахан шиг хотхон байгуулагдсан юм.

15 Ю. Цэдэнбал халагдав.

И Л: 1984 онд МАХН-ын ТХ-ны 8-р бүгд хурал Ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбалын асуудлыг авч хэлэлцээд түүнийг бүх албан тушаалаас нь чөлөөлөх шийдвэр гаргасан шүү дээ. Энэ үед та Шарын голд байсан юм байна. Энэ бүгд хурлын мэдээг яаж анх сонссон бэ? Ер нь Ю.Цэдэнбал гуайн асуудлыг шийдэх өөр арга зам байгаагүй юм уу?

Б Н: Манай гэр Шарын голд нүүж ирэх үед Д.Төмөр-Очир Дархан хотод амьдарч байсан юм. Энэ хоёр бол их ойрхон хотууд юм шүү дээ. Тэр хоёрын хооронд дал орчим л км байх. Би тэнд очоод Д.Төмөр-Очиртой маш сайн харилцаатай болсон юм. Тэр байнга манай гэрт ирдэг боллоо. Би тэднийг бас очидог боллоо. Тэр үед бид нар өөр хүнтэй уулзахад их хэцүү байсан юм. Бидэнтэй уулзсан хүнийг “хань хамсаатан!” гэж үзээд ажлаас нь халаад, бас цөллөгт явуулах аюул бодитойгоор оршиж байсан юм. Тэгээд бид нар өөр хүнтэй харьцахыг боддоггүй байлаа. Ийм үед өөр хоорондоо уулзаж ярилцах нь их сонирхолтой байсан юм. Дархан хот, Шарын голын хооронд бид нар дандаа вагоноор явдаг байлаа. Бид хоёр байнга уулзаж байгааг ч Дотоод яам хяналтаасаа гаргаагүй юм. Харин бидний уулзалтыг зогсоох оролдлого бол хийгээгүй юм.

Тэр үед би “Д.Төмөр-Очир бол улс орны дотор болж байгаа үйл явдлуудын талаар маш их мэдээлэл авдаг юм байна!” гэж мэдсэн юм. МАХН-ын ТХ-ны удирдлагуудын хооронд болж байгаа ярианууд, тэдний ажил хэрхэн явагдаж байгаа талаар болон тэдний хэн нь ямар хэл аманд орооцолдсон, хэн нь архи уусан, хэн нь нууц амрагийн хэрэгт орооцолдож байгаа зэргийг маш тодорхой мэддэг байсан юм. Энэ талаар олон нийгэд ил тод мэдээлэл бол байгаагүй юм. Энэ тухай мэдээ голдуу хов, живийн хэлбэрээр л тархана шүү дээ. Д.Төмөр-Очирт мэдээллийн маш том сүлжээ байсан байх. Тэр мэдээллийг цаг тухайд нь авч байгааг би ойлгосон юм. Энэ бүгд хурлын талаар болон түүний хэлэлцэх асуудлын талаар бүгд хурал хуралдахаас өмнө Д.Төмөр-Очир мэдээлэл авсан байсан юм.

Би энэ бүгд хурал хуралдахын өмнөхөн МАХН-ын ТХ-нд нэг захиа бичсэн юм. Гэтэл тэр захианы асуудлаар Дотоод яам надад сануулга өгсөн юм. “Та энэ захиалдаа МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн даргыг доромжилсон байна. Хэрвээ ийм утгатай захиа дахиад бичих юм бол таныг шийтгэнэ шүү!” гэж Дотоод яам надад анхааруулга өгсөн юм. Тэгээд би “Би санасан бодсон зүйлээ хэлсэн юм. Одоо надад өөр хэлэх зүйл байхгүй!” гэж хэлсэн юм. Тэгээд энэ хэлсэн үгээ баталгаажуулсан бичигт гарын үсэг зурсан юм.

Тэр үед Дотод яамны хэлтсийн дарга хурандаа Д.Дорж гэдэг хүн

надтай уулзсан юм. Тэр хүн:

-Гол нь бид таныг шийтгэхдээ биш, дахин ийм явдал гаргуулахгүйн тулд авч байгаа арага хэмжээ юм шүү. Хэрвээ дахиад ийм зүйлийг бичвэл таныг эрүүгийн хуулийн 92, 93-р зүйл болон 49-р зүйлээр шийтгэх бүрэн үндэслэл бидэнд бий шүү! гэж хэлсэн юм. Гэтэл түүнээс хойш тун удалгүй би хэлсэн үгэндээ хүрэлгүй дахиад МАХН-ын ТХ-нд хаягласан захиа бичих шаардлага гарсан юм.

Тэр үед МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүн С.Жалан-Аажавыг өндөр насных нь тэтгэвэрт гаргасан юм. Тэгээд удалгүй МАХН-ын ТХ-ны ХШХ-ноос “С.Жалан-Аажав бол Ц.Лоохууз, Б.Нямбуу, Б.Сурмаажав нарын намын эсрэг бүлгийн нэг удирдагч байсан!” гэж гүтгэсэн юм. С.Жалан-Аажав бол бидэнтэй огт холбоотой байгаагүй юм. Харин тэр үед МАХН-ын 6-р бүгд хуралд оролцохоор намайг Москвагаас ирэхэд тэр ирж уулзсан юм. Гэхдээ ганцаараа биш С.Лувсанчойнболтой хамт байсан юм.

С.Лувсанчойнбол бол Ю.Цэдэнбалын даалгавраар явж байсныг нь би ойлгосон. Харин С.Жалан-Аажавыг хэн явуулсныг мэдэхгүй. С.Лувсанчойнбол өөрөө дагуулж ирсэн байж магадгүй. С.Лувсанчойнбол тэр үед Ю.Цэдэнбалыг огцруулсны дараа ямар хүнийг, ямар албан тушаалд томиловол оновчтой вэ? гэх зэргээр надтай ярилцахыг хүссэн юм. Тэр хэнийг ямар албан тушаалд томилох тухай жагсаалт хийсэн юм билээ. Тэр жагсаалтыг С.Лувсанчойнбол Ю.Цэдэнбалын даалгавраар өөрөө хийсэн байх. Намайг өдөөн хатгах зорилготой хийсэн нь тодорхой шүү дээ. Тэр жагсаалттай нь С.Жалан-Аажав ердөө танилцаагүй байсныг нь би тэр үед ойлгосон. С.Жалан-Аажав “Ю.Цэдэнбалыг ажлаас халаад ер нь хэрэггүй. Түүнээс муу хүн төрийн эрх мэдлийг авбал аюултай юм болно!” гэх мэтээр надтай ярихыг оролдож байв. Надад түүнтэй ийм асуудлаар ярих ямар ч шаардлага байгаагүй учир түүгээр битүү баахан даажигнасан юм. Тухайлбал “Ю.Цэдэнбалын оронд Сайд нарын Зөвлөлийн даргаар Дотоод яаны сайд Б.Жамбалсүрэнг томиловол ямар вэ?” гэх зэргээр ярьсан юм. Б.Жамбалсүрэн бол ойворгон, сагсуу зантай, маш найдваргүй нөхөр байсан юм. Харин Ю.Цэдэнбал л түүнийг өөд нь татаж, үргэлж чирч явдаг байсан юм.

Гэтэл 1983 онд МАХН-ын ХШХ-ны дарга Бугын Дэжид “Энэ жагсаалтыг С.Жалан-Аажав зохиосон! Намын эсрэг бүлгийнхэнтэй хэнийг ямар албан тушаалд томилох талаар тохирч байсан!” гээд түүнийг гүтгэсэн юм. МАХН-ын ТХ-ны ХШХ С.Жалан-Аажавыг ингэж гүтгээд, тогтоол гаргасан юм. Тийм болохоор миний тэвчээр бүр барагдаад “С.Жалан-Аажав бол бидэнтэй ямар ч холбоогүй юм шүү!” гэдэг талаар МАХН-ын ТХ-ны ХШХ-нд захиа бичсэн юм. Би ингэж Дотоод яаманд

өгсөн амлалтаа зөрчсөн юм. Тэгээд нэгэнт л амлалтаа зөрчсөн болохоор баривчлагдахаа хүлээх болсон юм. Оройхон үед манай хаалгыг хүн тогшвол “За одоо намайг баривчлахаар ирлээ!” гэж л боддог боллоо. Хааяа Дархан орохдоо Дотоод яамны үүдэнд зогсож байгаа машиныг хараад “Намайг баривчлахаар яг л ийм машинаар ирэх байх даа!” гэж боддог боллоо. Тэгээд “За, баривчлах гээд байгаа юм бол баривчлана биз дээ!” гэж бодоод шоронд суух бэлтгэлээ хийж байсан юм.

Тэгээд нэг орой гэртээ суугаад телевизор үзэж байтал МАХН-ын ТХ-ны 8-р бүгд хурлын тухай албан мэдээ уншиж байна. Тэр хурал МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбалыг бүх албан тушаалаас нь чөлөөлсөн байлаа. Тэр мэдээг сонсоод хамгийн түрүүнд надад бодогдсон зүйл бол “За, би ямар ч байсан баривчлагдахгүй боллоо!” гэж бодогдсон юм шүү. Ингэж би үнэхээр баривчлагдах аюулаас гарсан юм. Энэ бүгд хурал хуралдсаны дараа би Д.Төмөр-Очиртой уулзсан юм. Д.Төмөр-Очир: “Ю.Цэдэнбал улс орноо удирдаж чадахгүй байгаа нь чи бид нар түүнийг шүүмжлэж байх үед л мэдэгдэж байсан юм шүү дээ. Бид нар ор үндэсгүй түүнийг шүүмжлээгүй юм. Энэ шийдвэр хэтэрхий оройтож гарлаа даа!” гэж хэлж байсан юм.

Ю.Цэдэнбал өөрөө ажлын ямар ч чадваргүй болсныг нь ашиглаад эхнэр А.И.Филатова нь ёстой дураараа дургиж эхэлсэн юм. Ер нь А.И.Филатова “Би улс орныг удирдаж чадна!” гэж хэлэх шахаж байсан юм. Ю.Цэдэнбалыг огцруулахад ЗХУКН оролцсон гэдэг нь ойлгомжтой шүү дээ. Тэнд Ю.Цэдэнбалын эхнэрийн үйл ажиллагаанаас их болгоомжилсон юм. Ер нь А.И.Филатовагийн хэлсэн, ярьсан үг бүр нь ЗХУКН-аас хэлж байгаа юм шиг ойлгогддог байсан юм. Түүнийг нь Ю.Цэдэнбал улам дэвэргээд л байдаг байлаа шүү дээ. Харин сүүлдээ монголчуудын дунд ямарч нэр хүндгүй болсон А.И.Филатовагийн үйл ажиллагаа ЗХУКН-ын нэр хүнд монголчуудын дунд асар хурдтайгаар унах нэг шалтгаан болж эхэлсэн юм.

КЮ: Ю.Цэдэнбал гуай бүр залуу байхдаа ажлын чадваргүй болсон тухай та ярьсан шүү дээ. Тэр үед түүнд тусалж өгдөг хүн байсан уу?

Б Н: Ю.Цэдэнбал өөрийн хариуцсан ажлаа хийж чадахгүй байгаагийг нь Д.Төмөр-Очир маш сайн тодорхойлдог юм. Тэр энэ асуудлаар МАХН-ын ТХ-ны бүгд хурал дээр хүртэл ярьж байсан юм. Д.Төмөр-Очир өөрөө олон жил Ю.Цэдэнбалын хэлэх үгийг бэлтгэж өгдөг байсан юм. Гол нь Ч.Лодойдамба, Д.Төмөр-Очир хоёр Ю.Цэдэнбалын тавих илтгэл, хэлэх үгийг нь бэлтгэж өгдөг байлаа шүү дээ. Тэр хоёр шууд орос хэл дээр нь бичээд өгдөг байсан юм. Сүүлд Д.Ёндон энэ үүргийг гүйцэтгэдэг болсон.

Д.Ёндон нэг хэсэг манай Гадаад харилцааны яамны орлогч сайдын албыг хашиж байсан юм шүү дээ. Ю.Цэдэнбалд сайн хийж чаддаг нэг ажил байсан юм. Тэр нь хүний бичсэн зүйлийг маш сайн редакторладаг юм. Хүний бичээд өгсөн зүйлийг улаан цоохор болтол нь засдаг байлаа шүү дээ. Энэ ажлыг тэр маш сайн хийдэг байв. Ю.Цэдэнбал МАХН-ын их хурал, бүгд хурал дээр тавих илтгэлүүдээ ерөөсөө өөрөө бичиж байгаагүй. Д.Төмөр-Очир, Ч.Лодойдамба нарын бэлтгэж өгсөн илтгэлүүдийг уншдаг байв шүү дээ.

КЮ: Ю.Цэдэнбал гуай чинь эдийн засагч мэргэжилтэй шүү дээ. Та түүнийг эдийн засагчийн хувьд хэрхэн үнэлдэг вэ?

Б Н: Би түүнийг эдийн засагчийн хувьд ч ер нь үнэлдэггүй. Тэр ер нь тун тааруухан эдийн засагч шүү дээ. МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн даргын хувьд санаачлага гаргаад өөрөө гардаж удирдаад бүтээчихсэн зүйл ерөөсөө байхгүй юм шүү дээ. “Ийм ажлыг манай Ю.Цэдэнбал дарга санаачлаад хийгээд бүтээчихсэн юм шүү!” гээд үзүүлэх юм одоо ердөө олдхогүй байгаа юм. Тэр үеийн “Атар газрыг эзэмших хөдөлгөөн”, “Нэгдэлжих хөдөлгөөн” зэрэг улс орныг бүхэлд нь хамарсан том, том ажлууд бол Ю.Цэдэнбалын хийсэн ажил биш. Тэр үед түүний доод талд Л.Цэнд, Д.Төмөр-Очир, Д.Майдар, Ц.Лоохууз нарын сайн зохион байгуулагчид ажиллаж байв. Тэдний хүчээр манай улс ийм том ажлуудын ард нь гарч чадсан юм шүү дээ.

Манай Ю.Цэдэнбал бол хүний хувьд дажгүй л хүн л дээ. Гэхдээ улс төрийн бие даасан бодлого байхгүй, бүх зүйлийг яг Оросын загвараар хийхийг боддог, өөрөө орос эхнэрийнхээ гарт орчихсон, бас маш их сэтгэлгээний хоцрогдолд орчихсон хүн байлаа! Энэ бүхэн түүнийг ажил хийх ямар ч чадваргүй болгож байсан юм. Би түүнийг хувийн талаар шүүмжлээгүй юм. Гагцхүү тэр ажлын чадваргүй болчихсон байдал нь улс орны хөгжилд үлэмж саад болж байсан юм. Би үүнийг л шүүмжилсэн юм.

Ю.Цэдэнбалд хувь хүнийх нь хувьд би хар муу санаа гаргаад, түүнийг МАХН-ын ТХ-ны бүгд хурал дээр, намын хамт олны өмнө шүүмжлээгүй юм шүү. Би түүнийг гүтгэж, асуудалд сэтгэлийн хөөрлөөр хандаж байгаагүй. Миний шүүмжлэл бодитой, үнэн зөв болохыг Ю.Цэдэнбал өөрөө сайн мэддэг байсан юм. Тийм учраас тэр намайг цөллөгт явуулсныхаа дараа ч надад муу хандаж байгаагүй .

Намайг цөллөгт байхад тэр гурван маш том зүйлээр надад тусалсан юм. Нэгдүгээрт, МАХН-ын ТХ-ны ХШХ-ны шийдвэрээр би Дорнод аймгийн Эрэнцавын САА-д малчин болох ёстой байсан юм. Мал хариулж байгаа хүн чинь сумын төвөөс хол амьдрах ёстой шүү дээ. Гэтэл манай

эхнэр эмч хүн учраас заавал сумын төв дээр амьдрах шаардлагатай байв. Миний ар гэрийн энэ байдлыг харгалзан үзээд, Ю.Цэдэнбал намайг малчныхаа ажлаас гарч сумын төвд гэр бүлийнхэнтэйгээ хамт амьдрахыг зөвшөөрсөн юм. Хоёрдугаарт, манай хүүхдүүдийг дээд сургуульд сурах явдлыг хориогүй юм. Манай хүүхдүүд их сурлага сайтай хүүхдүүд байсан юм. Тийм учраас би “манай хүүхдүүд сурлага, сахилга сайтай учир, тэднийг дээд сургууль суралцуулж өгөөч!” гэсэн хүсэлт Ю.Цэдэнбалд тавьсан юм. Ю.Цэдэнбал миний хүсэлтийг хүлээж аваад “Б.Нямбуугийн хүүхдүүд сурлага сайтай юм байна. Тэднийг суралцах хүсэлтийнх нь дагуу бусад хүүхдүүдийн нэгэн адил хаана ч явуулж суралцуулж болно!” гэж зөвшөөрсөн юм. Надтай хамт “намаас арга хэмжээ авхуулсан” хүмүүсийн хүүхдүүдийг бүгдийг нь дээд сургуульд суралцахыг хорьчихсон юм шүү дээ. Тэднийг бол маш хатуу хянаж, дарамталдаг байсан юм. Надаас өөр Ю.Цэдэнбалаас хүүхдүүдээ дээд сургуульд сургах зөвшөөрөл авч чадсан хүн байхгүй. Гуравдугаарт, би “Улаанбаатараас хол хөдөө амьдрахад төвөгтэй боллоо. Улаанбаатарын ойролцоо амьдрах зөвшөөрөл өгөөч!” гэдэг хүсэлтийг түүнд тавьсан. Тэр бас миний энэ хүсэлтийг хүлээж аваад зөвшөөрсөн. Тэр үед МАХН-аас арга хэмжээ авхуулаад хөдөө цөлөгдсөн хүмүүсийн асуудлыг дан ганц Ю.Цэдэнбал өөрөө шийддэг байв. Түүнээс өөр энэ асуудлаар их, бага ямар нэгэн шийдвэр гаргах нэг ч хүн байгаагүй юм шүү дээ. Цөлөгдсөн хүмүүстэй холбоотой бүх асуудлыг Ю.Цэдэнбал өөрөө гардаж, ганцаарааа шийддэг байсан юм шүү.

16 Л.Цэнд, Д. Төмөр-Очир хоёр.

И Л: Ю.Цэдэнбал гуай чинь Улсын баатар, Хөдөлмөрийн баатар зэрэг цолнуудыг авсан шүү дээ. Та энэ талаар ярьж өгнө үү?

Б Н: БНМАУ-ын Хөдөлмөрийн баатар цолыг 60-аад оны эхээр түүнд өгсөн юм. Түүнд Хөдөлмөрийн баатар цол олгох асуудалд олон хүн дургүй байсан юм. Ихэнх хүмүүс “Хөдөлмөрийн баатар цол олгох асуудлыг жаахан азная. Дараа өгч болно шүү дээ!” гэсэн байр суурьтай байсан юм. Энэ асуудлаар МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүн Л.Цэнд санаачлага гаргаж, МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүд болон Улаанбаатар хотын МАХН-ын хорооны товчооны гишүүдийн саналыг авсан юм. Л.Цэнд өөрөө Ю.Цэдэнбалын шахалтанд орсон байж болох юм. Ямар ч байсан тэр өөрөө бол “Ю.Цэдэнбалд Хөдөлмөрийн баатар цол олгох нь зөв!” гэсэн байр суурьтай байсан юм шиг байгаа юм. Л. Цэнд өөрөө “Ю.Цэдэнбал ажил хийх чадваргүй хүн шүү дээ!” гэсэн яриаг дэмждэг байж яагаад Ю.Цэдэнбалд Хөдөлмөрийн баатар цол олгох сонирхолтой

байсан бэ? гэсэн асуулт байдаг юм. Ю.Цэдэнбалд Хөдөлмөрийн баатар цол олгох асуудлыг Л.Цэнд идэвхитэй дэмжсэн нь улс төрийн зорилготой байсан байж магадгүй. Өөрөөр хэлбэл энэ бол Л.Цэндийн зүгээс Ю.Цэдэнбалыг МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн даргын албан тушаалаас нь огцруулах бэлтгэл ажлын нэг хэсэг нь байсан байж магадгүй. Түүнд Монгол улсын хөдөлмөрийн баатар цолыг өгөөд “За, Ю.Цэдэнбал аа. Ингээд баяртай! Одоо боллоо. Бид улс орноо, ажил төрлөө бодъё!” гэж хэлэх гэж байсан байх. Би ингэж боддог юм. Л.Цэнд бол Ю.Цэдэнбал ажил хийж чадахгүй байгааг хамгийн ойроос харж байгаа хүн шүү дээ. Тэгсэн хирнээ олон хүн дургүй байхад Ю.Цэдэнбалд Хөдөлмөрийн баатар цол олгохыг идэвхитэй дэмжиж байсныг үүнээс өөрөөр тайлбарлах боломжгүй юм.

Би Л.Цэндтэй нэг удаа их сүрхий муудалцсан юм. Энэ бол Ю.Цэдэнбалыг огцруулаад МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар Л.Цэнд өөрийгөө сонгуулах бодолтой байсантай холбоотой юм. Би түүний энэ санааг мэдсэнээс бид хоёр их сүрхий муудалцсан юм. Намайг Өмнөговь аймгийн МАХН-ын хорооны дарга байхад Л.Цэнд очсон юм. Тэр манай аймгийн ажлыг шалгах зорилготой очсон юм. Гэхдээ түүний очсон зорилго нь гаднаас нь харахад ийм байсан боловч цаад талдаа өөр зорилготой байв. Ю.Цэдэнбалыг огцруулаад, Л.Цэндийг МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн даргаар сонгох асуудлыг МАХН-ын ТХ-ны бүгд хурал хэлэлцвэл би Л.Цэндийг дэмжих ёстой байж. “Би дэмжихгүй!” гэдгээ түүнд ойлгуулсан. Л.Цэнд надаас дэмжлэг авч чадаагүйдээ их уурласан юм. Тэгээд “Бид танай Өмнөговь аймгийн ажлыг тусгайд нь авч хэлэлцэнэ шүү!” гэж хэлээд явсан юм. Би ч түүнийг явахад нь “Манай аймгийн ажил муу байгаа гэсэн зохиомол дүгнэлт гаргаж болно. Харин би таныг МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар сонгогдох асуудлыг дэмжихгүй шүү!” гэж хэлсэн юм.

Ер нь Л.Цэнд бол маш их авъяастай, их мэдлэгтэй, гарамгай сайн зохион байгуулагч хүн байсан юм шүү дээ. Тэр аварга том, том ажлуудын ард маш амархан гарч чаддаг гарамгай зохион байгуулагч хүн байв. Би түүнийг дэмжээгүйн гол шалтгаан бол тэр ийм сайн талуудтай боловч бас дутагдалтай хүн байв. Тэр бол битүү далд санаатай хүн юм л даа. Энэ бол их аюултай шинж чанар шүү дээ. Тийм далд санаатай хүнийг манайхан “Муу санаатай хүн!”, “Дотуур тамиртай хүн!” гэх мэтээр нэрлэдэг юм. “Төрийн тэргүүн ийм хүн болбол маш аюултай байдал үүсэж болох юм!” гэж би боддог. Л.Цэндийн МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар сонгогдох санаархал нь ЗХУ-ын Улсыг Аюулаас Хамгаалах Хорооны шугамаар Ю.Цэдэнбалын сонорт хүрсэн юм билээ.

Тэр үед Л.Цэнд, Д.Төмөр-Очир хоёрын харилцаа их хэцүү байсан юм.

Уг нь тэр хоёр их найрсаг сайхан харилцаатай байсан хүмүүс юм шүү дээ. Хорь гаруй жил хамт ажилласан, бие биенээ их сайн мэддэг хүмүүс байв. Гэтэл сүүлийн үед л муудалцаад тун ч эвлэрэхээ байсан юм л даа. Юунаас болсныг нь тэр үед бид нар огт ойлгодоггүй байв. Хожим энэ асуудал тодорхой болсон юм. Тэр үед Монголын нийгэмд Ю.Цэдэнбалын талаар элдвийн муу яриа тун чиг зогсохгүй байлаа. Монголын олон нийт түүнийг “Удахгүй огцорно!” гэсэн байдалд ороод, энэ үйл явдал болохыг хүлээх хандлагатай болсон юм. Ийм нөхцөлд Ю.Цэдэнбал энэ аюулыг зайлуулах арга хэмжээ авч эхэлсэн юм.

Түүний тооцоолсноор бол түүнд хамгийн их аюул учруулж болох хүн бол Д.Төмөр-Очир байж л дээ. Д.Төмөр-Очир бол Ю.Цэдэнбалыг МАХН-ын удаа дараагийн бүгд хурлууд дээр хурц шүүмжлэж байсан юм. Олон түмний дунд Д.Төмөр-Очирын нэр хүнд ч өндөр байлаа. Тэр бүр “Ю.Цэдэнбал аа, Чи одоо болих хэрэгтэй. Улс орны ажил, ард түмний амьдрал хэцүүхэн байна шүү!” гэж түүнд шууд хэлдэг байсан юм шүү дээ. Тийм учраас Ю.Цэдэнбал “аюул бол Д. Төмөр-Очирын зүгээс ирнэ!” гэж тооцоолсон юм шиг байгаа юм.

Тэр үед Ю.Цэдэнбалын толгойд “Яаж Д.Төмөр-Очирыг зайлуулах вэ?” гэсэн бодол эргэлдэж байсан байх. Ю.Цэдэнбал энэ ажилдаа Л.Цэндийг ашиглахаар шийдсэн байгаа юм. Л.Цэнд бас Ю.Цэдэнбалыг огцруулаад өөрөө МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар сонгогдох бодолтой байгаа хүн шүү дээ. Хэрвээ энэ бодол үнэхээр хэрэгжиж эхэлбэл түүнд “хамгийн их саад болох хүн бол Д.Төмөр-Очир мөн!” гэж Л.Цэнд бас тооцоолж байсан байх. Ю.Цэдэнбал Л.Цэнд хоёр ийм хоёр өөр зорилгын үүднээс холбоотон болж, Д.Төмөр-Очирыг огцруулсан байгаа юм. Тэд нар түүнийг огцруулаад, цөллөгт явуулсан юм.

Ингээд хэсэг хугацаа өнгөртөл Ю.Цэдэнбал өөрөө маш аюултай байдалд орсноо аажмаар ойлгож эхэлсэн байх. Одоо түүнийг Д.Цэндээс хамгаалах хүчтэй хүн дэргэд нь байсангүй. Ю.Цэдэнбал аяндаа өөрөө Д.Цэндийн гарт ороод ирсэн байх л даа. Д.Цэнд Ю.Цэдэнбалыг огцруулах нь цаг хугацааны асуудал болж ирэх төлөвтэй болоод ирсэн байна. Ийм аюултай байдалд орсноо Ю.Цэдэнбал ойлгоод, яаралтай арга хэмжээ авч эхэлсэн байдаг юм. Ю.Цэдэнбал “Одоо Д.Төмөр-Очироос өөр түүнд тус болж чадах хүчтэй хүн байхгүй!” гэдгийг ойлгосон байх. Тийм учраас Д.Төмөр-Очирыг хуучин ажилд нь эргүүлж авах санаачлагыг Ю.Цэдэнбал гаргаж, МАХН-ын ТХ-ны гишүүдийн дэмжлэгийг авахыг оролдож эхэлсэн юм. Яг энэ үед нь би Ю.Цэдэнбалтай нэг удаа уулзсан юм. Тэр “Д.Төмөр-Очирыг хуучин ажилд нь эргүүлж авахгүй бол болохгүй байна. Би Д.Цэндийн үгэнд ороод түүнийг ажлаас нь халчихсан юм. Чи ямар саналтай байна вэ? Чи бол МАХН-ын ТХ-ны нөлөө бүхий гишүүн хүн шүү

дээ! Д.Төмөр-Очирыг эргүүлээд хуучин ажилд нь авахад эсэргүүцэх хүмүүс их гарах байх. Чи миний саналыг дэмжэээрэй!” гэж тэр надад хэлж байсан юм.

Гэтэл Д.Төмөр-Очир өөрөө Ю.Цэдэнбалын энэ саналыг хүлээж авахаас эрс татгалзсан байдаг юм. “Та нар намайг ямар ч шалтгаангүй байхад энэ ажлаас огцруулсан шүү дээ. Би дахин улс төрийн ажил хийхгүй. Харин судалгааныхаа ажлыг бол хийнэ!” гэж хэлээд татгалзсан юм байж. Энэ үед Ю.Цэдэнбалд ерөөсөө “Д.Төмөр-Очирын зүгээс Ю.Цэдэнбалд ямар ч аюул байхгүй юм байна!” гэсэн бодол төрсөн байж магадгүй. Ингээд удаан ятгасны эцэст Д.Төмөр-Очир хуучин ажилдаа буцаж орохыг зөвшөөрсөн юм байж. Энэ асуудлыг хэлэлцсэн МАХН-ын ТХ-ны бүгд хурал дээр Д.Төмөр-Очирыг эргүүлэн хуучин ажилд нь авах саналыг эсэргүүцсэн нэг ч хүн гараагүй юм. Д.Төмөр-Очир өөрөө бас дутагдалгүй хүн ч биш л дээ. Тэр хүнтэй их таарамжгүй, их дураараа, зөрүүд хүн юм шүү дээ. Харин мэдлэг боловсрол, авъяас чадварын хувьд бол гайхамшигтай хүн л дээ. Тэр үед Монголд тийм хүн ховорхон байлаа. Ю.Цэдэнбал Д.Төмөр-Очир хоёр нэг дор удаан ажиллаж чадахгүй нь хэнд ч ойлгомжтой зүйл шүү дээ. Тэр үед Ю.Цэдэнбалын толгойд “Одоо Д.Төмөр-Очирыг яах вэ?” гэсэн бодол дахиад эргэлдэж эхэлсэн байх.

Д.Төмөр-Очир хуучин ажилдаа эргэж ороод “Нэг хүнийг тахин шүтэх явдлын хор уршгийг арилгах” өргөн кампанит ажилд орсон юм. Энэ бол Ю.Цэдэнбалын хамгийн эмзэг газар нь юм л даа. Ю.Цэдэнбал өөрөө Х.Чойбалсангийн үед улс төрийн хэлмэгдүүлэлтэд хэрхэн оролцож байсныг нь хамгийн сайн мэдэх хүний нэг нь Д.Төмөр-Очир юм л даа. Энэ хэрэг явдлуудтай холбоотой материалууд хаана байгааг ч тэр сайн мэдэж байсан юм. Энэ кампанит ажлаараа Д.Төмөр-Очир юунд хүрэх зорилготой байсныг таахад хэцүү л дээ. Тэр Ю.Цэдэнбалыг байнгын дарамтанд барьж байхыг зорьж байсан байж магадгүй. Энэ кампанит ажлын үр дүнд Ю.Цэдэнбал гарах газаргүй, буланд шахагдчихаад байгааг Д.Төмөр-Очир сайн ойлгож байсан байх.

Ийм хүнд байдлаас Ю.Цэдэнбал гарах гарц олсон юм. Ер нь Ю.Цэдэнбал бол иймэрхүү муу ажилд гаршсан хүн байсан юм шүү дээ. Бүх эрх, мэдэл түүний гарт байгаа байдлыг ашиглаад, тэр шударгаа биш ажил олныг хийсэн юм шүү. Ю.Цэдэнбал “Үндэсний үзлийг дэвэргэсэн, Монгол-Зөвлөлтийн найрамдлын эсрэг дайсагнасан хандлага гаргасан!” гэсэн үндэслэл гаргаж ирээд Д.Төмөр-Очирыг огцруулсан юм. Д.Төмөр-Очир бол “Би удирдах ажил хийх хүн биш шүү дээ. Би өөрөө ааш ариншин сайнгүй болохоор өөртөө олон дайсан бэлтгэх байх аа. Харин би эрдэм шинжилгэний ажил хийх сонирхолтой юм. Монголын түүх судлаад, багшлах ажлаа хийвэл болох юм!” гэж ярьдаг хүн байсан

юм. Ю.Цэдэнбалын дэргэд Д.Төмөр-Очир шиг гарамгай хүн байхад Л.Цэндийг огцруулах нь тийм ч хүнд асуудал биш байсан байх л даа. Гэхдээ тэр энэ бэлтгэлийг хийж аваад эхлээд Д.Төмөр-Очирыг огцруулсан юм. 1962 онд хуралдсан МАХН-ын ТХ-ны 3-р бүгд хурлаар Д.Төмөр-Очирыг дахиад бүх албан тушаалаас нь огцруулсан юм.

Л.Цэндийн зүгээс Ю.Цэдэнбалын асуудлаар ЗХУКН-ын ТХ-ны УТТ-ны зарим гишүүдтэй санал солилцож байсан юм билээ. Гэтэл тэд нар Л.Цэндийн энэ саналыг дэмжээгүй юм байж. Ингээд Л.Цэнд ялагдах нь гарцаагүй болсон байдаг юм. 1963 оны намар Л.Цэндийг огцруулав. Л.Цэнд нэг ч удаа Ю.Цэдэнбалыг илээр шүүмжлэж байгаагүй юм шүү дээ. Түүний үг маш их жинтэй, цөөхөн үгээр маш том санааг гаргаж чаддаг хүн байсан юм. Л.Цэндийг Завхан аймагт цөлж суулгав. Л.Цэнд ингэж Монголын улс төрийн тавцангаас буусан юм. Тэр дахиж улс төрд орж ирээгүй юм. Харин Л.Цэндийг ийнхүү огцруулсны дараа Ю.Цэдэнбал улс төрийн тэмцлийн нилээд туршлагатай болсон биз ээ.

Би Д. Төмөр-Очирыг огцруулахад Монголд байгаагүй, Москвад суралцаж байв. Тэр бүгд хурал хуралдсаны дараа жил би Д.Төмөр-Очиртой нэг удаа уулзсан юм. Тэр өөрөө над руу утасдаад “Уулзах хэрэг байна!” гэсэн юм. Ингээд тэр манайд ирлээ. Бид хоёр нэг шил шимийн архи тавьж байгаад тэр бүгд хурлын ажиллагааны талаар ярилаа. Д.Төмөр-Очир “МАХН-ын ТХ-ны 3-р бүгд хурлын үйл ажиллагааг эхнээс нь маш их сайн зохион байгуулсан тул ердөөсөө үг хэлж, өөрийгээ хамгаалах ямар ч боломж гараагүй!” гэж ярьж байсан юм. Тэгээд “Ойрын үед боломж гаргаад Ю.Цэдэнбалтай уулзмаар байна. Би түүнтэй уулзах хүсэлт гаргасан боловч тэр намайг хүлээж авахаас татгалзаад байгаа юм. Чи Ю.Цэдэнбал бид хоёрын уулзалтыг зохион байгуулаач! Намайг Баянхонгор аймгийн Барилгын газрын даргаар томилж явуулсан юм. Би уг нь өөрийн мэргэжлийн чиглэлээр ажилламаар байгаа юм!” гэж ярьсан юм. Бид манай гэрт уулзсан тухай мэдээг Дотоод яам авсан байна.

Тэр үед манай гэрийн утсыг Дотоод яам чагнаж байсан юм байна л даа. Нөхцөл байдал ийм болсон учир Д.Төмөр-Очиртой уулзсаны маргааш өдөр нь би шууд Ю.Цэдэнбалын өрөөнд орлоо. Тэгээд түүнд Д.Төмөр-Очиртой уулзсан уулзалтынхаа тухай бүгдийг нь ярьж өглөө. Тэгээд “Би Д.Төмөр-Очирыг дэмждэгийг та мэднэ. Тэр хүн уг нь улс оронд хэрэгтэй хүн шүү дээ. Тантай уулзах хүсэлтэй явдаг юм байна. Гэвч тодорхой шалтгааны улмаас уулзаж чаддаггүй юм байна!” гэж түүнд хэлсэн юм. Гэтэл миний үгийг сонсож байсан Ю.Цэдэнбал “За тийм юм бол, ойрын үед би түүнтэй уулья!” гэж хэлсэн юм. Би энэ тухай Д.Төмөр-Очирт хэллээ. Тэр ч сэтгэл нь их сэргэж байгаа бололтой байсан юм. Ингээд би удалгүй Москва руугаа явчихлаа.

Дараа жилийн нь зун би Д.Төмөр-Очироос Ю.Цэдэнбал, тэр хоёрын уулзалтын тухай асуусан юм. Гэтэл Д.Төмөр-Очир “Тийм уулзалт ерөөсөө болоогүй шүү! Тэр ер нь тийм л хүн шүү дээ! Ярьсан тохирсондоо хүрэх нь тун ч ховорхон үзэгдэл шүү дээ!” гэж байв. Д.Төмөр-Очир бол аргагүй их өргөн мэдлэгтэй хүн байсан юм. Аймгуудын МАХН-ын хороодын дарга нар Улаанбаатарт ямар нэгэн ажлаар ирэхэд хамгийн түрүүнд л Д.Төмөр-Очир тэднийг өөрийнхөө өрөөнд цуглуулж байгаад л улс оронд болж байгаа үйл явдлууд, дэлхий нийтэд болж байгаа үйл явдлуудын талаар яриа хийж, зөвлөлгөө өгдөг байв. Тэгээд л бид нараас нутаг орны байдал, ажил төрөл хэрхэн явагдаж байгаа талаар асууна шүү дээ. Тэгээд нэг л асуултанд хариулж чадахгүй бол “Та на ийм байж яаж энэ улс орныг авч явах юм бэ? Та нар наад бөндгөрүүдээ жаахан ажиллуулж байгаач! Жаахан ч гэсэн хэрэгтэй мэдээллээр наад бөндгөрөө дүүргэж байгаач! Энд тэндхийн найр наадмын тухай л бодоод явдаг юм уу?” гээд загнана шүү дээ.

Яамдын сайд нартай бол бүр ширүүн харьцдаг байсан юм. “Чи хөгжлийн хурдтай хөл нийлүүлээд явж чадахгүй байна шүү. Улс орны хөгжилд саад болж байхын оронд хурдан шиг энэ ажлаасаа гарах өргөдлөө өгөх хэрэгтэй байна!” гээд л загнана шүү дээ. Тэгээд МАХН-ын төв хэвлэл “Үнэн” сонин дээр зарим яамдын сайдын нэрийг нь заагаад “Ажил нь муу явж байна!” гээд шүүмжилдэг байсан юм. Тэр үед яамдын сайд нарыг ингэж шүүмжилдэг газар, хүн гэж ердөөсөө байгаагүй юм. Өөрийн яамныхаа сайдын ажлыг шүүмжилбэл өөрөө тэндээс хөөгдөнө шүү дээ. Ийм учраас энгийн хүмүүс Д.Төмөр-Очирын энэ арга хэмжээнд нь их дуртай байсан байх л даа. Зарим үед Д.Төмөр-Очирт шүүмжлүүлсэн яамдын сайд нар эсэргүүцэж л байсан юм.

И Л: 1990 онд “Ю.Цэдэнбалын тойрон хүрээлэгчидийн хэрэг” гэсэн нэг хэрэг прокурорт шилжсэн шүү дээ. Тэр хэрэг яаж шийдэгдсэн бэ?

Б Н: “Ю.Цэдэнбалын тойрон хүрээлэгчид” гэж түүнтэй олон жил хамт ажилласан Д.Моломжамц, Т.Рагчаа, Д.Содном, Б.Дэжид, П.Дамдин, С.Лхамжав, М.Пэлжээ зэрэг 40 орчим хүнийг хэлж байсан юм. Эд нар Ю.Цэдэнбалтай он удаан жил хамт ажиллаж, түүнийг хамгаалж, буруу үйлдлүүдийг нь хаацайлж явсан хүмүүс юм шүү дээ. 1990 онд хуралдсан МАХН-ын 20-р их хурлаас эдгээр хүмүүсийг анх удаа “Ю.Цэдэнбалын тойрон хүрээлэгчид” гэж тодорхойлсон юм. Эд нарыг МАХН-ын гишүүнээс хөөсөн юм. Тэгээд улсын мөнгө, хөрөнгийг идэж ууж ашигласан байдлыг нь тодорхойлсон юм. Улсын эдийн засгийг уналтанд оруулсан, улсын ихээхэн өмч хөрөнгийг үр ашиггүй зарцуулж,

их хэмжээний хөрөнгийг үрэн таран хийсэн зэрэг асуудал тавигдсан юм. Ю.Цэдэнбал улс орныг удирдаж чадахгүй байгааг мэдэж байсан хэрнээ түүнийг олон түмнээс нуун дарагдуулж, хаацайлан хамгаалж, даган баясаж байсан зэрэг асуудлууд тавигдсан юм.

Тэгтэл энэ хэрэг прокурор дээр их удсан юм. Тэр үед МАХН-ын нөлөө их байлаа шүү дээ. Шүүх, прокурорын газарт бол тэр чигтээ МАХН-ынхан ажиллаж байлаа. “Ю.Цэдэнбалын тойрон хүрээлэгч” нарын хэргийг Дээд шүүхэд хариуцаж байсан шүүгч бол Д.Шаравдорж юм. Энэ хүн 2004 оны сонгуулийн дараа байгуулагдсан “Зөвшөлцлийн засгийн газар”-т МАХН-аас Батлан хамгаалах яамны сайд болсон хүн юм. Энэ хүн энэ хэргийг хоёр жил орчим дарагдуулсан юм. Тэгээд эцэст нь “Гэмт хэргийн бүрдэлгүй!” гэсэн шийдвэрийг Улсын дээд шүүхээс гаргуулаад, энэ хэргийг хаачихсан юм. Уг нь бол тэднийг шийтгэх бүрэн үндэслэл байсан юм шүү дээ.

И Л: Ю.Цэдэнбал гуайн одон медалийг нь хураасан шүү дээ. Энэ чинь П.Очирбат гуайн тушаалаар хийгдсэн ажил байх аа?

Б Н: МАХН-ын онц 20-р их хурлаас Ю.Цэдэнбалыг МАХН-аас хөөсөн юм. Бас 20-р их хурлаас сонгогдсон МАХН-ын ТХ-ны УТТ-ны шинэ бүрэлдэхүүн хуралдаад Ю.Цэдэнбалд олгосон гол таван одон, медалийг нь хурааж авах шийдвэр гаргасан юм. Тэр үед МАХН төрийн эрхийг барьж байсан шүү дээ. Ерөнхийлөгч П.Очирбат МАХН-ын ТХ-ны УТТ-ны энэ шийдвэрийг үндэслээд тушаал гаргаад гол, гол одон медалуудыг нь хурааж авах шийдвэр гаргасан юм.

17 Монголын ардчилал, шинэчлэл.

И Л: 1990 оны 3-р сард МАХН-ын УТТ-ны гишүүд бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорсон шүү дээ. Та энэ шийдвэрийн талаар ямар бодолтой байдаг вэ?

Б Н: Энэ бол маш зөв шийдэл байсан юм. Ийм шийдвэр гаргахад МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Ж.Батмөнх их үүрэг гүйцэтгэсэн юм. Тэр үед Улаанбаатар хотын төвд Сүхбаатарын талбайд залуучууд өлсгөлөн зарласан байлаа шүү дээ. МАХН-ын УТТ-ны зарим гишүүд огцрохоос эрс татгалзаж байсан юм. Тэд нар хүч хэрэглэж өлсгөлөнг тараах бодолтой байсан юм. Бас улс орны хэмжээнд онц байдлыг тогтоохыг санаархаж байсан юм билээ. Энэ саналыг эрс эсэргүүцсэн хүн бол тухайн үеийн Дотоод яамны орлогч сайд байсан

генерал Ц.Жамсранжав юм шүү дээ.

Тэр үед Ардчилсан хөдөлгөөнийг Монголын нийгэм бүхэлдээ дэмжиж байсан юм. Ийм үед хүч хэрэглэж өлсгөлөнд оролцож байгаа залуучуудыг хөөж тараавал маш аюултай байдал үүсэж болох байсан юм. 1989 онд Хятадын Тань-Ан-Мэний талбайд болсон хэрэг явдал Монголд давтагдаж болох байсан юм. Ийм хүнд нөхцөлд МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Ж.Батмөнх МАХН-ын УТТ-г бүрэн бүрэлдэхүүнээр нь огцруулах маш зөв шийдвэр гаргасан юм. Ж.Батмөнх бол өөрөө их зөөлөн хүн юм л даа. Ю.Цэдэнбалтай нутаг нэгтэй юм. Түүнийг Ю.Цэдэнбал өөрөө сонгож, дэвшүүлээд манай Ерөнхий сайдаар томилж байсан юм. Ж.Батмөнх бол багш хүн юм. Төрийн өндөр албан тушаал хашихад өөрөө тийм дуртай байгаагүй юм билээ. Ер нь багшийнхаа ажлыг л хийгээд явж байх бодолтой байсан юм шиг байгаа юм. МАХН-ын УТТ бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрох шийдвэрийг тэр бараг ганцаараа гаргасан байх.

КЮ: Монголд ардчилал шинэчлэл эхэлснээс хойш арван таван жил өнгөрлөө шүү дээ. Одоогийн байдал ямар байна даа.

Б Н: Ардчилсан хөдөлгөөн өрнөсөнөөс хойших арван таван жилд ардчилсан хүчнийхэн нэг удаа засгийн эрх авсан. Түүнээс бусад жилүүдэд нь МАХН засгийн эрхийг барьж байлаа. МАХН бол хэдийгээр алдаа дутагдал гаргаж байсан боловч боловсон хүчин сайтай, буурь суурьтай, ажлын арга барил туршлага сайтай нам юм. Гэхдээ одоо үеийн шаардлагад нийцэхгүй, асуудалд хуучин байдлаараа хандах явдлыг гаргаж байна. 2004 оны бүх нийтийн сонгуулиар ардчилсан хүчин бараг яллаа. Үнэн хэрэг дээрээ ялсан юм. Гэсэн хэдий ч МАХН-ын зүгээс булхайцаад, сонгуулийн дүнд засвар оруулах гэж санаархаад байна. МАХН, АН хоёр бол манай улс төрийн хоёр гол хүчин гэдэг нь тодорхой байна. Энэ хоёр тэнцвэртэйгээр засгийн эрхийг ээлжлээд барьж байвал сайн байна. Энэ хоёр нам бие биендээ дайсагналцаад, бие биенийгээ үгүйсгэж ердөө болохгүй. Сонгуулийн дүнгээр МАХН, АН хоёр засгийн газраа зөвшилцлөөр байгууллаа. Энэ л хамгийн зөв шийдвэр юм.

Гэхдээ ерөнхийлөгч Н.Багабанди бол ардчилсан хүчинд дургүй хүн. Н.Багабанди ерөнхийлөгч болсноор нийт ард түмний эрх ашгийг хамгаалсан бодлого явуулж чадсангүй. Тэр бол их зальтай хүн. Ардчилсан хүчнээс Да.Ганболдыг ерөнхий сайд болгосонгүй. Н.Багабанди бол Монголын Ардчилсан хүчинд ихээхэн саад хийсэн хүн шүү дээ. М.Энхсайхан бол ардчилсан хүчний нэрийг бариад том албан тушаалд очих бодолтой байдаг л хүн. Хамгийн муу санаатай хүн. Ардчилсан хүчний бүр хамгийн анхнаас нь эхлэн явсан хүмүүс бол Р.Гончигдорж,

Ц.Элбэгдорж нар юм л даа.

И Л: Саяхан Ерөнхийлөгчийн сонгууль болж өнгөрлөө. Энэ сонгууль хэрхэн явагдсан талаар манай чөлөөт хэвлэл дээр олон янзын үзэл бодол гарч байна. Та энэ сонгуулийн талаар ямар бодолтой байна вэ?

Б Н: МАХН-аас Ерөнхийлөгчийн сонгуульд нар дэвшээд сонгуульд оролцсон Н.Энхбаярын талаар олон түмний дунд их олон янзын яриа явдаг юм байна. Маш их мөнгө төгрөг, хээл хахуулийн хэрэгт холбоотой гэсэн яриа байдаг юм байна. Тухайлбал Орос улсад хуучин өрийг төлөхдөө дундаас нь “50 сая ам. долларыг үрэгдүүлсэн!” гэсэн нэг яриа тасрахгүй байна. Бас өөрийнхөө эмчилгээнд зориулж улсын төвлөрсөн төсвийн хөрнгөнөөс “50 сая төгрөг бэлнээр гаргуулж авсан!” гэсэн нэг яриа яваад л байна. “Эхнэр Цолмонгоо төрийн хэрэгт оролцуулдаг. Дотоод яаманд зөвлөгчөөр томилож байсан!” гэсэн яриа нийгэмд тасрахгүй оршсоор байна. “Эхнэр Цолмонг Дотоод яамны зөвлөгчөөр томилсон!” гэдэг ярианаас бусад нь баталгаа, нотолгоогүй яриа юм. Үнэхээр энэ бүх мөнгө төгрөгөнд Н.Энхбаяр өөрөө холбоотой юм уу? гэдгийг нь баримтаар нотлох хэрэгтэй шүү дээ. Нотлож чадахгүй бол энэ бүх яриа чинь хүнийг хоосон гүтгэсэн явдал болж байгаа юм. Ийм баталгаа нотолгоогүй яриаг таслан зогсоох хэрэгтэй.

Юмжаагийн Аюуш

- | | |
|----------------------------------|---|
| 1 Унасан газар, угаасан ус минь. | 6 Гадаад худалдаа бол миний мэргэжил. |
| 2 Ахтайгаа уулзсан минь. | 7 Би Гадаад худалдааны яамны орлогч сайд болов. |
| 3 Би хотын хүн боллоо. | 8 Манайх. |
| 4 Москвад. | 9 Бэргэн эгч А.И. Филатова. |
| 5 “Хоршоодын холбоо” – нд. | |

1 Унасан газар, угаасан ус минь.

Коногая Юүки (цаашид **КЮ**): Тантай уулзаж байгаадаа би их баяртай байна. Энэ удаагийнхаа ярилцлагыг таны бага насны дурсамжаас эхэлбэл ямар вэ? Та хэдэн онд, хаана төрсөн, өөрийн аав ээж, ах, эгч, дүү нарын тухай бидэнд ярьж өгнө үү?

Юмжаагийн Аюуш (цаашид **ЮА**): За тэгье. Би 1926 онд одоогийн Увс аймгийн Давст суманд төрсөн хүн. Манай гэр өвөлжөөн дээрээ байхад би төрсөн юм гэнэ билээ. Би ээжээсээ ихэр төрсөн юм гэнэ билээ. Миний ихрийн өрөөсөн нь төрснийхөө дараа нэг хоноод нас барсан юм гэнэ билээ. Манай ээж бол арван хоёр удаа төрсөн юм. Би арван нэгдэх хүүхэд нь юм.

Манайхан хавар ууландаа жаахан өгсөж хаваржаандаа буугаад, тариагаа тарьчихаад, зусландаа гардаг байсан юм. Заримдаа бид Увс нуурын хөвөөгөөр хаварждаг байлаа. Манай зуслангийн газар уулан дээр байна шүү дээ. Зуны цагт нам дор газар ялаа ихтэй, халуун учир манайхан дандаа ууландаа гарч зусдаг байсан юм. Манай зусланд Хандгайтын голоор дээшээ өгсөж очдог юм. Манай зуслан бол зуны цагт их сайхан сэрүүхэн, өвс ногооны гарц сайтай газар юм л даа.

Их Тагнын уулнаас олон гол эх авдаг юм. Тэдний хоёр сайхан гол нь манай сумын нутаг дээгүүр өнгөрдөг юм. Нэг нь Хандгайтын гол, нөгөө нь Тарханын гол юм.

Манай нутгийн уулнууд давс ихтэй юм. Жамц давс шүү дээ. Манай тэндхийн бүх ууланд давс байдаг юм. Маш их давстай “Давст уул” гэж сайхан уул байдаг юм. 1966 онд Монгол, Зөвлөлтийн засгийн газар хооронд хилийн тухай гэрээ байгуулагдсан юм. Энэ гэрээгээр тэр уулын нэг хэсэг нь ЗХУ-ын нутаг болчихсон юм. Наад талын хэсэг нь манайдаа байгаа юм. Оросууд өөртөө орсон талаас нь давс авдаг болсон юм. Манайхан ч наад талын хэсгээс нь урьдын адил давс авсаар л байгаа юм.

Бид нар очоод газрыг нь жаахан ухаад, сүхээр цохиход том дөрвөлжин хэлбэртэй давс хагарч ирдэг юм. Манайхан ингэж авсан давсаа бүтэн жил хэрэглэдэг байлаа шүү дээ. Маш сайн чанарын давс байдаг юм.

КЮ: Танайх ямар тариа тарьдаг байв даа?

ЮА: “Ячмень” гэж оросоор нэрлэдэг тариа юм шүү дээ. Энэ бол улаан арвай юм. Айл бүрийн тариа тарьдаг талбай нь том, жижиг янз бүр л байна шүү дээ. Нэг газарт ойрхон, ойрхон олон айлын тариан талбай байдаг юм. Хавар тариагаа тарьчихаад, зусландаа гарсны дараа хорь хоног тутамд айлууд ээлжээр ирж, талбайгаа усалдаг байлаа. Тариан талбай руугаа усалгааны шуудуу татсан байдаг юм. Тэр шуудууг нь ариг гэж нэрлэдэг юм.

Тэр үед айл бүр тээрмийн чулуутай байлаа. Тэр бол дугуй хэлбэртэй хоёр чулуу юм. Тэр хоёр чулууг давхарлаж тавиад, дээд талын чулууг нь эргүүлээд байдаг юм. Хоёр чулууныхаа хооронд нь тариагаа хийнэ шүү дээ. Ингэж гурил хийдэг юм. Сайхан гурил гарна шүү дээ. Манайх голдуу тариа тарьж амьдардаг айл байлаа. Мал бол байсан л даа. Малын хажуугаар тариа тарьж амьдардаг байлаа. Ганцхан манайх ч биш манай нутгийн айлууд голдуу л тариа тарьж амьдарч байсан юм. Манай сумын зэргэлдээ байдаг Сагил сумынхан бас л тариа тарьж амьдардаг байлаа.

КЮ: Танайх олон малтай байсан уу?

ЮА: Манайх хонь ямаа зуун тавь орчим, үнээ 4-5, тэгээд 3-4 шартай айл байсан юм. Манай нутагт айлууд гэрийнхээ эд хогшлыг шар үхэрт ачаад, түүнийг сул тавьж туугаад явдаг юм. Энэ аргыг чинь “сул ачих” гэдэг юм. Шар үхэр цөөнтэй айл бол өөр айлаас нэг, хоёр шар үхрийг нь гуйж авдаг байсан юм. Олон хүүхэдтэй айлын амьдрал бол ядуувтар байна шүү дээ. Тийм айл өөр айлаас шар үхэр авч хэрэглэх нь элбэг байсан юм. Олон малтай баян айлууд манай нутагт нилээд байсан юм.

Тариаг баян айл ч тарина, ядуувтар айл ч тарьдаг л байлаа. Айл бүгд л тариатай байлаа шүү дээ. Хавар тариа тарих, намар тариа хураахад хийх ажил их байдаг юм. Ийм үед манай нутгийнхан бие биендээ сайн дураараа тусалдаг юм. Нутгийн хүмүүс ирж ажилд нь туслах үед тэр айл ямаа, эсвэл хонь төхөөрч, сайхан хоол хийж, тэднийг дайлдаг уламжлалтай юм.

Манай нутагт тарьсан тариагаа гар аргаар хадаж авдаг юм. Тэгээд түүнийг хэсэг хэсгээр нь бөөгнүүлж тавиад байдаг юм. Ингэж хураасан тариагаа хатаадаг юм. Тариа хатсаны дараа түүнийг цайруулах ажил эхэлнэ. Тариа цайруулдаг тусгай газар байдаг юм. Цайруулсан тариагаа

бас хэсэг хэсгээр нь овоолдог юм. Тэгээд түүнийг салхи ихтэй үед хүрэээр бага багаар өөд нь цацаад, буцааж овоолно. Ингэж тариагаа хатсан өвс, хогноос нь цэвэрлэдэг юм.

Манай нутгийн баруун талаар оршин суудаг урианхай нар дөрвөд хэлээр сайн ярьдаг юм. Тэд нар бас тариа тарьдаг байлаа. Тэд нар манай нутагт ирээд, айлуудаар ороод шимийн архи уугаад буцдаг байлаа. Тэд нарын амьдрал манайхаас онцын ялгаа байхгүй л дээ. Ер нь ижил шүү дээ. Тэд нар өөрсдөө бас тогоо нэрж шимийн архи хийнэ шүү дээ. Ааруул бас хийнэ. Гэхдээ урианхай нар манай нутгийн ардуудыг бодвол мал багатай байсан юм.

Манай сум бол засаг захиргааны хуучин хуваариар Дөрвөд Далай хан аймгийн Зоригт хааны хошуу юм. Миний эцэг тэгж ярьдаг байсан юм. Уг нь бол дөрвөд зон одоогийн Сэлэнгэ аймгийн Хиагт хавиар нутаглаж байсан юм шиг байгаа юм. Би сайн мэдэхгүй л дээ. Тэгээд Дөрвөд далай хаан тэднийг нүүлгэж Увс нуурын хойд талаар нутаглуулсан юм гэнэ билээ. Тэнд тариа ногоо тариалах боломж сайтай байсан учир дөрвөд зоныг нүүлгэсэн юм шиг байгаа юм. Дөрвөд зон хуучин нутагтаа байхдаа бас тариа ногоо тарьж байсан байж магадгүй. Дөрвөд зон тийшээ чухам хэдийд нүүж ирснийг би мэдэхгүй л дээ. Бараг зуу гаран жилийн өмнө нүүсэн байж магадгүй.

Манай ээж ах, дүү гурвуулаа юм. Манай ээж хамгийн том эгч нь юм. Түүний дараачийн эрэгтэй дүүг нь Чимэдцэрэн, хамгийн бага охин дүүг нь Дэвээ гэдэг байсан юм. Манай ээжийн дүү нар нь манайхтай ойрхон нутаглаж явдаг байсан юм. Чимэдцэрэнгийнх ганцхан хүүхэдтэй айл байсан юм. Тэднийх миний дээд талын ахыг өргөж авсан юм. Манайх ах дүү олуулаа шүү дээ.

1920-оод оны сүүлчээр баян чинээлэг хүмүүсийн хөрөнгийг хураасан шүү дээ. Тэр үед миний ээжийн дүү Чимэдцэрэнг баривчилсан юм. Тэднийх олон малтай баян айл байсан учир баривчилсан гэдэг юм. Түүнийг “Улаангомьн шорон”-д хорьж байсан юм билээ. Тэгээд Улаангомьн ойролцоо газар буудаж алсан байгаа юм. Тэдний бүх малыг нь хураагаад авчихсан юм. Түүнээс хойш Чимэдцэрэн ахын сүүлчийн эхнэр нь нас барсан юм. Ингээд манайхаас өргөж авсан миний ах гэртээ эргээд ирж байсан юм. Тэгээд тэр хэдэн жилийн дараа цэргийн албанд татагдсан юм. Цэргээс халагдсаны дараа Улаанбаатарт амьдарч байгаад саяхан нас барлаа.

Миний аав бол бас ах, дүү гурвуулаа юм. Тэр дээрээ нэг эгчтэй, доороо нэг дүүтэй хүн. Тэд нар бүгд нутагтаа малаа маллаад амьдарч явлаа. Манай нутагт олон хүүхэдтэй айл бол өөрийн хүүхдийг өөр айлд өргүүлэх явдал нилээд байсан юм. Өөрийн ах, дүү төрөл садангийн айлдаа

голдуу хүүхдээ өргүүлдэг байлаа. Цөөхөн хүүхэдтэй айл л өөр айлаас хүүхэд өргөж авна шүү дээ. Ах, дүү төрөл садангийн холбоо байхгүй ч гэсэн хүүхдийг нь өргөж авах хүсэлтэй айл байвал өргүүлчихдэг юм.

Би өөрийн ах Цэдэнбалыг ерөөсөө мэддэггүй байлаа шүү дээ. Тэр намайг төрж байх үед л Улаангомд бага сургуулийн хоёрдугаар ангийг төгсөөд Ховд руу явсан юм билээ. Тэнд бага сургуулийн дөрөвдүгээр анги төгссөн юм билээ. Тэндээс Улаанбаатарт сургуульд явжээ. Түүнийг Улаанбаатарт ирэхэд нь өөр аймгаас ирсэн олон хүүхэдтэй хамтаар шууд л Орос улсад сургуульд явуулжээ. Эхлээд Улаан-Үдэд сурч байсан юм шиг байгаа юм. Тэгээд дараа нь Эрхүү хотод очсон юм байх. Тэнд их олон сургуульд сурч байсан юм шиг байгаа юм. Хүн эмнэлэгийн техникумд сурч байсан гэдэг яриа ч байдаг юм. Тэгээд Эрхүү хотод Санхүүгийн дээд сургуульд орсон юм шиг байгаа юм. Ингээд нийтдээ 10 жил орчим тэр алга болчихсон юм шүү дээ. Бидэнд захидал ч байхгүй, ямар ч хэл мэдээ ирдэггүй байлаа шүү дээ. Ахын тухай бидэнд ээж л ярьдаг байлаа.

Манай аав 1930-аад оны сүүлчээр нас барсан юм. Тэр манай сумын хөрш зэргэлдээ Сагил сум руу явж, нэг хүнээс хуучин өрөө нэхсэн юм шиг байгаа юм. Тэндээс эргэж ирээд л бие нь муудаад байсан. Тэгээд хоёр хоноод л нас барчихсан юм. Одоо бодоод байхад мухар олгой туссан юм шиг байгаа юм.

2 Ахтайгаа уулзсан минь.

КЮ: Та өөрөө хэзээ сургуульд орсон юм бэ?

ЮА: Намайг 12-13 орчим настай байхад манай сумын төв дээр нэг түр сургууль байгуулагдсан юм. Тэнд голдуу олон хүүхэдтэй айлын хүүхдүүд очиж сурдаг байлаа. Би тэнд хоёр зун очиж сурсан шиг санагдаад байна. Тэгээд монгол бичгээр бичдэг, дөрвөн аргын тоог боддог болсон юм. Тэр үед бичиг үсэг мэддэг, дөрвөн аргын тоо боддог хүмүүсийг дайчлаад мал тооллогонд явуулдаг байлаа. Би бас мал тооллогын ажилд дайчлагддаг боллоо.

Энэ үед миний ах Цэдэнбалын сураг анх удаа гарсан юм. Үүнээс өмнө түүний тухай бид нар юу ч мэддэггүй байлаа. Бид нар “Манай ах хэзээ гэртээ ирэх юм бол доо?” гээд л ярьдаг байлаа. Тэр Эрхүү хотноо дээд сургууль төгсөөд, Улаанбаатар хотод Санхүүгийн техникумын хичээлийн эрхлэгчээр томилогдсон юм байж. Манай ах тэнд хагас жил орчим ажилласан юм шиг байгаа юм. 1939 оны үед билүү дээ, би сайн санахгүй байна, манай ах бидэнд хүнээр мөнгө явуулж байсан юм. Бас “Удахгүй гэртээ харина!” гэж хүнээр хэлүүлсэн байсан юм.

Тэр үед аав нас барсан байлаа. Гэсэн ч тэр гэртээ ирээгүй юм. Дайн эхлээд ирж чадаагүй юм билээ. 1939 онд Монгол-Японы дайн эхлэхээс өмнөхөн ахыг гэнэт Монгол банкны даргаар томилсон юм байж. Дайн эхлэнгүүт манай засгийн газар дайны ар талын албыг ахад хариуцуулсан юм байж. Дайнд орж байгаа цэргүүдийг хоол хүнс, хувцас хунараар хангах ар талын бүх л ажлыг хариуцуулсан юм байна л даа.

Тэр үед Зөвлөлт Хобоот Улс (ЗХУ)-аас Монгол улсад суугаа элчин сайд В.Иванов гэдэг хүн байж. Манай ах энэ хүнтэй хамт дайны ар талын албаны ажлаар Сүхбаатар, Хэнтий, Дорнод аймгуудаар явдаг байж. Манай ах энэ аймгуудаас цэргийн хүнс авдаг байсан юм шиг байгаа юм. Цэргийн зэвсэг, техник нь ЗХУ-аас ирсэн юм болов уу даа. Бас ЗХУ-ын цэрэг ч ирсэн бололтой юм билээ. Ах тэнд жил орчим ажилласан байх. Тийм их удаагүй л юм шиг байгаа юм.

Ингээд байлдааны ажиллагаа зогсжээ. Би энэ бүгдийг хожим мэдсэн юм. Ингэж байтал Монгол Ардын Хувьсгалт Нам (МАХН)-ын 10-р их хурал хуралдсан юм билээ. Энэ хурлаар ахыг МАХН-ын Төв Хорооны (ТХ)-ны Ерөнхий нарийн бичгийн даргаар сонгосон юм байж.

КЮ: Энэ хэдэн он бэ?

ЮА: Энэ бол 1940 он шүү дээ. Манай ах Монгол банкны захиралаар томилогдоод, дараа нь Сангийн яамны орлогч сайдаар томилогдсон юм байж. Тэгээд “Нэг удаа хөдөө ажлаар явж байгаад эргээд ирсэн чинь Сангийн яамны жинхэнэ сайдаар томилсон байсан!” гэж ах ярьдаг юм.

1940 онд МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн даргаар сонгогдсоны дараа ах гэртээ ирсэн юм. Ах гэртээ эргэж ирдэг тэр өдөр би хонио хариулж явж байгаад орой хонио гэрийнхээ ойролцоо аваад иртэл манай гадаа гоё хар машинтай хүмүүс ирчихсэн байсан юм. Би ямар хүмүүс манайд ирснийг мэдээгүй тул гэртээ бараг гүйх шахам явсаар ирлээ. Гэтэл миний ах ирсэн байж. Тэр өдөр хонио хол явж хариулсан тул нилээд ядарч ирсэн байх л даа, амархан унтчихсан юм. Би ингэж анх удаа ахтайгаа уулзсан юм. Би 14 настай байсан. Би тэр үед Улаанбаатарт ирсэн бол ахтайгаа уулзах л байсан байх. Манай ах чинь арван жил ямар ч хэл, сураггүй байж байгаад гэртээ эргэж ирсэн юм шүү дээ. ЗХУ-д сурч байхдаа Улаанбаатарт ирээд бас жаахан ажил хийж байгаад буцдаг байсан юм шиг байгаа юм. Манай ээж л “Ах чинь ЗХУ-д сургуульд явсан юм шүү!” гэж ярьдаг байлаа. Бидэнд бол ямар ч захиа, хэл сураг ирдэггүй байлаа. Их эхцүү үе шүү дээ. Тэр үед шуудан, харилцаа холбоо байхгүй байлаа шүү дээ. Зөвхөн морин өртөө л ажилладаг байлаа. Морин өртөө Улаанбаатар хүртэл явж байсан юм уу? Үгүй ч юм уу? Бүү мэд Тэр үед энэ талаар мэдэх

юм огт байхгүй байлаа.

Намайг анх харахад манай ах костюмтай байсан юм. Тэр үед костюмыг “орос хувцас” гэдэг байлаа шүү дээ. Тэр үед маршал Х.Чойбалсан бас албан ажлаар баруун аймгуудаар явахаар болсон юм билээ. Ах гэртээ ирээд хоёр, гурав хонож байтал Х.Чойбалсан манай гэрт хүрээд ирлээ. Х.Чойбалсантай хамт их олон хүн явж байсан юм. Манай гадаа арваад машин ирсэн байх. Би хонио хариулаад, орой гэртээ эргэж иртэл манай гадаа эрээн майхан барьчихсан, олон машин ирчихсэн байлаа. “Маршал Х.Чойбалсан, ЗХУ-ын элчин сайд нар ирсэн!” гээд л хүмүүс ярьж байлаа. Тэд нар намайг хонио хариулахаар явсны дараахан өглөө нилээд эрт манай гадаа ирсэн юм шиг байгаа юм. Тэгээд манай багийн ардуудыг цуглуулаад МАХН-ын 10-р их хурлаас гаргасан шийдвэрийн талаар ярьж өгсөн юм билээ.

Тэд нар манай ээжид жаазанд хийсэн манай ахын нэг сайхан зургийг бэлэглэсэн юм. Маршал Х.Чойбалсан тэр зургийг манай ээжид гардуулж өгөхдөө “Та бол МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн даргыг төрүүлж өгсөн их гавъяатай хүн шүү. Танд танай хүүгийн чинь зургийг өгч байна!” гэж хэлсэн юм. Тэд нартай хамт манай гэрт манай аймгийн дарга ирсэн юм. Х.Чойбалсантай хамт манайд ирсэн олон хүмүүс өглөө намайг босоход бүгд явчихсан байлаа.

КЮ: Та ахтайгаа анх удаа уулзаад юу ярих даа?

ЮА: Үгүй, үгүй би юм яриагүй шүү. Би тэр үед хүүхэд байлаа шүү дээ. Юугаа ч ярих юм билээ дээ. Би чинь тэр үед хонь хариулдаг л хүүхэд байлаа. Тэр үед манай ах, ээж хоёрын хооронд нэг яриа болсон юм шиг байгаа юм. Чухам хэн нь эхлэж тэр яриаг хийснийг би мэдэхгүй. “Энэ дүүгээ сургуульд сургах юмсан!” гэсэн яриа болсон юм шиг байгаа юм. Ээж эхлэж ярьсан юм болов уу даа. Тэгээд нэг өглөө ах “Одоо Ховд аймаг орно!” гэж хэлээд, намайг өөрийн машинд суулгаад л аваад явсан юм.

Бид нар Увс аймгийн төв дээр нэг хоноод, цааш яваад Ховдод ирсэн юм. Гэтэл тэнд Х.Чойбалсан бас хамт яваа хүмүүстэйгээ ирлээ. Ингэж бид нар тэнд цугласан юм. Тэгээд Ховдоос бүгдээрээ хамтаараа Улаанбаатарын зүг хөдөллөө. Гэтэл замдаа бид нар маш удаан явлаа. Замдаа тааралдсан сум болгонд л ардуудтай уулзалт, яриа зохиож явлаа. Ярьдаг юм нь МАХН-ын 10-р их хурлын тухай л байсан юм. Бид нар бараг хоёр долоо хоног яваад наадмын өмнө Улаанбаатар хотод орж ирж байлаа шүү дээ.

Тэр үед манай ах эхнэр авч гэрлээгүй байлаа. Тэр Монгол банкны хоёр давхар байшингийн 2-р давхарт ганцаараа амьдардаг байлаа. Би

түүнтэй хамт амьдрахаар боллоо. Ах тэр үед хөдөө их явдаг байлаа. Ингэж явахад нь түүнтэй хамт нэг комиссар явдаг юм. Тэр комиссар нь буутай байна л даа. Ингээд жолоочтойгоо нийлээд гурван хүн болно шүү дээ. Тэд нар нэг удаа явахдаа бараг л хорь орчим хоног явна шүү дээ. Заримдаа бараг сар болно доо. Ахыг ингээд ажлаар хөдөө явахад би гэртээ ганцаараа үлддэг байлаа.

Би зун наадам болох гэж байхад Улаанбаатарт орж ирсэн шүү дээ. Намар болтол би ийм амьдралаар амьдарч байлаа. Хоол, ундаа өөрөө л хийж иднэ шүү дээ. Бас ах явахдаа хоол, хүнсэнд хэрэглэх мөнгө өгсөн юм. Тэгээд би тэр мөнгөөр нь гуанзанд ороод хуушуур авч иддэг байлаа. Тэр үед нэг төгрөгөнд 10 ширхэг хуушуур өгдөг байлаа шүү дээ. Мөнгөний ханш бол сайн байсан байгаа юм шүү. Одоо бол нэг хуушуур 130-140 төгрөг болсон байна. Би тэр арван хуушуурыг нь барахгүй шүү дээ. Би 3 хуушуур идээд л цадчихдаг юм. Үлдсэн хуушууруудаа гэртээ авч ирээд тавьчихна. Тэгээд өглөө оройд нь түүнийгээ иддэг байлаа.

Би ахыг хөдөө явсны дараа ганцаараа их уйдна шүү дээ. Тэгээд нэгдүгээр давхарт байгаа Монгол банканд дээр очдог боллоо. Тэнд олон хүн ажилладаг байлаа. Тэгээд тэндхийн залуучуудтай, охидуудтай танилцлаа. Тэнд өдөр болгон л ордог байлаа. Ингээд тэдэнтэй сайн танилцаад ирэх үед тэд нар надад ямар нэгэн бичиг өгөөд “Үүнийг тэр хүнд аваачаад өг!” гээд янз бүрийн бичиг өгдөг боллоо. Би хийх ажилгүй, завтай хүн болохоор ийм бичигнүүдийг ийш тийш нь зөөдөг боллоо. Ингээд өдөрт нь Монгол банканд дотор бичиг, цаас ийш тийш нь сайн дураараа зөөдөг ажилтай боллоо. Цаг хурдан өнгөрч уйдаагүй боллоо.

3 Би хотын хүн боллоо.

КЮ: Та анх Улаанбаатар хотод орж ирэхэд ямар санагдаж байв даа?

ЮА: Өө, мэдэхгүй. Би хөдөөнөс орж байгаа болохоор мэдэх юм огт байхгүй шүү дээ. Нэг л их олон хүнтэй л хот байсан шиг санагдаж байна.

1940 онд буюу Зөвлөлт-Германы дайны урд жил би Улаанбаатарт орж ирсэн юм шүү дээ. Иймэрхүү байдлаар амьдарч байтал манай ах Цэдэнбал нэг өдөр “Би өөрийн ажиллаж байсан техникумд чамайг оруулна!” гэж байна шүү. Би ч юм хэлсэнгүй. Тэгээд удалгүй тэр өөрөө дахиад хөдөө явчихлаа. Тэгтэл нэг өдөр ахын жолооч нь ирээд “Одоо хоёулаа ахын чинь сургууль дээр очно!” гэж байна. Ингээд би түүний машинд нь суугаад ахын сургууль руу явлаа. Ахын өөрийн ажиллаж байсан сургууль нь Санхүүгийн техникум шүү дээ. Монгол банкнаас Санхүүгийн техникум хүртэл нилээд хол юм. Тэнд очтол хичээлийн эрхлэгч нь байсангүй. Ингээд

бид хоёр түүнийг жаахан хүлээлээ. Тэр ирсэнгүй. Тэгээд хоёулаа манай гэр лүү буцлаа. Ингээд буцаж явж байгаад “Бөмбөгөр ногоон театр” хүрээд би тэр жолоочид “Би энэ сургуульд сурч чадахгүй юм байна. Энэ сургууль манай гэрээс их хол юм байна шүү дээ. Би Бөмбөгөр ногоон театр, Монгол банкны байшингаас өөр газар мэдэхгүй. Би хөдөөний хүн. Ийм олон байшингуудыг сүлжээд явж чадахгүй!” гэж хэллээ. Ингээд тэр өдрөөс хойш хэд хонолоо.

Тэр үед манай ах гурван жолоочтой байсан юм. Нэг өдөр өөр нэг жолооч ирээд “За, одоо чамайг би аваад явна. Хоёулаа өөр сургууль дээр очно!” гэж байна. Ингээд бас л түүний машинд нь суугаад явлаа. Бид нар явсаар байгаад нэг уулын бараг орой дээр нь гарлаа. Тэнд очоод нэг байшинд орлоо. Хүмүүс нь ёслоод л нэг л өөр байна шүү. Бид нар цэргийн сургууль дээр ирсэн юм байж. Тэнд надаар дөрвөн аргын тоо бодууллаа. Бас монгол бичгээр юм бичүүлж байна. Надаас шалгалт авсан юм байж. Тэнд бид хоёр их удсан юм. Тэгээд л тэндхийн багш нартай уулзаж эхэллээ. Олон ч багштай уулзлаа. Тэгээд “Одоо л дууссан байх!” гэж бодоод хаалга руу явах гэтэл нэг хүн “Явах болоогүй шүү! Тэр хананд очоод зогсож бай!” гэж хэллээ. Тэгээд түүний заасан хананд нь очоод л зогслоо. Тэгтэл тэр хананд улаан тууз татсан байна. Тэр туузанд миний өндөр, нам таарах ёстой юм байж л дээ. Гэтэл түүнд миний нуруу хүрдэггүй. Тэгтэл нөгөө багш “Энэ нөхрийн нуруу нь таарахгүй байна шүү дээ. Больё, больё!” гэж хэллээ. Ингээд би тэр цэргийн сургуульд гологдчихлоо. Энэ өдрөөс хойш манай ах “Монгол банкны байшингийн ойролцоо ямар сургууль байгааг судлаж үзээд түүнд оруул!” гэсэн даалгавар өгсөн юм байна л даа.

Монгол банк бол одоогийнхоо энэ л байшиндаа байсан юм шүү дээ. Нэг өдөр ахын бас нэг жолооч нь ирлээ. Би түүний машинд суугаад л явлаа. Монгол банкны байшингаас баруун тийш их ойрхон газарт “Өндөр хоршоо” гэж нэрлэдэг их дэлгүүр байсан юм. Тэр Өндөр хоршооны хажуугаар гараад явж байтал замын урд талд нь “Худалдааны техникум” гэсэн хаяг харагдлаа. Би жолоочийг зогсоогоод “Энд орж үзье!” гэж хэллээ. Ингээд бид хоёр тэр байшинд орлоо. Тэнд ороод бас шалгалт өглөө. Би наймдугаар сарын 25-ны орчим тэр шалгалтыг нь өгсөн юм шиг байгаа юм.

Хичээл бол 9-р сарын 1-нд л эхэлнэ шүү дээ. Надтай хамт явсан жолооч “Энэ бол Хоршоодын холбооны харъяа сургууль байна! Хоршоодын холбоо бол Монгол улсын бүх худалдааг хариуцдаг газар шүү!” гэж хэлж байна. Бид хоёр тэр өдөр шалгалтаа өгчихөөд тэндээс явлаа. Маргааш нь дахиад ирлээ. Тэнд “Ямар ангид орох вэ?” гэж асууж байна. Манай жолооч “Ямар анги байна?” гэж асуулаа. Гэтэл барааны анги гэх мэтээр олон анги нэрлэж байна. Би хөдөө байхдаа санпингаар

хүмүүс тооцоо бодож байхыг мэдэх юм. Мал тооллогын үеэр хөдөө нутагт санпин их хэрэглэдэг юм. Би мал тооллогын ажилд дайчлагдаад явж байсан шүү дээ. Мал тооллогын ажлаар ирсэн манай сумын нягтлан бодогч нар сампинг шажигнуулаад л тооцоо хийнэ шүү дээ. Би өөрөө тэр үед сампингаар тооцоо хийж сураагүй л дээ, гэхдээ сампингаар тэдэн шиг тооцоо хийж сурхыг боддог байсан юм болов уу даа, мэдэхгүй. Тэгээд би “Санпин цохидог ангид орё!” гэж хэллээ. Багш нар нь инээлдэж байна. Ингээд тэр сургууль намайг авахаар боллоо.

Бусад хүүхдүүд арван жилийн сургууль төгсөөд ирсэн байна. Би бол арван жилийн сургууль төгсөөгүй шүү дээ. Нутагтаа байхдаа түр сургуульд л хоёр зун ч билүү дээ, сурсан юм. Тийм учраас намайг үндсэн ангид оруулсангүй, бэлтгэл ангид орууллаа. Ингээд нэг жил бэлтгэл ангид сураад, үндсэн ангидаа дөрвөн жил сураад төгссөн юм. 1944 оны хавар сургуулиа төгсөөд Хоршоодын холбоонд ажилд орлоо. Би дансны байцаагч гэдэг ажил хийж байсан юм. Тэнд би 3 жил ажиллаа.

4 Москвад.

ЮА: 1946 оны намар Хоршоодын холбооны шугамаар 3 хүнийг Москвад Худалдааны дээд сургуульд явуулсан юм. Тэдний тоонд намайг багтаалаа. Ингээд Москва явлаа. Москвад очоод Монголын элчин сайдын яаман дээр хэд хонолоо. Тэгээд Москвагийн Худалдааны дээд сургуульд сурахаар боллоо.

Гэтэл нэг асуудал босож ирлээ. Намайг “Арван жилийн боловсрол эзэмшээгүй хүн байна. Үндсэн ангид орж болохгүй!” гэсэн хариу ирлээ. Тэр сургуулийн ойрхон ЗХУ-ын Хоршоодын холбооны төв байр байсан юм. Би тэнд Монголын Элчин сайдын яамны хүнтэй хамт очлоо. Тэнд сургуулийн асуудал хариуцсан хүнтэй уулзлаа. Тэр хүн “Та нар жаахан хүлээж байна уу? Би хэд хоногийн дараа хариу өгнө!” гэж байна. Ингээд тэндээс шийдвэр ирэхийг хүлээгээд хэд хонолоо. Тэгж байтал “Худалдааны техникумын бэлтгэл ангид суралцуулна!” гэсэн шийдвэр ирлээ. Ингээд Москвагаас хорь гаруй км-т байдаг Худалдааны техникумын бэлтгэл ангид суралцахаар боллоо.

Надтай хамт ирсэн нэг хүн нутагтаа байхдаа түүхийн эдийн мэргэжилтэн байсан юм. Тэр хүн “Заавал түүхий эдийн ангид орно. Өөр ангид орохгүй!” гэсэн асуудал тавьсан юм. Гэтэл бидний очсон тэр сургуульд түүхий эдийн анги угаасаа байхгүй юм байж. Ингээд тэр хүн түүхий эдийн ангитай сургуульд сурахаар Эрхүү хот руу явчихлаа. Нөгөө нэг хүн нь санхүүгийн мэргэжилтэн байсан юм. Тэр хүн бас “Заавал санхүүгийн ангид орно!” гэж зүтгэлээ. Хэсэг хугацаа өнгөрсний дараа

сургуулийн захиргаа түүнийг санхүүгийн ангид орохыг зөвшөөрлөө. Ингээд бүх юм жигдэрч ирлээ. Ингээд бид нар тус тусын сургуульдаа суралцаж байтал нөгөө санхүүгийн ангид орсон хүний бие нь муудаад нутаг буцлаа. Ингээд би Москвад ганцаараа үлдсэн юм. Тэр үед би Худалдааны техникумын суралцагсад зориулсан байранд сургуулийнхаа ойрхон газарт амьдарч байсан юм. Тэндээс би байсхийгээд л Монголын Элчин сайдын яаман дээр очдог байлаа. Хагас жил орчим сурчихлаа. Тэр үед нэг удаа Монголын Элчин сайдын яаман дээр очсон юм. Тэгтэл Элчин сайдын яамны нарийн бичгийн дарга “Чи одоо тэр техникумд суралцаад хэрэггүй. Өөрийн хувцас, номоо аваад Элчин сайдын яаман дээр хурдан ир!” гэж байна. Би ч хурдан байрандаа буцаж очоод, өөрийн бүх юмаа аваад ирлээ. Тэгтэл Элчин сайдын яамны нарийн бичгийн дарга “Чи одоо энэ байранд амьдарч бай!” гээд нэг айлын байр надад өгч байна. Тэр байранд байсан айл нь хаашаа явсан юм бэ? Бүү мэд Монгол руу буцсан байж магадгүй. Ингээд би тэр байранд ганцаараа амьдардаг боллоо. Тэнд би дараа жилийн намар хүртэл амьдарсан юм.

Дараа жилийн намар 8-р сарын эхээр л байх, нэг өдөр Элчин сайдын яамны нарийн бичгийн дарга “Одоо хоёулаа Худалдааны дээд сургууль дээр очно!” гэж байна. Ингээд би түүнийг дагаад явлаа. Тэнд очоод бид хоёр сургуулийн захиралтай нь уулзлаа. Намайг тэр сургуульд элсүүлж авахыг хүссэн бичгийг бид хоёр Элчин сайдын яамнаас авч очсон юм. Захирал тэр бичгийг уншиж үзэж байна. Тэгээд “Та нар жаахан хүлээж байгаарай. Бид удахгүй хариу өгнө!” гэж хэлж байна. Ингээд түүнээс хойш хэдэн өдрийн дараа Элчин сайдын яамны нарийн бичгийн дарга “Одоо удахгүй Худалдааны дээд сургуулийн элсэлтийн шалгалт эхлэх юм байна. Тэр сургуульд ЗХУ-ын бүх Бүгд найрамдах улсуудаас хүүхдүүд ирдэг юм. Чи тэдэнтэй хамт элсэлтийн шалгалт өгнө шүү!” гэж байна. Ингээд би шалгалтанд бэлтгэх хэрэгтэй боллоо. Би чинь ерөөсөө наймдугаар анги ч төгсөөгүй хүн шүү дээ. Тэр үед ЗХУ-ын Москва хотод дээд сургуульд суралцахаар ирсэн монгол хүүхдүүд заавал Элчин сайдын яаман дээрээ ирдэг байлаа. Тэднээс ганц хоёр хүүхэдтэй танилцаж авлаа. Тэд нар бүгд 10-р анги төгссөн хүүхдүүд шүү дээ. Ингээд тэдний заримаар нь тоо бодлогын хичээл заалгадаг боллоо.

Тэгтэл Худалдааны дээд сургууль өөрөө элсэлтийн шалгалтанд орох хүүхдүүдэд зориулсан давтлага-семинар зохион байгуулж эхэллээ. Намайг тэр семинарт Элчин сайдын яамны нарийн бичгийн дарга оруулж өглөө. Тэр сургууль дээр элсэлтийн шалгалтыг ямар, ямар хичээлээр авахыг урьдчилаад зарласан байна. Би өөрөө ямар, ямар шалгалт өгөх ёстойгоо мэдэж авлаа. Ингээд ижил шалгалт өгөх хүүхдүүдтэйгээ танилцаж авлаа. Тэд нар ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтдаг Бүгд найрамдах улсуудас ирсэн

хүүхдүүд шүү дээ. Ингэж явсаар байгаад би гол, гол шалгалтуудаа амжилттай өгчихлөө.

Ингээд хамгийн сүүлд ЗХУ-ын Коммунист намын түүхийн шалгалт өгөхөөр боллоо. Бусад хүүхдүүд энэ шалгалтыг нутагтаа байхдаа өгсөн юм байна. Ингээд шалгалт авахаар тогтоосон өдөр нь ирлээ. Багш надаас хэдэн асуулт асууж байна. Би хариуллаа. Тэгтэл багш:

-Чи хувийн малтай юу? гэж асууж байна.

-Би өөрөө хувийн малгүй. Манай аав, ээж хувийн малтай! гэж би хариуллаа. Гэтэл тэр багш:

-Кто ты такой? гэж асууж байна. Би энэ асуултанд хариулах гээд чадсангүй. Надаас “Чи хувийн аж ахуйтан мөн үү? гэж асууж байгаа юм болов уу? Хувийн аж ахуйтныг энэ сургууль авдаггүй юм болов уу?” гэж би дотроо бодлоо. “Хувийн аж ахуйтан” гэдэг үгийг “Единоличник” гэж орчуулж болдог шүү дээ. Тэгтэл өөр нэг багш дахиад:

-Кто ты такой? гэж асууж байна. Тэгээд би хэлэх үггүй болоод зогсож байлаа.

Тэгтэл надтай хамт тэр шалгалтанд орсон нэг охин “Марксист!” гээд зөөлхөн хэлэхийг нь сонслоо. Тэгээд би:

-Я марксист! гээд чанга хэллээ. Тэгтэл:

-О, молодец! гээд миний “зачётная книжка”-г аваад шууд дүн тавьж байна. Би “Единоличник” гээд хариулчихсан бол яах ч байсан юм билээ? Бүү мэд. Надаас “Чи одоо ямар үзэл суртлаар хүмүүжиж байна?” гэж асуусан юм шиг байгаа юм.

Тэр үед манай сургуульд бүр Орос улс хаант засагтай байх үеийн багш нар багшилдаг байсан юм. Тийм хүмүүс л худалдааг жинхэнэ утгаар нь ойлгоно, бас мэднэ шүү дээ. Дэлхийн худалдааны асуудлыг Англи улсын худалдааны жишээн дээр тайлбарладаг байлаа. Олон улсын зах зээл дээр барааны үнэ хэрхэн тогтож байдаг тухай бас ярина. “Бараа бүтээгдэхүүний үнэ Английн алтны үнэнээс хамааралтай байдаг. Нефьтийн үнэ ч бас түүнээс хамаардаг. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ ч алтны үнэнээс хамаарч тогтдог юм! Английн фунт стерлинг бол дэлхийн хамгийн хүнд алтан барьцаатай мөнгө юм!” гээд л ярина шүү дээ. Манай багш нар Англи дахь алтны үнийн талаар гарч байгаа мэдээллүүдийг бидэнд өгдөг байлаа.

Дайн дуусаад удаагүй байсан болохоор биднийг Москвад сурч байхад амьдрал их хүнд байсан юм. Их сургуулийн оюутан хүнд дэлгүүрт 500 грамм л талх өгдөг байлаа. Түүнээс илүү өгөхгүй. Ийм норм тогтоочихсон байсан юм. Бид нар “хүнсний карт”-тай байлаа.

Тэр үед ЗХУ-д хүнсний зүйлийн хүрэлцээ муу байсан учир зөвхөн бид нар биш бүх хүн хүнсний карттай байлаа. Тэр картаар нэг хүнд

өгөх хүнсний зүйлд хэмжээ тогтоочихсон байсан юм. Надтай хамт тэр сургуульд дөрвөн монгол хүн сурч байлаа. Тэдний хоёр нь дайнаас өмнө тэнд сурч байгаад, дайн эхлэхээр нутаг буцсан юм байна. Тэгээд дайн дуусахаар эргэж ирээд сургуульдаа орсон юм. Малын гаралтай түүхий эд экспортоор гаргадаг манай “Цагаан эрэг дамжлага бааз” гэж байсан юм. Бид нар Цагаан эргийн дамжлага баазаас нэг бочка масло авсан юм. Түүнийгээ вагоноор зөгөөд Москвад аваачсан юм. Бид нар тэр маслаа оюутны байрныхаа цонхон дээр тавьчихдаг байлаа. Тэгээд нөгөө 500 грамм талхаа аваад, масло түрхээд иднэ шүү дээ. 500 грамм талх гэдэг бол их жаахан л даа. Гэхдээ өөр хүнсний зүйл байхгүй болохоор түүгээрээ л амьдарч байлаа. Сүүлдээ хүнсний зүйлийн хүрэлцээ арай дээр болоод хүнсний карт байхгүй болсон юм.

Бид нар өөрийнхөө Элчин сайдын яаман дээр очоод оюутны тэтгэлэг авдаг байлаа. Нэг оюутан 500 гаруй рубль авч байсан шиг санагдаж байна. Тэр үед Москвад нийтдээ 30 орчим хүн л сурч байсан байх. М.В.Ломоносовын нэрэмжит Москвагийн Их Сургууль, Гадаад хэлний дээд сургууль, Гадаад худалдааны дээд сургуульд монгол хүн сурч байсан юм. Миний сурч байсан Худалдааны дээд сургуулиас гадна бас Гадаад худалдааны дээд сургууль гэж байсан юм. Гадаад худалдааны сургуульд дандаа гадаад худалдааны чиглэлийн хичээл үздэг байсан байх. Манай Худалдааны дээд сургууль зөвхөн дотоодын худалдааны асуудлыг үздэг байлаа. Гэхдээ энэ хоёр сургуульд онцын ялгаа байгаагүй юм л даа. Үздэг хичээлүүд нь ерөнхийдөө ижилдүү байсан юм. “Яаж мөнгө олох вэ? Олсон мөнгийг яаж зарцуулах вэ?” гэдэгт л гол анхаарлаа хандуулна шүү дээ. Ийм хичээлүүдийг Орос улс хаант засагтай байх үеийн л профессорууд голдуу заана шүү дээ. Зарим нь их өндөр настай болчихсон байж билээ. Тэд нар бол зах зээлийн харилцааг зүгээр нэг онолоор биш өөрсдийнхөө амьдралаар мэдэх хүмүүс юм л даа. Зах зээлийн эдийн засгийн харилцааны онолыг ч гэсэн тэд нар жинхэнэ утгаар нь судалсан хүмүүс байсан юм. Тэд нар бол үнэ, ханшийн асуудлыг сайн мэддэг юм. Тэд нар чинь капитализмаа ч сайн мэддэг, одоогийнхоо социализмаа ч сайн мэддэг хүмүүс юм.

Ичинхорлоогийн Лхагвасүрэн (цаашид **ИЛ**): Та нарт гол нь социалист хувьсгалаас өмнөх үеийн зах зээлийн эдийн засгийн харицааны асуудлыг заадаг байсан уу?

ЮА: Үгүй, дандаа тийм биш. Тэд нар одоо тавигдаж байгаа шинэ зорилтуудын тухай ч заадаг байсан юм. Тэгэхээр бидэнд шинэ, хуучин эдийн засгийн хоёр ситемийг хоёуланг нь заадаг байсан гэж ойлгож

болно. Манай багш нар бүгд англи хэлээр сайн ярьдаг байлаа. Бидэнд бас англи хэл заадаг байсан юм.

5 “Хоршоодын холбоо” - нд.

ЮА: Би сургуулиа төгсөж ирээд арав гаран жил ердөө гадаадтай харилцаатай ажил хийгээгүй юм. Би ирээд Хоршоодын холбоонд ажилласан юм. Энд Монголын дотоодын бүх худалдааны асуудлыг хариуцаж байлаа. Ингээд 1960 онд МАХН-ын ТХ-ны бүгд хурал хуралдаад гадаад худалдааны асуудлыг хариуцсан бие даасан Гадаад худалдааны яамыг байгуулах шийдвэр гаргасан юм. Манай Хоршоодын холбоо зөвхөн дотоод худалдаагаа хариуцахаар болсон юм. Гадаад худалдааны яамны экспортын асуудал эрхэлсэн орлогч сайдаар Л.Ганжууржав гэдэг хүн томилогдсон юм. Энэ хүн намайг өөрийн яаманд ажилд оруулсан юм. Намайг Гадаад худалдааны яамны импорт хариуцсан газрын даргаар томилсон юм. Ингэж би Гадаад худалдааны яаманд ирсэн юм.

Би энд ажиллаж байхдаа нэг удаа Хатгалын боомтод томилолтоор ажилласан юм. Энэ боомтоор манайхаас ЗХУ-д малыг хөлөөр нь гаргадаг байлаа шүү дээ. Энд хэд хоног ажиллаж байгаад Улаанбаатарт иртэл миний элэг их өвддөг боллоо. Тэгээд би Улаанбаатарт элгээ эмчлүүлээд нилээд засарлаа. Тэгтэл түүний дараа жил нь миний элэг дахиад өвдөж эхэллээ. Эмч нар надад “Чехсловак улсад байдаг Карловы Вары гэдэг рашааныг гурван жил дараалан уух хэрэгтэй!” гэсэн зөвлөлгөөг өгдөг болсон юм. Энэ үед манайхаас Унгар улсад сууж байгаа Элчин сайдын яамны худалдааны зөвлөхөөр нэг хүн ажиллаж байсан юм. Тэр хүний тэнд ажиллах хугацаа нь дуусаад буцаад ирлээ. Ингээд намайг түүний оронд худалдааны зөвлөхөөр томиллоо. Ингээд би Будапештэд 5 жил амьдарсан юм. Тэнд байхдаа Чехсловак улсын Карловы Вары гэдэг алдартай рашаан сувилалын газарт гурван жил дараалан амарч, рашаан уулаа. Нэг очихдоо хоёр долоо л хонож байсан байх. Миний элэгний өвчин бүрэн эдгэрлээ. Миний элэг одоо болтол дахиж өвдөөгүй юм шүү.

И Л: Танд тэр рашаан их сайн эмчилгээ болсон байна шүү дээ.

ЮА: Тэгсэн юм шүү. Маш сайн эмчилгээ болсон юм. Эхлээд тэндхийн эмч нар миний биеийг үзээд “Та өдөр бүр рашаан ууж байх шаардлагатай юм байна!” гэж зөвлөсөн юм. Тэгээд би өдөр бүр л уудаг байлаа. Тэндхийн рашаанууд ер нь их сонин шүү дээ. 13 төрлийн рашаан дээшээ олгойдож байдаг юм.

И Л: Тэр рашаануудын амт нь ямар байна? Өөр, өөр байдаг уу?

ЮА: Ер нь амт байхгүй. Заримдаа нэг л гашуувтар амт амтагддаг юм. Өөр амт ерөөсөө байхгүй. Зүгээр л усны амттай байдаг юм. Би тэр рашаанаас өглөө, өдөр, орой уудаг байлаа.

И Л: 1960 онд Гадаад худалдааны яам байгуулагдахаас өмнө Хоршоодын холбоо гэдэг газар гадаад, дотоод худалдааг хоёуланг нь хариуцаж байсан юм уу?

ЮА: Тийм шүү. 1960 онд Хоршоодын холбоо өөрийн мэдэлд байсан бүх дамжлага баазуудаа бие даасан Гадаад худалдааны яаманд шилжүүлж өгсөн юм. Тэр үед Цагаан нуур, Хатгал гээд том, том дамжлага баазууд ажиллаж байлаа шүү дээ. Тэр баазуудаар манай мал ЗХУ-д гардаг байлаа. Дорнод аймагт Төв бараа бааз байсан юм. Монгол улсын доторхи худалдааг Хоршоодын холбоо хариуцахаар болсон юм. Тэгж байтал Хоршоодын холбоог татан буулгаад, түүний оронд Худалдаа, бэлтгэлийн яам байгуулагдсан юм. Энэ яам улсын бүх худалдааны асуудал, түүхий эдийн бэлтгэлийн асуудлыг хариуцдаг болсон юм.

И Л: Тэр үед Монгол улс ямар, ямар оронтой гадаад худалдааны харилцаатай байсан бэ?

ЮА: Тэр үед манай Гадаад худалданы яаманд харъяалагддаг Худалдааны танхимын дарга нь Наваан-Юндэн гэдэг хүн байсан юм. Тэр хүн бүр бага байхдаа Германд дээд сургууль төгссөн юм гэнэ билээ. Германаар маш сайн ярьдаг хүн байсан юм. Би Гадаад худалдааны яамны импортын газрын дарга байлаа шүү дээ. Манай “Монгол экспорт” нэгтгэлд малын ноосны мэргэжилтэн нэг сайн залуу байсан юм. Би одоо нэрийг нь санахгүй байна. Бид гурав тэр үед дандаа барууны хөрөнгөтөн орнуудаар явж худалдаа хийдэг байлаа.

Тэр үед Швейцарын нутаг дээр, Германы хилд ойрхон “Сандоз” гэдэг том компани байсан юм. Энэ компани дэргэдээ маш том үйлдвэртэй байсан юм. Энэ компани арьс ширийг боловсруулахад маш чухал ач холбогдолтой химийн бодисыг үйлдвэрлэдэг юм. Дэлхийн олон орон энэ фирмээс арьс шир боловсруулахад хэрэгтэй бодис авдаг юм. Бид гурав хамгийн анх энэ компани дээр очлоо. Компанийн удирдлагуудтай нь уулзлаа, үйлдвэрүүдийг нь үзлээ. Тэгээд арьс шир боловсруулахад хэрэглэдэг тэр хиймийн бодисоос нь худалдаж авах гэрээ байгууллаа. Бид нар ингэж анх удаа энэ компанитай 200 тонн химийн бодис авах гэрээ

хийж байсан юм. Монгол улсын арьс ширний үйлдвэрүүд энэ фирмийн хиймийн бодисийг одоо болтол авч байна. Энэ компани бол Швейцарийн компани юм. Манай улс Гадаад худалдааны яамтай болсноосоо хойш дэлхийн 30 гаруй оронтой гадаад худалдааны харицаатай болсон юм. Энэ үеэс эхлээд хөрөнгөтөн орнуудтай гадаад худалдааны харилцаатай болсон юм.

Манайх хөрөнгөтөн орнуудад ямааны ноолуур, хонины ноос экспортоор гаргадаг байлаа. Манай хонины ноосыг авах их дуртай байдаг юм. Учир нь барууны орнуудын нэхмэлийн үйлдвэрүүд химийн аргаар гаргаж авсан синтетик материалтайгаа хонины ноосыг хольж шинэ төрлийн утас гаргаж авдаг юм. Тухайлбал миний ажиллаж байсан Унгар улс манайхаас авсан хонины ноосыг синтетик материалтай холиод сайхан утас гаргаж аваад, түүгээрээ эрэгтэй хүний костюм хийх материал үйлдвэрлэдэг байсан юм. Тэр материалаа цааш нь барууны орнууд руу хатуу валютаар зардаг байсан юм.

И Л: Одоо монгол хонины ноосыг авах газар байхгүй учир малчид ноосоо бараг л хаяж байна шүү дээ. Маш бага үнээр заримдаа Хятадын наймаачид авдаг болсон байна.

ЮА: Уг нь бол Үйлдвэр худалдааны яамны шугамаар хонины ноосыг экспортлох ажлыг сайн зохион байгуулах ёстой юм. Хонины ноос авдаг улс, компаниуд олон бий юм шүү дээ. Нөгөө талаар 1990-ээд оноос хойш манай мал хувьд очсон шүү дээ. Ийм болохоор ноос авах ажлыг зохион байгуулахад бэрхшээлтэй болсон байж магадгүй.

Биднийг Гадаад худалдааны яаманд ажиллаж байхад түүний харьяанд импортын гурав, экспортын нэг, нийтдээ дөрвөн том үйлдвэр-худалдааны нэгдэл ажиллаж байсан юм. “Монгол экспорт нэгдэл”-ийн шугамаар манай бараа бүтээгдэхүүн гадаадад гардаг байлаа. “Арьс, шир, ноосны нэгдэл” гэж маш том нэгдэл байлаа. “Монгол техник импорт нэгдэл” гэж маш хүчтэй нэгдэл байлаа. Монгол улс өөрийн хэрэгцээний бүх техник, багаж төхөөрөмжийг энэ нэгдлийн шугамаар захиалж авдаг байлаа шүү дээ. Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүнийг импортоор оруулж ирэх асуудал хариуцсан “Материал импекс” гэж байлаа. Бас шатах тослох материалыг импортоор оруулж ирэх асуудал хариуцсан нэг нэгдэл байсан юм. 1990-ээд оноос хойш ийм үйлдвэр-худалдааны нэгдлүүд бүгд байхгүй болжээ.

Би Унгар улсад худалдааны төлөөлөгчөөр ажиллаж байх үедээ Унгар улсын Гадаад худалдааны яамнаас зохион байгуулсан хүлээн авалтанд нэг удаа орсон юм. Тэнд Унгарын гадаад худалдааны яамны нэг

мэргэжилтэнтэй ойр зуурын юм яриад зогсож байлаа. Би уг нь түүнийг таньдаг юм. Тэр хүн:

-Танайд гадаадад өлөн гэдэс гаргах төлөвлөгөө байна уу? гэж асууж байна.

-Тийм хүсэл, санаа бол байгаа, гэхдээ одоохондоо манайхаас ийм бүтээгдэхүүн авах хүсэлт гаргасан улс алга байна! гэж би түүнд хэлсэн юм. Тэгтэл тэр хүн:

-Тэгвэл би таныг нэг хүнтэй танилцуулж өгье. Тэр хүн өлөн гэдэсний мэргэжилтэн юм. Тэр хүн энэ асуудлыг их сонирхож байгаа юм! Уг нь Швейцар хүн юм л даа! гэж байна шүү.

-Өө, тэгье. Тэр хүнтэй чинь би уулзъя! Тэр хүн чинь Будапештэд ирдэг юм уу? гэж би асуулаа.

-Ирдэг юм. Сард хоёр удаа ирдэг юм! гэж байна.

Ингээд л энэ яриа дууссан юм. Тэр ярианаас хойш нэг их удалгүй тэр хүн над руу утасдаж байна. “Швейцараас нөгөө өлөн гэдэсний мэргэжилтэн ирээд Гелес уулан дээр байдаг зочид буудалд буусан. Та хэзээ уулзаж чадах вэ?” гэж байна.

Унгарт байгаа манай Элчин сайдын яамны байр Гелес ууланд байрладаг юм. Түүний ойролцоо нэг том зочид буудал байдаг юм. Швейцараас ирсэн тэр хүн манай элчин сайдын яамны ойрхон буусан юм шиг санагдаад байлаа. Ингээд нэг өдрийн дараа үдийн цайны цагаар би түүний буусан зочид буудалд очлоо. Би нэг герман хэлний орчуулагчтай очсон юм. Ингээд нөгөө хүнтэй танилцаад, хамт үдийн хоолонд ороод, нилээд ярьлаа. Тэр хүн “Өлөн гэдэсний асуудлаар Монголд очих сонирхолтой байна!” гэж ярьж байна. Ингээд энэ уулзалтын дараа би Гадаад худалдааны яамтай холбоо барилаа. Гэтэл манай яамны экспортын асуудал эрхэлсэн орлогч сайд Ганжууржав гуай:

-Тэр хүний бүх зардлыг манай тал хариуцна. Хэзээ Монголд ирж чадахыг нь асуугаад яаралтай хариу ирүүл! гэж байна шүү. Ингээд би түүнтэй дахин холбоо барьлаа. Тэгтэл тэр хүн:

-Хэзээ ч болно! Одоо ч явсан болно! гэж байна. Ингээд бид түүнийг Монголд очуулах ажлыг зохион байгууллаа. Будапештээс Москва очуулаад, тэндээсээ Улаанбаатарт ирлээ. Бид энэ ажлыг маш хурдан зохион байгуулсан юм. Би өөрөө хамт ирлээ. Ингээд түүнд манайхан Улаанбаатарын Мах комбинатыг үзүүлэв. Тэнд очоод тэр хүн монголын мэргэжилтнүүдэд маш их зөвлөлгөө өглөө. Өлөн гэдсийг яаж ялгаж авах талаар сайхан зөвлөлгөө өгсөн юм. Ингээд тэр хүн жилд хоёр удаа Монголд ирдэг боллоо. Бид нар 1964 оноос 2000 он хүртэл хамтарч ажилласан юм шүү дээ. Түүнийг Штоун гэдэг юм. Манай өлөн гэдэс ингэж экспортонд гарч эхэлсэн юм.

Эхний удаад бид нар 50.000 ширхэг өлөн гэдэс нийлүүлэх гэрээ хийсэн юм. Сүүлдээ энэ тоо өссөөр байгаад 300.000 болсон юм. Бид өлөн гэдсийг дандаа хатуу валютаар зардаг байлаа. Барууны орнууд өлөн гэдсийг эмнэлэгт хэрэглэдэг юм. Мэс засал хийлгэсэн хүнд оёдол тавих утас болгож ашигладаг юм билээ. Манайхаас өлөн гэдсийг гол нь ийм зориулалтаар авч байсан юм. Зөвхөн хонины өлөн гэдэс авна шүү дээ. Ямааны өлөн гэдэс эмнэлэгийн хэрэгцээнд тохирдоггүй юм гэнэ билээ. Бид нар 2000 он хүртэл өлөн гэдсийг барууны орнуудад экспортод гаргаж байлаа. Баруун Германаас бид нар эм авч байсан юм. Манай гадаад худалдаанд хатуу валютын хэрэгцээ маш их байсан даа.

6 Гадаад худалдаа бол миний мэргэжил.

И Л: Тэр үед хөрөнгөтөн орнуудтай худалдаа хийхэд манай үзэл суртал бэрхшээл учруулж байсан уу?

ЮА: Манай үзэл суртал гадаад худалдаанд бэрхшээл учруулж байсан байж болох юм. Би сайн мэдэхгүй байна. 1960-аад оноос л бид нар хөрөнгөтөн оронтой худалдаа хийж эхэлсэн юм шүү дээ.

КЮ: Унгар улс, Монгол улс хоёр гадаад худалдааны ямар харилцаатай байсан бэ?

ЮА: Би Монгол улсаас Унгар улсад суух худалдааны төлөөлөгчийн ажлыг 5 жил хийсэн юм. Унгар улс өөрөө шуудангийн марк хийж гадаадад зардаг юм. Бид нар Унгарт монгол маркийг хийлгээд зардаг байв. Тэд нар өөрийнхөө мөнгөөр монгол маркийг авдаг байв. Тэд авсан үнэнийхээ 30%-ийг нь хатуу валютаар төлдөг байв.

Унгарт очсоны дараа би дахин тооцоо хийж үзлээ. Гэтэл ийм төрлийн худалдаа их алдагдалтай юм шиг санагддаг болчихлоо. Унгарын тал заримдаа манайд энэ валютаар төлөх 30%-аа ч бүрэн гүйцэд төлдөггүй байв. Тэгээд бид нар “монгол маркийг ерөөсөө өөрсдөө зарсан нь илүү ашиг өгөх юм байна!” гэдэг дээр санал нэгдсэн юм. Ингээд энэ асуудлыг Гадаад худалдааны яаманд танилцууллаа. Манай яам энэ асуудлыг авч хэлэлцээд бидний саналыг зөвшөөрлөө. Тэгээд би Унгарын талд энэ асуудлыг танилцууллаа. Хоёр тал энэ асуудлаар хэлэлцээр хийхээр боллоо. Хэлэлцээрт манай Холбооны яамны орлогч сайд бас манай Элчин сайд оролцсон юм. Унгарын тал манай тавьсан асуудлыг эхлээд зөвшөөрөхгүй байлаа. Ингээд хэлэлцээр сунжирч гурван өдөр үргэлжилсэн юм. Тэгээд эцэст нь тэд нар зөвшөөрлөө.

Гэтэл тэдний талд зарагдаагүй монгол марк маш их байсан юм байна. Унгарын талтай байгуулсан гэрээн дээр хэдэн онд, хичнээн ширхэг марк өгсөн нь тов тодорхой байж байгаа шүү дээ. Ингээд энэ бүх үлдэгдэл монгол маркийг манай тал эргүүлж авахаар боллоо. Бид нар үлдэгдэл маркийг маш хурдан Монгол руу ачууллаа. Үүнээс хойш бид нар монгол маркийг өөрсдөө зардаг болсон юм.

Монгол марк бол их сайн марк шүү дээ. Сэдэв, зураг нь их сайхан. Монгол марк гадаадын марк сонирхогчдын дунд их нэр хүндтэй зүйл байсан юм. Одоо ч ийм л байгаа байх. Түүнээс хойш монгол марк дэлхийн 20 гаруй оронд гардаг болсон юм.

Энэ явдал болсноос хойш удалгүй, Америкийн нэг бизнесмен алтан марк хийнэ гэсэн зар тараасан юм. Бид нар тэр алтан марк хийдэг компанийн орлогч захирлыг нь Монголд ирэхийг урилаа. Уг нь журмаараа бол гадаадаас хүн урихдаа бид нар МАХН-ын ТХ-той энэ асуудлыг урьдчилж ярих ёстой юм. Тэнд ямар зорилгоор, хаанахын хэн гэдэг хүнийг урьж байгаагаа танилцуулдаг юм. Тэндээс бидэнд тэр хүнийг урьж болно, болохгүй гэсэн хариу өгдөг байлаа. Энэ удаа бид нар энэ журмыг мөрдсөнгүй, өөрсдөө шууд урьчихлаа. Тэр бидний урилгыг аваад шууд л ирлээ. Би энэ үед Гадаад худалдааны яамны орлогч сайдын албыг хашиж байсан юм. Бид нар түүнтэй хэлэлцээр хийлээ. Тэр хүн ангийн сэдэвтэй маркийг их сонирхож байна. Манайх бар, ирвэс, буга, аргал, янгир зэрэг ан амьтны сэдэвтэй олон марк хийдэг байлаа. Бид түүнд ийм сэдэвтэй маркнудаа үзүүллээ.

Тэр хүн “Монгол маркаар алтан марк хийж болох юм байна! Бид 20 унцийн алтаар хийнэ. Америкийн баячууд ийм маркийг их авдаг юм. Та нар өөрсдөө хэдийг ч авч болно. Бид нар зараад, та нарт мөнгийг нь өгч болох юм байна!” гэж байна шүү. Ингээд эхний удаад ангийн сэдэвтэй 30 ширхэг маркийг тэр хүний захиалгаар бид нар хийж өгөхөөр боллоо. Гэтэл тэр үед нэг инээдмийн юм боллоо. Бидний хийсэн гэрээг баталж өгөх хүн байдаггүй. Гадаад худалдааны асуудал эрхэлсэн МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга, Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга нар социалист орнуудын Эдийн Засгийн Харилцан Туслалцах Зөвлөл (ЭЗХТЗ)-ийн хуралд оролцохоор бүгд Москва явсан байлаа. Ингээд бидний байгуулсан гэрээг батлах хүнгүй болчихжээ.

И Л: Тэр үед Гадаад худалдааны яамны шугамаар гадаад оронтой байгуулсан гэрээг заавал МАХН-ын ТХ-гоор батлуулдаг журамтай байсан уу?

ЮА: Өө, тэгэлгүй, яахав. Хаанахын ямар улстай, юун тухай хэлэлцээ

хийх гэж байгаагаа бид нар урьдчилаад танилцуулна шүү дээ. Тэгээд тэндээс олон юмыг биднээс шаардаад авдаг байлаа. Чухам юу шаарддаг, тэр нь ямар хэрэгтэйг би мэдэхгүй шүү дээ. Маш олон юм бүрдүүлж өгөх шаардлагатай байдаг юм. Тэгээд тэндээс зөвшөөрөл ирвэл гэрээгээ байгуулна. Би алтан маркны асуудлаар байгуулсан гэрээгээ танилцуулах хүн байдаггүй.

Гэтэл Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга Д.Майдар гуай Улаанбаатарт байгаа сураг сонслоо. Тэр Москвад хуралд яваагүй юм байж. Тэр үед Д.Майдар гуай байгаль орчин, ан амьтны асуудлыг давхар хариуцдаг байсан юм. Ингээд би Д.Майдар гуайтай уулзлаа. Би түүнд ирсэн зорилгоо танилцууллаа. Манай Гадаад худалдааны яамныхан алтан марк хийх эдийн засгийн тооцоог нь надад гаргаж өгсөн юм. Д.Майдар гуай тэр тооцоог бас үзлээ. Тэгж байснаа:

-Энэ асуудлыг би шийдэхгүй. Энэ асуудлаар танай ах Ю.Цэдэнбалтай ярих хэрэгтэй юм байна! гэж байна шүү. Ингээд бид хоёр миний авч очсон бүх бичигнүүдийг аваад, манай ахын ажлын өрөө рүү явлаа. Яг үүдэнд нь ирээд “Чи эндээ хүлээж бай!” гэж хэлээд, намайг орхичихоод ганцаараа орчихлоо. Би ахынхаа ажлын өрөөний үүдэнд нь Д.Майдар гуайг хүлээгээд сууж байлаа. Тэгээд нэг их удалгүй манай ахын нарийн бичгийн даргын утас дуугарлаа. Тэр утсыг авч ярьлаа. Тэгээд:

-Ю.Цэдэнбал гуай таныг орж ирэхийг урьж байна! гэж байна. Ингээд би ахын ажлын өрөөнд орлоо. Манай ах, Д.Майдар гуай хоёр миний өгсөн бичигнүүдийг бүгдийг дэлгэсэн үзэж байна. Намайг орохоор ах:

-Чиний энэ яриад байгаа юм чинь ямар учиртай юм бэ? Та нар алтан маркийг Америкад хэвлүүлээд, тэнд нь зарах юм байна. Тэгээд жилд ямар хэмжээний ашигтай байх юм бэ? гэж асууж байна.

-Бид нар тооцоонуудыг нь Гадаад худалдааны яаман дээрээ сайн ярьсан юм. Танд өгсөн бичигнүүд дээр бүх тооцоо, нэг жилд олох ашиг зэрэг нь бүгд бичээстэй байгаа шүү дээ! гэж би түүнд хэллээ.

Тэгтэл тэр:

-Тэр Америкууд чинь одоо хаана байгаа юм бэ? Монголд ирсэн байгаа юм уу? гэж байна.

-Өө, тэд нар одоо Улаанбаатарт ирчихсэн байж байна. Бид нар тэдэнтэй байгуулсан гэрээгээ батлуулах гэтэл түүнийг батлах хүн байдаггүй. Манай асуудлыг хариуцсан хүмүүс бүгд Москвад хуралд явсан юм байна! гэж би хэллээ.

-Аа. Тийм үү! Тэгвэл та нар тэр гэрээгээ байгуулчих. Тэгээд тэр ирсэн Америкууддаа сайхан хүлээн авалт зохион байгуулаад явуулчих! гэж байна. Энэ үгийг сонсоод би бөөн баяр боллоо.

КЮ: Та өөрийн ах дээрээ Гадаад худалдааны ажлаар олон орж байсан уу?

ЮА: Үгүй. Би ерөөсөө орж байгаагүй юм. Манай ах намайг өөрийн ажлынхаа ерөөнд ямар ч ажлын шугамаар хүлээн авч байгаагүй юм. Тэр намайг тоож ерөөсөө ажил ярьдаггүй байсан юм шүү дээ.

Энэ алтан маркны худалдаа маш их ашигтай болсон юм. Америкийн тэр компани надад өөрсдийн хийсэн алтан маркны хэдэн загварыг өгч явуулсан байна билээ. Би түүнийг одоо ч хадгалаад байж байна. Ер нь монгол маркны наймаа бол ашигтай байдаг юм. Манай улс одоо ч гэсэн монгол маркны наймааг хийсээр байна.

7 Би Гадаад худалдааны яамны орлогч сайд болов.

КЮ: Тэр үед гадаад орнуудтай хийж байсан худалдааны бүх асуудал ганц танай яамаар дамжиж байсан уу?

ЮА: Тийм. Манай үйлдвэр аж, ахуйн газрууд өөрсдөө гадаадын байгууллагуудтай шууд харьцах эрх эдэлдэггүй байсан юм. Заавал манай яамаар дамжиж харьцах ёстой байсан юм. Манай яамаар дамжуулж өөрийн хэрэгцээт техник, тоног төхөөрөмж, үйлдвэрлэл явуулахад шаардлагатай түүхий эд, мартериалыг захиалж гадаадаас авдаг, манай яамаар дэмжуулж өөрсдийн хийсэн бараа бүтээгдэхүүнийг гадаадын зах зээлд гаргадаг байлаа. Манай яам бол зөвхөн гадаад худалдааны асуудлыг л хариуцаж байлаа. Дотоодын худалдааг хариуцсан Худалдаа, бэлтгэлийн яам ажиллаж байлаа шүү дээ.

КЮ: Та Унгар улсад худалдааны төлөөлөгчөөр ажиллаж байсан юм байна. Үүний дараа хаана ажилласан бэ?

ЮА: Өө, би Унгар улсад 5 жил ажиллаад, миний тэнд ажиллах хугацаа дууссан юм. Ингээд Монгол руугаа буцах бэлтгэлээ хийж байтал гэнэт намайг Москвад суух худалдааны зөвлөхөөр томилчихсон юм. Ингээд би Москвад 7 жил ажилласан юм. Москвагаас Монголд ирээд Гадаад худалдааны яамны орлогч сайдын албыг хаших болсон юм. Алтан маркны наймаа бол би Гадаад худалдааны яамны орлогч сайдаар томилогдсоныхоо дараахан хийсэн ажил юм шүү дээ. Би Унгарт ажиллаж байхдаа маркны талаар маш их юм мэддэг болсон юм. Маркны асуудлаар мэргэжсэн Унгарын нэг нэртэй профессор байлаа. Би түүнийг өөрийн Элчин сайдын яамандаа урьж ирүүлээд, маркны талаар лекц уншуулдаг байлаа. Унгарт суугаа Элчин сайдын яаманд манай Бямбын Ренчин гуайн

охин ажиллаж байсан юм. Тэр унгар хэлийг их сайн мэддэг байсан юм. Би тэр профессорын лекцийг Б.Ренчин гуайн охиноор орчуулуулаад бүгдийг уншиж үзсэн юм.

И Л: Монгол марк хэдэн оноос эхлэж гарсан юм бэ?

ЮА: Өө, их дээр үеэс гарсан юм шиг байгаа юм. Бараг Богд хаант Монгол улсын үеэс л гарч эхэлсэн юм биш үү? Тийм шүү. Тийм дээр үеэс л гарч эхэлсэн байх. 1921 оны Ардын хувьсгалын дараа Ерөнхий сайд Д.Цэрэндоржийн үед монгол марк гарч байсан юм билээ. Тэр үед Х.Чойбалсан гуайн цээж зурагтай жижигхэн марк гарсан юм билээ. Одоо тэр үеийн маркнууд бүр олодохоо байжээ. Гадаадын марк сонирхогчид “Монгол шуудан гэж юу гэсэн үг вэ?” гэж их асуудаг юм. Бас монгол марк дээр бичээтэй байдаг “Мөнгө” гэсэн үгийг “Энэ юу гэсэн үг вэ?” гэж их асуудаг юм.

ЮА: Би та нарт баахан дэмий юм ярьж байна уу?

КЮ: Үгүй шүү. Та их сонирхолтой яриа ярьж байна.

ЮА: Гадаад худалдааны яамны орлогч сайдын ажил их хэцүү ажил байсан юм. Тэр яаманд ажиллаж байгаа хүмүүсийн ажлын цагийг бүртгэх ажлыг би шууд хариуцдаг байлаа. Хэн нэгэн хүн ажлаасаа хоцроод ирсэн асуудал гарвал шууд л надтай холбогдоод явчихна шүү дээ.

Тус яамны ажилтнуудын дунд гарч байгаа элдвийн хов, живийн асуудлыг бас зохицуулдаг байлаа. Хоёр ажилтны хооронд ямар нэгэн маргаан гарсан бол маргааныг таслах шаардлагатай болно. Эмэгтэйчүүд олонтой бол бас их хэцүү шүү дээ. Яамны дотоод амьдаралд яамны жинхэнэ сайд оролцохгүй шүү дээ. Би л оролцож зохицуулах хэрэгтэй болдог юм.

Тэр үед импортын асуудлаар яаралтай шийдэх асуудлууд байнга босож ирдэг байлаа. Гадаадаас манай захиалгатай бараа бүтээгдэхүүн гэрээт хугацаандаа ирэхгүй байх явдал их гардаг байлаа. Хамгийн хэцүү нь шатахууны импорт байсан юм. Графикт хугацаанаасаа хоцорвол дотоодын хэрэглэгчид шатахуунгүй болох аюул тулгарна шүү дээ. Ийм үед бүх тээврийн хэрэгсэл зогсоно шүү дээ. Тэр үед Гадаад худалдаанаас олсон бүх ашгийг улс авдаг байсан. Тэр хөрөнгийг Сангийн яам мэдэж захиран зарцуулдаг байлаа. Гадаад худалдааны яаманд хөрөнгө, мөнгө шаардлагатай болсон тохиолдолд Сангийн яамнаас авна. Сангийн яам манай яаманд хөрөнгө, мөнгө хуваарьлахдаа нэг их харамлаад байхгүй л

дээ. Одоо бол байдал өөр болсон байх. Хувийн компаниуд гадаадтай шууд харьцаж байна.

Намайг Монгол улсын Гадаад худалданы яамны орлогч сайд байхад Болгар улсад нэг олон улсын хурал болсон юм. Тэр хуралд орох төлөөлөгчдийн бүрэлдхүүнийг МАХН-ын ТХ-гоор баталсан юм. Намайг төлөөлөгчдийн тэргүүнээр томиллоо. Ингээд би төлөөлөгчдөө аваад тэр хуралд очлоо. Тэгтэл тэр хурал дээр Болгар, Зүүн Герман, Югослав, Монгол, Польш зэрэг таван орны Гадаад худалдааны яамны орлогч сайд нарыг худалдааны “Меркурий” шагналаар шагнасан юм. Энэ асуудлыг тэр хурлыг зохион байгуулагчид нь урьдчилаад манай МАХН-ын ТХ-нд танилцуулсан юм байна. Тийм учраас намайг тэр хуралд оролцох төлөөлөгчдийн тэргүүнээр томилсон юм байж. Би Гадаад худалдааны яаманд ажиллах болсон цагаасаа эхлээд хөрөнгөтөн орнуудтай хийх худалдааны асуудлыг хариуцаж байсан шүү дээ. Манайхтай худалдаа хийж байсан барууны хөрөнгөтөн оронууд бол Англи, Франц, Баруун Герман, Швейцар, Итали, Бельги, Швец зэрэг юм.

И Л: Манай улс Финлянд, Шведтэй ямар чиглэлийн худалдаа хийж байсан юм бэ?

КЮ: Манайх Финляндаас эмнэлгийн тоног төхөөрөмж авдаг байсан юм. Манайд зүрхний мэс заслын нэртэй эмч, доктор, профессор Д.Шагдарсүрэн гэдэг хүн байлаа шүү дээ. Д.Шагдарсүрэн гуайн зүрхний мэс засалд хэрэгтэй багаж төхөөрөмжийг Финляндаас авч байсан юм. Би Москвад худалдааны төлөөлөгч байхдаа Финлянд руу байнга явдаг байлаа.

Нэг удаа надтай хамт Зүүн Германд сууж байгаа манай худалдааны төлөөлөгч С.Гонгор хамт явсан юм. Тэр хүн бичгийн сайн чанарын цаас авах зорилготой явсан юм. Бид хоёр Финляндаас цааш Швед орлоо. Тэндээс сайн чанарын цаас авахаар гэрээ хийлээ. Тэр цаас хийдэг компанийн гадаад худалдааны менежер нэг настай хүн байсан юм. Одоо би нэрийг нь санахгүй байна. Тэр хүнтэй бид хоёр цаас авах гэрээгээ байгууллаа. Тэгээд орой нь ресторанд хамт хоол идлээ. Манай С.Гонгор гурван аяганд гурван өөр архи хийгээд “Алийг нь уух вэ?” гэж асуулаа. Тэр хүн “Хатууг нь ууна!” гээд виски хийсэн аягыг авлаа. Би улаан вино хийсэн аягыг нь авлаа. Ингээд гурвуулаа архиа тулгаад уулаа.

Тэгтэл тэр хүн “Та нар их сайхан байна шүү!” гэж байна. Бид хоёр сайн ойлгосонгүй. “Юу нь сайхан байна?” гэж түүнээс хоёулаа бараг зэрэг шахуу асуулаа. “Та нар чинь Чингис хаан, Бат хаан гээд дэлхийн хамгийн алдартай хүмүүсийн эх орноос ирсэн, тэдний хойч үе шүү дээ. Бид

нар төрөөд л байна. Үхээд л байна. Хэн нь ч тийм алдрын оргилд хүрч чадсангүй!” гэж байна. Энэ үг надад одоо болтол санагдаад байдаг юм.

Ер нь Европын хүмүүс манай Чингис хаан, түүний ач хүү Бат хаан нарыг маш сайн мэддэг юм шүү дээ. Тэр үед бид нар харин өөрсдөө эд нарын тухай их зүйл мэддэггүй байсан юм шүү дээ. Би техникумд сурч байхдаа тэдний тухай бараг сонсоонгүй юм. Тэгээд л эцэг, эх, найз нөхөд, таньдаг хүмүүсийн дунд ам дамжсан ярианаас л Чингис хааны тухай сонсож байсан байх. Ер нь түүх уншаад үзэхээр Чингис хааны байгуулсан Их Монгол улс дэлхийн түүхэнд хамгийг хүчирхэг улс байсан юм байна. Чингис хааны цэрэг Дундад Азийг бүхэлд өөрийн мэдэлд оруулаад, урагшаа Энэтхэг хүрч байсан байна шүү дээ. Бат хаан бол Дорнод Европыг бүхэлд нь захирч байж. Гайхамшигтай байна шүү.

Би Гадаад худалдааны яамны орлогч сайд байхдаа Энэтхэгт, Дели хотноо зохион байгуулагдсан олон улсын нэг хуралд орсон юм. Делид суугаа манай элчин сайдын яаманд хинди хэл сайн мэддэг залуучууд ажиллаж байсан юм. Тэд нараар орчуулуулаад тэр хуралд суусан юм. Бас би өөрөө англиар хүмүүстэй ярьдаг байлаа. Одоо би англи хэлийг бүр мартсан байна шүү дээ. Англи хэлийг огт хэрэглэхгүй байгаа болохоор маш амархан мартаж байна.

Тэр хурлын дараа алдарт Таж Махалын бунхан - сүмийг үзлээ. Таж Махалын энэ бунхан-сүм бол дэлхийн долоон гайхамшигийн нэг юм шүү дээ. ЮНЕСКО түүнийг дэлхийн соёлын өвд бүртгэсэн юм билээ. Улаан, ногоон өнгийн гантиг чулуугаар барьсан энэ бунхан-сүмийг үзэж байхад хүний оюун ухаан, ур чадварыг шүтэн бишрэх гайхамшигтай сэтгэгдэл төрдөг юм.

Таж Махалын бунхан-сүмийг бариулсан түүхийг сонсоход их сайхан шүү дээ. Энэ сүм чинь Монгол хүний түүхтэй холбоотой юм. Энэ сүмийг бариулсан хаан бол Монгол гаралтай хүн юм. Түүний эхнэр 13 дахь хүүхдээ төрүүлэх үедээ нас барсан юм билээ. Тэр хаан өөрийн хайртай эхнэрийнхээ дурсгалд зориулж энэ сүмийг бариулсан түүхтэй юм билээ. Тэгээд “Намайг миний эхнэрийн шарилын дэргэд оршуулаарай!” хэмээн захисан юм байж. Тэр бунхан-сүмд одоо тэр хаан, түүний эхнэр хоёрын шарил байдаг юм байна. Маш гайхамшигтай юм шүү.

Бид нар дандаа одоогийнх шигээ жижигхэн байгаагүй юм. Бид дэлхийн хэмжээний эзэнт гүрнийг байгуулж байсан түүхтэй хүмүүс шүү дээ. Улс, орон бүр л хүчирхэг эдийн засагтай, өргөн удам нутаг дэвсгэртэй, хүн ардаа баян тансаг амьдралтай болгохыг мөрөөддөг биз дээ. Гэхдээ түүхэндээ нэг удаа ч гэсэн ийм байж чадсан улс ер нь хэд байдаг бол? Мөрөөдөх, түүнийг хэрэгжүүлж чадах хоёрт бас ялгаа бий шүү. “Чингис хааны байгуулсан Их Монгол улсын үед дэлхийн худалдаа,

соёл үсрэнгүй хөгжих нөхцөл анх удаа бүрдсэн!” гэж эрдэмтэд бичээд, яриад байгаа шүү дээ. Их Монгол улсын үед олон шашин энх тайвнаар зэрэгцэн оршиж байсан байна. Бас улсын хил хязгаар гэдэг юм байхгүй байж. Олон ард түмэн, угсаатнууд, улс орон нэг захиргаатай болсон тул худалдаа, арилжааны ажил чөлөөтэй болж, цэцэглэн хөгжиж, хүмүүс нааш, цаашаа чөлөөтэй аялж явах боломжтой болсон байна. Бид нар дэлхийн хөгжлийн түүхийг ингэж өөрчилсөн байна шүү дээ. Европод ажиллаж байхад энэ талаар хүмүүс маш их зүйлийг мэддэг нь харагдаад байдаг юм. Гэтэл бид нар, монголчууд өөрсдөө энэ талаар мэдэхгүй л байлаа шүү дээ. Үзэл суртлаасаа болдог юм уу? Өөр юмнаас болдог юм уу? Бүү мэд. Бид нар өөрсдөө энэ түүхийг маш бага мэддэг шүү дээ.

И Л: “Говь” комбинатыг барихаас өмнө Монгол улс ямааныхаа ноолуурыг ямар оронд экспортоор гаргаж байсан бэ?

ЮА: Манай ямааны ноолуур ЗХУ, Швейцарь улсад гарч байсан юм. Зарим үед Баруун Герман улс авдаг байлаа. Тэр үед ямааны ноолуур “Монгол экспорт” нэгдлээр дамжиж гадаадад гарч байсан юм. Манай Гадаад худалдааны яамны сайдаар Д.Гомбожав гуай ажиллаж эхэлснээс хойш гадаад худалдаа их идэвхитэй болсон юм. Манай сайд өөрөө гадаад худалдааны мэргэжилтэн байсан болохоор гадаад худалдааны асуудлыг их сайн мэддэг хүн байсан юм. Бид нар гадаадад томилолтоор явахдаа сайддаа явах ажлаа танилцуулдаг журамтай байлаа. Манай сайд сүүлдээ МАХН-ын ТХ-ны Улс Төрийн Товчооны гишүүн, гадаад худалдааны асуудал эрхэлсэн нарийн бичгийн даргаар сонгогдоод олон жил ажилласан юм.

8 Манайх.

КЮ: Одоо таны хувийн амьдралын талаар ярилцмаар байна. Та хэдэн онд гэрлэсэн бэ?

ЮА: 1940 онд намайг Улаанбаатар хотод анх миний ах Цэдэнбал дагуулж ирсэн гэж би ярьсан шүү дээ. Би хотод ирээд ахын гэрт Монгол банкны хоёрдугаар давхарт амьдарч байлаа. Ах хөдөө их явдаг байлаа. Түүнийг хөдөө явсан хойгуур би ганцаараа л амьдардаг байлаа. Тэгж байх үедээ манай нутгийн Ө.Бадрах гэдэг айлаар би очдог болсон юм. Энэ Өлзийтийн Бадрах гуай бол яг манай нутгийнх, тэр усмаа яг манай багийн айл байсан юм. Ө.Бадрах гуай 1930-аад оны эхээр МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга байсан юм. Тэгээд сүүлдээ МАХН-ын дотор “зүүний алдаа

завхралыг гаргасан” гэдэг үндэслэлээр ажлаасаа халагдсан юм. Намайг нутагтаа хонь хариулж явахад Ө.Бадрах гуай их гоё машинтай нутагтаа ирж байсан юм. Би тэр үед анх удаа машин харсан юм. Ө.Бадрах гуайн ах дүү нар нь манайхтай их ойрхон нутагладаг байсан юм. Тэр нутагтаа ирээд ах, дүү нарынхаа гэрийн гадаа алаг хээтэй майхан барьчихсан байлаа. Би хүүхэд байсан болохоор машиныг нь үзэхээр тэдний хотонд очлоо. Би хамт хонь хариулдаг нэг найзтайгаа очсон юм. Бид хоёрт нэг зөөлхөн цагаан юм өглөө. Идэх юм байна гэдгийг нь ч мэдлээ. Тэгээд хоёулаа түүнийг идэж үзэхээр голын хөвөөнд очлоо. Тэгээд сайхан ногоон зүлгэн дээр суугаад нөгөө зүйлийг идэж үзлээ. Тэгтэл тэр огт давсгүй, нэг хачин амттай юм байна. Надтай хамт очсон найз маань “Энэ чинь давсгүй, ямар муухай амттай эд вэ?” гэснээ түүнийг хол шидчихлээ. Би жаахан идэх гэтэл муухай амтагдаад идэж болсонгүй. Тэгээд би бас хол шидчихлээ. Тэр үед бидэнд юу өгсөн юм бэ? Бүү мэд, Одоо бодоод байхад талх л өгсөн юм шиг байгаа юм. Тэр үед манай нутагт талх гэж огт мэддэггүй байлаа шүү дээ. 1938 онд Ө.Бадрах гуай “МАХН-ын дотор зүүний алдаа завхралыг гаргасан” гэдэг үндэслэлээр цаазлагдсан юм.

Би Монгол банкны хоёр давхарг ахтайгаа хамт амьдарч байхдаа Ө.Бадрах гуайн гэрт очих үед заримдаа тэднийд нэг жаахан бор охин ирдэг байсан юм. Тэр бол Д.Элээ гэдэг хүнийн хүүхэд гэдгийг би тэр үед дуулсан юм. Энэ Д.Элээ гуай бол манай Увс аймгийн Наранбулаг сумын хүн юм. Тэр нэг үе Монголын Үйлдвэрчний Төв Зөвлөлийн дарга байсан хүн юм л даа. 1938 онд түүнийг улс төрийн хилс хэрэгт гүтгээд цаазалсан юм билээ. 1938 онд манай нутгийн С.Шижээ гэдэг хүн бас цаазлуулсан юм. С.Шижээ гуай ч бас л МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн даргын албыг хашиж байсан хүн шүү дээ.

Ө.Бадрах гуайн эхнэр, Д.Элээ гуайн эхнэрүүд их найз юм байж л дээ. Тэгээд Д.Элээ гуайн охин тэднийд ирдэг байж. Би техникумаа төгсөх гэж байх үедээ Ө.Бадрах гуайнд нэг удаа ирсэн юм. Тэгтэл тэднийд ирээд байдаг жаахан бор охин бүр том болчихсон Улсын төлөвлөгөөний комиссын нэр дээр ЗХУ-д сургуульд явахаар болсон тухай сонслоо. Тэгсэн Ө.Бадрах гуайн эхнэр: “Чи байн, байн Ленин клубт болдог бүжиг рүү гүйгээд байна шүү. Тэнд янз бүрийн хүн цугладаг юм. Чи тийшээ гүйж байхаар энэ хөөрхөн бор охинтой суух хэрэгтэй!” гэж байна шүү. Би эхнэртэйгээ тэгж суусан юм. Ингээд манайх одоо гурван охин, нэг хүүтэй айл болсон юм.

1938 онд Ө.Бадрах гуай, Д.Элээ гуай нарыг цаазалсан шүү дээ. Тэгээд эхнэрүүд нь их зовлон үзсэн юм билээ. Тэр үед цаазлагдсан хүмүүсийн бүх хөрөнгийг нь хураадаг байсан юм байна. Тэгээд тэд нар хөрөнгөө хураалгаад амьдрах гэргүй болсон юм байна л даа. Нэг удаа болсон

явдлуудыг маршал Х.Чойбалсанд хэлэх завшаан олджээ. Түүнтэй хуучин танил байсан юм байж. Тэгээд маршал Х.Чойбалсан нэг гэр өгсөн юм билээ. Ингээд одоогийн Багшийн их сургуулийн хойд талын хашаанд гэрээ бариад амьдарч эхэлсэн юм билээ. Тэр хоёр тэр үед нэг гэрт хамт амьдарч байсан юм шиг байгаа юм.

Би Улаанбаатар хотод техникумд сурч байхдаа зуныхаа амралтаар нутагтаа очдог байлаа. Намар сургуулийн хичээл эхлэхээр буцаад ирдэг байлаа. Намар ирэхдээ монгол дээлтэйгээ ирнэ шүү дээ. Тэр үед техникумд сурч байгаа хүүхдүүдэд улсаас хувцас өгдөг байлаа. Манай сургуулийн аж ахуйн эрхлэгч бидний дээлийг аваад, нэг шуудайд хийгээд складад хураачихдаг байлаа. Би хавар тэр хувцасаа эргүүлж аваад, шуудангийн машинд суугаад нутаг явдаг байсан юм.

Түүнээс хойш, 1950 онд манай ээж Улаанбаатарт ирсэн байх. Улаанбаатарт ирэхээсээ өмнө ээж манай нэг эгчтэй хамт амьдардаг байсан юм. Тэр эгчийн нөхөр нь нас бараад ээжтэй хамт амьдардаг болсон юм. Тэр хоёр хамт Улаанбаатарт ирсэн юм.

КЮ: Танай ээж Улаанбаатарт ирээд хаана амьдарч байсан юм бэ?

ЮА: Ээж ахын байрны ар талд монгол гэрт амьдарч байсан юм. Тэр үед ах эхнэр авсан байлаа. Ахын байр их том хашаатай байсан юм. Бас тусгай харуул, хамгаалалттай байлаа. Тэр хашаа нь хойд талдаа нэг жижигхэн хаалгатай байсан юм. Урд талдаа бол их том хаалгатай л даа. Тэнд нь хамгаалалтын цэрэг олонтой байсан юм. Бид нар ээж дээрээ ирэх хэрэг гарвал эхлээд ахын хамгаалалтын алба руу утсаар яриад очих цагаа хэлж зөвшөөрөл авдаг байлаа. Манай ээж бүх насаараа монгол гэртээ амьдарсан болохоор байшинд ердөө амьдарч чаддаггүй байсан юм. Ээж “Байшинд агааргүй, бүгчим байна! Бас модон шал нь их дуутай байна!” гэж хэлдэг юм.

Манай ах байнгын маш их ажилтай байлаа шүү дээ. Өөрөө бас их ном уншдаг байлаа. Шөнийн 3-4 цагаас өмнө ерөөсөө унтдаггүй байсан юм. Тэгээд өглөө эрт босно шүү дээ. Манай ах бүх зүйлээ орос хэл дээр бичдэг байсан юм. Түүнийг нь МАХН-ын ТХ-ны орчуулагч нар монгол хэл рүү орчуулдаг байлаа. Монгол хэл рүү орчуулсны дараа өөрөө уншиж үздэг байсан юм. Би бас нарийн сайн мэдэхгүй. Түүний комиссарууд нь тэгж ярьдаг байсан юм.

Түүний эхнэр нь утсаар биднийг хааяа дууддаг байлаа. Тэдний гэрт кино гардаг байлаа. Тэгээд ахын эхнэр “Манайд ирж кино үз!” гэж биднийг дууддаг юм.

Бид нар ахаасаа гуйдаг нэг юм байсан юм. Энэ бол машин юм л даа.

Хүүхдийн бие муудсан үед эмнэлэг явах хэрэг гарна шүү дээ. Тийм үед манай ах машин өгч бидэнд тусалдаг байлаа. Надаас хүмүүс “Чи ахаасаа мөнгө их авч байсан уу?” гэж их асуудаг юм. Манай ах мөнгөтэй байсан юм уу? Үгүй юм уу? Бүү мэд.

Ахын эхнэр нь ажил хийдэггүй байсан болохоор ганц ахын цалингаар амьдарч байсан айл шүү дээ. Хүмүүс ийм л юм надаас асуугаад байна шүү дээ. Би хүмүүст “Би ахаасаа хааяа эмнэлэг явахад хэрэглэх машин л гуйдаг байсан!” гэж хэлдэг байлаа. Миний үгэнд үнэмшдэг юм уу? Үгүй юм уу? Бүү мэд Хожим манай ахын эхнэр нь Хүүхдийн төлөө фондын дарга болсон юм. Тэгээд цалин авдаг болсон байх. Манай ахын эхнэр тэр орос авгай их ажил хийсэн хүн юм шүү. 1974 онд Зөвлөлт Холбоот Улсын Коммунист Нам (ЗХУКН)-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Л.И.Брежневиг Монголд айлчлах үеэр “Гэрлэх ёслолын ордон”-г Улаанбаатарт ЗХУ-ын хөрөнгөөр бариулах зөвшөөрөл авчихсан юм. Бас хүүхдийн цэцэрлэг олныг бариулсан юм шүү дээ.

9 Бэргэн эгч А.И. Филатова.

КЮ: Та ахынхаа эхнэр А.И.Филатова гуайтай анх хэзээ уулзсан юм бэ?

ЮА: Би ЗХУ-д сурч байсан шүү дээ. Тэр үед уулзсан юм. Тэр үед манай ах анхдугаар таван жилийн төлөвлөгөөг боловсруулах зорилгоор Москвад ирсэн байлаа. Тэр Москвад ирээд бараг таван сар болсон байх. Би хааяа түүний буусан Москвагийн “Метрополь” зочид буудалд очиж түүнтэй уулздаг байлаа.

Нэг орой ахын комиссар нь над руу утасдаад “Өнөөдөр орой ахтайгаа цуг нэг айлд очиж хоол иднэ шүү!” гэж байна. Тэгж байтал И.В.Важнов гэдэг орос хүнээс бас утас ирлээ. Тэр ч мөн л энэ тухай ярьж байна. Орой нь би ахын комиссарыг дагаад нэг орос айлд очлоо. Тэр айлынх зочид буудлаас их ойрхон юм.

Тэнд надтай утсаар ярьсан И.В.Важнов гуай оросын цэргийн нэг хурандаагийн хамт байж байлаа. Бас нэг орос эмэгтэй сууж байна. Тэд нарын эсрэг талд хоёр залуухан орос хүүхэн сууж байна. Гаднаас орж ирсэн бид нар сул сандлууд дээр нь суулаа. Ахын комиссар намайг тэдэнтэй танилцуулж байна. Би нэрээ хэлээд бүгдтэй нь гар барилаа. Тэгээд ойр зуурын юм яриад байж байтал удалгүй гаднаас манай ах ороод ирлээ. Ингээд бүгдээрээ нэг ширээ тойрч суугаад оройн хоол идлээ.

Тэгээд би тэндээс шууд л сургуулийнхаа байр руу буцлаа. Бидэнтэй хамт хоол идсэн хоёр залуухан орос хүүхний нэг нь манай бэргэн эгч болох гэж байсан юм байж. Тэнд байсан гурван эмэгтэй бол төрсөн эгч дүү гурав

юм байж л дээ. Тэнд байсан цэргийн хурандаа нь тэр гурвын хамгийн том эгчийн нөхөр юм байж. Тэр хурандаа, И.В.Важнов гуай хоёр найз юм байж. Тэр хоёр хамтдаа Кремльд ажиллаж байсан юм байж. И.В.Важнов гуай бол МАХН-ын зөвлөхөөр Монголд ажиллаж байсан хүн юм шүү дээ. Тэр хүн И.В.Сталинтай байнга уулздаг байж. И.В.Важнов гэдэг энэ орос хүн манай ах, бэргэн эгч хоёрын гэрлэх асуудлыг зохион байгуулсан юм шиг байгаа юм. Ах надад энэ талаар юу ч яриагүй л дээ. Би энэ тухай ахын комиссаруудаас нь хожим сонсож, мэдсэн юм. Би ингэж анх удаа бэргэн эгчээ харсан юм. 1947 онд манай бэргэн эгч Улаанбаатарт ирсэн юм.

КЮ: Та нар ахынхаа гэрт очдог байсан уу?

ЮА: Бид нар ахын гэрт нь очдог байсан юм шүү. Манай бэргэн эгч, эхнэр бид хоёрыг “Манайд ирж кино үз!” гэж дууддаг байлаа. Тэнд янз бүрийн л кино үздэг байлаа. Голдуу орос кино үзнэ дээ. Хөдөө аж ахуй, анагаах ухааны тухай кино бас үздэг байсан юм.

Манай гэр одоогийн офицеруудын ордны урд талд их удсан юм. Тэнд Хоршоодын холбооны орон сууц, бас ажлын байр нь байлаа. Тэгээд сүүлд би Гадаад худалдааны яаманд ажиллах болсон үеэс эхлээд манайх хотын төв рүү нүүж ирсэн юм. Манай ахынх хоёр хүүхэдтэй байсан юм. Том хүүг нь Владислав, бага хүүг нь Зориг гэдэг юм. Энэ хоёрын ах нь дөнгөж төрөөд хүн болж чадалгүй нас барсан юм. Одоо Ц.Зориг хүү Москвад амьдарч байна. Бага байхдаа тэр үе, үе манайд гүйгээд ирдэг байлаа. Ц.Зориг одоо хааяа Улаанбаатарт ирдэг юм. 1993 онд Владислав хүү нь нас барсан юм.

КЮ: Одоо А. Буянтөгс (Аюуш гуайн бага охин-ред.) жаахан ярих уу?

А.Буянтөгс: Манай аав Унгарт ажиллахаар явахад би Улаанбаатарт эмээ, өвөө хоёртойгоо үлдсэн юм. Тэр үед би аавын ахынд байнга очдог байсан юм. Тэдний гэрт л байсан даа. Яагаад гэвэл манай аавын ахынх эмэгтэй хүүхэдгүй айл шүү дээ. Тэгээд надад өөрийн хүүхэд шигээ л ханддаг байсан юм. Надад их юм зааж өгдөг байж билээ.

1984 оноос хойш манай аавын ах нь гэр бүлийнхээ хамт Москвад амьдрах боллоо. Тэр цагаас хойш би уулзаагүй их удсан юм л даа. 2001 оны 8-р сард би аспирантурт суралцахаар Москвад очлоо. Тэр үед би түүнтэй дахин уулзсан юм. Тэр намайг очиход их баярлаж байсан.

И Л: Би түүний хүү Ц.Зоригийн бичсэн “Сүүлчийн долоон жил” нэртэй дурсамжийн номыг уншиж үзсэн юм. Тэр номонд Ц.Зориг: “Аавыг албан

тушаалаас нь огцруулсан явдал бол цэвэр хуйвалдаан байсан. 1984 оны 7-р сарын сүүлчээр аав, ээж бид гурав ЗХУ-д амрахаар очсон. Манай гэр бүлийнхэн олон жил тэнд амарч байсан. Энэ удаа Монголоос явахад аавын бие эрүүл, саруул, ямар ч өвчний шинж тэмдэг мэдэгдээгүй. Гэтэл ЗХУ-ын Улсыг Аюулаас Хамгаалах Хороо (Комитет Государственной Безопасности КГБ–ред.) тэднийг Москвад шууд гэрийн хорионд оруулсан. Кремлийн эмч нар “Аавын чинь бие муу байна! Тэр ажил хийж болохгүй! Энд түүнийг эмчлэх шаардлагатай!” гэж хэлсэн. Гэвч тэд нар өвчний оношийг тодорхой тайлбарлаж чадахгүй байсан. Тэднийг Москвад гэрийн хорионд байхад МАХН-ын ТХ-ны 8-р бүгд хурал хуралдаж, аавыг бүх албан тушаалаас нь огцруулсан!” гэсэн утгатай зүйлүүдийг бичсэн байна билээ. Та энэ талаар юу хэлэх вэ?

ЮА: Тийм яриануудыг би сонсож байсан. Тэгж ярьдаг юм. Тэр хурал болохоос өмнө би ахтай уулзаж байсан. Манай ах надтай их юм ярьдаггүй байсан юм шүү дээ. Хааяа миний ажил ямар байгааг асуудаг байсан. Ондоо юм огт ярихгүй шүү дээ. Ер нь манай ах бол их дуугүй хүн байсан юм. Ярихдаа их дуртай хүн байдаг шүү дээ. Манай ах бол тийм биш. Ерөөсөө ярианд дуртай биш хүн байсан юм. Түүнээс хүн юм асуувал хариулаад хэлээд өгнө. Өөрөө яриа санаачлаад, яриа өдөөд, яриад байх нь их ховор. Ялангуяа ах дүү нартаа улс төр, улс орны байдал, өөрийн ажил төрлийн талаар ерөөсөө ярихгүй шүү дээ. Бид нарыг огт тоохгүй. Тийм сэдвээр бол тэр өөрийнхөө зиндааны хүмүүстэй л ярина шүү дээ. Бидэнтэй тийм сэдвээр огт ярихгүй. Харин ном унших маш их дуртай хүн байсан юм. Нэг ном уншаад эхэлбэл дуусгаж байж л сална шүү дээ.

Түүнийг нас барахын өмнөхөн манай бэргэн эгч намайг дуудсан юм. Тэр үед би Болгарт суугаа Элчин сайдан яаманд худалдааны төлөөлөгчийн ажил хийж байсан. Би Москвад очиж ахтайгаа уулзсан юм. Надтай уулзахад түүний бие үнэхээр тааруухан байсан шүү. Монголчууд өөх тостой зүйл хүнсэндээ их хэрэглэдэг шүү дээ. Тийм учир манайд элэг цөсний өвчин их байдаг юм. Ахад энэ чиглэлийн өвчин илэрсэн юм шиг байгаа юм. Би хэд хоног эмнэлэгт ахынхаа дэргэд байсан.

Өглөө 11 цагийн орчим нэг тариагаар түүнийг тарьдаг байсан юм. Чухам ямар нэртэй тариа байсныг би мэдэхгүй. Тэр тариа л түүнд сайн таардаггүй юм шиг надад санагдаад байсан юм. Тэр тариагаар тариулсны дараа л бие нь нэг л өөр болчихоод байх шиг байсан юм. “Зарим зүйлийг мартаад байна уу даа?” гэж надад санагдаад байсан. Ер нь бие нь муу, хэвтэрт байгаа хүн эрүүл хүн шиг байж чадахгүй л дээ. Тэгээд ч нас нь нилээд өндөр болсон байсан шүү дээ.

Манай ах ер нь бол их ой сайтай хүн байсан гэж би боддог юм.

Тэр ЗХУ-ын 74 төрлийн хэвлэлийг захиалаад уншдаг байлаа. Уншсан бүх мариалынхаа хэрэгтэй газар нь улаан, ногоон өнгийн харандаагаар зураад, захад нь тэмдэглэл хийдэг байсан юм. Тэгээд комиссарууддаа хэдэн оны, ямар сэтгүүлийн, хэд дэхь дугаарт ямар материал байгааг бүгдийг нь цээжээрээ хэлээд, “Тэр материалыг аваад ир!” гэж даалгадаг байсан юм. Би ийм яриаг комиссаруудаас нь сонссож байсан. Тэр гэртээ маш сайхан номын сантай байсан юм. Гадаад орнуудад сууж байгаа манай Элчин сайдын яамаар дамжуулаад маш сайн номнуудыг тэр цуглуулж чадсан юм.

КЮ: Тэр номын сан одоо хаана байна вэ?

ЮА: Ахын номын сан одоо байхгүй. Зарим номыг нь Улсын төв номын санд өгсөн юм уу? Үгүй юм уу? Бүү мэд Түүнийг бүх албан тушаалаас нь огцруулсны дараа байранд байсан эд хогшлуудыг нь тараачихсан юм шүү дээ. Чухам ямар байгууллагын шийдвэрээр ийм ажлыг хийснийг би мэдэхгүй. Монгол улсын төрийн тэргүүн байсан хүний өдөр дутам хэрэглэж байсан эд юмсыг тарааж, үрэн таран хийсэн явдал бол их хариуцлагагүй, маш харамсалтай хэрэг болсон юм. Манай ахын өөрөө бичсэн өдрийн тэмдэглэлүүд, янз бүрийн үед шагнуулсан шагналын тэмдэгнүүд, газрын зурагнууд, гал тогооны хэрэглэлүүдийг нь Улсын прокурорын газар хурааж авсан сураг байсан.

Харин түүний шагнуулсан төрийн одон медалууд нь хаана байсан юм бэ? Мэдэхгүй. Манай ахад Монгол хүмүүсийн өгсөн бэлэг дурсгалын зүйлүүд ч их байсан юм. Одоо тэд нар хаана байгаа юм бэ? Бүү мэд Манай ахад маш олон буу байсан юм. Ах бол ан хийдэг хүн байгаагүй юм. Гэхдээ гадаадын хүмүүс ахтай уулзахдаа буу бэлэглэдэг байсан юм билээ.

Манай ах Оросын цэргийн маш олон генералтай хувийн сайн танилууд байсан юм. Түүнийг Москвад амьдарч байхад нь тэд нараас байнга утас ирдэг байсан юм билээ. Манай ах 1939 оны Халх голын дайнд дэслэгч генерал цолтой орж байсан юм. Хожим маршал цолтой болсон хүн юм шүү дээ. Ахын байранд байсан буунуудыг нь Дотоод яам хурааж авсан юм билээ. Хожим музейд шилжүүлж өгсөн байж магадгүй. 1984 онд хуралдсан МАХН-ын ТХ-ны 8-р бүгд хурлын тухай тэр надтай нэг ч удаа ярьж байгаагүй.

И Л: Таныг Гадаад худалдааны яаманд ажиллаж байхад гадаад худалдааны алдагдлын тухай ярьдаг байсан уу?

ЮА: Гадаад худалдааны алдагдал гэж байсан юм. Гадаад худалдааны

шугамаар өгсөн, авсан зүйлүүдийн үнийн зөрөө гардаг байсан юм. Манайх өөрийн бараа, бүтээгдэхүүнээ өгөөд, оронд нь өөрт хэрэгтэй бараа бүтээгдэхүүн авна шүү дээ. Ийм үед үнийн зөрүү гардаг юм. Энэ бүхнээс гадаад худалдааны алдагдал гардаг юм. Дэлхийн зах зээл дээр боловсруулсан бэлэн бүтээгдэхүүн гаргавал ашиг ихтэй байдаг юм. Тухайлбал ямааны ноолуурыг түүхийгээр, ноолуур чигээр нь гаргах, ямааны ноолуураар цамц хийгээд гаргах хоёрт маш их ялгаа байдаг юм. Манай улс ийм үйлдвэрийн аргаар хийсэн бэлэн бүтээгдэхүүн гаргахын төлөө их хичээж байсан юм. ЗХУ бол манайхаас малын гаралтай түүхий эдийг авдаг гол орон байлаа шүү дээ.

Гадаад худалдааны яаманд үнийн хэлтэс гэсэн нэртэй нэг хэлтэс ажиллаж байсан юм. Тэнд дэлхийн зах зээлийн үнийн өөрчлөлтийн тухай мэдээллийг цаг тухайд нь авдаг байлаа. Монгол улс өргөн хэрэглээнийхээ бараг бүх барааг ЗХУ-аас авдаг байлаа. Энэ бүгдийг Монгол улс шууд мөнгийг нь төлөөд л авч байсан юм шүү дээ. ЗХУ бол манай гадаад эдийн засгийн гол түнш байлаа.

Үйлдвэр барих, зам тавих зэрэг томоохон хөрөнгө оруулалт шаардсан ажлуудад манай улс ЗХУ-аас зээл авч байсан байх. Бид ЗХУ-д мал экспортоор гаргаж байсан юм. Малыг амьдаар нь гаргахад алдагдалтай байдаг юм. Малыг гол нь Хатгалын боомтоор гаргаж байлаа. ЗХУ манайхаас амьд мал авахдаа нилээд хатуу шаардлага тавьдаг байсан юм. Малын халдварт өвчин гарсан тохиолдолд мал авахаа бүрэн зогсооно шүү дээ. Заримдаа халдварт өвчин биш байсан ч ганц нэг мал хөнгөн өвчин туссан бол авахгүй байх тохиолдол их гардаг юм. Манай дамжлаг баазуудад Хөдөө Аж Ахуй (ХАА)-н яамны малын эмч нар ажилладаг байлаа. Тэд нар малын эрүүл мэндийн талаар ЗХУ-ын талд танилцуулдаг юм. Мал хүлээж авч байгаа ЗХУ-ын талын мэргэжилтнүүдтэй ярьж зохицох асуудал их гардаг байлаа.

Би олон удаа Хатгалын боомтод очиж, оросуудтай олон асуудлыг зохицуулж байлаа. Манай Гадаад худалдааны яаманд Д.Ганжууржав, С.Цагаандорж, Б.Цэрэндэндэв нарын сайн ажилтнууд байсан юм. Тэд нар бол орос хүнтэй амархан ойлголцдог, ажлаа сайн мэддэг, туршлагатай хүмүүс байлаа. Гол нь ой тогтоомж сайтай, гүйлгээ ухаантай хүмүүс байсан юм. Эд нар бол Өвөрхангай, Архангай хавийн төв халх нутгийн хүмүүс юм.

Гадаадаас худалдаж авсан бараа бүтээгдэхүүнийг дотоодын зах зээл дээр зарах үнийг Үнэ, стандартын улсын хорооноос тогтоодог юм. Тэр үед бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байсан шүү дээ. Нэг төрлийн барааны үнэ он удаан жилээр ч өөрчлөгдөхгүй байх явдал байсан юм. Шинэ бараа бүтээгдэхүүнд шинээр үнийг нь тогтоож өгдөг байлаа.

Социалист орнууд бараа бүтээгдэхүүндээ улсаас хатуу үнэ тогтоож өгдөг учраас тэдэнтэй худалдаа хийхэд хялбар байдаг юм. Харин хөрөнгөтөн орнуудтай худалдаа хийхэд бараа бүтээгдэхүүн нэг бүрийн авах үнийг ярьж тохиролцоно шүү дээ. Их төвөгтэй ажил шүү.

Монгол улс гадаад орнуудтай худалдаа хийхэд тээврийн асуудал их хүнд байдаг юм. Монгол улсад гадаад усан замын тээвэр байхгүй. Гадаадаас авч байгаа бүх бараа бүтээгдэхүүнийг төмөр зам, эсвэл онгоцоор тээвэрлэдэг юм. Европын орнуудаас бараа тээвэрлэхэд Сибирийн төмөр замыг ашиглах хэрэгтэй болдог юм. Маш урт замыг туулж Монголд орж ирдэг юм. Бид ЗХУ-д төмөр зам ашигласны төлбөрийг төлнө шүү дээ. Овор багатай, хөнгөн зүйлүүдийг бол онгоцоор тээвэрлэж болдог юм. Онгоцоор хийж байгаа бүх тээвэр Москвагаар дамждаг байлаа.

КЮ: За, бидний өнөөдрийн яриа өндөрлөх дөхөж байна. Үлдэж байгаа богинохон хугацаанд танд өөрт чинь нэмж хэлэх үг байна уу?

ЮА: За, би өөрийн хийж явсан ажлынхаа талаар та бүхэнд ярилаа. Та бүхэн хэрэгтэй гэж үзсэн зүйлүүдээ авна биз дээ. Өөр нэмж хэлэх юм санаанд орж ирэхгүй байна шүү.

КЮ: За, сонирхолтой яриа ярьж өгсөн танд баярлалаа.

Санпилын Жалан-Аажав

1 “Миний төрсөн нутаг”	7 Сайд Нарын Зөвлөлийн хуулийн хорооны дарга.
2 Шохойн үйлдвэрийн ажилчин.	8 “Монгол телевиз” байгуулагдлаа.
3 Би нам, улсын төв сургуульд орлоо.	9 Улс Төр.
4 Би өөрийн төрөлх сургуульдаа багш болов.	10 Ю. Цэдэнбалын талаар миний хэлэх үг.
5 Хууль Судлах.	11 Хэлмэгдүүлэл.
6 Монгол улсын Ерөнхий прокурор.	

1 “Миний төрсөн нутаг”

Конагая Юүки (цаашид **КЮ**): За, өнөөдөр Монгол Ардын Хувьсгалт Нам (МАХН)-ын Төв Хороо (ТХ)-ны Улс Төрийн Товчоо (УТТ)-ны гишүүн, нарийн бичгийн дарга, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн орлогч дарга (дэд ерөнхийлөгч-ред.) зэрэг өндөр албан тушаалуудыг олон жил нэр төртэй хашиж явсан Санпилын Жалан-Аажав тантай уулзаж байгаадаа бид их баяртай байна. Монгол улсын шинэ үеийн түүх бичигдэж эхэлж байх тэр үед та төрж байжээ. Та хоёр үе тэнгийнхэн байна шүү дээ.

Санпилын Жалан-Аажав (цаашид **СЖ**): Тийм шүү. Тэгэж хэлж болно.

КЮ: Өнөөдрийн ярилцлагыг таны бага насны дурсамжаас эхэлбэл ямар вэ? Та хаана, хэдэн онд төрсөн, өөрийн аав, ээж, ах, эгч, дүү нарын тухай бидэнд ярьж өгнө үү?

СЖ: Тэгье. Өнөөдрийн энэ ярилцлагыг миний бага насны дурсамжаас эхэлье. Би Хантайшир уулын аймаг, Отгон хайрхан уулын хошуу буюу одоогийн Завхан аймгийн Алдархаан сумын нутагт 1923 онд төрсөн хүн. Богдын голын хөвөөнд Хэрэмтийн ам гэдэг газар манай гэрээвөлжөөндөө байхад би төрсөн гэдэг юм. Тэр үед орчин үеийн эмнэлэг байсангүй, бүх хүүхдүүд гэртээ төрдөг, тэднийг одоогийнхтой ижил бүртгэж авдаггүй байлаа. Би ч мөн тийм л байдлаар төрсөн байх.

Миний төрсөн нутаг Завхан аймаг бол Монголын баруун хэсэгт Улаанбаатараас 1150 км-ийн зайд оршдог, хангай, говь хосолсон, гол мөрөн, ой мод ихтэй нутаг юм. 1990 оноос өмнө Монгол улс 18 аймагтай байлаа. 1992 онд засаг захиргааны өөрчлөлт хийж 21 аймагтай болсон юм. 1921 оны Ардын хувьсгалаас өмнө бол 4 аймаг, шавь тавтай, дал

гаруй хошуутай байлаа. 1921 оноос хойш Монгол улс засаг захиргааны өөрчлөлтийг олон удаа хийсэн юм шүү дээ. Одоо бас л засаг захиргааны өөрчлөлт хийх юм шиг байна. Хэзээ яаж хийх нь тодорхой бус боловч улс төрийн хүрээнд энэ асуудал яригдаад эхэлсэн байна.

Миний төрсөн Алдархаан суманд Монголын хоёр дахь өндөр уул Отгонтэнгэр Богд Очирваань хайрхан оршдог юм. Тэр далайн түвшнээс 4.300 гаруй метрт өргөгдсөн учир орой нь өвөл ч, зун ч байнга мөнх цастай байдаг юм. Энэ уул бол монголчууд бидний хамгийн их бэлэгшээж, тахиж, шүтэж байдаг их хайрхануудын нэг юм. Энд Отгонтэнгэр уулын тахилга жил бүр болдог. Энэ тахилгад Монголын бүх аймгаас ард олон хуран цуглардаг юм. Отгон тэнгэр уул эргэн тойрондоо тансаг сайхан үнэртэй арцаар хучаастай байдаг билээ. Энэ уулын хормойд Хөх нуур, Цагаан нуур гэсэн 2 сайхан нуур бий. Бас Отгонтэнгэрийн рашаан гэж алдартай сайхан рашаан бий. Хүний эрүүл мэндэд туйлын сайн энэ рашааныг баруун аймгийн бүх ард түмэн ууж, түүнд орж хэрэглэдэг юм. Энд маш олон төрлийн өвчнийг анагаах чадалтай төрөл бүрийн рашаан байдаг юм. Биднийг хүүхэд байх үед хэн, хэзээ хийснийг нь мэдэхгүй, нүдний рашаан, хэл, гар, үе мөчний рашаан гэх мэтээр монголоор бичиж, англиар орчуулсан хуучин хаягтай байлаа. Англи хэлийг сайн мэддэг, эрдэмтэн хүн энэ тайлбарыг хийсэн байж магадгүй.

Аливаа хүнд хайртай юм олон л байдаг байх, тэгэхдээ төрсөн нутаг, төрүүлсэн эхээс илүү хайртай юм ер нь байдаг болов уу? Монголын сайхан орныг манай их зохиолч Д.Нацагдорж чин үнэнээр нь гайхамшигтай сайхнаар магтан дуулсан юм. Д.Нацагдоржийн “Миний нутаг” шүлэг бол, Монгол нутгаа монгол хэлээрээ яруу сайхнаар магтан дуулсан гайхамшигтай бүтээл юм. Бидний өвөг дээдэс ийм сайхан эх орныг, ийм сайхан хэл, соёлыг бидэнд өвлүүлж үлдээсэн юм шүү. Энэ сайхан нутагт монголчууд бид үеийн үеэсээ амьдарч, аж төрж өнөөдөртэй золгожээ. Би ийм л нутагт төрсөн хүн. Би үүгээрээ бахархаж, баярлаж явдаг хүн.

Миний ээжийн аав буюу миний өвөө аав бол Сүрэн тойн гэдэг нэртэй тайж хүн байсан юм. Чингис хааны Алтан ургийн цагаан ястай хүнийг тайж гэдэг шүү дээ. Гэхдээ буурал аав бол хамжлагагүй тайж байлаа. Сүрэн тойны охин Дашцэвэг бол миний ээж юм. Миний ээж дөрвөн хүү төрүүлсний хамгийн том нь би билээ. Би 15 нас хүртлээ өвөө аав, ээж хоёрынхоо хайр ивээл дор нутагтаа өсөж бойжлоо. Миний буурал аавынх 100 гаруй адуутай, 20-30 үхэртэй, 2-3 зуун хоньтой, дунд зэргийн хөрөнгө, чинээтэй айл байлаа. Манайхан зуны улиралд Хангай газар зусаад, өвөл нь говь руу нүүж өвөлждөг байлаа. Ингэж нүүхэд талдаа 300 шахуу км замыг туулдаг байлаа.

КЮ: Та хэзээ, хаана анх бага сургуульд орсон бэ?

СЖ: Би ер нь бага, дунд сургуульд сураагүй хүн юм шүү дээ. Намайг бага настай хүүхэд байх үед монголчууд, Монгол орон таван хошуу малаа маллаж, түүнийхээ буян хишгийг хүртэж мөр бүтэн, гэдэс цатгалан, дутагдаж гачиндах зүйлгүй амгалан тайван, аз жаргалтай сайн сайхан амьдарч байсан гэж би бодож явдаг юм. Манай нутагт ахуй амьдралын хувьд ядуувтар хувь хүн, айл өрх байсан боловч гуйлга гуйдаг, гэр оронгүй тэнүүчилж явдаг хүн огт байсангүй.

Бид тийм амьдрлыг огт мэддэггүй байлаа. Мал олонтой амьдрал нь хангалуун айл өрх, мал цөөнтэй амьдрал нь тарчигдуу айл өрх, хувь хүмүүсийгээ ад үздэггүй, харин ч ойргон нягтарч бие биендээ туслаж, ойр дотно харилцаатай байхыг хичээдэг байсан билээ. Ер нь монголчууд эрт дээр үеэс саахалт айл, хот айлын хэлбэрээр бие биентэйгээ ойртож, харилцан туслаж, ажил төрлөө хамтын хүчээр хийж байсан явдал нь нийгэм, эдийн засаг, улс төрийн асар их ач холбогдолтой, өвөрмөгц тогтолцоо байсан гэж би боддог юм. Намайг хүүхэд ахуй байхад манай нутагт хулгай, дээрэм хийх, бусдыг залилан мэхлэх, архи дан согтуурах, танхайрах, бусдын эрх чөлөөнд халдах, хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг, ямар нэгэн гэмт халдлага хийх зэрэг үйлдлүүдийн нэг нь ч огт байсангүй, би ийм үйлдлүүдийн тухай огт дуулаагүй, сонсоогүй явжээ. Бүх хүн бие биендээ ах, дүүсгээр найрсаг ханддаг, бие биенийгээ хайрлаж хүндэлдэг, амгалан тайван амьдарч байсан билээ.

Тэр үед манай нутагт хүрээ, хийд нилээд олон байлаа. 1921 онд Ардын хувьсгал ялж байх үед Монгол оронд нийт 700-гаад сүм, хийд, 100 гаран мянган лам, хувраг байсан гэсэн мэдээ байдаг юм. Тэдний нэлээд нь манай Завхан аймагт байжээ. Монголд 5-6 томоохон хутагт, хувилгаанууд байсны ихэнх нь манай Завхан аймгаас гаралтай юм байж. Хутагт, хувилгаан гэдэг бол Монголын Бурхны шашны өндөр цол хэргэм шүү дээ. Монголын томоохон хутагтын нэг Данзанравжаа говь нутагт амьдарч байж. Тэр “Говийн ноён хутагт” гэдэг нэрээр Монгол даяар алдаршсан байна. Данзанравжаа бол түүхч, зохиолч, шүлэгч бас жүжгийн зохиолч хүн байж.

Тэр үед манайхан хадлан хадаж авдаггүй байлаа. Цас их орсон үед цас багатай газар руугаа нүүнэ. Монголын нүүдэлчдийн нэг онцлог нь энэ юм шүү дээ. Цас их ороод, мал идэх өвсгүй болоод ирвэл цас багатай, мал идэх өвс сайтай нутаг руугаа нүүдэг юм. Манай нүүдэлч, малчид цас орох, салхи шуурга дэгдэхийг одоогийн цаг, уурын мэргэжилтнүүдээс илүү сайн мэддэг байсан гэж хэлж болно. Малчид, нүүдэлчид хэзээ цаг агаар хүйтрэхийг урьдчилж мэдээд, нүүдэл суудлаа зохицуулчихдаг юм. Малаа

онд мэнд сайн оруулахын тулд нүүх ажлаа хойш нь тавина гэсэн ойлголт огт байгаагүй юм.

Миний буурал аав Сүрэн тойн бол нутаг орондоо нэрд гарсан сайн малчин, төрөлхийн ухаантай, туйлын ажилсаг, сайхан зантай, хүнлэг хүн байлаа. Тэр айл, саахалтынхаа хүмүүст түшиг тулгуур болж, байнга туслаж, дэмжиж байдгаараа олон түмний хайр хүндэтгэлийг хүлээж явсан буянтай буурал байжээ.

Буурал аав маань өдөр болгон малдаа явдаг байсан учир нутгийн айлуудын мал хаана бэлчиж байгаа, тарга тэвээрэг нь ямар байгаа, хөдөө хээрийн бэлчээрт хаана ямар мал эзэнгүй, хариулагагүй явж байгаа талаар болон нутаг орны бэлчээр ус, цаг агаарын хувьсалт, өөрчлөлтийн талаар маш их өргөн мэдээлэлтэй, мэдлэгтэй хүн байсан юм. Тийм учраас буурал ааваас алдсан малаа асууж сураглах, нутаг орны бэлчээр, усны байдал, цаг агаарын талаар асууж мэдэх, нутаг оронд болж байгаа үйл явдлуудын талаар санаа бодлоо солилцох зорилготой олон хүн манайд цугладаг байлаа. Би буурал аавыгаа дагаж мал маллах арга ухаанаас нь суралцаж, насандаа тохирсон ажлуудыг муугүй хийж чаддаг болсон билээ.

Тэр үед манай нутагт бичиг, үсэг мэддэг хүн маш ховор байлаа. Манай буурал аав охиныгоо буюу миний ээжийг бага настай байхад нь монгол бичиг мэддэг хүнд шавь оруулж байжээ. Миний ээж ингэж монгол бичиг сурч, уншиж, бичиж чаддаг, дөрвөн аргын тоо боддог болсон байна. 1922 онд Хантайшир уулын аймаг шинээр байгуулагдахад миний ээж аймгийн захиргаанд бичээчийн ажилд орж байж. Миний ээж надад монгол бичиг өөрөө зааж сургасан юм. Бас нэмэх, хасах, үржүүлж, хуваах 4 аргаар тоо бодохыг зааж өгсөн юм. Ингэж би ээжээрээ Монгол бичиг, Дөрвөн аргын тоо заалгасан маань цаашид эрдэм номын мөр хөөх замын минь эхлэл нь болсон юм.

Тэр үед манай Алдархаан сумын нутагт, Яруугийн гол, Чигэстэйн голын савд Хөх хошуу хэмээх газар анхны бага сургууль байгуулагдаж, тэнд Д.Чимэд багш гэж олонд хүндлэгдсэн залуухан бүсгүй ажиллаж байлаа. Тэр шөвгөр хар гэж манай нутгийнхан нэрлэдэг савхин гутал өмсөж, гэзгээ тайрч халимаг болгоод, дугуй цагаан малгайг хазгайдуу тавьж явдаг нь их л содон, дэгжин харагддаг байж билээ. Д.Чимэд багш бол ард түмний үр хүүхдийг сургаж хүмүүжүүлэх ажлыг эхлүүлж, манай нутагт орчин цагийн соёл, боловсролын үндсийг тавьж өгсөн мөнхийн гавьяатай хүн билээ.

Тэр бага сургуулийн ойролцоо, ганцхан өрөөтэй жижигхэн цагаан байшинд Лодон гэдэг бага эмч ард олонд шинжлэх ухааны эмнэлэгийн тусламжийг үзүүлж эхэлсэн юм. Манай нутаг дахь анхны энэ Хүн эмнэлэгийн салбар нь Лодонгийн цагаан байшин нэрээр ард олны дунд

алдаршсан юм. Түүний яг дэргэд шахуу олон зуун лам, хуврагуудтай, аварга том барилга байгууламжтай, олон мянга мал, арвин их хөрөнгийг нь хариуцсан хүчирхэг жастай, ард олны дотор үлэмжийн их нэр хүндтэй алдарт Яруугийн хийд оршиж байсан ч ганц эмчтэй, ганцхан өрөөтэй Лодонгийн цагаан байшинд очиж өвчтэй биеэ үзүүлдэг, өвчин зовлонгоосоо салж, хагацдаг хүний тоо өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж, Лодон доктор ард олны дотор хурдан хугацаанд өндөр их нэр хүндийг олж байсан билээ. Хожим Лодонгийн цагаан байшингийн бага эмч Лодон мэдрэлийн өвчний тэргүүлэх эмч, шинжлэх ухааны доктор, профессор Монгол улс даяар нэр алдар нь түгсэн эмч болсон байж билээ.

Ичинхорлоогийн Лхагвасүрэн (цаашид **ИЛ**): Та бага болон дунд сургуульд сурч байгаагүй юм байна. Тэр үед хөдөөнөөс залуучууд голдуу л техникумд суралцах зорилгоор анх Улаанбаатарт орж ирсэн байдаг юм билээ. Анх ямар зорилгоор Улаанбаатар хотод ирж байсан бэ?

С Ж: Намайг арав орчим настай байхад буурал аав маань ертөнцийн мөнх бусыг үзүүлж, ээж бид нарын амьдрал их өөрчлөлт орсон юм. Манайх буурал аавын үед олон малтай, чинээлэг, нэр хүндтэй, сайхан айл байсан боловч, буурал ааваас хойш зуданд малаа үхүүлээд, амьдрал маань ихэд доошлож ирсэн юм. Ээж маань ганцаардаад хүүхдүүд бид нар нас бие гүйцээгүй, хэцүү үе байлаа. Монгол хүн малгүй болчихвол амьдрал нь хэцүү байдалд орно шүү дээ.

Миний ээж өрх толгойлж эхэлсэн энэ үед, манайх Шарав тойныхтой айл бууж, хэдэн жил хамт нүүж, буудаг болсон юм. Шарав тойн бол миний буурал аавын төрсөн дүү юм. Тэднийх олон малтай, хөрөнгө сайтай, дотроо гоёмсог тавилга бүхий том гэртэй, цэвэр цэмцгэр айл байж билээ. Шарав тойн, түүний эхнэр Намжил авгай хоёр нягт нямбай, маш ажилсаг, хот, хүрээний дээгүүр албаны буюу өндөр зиндааны хүмүүстэй харилцаа холбоо сайтай хүмүүс байсан юм. Шарав тойн болон түүний эхнэр Намжил авгай хоёр бол өөрсдийн л мал хөрөнгийг улам арвин болгож, баяжих бодолтой байснаас ээж, бид нарт туслах бодолгүй хүмүүс байлаа.

Манай мал цөөрч амьдрал маань дордох тусам тэдний бидэндтэй харьцах харьцаанд их өөрчлөлт орж байлаа. Манайх Шарав тойныхтой хамт бууснаас хойш би тэдний адууг малладаг болж, түүнийг өвөл, зунгүй шөнийн цагт манаж хонодог байж билээ. Би тэдний адууг малладаг болсноос хойш 5-6 жилийн дотор тэдний адуу маш хурдан өссөж, аймаг, сумандаа алдартай хурдан, жороо морьнуудтай болсон билээ. Би бас тэдний хонийг хариулдаг, ноос, үсийг нь хяргаж авдаг, эсгий хийхэд нь оролцдог, ус, түлээг нь зөөж өгдөг өөрөөр хэлбэл бүхий л хар, бор ажлыг

хийдэг болсон билээ.

Энэ бүх ажлыг насны бага байхад хийхэд хэцүү байсан боловч намайг ажил хийж сургасан, хатуужил суулгасан гэж боддог юм. Тэр үед манайх өөрийн мал цөөтэй болсон тул эсгий хийж гэрийнхээ бүрээсийг сольж чаддаггүй байлаа. Манай гэрийн эсгий аажмаар энд тэндээ цоорч, зуны цагт нар, сар харагддаг болж, борооны ус тэр чигээрээ урсан орж ирдэг болсон билээ. Шарав тойн, Намжил авгай хоёр бидний энэ байдлыг мэддэг байсан боловч огтхон ч туслаагүйгээр барахгүй, “хонь малгүй та нар юугаар эсгий хийх юм бэ?” гэж тавлаж байсныг би мартддаггүй юм. Тэр үед “би бушуухан том болж, ээждээ сайхан гэр барьж өгнө дөө!” гэж бодож байснаа сайн санаж байна. “Ээжийнхээ ачыг яаж хариулана даа, ээжийгээ хэзээ нэгэн цагт заавал баярлуулна даа!” гэсэн бодол чухамхүү тэр цаг мөчөөс намайг эзэмдсэн байх.

Манайх Шарав тойныхтой хамт Борхын гол, Донойн хөндий гэдэг газруудаар хаваржаад, зун болох үед Хангай өөд нүүж, Чигэстэйн голын хойд талаар зусаад, намар болоход бусад айлуудын хамтаар говь руу нүүж намаржаад, тэндээ өвөлждөг байлаа. Нэг намар айлууд уламжлалт ёсоор говь руу нүүх дөхөж байхад миний ээж, дүү бид хоёрт хандаж:

-Энэ жил гурвуулаа аймгийн төв орж өвөлжинө! Ээж нь хоёр хүүгээ сургуульд суулгаж, эрдэм ном сургана! Үүнээс хойш манайх Шарав тойныхтой хамт нүүхгүй! Та хоёр юу гэж бодож байна? гэж асуусан юм. “Манайх Шарав тойныхтой дахин хамт нүүхгүй!” гэсэн үгийг дуулаад дотроо маш их баярлаж байсан боловч ээждээ:

-Та өөрөө л мэд! гэж хэлж билээ.

Миний дүү Пүрэвжав ээжийн хэлсэн үгийг сонсоод, босон харайж гүйгээд ээжийг үнсэж:

-Ямар сайхан юм бэ? Ээжээ. Би сургуульд орно тиймээ? гэж хэлж байсныг би тодхон санадаг юм. Тэр орой ээж, дүү, бид гурав бараг хэзээ ч байгаагүй тийм их баяртай, хөгжөөнтэй сайхан байж билээ. Миний ээжийн энэ шийдвэр хүүхдүүдийнхээ ирээдүйг бодсон маш зөв шийдвэр байсан юм.

Шарав тойны эхнэр Намжил авгайн хэтэрхий нягт, нямбай чанар, хатуу үг тухайн үедээ миний дургүйг хүргэдэг, хор шарыг хөдөлгөдөг, хэцүү байсан боловч намайг ажилд сургаж, миний цаашдын амьдрал ирээдүйд тус болсныг би ойлгож явдаг билээ. Надаар олон жил малаа маллуулж, гэр ахуйн хамаг хүнд хүчир ажлаа хийлгэж байсны шан хөлсөнд намайг тэднийхээс салж бүр мөсөн явах үед нэг даага, таван төгрөг өгч байж билээ. Би түүнийг нь чамладаггүй юм.

Дүү бид хоёр Завхан аймгийн төв Улиастай хотын ерөнхий боловсролын дунд сургуульд ганцхан жил суралцаад, амьдралын

боломжгүй байдлаасаа болоод цаашид үргэлжлүүлэн суралцаж чадаагүй юм. Ер нь миний ерөнхий боловсролын сургуульд сурсан маань ердөө энэ л юм.

Манай нутагт Хөх хошуу гэдэг газар байдаг тухай дээр өгүүлсэн шүү дээ. Тэр нутаг бол их модтой, бас сайхан голуудтай, түүнийг нь дагаад бургас их ургадаг юм л даа. Тэнд манай нутгийн хүмүүс модоор гэрийн яс мод, гэрийн доторхи эд хогшил болон хүний хэрэгцээт бусад зүйлүүдийг хийж, түүнийг нь Ховд, Баянхонгор, Увс, Говь-Алтай зэрэг мод багатай аймгийн хүмүүс ирж, худалдаж авдаг байлаа. Миний ээж амьдралын хүнд хэцүү байдлыг хүүхдүүд бидэнд илэн далангүй тайлбарлан ойлгуулж, манайх Хөх хошуунд нүүж очихоор шийдсэн юм. Тэнд очоод ээж, бид хоёр модоор араг, шээзгий болон унь, хана, тооно зэрэг гэрийн яс мод хийх аргуудыг сайн хүмүүсээр заалгаж сурсан юм. Бид хоёр энэ ажлыг бас чиг муугүй сурсан байх, холоос ирсэн хүмүүс бидний хийсэн зүйлүүдийг худалдаж аваад явдаг болсон юм. Тэр үед цаасан мөнгө гүйлгээнд сайн ороогүй байлаа. Ээж бид хоёрын хийсэн зүйлүүдийг хүмүүс аваад оронд нь цагаан идээ өгдөг байлаа. Би ийм модчингийн ажлыг хоёр жил орчим хийсэн юм.

Тэр үед Улаанбаатар хот болон төвийн бүсийн аймгуудаар жижигхэн боловч үйлдвэрийн газрууд ашиглалтанд орж эхэлж байсан байх. Аж үйлдвэрийн комбинат ч ашиглалтанд орж байсан байх. Яг ийм үед Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт байдаг Цагаан булаг дахь шохойн үйлдвэрээс хүмүүс ирээд, манай нутгаас ажилчин элсүүлж эхэлсэн юм. Тэд нар Улиастай хотод байрлаж байгаа гэдгийг дуулаад, ээж бид хоёр тэнд очихоор шийдлээ. Тэд нар миний ээжийг ажилчнаар элсүүлж авахаар боллоо. Ингээд ээж, миний хойд аав болж байсан Санпил ах хоёр Улаанбаатар явсан юм. Би ээжийгээ хол газар явуулахад хэцүү байсан боловч өөрөө заавал хойноос нь очих бодолтойгоор үлдэж байлаа. Би ээжийнхээ хойноос хурдан очихыг л үргэлж бодож явдаг байсан байх.

Манайхтай айл байсан, намайг сайн таних, нутгийн ах Н.Чимэдрэгзэн Завхан аймгийн захиргаанд ажиллаж байсан юм. Би түүнтэй нэг удаа уулзахдаа, намайг Улаанбаатар хотод ямар нэгэн сургуульд явуулж өгөхийг гуйлаа. Ингээд хэд хонож байтал Н. Чимэдрэгзэн ах нэг өдөр намайг өөрийн гэрт ирэхийг урьжээ. Намайг тэдний гэрт яаран очиход тэр:

-Чамайг Улаанбаатар хотын “Хүн эмнэлэгийн техникум” явуулахаар боллоо. Чи маргааш аймгийн захиргаан дээр очиж замынхаа зардлын мөнгийг аваарай! гэж хэлсэн юм. Тэр үед Улаанбаатар хот руу сургуульд явж байгаа хүнд замын зардлыг нь аймгийн захиргаанаас өгдөг байлаа.

Н.Чимэдрэгзэн ах Завхан аймагт ирсэн Хүн эмнэлэгийн техникумын

ганцхан хуваарийг надад авч өгсөн юм билээ.

Ингэж би Улаанбаатар явах боллоо. Тэр үед Завхан аймгиас Улаанбаатар хүртэл шуудангийн машинаас өөр явах унаа байгаагүй юм. Одоогийнхтой ижил нисэх онгоц байсангүй. Ингээд би шуудангийн машинд суугаад, замдаа 18 хоног явж Улаанбаатарт ирж байлаа. Миний суусан машин Улаанбаатар хотын Монгол тээхийн буудалд ирэхэд, олон хоног намайг хүлээгээд, их ядарсан ээж минь угтаж авч байсан юм. Ээж бид хоёр ингэж дахин уулзаж чадсандаа туйлын их баярлалдаж байж билээ.

КЮ: Энэ хэзээ болсон үйл явдал вэ? Та Хүн эмнэлэгийн техникумд суралцаад эмч болсон уу?

С Ж: Энэ бол 1937 оны намар болсон үйл явдал шүү дээ. Ээж бид хоёр хэд хоногийн дараа Хүн эмнэлэгийн техникум дээр очлоо. Тэр сургууль одоогийн Эрүүл мэндийн яам байгаа газрын ойролцоо байсан юм. Би сургуулийн захирал дээр нь орлоо. Завхан аймгаас гарахад Аймгийн захиргаанаас надад сургуулийн бичиг өгсөн юм. Түүнийгээ захиралд үзүүлээ. Тэгтэл захирал:

-За, ойлголоо. Дотуур байранд орно доо! Хувцасаа соль, усанд ор! Сургууль удахгүй эхлэнэ! Тэр болтол ийм бэлтгэл хийгээд байж бай! гэсэн утгатай зүйл хэлж байна. Би захиралд:

-За, гэж хэлчихээд өрөөнөөс нь гарлаа. Гадаа миний ээж хүлээж байсан юм.

Тэгээд би ээждээ:

-Ээжээ, би энэ сургуульд орохгүй! Тантай хамт Цагаан булаг дахь шохойн үйлдвэрт ажилд орбё! Та тэнд ганцаараа ажиллаад, их цалин авч чадахгүй байгаа шүү дээ! гэж хэллээ. Ээж надад юм хэлсэнгүй, дуугүй л байлаа. Ээж дургүй байна гэж би ойлголоо. Ингээд ээж бид хоёр энэ талаар удаан ярилцлаа. Эцэст нь би дийллээ. Тэр үед би арван таван нас дөнгөж хүрч байсан юм шүү дээ. “Насанд хүрээгүй хүүхэд ажилд авахгүй байх!” гэж ээж айгаад байсан юм байж. Насанд хүрээгүй хүүхдийг улсын үйлдвэрийн газар ажлуулахыг хуулиар хорьдог байсан юм байж. Би үүнийг хожим ойлгосон юм. Ингээд хэд хоногийн дараа бид нар Цагаан булаг дахь шохойн үйлдвэр байдаг Эрдэнэ суманд ирлээ. Санпил гуай бид хоёр хамт явж шохойн үйлдвэр дээр ирж даргатай нь уулзлаа. Тэр үйлдвэрийн дарга С.Дагвадорж гэдэг хүн байсан юм. Би тэр хүнд ажилд орохыг хүссэн өргөдөлөө өглөө. С.Дагвадорж дарга миний өргөдлийг уншиж үзээд:

-Чи хөдөлмөрийн насанд хүрээгүй хүн байна. Насанд хүрээгүй хүнийг ажилд авдаггүй юм шүү дээ! Тэгээд ч чи ийм хүнд ажил хийж чадах юм

уу? Энд уул нураадаг ажил хийдэг юм шүү дээ! гэж байна. Би түүнд юу ч хариулж чадсангүй. Гэтэл Санпил гуай:

-Манай Жалан-Аажав энэ ажлыг хийж чадах байх аа. Хөдөө байхдаа мал сайн малладаг хүүхэд байсан юм. Бас модчин хийж байсан хүн шүү! гэх мэтээр миний талаар магтаалын хэдэн үг хэллээ. Үйлдвэрийн дарга түүний үгийг анхааралтай сонсож байгаад:

-Аа, тийм үү. Тэгвэл нэг арга байна. Насанд хүрээгүй хүн учир чамайг туслах ажилчинаар л авч болох юм байна. Чи өдөрт 6 цаг л ажиллана шүү дээ! Бусад хүнтэй ижил 8 цаг биш. Чиний ажиллах бригадыг бид одоохон шийднэ! гэж хэллээ. Ингэж миний хүсэл биелэж Шохойн үйлдвэрийн ажилчин болсон юм.

2 Шохойн үйлдвэрийн ажилчин.

КЮ: Та улс, эх орондоо хөдөлмөрлөсөн хөдөлмөрийнхөө гарааг Шохойн үйлдвэрийн ажилчин болж эхлэж байжээ. Харин яаж хуульч мэргэжилтэй болсон тухайгаа ярьж өгнө үү?

СЖ: Цагаан булаг дахь Шохойны үйлдвэр бол Улаанбаатар хотыг шохойгоор хангадаг, манай барилгын материалын томоохон үйлдвэр байсан юм.

С.Дагвадорж дарга миний ажиллах бригадыг үнэхээр тэр өдөрт нь шийдсэн байж. Би Т.Амир даргатай, голдуу казах, чантуу нараас тогтсон бригадад ажиллах боллоо. Манай бригадын дарга Т.Амир гуай бол монголоор маш цэвэрхэн ярьдаг чантуу хүн байлаа. Намайг ажилд орсон өдөр Т.Амир гуай надад миний хөдөлмөрийн багаж зэвсэг болох хүрз, зээтүү, том лантуу, хурц иртэй цүүц, дотроо дарьтай цагаан ишнүүр, төмөр лаазтай дарь өгч билээ. Ингээд би Жамбаа гэдэг монгол залуутай хамт ажиллахаар боллоо. Манай бригадад бид хоёроос өөр монгол хүн байсангүй.

Тэр үед бид нар шохойгоо Оросын “Урал Зис-5” гэдэг машинд ачдаг байлаа. Сүүлд пар, пар гэсэн дуутай намхан хар машинд ачдаг болсон юм. Энэ бол Халх голын дайнд Япончуудаас олзлож авсан машин байсан юм гэнэ билээ. Чухам ямар замаар энэ үйлдвэрт ирсэн юм бэ? Бүү мэд.

Тэр үед Улаанбаатар хот дөнгөж л барилгажиж эхэлж байлаа. Би тэр үйлдвэрт чулуучин хийж эхэлсэн юм. Шохойн чулуун хадыг бид нар нэг метр орчим диаметртэй, 70-80 см-тэй гүнзгий нүхлээд, тэр нүхнийхээ ёроолд нь дотроо дарьтай ишнүүрийнхээ үзүүрийг байрлуулаад, түүнийг нойтон шохойгоор булдаг юм. Ингээд ишнүүрийнхээ нөгөө үзүүрийг шүдэнзээр асаадаг юм. Гал явсаар дарьтай ишнүүрт хүрч дэлбэрдэг юм.

Бид нар дэлбэрэлт болохоос өмнө өөрсдөө тэндээс хол зайлсан байх ёстой юм. Үүний тулд бид нар ишнүүрийн ил байгаа үзүүрт шүдэнз зурж асаамагц, хар хурдаараа гүйж хол зайлдаг байлаа.

Манай бригадын дарга Т.Амир гуай өөрөө маш сайн ажилладаг, өөрийнхөө бригадын ажилчдад маш өндөр шаардлага тавьдаг хүн байлаа. Би ажлаа хурдан сурч, Жамбаа бид хоёр “Сайн ажиллаж байна!” гэж түүнд магтуулдаг боллоо.

Би насанд хүрээгүй байсан болохоор үйлдвэрийн даргын хэлсэн ёсоор өдөрт 6 цаг ажиллах ёстой байсан юм. Гэтэл ажилдаа дасаад, ажлаа сайн хийж чаддаг болоод ирэхээр 8 цаг ажилладаг боллоо. Заримдаа 10 цаг ажиллах ч үе гардаг боллоо. Зарим үед шохой шатаах ажилд шөнийн цагаар гардаг болов. Миний ажлын цагийг хянадаг хүнгүй боллоо.

Ингэж ажилласаар байтал анхны цалин авах боллоо. Би анх удаа маш өндөр цалин авч үзлээ. Би ийм их өндөр цалин авсандаа маш их гайхаж, бас маш их баярлаж байж билээ. Надад үндсэн цалингаас гадна илүү цаг ажилсны хөлсийг нэмээд, нийтдээ 800 төгрөг өгсөн юм. Би цалингаа аваад шууд дэлгүүрт хар хурдаараа гүйж очоод, хөх цэнхэр өнгөтэй торгоноос нэг дээл хийх хэмжээгээр, бор ногоон өнгөтэй торгоноос нэг дээл хийх хэмжээгээр аваад, төмөр лаазтай орос чихэр бас нэмж аваад, үлдсэн мөнгөнийхөө хамт ээждээ авч ирж өгч байлаа. Бидний ажлын байрнаас холгүй манай үйлдвэрийн ажилчдад зориулсан дэлгүүр байсан юм. Тэр дэлгүүрт голдуу Германы бараа зардаг байлаа.

Миний ээж тэр өдөр маш их баярлаж билээ. Миний ээж надад сайхан бууз хийж өгөөд “Эр хүн өсөж, эсгий сунана гэдэг чинь энэ шүү дээ!” гэж дахин, дахин хэлж байж билээ. 800 төгрөг гэдэг бол тэр үеийн ханшаар маш их мөнгө байсан юм. Нэг сайн морийг 20 төгрөгөөр, нэг хонийг 6 төгрөгөөр авч байсан үе шүү дээ. “Хүн болсных ээжийгээ баярлуулж явах хэрэгтэй!” гэж миний буурал аав надад бүр багаас ойлгуулдаг байсан юм л даа. Түүний сургадаг олон сургааль бий. “Нүгэл хийж болохгүй! Дандаа буян хийж байх хэрэгтэй! Хүнд дандаа тус болж явах хэрэгтэй! Ямар ч хүнийг, хэзээ ч муу хэлж болохгүй!” гэж тэр сургадаг байлаа.

Монгол хүний сэтгэл зүйд нэг онцлог юм бий. Энэ бол эцэг, эхийн ачийг хариулах, эцэг, эхийгээ баярлуулж, ачийг нь хариулах эрмэлзэл юм. “Монгол хүн болгонд ийм эрмэлзэл байдаг!” гэж би боддог юм. Ялангуяа ээжийгээ баярлуулж, ачийг нь хариулах эрмэлзэл маш их хүчтэй байдаг юм. Манай ардын болон зохиолын дуу, шүлгэнд эхийн тухай сэдэв маш том байр суурийг эзэлж байдгийг та нар ажигласан байх. “Эцэг, эхийн ач буян бол юутай ч зүйрлэшгүй маш их арвин учир ямар ч хүн эцэг, эхийнхээ ачийг бүрэн дүүрэн хариулж чаддаггүй юм! Тийм учраас хүн өөрийн эцэг, эхийг бага ч гэсэн ямагт баярлуулж явах ёстой юм!” гэсэн

үзэл байдаг юм. Бороо орсны дараа өвсөн дээр тогтосон жижигхэн усан дуслуудыг монголчууд “шүүдэр” гэж нэрлэдэг шүү дээ. Тийм шүүдэрийн усыг цуглуулах нь маш их хэцүү ажил бөгөөд хүн яаж ч хичээгээд нэг аяга дүүрэн шүүдрийн ус цуглуулж бардаггүй юм гэнэ билээ. Эцэг, эхийн ач, буяныг хариулахыг монголчууд шүүдрийн ус цуглуулахтай адилтгасан байдаг юм.

Цагаан булаг дахь Шохойн үйлдвэрт би хоёр жил иймэрхүү маягаар ажиллаа. Манай үйлдвэрийн дарга С.Дагвадорж гуай надад муугүй ханддаг байлаа. Би монгол бичгээр уншдаг, бичдэг бас дөрвөн аргын тоо муухан боддог байсан нь нөлөөлсөн ч байж магадгүй.

1939 онд Цагаан булаг дахь Шохойн үйлдвэрийн захиргаа намайг Улаанбаатар хотод Санхүүгийн техникумд суралцуулах шийдвэр гаргасан юм. Тэр үед Монголд дээд сургууль байгуулагдаагүй, харин хэдэн сайхан техникум ажиллаж байлаа шүү дээ. Ингээд би Санхүүгийн техникумд суралцахаар хоёр дахь удаагаа Улаанбаатар хотод орж ирлээ.

Манай хамаатангийн нэг ахын гэр одоогийн Богд хааны ордон музейн орчим байсан юм. Тэр ахыг С.Додгор гэдэг юм. Ээж бид хоёр тэдний гэрт буугаад хэд хонолоо. Санхүүгийн техникум дээр арай очоогүй, ер нь удахгүй очихоор бэлтгэж байлаа.

С.Додгор ахын гэрийн хойд талаар Налайх руу явдаг нарийн төмөр зам гардаг байлаа. Тэдний гэрээс зүүн тийш Голын цэнгэлдэх байдаг юм. Энэ Голын цэнгэлдэх гэдэг бол Наадам хийдэг газар шүү дээ. Түүний урд талд том талбай байдаг юм. Наадмын үеэр тэнд төрөл бүрийн худалдаа гарч, олон хүн цуглардаг байсан юм. Түүнээс урагш, Туул голын бараг хөвөөнд ногоон дээвэртэй хэсэг цагаан байшин байсан юм. Тэр хэсэг цагаан байшингийн орчим орой болгон олон хүмүүс дуу дуулаад л жагсаалаараа явж байхыг би ажигладаг байлаа. Тэр хүмүүс бүгд ижил ногоон өнгийн дээл, шовгор оройтой малгай, савхин гутал өмссөн нь надад их содон харагддаг байж билээ. Юун хүмүүс, юу хийж байгааг би огт мэдэхгүй байсан юм. Тэд нар их сонин санагдаад, би хэдэн орой ажиглалаа. Тэгээд нэг өдөр С.Додгор ахыг ажлаа тараад гэртээ ирэхэд түүнээс:

-Энэ танай гэрээс зүүн тийш байгаа ногоон дээвэртэй цагаан байшингуудад юу байдаг юм бэ? гэж асуулаа.

С.Додгор ах:

-Тэр үү. Тэр бол “Нам, улсын төв сургууль”-ийн байр шүү дээ! Тэнд дандаа дарга болох хүмүүсийг бэлтгэдэг юм! Их сайхан сургууль шүү! гэж байна. Маргааш нь би дахиад тэнд очлоо. Олон хүмүүс дуу дуулаад л жагсаалаараа яваад л байна. “Энэ сургуульд яаж ордог юм бол?” гэж дотроо бодлоо. Тэгээд тэндээс С.Додгор ахынд эргэж ирээд ээждээ:

-Ээжээ, би Нам, улсын төв сургуульд орё! Энэ сургуульд орж болдог юм болов уу? Яаж ордог юм бол? гэж асуулаа.

Ээж миний үгийг сонсоод:

-Ээж нь яаж мэдэх вэ дээ! Тэр сургуульд орж болдог юм уу? Болдоггүй юм уу? Дарга нарыг бэлтгэдэг сургууль юм бол бид нар шиг хүмүүсийг авахгүй байлгүй дээ! Миний хүү С.Додгор ахаасаа асуугаад үз л дээ! гэж байна.

Ингээд би дахиад С. Додгор ахтай тэр сургуулийн талаар ярилцлаа. Түүнээс тэр сургуульд суралцуулахыг хүссэн өргөдөл бичээд, МАХН-ын ТХ-ны боловсон хүчний дарга Д.Доржпалам гэдэг хүнтэй уулзах ёстойг мэдэж авлаа. МАХН-ын Төв Хороо гэж юу хийдэг байгууллага юм бэ? Хаана байдаг юм бэ? Бүү мэд. Би энэ байгууллагын нэрийг бараг л анх удаагаа сонсож байсан байх. Ингээд МАХН-ын Төв Хорооны байр хаана байдгийг С.Додгор ахаар сайн заалгаж авлаа.

3 Би нам, улсын төв сургуульд орлоо.

С Ж: Маргааш нь би өөрөө сургуульд орох өргөдөл бичлээ. Ингээд ээжийгээ дагуулаад, МАХН-ын Төв Хорооны төв байранд ирлээ. Тэр үед МАХН-ын Төв Хорооны төв байр яг одоо байгаа тэр газраа байсан юм. Тэнд одоогийнх шиг том цагаан ордон биш, жижигхэн цагаан байшин байлаа. Би тэр жижигхэн цагаан байшинд орлоо. Тэнд жижүүр нь сууж байна. Тэр намайг ажиглаж хараад:

-Чи энд юу хийж яваа хүүхэд вэ? гэж дооглонгүй асууж байна.

Би:

-Үгүй, ахаа, Би МАХН-ын Төв Хорооны боловсон хүчний дарга С.Доржпалам гэдэг хүнтэй уулзах гэж ирсэн юм. Би тэр хүнтэй уулзаж болох уу? гэж асуулаа. “Намайг оруулахгүй байх!” хэмээн би дотороо их айж байсан байх л даа. Тэр жижүүр миний асуултанд хариулахгүй их л удах шиг болсон юм. Тэгтэл:

-Чи тэгээд түүнтэй уулзаж юу ярих юм бэ? гэж байна.

Би:

-Үгүй, ахаа. Би тэр хүнтэй уулзах маш чухал хэрэгтэй байна! гэж хэллээ. Тэгтэл жижүүр над руу их том харснаа, юу бодсон юм бэ бүү мэд:

-Тэнд зогсоод хүлээж бай! гэж хэлээд, сая миний орж ирсэн үүд рүү зааж байна. Би түүний заасан газарт нь очоод зогслоо. “Хүүхэд оруулахгүй. Гар!” гэж хэлэх байх гэж бодогдоод л байлаа. Жижүүр утсаар ярьж байна. Би их удаан хүлээлээ. Тэгж байтал тэр гараараа дохиод намайг дуудаж байна.

-За, чи одоо нэгдүгээр давхрын энэ өрөөнд оч! гээд өрөөний номер бичсэн

жижиг цаас өглөө. Би хайж явсаар байж тэр өрөөг олоод орлоо. Тэнд боровтор царайтай хүн сууж байна. Тэр хүн:

-За, чи ямар хэргээр ирсэн хүүхэд вэ? гэж асууж байна.

-Ахаа, би танд энэ өргөдөлийг өгөх гэж ирсэн юм! гэж хэлээд түүнд өглөө. Тэр хүн миний бичсэн өргөдөлийг уншиж ч үзсэнгүй. Эргүүлж, тойруулаад харж байна. Одоо бодоход ямар цаасан дээр юу бичиж өгсөн юм бэ? Бүү мэд. Олигтой юм байгаагүй биз.

Тэгтэл тэр хүн:

-За. Чи тэгээд бичиг, үсэг мэддэг хүн үү? Үгүй юү? гэж асууж байна.

Би:

-Мэддэг! гээд л хэлчихлээ.

Тэгтэл тэр хүн:

-За, тэгвэл чи энэ хүснэгтийг шугамдаад байж бай! 30 хувь хийх юм шүү. Сайхан цэвэрхэн хийгээрэй! Би одоо хуралд орлоо! гэж хэлээд баахан цаас, нэг шугам, харандаа, хүснэгт өгөөд, өөрөө гараад явчихлаа. Би нөгөө хүснэгтийг шугамдаад, хуулаад, хийгээд л байлаа. Аминдаа цэвэрхэн сайн хийхийг их хичээлээ. Тэр хүн орж ирэлгүй их удлаа. Намайг хүснэгтийг шугамдаад дуусч байхад тэр орж ирээд, миний хийсэн ажлыг анхааралтай үзэж эхэллээ. Тэр хүн хүснэгтийг хуудас бүрээр нь үзэж дуусаад:

-За, энэ болсон байна! Сайн хийсэн байна! гэж хэллээ шүү. Тэгээд нэг цаас авч юм бичлээ. Түүнийгээ надад өгөөд:

-Чи энэ бичгийг аваад Нам, улсын төв сургуулийн захирал Л.Сэрээтэр дээр оч! гэж хэллээ. Би түүний өрөөнөөс дөнгөж гараад тэр бичгийг уншиж үзвэл “Энэ хүүхдийг шалгалтанд оруул! Д.Доржпалам” гэж бичсэн байлаа.

Ингээд миний зорьсон хэрэг ийм сайхан бүтэмжтэй болсонд их баяртай тэр байшингаас гарч иртэл, ээж маань намайг олон цаг гадаа хүлээгээд маш их ядарсан, сэтгэл нь их зовсон сууж байж билээ.

1937-38 оны үед Монголд олон хүн ямарч учир шалтгаангүй баривчлагдаж, цаазлуулсан эмгэнэлт явдал болсон юм шүү дээ. “Улс төрийн хэлмэгдүүлэлт” газар авч байсан үе. Намайг тэр байшингаас гарч ирэхгүй удаад байхаар ээж “Миний хүү баривчлагдсан юм болов уу?” гэж бодоод, айгаад байсан юм байж л дээ. Ингээд ээж бид хоёр эсэн мэнд буцаж ирлээ.

Орой нь С.Додгор ахад болсон явдлаа ярьлаа. Тэр миний явсан хэрэг бүтэмжтэй болсонд бас их баярлаж байна. Ер нь тэр үед энгийн хүмүүс МАХН-ын Төв Хорооны төв байранд бараг ордоггүй байсан байх. Тэр тусмаа над шиг сургуульд орох өргөдөлөө өөрөө бариад тэнд очдог хүн ер нь байсан болов уу? Би чинь “МАХН ын Төв Хороо” гэдэг үгийн утгыг ойлгохгүй шахам байсан хирнээ тэнд сургуульд орох өргөдөл бариад

орчихсон хүн юм шүү дээ. Юу хийдэг, ямар гээч байгууллага болох талаар бол бүр юу ч мэдэхгүй хүн орсон байгаа юм. “Тэнэг хүн тэг дундуур нь” гэж монголчууд ярьдаг шүү дээ. Яг л тийм юм болсон юм. Манай С.Додгор ах ч тэр байшинд орж үзээгүй байсан юм байж л дээ. Тэр намайг “Маш зоригтой байна!” гэж магтаж байсан юм.

Маргааш нь би ээжийгээ дагуулаад Нам, улсын төв сургууль дээр ирлээ. Тэнд захирал Л.Сэрээтэртэй уулзлаа. Би захиралд Д.Доржпалам гуайн надад өгсөн бичгийг өглөө. Захирал түүнийг уншиж үзээд “Шалгалтанд орохыг зөвшөөрөв. Л.Сэрээтэр” гэсэн бас нэг бичгийг надад өглөө. Тэр энэ бичгийг надад өгөөд:

-Шалгалт маргааш эхэлнэ! Хоцорч болохгүй шүү! гэж хэлж байна.

Би:

-Багшаа! Ямар шалгалт авах вэ? гэж асууж байснаа одоо тодхон санадаг юм.

-Монгол бичиг, тоо бодлого, улс төрийн шалгалт авна! Сайн бэлтгэсэн биз дээ? гэж тэр хэлж байсан юм. Ингээд ээж, бид хоёр Додгор ахындаа буцаад ирлээ. Би “улс төр” гэж юу болохыг бас мэддэггүй. Тэгээд дахиад л С.Додгор ахаас энэ юу гэсэн утгатай үг болохыг нь асуулаа.

-Би сайн мэдэхгүй. Бодвол дэлхий дахины байдал, Монгол улсын дотоод, гадаад байдлын л тухай ярих хэрэгтэй байх л даа! гэж тэр хэлж байна. Тэгээд:

-Чи энэ номыг сайн унш! гэж хэлээд надад хатуу саарал хавтастай ном өглөө. Тэр ном нь “И.В.Сталин. ЗХУКН-ын 18-р их хурал дээр тавьсан илтгэл” гэсэн нэртэй байсан юм. Би ганцхан орой энэ номыг бүгдийг нь уншиж чадахгүй шүү дээ. Гэхдээ бас энэ сэдэв миний өгөх шалгалтанд хэрэг болох ч юм уу? үгүй ч юм уу? Бүү мэд. Тэгээд хэрэг болж магадгүй гэж бодоод нилээд хэдэн өгүүлбэрийг нь шууд цээжилчихлээ.

Ингээд маргааш нь шалгалтанд орлоо. Би тоо бодлогод их муу байсан юм. Нэмж, хасахыг бол бодоод байна. Харин үржүүлэх, хуваах үйлдлийг хийхдээ сайн биш л дээ. Надтай хамт шалгалтанд орсон нэг ах их сайн бодож байна. Тэгээд түүнээс бүгдийг нь шууд хуулаадөгчихлөө. Монгол бичгийн шалгалтыг нь бол өөрөө давчихлаа. Ингээд улс төрийн шалгалтанд орохоор боллоо. Додгор ахын өгсөн нөгөө номноос “500 сая хүнийг хамарсан дэлхийн 2-р дайн Шанхайгаас Гибралтарын хоолой хүртэл үргэлжилсээр байна!” гэх мэтийн өгүүлбэрүүдийг цээжилсэн маань санаанд тодхон ороод л байна. Тэр номноос цээжилсэн бусад өгүүлбэрүүдээ санах гээд оролдоод үзлээ. Бараг санаж байна. “Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэлийн дүрэм”-ээс би бас нилээд хэдэн өгүүлбэр цээжилсэн юм. Тэднийг бараг санаж байна. Ингээд шалгалт явагдаж байгаа өрөөнд орчихлоо. Тэгээд л шалгалт авч байгаа багшийн өмнө

суугаад нөгөө цээжилсэн зүйлсээ л эргүүлээд ярьж гарлаа. Одоо бодоход юу ярьж байсан юм бэ? бүү мэд. Баахан л юм яриад байсан шиг санагддаг юм. Уг нь багш надад өөрөө асуулт тавих ёстой шүү дээ.

Тэгж байтал багш:

-За болно! Их сайн байна! гэж байна шүү. Би айх, гайхах хоёр зэрэгцээд их сандарч, хөлс гарч, өвдөг чичирч байснаа санадаг юм. Ингээд шалгалтанд тэнцсэн юм байлгүй дээ, Нам, улсын төв сургуульд суралцахаар боллоо. Тэр үед энэ сургууль улс төр, хууль гэсэн үндсэн хоёр ангитай байсан юм. Энэ сургууль анх 1924 онд Намын түр сургууль нэртэйгээр, 19-30 насны 60 орчим суралцагчидтайгаар байгуулагдаж байсан түүхтэй юм. Түүнийг байгуулахад МАХН-ын Төв Хорооны дарга Ц.Дамбадорж гол үүрэг гүйцэтгэжээ. Сургуулийн нээлтийн ажиллагаа “Богд хааны хайстын ордонд” болж, түүнд Монгол улсын ерөнхий сайд Б.Цэрэндорж, Улсын бага хурлын дарга П.Гэндэн нар ирж, оролцож байжээ. Энэ сургуулийн анхны захиралаар нь МАХН-ын Төв Хорооны тэргүүлэгч гишүүн Н.Хаянхярваа ажиллаж байсан бөгөөд багшаар нь Б.Цэрэндорж, С.Данзан, Ж.Цэвээн, Р.Элбэгдорж, Г.Доржпалам нар ажиллаж байсан юм. Эд нар бол Монголын шинэ үеийн түүхэнд нэрээ үлдээсэн алдартай хүмүүс шүү дээ. 1940 он хүртэлх 16 жилийн дотор энэ сургуулийн 17 удаагийн төгсөлтөөр 1309 хүн төгсөж гарсан байна. Эд нар бүгд төрийн захиргааны удирдах ажилтан болсон юм. Үүнээс гадна эдийн засагч, ня-бо гийн мэргэжилтэй 100 гаруй хүнийг бэлтгэсэн юм билээ.

Өнгөрсөн жил энэ сургуулийн 80 жилийн ой боллоо. Одоо түүнийг Удирдлагын хөгжлийн Академи гэж нэрлэх болжээ.

Би энэ сургуульд 2 жил сураад “онцсайн” дүнтэй, “онцсайн” сахилга баттай төгссөн юм. Биднийг энэ сургуульд сурч байхад болсон нэгэн томоохон үйл явдал бол улс орон даяар өрнөсөн “Ноос бол алт” гэдэг хөдөлгөөн юм.

Урьд өмнө нь төдийлөн сайн ашигладаггүй байсан хонины ноос, ямааны ноолуурыг хаялгүйгээр цуглуулж авах их ажил өрнөлөө. Энэ ажилд Улаанбаатар хотын үйлдвэр, албан газруудын ажилчин, албан хаагчид, техникумд суралцагчдыг олноор нь дайчлан оролцуулсан юм. Манай сургуулийн суралцагчид ч бас дайчлагдан оролцлоо. Бидэнд ямааны ноолуурыг төмөр самаар хэрхэн самнах, хонины ноосыг хэрхэн хяргах талаар урьдчилан зааж, дадлага сургууль хийлгэсэн юм. Ингээд 6-р сард, хөдөө нутаг явах тэр өдөр Төв бараа баазын хашаанд “үдэлтийн ёслол” боллоо. Энэ ёслолын ажиллагаанд Ерөнхий сайд, маршал Х.Чойбалсан, МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Юмжаагийн Цэдэнбал нар ирж оролцсон юм. Тэд нар хүн бүрт төмрөөр хийсэн ямааы сам гардуулан өгч, улс орныг хамарсан энэ чухал ажилд

идэвхитэй оролцохыг захиж байсан юм.

Би Завхан аймгийн Баян-Уул суманд (одоо Говь-Алтай аймгийн сум болсон –ред.) хуваарьлагдан очлоо. Ингээд өртөөнөөс морь авч унаад, сургуулийн хүүхдүүдийг дагуулан явж, сумын бараг бүх айлаар орж, хонийг яаж хяргах, ямааг төмөр самаар хэрхэн самнахыг зааж сургаж, явсан билээ. Энэ бол манай улсад малын гаралтай түүхий эдийг төлөвлөгөөтэйгээр ашиглах томоохон ажлын эхлэл болсон билээ. Би энэ ажилд оролцоод 8-р сард Улаанбаатарт эргэж ирлээ. Намайг Улаанбаатарт эргэж ирэхэд манай сургуулийг татан буулгаад, Шинэ хүчний дээд сургууль болгон өөрчлөн зохион байгуулсан байлаа. Би шинээр байгуулагдсан Шинэ хүчний дээд сургуульд элсэн суралцах хүсэлтээ гаргах бодолтой хэсэг хугацааг өнгөрөөлөө.

Энэ үед тус сургуульд элсэн суралцах нарийн журам мөрдөгдөж эхэлсэн юм. Суралцах хүсэлтээ гаргасан хүмүүсээс эхлээд элсэлтийн шалгалт авна. Шалгалтанд тэнцсэн хүний асуудлыг МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга нарийн зөвлөлгөөнөөр авч хэлэлцэнэ. МАХН-ын нарийн бичгийн дарга нар тэр хүнд олон янзын асуулт тавьж, хариулт авна. Тэд нар ингэж хүн бүртэй сайтар танилцдаг байлаа. Ингээд тухайн хүн шаардлага хангаж байгаа бол МАХН-ын Төв Хорооны тогтоол гарч, сургуульд суралцах зам нь нээгддэг байлаа. Шинээр байгуулагдсан

Шинэ хүчний дээд сургуульд, ялангуяа эхний жилүүдэд Улаанбаатар хот, аймгийн МАХН-ын хороодын нарийн бичгийн дарга нар, аймгийн дарга, тэдгээрийн орлогчид, үйлдвэр аж ахуйн газрын дарга нар, олон нийтийн байгууллагын удирдагчид зэрэг хариуцлагатай ажил хийж байгаа хүмүүс тэргүүн ээлжинд элсэн орж суралцаж байлаа. Мөн сурлага, сахилга бат сайтай цаашдаа сурч боловсрох ирээдүйтэй, тэргүүний сайн залуучуудыг тус сургуульд элсүүлэх бодлогыг тууштай баримтлаж байсан юм. Миний хувьд урьд өмнө нь МАХН-ын болон улсын хариуцлагатай ажил хийж байгаагүй боловч Нам, улсын төв сургуулийг “онц” дүнтэй төгссөн болон элсэлтийн шалгалтыг маш сайн өгсөн тул энэ сургуульд суралцах боломжтой болсон юм.

Шинэ хүчний дээд сургуулийн захирлаар МАХН-ын ТХ-ны тэргүүлэгч гишүүн, нарийн бичгийн дарга, Ерөнхий сайд маршал Х.Чойбалсангийн нэгдүгээр орлогч Ч.Сүрэнжав гуай олон жил ажилласан юм. Энэ үед манай улсад бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх, ялангуяа удирдах ажилтан, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх талаар эргэлтийн шинжтэй олон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн юм.1941 онд миний элсэн орсон Шинэ хүчний дээд сургууль, 1942 онд Монгол Улсын Их Сургууль тус тус байгуулагдсан нь дээд боловсролтой, нарийн

мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд чухал алхам болсон билээ. Энэ хоёр сургуулийг байгуулах санаачлагыг анх МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбал гаргасан юм билээ.

Юмжаагийн Цэдэнбал Шинэ хүчний дээд сургуульд эдийн засгийн ухааны ерөнхий онолын хичээлийг зааж байлаа. Ю.Цэдэнбал К.Марксын “Капитал” гэдэг алдарт бүтээлийн үзэл санаанд тулгуурлаж бидэнд энэ хичээлийг заасан юм. Тэр үед “Капитал” монгол хэлэнд орчуулагдаагүй, Ю.Цэдэнбал түүнийг шууд орос хэл дээр уншиж, судласан байх. Германы суут ухаантан Карл Маркс энэ бүтээлдээ капиталист нийгмийн эдийн засгийн зүй тогтол, энэ нийгмийн үйлдвэрлэлийн харилцааны шинж чанарыг гүн гүнзгий задлан шинжилж, онолын дүгнэлт хийснийг Ю.Цэдэнбал бидэнд гайхамшигтай сайхнаар тайлбарлан ярьдаг байж билээ. Тэр самбар дээр шохойгоор бичиж, “Капитал”-д гарч байгаа улс, төр эдийн засгийн ухааны нэр томъёонуудын утгыг тайлбарлаж өгдөг байлаа. Ер нь Карл Марксын энэ алдарт бүтээлийг судлаж, улс төр, эдийн засгийн ухааны лекцийг уншсан анхны монгол хүн бол Юмжаагийн Цэдэнбал юм. Түүнтэй энэ талаар өрсөлдөх нэг ч хүн байгаагүй гэж хэлж болно. Ю.Цэдэнбал бол эдийн засгийн ухааны тусгай дээд боловсролтой, манай анхны томоохон сэхээтнүүдийн нэг байлаа. Тэрээр ямар ч хүнд тайлбарлан ойлгуулах чадвартай, маш өргөн мэдлэгтэй, энгийн үгээр, эмх цэгцтэй, ойлгомжтой ярьж чаддаг хүн байсан юм шүү дээ. Би хожим түүнтэй хамт хөдөө орон нутагт олон удаа, олон газраар явж, олон хүнтэй уулзаж, олон удаа түүний яриаг чагнаж байсан хүний хувьд үүнийг гэрчлэн хэлж байгаа юм.

Түгээмэл түүхийн хичээлийг Базарын Ширэндэв заадаг байлаа. Энэ хүн МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны гишүүн, нарийн бичгийн даргын албыг хашиж байгаад, хожим Ардын боловсролын яамны сайд, Монгол Улсын Их Сургуулийн анхны захирал, Монголын Шинжлэх ухааны академийн анхны ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж байсан билээ. Хожим академич болсон Д.Аюурзана, Ш.Лувсанвандан, гавьяат багш болсон Д.Цэдэнжав, С.Жамьяндагва нар бидэнд хичээл зааж байсан юм.

Ш.Лувсанвандан багш бол үнэхээр номын их багш, жинхэнэ эрдэмтэн хүн байсан юм. Гадаадын олон хэлийг бие дааж, өөрийн их хөдөлмөр, онцгой авъяас, ухаанаараа сурсан юм шүү дээ. Монгол хэл шинжлэлийн ухаанд Ш.Лувсанвандан багш бол мөнхийн гавъяатай хүн. Ш.Лувсанвандан багшийн зохиосон “Монгол бичгийн цагаан толгой”-г бид одоо ч хэрэглэсээр байна.

Манай Д.Аюурзана багш хожим нарийвтар ноостой “Орхон” үүлдрийн хонь гарган авч, Төрийн шагнал хүртсэн билээ. Монгол хонийг

нарийн ноостой хоньтой эрлийзжүүлэх туршилтыг тэр амжилттай хийж, цоо шинэ үүлдрийн хонийг Монголд бий болгож чадсан их эрдэмтэн, том гавьатай хүн билээ.

Би гэртээ ээжээрээ Монгол бичиг заалгаж, дөрвөн аргын тоо бодож сурсан, Улиастайн 10 жилийн сургуульд ганцхан жил суралцсан хүн анх нутгаасаа гарч байсан билээ.

Би Шинэ хүчний дээд сургуульд элсэн орж суралцаж байхдаа ирээдүйд хийх ажлынхаа тухай огт бодож байгаагүй юм. Ээж маань “Миний хүү эрдэм, номтой хүн болоорой. Ном сайн сураарай!” гэж захидаг байсныг л байнга санаж явсан билээ. 1930-1940 -өөд оны үед хөдөөнөөс Улаанбаатарт ирж сургуульд суралцагсадын дийлэнхи олонхи нь мал хөрөнгөөр ядмагхан буюу олон хүүхэдтэй айлын хүүхдүүд байсан юм. Тэр үед баян чинээлэг хүмүүс олон байсан боловч тэдэнд хүүхдээ сургуульд суралцуулах дур сонирхол огтхон ч байсангүй. Зовлон үзсэн, ялангуяа ядуугийн зовлон бэрхшээлийг үзсэн, дээгүүр зиндааны хүмүүст дээрэлхүүлж явсан хүн амьдарлын төлөө, хичээл сурлагын төлөө идэвхи зүтгэл гаргаж, өөрийгөө дайчлаж, тэмцэхдээ илүү байдаг байх.

Намайг оюутан байхад манай Шинэ хүчний сургуулийн оюутнууд Суртлын бригадыг удирдаж, хөдөө орон нутагт ажилладаг байлаа. Тэр үед ийм Суртлын бригадыг Монгол улсын бүх аймагт томилон ажиллуулж байсан юм. Сурталын бригад хөдөө орон нутагт ард олонд кино гарган үзүүлж, заримдаа дуулж, хуурдан урлагийн номер үзүүлж, Монгол орны дотоод байдал, олон улсын байдлын талаар яриа хийдэг байсан юм. Хөдөөгийн малчин, нүүдэлчин ард олон Суртлын бригад ирэхэд их дуртай, түүнийг маш их талархан хүлээж авдаг байлаа.

Би өөрийн Завхан аймагт Суртлын бригад удирдаж очоод, аймгийн төвийн албан байгууллагуудын бүх дарга нарыг соёлын ордонд цуглуулж, олон улсын байдлын талаар 4 цаг гаруй лекц уншихад хүмүүс миний яриаг ихэд сонирхож олон асуулт, асууж байсныг тод санаж байна. Миний лекцийн дараа олон хүн надад баяр хүргэж байсны дотор Завхан аймгийн дарга, тус аймаг дахь МАХН-ын хорооны дарга нар өөрсдөө ирж баяр хүргэж байсан нь миний урам зоригийг улам нэмж байсан юм. Энэ бүгдээс үндэслээд их юм мэддэг болох, мэддэг юмаа хүмүүст хүргэж, ярьж сурах нь маш чухал юм байна гэдгийг би улам бүр ойлгох болж, багшийн ажилд дуртай, сонирхолтой болж байсан билээ.

4 Би өөрийн төрөлх сургуульдаа багш болов.

С Ж: Манай сургуулийн анхны төгсөлт 1943 онд боллоо. Тэр үед манай сургуулийг 43 хүн төгссөн юм. Тэд нар бүгд Улаанбаатар хот болон

хөдөөгийн аймагт МАХН-ын болон, улс, олон нийтийн байгууллагуудад хариуцлагатай ажилд шууд томилогдож байлаа. Тухайлбал, надтай нэг ангид сурч байсан С.Дамдин Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэлийн Төв Хорооны 1-р нарийн бичгийн даргаар, Ц.Дашдэндэв Монгол улсын засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргаар, Т.Дамбийням Хөдөө Аж Ахуйн Яамны орлогч сайдаар, Б.Банзрагч, Ж.Чойжамц, С.Балжир нар хөдөөгийн аймгийн МАХН-ын хорооны нэгдүгээр нарийн бичгийн даргаар, С.Самдан Улаанбаатар хотын прокуророор тус тус томилогдож байсан билээ.

Сургуулийн захиргааны шийдвэр гарч намайг өөрийн сургуульдаа багшаар үлдээсэн юм. Миний хувьд МАХН болон төрийн удирдах ажилтан нарыг бэлтгэж байсан энэ том сургуульд багш болох мэдлэг, туршлага, ур чадвар хангалттай биш байсан нь мэдээжийн хэрэг. Гэхдээ манай сургуулийн захиргаа ийм шийдвэр гаргахдаа “цаашдаа хурдан хугацааны дотор мэдлэг, боловсролоо дээшлүүлж, багшлах ур чадвар эзэмшиж чадна!” гэж надад найдсан байх. Ингээд сургуулийн захиргаа намайг ЗХУ-ын Коммунист намын түүхийн багшаар томилож байлаа.

Тэр үед ЗХУКН-ын түүхийн сурах бичиг монгол хэл дээр бараг байсангүй. Анхны ганцхан сурах бичиг монгол хэл дээр дөнгөж хэвлэгдээд байсан үе юм. Гэтэл тэр сурах бичиг маш цөөхөн тоогоор хэвлэгдсэн тул хүн бүр түүнийг олж унших боломжгүй байлаа. 1944 оноос эхлээд МАХН-ын Төв Хорооны хүсэлтээр, ЗХУКН-ын Төв Хорооны дэргэдэх Нийгмийн ухааны академийн сонсогчдод зориулж Е.Ярославский гэдэг хүний бэлтгэсэн “ЗХУКН-ын түүхийн лекцийн эмхтгэл” манай сургуульд ирдэг болсон юм. Би орос хэл бараг мэдэхгүй байсан боловч тэр номыг толь бичгийн тусламжтайгаар унших гэж өдөр, шөнөгүй оролдсоор байгаад ерөнхий утгыг нь бараг ойлгодог боллоо. Ингээд өөрийн ойлгож мэдсэн зүйлүүдээ оюутнууддаа ярьж өгдөг болж байлаа.

Яг энэ үед МАХН-ын Төв Хорооны тогтоол гарч надад айхтар сүрхий албан даалгавар өглөө. МАХН-ын Төв Хороо Д.Төмөр-Очир философийн сэдвээр, С.Жалан-Аажав надад ЗХУКН-ын (большевик намын) түүхийн сэдвээр лекцүүд бэлтгэж, товхимол болгон хэвлүүлэх шийдвэр гаргасан юм. Дарамын Төмөр-Очир тэр үед манай сургуульд тэнхимийн эрхлэгчээр ажиллаж байлаа. Хожим тэр МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны гишүүн, нарийн бичгийн даргаар сонгогдон ажилласан юм.

Би ийм том даалгавар аваад В.И.Лениний “Юу хийх вэ?”, “Нэг алхам урагш хоёр алхам хойш”, “Материализм ба эмпиокритицизм”, “Төр ба хувьсгал”, “Социалист хувьсгал дахь социал-демократ намын хоёр тактик”, “Коммунизм дахь зүүний нялхсын өвчин” зэрэг зохиолуудыг өдөр, шөнөгүй сууж орос хэл дээр уншиж байлаа. Эдгээр нь В.И.Лениний

хамгийн алдартай зохиолууд бөгөөд марксизм-ленинизмын сургаалын сор болсон бүтээлүүд билээ.

Үүний үр дүнд би ЗХУКН-ын түүхийн сэдвээр 60 гаруй лекцийг бэлтгэж, 20 гаруй товхимолыг хэвлүүлж байлаа. Олон түмэн энэ товхимолуудад “С.Жалан-Аажавын лекцүүд” гэсэн нэр хайрласан юм. Миний хэвлүүлсэн товхимолууд олон жилийн туршид манай их дээд, сургуулиудын багш нар, оюутнуудын дунд гараас гар дамжин хэрэглэгдэж, гарын авлага болж байсан билээ. Миний мэдлэг боловсролын түвшингээс хамааран тэдгээр лекцүүд чанар чансааны хувьд хангалттай сайн байгаагүй нь мэдээжийн хэрэг боловч олон жил эдгээр лекцүүдийг олон хүн уншиж, гарын авлага болгон хэрэглэж, зарим хүн өөрөө ирж надад талархал илэрхийлж байсан нь надад их урам оруулж байсан билээ.

5 Хууль Судлах.

СЖ: Шинэ хүчний дээд сургуулийг төгссөнөөс хойш 7 жилийн дараа, 1951 онд би ЗХУ-ын Иркутск хотын улсын их сургуульд элсэн орж, 1956 онд хууль, түүхийн мэргэжлээр төгссөн юм. Их сургуулийн төгсөлтийн дипломын ажлаа би “1926 онд болсон Монгол улсын шүүхийн шинэчлэл” сэдвээр бичлээ. Миний дипломын ажилыг олон ном, зохиол бичиж ЗХУ-д ихэд нэрд гарсан эрдэмтэн Н.Ф.Фарберов удирдсан юм. Н.П.Фарберов багш намайг дипломын ажлаа амжилттай хамгаалсны дараа: “Би ЗХУ-ын Шинжлэх ухааны академийн төр, эрх зүйн хүрээлэнд ажллахаар болсон. Чи манай хүрээлэнд ирж, миний удирдлагын дор эрдмийн зэрэг хамгаалах ажил хийж болно. Би чамд туслана шүү!” гэж хэлсэн юм. Би маш их баярлаж, Москвад очиж, ЗХУ-ын ШУА-ийн Төр эрх зүйн хүрээлэнгийн доктрантурт элсэн суралцахаар багштайгаа тохиролцож байсан билээ. Гэсэн ч би энэ хүрээлэнгийн аспирантурт өдрөөр суралцах хүсэл маань биелээгүй юм. Харин албан ажлын зав чөлөөгөөр, амралтын цагаа ашиглан “Ардын төрийн хууль тогтоох ажлын үндсэн чиглэл: 1921-1941 он хүртэл” гэдэг сэдвээр эрдмийн зэрэг хамгаалах зохиолоо бичиж, 1967 онд ЗХУ-ын ШУА-ийн Төр, эрх зүйн хүрээлэнгийн эрдмийн зөвлөлд амжилттай хамгаалсан юм. Намайг эхэлсэн ажлаа ийнхүү амжилттай дуусгахад тус хүрээлэнгийн эрдэмтэд, миний багш Н.Ф.Фарберов гүн туслалцаа үзүүлсний ач тусыг би хэзээ ч мартдаггүй билээ.

Намайг ЗХУ-д сургуульд явуулж, эрх зүйн мэргэжил эзэмших, мөн эрдмийн зэрэг хамгаалахад дэмжлэг туслалцаа үзүүлж байсан МАХН-ын Төв Хороо, түүний удирдлагад би талархаж явдгаа энд хэлэхийг хүсч байна. Ер нь манай орон дахь нийгмийн социалист тогтолцооны үед

засгийн эрх барьж байсан МАХН улс, орноо хөгжүүлэх, ард түмнийхээ аж амьдрал, соёлын хэмжээг дээшлүүлэхийн төлөө маш их хүчин чармайлт гаргаж байсныг онцлон хэлэх ёстой гэж бодож байна. Дотоодын их, дээд сургуулиуд болон ЗХУ, бусад социалист орнуудад олон мянган залуучуудыг үнэ төлбөргүй сургаж, төрөл бүрийн мэргэжлийг эзэмшүүлж байсан билээ. Энэ ажил бол Монгол улсын хөгжил цэцэглэлтэнд үнэлж баршгүй ач холбогдлоо өгсөн юм.

И Л: Та Иркутск хотын улсын их сургуулийг төгсөж ирээд хуульч мэргэжлээрээ ажилласан уу? Эсвэл өөр ажил хийж байв уу? Хаана ажиллаж эхэлсэн бэ?

С Ж: Би Иркутск хотод их сургууль төгсөж ирээд, Шинэ хүчний сургуульдаа тэнхимийн эрхлэгч багшаар томилогдож, “БНМАУ-ын төр, эрхийн үндсүүд” гэдэг хичээлийг зааж эхэлсэн юм. Тэгээд багш, эрдэм шинжилгээний ажлаас өөр ажил хийхгүй гэсэн бодолтой ажилдаа урам зоригтой орж байлаа. Багшлах ажлынхаа хажуугаар эрдэм шинжилгээний ажлыг шаргуу хийж эхэлсэн юм. Би Монголын хууль цаазын түүхэн хөгжлийг сонирхон судлаж, “Халх журам бол Монгол хууль цаазын эртний дурсгалт бичиг мөн” гэсэн нэртэй эрдэм шинжилгээний анхны томоохон бүтээлээ 1958 онд хэвлүүлж байлаа.

“Халх журам” бол Монголын хууль, цаазын хөгжлийн хамгийн дорвитой бүтээл юм. Халх журам хуулийг 1709 оны үед Халхын Түшээт хан тэргүүтэй Монголын хаад, ноёд, төр, шашны тэргүүнүүд, эрдэмтэн мэргэд, одоогийн Булган, Сэлэнгэ аймгуудын заагт, Евийн голын хөвөө газарт хуралдаж, батлан гаргасан түүхтэй юм. Түүнээс хойш түүнийг хорь гаруй удаа дахин засварлаж, өөрчлөлт, нэмэлтийг оруулж байсан юм. “Халх журам”-ын талаар “Баруун хүрээний халх журам”, “Их хүрээний халх журам” гэдэг хоёр эх Монгол улсын төв номын сангийн гар бичмэлийн фондод хадгалагдан иржээ. Би “Халх журам”-д багтсан бүх хэргийг төрөлжүүлж, нийт арван дөрвөн бүлэг, гурван зуун нэг зүйлд хувааж, зарим нэр томъёонд нь тайлбар бичиж, дэлгэрэнгүй оршил бичээд хэвлүүлж байлаа. Цаашид энэхүү алдарт “Халх журам”-ыг бүхэлд нь болон түүн дотор багтсан олон хууль, олон төрлийн хэргүүдийг задлаж нарийвчлан судлах нь түүх судлал болон Монголын хууль, цаазны ухааны хөгжилд чухал ач холбогдолтой гэж би боддог юм. Миний бие Халх журам хуулийн сэдвээр олон улсын эрдэм шинжилгээний хуралд олон удаа оролцож, илтгэл хэлэлцүүлж байлаа.

Бас түүхэнд “Улаан хацарт” гэдэг нэрээр алдаршсан эрүүгийн болон иргэний хуулийг төрөлжүүлж, хоёр бүлэгт хувааж, эртний монгол

бичгээс одоогийн хэрэглэж байгаа крилл үсгэнд буулгаж, дэлгэрэнгүй оршил бичиж хэвлүүлэх ажлыг би гүйцэтгэж байлаа. “Улаан хацарт” нь Их шавийн яаманд үндсэндээ “Халх журам” хуулиар, шүүхийн журмаар таслан шийдвэрлэсэн олон хэргүүдийн түүвэр, эмхэтгэл юм. Өөрөөр хэлбэл шүүхийн практик буюу цаашид тэдгээртэй төсөөтэй хэргүүдийг таслан шийдвэрлэхэд үлгэр загвар болгон хэрэглэж болох тийм хэргүүдийн эмхэтгэл юм. “Улаан хацарт”-ыг судлаж үзэхэд хуучин цагийн хэрэг шийдвэрлэгч монгол түшмэлүүд тухайн хэрэг хууль зөрчсөн хэрэг мөн, эсэх, хэрэв мөн бол ямар хуульд хамаарагдах, тэр хэрэгт ямар төрлийн, ямар хэмжээний ял, шийтгэл ноогдуулах тухай асуудлыг алдаагүй, зөв мэргэн, шударга шийдвэрлэж байсныг мэдэж болно.

Үүнээс гадна би Монголын их Хубилай сэцэн хааны “төр засах хөтөлбөр” буюу түүхэнд “Арван буянт номын цагаан түүх” нэрээр алдаршсан сурвалж бичгийг судлаж, судалгааны нэгэн товхимлыг хэвлүүлсэн билээ. “Арван буянт номын цагаан түүх” бол Монголын төр ёс, хууль цаазны ухааны хөгжилд онцгой байр суурийн эзэлдэг чухал сурвалж бичиг юм. Ер нь Монголын төрт ёс, хууль цаазын сэтгэлгээний уламжлал бол аугаа их юм. Та нар Чингис хааны “Их засаг” хуулийн талаар сонссон байж магадгүй. Энэ бол Монголын төрт, ёс хууль цаазын сэтгэлгээний ноён оргил нь юм шүү дээ. Тэр үед хууль маш чанга хатуу байж. Түүнийг ягштал мөрддөг байж. Тэр үед тийм хуультай орон байсан юм уу? Мэдэхгүй. Бид өөрсдөө тийм байж дэлхийг хойноосоо дагуулна шүү дээ. Зүгээр нэг морь унаж, сэлэм эргүүлсэн, ааг, омгоо багтааж ядсан сахилгагүй Монголчууд газар сайгүй давхиад байсан юм биш. Түүхийг ийм байдлаар хялбарчилж болохгүй.

Миний бие Монголын төр ёс, Монголын хууль, цаазны ухааны түүхэн уламжлал, тэдгээрт холбогдох зарим гол, гол тулгуур хуулиудыг судлахын хамт төр, эрх зүйн онол, эрх зүйн гүн ухааны салбарт судалгаа хийж ирсэн юм. Мөн Монголын их, дээд сургуулиудад эрх зүйн мэргэжлээр суралцагсад болон энэ салбарт ажиллаж байгаа мэргэжилтнүүдэд зориулан “Төр эрх зүйн онол” нэртэй номоо хэвлүүлэн гаргалаа. Энэ номыг би өөрийн бичсэн лекцүүдэд тулгуурлан бэлтгэсэн юм. Өнгөрсөн хугацаанд би түүх, хууль, улс төр судлалын сэдвээр олон арван эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж хэвлүүлсэн байна.

Миний бие 1959 оноос 1984 оныг хүртэл өөр ажилд шилжсэн боловч багшлах ажлаа бүр мөсөн орхиогүй юм. Би Монгол улсын Ерөнхий прокурор, Монгол Улсын Сайд Нарын Зөвлөлийн Хуулийн Хорооны дарга /Хууль зүйн яамны сайд /, Мэдээлэл, Радио, Телевизийн улсын Хорооны даргын албыг хашиж байхдаа Монгол Улсын Их Сургуульд цөөхөн цагаар боловч “БНМАУ-ын төрийн эрх зүй”, “Эрх зүйн гүн

ухаан”-ны сэдвээр лекц уншиж байсан билээ. Мөн түүнчлэн МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн товчооны гишүүн, нарийн бичгийн даргын өндөр албан тушаалыг хашиж байхдаа ч боломж л гарвал цөөн цагаар Монгол улсын Их сургуульд лекц уншдаг байлаа.

Миний өөртөө баярлаж бахархаж явдаг нэг гол зүйл бол 1943 онд 21-22 настай байхаасаа эхлэн багш гэдэг сайхан нэртэй, энэ буянтай ажлыг орон тооны болон орон тооны бус хэлбэрээр 30 шахам жил хийж, олон зуун шавь нартай болсон явдал юм. Миний шавь нарын гол бүрэлдэхүүн бол МАХН, Монголын төр, олон нийт, хууль хяналт, соёл, боловсрол, аж ахуйн байгууллагуудын удирдах ажилтнууд, Монгол улсын хууль зүйн албаны гол хүч болж, түүнийг авч яваа хуульч хэмээх түгээмэл бөгөөд сайхан мэргэжлийг эзэмшсэн хүмүүс билээ. Миний багшлаж байсан үеийн ажлыг үнэлж, миний ажиллаж байсан Монгол Улсын Их Сургууль, Удирдлагын хөгжлийн академи зэрэг өнөөг цагийн Монгол улсын эрдэм, оюуны ноён оргил болсон сургуулиуд надад “Хүндэт профессор” цолоо хайрласанд би гүнээ талархаж явдаг билээ. Ингээд багшийнхаа ажил, эрдэм шинжилгээнийхээ ажлыг хийгээд байж байтал МАХН-ын Төв Хорооны үзэл суртал, соёлын асуудал эрхэлсэн нарийн бичгийн дарга Д.Төмөр-Очир нэг удаа надтай уулзаад :

-Чи МАХН ын Төв Хороонд ирж надтай хамт ажилла! Миний ажилд тусал! Одоо газар бүрт ажил сайжруулах асуудал хоолойд тулсан асуудал болоод байна! гэж хэлсэн юм. Би түүний энэ саналаас татгалзсан боловч тэр дахиад хэд хэдэн удаа энэ саналаа надад тавьсан юм. Гэтэл нэг өдөр би хичээлээ заагаад, шохойгоо бариад, самбарынхаа дэргэд, оюутнуудынхаа өмнө зогсож байтал манай сургуулийн захирал С.Доржбат ангид орж ирээд:

-Чамайг МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбал гуай дуудсан. Тэр сая надтай утсаар ярилаа! Одоо яаралтай хүрээд ир! гэсэн шүү. Хурдхан очихыг бодоорой! гэж хэлээд гараад явчихлаа. Ингээд би оюутнуудаа тараачихаад, МАХН-ын Төв хороон дээр яаран ирлээ. Намайг Ерөнхий нарийн бичгийн даргын ажлын өрөөнд ороход тэнд Ю.Цэдэнбал даргатай хамт Д.Төмөр-Очир сууж байлаа. Намайг орж ирэхийг Ю.Цэдэнбал дарга хараад, өөрийн хажууд байсан сул суудлыг зааж, суухыг урьлаа. Тэгээд:

-Энэ нөхөр (Д.Төмөр-Очирыг хэлж байна –ред.) чамайг МАХН-ын Төв Хорооны хэлтсийн даргаар томилуулах гээд гуншигнаад болдоггүй ээ! Би уг нь чамайг хуульч мэргэжлийн чинь дагуу маш чухал ажилд томилох бодолтой байсан юм. Гэтэл Д.Төмөр-Очир чамайг заавал Төв Хорооны хэлтсийн даргаар томилуулах гээд болохгүй байна! Тийм учраас өамайг энэ нөхрийн мэдэлд өгөхөөр бид нар шийдэж байна. Та хоёр бол

хамт ажиллаж байсан, бие биеэ сайн мэдэх хүмүүс шүү дээ. Одоо энэ асуудлыг МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны хуралд оруулж хэлэлцүүлнэ! гэв. Би үүний өмнө Д.Төмөр-Очирын хэлсэн саналаас олон удаа татгалзаж байсан боловч энэ удаа Ю.Цэдэнбал даргын саналаас татгалзаж чадсангүй “За!” гээд зөвшөөрчихлөө.

Ингэж би МАХН-ын Төв Хорооны үзэл суртал, соёлын хэлтсийн даргаар томилогдсон юм. Тэнд ажилладаг болоод шинэ ажилдаа дасаад, нилээд гаршиж байлаа. Миний даргаар Дарамын Төмөр-Очир ажиллаж байлаа. Би түүнтэй хамт Шинэ хүчний сургуульд ажиллаж байсан, бие биенийхээ ажлын арга барилыг мэддэг, бие, биенийгээ сайн ойлгодог байсан маань шинэ ажилд их тус болж байлаа. 1958 онд манай Шинэ хүчний дээд сургуулийг Намын дээд сургууль болгож өөрчлөн зохион байгуулсан билээ.

6 Монгол улсын Ерөнхий прокурор.

С Ж: Иймэрхүү байдлаар тэнд ажиллаж байтал нэг удаа Ю.Цэдэнбал дарга намайг дуудсан байлаа. МАХН-ын Төв Хороонд ажилладаг болсноос хойш өдөр тутмын ажлын шугамаар тэр намайг байнга дуудаж, үүрэг, даалгавар өгдөг байсан болохоор энэ удаа ч онцын юм бодсонгүй би түүний өрөөнд шууд л орчихлоо.

Гэтэл тэр:

-Бид нар чамайг нэг хатуухан эмээл дээр суулгахаар ярьж байна! гэж хэлдэг юм байна. Би жаахан гайхлаа. Тэгээд:

-Тэр чинь юу гэсэн үг вэ? даргаа, гэж асуулаа.

Тэгтэл тэр:

-Чамайг Монгол улсын Ерөнхий прокуророор томилохоор би ярьж байна! Энэ их чухал ажил байгаа юм шүү. Одоо хуулиа сайн биелүүлдэг болгох, хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудал их чухал болоод байна. Ажлын шаардлагаар чамайг Ерөнхий прокуророор томилож байгаа юм шүү. Чи сайн ажиллаарай! гэж байна. Тэр үед Ю.Цэдэнбалтай хамт Д.Төмөр-Очир бас сууж байсан юм. Хожим Д.Төмөр-Очир надад “Хууль завхруулах явдалтай хатуу тэмцэх, бүх шатанд хуулийн биелэлтэнд тавих хяналтыг эрс чангалах явдал маш чухал болоод байсан юм. Ийм учраас чамайг Ерөнхий прокуророор томилох Ю.Цэдэнбалын саналыг би дэмжсэн юм шүү!” гэж хэлж байж билээ. Намайг ийнхүү Монгол улсын Ерөнхий прокуророор томилсон явдалд би өөрөө дуртай биш байсан боловч тэр үед МАХН-ын гишүүн хүн, намын шийдвэр, өгсөн үүрэг даалгаварыг үг дуугүй биелүүлдэг байлаа. Бид нар ийм хүмүүжилтэй байсан болохоор шинээр томилогдсон ажилдаа орлоо.

Ингээд Монгол улсын Ерөнхий прокурорын газар очиж Ерөнхий прокуророор ажиллаж байсан Д.Чойжамц гуайтай уулзлаа. Д.Чойжамц гуай өөрийн ажил байдлын тухай, ажлаа хэрхэн хүлээлцэх тухай нилээд ярьлаа. Бидний яриа дуусах үед Д.Чойжамц гуай суудлаасаа босож, ширээнийхээ шургуулгыг онгойлгоод, нэг том тамга гаргаж ирээд надад гардуулан өглөө.

Тэгээд тэр:

-За, энэ бол бусад бүх тамганаас ялгаатай тамга байгаа юм шүү. Энэ тамгыг гагцхүү Ерөнхий прокурор өөрөө хадгалж байдаг ёстой юм! гэж хэлж билээ. Би төрийн том албаны тэр сүрхий тамганаас адис аваад, хадгалдаг газар нь буцаагаад тавьж билээ.

Би үнэхээр Ерөнхий прокурор гэдэг том албан тушаалаас сүрдэж, дотроо айж байлаа. “Яаж энэ том албыг хашина даа!” гэж миний сэтгэл их зовж байлаа. Хэдийгээр хуульч мэргэжилтэй боловч урьд нь тийм том албан тушаалын ажил хийж байсан туршлага надад байсангүй. Ингээд шинэ ажлаа хүлээж аваад, Ерөнхий прокурорын газрын аппаратын бүх ажилтнуудтай нэг бүрчлэн уулзаж, хийж байгаа ажлынх нь тухай асууж, тэдний санал, сэтгэгдлийг нь сонсож, хэлсэн, ярьсан бүхнийг бичиж авч байж билээ.

Тэр үед Улсын прокурорын газар нь Ерөнхий хяналтын хэлтэс, Мөрдөн байцаах ажлын хяналтын хэлтэс, Шүүхийн хяналтын хэлтэс, Тусгай хяналтын хэлтэс гэсэн үндсэн дөрвөн хяналтын хэлтэстэй, тэнд 60 орчим ажилтан ажиллаж байлаа. Прокурорын байгууллага Монгол улсын хуулийн биелэлтэд тавих дээд хяналтын эрх, мэдлийг хэрэгжүүлж байснаараа Монгол улсын хуулийн биелэлтийг тус улсын бүх нутаг дэвсгэр дээр нэгэн жигд хангах хэрэгт том үүрэг гүйцэтгэж байсан юм. Өөрөөр хэлбэл төр нь эрх мэдэл, чиг үүргээ хууль сахиулах байгууллагуудаараа дамжуулан хэрэгжүүлдэг учраас төрийн эрх мэдэл, чиг үүргийг хэрэгжүүлэх явдалд прокурорын бүх шатны байгууллага онцгой чухал үүрэг гүйцэтгэж байсан юм. Төр өөрийн чиг үүргийг амжилттай биелүүлэхийн тулд прокурорын байгууллагад өндөр эрх мэдэл эдлүүлж, үйл ажиллагаагаа өргөн цар хүрээтэй явуулах бүх талын бололцоогоор хангаж байсан нь зөв бодлого, зөв үзэл баримтлал, зөв үйл ажиллагаа байсан юм.

Прокурорын хяналтын үндсэн зорилт, үндсэн чиглэл нь:

Нэгдүгээрт. Монгол улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг бататган бэхжүүлэх, түүнийг ямар нэгэн гэмт халдлага, аюул заналаас хамгаалах;

Хоёрдугаарт. Монгол улсын бүх иргэдэд Үндсэн хууль болон бусад хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөг эдлүүлж, аливаа нэгэн зөрчлөөс

хамгаалах;

Гуравдугаарт. Бие хүмүүс болон нийгмийн амьдрал, хөгжил дэвшилд онцгой чухал ач холбогдолтой тэдгээрийн өмч хөрөнгийн халдашгүй дархан эрхийг хангах;

Дөрөвдүгээрт. Хүний амьд байх болон амьдрах эрх, эрүүл мэндийг ямар нэгэн халдлагаас хамгаалах.

Ер нь нийгмийн амьдралын тулгын гурван чулуу хэмээн олон улсын хэмжээнд нэрт эрдэмтэд цохон тэмдэглэж, тодорхойлсон хүн, эрх чөлөө, өмчийн халдашгүй дархан эрхийг хамгаалахад прокурорын ажил чиглэж байсан юм. Харин социалист нийгмийн тогтолцоонд зарим нэгэн дутагдал, хязгаарлалт, гажуудал байсныг дурдахгүй байж болохгүй. Энэ нь манай прокурорын үйл ажиллагаанд хүчтэй нөлөөлж байсан тал бий.

Прокурор Монгол улсын хуулийн биелэлтэд дээд хяналт тавьж тэдгээрийн биелэлтийг бүрэн дүүрэн хангуулж байхын тулд:

Нэгдүгээрт. Монгол улсын бүх хуулийг нэг мөр, нарийн чанд сахиж биелүүлэхийг төрийн ба төрийн бус байгууллага, тэдгээрийн бүх албан тушаалтан, нийт ард иргэдээс нэгэн адил шаардаж, ханган биелүүлж байсан. Прокурорын байгууллага үйл ажиллагаандаа “Монгол улсын бүх иргэд хуулийн өмнө тэгш эрхтэй байх”, “хуулийн хариуцлагыг мөн нэгэн адил хүлээдэг байх” зарчмыг баримталж хэрэгжүүлдэг байв.

Хоёрдугаарт. Гэмт хэрэг үйлдэгсэдийг илрүүлэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагаанд хяналт тавьж, холбогдох хууль, тогтоомжийн биелэлтийг хангуулж, “гэмт хэрэг үйлдсэн нэг ч этгээдэд ял завшуулахгүй, гэмт хэрэг хийгээгүй нэг ч хүнийг хохироохгүй байх” зарчмыг хатуу баримталж ажилладаг байсан.

Гуравдугаарт. Төрийн бүх шатны байгууллагаас гаргаж буй эрх зүйн актууд (тогтоол, тушаал, дүрэм, заавар зэрэг) Монгол улсын Үндсэн хууль болон бусад бүх хуультай бүрэн дүүрэн нийцэж байх зарчмыг тууштай баримталж ажилладаг. Сайд Нарын Зөвлөлийн тогтоол, яамын сайд, тусгай газрын дарга нарын гаргасан тушаал, баталсан дүрэм, заавар, бүх шатны гүйцэтгэх захиргаадын тогтоол шийдвэрийн нэг хувийг прокурорын зохих шатны байгууллагууд заавал авдаг, хуульд нийцэж байгаа эсэхийг хянадаг, зөрчил гаргасан бол эсэргүүцэл бичиж түүнийг арилгуулах арга хэмжээ авдаг байсан.

Үүнээс гадна прокурорын байгууллага гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хуулийн бусад байгууллагуудтай хамтран өргөнөөр зохион байгуулдаг байсныг тэмдэглэх хэрэгтэй юм.

7 Сайд Нарын Зөвлөлийн хуулийн хорооны дарга.

КЮ: Та Ю.Цэдэнбал гуайг ер нь хэдэн оноос эхлэж таньдаг, мэддэг болсон юм бэ?

СЖ: Би 1939-41 онд Нам улсын төв сургуульд суралцаж төгсөөд, 1941-1943 онд Шинэ хүчний дээд сургуульд суралцсан гэж дээр ярьсан шүү дээ. Намайг Шинэ хүчний дээд сургуульд сурч байхад Ю.Цэдэнбал бидэнд эдийн засгийн ерөнхий онолын хичээл зааж байсан юм. Дараа нь 1943 онд бид нар сургуулиа төгсөхөд Улсын шалгалтын комиссын даргаар нь Юмжаагийн Цэдэнбал ажилласан юм. Тэр үед Ю.Цэдэнбал оюутнууд хэрхэн хариулж байгааг анхааралтай сонсож, шалгалтын асуулт бүрийн хажууд өөрийн үнэлэлт, дүгнэлтийг монгол бичгээр бичиж тэмдэглэдэг байлаа. Би архивт байсан шалгалтын тэр материалуудыг хожим үзэж байхдаа Ю.Цэдэнбал тэр үед монгол бичгээр ямарч алдаагүй, маш сайхан бичиж байсныг нь мэдсэн юм. Тэр улсын шалгалт авч байх үедээ үдийн завсарлагаар оюутан бидэнтэй бөмбөг тоглож, хамт зургаа авахуулдаг байлаа. Би тэр үеэс л түүнийг мэддэг, таньдаг болсон юм.

Түүнээс хойш 40 гаран жилийн турш янз бүрийн ажлыг түүний удирдлагын дор хийж явжээ. 1960 онд миний биеийн эрүүл мэндийн байдал сайнгүй байсан тул би өөрөө Ерөнхий прокурорын ажлаас чөлөөлөгдөх хүсэлтийг МАХН-ын ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбалд гаргасан юм. Тэр миний хүсэлтийг хүлээж аваад, намайг энэ ажлаас чөлөөлж, Сайд Нарын Зөвлөлийн Хуулийн Хорооны даргаар томилсон юм. Сайд Нарын Зөвлөлийн Хуулийн Хороо бол Монгол улсын Шүүх яамны гүйцэтгэж ирсэн чиг үүргийг үндсэнд нь уламжлан авч хэрэгжүүлж байсан төрийн захиргааны төв байгууллага юм. Шүүх яамны эрхэлж байсан ажлуудаас гол нь шүүхийн зохион байгуулалтын харьяалалыг Улсын Дээд Шүүхэд шилжүүлсэн байлаа.

Сайд Нарын Зөвлөлийн Хуулийн Хороо нь төрийн эрх барих дээд байгууллагын гүйцэтгэдэг гол үүрэг болох хууль тогтоох үйл ажиллагааны хамгийн чухал бүрэлдэхүүн хэсэг болох хуулийн төсөл боловсруулах нарийн төвөгтэй, өндөр хариуцлагатай нүсэр том ажлыг эрхлэн гүйцэтгэж байсан юм.

1960 онд намайг Хуулийн Хорооны даргын ажлыг авч байхад Монгол улсын шинэ Үндсэн хуулийн төслийг боловсруулж, бүх ард түмнээр хэлэлцүүлэн улмаар Ардын Их Хурлын Чуулганд оруулж батлуулах өндөр хариуцлагатай, чухал ажил эхэлсэн юм. МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбалын ахалсан Улсын комисс байгуулагдаж, шинэ Үндсэн хуулийн анхны төслийг боловсруулах үүрэг,

даалгаврыг манай Хуулийн Хороонд өгч байлаа. Үндсэн хуулийн төсөл боловсруулах улсын комиссоос ийм үүрэг, даалгавар авсан манай Хуулийн Хорооны хуульчид, бид нар өөрийн орны тухайн үеийн түүхэн нөхцөл байдалд шинжлэх ухааны үндэстэй зөв үнэлэлт, дүгнэлт өгөх, улс орныхоо ирээдүйн төлөв байдлыг аль болохоор зөв тодорхойлохыг хичээж, төр, эрх зүйн шинжлэх ухаан, өнгөрсөн үеийн түүхэн туршилгын талаар өөрсдийн мэддэг, төсөөлдөг бүхнээ дайчлан ажиллаж, шинэ Үндсэн хуулийн төслийн анхны нэг эх буюу хувилбарыг боловсруулж Үндсэн хуулийн Улсын комиссын дарга Ю.Цэдэнбалд өргөн барьж байсан юм.

Бид нар шинэ Үндсэн хуулийн төслийг юуны өмнө дэлхийн дахинаа социалист нийгмийн тогтолцоо бодитойгоор оршин тогтнож байсныг харгалзан үзэж, “Хүн төрлөхтөний ирээдүй бол социализм-коммунизм мөн!” гэсэн үзэл, баримтлалд тулгуурлаж, боловсруулсан билээ. Шинэ Үндсэн хуульд манай оронд үйлдвэрлэлийн социалист харилцаа ялсан түүхэн амжилтыг дүгнэж, цаашид энэ харилцааг улам боловсронгуй болгох, Монгол улсын иргэдийн эрх, эрх чөлөөг хангаж, хамгаалах, ард түмний аж амьдрал, соёлын хэмжээг дээшлүүлэх, Монгол улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг бататган бэхжүүлэх, Монгол улсад социализмын материал техникийн баазыг байгуулах зэрэг нийгэм, төрийн байгууллын гол чухал асуудлуудыг бүрэн дүүрэн тусгаж өгөх хэрэгтэй байсан юм.

Сайд нарын Зөвлөлийн Хуулийн Хорооны боловсруулсан шинэ Үндсэн хуулийн тэрхүү төслийг Үндсэн хуулийн төсөл боловсруулах Улсын комисс хүлээн авсан боловч шинэ Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг Ю.Цэдэнбал өөрөө гардан хийж, бүх ард түмнээр хэлэлцүүлэх эцсийн хувилбарыг боловсруулсан юм.

Ю.Цэдэнбал дарга тэр үед намайг дуудаж:

-Үндсэн хуулийн төсөл боловсруулах нь маш их хариуцлагатай ажил юм шүү. Би Улсын комиссийн даргын хувьд өөрөө энэ төсөл дээр ажиллах ёстой! Би чамайг дэргэдээ авна! Би Улс Төрийн Товчооны тогтоол гаргуулж, үндсэн ажлаасаа нэг сараас доошгүй хугацаагаар чөлөөлөгдөнө. Хоёулаа энэ байшингаас (Төрийн ордонг хэлж байна –ред.) холдож, Баян голд байдаг манай зуслангийн байранд очиж ажиллана. Чи социалист орнуудын Үндсэн хуулиас гадна Америк, Англи, Герман, Япон мэтийн томоохон хөрөнгөтөн орнуудын Үндсэн хуулиуд, мөн төр, эрх зүйн онолын талаар зөвлөлтийн эрдэмтэдийн бичсэн сүүлийн үеийн сайн ном, зохиолуудыг цуглуулаад, тэнд авч очих хэрэгтэй! гэж хэлсэн юм.

Ингээд Ю.Цэдэнбал дарга бид хоёр Баян голд байдаг тэдний зуслангийн байранд 38 хоног өдөр, шөнөгүй сууж Үндсэн хуулийн төслийг бараг цоо шинээр боловсруулж, бүх ард түмнээр хэлэлцүүлж, санал авах

эцсийн хувилбарыг гаргасан юм.

Ю.Цэдэнбал миний авч очсон нилээд олон орны Үндсэн хууль болон төр, эрх зүйн талаар зөвлөлтийн эрдэмтэдийн бичсэн номуудыг судалж, бэлтгэлээ хангасны дараа Үндсэн хуулийн төслийг шууд орос хэл дээр өдөр, шөнөгүй сууж өөрөө гараараа бичээд дуусгаж байсан юм. Миний хувьд түүний шаардсан материалыг нь олж өгөх, бичсэн зүйлүүдийг нь бичээч нарт хуваан өгч бичүүлэх, бичээч нарын бичсэн зүйлүүдэд үг, үсгийн алдаа байгаа эсэхийг нь хянах, Үндсэн хуулийн төслийн бүх бүлэг, зүйл ангид бичигдсэн үгүүдийг тоолж, тусгай данс хөтлөх мэтийн хар, бор техник ажлуудыг л хийдэг байлаа. Ю.Цэдэнбал намайг хуульч мэргэжилтэй хүний хувиар дэргэдээ байлгаж төр, эрх зүйн онолын зарим асуудлаар ярилцаж, санал бодлоо солилцдог байсан юм.

Ю.Цэдэнбал залуудаа Эрхүү хотын Санхүү, эдийн засгийн дээд сургуульд суралцаж байхдаа төр, эрх зүйн шинжлэх ухааны талаар мэдлэг боловсрол сайтай, хуулинд их сонирхолтой болсон хүн байсан юм билээ. Тэрээр Санхүү, эдийн засгийн дээд сургуулийг дүүргэснийхээ дараа Москвад очиж номын худалдаануудаар орж, хуулийн тухай ном цуглуулж, Москвагийн Хууль зүйн дээд сургуульд орж суралцахаар бэлтгэж байсан юм билээ. Яг энэ үед буюу 1940 онд маршал Х.Чойбалсан Москвад сууж байсан манай Элчин сайд Ж.Самбуу гуайд үүрэг өгч, Ю.Цэдэнбалыг Улаанбаатарт дуудан ирүүлсэн юм билээ. Энэ тухайгаа тэр бидэнд байн байн ярьдаг байж билээ.

Ю.Цэдэнбал илтгэл, хэлэх үг, өгүүлэл болон ямар нэгэн баримт бичгийг утга агуулга, хэллэг, найруулгын хувьд өндөр түвшинд бичиж, боловсруулж чаддаг хүн байсныг түүнтэй хамт ажиллаж байсан бүх хүн сайн мэднэ. Ю.Цэдэнбал шиг баримт бичиг боловсруулах чадвартай, өдөр, шөнөгүй сууж ажиллах тэсвэртэй хүн тэр үед Төрийн ордонд байгаагүй байх шүү. Ю.Цэдэнбалын бараг ганцаараа бичиж боловсруулсан Үндсэн хуулийн төслийг бүх ард түмнээр хэлэлцүүлж, улмаар Ардын Их Хурлын Чуулганаар хэлэлцүүлж, 1960 онд батлан гаргахад түүнийг олон нийтийн зүгээс сайшаан дэмжиж байсныг би сайн мэдэх билээ.

1960 оны Үндсэн хууль манай оронд 30 гаруй жил үйлчлэхдээ Монгол улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг улам бататган бэхжүүлэх, манай орны эдийн засаг, соёлыг эрчимтэй хөгжүүлэх, ард түмний материаллаг амьдрал, соёл, ахуйн түвшинг дээшлүүлэх талаар түүхэн чухал үүрэг гүйцэтгэсэн гэж би судлаачийн хувьд үздэг билээ. Ер нь аливаа юмыг тухайн үеийн нөхцөл байдалтай нь нягт холбон үздэг байх хэрэгтэй гэж суут хүмүүс, эрдэмтэн мэргэд, онол, түүхэн туршлага сургаж байдаг билээ.

1960 оны Үндсэн хуулийн төслийг боловсруулах, бүх ард түмнээр

хэлэлцүүлж, Ардын Их Хурлын чуулганаар батлуулах, цаашид сурталчилах талаар Сайд нарын Зөвлөлийн Хуулийн Хорооны бүх хамт олон их хувь нэмэр оруулсныг би гүнээ талархан тэмдэглэж байна.

1960 оны Үндсэн хууль батлагдан гарсны дараа тэр үед дагаж мөрдөж байсан бүх хууль, эрх зүйн бусад бүх актуудыг шинэ Үндсэн хууль үзэл санаанд нийцүүлэн шинэчлэх их ажил эхэлсэн билээ. Үүнд юуны өмнө Эрүүгийн ба эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний ба иргэний байцаан шийтгэх хууль, Хөдөлмөрийн хууль, Гэр бүлийн хууль зэрэг томоохон хуулиудыг яаралтай шинэчлэх хэрэгтэй байлаа. Өндөр мэргэжил, туршлага, бас баримт бичиг боловсруулах ур чадвар шаарддаг энэ чухал ажилд манай Хуулийн Хорооны ажилтнууд болох Цэнд, Хорхой, Амархүү, Жамбалдорж нарын зэрэг сайн хуульчид, шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн юм.

Тэдний боловсруулсан дээрхи хуулиудын төсөл зохих журмын дагуу хянагдан, улмаар Ардын Их Хурлын чуулганаар хэлэлцэгдэж, батлагдан гарч, олон жил дагаж, мөрдөгдөж байсан билээ.

Сайд нарын Зөвлөлийн Хуулийн хорооны хамт олноос хийсэн нэгэн том ажил бол 1921 оноос 1960 он хүртлэх хугацаанд төр засгаас батлан гаргасан эрх зүйн бүх актыг (хууль, тогтоол, шийдвэр, дүрэм заавар зэрэг) системчлэн ангилж, хэвлүүлэх нарийн төвөгтэй, нөр их ажил байсан юм. Энэ ажилд улс төр, нийгэм-эдийн засаг, соёл боловсрол, шинжлэх ухаан зэрэг бүх салбарын талаар гаргасан эрх зүйн актууд хамрагдсан билээ. Жишээ нь, хөдөө аж ахуй, аж үйлдвэр, соёл боловсрол, эрүүлийг хамгаалах, худалдаа үйлчилгээ, тээвэр, холбоо, шинжлэх ухаан, засаг захиргааны зэрэг бүх салбарын талаар гарсан, хүчин төгөлдөр, дагаж мөрдөж буй актуудын системчилсэн эмхэтгэлийг тус тусад нь ном болгон хэвлүүлж байлаа.

Эрх зүйн актуудыг ингэж системчилэн ангилж эмхэтгэл болгон гаргаж байх нь хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хууль тогтоомжийг тухайн салбарын ажил албанд зөв хэрэглэх, нарийн чанд дагаж мөрдөх, хуулийг сурталчилах, хэрэгжү үлж, биелүүлэх явдалд асар их ач холбогдолтой байдаг ажээ. Тус хорооны хамт олон энэ нүсэр их ажлыг өдөр, шөнөгүй сууж маш их идэвхи зүтгэл гаргаж, богино хугацаанд хийж дуусгаж байлаа.

Манай Хуулийн Хорооноос эрхлэн гүйцэтгэж байсан бас нэгэн чухал ажил бол бусад байгууллага, газруудаас боловсруулж Ардын Их Хурал, Засгийн газарт оруулж ирүүлсэн эрх зүйн бүх актыг хянан үзэж, зөвшөөрөл өгөх ажил байсан юм.

Намайг Хуулийн хороонд ажиллаж байхад нэг өдөр Ю.Цэдэнбал дарга дуудлаа. Энэ удаа ч шинэ томилгоо яригдана гэж бас л бодсонгүй

түүний ажлын өрөөнд яваад орчихлоо. Тэр:

-Чамайг Хуулийн Хорооны даргаас гадна Сайд нарын Зөвлөлийн Хэрэг эрхлэх газарын орлогч даргаар томилохоор бид ярилцаж байна. Үүнээс хойш чиний буюу Хуулийн хорооны визгүйгээр (зөвшөөрөлгүйгээр –ред.) ямар нэгэн тогтоолын төслийг Засгийн газрын хуралд оруулахыг хориглосон шийдвэр гаргаж байгаа юм! гэж хэллээ.

Энэ бол Монгол улсын Засгийн газраас эхлэн төр, захиргааны бүх байгууллага, албан тушаалтнууд үйл ажиллагаагаа гагцхүү хуулийн хүрээнд явуулдаг байх хууль, тогтоомжийг нарийн чанд сахиж биелүүлдэг байхад чиглэгдсэн чухал арга хэмжээ байсан юм.

Одоо ч гэсэн хууль зүй, дотоод хэргийн яамны визгүй бол ямар ч хуулийн төслийг Улсын Их Хурал, Засгийн газарт оруулахыг хориглодог байх нь зүйтэй юм. Гэвч ийм ажил хийж байгаа нь харагдахгүй л байна. Сайд нарын Зөвлөлийн Хуулийн Хорооны хамт олон мэдлэг мэргэжил сайтай, өндөр идэвхи зүтгэлтэй, маш ажилсаг хүмүүс байсныг би тэмдэглэн хэлэхийг хүсэж байна.

КЮ: Одоо таны хувийн амьдралыг сонирхож болох уу? Та хэзээ гэрлэсэн бэ? Танайх хэдэн хүүхэдтэй айл болсон бэ?

СЖ: Би ээжийнхээ хүүхэд, бидэнд захиж хэлдэг байсан сургаалиудын дотроос энд хоёр зүйлийг тэмдэглэж хэлэхийг хүсэж байна. “Миний хүү эрдэм номтой хүн болоорой! Ээж нь хүүгээ Улаанбаатарт явуулж сургуульд оруулна!” гэж тэр нутагтаа байхад надад үргэлж хэлдэг байж билээ. Миний ээж хүү намайгаа Улаанбаатарт ирүүлж, сургуульд оруулснаар миний бие насан туршдаа номын мөр хөөж эдүүгээг хүрлээ.

“Миний хүү одоо том болж байна. Эр хүн насандаа хүрээд авгай, хүүхэдтэй болж, айл өрх толгойлдог жамтай. Авгай авах гэж яарч болохгүй, эхнэр хүүхдээ тэжээх чадалтай болсон үедээ л шийдэх хэрэгтэй байдаг юм шүү!” гэж сургадаг байлаа. Би ээжийнхээ захиасыг биелүүлэхийг л хичээж явсан билээ. Би Жигмэд овогтой Ичинхорлоотой Нам, улсын төв сургуульд хамт суралцаж байхдаа танилцаж, дараа нь Шинэ хүчний дээд сургууль би багшлах болсон үед бид хоёр гэрлэсэн юм. Миний хань Ж.Ичинхорлоо Нам улсын төв сургууль, Шинэ хүчний дээд сургууль, дараа нь Монгол улсын их сургуульд суралцаж түүхч, сэтгүүлч мэргэжилтэй болсон хүн билээ. Миний эхнэр Ичинхорлоогийн аав нь Гандан тэгчинлин хийдийн том лам нарын зоог барьдаг лам хүн байсан юм. Ээж нь Монголын төрийн тэргүүн Богд хааны буюу Монголын Бурхны шашны тэргүүн Богд Жавзандамба хутагтийн уран оёдолчин хүн байсан юм. Түүний нэрийг Норжмаа гэдэг байсан юм.

Эхнэр бид хоёрын охин Хандсүрэн Монгол Улсын Их Сургуулийн хуулийн сургуульд багшилдаг юм. Хожим намайг бүх албан тушаалаасаа халагдаж, нутаг заагдаж явахад түүнийг бас ямарч шалтгаангүйгээр ажлаас халж хохироож байсан билээ. Миний охин Хандсүрэнгийн том хүү Жаргалсайхан бас Монгол Улсын Их Сургуулийг биологийн мэргэжлээр төгссөн юм. Тэр цаашид эрдэм шинжилгээний ажил хийх бүрэн боломжтой хүү байгаа юм. Хандсүрэнгийн охин Тэгшзаяа Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн олон улсын эрх зүйн ангид сурч байгаад би их баяртай байна. Би одоо ач, зээ нараасаа гадна гучаа үзээд маш их баяртай байна. Миний гучийн нэрийг Чүнгүн гэдэг юм. Хүүхэд хөгжим хоёр гэр дулаацуулдаг, хүний бухимдлыг тайлдаг, инээд, баяр, баясгаланг буй болгодог гэж ярьдаг шүү дээ. Энэ бол амьдралаас ургаж гарсан үнэн үг юм.

8 “Монгол телевиз” байгуулагдлаа.

И Л: Таныг Монгол телевизийг байгуулж, энэ чухал байгууллагын тулгын чулууг нь тулалцсан хүн! гэж ярьдаг шүү дээ. Та энэ талаар ярьж өгнө үү?

С Ж: Миний бие Сайд нарын Зөвлөлийн Хуулийн хорооны даргаар дөрвөн жил гаруй ажиллахдаа мэргэжилдээ сайн, хуулийн ажлын талаар туршлагатай С.Цэнд, Т.Хорхой нарын зэрэг сайн нөхдөөс багагүй зүйл сурч, мэдэж, хууль боловсруулах ажилд овоо дадлагажиж байсан билээ. Энэ үед нэг өдөр Ю.Цэдэнбал дарга өөрийн ажлынхаа өрөөнд дуудсан байлаа. Түүний өөрөөнд намайг ороход тэр:

-Чамайг бид нар өөр ажилд томилохоор ярилцаж байна. Чиний очиж ажиллах шинэ газар бол үхрийн бөөртэй төстэй газар юм шүү. Тэнд радио, мэдээлэл, сонин сэтгүүл гээд олон байгууллага олон чиглэлийн ажил явуулж байдаг юм. Тэнд сахилга, дэг журам сайн байх ёстой. Чи хуульч хүн учраас чамайг энэ ажилд томилож байгаа юм шүү! гэж байна.

Би түүнд:

-Би сэтгүүлч мэргэжилгүй тул ийм ажлыг хийж чадахгүй байх. Та намайг одоогийн хийж байгаа ажилд маань үлдээж өгөөч! гэж гуйлаа. Гэсэн ч тэр миний хүсэлтийг хүлээж авсангүй. Ингээд 1964 оны 4-р сарын 11-нд МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны хурлаар энэ асуудлыг хэлэлцээд Мэдээлэл, Радиогийн Хэрэг эрхлэх газрын даргаар томилчихлоо. Тэр үед МАХН-ын гишүүн хүн намаас өгсөн үүрэг даалгаварыг үг, дуугүй биелүүлэх ёстой учир шинэ ажилдаа хурдан орж, сайн ажиллахыг л бодох хэрэгтэй боллоо. Миний томилогдож очсон Мэдээлэл, Радиогийн Хэрэг эрхлэх газар маань бүх талын боловсролтой,

чадвартай, ажилдаа эзэн болж чаддаг боловсон хүчнээр сайн хангагдсан, маш чухал ажил хариуцдаг байгууллага байлаа. Тус газарт манай улсын шилдэг сайн сэтгүүлчид, улс төр судлаачид, тоймчид, манай улсын урдаа барьдаг орчуулагчид англи, орос, хятад, герман, франц зэрэг олон хэл сайн мэддэг хүмүүс ажиллаж байсан юм. Миний хувьд улсын ажил алба явуулдаг ерөнхий зарчмыг нарийн чанд хэрэгжүүлэх, хариуцлагыг өндөржүүлэх, сахилга, дэг журмыг сайн байлгахад л анхаарч ажиллах хэрэгтэй байсан.

“Алтны дэргэд байсан гууль шарладаг!” гэж монголчууд ярьдаг шүү дээ. Миний шинээр очсон газар ажил мэргэжилдээ сайн хүмүүс олон байсан учраас тэднээс багагүй зүйл сурч, мэдэж, хэвлэл мэдээллийн талаар овоо төсөөлөлтэй болж байлаа. Миний хувьд тус байгууллагад нилээд олон жил ажиллахдаа биечлэн хөөцөлдөж, багагүй бэрхшээлийг даван туулж байж, бусад хүмүүстэй санаа нийлж хамтын хүчээр бүтээн байгуулсан том ажил бол Монгол телевизийг байгуулж, үйл ажиллагааг нь жигдрүүлж өгсөн явдал мөн гэж би хэлж чадах юм.

Харин надад өөрийгөө магтан дуулдаг, албан тушаалын хойноос улайран хөөцөлддөг тийм муу чанар буюу тийм синдром байхгүй юм шүү! Монгол улсад орчин үеийн мэдээллийн хүчирхэг хэрэгсэл, хүний нийгмийн соёлын хөгжлийн гайхамшигт ололтын нэг болсон телевиз байгуулах тухай асуудал 1960-аад оны эхний хагаст Холбооны яам, Мэдээлэл Радиоогийн Хэрэг эрхлэх газрын төвшинд яригдаж эхэлсэн юм. Ингээд энэ асуудал Улсын төлөвлөгөөний комисс, Засгийн газрын хэмжээнд олон дахин яригдаж, телевиз байгуулахыг зарчмын хувьд бүх шатанд зөвшөөрч байсан боловч ямар хэмжээтэй, ямар үнэ өртөгтэйгөөр байгуулах асуудлаар тохиролцож чадахгүй удсан юм. Төлөвлөгөөний комисс, Сангийн яам зэрэг газрууд аль болохоор бага хэмжээний өртөг зардалаар, багатай хэмжээний телевиз байгуулахыг санал болгож, түүнийгээ хатуу хамгаалж байсан нь гол бэрхшээл болж байсан юм. Энэ асуудал ийнхүү төсөв, хөрөнгөнөөс хамааран нилээд сунжрах байдалтай болсон тул миний бие шууд Ю.Цэдэнбал даргад хандаж, энэ асуудлыг танилцуулахаар шийдэж байсан юм. Ингээд нэг удаа МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчоо хуралдаж байх үед нь зөвшөөрөл аваад орлоо. Уг нь тэр хурлын хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд манай асуудал ороогүй, намайг ч дуудаагүй юм шүү дээ. Ю.Цэдэнбал даргатай уулзах өөр боломж надад байсангүй. Нилээд хүндхэн л юм боллоо. Би хуралд ороод Монгол улсад Телевиз байгуулах асуудлыг түргэн шийдвэрлэж өгөхийг Ю.Цэдэнбал даргаас хүсэж, тодорхой санал тавьлаа. Миний хэлж байгаа үгийг Улс Төрийн Товчооны гишүүд анхааралтай сонсож, янз бүрийн зүйл асуулаа. Ийм яриа ид өрнөж байхад Ю.Цэдэнбал дарга ярианд оролцож “Ямар

хэмжээний, ямар хүчин чадалтай телевиз байгуулах гээд байгаа юм бэ?” гэх мэтээр нилээд асуулаа. Энэ ярианы эцэст тэр:

-За нөхөд минь. Та нарын ямар телевиз байгуулах гээд байгааг чинь би бага ч гэсэн ойлголоо. Манай телевиз ямар болох нь та нараас шууд хамаарна шүү. Улаан-Үдийн телевиз ямар ажиллаж байгааг та нар мэдэж байгаа шүү дээ! Бид түүнээс илүү л телевизтэй болох ёстой шүү! гэж хэлснээр бидний Монгол телевиз байгуулах ажил шийдвэрлэгдэж байсан юм.

Монгол телевиз байгуулах асуудал ингэж нилээд удаж байж шийдвэрлэгдсэний дараа түүнийг Зөвлөлтийн барилгын хоёрдугаар трест маш богинохон хугацаанд, чанарын өндөр түвшинд барьж Монголын талд хүлээлгэн өгсөн билээ. Телевизийн төвийг нэгэнт байгуулах болсон тул телевизийн нэвтрүүлгийг хэрхэн яаж явуулах тухай асуудал миний удирдаж байсан байгууллагын шууд хариуцах гол ажил мөн учир тухайн үед олон бэрхшээлтэй тулгарч тэдгээрийг даван туулах хэрэгтэй болсон юм.

Хамгийн хэцүү асуудал бол манайд телевизийн мэргэжилтэй инженер техникийн ажилтнууд, телевизийн нэвтрүүлгийг бэлтгэн явуулах мэдлэг, туршлагатай сэтгүүлч, найруулагч, зураглаач (оператор), нэвтрүүлэгч зэрэг олон төрлийн нарийн мэргэжлийн ажилд тэнцэх хүмүүсийг яаралтай олж бэлтгэх явдал байсан юм.

Бидэнд энэ талаар тусламж үзүүлэхийг ЗХУ-ын Радио, телевизийн улсын хорооноос хүссэн билээ. Ингээд миний бие Москвад очиж ЗХУ-ын Радио, телевизийн улсын хорооны дарга Е.Г.Лаптинтай уулзаж, учир байдлаа танилцуулж, тодорхой хүсэлтүүд тавьсаныг тэр хүлээн авч, хэлэлцээр байгуулж, Е.Г.Лаптин бид хоёр гарын үсэг зурсанаар асуудал шийдвэрлэгдэж байлаа.

Монгол улсад телевизийн нэвтрүүлэг 1967 оны 9-р сарын 27-нд эхэлснээр монгол айлын гэрт орчин үеийн том соёл орж ирсэн билээ. Монгол телевизийн тулгын чулууг тавьж, түүний анхны нэвтрүүлгүүдийг бэлтгэн явуулсан алтан хараацайнууд оюун ухаан, хүч чадлаа дайчлан өндөр идэвхи, зүтгэл, сайхан сэтгэл гаргаж ажилласны ачаар монгол телевизийн нээлтийн ажиллагаа сайхан болж, манай анхны нэвтрүүлгийг монголын үзэгчид халуун дотноор, сэтгэл хангалуун хүлээн авч байсан билээ. Энэ бол манай телевизийн анхны хамт олонд урам хайрласан хүчтэй дэмжлэг болсон юм.

Монгол телевизийг цаашид бататган бэхжүүлэх, өргөтгөх, нэвтрүүлгийн чанар, үр өгөөжийг дээшлүүлэх талаар олон чухал арга хэмжээ авч байсны нэг нь уран бүтээлийн ажилд дур сонирхолтой, цаашид өсч хөгжих ирээдүйт сайтай олон залуучуудыг сонгон шалгаруулж,

сэтгүүлч, найруулагч, зураглаач, инженер техникийн дээд мэргэжил эзэмшүүлэхээр жил бүр зохих мэргэжлийн сургуулиудад явуулж байсан явдал юм.

Тэдгээр залуучууд дээд мэргэжилтэй болж сургуулиа төгсөж ирэхийн хэрээр Монгол телевиз мэргэжилтэй боловсон хүчнээр бэхжиж, нэвтрүүлгийн цар хүрээ өргөжиж чанар, үр өгөөж нь дээшилсээр байлаа.

9 Улс Төр.

С Ж: Миний бие 1971 оны 11-р сараас 1983 оны 6-р сар хүртлэх хугацаанд МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны гишүүн, нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн орлогч даргаар ажиллаж байв.

Нам, төрийн дээд удирдлагын бүрэлдхүүнд ажиллаж байх хугацаанд миний тухайлан хариуцаж байсан үндсэн асуудал бол:

- Намын ажил;
- Их барилга;
- Хууль, хяналт, төр, олон нийтийн байгууллагууд;
- Улаанбаатар хотын асуудал зэрэг болно.

Дээр дурьдсан тодорхой асуудлуудаас бүх ажлын гол нь МАХН-ын ТХ-ны Улс Төрийн Товчоо, ТХ-ны нарийн бичгийн дарга нарын зөвлөгөөнд төвлөрч байсан юм. Учир нь МАХН, төрөөс шийдвэрлэх улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын байгуулалттай холбогдсон бүх үндсэн асуудлууд, товчоор хэлбэл нам, төрийн дотоод, гадаад бодлого, үйл ажиллагааны зангилаа асуудлуудыг энд төвлөрүүлж шийдвэрлэдэг байсан юм. Эндээс гадуур нэгч асуудал шийдэгдэж байгаагүй билээ.

МАХН, төрийн дээд удирдлагын бүрэлдэхүүнд ажиллаж байсан хүмүүсийн үйл ажиллагаа хувийн ба хамтын хариуцлагын зарчмаар явагдаж байсан гэж үзэж болно.

Би өөрөө шууд хариуцаж байсан зарим гол ажлынхаа талаар цөөн үг хэлье.

МАХН-аас явуулж байсан дотоод, адаад бодлого, бүх үйл ажиллагаа бол том түүх юм. XX зуунд Монгол Улсыг хөгжүүлж, орчин үеийн Монгол Улс болгосон түүх шүү дээ. Тэр том түүхийг энд бүгдийг ярих ямар ч боломжгүй юм. Би зөвхөн энэ ажлыг хариуцаж байсан үедээ л хийж байсан ажлаасаа зарим нэг зүйлийг товч өгүүлэх гэж оролдож байгаа юм. Тэр үеийн МАХН-ын ажил их өргөн цар хүрээтэй том ажил байснаас би зөвхөн намын зохион байгуулалтын асуудлыг л хариуцдаг байлаа.

МАХН-ын Төв Хороонд миний удирдлагын дор энэ ажлыг хариуцсан

намын ажлын хэлтэс ажиллаж байлаа. Энэ хэлтэс 18 аймаг, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын МАХН-ын хороодын намын зохион байгуулалтын ажил, Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэл, Пионерийн байгууллага, Монголын Үйлдвэрчний Эвлэл, Монголын Эмэгтэйчүүдийн байгууллагын асуудлыг ерөнхийд харьяалан хариуцаж байсан юм.

Тус хэлтэс Намын байгууллагын удирдан зохион байгуулах үүрэг, хариуцлагыг байнга дээшлүүлж байх зорилттой ажиллаж байлаа. Аймаг, хот нэг бүрийг хариуцсан зохион байгуулагчид, олон нийтийн төв байгууллагуудыг хариуцсан зааварлагч, намын батлах, тоо бүртгэлийн ажил хариуцдаг тасаг ажиллаж байв.

МАХН-ын Их хурал, Намын Төв Хорооны бүгд хурал, Улс Төрийн Товчооноос гаргасан шийдвэр, удирдамжийн үндсэн дээр намын бүх шатны байгууллагуудыг бэхжүүлэх, тэдгээрийн ажлыг удирдан зохион байгуулах, ажлыг нь шалгаж заавар зөвөлгөө өгөх зэрэг чухал ажлыг энэ намын ажлын хэлтэс хариуцдаг байсан юм. Миний үед тус хэлтсийн эрхлэгчээр ажиллаж байсан Г.Адьяа, Ц.Балхаажав нар сүүлд МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн даргын өндөр албан тушаалд дэвшин ажиллаж байв.

Нөгөө талаар Намын ажлын хэлтэс нь намын удирдах боловсон хүчний чухал нөөц газар болж байлаа. Жишээ нь намын ажлын хэлтсийн аймаг, хот хариуцсан зохион байгуулагчдыг аймаг, хотын МАХН-ын хороодын нэгдүгээр болон салбар хариуцсан нарийн бичгийн даргаар томилон ажиллуулдаг байсан юм.

Мөн тэдгээрийн зарим нь яамны сайд, тусгай газрын дарга, аймаг, хотын гүйцэтгэх захиргааны дарга зэрэг албан тушаалд томилогдон ажилладаг байлаа. Тус хэлтэст улс төрийн болон тусгай дээд мэргэжилтэй, өндөр боловсролтой, ёс зүй, ажил хэргийн талаар шалгарсан шилдэг боловсон хүчнүүд ажилладаг байсан юм.

Намын ажлын хэлтэсийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь МАХН-ын бүх шатны байгууллагуудыг боловсон хүчнээр бэхжүүлэх, бүх үйл ажиллагааг нь идэвхжүүлэх, тус тусын шат буюу салбарт нь намын байгууллагын удирдан зохион байгуулах үүрэг, хариуцлагыг байнга дээшлүүлж байх явдал байлаа. Энэ зорилгоор намын анхан шатны байгууллагуудын улсын зөвлөлгөөнийг нийслэл Улаанбаатар хотод, намын анхан шатны байгууллагуудын бүсчилсэн зөвлөлгөөнийг өөр өөр газарт тогтмол хийж байсан нь намын бүх шатны байгууллагуудын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, тэдгээрийг бүх талаар бэхжүүлэхэд хүчтэй түлхэц болж байсан юм. Энэ мэтээр тэр үед явуулж байсан бодлого, цаг үеийн ажлуудын талаар дурсан санаж яриад байвал бараг эцэс төгсгөлгүй яриа болох бизээ. Өөрөөр хэлбэл МАХН-аас улс орны эдийн засгийн

бүх салбар, соёл боловсролыг хөгжүүлэх, ард түмний аж амьдрал, соёлын хэмжээг дээшлүүлэх талаар дэвшүүлэн тавьж байсан зорилтуудыг биелүүлэх хэрэгт намын бүх шатны байгууллагын ажлыг чиглүүлж байлаа.

Миний энд дурсамж болгон тэмдэглэж хэлэхийг хүсч байгаа гол асуудал бол МАХН-ын үүрүүдээс эхлэн МАХН-ын Төв Хороог оролцуулан намын бүх шатны байгууллага өндөр мэргэжил, боловсролтой, туршлагатай, ёс зүй, ажил хэргийн хувьд сайн төлөвшсөн буюу төлөвшин буй боловсон хүчнээр бэхжсэн буюу бэхжиж байсан явдал юм. Жишээ нь: бүх аймаг, хотын намын хороодын нарийн бичгийн дарга нар бараг бүгдээрээ дотооддоо Намын Дээд Сургууль, гадаадад ЗХУКН-ын Төв Хорооны дэргэдэх Намын Дээд Сургууль буюу Нийгмийн Ухааны Академийг төгссөн хүмүүс ажиллаж, тэдний зарим нь давхар тусгай дээд мэргэжилтэй хүмүүс байлаа. Төвчоор хэлбэл МАХН сайн бэлтгэгдсэн боловсон хүчин шиг үнэ цэнэтэй зүйл байхгүй! гэдэг үзэл баримтлалыг тууштай баримталж байсан юм.

Эдгээр он жилүүдэд манай оронд боловсрол, соёл, шинжлэх ухаан, эрүүлийг хамгаалах талаар нам, засгаас дэвшүүлэн тавьсан зорилтууд амжилттай хэрэгжиж байлаа.

Сургуулийн насны бүх хүүхэд ерөнхий боловсролын сургуулиудад хамрагдан бүрэн дунд боловсрол эзэмшиж, улмаар дотоод, гадаадад их, дээд болон тусгай мэргэжлийн дунд сургуулиудад дэвшин суралцаж төрөл бүрийн мэргэжилтэй, бүх талын боловсролтой боловсон хүчнүүд болж эдийн засаг, соёлын байгуулалтын бүх салбарт ажиллаж, тэдгээрийг хөгжүүлж байв.

Манай улсын насанд хүрсэн бүх иргэд бичиг үсэг мэддэг болсон, хүн ам янз бүрийн халдварт өвчнөөс бүрэн ангижирч эрүүлжсэн явдал нам, засгийн зөв бодлого, авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн сайхан үр дүн байв.

Монгол улсад анх удаа Шинжлэх Ухааны Академи, түүний харьяа эрдэм шинжилгээний олон хүрээлэнгүүд байгуулагдаж, шинжлэх ухаан амжилттай хөгжиж, улс орны хөгжил дэвшилд чухал үүрэг гүйцэтгэж эхэлсэн юм.

Ялангуяа боловсрол тэргүүлэх салбар болон хөгжиж байсны тодорхой жишээ баримт бол ерөнхий боловсролын сургуулиуд бүх аймаг, хотын төв, бүх сумдад буй болж, Монгол Улсын Их Сургууль, дараа нь түүнээс салбарлаж Багшийн Их Сургууль, Хөдөө Аж Ахуйн Их Сургууль, Анагаах Ухааны Их Сургууль зэрэг их сургуулиуд байгуулагдсан явдал юм. Бас тусгай мэргэжлийн дунд сургуулиуд олноороо байгуулагдан тэдгээрт манай орны мянга мянган хөвгүүд, охид суралцан, улмаар төрөл бүрийн

мэргэжилтэй болсон хүчнүүд төрж гарсаар байсан нь монголын ард түмний үндэсний бахархал болж байв.

Түүнчлэн урлаг, утга зохиол цэцэглэн хөгжиж байсан нь Монголын ард түмний соёл, боловсрол, оюуны сан хөмрөгийг хөгжүүлэх хэрэгт том үүрэг гүйцэтгэх болсон билээ.

Ийнхүү эрх баригч МАХН-аас улс орныхоо эдийн засаг, соёлыг хөгжүүлэх, ард түмний аж амьдрал соёлын хэмжээг дээшлүүлэх талаар дэвшүүлэн тавьж байсан зорилтууд амжилттай хэрэгжиж байсан юм. Эдгээрийн үр дүнд ард түмэн идэх хоол, өмсөх хувцас, эд хогшил, мөнгө төгрөгний хувьд гачигдах зовлонгүй шахам болж, санаа сэтгэлийн хувьд амгалан тайван, айх юмгүй, аюулгүй орчинд аятай тохитой амьдардаг болоод байлаа.

С.Жалан-Аажав миний биеийг МАХН-ын Төв Хороонд намын ажил хариуцсан нарийн бичгийн даргаар ажиллаж байсан жилүүдэд тус нам тэргүүний хүмүүсээр эгнээгээ бэхжүүлж, 70 гаруй мянган гишүүдтэй болоод байсан билээ. Монгол улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг бататган бэхжүүлэх, улс орны эдийн засаг, соёлыг хэрэгжүүлэх, ард түмний аж амьдралыг дээшлүүлэх талаар МАХН-ын программд тодорхойлогдсон зорилтуудыг хэрэгжүүлэх нөр их ажлыг удирдан зохион байгуулах, байнгын шуурхай удирдлагаар хангах явдал МАХН-ын Улс Төрийн Товчооны гол үүрэг, хариуцах үндсэн ажил болж байсан юм.

Улс Төрийн Товчоо энэ үүргээ хэрэгжүүлэхийн тулд нам, төрийн дотоод, гадаад бодлого, амьдрал, улс орны амьдрал, хөгжил дэвшилтэй холбогдсон бүх үндсэн асуудлуудын талаар тодорхой шийдвэрүүд гаргаж, тэдгээрийн биелэлтийг хангах ажлыг удирдан зохион байгуулдаг байсан юм. Жалан-Аажав миний бие эдгээрийг миний бүрэн биш боловч зохих хэмжээгээр мэддэг 1940-өөд оноос 1980-аад оны Улс Төрийн Товчоонд холбогдуулан хэлж байгаа юм.

Улс Төрийн Товчооны бүрэлдэхүүнд жинхэнэ гишүүн 7 хүн, орлогч гишүүн 2 хүн, бүгд есөн хүн ажилладаг байсан юм. Сүүлийн 20 гаруй жилд Улс Төрийн Товчооны гишүүнээр Ю.Цэдэнбал, Ж.Батмөнх, Д.Моломжамц, Д.Майдар, Т.Рагчаа, С.Лувсанравдан, Б.Алтангэрэл, С.Гомбожав, Б.Дэжид, С.Жалан-Аажав нар янз бүрийн хугацаагаар ажиллаж байв.

Ер нь МАХН, Монголын төр, улс орон, ард түмнийг удирдан чиглүүлэх, зохион байгуулах бүх ажил Улс Төрийн Товчоонд төвлөрч байсан юм.

Энд МАХН-ын гүйцэтгэж байсан үүрэг роль, үйл ажиллагаа, нэр хүндтэй шууд холбоотой зарчмын нэг чухал асуудлыг хөндөж хэлэх хэрэгтэй гэж үзэж байна. “МАХН бол манай нийгмийг удирдан

чиглүүлэгч, зоригжуулан зохион байгуулагч гол хүч мөн!” хэмээн Үндсэн хуульд заажээ. Ийнхүү МАХН-ын эрх зүйн байдлыг Монгол улсын Үндсэн хуулиар тогтоож баталгаажуулсан байлаа. Ийм учраас МАХН-ыг “төржсөн нам, төрийн эрх барих явдал нь хуулиар баталгаажуулагдсан нам байсан!” гэж үзэх ёстой. Энэ бол ганц манайд бус дэлхийн социалист тогтолцоо оршин тогтнож байх үед түүнд багтаж байсан бүх улс орнуудад үйлчилж байсан зарчим юм.

МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны бүрэлдэхүүнд Төв Хорооны нарийн бичгийн дарга нараас гадна Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн дарга (ерөнхийлөгч–ред.), Сайд нарын Зөвлөлийн дарга (Ерөнхий сайд–ред.), түүний хоёр орлогч дарга байнга ордог байсан юм. Ийм учраас Төв Хорооны Улс Төрийн Товчоо бол МАХН-ын Их хурал, Төв Хорооны бүгд хурлын чөлөө цагт хууль ёсоор МАХН, төрийн дээд эрх барих төв байгууллага болж байлаа. МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчоо бол зөвхөн “бодлого” гэгчийг тодорхойлдог, хоосон ярьдаг, хэрүүл маргаан хийж, бүх асуудлыг улс төржүүлж суудаг газар бус, улс орноо жинхэнэ ёсоор, ажил хэрэгчээр удирддаг, үйл ажиллагаагаа цаг хязгааргүй, маш өргөн хүрээтэй явуулдаг, нөр их ажлын газар байсан юм. Жишээ нь, улсын төвлөрсөн төсөв, улс ардын аж ахуй соёлыг хөгжүүлэх төлөвлөгөөг үндсэндээ Улс Төрийн Товчоо боловсруулдаг, түүнийг өөрийн хурлаараа хэлэлцдэг, улмаар батлуулахаар зохих төрийн дээд шатны хурлуудад оруулдаг байсан юм.

Миний дээр өгүүлсэн зүйлүүдийг батлах өөр нэг зүйл бол МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны гишүүн, нарийн бичгийн дарга байсан Д.Моломжамц эдийн засгийн төв байгууллагууд, Монгол улсын аж үйлдвэрийн асуудлыг, Н.Жагварал хөдөө аж ахуйн асуудлыг, С.Гомбожав дотоод, гадаад худалдаа, эдийн засгийн гадаад харилцааны асуудлыг, С.Жалан-Аажав миний бие МАХН, төрийн захиргаа, олон нийт, хууль хяналтын асуудлаас гадна их барилгын ажлыг тус тус хариуцдаг байсныг дурьдахад хангалттай бизээ.

МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчоо МАХН-ын бодлого, үйл ажиллагааг эрхлэн хариуцдаг гол төв болж байсны хувьд МАХН, улс орны өмнө хүлээсэн өндөр хариуцлагатай үүргээ амжилттай биелүүлж, МАХН-ын өндөр нэр хүндийг үйл ажиллагаагаараа бататган бэхжүүлж байсныг С.Жалан-Аажав миний бие МАХН-ын Төв Хороонд намын ажил хариуцсан нарийн бичгийн даргаар 10 гаруй жил ажиллаж, Төв Хорооны гишүүнээр хориод жил сонгогдон ажиллаж байсны хувьд нотлон хэлж чадах юм.

Түүнчлэн МАХН улс орон, ард түмнийхээ ашиг сонирхлыг тууштай хамгаалдаг, ард түмнээ хайрлан хүндэтгэдэг, тэднийг хэзээ ч хуурч мэхэлж

байгаагүй тийм улс төрийн хүчин байсан гэдгийг би түүний эгнээнд 60-аад жил байсны хувьд хэлж чадах юм.

МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны гишүүдийн дотроос ямар нэгэн гэмт хэрэг зөрчилд, тухайлбал: төрийн өмч хөрөнгийг идэж ашигласан, үрэн таран хийсэн, авилгалд (хээл хахуульд) автагдсан, хуурч мэхэлсэн, залилан, луйвар зэрэг эрүүгийн шинжтэй ямар нэгэн гэмт хэрэгт холбогдсон, ёс зүйн зөрчил гаргасан нэг ч хүн байгаагүйг энд онцолж хэлье.

Миний бие МАХН-ын үйл ажиллагаа, нэр хүндийн асуудалтай холбогдуулж энэ бүгдийг тэмдэглэж хэлэхдээ МАХН-ын бодлого, үйл ажиллагаанд гарч байсан зарим алдаа, дутагдал, гажуудлыг үгүйсгэх буюу хаацйлан хамгаалах санаа, зорилго байхгүй болохыг онцолж тэмдэглэхийг хүсэж байна.

МАХН тухайн үед бүх асуудлыг нэг намын баримталж байсан үзэл сурталтай холбож авч үздэг байсан учраас зарим асуудалд өрөөсгөлөөр хандаж, том алдаа гаргаж байсан явдлууд бий. Жишээ нь “сэхээтний төөрөгдөл”, “намын эсрэг бүлэг”гэгч асуудал, Л.Цэнд, Д.Төмөр-Очир зэрэг боловсон хүчинтэй холбоотой зарим асуудлын талаар том алдаа дутагдал гаргаж байсныг дахин хэзээ ч давтан гаргаж болохгүй юм. Миний бие энд хэдийгээр түүх болон өнгөрсөн боловч нэг зүйлийн түүхийн сургамжийн үүднээс тэмдэглэж хэлэхийг хүсч байна.

МАХН-ын удирдан чиглүүлэх, зохион байгуулах гол үүргийг хүлээж түүнийг хэрэгжүүлэх гол газар болж байсан Улс Төрийн Товчооны бүрэлдэхүүнийг үе үе буюу их удалгүйгээр шинэчилж, сайн бэлтгэгдсэн залуу боловсон хүчнээр бэхжүүлж байх хэрэгтэй байсан юм. Д.Төмөр-Очир МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны гишүүн, нарийн бичгийн дарга байхдаа МАХН-ын Төв Хорооны нэгэн ээлжит бүгд хурал дээр хамгийн түрүүн босч үг хэлэхдээ мэдлэг боловсрол, ажлын арга барилаар хоцрогдсон хэмээн Улс Төрийн Товчооны гишүүн байсан Дамба, Сүрэнжав, Самдан, Балган, Ламчин нарыг шүүмжилсэн юм. МАХН-ын Төв Хорооны Бүгд хурлын гишүүд түүнийг дэмжиж, дээр дурьдсан хүмүүсийг нэгэн зэрэг өөрчилж байлаа. Энэ мэтээр МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны бүрэлдэхүүнийг шинэчилж байх нь зайлшгүй шаардлагатай байсан боловч МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны үйл ажиллагааг удирдаж байсан Ю.Цэдэнбал ийм ажлыг хийдэггүй байсан нь түүний нэг сүрхий алдаа байсан гэж хэлж болох байхаа. Ер нь миний мэдэж байгаагаар Д.Төмөр-Очироос өөр МАХН-ын Улс Төрийн Товчоо, төрийн дээд удирдлагад халдаж улс орон ард түмнийхээ ашиг сонирхлын төлөө шудрага шүүмжлэл тавьж байсан хүн бараг байхгүй болов уу.

Д.Төмөр-Очир тухайн үед Ю.Цэдэнбалыг дэмжиж ч байсан, бас алдаа дутагдлыг нь шулуун шудрагаар шүүмжилдэг ч байсан. Д.Төмөр-Очирын талаар алдаатай шийдвэр гаргаж, түүнийг хохироож байсан явдлаа Ю.Цэдэнбал хожим хүлээн зөвшөөрч “Би Төмөр-Очирыг хэтрүүлж байжээ! Д.Төмөр-Очир ажилд надаас илүү шүү дээ. Даан ч ааш нь ...” гэж ярьдаг байсан юм.

МАХН-тай холбогдуулж миний энд тэмдэглэн хэлж байгаа зарим алдаа дутагдлын тухай асуудал нь МАХН-ын гаргаж байсан алдаа дутагдал гэж үзэж болох мэт боловч гол нь тэр үед МАХН-ын төв байгууллагыг удирдаж байсан Ю.Цэдэнбалтай шууд холбоотой, ихэнхдээ түүнээс шалтгаалж байсныг түүхийн сургамж болгож, жинхэнэ үнэнээр нь хэлэх ёстой гэж би үзэж байна.

Хууль зүйн үүднээс аливаа асуудал, аливаа нэгэн хэргийг түүнийг үйлдсэн жинхэнэ субъекттэй нь холбон авч үздэг ёстойн нэгэн адил МАХН-ын дээд удирдлага буюу Ю.Цэдэнбалын гаргаж байсан алдаа, хийж байсан нүглийг МАХН-д буюу түүний олон мянган жирийн гишүүдэд тохон хүлээлгэх гэж оролдох буюу тэднийг яллаж, харааж зүхэж хэрхэвч болохгүй. Энэ бол хууль зүй болон ёс зүйд үл нийцнэ.

10 Ю. Цэдэнбалын талаар миний хэлэх үг.

КЮ: Та МАХН-ын ерөнхий нарийн бичгийн дарга асан Ю.Цэдэнбалтай олон жил танил байсан хүний хувьд, түүнтэй хамт ажиллаж байсан он, жилүүдийнхээ тухай дурсамжаас бидэнд жааханч гэсэн ярьж өгнө үү?

С Ж: Би МАХН-ын Төв Хорооны намын ажил эрхэлсэн нарийн бичгийн дарга байх үед хийж байсан ажлынхаа талаар сая товч ярьлаа. 1984 оны 8-р сард хуралдсан МАХН-ын ТХ-ны 8-р бүгд хурал МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбалын асуудлаар зөв шийдвэр гаргаж чадаагүй гэж би бодож явдаг юм. Тийм учраас МАХН-ын ерөнхий нарийн бичгийн дарга асан Ю.Цэдэнбалын талаар цөөн үг хэлэх нь зүйтэй гэж үзэж байна. 40 гаруй жил МАХН, Монгол улсын төр, засгийн тэргүүн байсан Ю.Цэдэнбалын намтар, үйл ажиллагаа буюу түүний хийж бүтээсэн асар их ажил, байгуулсан гавъяа зүтгэлийн тухай бүгдийг өгүүлэх боломжгүй бөгөөд тэгэх ч хэрэггүй юм. Миний бие Ю.Цэдэнбалтай 1942 онд анх танилцсан, Шинэ хүчний дээд сургуульд суралцаж байхдаа эдийн засгийн ухааны ерөнхий онолын хичээл заалгаж, түүнд улсын шалгалт өгч байсан билээ. 1958 оноос хойш түүний шууд удирдлагын дор төр, засгийн өндөр хариуцлагатай ажил олон жил хийж байсан билээ. 1972-1984 онуудад МАХН-ын болон Монголын төрийн дээд

удирдлагын бүрэлдэхүүнд мөн түүний удирдлагын дор ажиллаж байсны хувьд Ю.Цэдэнбал ямар хүн байсан тухай өөрийн сэтгэгдлийг хэлэх боломжтой гэж үзэж байна.

Ю.Цэдэнбал нь Монгол улсын хөгжил, цэцэглэлт, тусгаар тогтнолын төлөө, ард түмний язгуур эрх ашгийн төлөө өөрийн бүх хүч чадал, оюун ухаанаа шавхан дайчилж ажилладаг, өндөр нэр хүнд бүхий улс төрийн том удирдагч, лидер байсныг би батлан хэлж чадна.

Ю.Цэдэнбал нь өндөр боловсролтой, соёлтой, өргөн мэдлэгтэй, ажлын эрч, хүч чадвартай, туйлын ажилсаг, улс төрийн баялаг туршлагатай, ноён нуруутай, өндөр шаардлагатай, олон түмний хүндэтгэлийг хүлээсэн хүн байсан юм.

Ю.Цэдэнбал манай орны эдийн засаг, соёлын байгуулалтын бүх салбарыг үүсгэн байгуулах, эрчимтэй хөгжүүлж, өндөр амжилтанд хүргэх, ард түмний аж амьдрал, соёлын хэмжээг дээшлүүлэх үйлсэд асар үүрэг гүйцэтгэсэн билээ.

Ю.Цэдэнбалын санал, санаачлагаар манайд эдийн засаг, соёлын олон салбарууд цоо шинээр үүсч хөгжсөн юм. Атар газрыг эзэмших хөдөлгөөн өрнүүлэх замаар газар тариалангийн цоо шинэ салбарыг буй болгож, аж үйлдвэрийн шинэ, шинэ цогцолборуудыг барьж, байгуулахад түүний санаачлага, идэвхи зүтгэл, бүх талын дэмжлэг асар их байсан юм.

Ю.Цэдэнбал манай оронд бүх төрлийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх ажилд жинхэнэ хувьсгал хийсэн хүн юм. Түүний санаачлагаар МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Намын дээд сургууль, Монгол Улсын Их Сургууль байгуулагдсан нь улс орны хөгжилд үнэлж барашгүй ач холбогдолтой ажил байсан юм.

Ю.Цэдэнбал бол хүний амаар будаа иддэггүй өөрөө сэтгэж, бодох өндөр чадвартай хүн байв. Тэр “МАХН-ын программ”, “Үндсэн хууль” зэрэг МАХН, Монголын төрийн томоохон баримт бичгүүдийн эцсийн боловсруулалтыг өөрөө шууд хариуцаж, гардан хийж гүйцэтгэдэг байлаа. МАХН-ын Их хурал, бүгд хурлууд болон өөр бусад хурал зөвлөлгөөнд тавих илтгэл, хэлэх үгээ тэр зөвхөн өөрөө бичиж, боловсруулдаг байсныг би гэрчлэн хэлж чадна.

Ю.Цэдэнбал Монгол улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг бататган бэхжүүлэх талаар үлэмж их зүйлийг хийж бүтээсэн, жинхэнэ эх оронч хүн байлаа. Түүнийг “Оросын талыг баримтлагч, оросын сонирхол, ашиг тусын төлөө ажиллаж байсан!” гэж зарим хүмүүс ярьдаг. Энэ бол ямар ч баримт, нотолгоогүй, оргүй хоосон яриа юм.

Ю.Цэдэнбал бол жинхэнэ ард түмний удирдагч мөн байсан. Тэр хөдөө явж, орон нутгийн ажил, амьдралтай байнга танилцаж, хүмүүсийн санал сэтгэгдлийг сонсож, эрэлт хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авдаг,

тэдгээрийг шуурхай барагдуулж өгдөг, ер нь гачигдал зовлон тохиолдсон хүмүүст аль болохоор туслахыг хичээдэг, хүний төлөө санаа, анхаарал их тавьдаг, хүмүүнлэг энэрэнгүй, сайхан сэтгэлтэй хүн байсан. Орон сууц, мөнгө, төгрөгний тусламж хүссэн, эсхүл сургуульд явуулж өгөхийг хүссэн, гачигдал зовлонгоо тоочиж, ял шийтгүүлсэн үр хүүхэд буюу садан төрлийнхөө хүнийг хорих газраас суллаж өгөөч гэж хүсч өөртэй нь уулзсан хүмүүст тусламж үзүүлж, орон сууц өгч, санхүүгийн тусламж үзүүлж, хүүхдийг нь шоронгоос гаргаж өгөх арга хэмжээ авах талаар МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга нарт болон надад байнга үүрэг өгч, эсхүүл өөрөө шууд арга хэмжээ авч тусламж үзүүлдэг байсан юм.

Ю.Цэдэнбал “сэхээтний төөрөгдөл”, “намын эсрэг бүлэг” гэгч, түүнчлэн Л.Цэнд, Д.Төмөр-Очир нарын зэрэг боловсон хүчний асуудлаар алдаа, гажуудал, завхарлууд гаргаж, МАХН-ын болон Монголын төр, засгийн удирдлагад өөрийнх нь оронд гарч ирэх магадлал өндөртэй, сайн бэлтгэгдсэн, ажлын арвин туршлагатай зарим хүнийг ямар нэгэн зүйлээр заавал буруутгаж, ажлаас нь халж, нутаг зааж зайлуулдаг байлаа.

Ю.Цэдэнбал МАХН-ын ерөнхий нарийн бичгийн дарга байсан сүүлчийн жилүүдэд эхнэр Анастасия Ивановна Филатова нь түүний ажил хэрэгт нь шууд оролцож, хутган үймүүлж байсны уршгаар зарим удирдах боловсон хүчний талаар алдаатай шийдвэр гаргаж, гэм буруугүй хүмүүсийг хохироох явдал гарч байлаа.

Ю.Цэдэнбалд хов зөөж толгойг нь эргүүлдэг, хутган үймүүлдэг, өөрсөддөө нэр хүнд, ашиг завшаан олохыг хичээдэг тийм үл бүтэх цөөн тооны хүмүүс байсан бөгөөд тэдний хорт явуулгын уршгаар тэр МАХН-ын болон Монголын төрийн дээд удирдлагын бүрэлдэхүүнд хамт ажиллаж байсан нөхдөө харддаг, сэрддэг болж, тэдний хооронд үл итгэх байдал буй болсон юм.

Ю.Цэдэнбал 1970-аад оны эцсээс ажилдаа тэнцэхгүй, ажил хариуцах чадваргүй болсон бөгөөд нас ахисан хүний хувьд биеийн эрүүл мэндийн байдал нь тааруу болж, сүүлдээ эрс муудсан юм. Тэр олон жилийн турш биеэ өчүүхэн ч хайрлахгүй явж, амралт, чөлөө завгүй, өдөр шөнөгүй ажилладаг байсан учраас хүний биед байдаг бүх хүч, нөөцөө шавхаж дуусгасан хүн гэж би боддог. Энэ байдлыг үндэслэн түүнийг МАХН-ын болон Монголын төр, засгийн дээд албан тушаалын ажлаас чөлөөлсөн явдал бол зөв, зүйтэй арга хэмжээ байсан билээ.

Ю.Цэдэнбалыг насан өөд болтол нь сэтгэл санаагаар амгалан, тайван байлгаж, асарч, сувилаж байх ёстой байсан боловч манай тэр үеийн эрх баригчид үнэн хэрэгтээ түүнийг “хог дээр хаясан” юм. Ямар ч үндэсгүйгээр түүнийг элдвээр харааж, муу хэлж байсныг хэрхэвч зөвтгөж болохгүй юм.

Ю.Цэдэнбал Москвад “гэрийн хорио”-нд, сэтгэл, санаагаар маш их зовж, уйгарлан гуниглаж, гутарч нэг өрөөнд ганцаараа суусаар насан өөд болсон билээ. Түүнийг ийм байдалд оруулахгүй байх боломж байсан юм.

Ю.Цэдэнбалыг насан өөд болсны дараа шарилыг нь түүний эхнэр, үр хүүхэд, төрөл төрөгсөд Монгол эх оронд нь авч ирж оршуулахад, тэр үед манай МАХН болон Монголын төр, засгийн дээд удирдлагад ажиллаж байсан хүмүүс ямар ч хүндэтгэл үзүүлээгүй, өчүүхэн ч анхаарал тавилгүй өнгөрч байсан нь дэндүү жудаггүй, хүнлэг биш явдал болсон юм. Эдгээр хүмүүс бол урьд нь Ю.Цэдэнбалын үед, түүний дэмжлэгээр МАХН-ын болон Монголын төрийн дээгүүр алба хашиж явсан, түүнийг сайн таньдаг, мэддэг хүмүүс байсан нь нэн харамсалтай.

Ю.Цэдэнбалд Монголын төрөөс олгосон цэргийн дээд цол Монгол улсын маршал, бас Монгол улсын баатар, Монгол улсын хөдөлмөрийн баатар цолнуудыг хүчингүй болгож, түүний хийсэн бүтээснийг нь үнэлж шагнасан төрийн одон медалуудыг нь хураан авч, МАХН-ын гишүүнээс хөөсөн нь туйлын буруу үйлдэл юм. Ийм үйлдэл гаргасан хүмүүстэй хуулийн дагуу хариуцлага тооцох хэрэгтэй юм.

Ю.Цэдэнбалыг Москвад амьдарч байх үед нь түүний Улаанбаатарт хууль ёсоор эзэмшиж байсан орон сууц, хувийн эд, хогшилд нь хууль бусаар халдаж, үрэн таран хийж, алга болгосон адал балмад явдлыг хуулийн дагуу мөрдөн шалгах нь зүйд нийцнэ.

Ю.Цэдэнбалд алдаа дутагдал, сул тал байсныг үгүйсгэж болохгүй боловч түүний хийж бүтээсэн асар их зүйл, гавъяа зүтгэлийг хэн ч түүхийн хуудаснаас арчин хаяж чадахгүй нь лавтай. Түүх, түүхээрээ үлддэг жамтай юм.

Ю.Цэдэнбалтай хамт ажиллаж байсан МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны гишүүдийг буруутгаж, шийтгэхийн тулд “гойрон хүрээлэгчид”-ийн хэмээх зохиомол хэргийг буй болгохыг оролдсон боловч хууль нүдтэй учраас тэднийг шийтгэж чадаагүй юм.

Ю.Цэдэнбал ажил хариуцаж, зөв шийдвэр гаргах чадваргүй болж, 1970-аад оны эцсээр нас ахисан хүний хувьд биеийн эрүүл мэндийн байдал нь эрс дордож байгааг мэдсээр байж, тухайн үед санаачилга гаргаж түүнийг МАХН-ын ТХ-ны ерөнхий нарийн бичгийн даргын ажлаас зохих хүндэтгэлтэйгээр чөлөөлөөгүй явдал бол МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны ноцтой алдаа болсон юм.

Ю.Цэдэнбалын байгуулсан гавъяа зүтгэл, бас гаргаж байсан зарим алдаа дутагдлын талаар би хувийнхаа бодол сэтгэгдлийг цухас ярихад ийм байна.

11 Хэлмэгдүүлэл.

И Л: Таныг яагаад “намын эсрэг бүлэг” гэгчтэй холбосон юм бэ? Үнэхээр тийм бүлэг байсан юм уу?

С Ж: Ю.Цэдэнбал бид хоёр ажил төрлийн харилцаа муугүй, надад итгэдэг, ажлын талаар миний тавьсан санал, шүүмжлэлтэй хэлсэн үгэнд хүндэтгэлтэй ханддаг байсан юм. Манай Ардын Их Хурлын дарга (ерөнхийлөгч–ред.) Жамсрангийн Самбуу гэдэг хүн байлаа шүү дээ. Тэр бол төрөлхийн их ухаантай, ёстой жинхэнэ сайхан монгол хүн байлаа. Түүнийг нас барсны дараа ЮЦэдэнбал Сайд нарын Зөвлөлийн даргын албан тушаалд намайг томилуулах саналтай байгаагаа хэлсэн юм. Би түүний энэ санаалаас эрс татгалзсан боловч тэр надад ихээхэн даралт, шахалт үзүүлж эхэлсэн юм. “Сайд нарын Зөвлөлийн дарга бол эдийн засгийн мэргэжилтэй асар их мэдлэг, боловсролтой, улс төрийн болон амьдралын их туршлагатай хүн байх ёстой!” гэж би боддог юм. Ю.Цэдэнбал бид хоёр энэ асуудлаар хоёр, гурван өдөр ярьж, заримдаа бүр шөнийн 3-4 цаг хүргэж байлаа. МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны хурал дээр ч би энэ санаалаас татгалзаж байгаагаа хэлсэн юм. Ингээд Ю.Цэдэнбал ч өөрийн саналаасаа татгалзаж байлаа. Ер нь үнэндээ Ю.Цэдэнбал бол намайг нийгмийн хог дээр гаргаж хаясан хүн юм шүү дээ.

Би 1983 оны зун МАХН-ын төлөөгчдийг тэргүүлж, ЗХУКН-ын урилгаар ЗХУ-д албан ёсны айлчлал хийсэн юм. Тэнд манай төлөөлөгчдийг маш сайхан хүлээж авлаа. Айлчлалыг маш сайн зохион байгуулж, айлчлалын бүх үйл явц дээд хэмжээнд болж өнгөрлөө. Ингээд Улаанбаатарт буцаж ирлээ. Нас 60 хүрч байлаа. Улаанбаатарт ирсний маргааш шууд л Ю.Цэдэнбал дарга дээр орлоо. Гэтэл тэр хүйтэндүү байдлаар:

-Чи хаашаа яваад ирэв ээ? гэж асууж байна. Би их гайхлаа. Тэгээд:

-Би ЗХУКН-ын урилгаар ЗХУ-д айлчлаад ирлээ. Энэ талаар “Үнэн” сонин байнга л мэдээлж байсан шүү дээ. Та уншиж байсан байлгүй дээ! гэж хэллээ. Тэгтэл тэр юм ч хэлсэнгүй, дуугүй л байна. Бид хоёрын хооронд олигтой яриа болсонгүй. Би “ямар нэгэн юм болж байна!” гэж дотроо бодлоо. Ингээд түүний өрөөнөөс гарлаа. Гэтэл МАХН-ын Төв Хорооны бүгд хурал тун удахгүй хуралдахаар бэлтгэж байгаа мэдээ сонсогдлоо. Уг нь МАХН-ын Бүгд хурал хэзээ хуралдах, ямар асуудал хэлэлцэхийг би л мэддэг, шийддэг байлаа шүү дээ. Тэгтэл удсан ч үгүй Ю.Цэдэнбал дарга намайг өрөөндөө дуудсан байна. Би юу ярих гэж байгааг нь гадарлаж байлаа. Ингээд түүний өрөөнд орлоо. Тэр урьдын адил их хүйтэн, хөндий

хэвээрээ л байна. Намайг тэр суу гэж урьсан ч үгүй. Тэгээд:

-Бид нар чамайг тэтгэвэрт чинь гаргахаар ярьж байна! Улс Төрийн Товчооны хурлаар ярина. Энэ асуудлыг бүгд хуралд оруулна! гэж их хөндий хэлж байна.

Би:

-Тэтгэвэрт гарч болох юм. Ер нь “Би тэтгэвэртээ гаръя. Эрдэм шинжилгээний ажлаа хийе! гэж танд хэлдэг л байсан шүү дээ. Гэхдээ одоо тэтгэвэрт гаргаж байгаа шалтгааныг сонсмоор байна. Би улс төрийн ажил хийж байгаа хуульч хүн!” гэж хэллээ. Гэтэл Ю.Цэдэнбал дарга юм хэлсэнгүй.

Би:

-Маргааш хуралдах бүгд хуралд би үг хэлнэ! гэж гэлээ.

Гэтэл тэр: “Чи үг хэлээд хэрэггүй! Чамайг харж үзнэ! Зөвхөн талархалын л үг хэлэх хэрэгтэй!” гэж байна. Би ч бүгд хуралд талархалын үгнээс өөр үг хэлсэнгүй. Уг нь надад хэлэх үг их байсан л даа. “Элдэв юм ярьж намынхаа нэгдэл, нягтралыг бусниулаад хэрэггүй!” гэж л би бодсон юм. Ингээд “ШУА-д очиж эрдэм шинжилгээний ажил хийнэ дээ!” гэсэн бодолтой ажлаасаа гарчихлаа. Хэд хоноод Ю.Цэдэнбалтай уулзахаар очтол туслах нь оруулдаггүй. Өдөр бүр би түүний өрөөнд чөлөөтэй ордог байсан хүн шүү дээ.

Яаж гуйгаад ч оруулсангүй. Ингээд чимээгүйхэн хэдэн сар боллоо. Ингээд байж байтал 12-р сард МАХН-ын ТХ-ны Намын Хянан Шалгах Хороо (НХШХ) намайг дуудсан байна. Би тэнд очлоо. Тэнд МАХН-ын ТХ-ны НХШХ-ны хурал боллоо. Тэр хурал дээр НХШХ-ны дарга Б.Дэжид гэдэг хүн:

-1964 онд гарсан намын эсрэг бүлгийн удирдагч нь чи байсан байна. Энэ бол баримтаар нотлогдсон зүйл. Чамайг МАХН-ын ТХ-ны гишүүнээс хөөх асуудлыг бид МАХН-ын бүгд хуралд оруулна! гэж байна. Ийм гүжир гүтгэлэгийг би анх удаагаа өөр дээрээ хүлээж авсан болохоор эхэн үедээ маш хүчтэй шоконд орсон билээ. Гэхдээ биеэ барьж 1964 оны “намын эсрэг бүлэг” гэгчтэй ямарч холбоогүй гэдгээ хэллээ. Тэр үед “гүжир үгэнд саам үг хариугүй!” гэдэг монголчуудын нэг мэргэн үг санаанд орж ирж байлаа. 1964 оны 12-р сард хуралдсан МАХН-ын Төв Хорооны 6-р бүгд хурал дээр Ц.Лоохууз, Б.Нямбуу, Б.Сурмаажав нар “Манай улсын хөгжил их удаан байна! Өр, зээл их тавьж байна! Нутаг, орныхоо нэг хэсгийг өөр оронд зүгээр өглөө! Хээл, хахуул авч, өгч байна! Ю.Цэдэнбал Оросын эрх ашгийг хамгаалж байна! Үндэсний сэхээтнүүдээ хавчин гадуурхаж байна!” гэж шүүмжилсэн юм. Тэдэнд “намын эсрэг бүлэг” гэдэг нэр өгөөд, нутаг заагаад, цөлсөн юм. Энэ цөллөг маш олон жил үргэлжилж, тэд нар бараг 30 жилийн дараа сая цагаадаж байсан юм шүү дээ. Би тэд

нартай ямар ч холбоогүй хүн шүү дээ. Тэр өдөр намайг МАХН-аас хөөж, миний МАХН-ын батлахыг хурааж авлаа. Үүнээс хойш 2 сарын дараа Цагдаагийн газрын дарга намайг дуудаж уулзаад:

-Таныг Завхан аймгийн Алдархаан сумын нутагт суулгах шийдвэр гарсан тул хурдан тийшээ явах хэрэгтэй! гэж мэдэгдсэн юм. Түүнээс хойш хэд хоногийн дараа миний амьдарч байсан улсын орон сууцыг хууль бусаар хурааж аваад, манай гэрийн эд хогшлыг цагдаагийн ажилтнууд машинд ачиж Завхан аймагт хүргэж өгөхөөр аваад явцгаалаа. Түүнээс хойш 2 хоногийн дараа цагдаагийн ажилтан намайг нисэх онгоцонд албан журмаар суулгаж, Завхан аймгийн төвд хүргүүлж, тэнд цагдаагийн хошууч тосч аваад Алдархаан суманд хүргэж өгч байлаа. Миний охин Ж.Хандсүрэн тэр үед Монгол Улсын Их Сургуульд багш байсан юм. Түүнийг бас ажлаас нь шууд халлаа. Ингэж би бүх албан тушаалаасаа халагдаж, огт хийгээгүй хэрэгтээ гүтгүүлж, МАХН-аас хөөгдөж, нутаг заагдан цөлөгдсөн билээ.

Энэ бүхнийг Ю.Цэдэнбалын эхнэр Анастасия Ивановна Филатова, НХШХ-ны дарга Бугын Дэжид хоёр хийсэн юм. Ю.Цэдэнбалын эхнэр, Хүүхдийн төлөө фондын дарга А.И.Филатова бид хоёрын харилцаа хэд хэдэн асуудлаас болж муудаад, сүүлдээ маш хурцадмал байдалтай болсон юм. А.И.Филатова хийж болохгүй маш олон юмыг надаас шаарддаг байсан боловч би түүний шаардлагын нэгийг нь ч хүлээж аваагүй, харин өрийн байр суурийг илэрхийлж, зөвшөөрөхгүй байгаагаа хэлдэг байсан юм. Тухайлбал, хариуцсан ажлаа сайн хийж байгаа, манай нийгэмд нэр хүндтэй олон хүнийг ямарч үндэслэлгүйгээр ажлаас нь халах шаардлагыг удаа дараа тавьж, маш хүчтэй шахалтыг үзүүлж байсан юм. Хамгийн сүүлд А.И.Филатова миний ажлын өрөөнд шууд дайрч орж ирээд, сурсан зангаараа харааж, хашгачиж байгаад “Үүнээс хойш би чамайг МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга гэж үзэхгүй. Одоо Б.Дэжид бүхнийг мэднэ!” гэж хэлээд гарч явсан юм. 1984 онд А.И.Филатова Москвад байхдаа манай нэг хариуцлагатай ажилтанд “Би Улаанбаатарт очоод С.Жалан-Аажавыг хар гэрт суулгана!” гэж хэлсэн байдаг юм. Хар гэр гэдэг чинь шорон шүү дээ. А.И.Филатова намайг шоронд суулгахыг мөрөөдөж байж. Тэр мөрөөдөл нь биелэлээ олж эхлэх нөхцөл нь бүрдээд байж.

Ингэж А.И.Филатова бид хоёрын харилцаа маш хурцадмал, дайны байдалд орсон нь Б.Дэжидэд их аятайхан явдал болсон юм. Бугын Дэжид бол манай Дотоод яамны сайд байсан хүн. МАХН-ын 17-р Их хурал хуралдаж байх үед Ю.Цэдэнбал надад Дотоод яамны сайд Бугын Дэжидийг МАХН-ын НХШХ-ны даргаар томилох бодолтой байгаагаа хэлсэн юм. Би түүний энэ саналын дэмжээгүй юм. “Б.Дэжид бол тагнуул

шүү дээ. МАХН-ын ТХ-ны Улс Төрийн Товчоонд нэг тагнуул орж ирнэ гэсэн үг, өрөөр хэлбэл Берия гэсэн үг шүү дээ!” гэж би түүнд хэлсэн юм. И.Берия бол И.В.Сталины үед ЗХУ-ын Улсыг Аюулаас Хамгаалах Хорооны дарга байсан хүн. Тэр хүн И.В.Сталинтай нийлж олон гэмгүй хүнийг хэлмэгдүүлж, цаазалсан хамгийн аймшигтай хүн шүү дээ. Б.Дэжид ингэж МАХН-ын Төв Хорооны НХШХ-ны даргаар томилогдож, МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчоонд орж ирсэн юм. Түүний талаар миний хэлсэн үгийг Ю.Цэдэнбалаас тэр сонссон байх л даа. Тэр надад сайн хандахгүй байх нь ойлгомжтой. А.И.Филатова, Б.Дэжид хоёр ингэж өөр өөрсдийнхээ зорилгыг хэрэгжүүлэхийн тулд сүрхий гар нийлж, бие биенийгээ ашиглаж эхэлсэн юм.

Эхлээд С.Жалан-Аажав миний биеийг МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны гишүүн, нарийн бичгийн дарга, Ардын Их хурлын тэргүүлэгчдийн орлогч даргын (дэд ерөнхийлөгч-ред.) ажлаас чөлөөлүүлж, дараа нь МАХН-ын Төв Хорооны гишүүнээс чөлөөлөх тухай асуудлыг Ю.Цэдэнбалаар зөвшөөрүүлсэн байгаа юм. МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбал тэдний үгэнд орж ийм шийдвэр гаргасан юм. Тэгээд МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчоо, бүгд хурлаар тус тус хэлэлцүүлж, шийдвэрлүүлсэн юм. Ингээд МАХН-ын НХШХ-ны шийдвэр гарч намайг МАХН-ын гишүүнээс хөөж, нутаг зааж цөлсөн юм.

1990 онд “С.Жалан-Аажавын намын эсрэг ажил, явуулгын тухай” гэдэг нэртэй МАХН-ын Төв Хорооны тогтоол хүчингүй болж, би 1990 оны 7-р сарын 31-нд “цагаатгалын үнэмлэх”-ээ гардан авч байлаа. Би цөллөгөөс буцаж Улаанбаатарт ирээд хийх ажилгүй, амьдрал маш ядуу, гудамжаар өдөржин явж, шар өдөр, бор хоногийг өнгөрөөсөн болж явах үед, манай нэртэй хуульч, доктор, профессор, Монголын Үндсэн Хуулийн Цэцийн анхны дарга Ж.Совд өөрийн тэргүүлж байсан Төр, эрх зүйн хүрээлэнд намайг эрдэм шинжилгээний ажилтнаар авсанд би их баярлаж байдаг билээ. Тэр үед Санпилын Жалан-Аажав миний амьдрал дахин шинээр эхэлж байх шиг санагдаж байж билээ. Би ингэж миний амьдралд тохиолдсон хүнд хэцүү үеийг даван туулж, багш, эрдэм шинжилгээнийхээ ажлыг дахин хийж эхэлсэн билээ. Миний олон жил багшийн ажил хийсэн, эрдэм шинжилгээний өчүүхэн зүтгэл бүтээлийг өндөрөөр үнэлж Монгол улсын ерөнхийлөгч зарлиг гарагж “Монгол улсын гавьяат хуульч” гэдэг өндөр шагналыг хайрласан явдалд би гүн талархал илэрхийлж байна.

КЮ: За. Сайхан яриа ярьж өгсөн танд их баярлалаа.

Думаагийн Содном

1 Эх орон эндээс эхэлдэг.	7 Ю. Цэдэнбал гуайд алдаа байсан уу?
2 Би Санхүүгийн техникумд оров.	8 Ардчилсан хөдөлгөөний эхлэл.
3 Би Эрхүү хотод сурахаар явлаа.	9 Хүнд үе.
4 Монгол улсын Сангийн сайд.	10 “Ю.Цэдэнбалын тойрон хүрээлэгчид” гэгчид.
5 Их өр.	11 “Алдагдсан он, жилүүд”.
6 Ю. Цэдэнбал гуайг халлаа.	

1 Эх орон эндээс эхэлдэг.

Конагая Юүки (цаашид **КЮ**): За, бидний урилгыг хүлээн авч хүрэлцэн ирсэн явдалд бид маш их баяртай байна. Монгол улсын Сангийн сайд, Төлөвлөгөөний комиссын дарга, Сайд нарын Зөвлөлийн дарга, МАХН-ын ТХ-ны Улс төрийн Товчооны гишүүн зэрэг МАХН болон Монголын төрийн өндөр албан тушаалыг олон жил нэр төртэй, үр бүтээлтэй хашиж явсан Думаагийн Содном тантай уулзаж байгаа энэ завшааныг ашиглан Монгол улсын нийгэм, улс төр, эдийн засгийн амьдралтай холбоотой асуудлуудаар чөлөөт ярилцлага хийх сонирхолтой байна. Энэ удаагийнхаа ярилцлагыг таны бага насны дурсамжаас эхэлбэл ямар вэ? Та хэдэн онд, хаана төрсөн болон өөрийн аав, ээж, ах эгч, дүү нарынхаа тухай ярьж өгнө үү?

Думаагийн Содном (цаашид **ДС**): За, та бүхэнтэй уулзаж байгаадаа би баяртай байна. Монголын Алтан говь-Дорноговь аймгийн Баянмөнх (одоогийн Өргөн сум) сумын нутагт “Аргалын уул” нэртэй хайрхан бий. Энэ уулын хойд зүгт байдаг Гарамын гол хэмээх жалганы дунд хэсгийн баруун талд баруун хойноос зүүн өмнө зүг дамнан орж ирсэн жижиг толгодын энгэрт байдаг “Илийн бууц” гэж нэрлэдэг намаржаанд 1933 онд миний бие эцэг, эхийн насан идэрт хувь тохион мэндэлсэн юм.

Төрсөн энэ бууцаа би 1968 онд ээжээрээ заалгаж авсан юм. Ээж минь зааж өгөөгүй бол би төрсөн бууцаа мэдэхгүй үлдэх байсан байж магадгүй. Ээжийн минь зааж өгсөн тэр бууц, гэрийн буурь дээр очих бүрийд “Эх орон эндээс эхэлдэг” гэсэн бодол өөрийн эрхгүй төрдөг билээ. Өндийхэд минь дэмжиж, хазайхад минь түшиж өндийлгөсөн нутгийн бор толгод, элс, шороо минь, тэнд ургадаг тачир боловч тансаг ургамал, таана хүмүүлийн үнэр даанч сайхан. Ивээл халамжиндаа багтааж, бага залуу насанд минь түшиг болж, эгэл жирийн амьдрал, хүнлэг сайхан сэтгэлээрээ үлгэрлэсэн

нутгийн ард иргэд, ахан дүүс нарынхаа агуу ач тусыг мартахын аргагүй.

Би яг төрсөн өдрөө мэддэггүй юм. Тэр үед шинээр төрж байгаа хүүхдийг бүртгэж байсангүй. Ээжийн хэлснээр баримжаалж байгаад хожим 7-р сарын 14-нд төрсөн гэж бүртгүүлээд “Төрсний гэрчилгээ” авсан билээ. Миний дээд өвөг болох Цоовгой гэдэг баруун монголын Ханхөхий нэртэй газар олон жил цэргийн алба хааж байгаад тэндээс эхнэр авч нутагтаа ирсэн гэдэг юм. Тэр хоёр нэг хүүдээ Цэдэн гэдэг нэр хайрлажээ. Энэ Цэдэн нь “Бөгтөр” хэмээх хочтой байсан бөгөөд Жаргал, Охин, Ханд нэртэй гурван охинтой болжээ. Жаргалын нөхрийг Гомбо гэдэг байж. Тэр хоёр Цэвэг, Сосор нэртэй хоёр охин, Гончиг нэртэй хүүтэй байж. Тэд нарын үр, удам болох олон хүн одоогийн Өргөн сумын нутагт амьдарч байна.

Жаргалын Цэвэг нь анхандаа Жамъян, дараа нь Самдан нэртэй нөхөртэй байж. Тэр хоёр хоёулаа сахил хүртсэн лам хүн байсан бөгөөд улс төрийн хилс хэргээр цаазлуулсан юм гэнэ билээ. Бидний эмээ ээж Цэвэг 9 хүүхэд төрүүлж өсгөсөн билээ. Дандиа, Дэндэв, Маам гэсэн гурван банди, Дулмаа, Бор, Баламцоо, Дуламсүрэн, Долгорсүрэн, Дүгэр гэсэн зургаан охинтой байж. Тэд нарын ихэнхийг нь би мэддэг юм. Түүнээс Дандиа 1, Дэндэв 11, Маам 3, Дулмаа 8, Баламцоо 2, Дуламсүрэн 6, Дүгэр 7 хүүхэдтэй байж. Дорноговь аймгийн одоогийн Өргөн сумын зүүн талын нутагт, ялангуяа Аргал уулын ойролцоо аж төрж буй айлуудын ихэнх нь “Өндөр” хочтой байсан. Дэндэв болон түүний дүү Дуламсүрэн нарын хүүхэд, ач, гуч нар байгаа юм. Бидний эцэг Чойжамц 1905 онд, эх Думаа 1902 онд төржээ. Тэд нар хорьдугаар зууны яг босгон дээр төрж, аав минь 40-өөд он хүртэл, ээж минь 1973 онд хүртэл амьдарсан юм. Би бол бүр шинэ мянганы шинэ зууныг үзэж амьдарч байгаа азтай хүн. Миний дурсамж яриа бол бүтэн нэг зууны Монголын амьдралын түүхийг товч хамарч байгаа юм шиг сэтгэгдэл төрж магадгүй. Монгол хүний дундаж наслалт тийм урт биш боловч бас ч чамлахааргүй уртсаж, цаашид хэмжээ чансаагаараа нэмэгдэх сайхан ирээдүй бий.

Миний ээжийг Думаа, аавыг Чойжамц гэдэг байсан. Миний аав олны дунд “Аргалын уулын Алтан Чой” гэдэг нэрээр алдаршсан хүн байж. Тэр хоёр ханилан суугаад төрүүлж өсгөсөн хүүхдүүд нь бол :

- Должинсүрэн - 1923
- Бяхар - 1925-1943
- Жамсран - 1927-1994
- Дондов - 1929-1985
- Бадарч - 1931-1999
- Жамсран - 1930-1992
- Содном - 1933

- Цагаан - 1936

Миний охин дүү Цагаан бид хоёр одоо амьд байна. Бидний эмээ ээж маань 92 настайдаа 1971 онд бурхан болсон билээ. Намайг бага байхад бурхан болсон Чойжамц аавынхаа гарал үүсэл, амьдралын замналыг нь цагийн эрх, нөхцөл байдлаас болоод тодорхой мэдэж чадаагүйдээ харамсаж явдаг юм. Түүний эгч нь Рэгзэдмаа, дүү нар нь Дамбийням, Зундуй, Дуламсүрэн, Дамдинжав, Чимэд гэдэг хүмүүс байв. Миний ах Бадарчийн бичиж үлдээсэн дурсамжаас үзвэл бидний аав Дорноговь аймгийн Сайхандулаан сумын хүн юм билээ. Түүний эхийг Цэрэн гэдэг байж. Цэрэнгийн ах Наваан лам хүн байсан бөгөөд Баянмөнхийн хийдэд суухаар ирэхдээ Цэрэнгийн охин Рэгзэдмаа, хүү Чойжамц нарыг Сайхандулаанаас авч иржээ. Удалгүй Цэрэн нь тэднийхээ хойноос ирж, тэндээ суурьшаад Чүлтэм гэдэг хүнтэй гэр бүл болсон аж. Бидний өвөг эцэг Дэндээцэвээн лам хүн байсан юм гэнэ билээ гэж миний ах Бадарч өөрийн дурсамждаа бичсэн байдаг юм.

Миний аав Баянмөнх суманд олонд нэртэй, аливаад авхаалжтай, сэргэлэн хүн байсан гэдэг юм. Манай нутгийн хамгийн сүрлэг сайхан уулын нэрээр түүнийг “Аргал уулын Алтан Чой” гэж олон түмэн дууддаг байж. Монголын төрийн нэртэй зүтгэлтэн Сономын Лувсан гуай манай аймгийн Дэлгэрэх сумын хүн билээ. С.Лувсан гуай миний аавтай танил байж. “Хааяа бид нар даалуу тоглодог байсан. Наймаа хийж панз үсэргэдэг сэргэлэн сайхан хүн байсан юм шүү” гэж тэр миний аавын тухай дурсан ярьдаг байж билээ. Монголын дотоод гадаад нөхцөл байдал эдрээтэй байсан 1930-аад оны үед манай төр, засаг улс орныхоо аюулгүй байдлыг хамгаалах үйлсдээ, тухайлбал, гадаад тагнуулын үйл ажиллагаанд хил хязгаарын нутгийн иргэдийн идэвхи чадалтай хэсгээс дайчилан оролцуулдаг байж. Тэр үед Японы милитарист цэрэг Хятадыг эзэлсэн, Өвөрмонголын нутагт байрласан арми нь манай улсын аюулгүй байдалд заналхийлж байсан учир эх орноо хамгаалах хэрэгт Монголын иргэд чадах хирээр зүтгэж байжээ.

Ээж маань “Аав чинь нэг биш удаа олон цөөн хоногоор хаана ямар зорилгоор нь мэдэгдэхгүй явж байгаад ирдэг байсан. Хаана ямар хэргээр явах, яах гэж байгаагаа надад хэлдэггүй байсан боловч хил давж тусгай даалгавар биелүүлэх ажилтай юм гэдгийг нь би гадарладаг байсан. Тэр тухай хэнд ч юу ч ярьж болдоггүй байсан юм” гэж байж билээ. Бодвол миний аав наймаа хийх, мал эрэх, хамаатан садантайгаа уулзах зэрэг шалтаг олж, Өвөр Монголын нутагт очиж, тэндээс мэдээлэл олох, ялангуяа хил орчмын нутагт байх цэргийн холбогдолтой мэдээлэл цуглуулах үүрэг гүйцэтгэдэг байсан байх. Эцэг маань хамгийн сүүлд 1940 оны үед “Түргэн ирэхийг хичээнэ, удаж ирэхэд хүрч болзошгүй.

Хүүхдүүдээ халамжлаарай!” гэж захиж хэлээд явжээ. Тэгээд эргэж ирээгүй гэдэг юм.

1945 онд дайн дууссаны дараа урд зүгээс маш олон цэрэг буцаж ирж байсныг би мэддэг юм. Тэр үед манай нутгаас сураггүй алга болсон нилээд хэдэн хүн буцаж ирж байлаа. Үүнээс хойш ч буцаад ирж л байлаа. Би аавыгаа багадаа Жоожоо гэж дууддаг байсан юм. Ээж бид хоёр Жоожоо маань буцаад ирэх байх гэж их горьдож байлаа. Ээж бид хоёрын горьдлого 1960-аад оны үед тасарсан гэж болно. Аавын дүү Зундуй гэдэг хүн байлаа. Зундуй ах мөн дөчөөд оны эхэн үед алга болоод 1945 онд буцаад ирж байсныг би сайн мэдэх юм. Зундуй ах 1960-аад оны үед миний төрсөн ах Бадарчид нэг түүх ярьсан байдаг юм. Чойжамц ах нь хамгийн сүүлд явахынхаа өмнө дүү Зундуйтайгаа хөдөө уулзаад “Дахин хил давж явах үүрэг авлаа. Чи миний оронд явж нэг үүрэг гүйцэтгээд ирэхгүй юү. Орондоо итгэлтэй хүн явуулахыг зөвшөөрч байгаа юм” гэж ярьж байжээ. Тэгэхэд Зундуй ах түүний оронд явж чадсангүй. Харин сүүлд тэр бас дайчлагдаад хил давж ажилласан юм билээ. Ингэж явахдаа баригдаж хэцүү эрүү шүүлтэд орж, зовж зүдэрсэн бөгөөд нас гайгүй боловч миний мэдэхээр бие сайнгүй, нэг ч шүдгүй болсон хүн байж билээ. 1959 онд Зундуй ах надад “Аав чинь Өвөр Монголын нутагт очиж, мэдээ олж ирэх даалгавартай яваад баригдаж, шоронд хоригдож, олон хэцүү эрүү шүүлтийг давж чадсан юм. Тэгээд тэр нутагт Япон цэргүүдийн дарга нарын уналгын агт морьдыг хариулах үүрэг гүйцэтгэдэг болоод байж. Ийм үүрэг гүйцэтгэж байхдаа хоёр нөхрийн хамт оргож нутгийн зүг зугтсан байна. Олон хоног явж ядарсан тэд нар Монголынхоо хилийн ойролцоо ирээд амарч байгаад дэрсэн дотор унтчихсан юм байж. Энэ үед нь тэднийг тэр нутгийн хүн харж, мэдээ өгснөөр барьж авсан байна. Баригдсан газарт эрүү шүүлт болоход аав чинь бүх бурууг өөртөө авч буудуудсан байна. Энэ бүхнийг би хил давж явахдаа мэдсэн боловч ярьж болохгүй гэсэн тангарагтай байсан тул чамд болон бусад хүнд хэлдэггүй байсан юм. Одоо ч гэсэн тийм. Гэхдээ чи мэдэж авах ёстой. Юмны нарийн учрыг ойлгох насны хүн болсон учир чамд хэлж байна. Мэдэж ав. Гэхдээ цааш яриад байх хэрэггүй биз” гэж ярьсан юм.

Зундуй ахын ярьсныг бодсоор яваад 1980-аад оны үед би Нийгмийг аюулаас хамгаалах яаманд (хуучин нэрээр Дотоод яам –ред.)хандаж аав Чойжамцынхаа холбогдолтой баримт бичиг байдаг эсэхийг шалгаж өгөхийг хүссэн юм. Тэндээс “Манай архивт танай аавын тухай материал байхгүй” гэсэн хариу ирсэн юм. Гэтэл сүүлийн үед манай зарим сонин манай аавын тухай сонирхолтой материал хэвлэдэг болов. Тухайлбал:

1. “81-р суваг” сонины 1998 оны 35, 36 дугаарт “Эх орончийн цагид” нэртэй буланд Дорноговь аймагт байгаа бэлтгэл комиссар Батын Санжаа

нэрээр бичсэн нийтлэлд: “Эх орныхоо тусгаар тогтнолын төлөө хилийн шугамын цаана хэдэн арван эрчүүд харь оронд тагнуулын үүрэг гүйцэтгэж ирсэн. Тэдний заримаас дурьдахад хуучин төрийн үед Сайд нарын Зөвлөлийн дарга асан Думаагийн Содномын эцэг ”Аргалын уулын Алтан Чой” буюу Чойжамц гэж хүн байгаад эх орныхоо даалгавраар гадаадад ажиллаж Япон цэргүүдтэй буудалцсаар эх орныхоо хил дээр ирэнгүүт, Монголынхоо тэнгэрийг харлаа одоо боллоо хэмээн хэдэнтээ хэлээд шархадсан өөрийгөө буудаж үхсэн түүхтэй” гэжээ.

2. Мөн сонины 1999 оны № 07,08 дугаарт Дорноговь аймгийн Хатан булаг сумын Мааньтын Цэрэндорж гэдэг хүний хураангуйлан хураангуйлж, сийрүүлсэн нийтлэлд: “Эх орончийн хатан зүрх зогсохгүй. Монголын алдарт буурлууд, тагнуулууд эх орны төлөө үнэнчээр зүтгэж явсан. Би сониноор дамжуулж, хойт үеийн үр хүүхэддээ нэгийг үлдэг, бодог гэж “Аргалын уулын Алтан Чой”-гийн тухай бичсэн. Чойжамц хэмээх хүн говь нутагтаа хэний ч сэтгэл татам сайхан эр. Уул нутаг нь Дундговь аймгийн Гурван сайхан сумын хүн. Дорноговь аймгийн Баянмөнх сумын Думаатай сууж өөр шигээ бие бялдартай, хүнлэг сайхан сэтгэлтэй хэдэн хүүтэй болсон. Тухайн үедээ эх орны даалгавар биелүүлж яваад баригдаад, бяр тэнхээ зааж шоронгоос оргон зугатаж яваад Монголынхоо торгон хил дээр ирээд баригджээ. Тэр баригдахдаа “Монгол нутгийнхаа хөх тэнгэрийг харлаа, одоо боллоо. Би Японы самурай нарын гарт үхэхгүй!” гэж хэлээд зүрхэндээ хутгалж насан эцэс болсон цогтой эх оронч билээ. Хүү нь аав шигээ биерхүү хүн бөгөөд сүүлд Монгол улсын Сайд нарын Зөвлөлийн дарга болсон Содном билээ!” гэж бичсэн байв.

3. “Маш нууц” сонины 1999 оны № 39, 40 дугаарт Р.Мөнхтөр гэдэг хүн миний эцэг Чойжамцыг яах аргагүй Монгол эх орныхоо өмнө гавъяа байгуулсан буурлуудын нэг мөн гээд насан өөд болсон тухай нь дээрх сонингуудад гарч байсан материалтай ижил утгатай зүйлүүдийг бичээд намайг эцгийнхээ нэрээр овоглоогүйн учрыг асуусан байдаг юм.

Энэ сонингуудад гарч байсан материалуудаас харахад миний аав эх орныхоо төлөө тэмцэж явсан шударга иргэн байсан, эх орныхоо төлөө амиа өгсөн эцгээрээ бид бахархаж, ярьж бичиж байх ёстой гэсэн итгэл үнэмшлийг төрүүлсэн юм. Ээж маань хүүхдүүдээ өөрийн нэрээр “Думаагийн” гэж овоглож байсан нь тухай үедээ яах аргагүй зөв шийдэл байсан байх.

2000 онд Монгол улсын иргэний паспортыг солиход би өөрийгөө Алтан Чой овогт Думаагийн Содном гэж бүртгүүлээд, аавынхаа нэр, цолоор овоглох болсон юм даа.

Би Монголын Батлан хамгаалах яам, Тагнуулын төв газар болон

Хязгаарын цэргийн газрын архиваас аавынхаа тухай материалыг олоогүй юм. Бас тухайн үед Монголд байрлаж байсан Оросын цэргийн ангийн архиваас ч ийм материал олоогүй. Ингэж миний эрэл мухардалд орсон билээ. Бид улсынхаа архивыг бүрдүүлэх, бүрэн хадгалах, хамгаалахад зохих ёсоор анхаардаг байвал төр нь иргэнээ мартахгүй, иргэд нь эцэг эх, ах, дүү, садан төрлөө алдахгүй мэдэж байх нөхцөлийг бүрдүүлж байх юм байна.

2 Би Санхүүгийн техникумд оров.

КЮ: Та хэдэн онд бага сургуульд орсон юм бэ?

Д С: Миний бага, залуу нас жинхэнэ сайхан Монгол хүмүүсийн дунд өнгөрсөн юм. Миний ах нараас Дондов, Бадарч, бага Жамсран ахыг айлд өргүүлсэн учир гэртээ том Жамсран ах, Цагаан бид гурав үлдсэн юм. Би ээжийгээ Умаа гэж дууддаг байлаа. Бид нар хоорондоо гайхалтай эвтэй, бие биендээ халамж анхааралтай амьдарцгааж байлаа.

Би 1942 онд бага сургуульд орсон юм. Намайг бага сургуульд сурах болсноор манай гэр Баянмөнх сумын төвд нүүж ирэв. Том Жамсран ах Улаанбаатар хотод Цэргийн сургуульд суралцахаар явж, гэртээ миний охин дүү Цагаан бид хоёр Умаатайгаа үлдэж байлаа. Тэр үед Зөвлөлт-Германы дайн явагдаж байсан үе шүү дээ. Тэр үед Зөвлөлтийн улаан армид туслах хөдөлгөөн өрнөж, манай нутгийн ардууд адуун сүргээсээ хамгийн сайныг нь сонгож зөвлөлтийн армид бэлэглэж байсныг би мэдэх юм. Монголчууд бүгдээрээ дулаан хувцас, үнэт эдлэлүүд, мөнгө төгрөг, хоол хүнс гээд байгаа бүхнээ Зөвлөлтийн армид бэлэг болгон өгч байлаа. Монголын ард түмний бэлэглэсэн хөрөнгөөр санхүүжүүлж, танкийн болон нисэх онгоцны тусгай анги, бүлэглэлийг зохион байгуулж, манай нам, төрийн удирдагчид, хөдөлмөрчдийн төлөөлөгчид фронтод хүргэн өгөх ажлыг зохион байгуулж байсан билээ. Баянмөнх сумын төвийн ойролцоо хэдэн орос цэрэг зээр агнаад, түүнийгээ машинд ачуулж байсныг би санадаг юм. Бодвол фронтод явуулж байсан байх. Би тэр орос цэргүүд дээр хааяа очдог байлаа. Тэд нар бидэнд зээрийн махаар хийсэн котлет өгдөг байсан юм. Сонгино, сармис хийсэн болохоор бидний өдөр бүр гэртээ иддэг хоолноос өөр сонин гоё амттай байсан биз. Бид нар хүүхдүүд тэд нар дээр дахин дахин очиж котлет иддэг байв. Амьдралдаа анх удаа орос хүний нүүр харж, орос хүний хийсэн хоол идэж байсан маань тэр юм.

Манай Бяхар ах 1943 онд уушигний хатгаа авч нас барсан юм. Тэр үед шинжлэх ухааны эмнэлэг манай нутагт сул байсан болохоор эмчилж чадаагүй юм. Миний ээж биднийг сургуульд сургахыг чармайсаар байлаа.

Тэр үед ээж маань сургуульд галчийн ажил хийж амьдрал залгуулж байлаа. Бидний хэнд нь ч малаа хариул, сургуулиа хойшлуул гэж хэлээгүй юм. Бидний хамгийн том ах Бяхарыг 18 настай байхдаа нас барахад ээж маш их гашуудаж, заримдаа ухаан нь орж, гарч байсныг би одоо тод санадаг юм. Бид нар ээждээ санаа зовж, өрөвдөж, зовлонг нь нимгэлэх аргаа олж ядаж байсан даа. Тэр ах маань амьд байсан бол одоо ная дөхсөн өвгөн байх байж.

Сургуулийн зуны амралтаар би Дэндэв ахынд очиж мал хариулдаг байлаа. Тэднийд миний аавын үлдээсэн хэдэн адуу байсан юм. Эмээ ээж Цэвэг маань бас тэднийд байсан болохоор бид тэднийд очих нь зүйн хэрэг юм л даа. Би тэмээ гэдэг амьтныг багадаа хариулдаг байсан болохоор энэгшин хайрладаг болсон юм. Өглөө эрт тэмээн сүргээ бэлчээрт гаргаад, өдөржин дэргэд нь байж, үд хирд гэртээ ирж цай уугаад, буцаж орой нар жаргах үед хотлуулдаг байлаа. Бие жижиг байсан болохоор хээр мориноосоо буучихвал буцаж мордох гэж бөөн ажил болдог байлаа. Тэгээд том чулуу эсвэл өндөр эрэг хайж явж олоод түүн дээрээ гарч байж дөрөөгөө дөрөөлж мориндоо морддог байж билээ. Тэр үеийнхэний малаа байнга дагаж хариулдаг байсан уламжлал одоо байхгүй болсон шиг байна. Түүнийг сэргээх нь их чухал юм шүү. Монгол улс тэмээгээ өсгөж хамгаалж чадвал Монголынхоо төдийгүй, хүн төрлөхтний түүхэнд үнэлэгдэх буянтай үйлстэн болж болно гэж хэлмээр байна. Дэлхийд хоёр бөхтэй ба ганц бөхтэй гэсэн төрлийн тэмээ байдаг ба хоёр бөхтэй тэмээ нь Монгол, Хятад, Казахстан улсад л байна. Өөр газар байхгүй, устаж үгүй болжээ.

Намар болж сургуулийн зуны амралт дусахад эцэг эхчүүд түлш, аргал ачсан тэмээн цуваан дээр хүүхдүүдээ суулгаад сумын төвд хүргэж ирдэг байж билээ. Говийн аймаг, сумын төвд амьдарч байгаа хүмүүс аргалаа нөөцөлдөг учир өвөл гал алдах аюул байдаггүй нь гайхалтай шүү. Дэлхийн дайн болж хаа нэгтэй хол газар гамшиг нүүрлэж байсан ч манай Баянмөнх сумынхан урлаг уран сайхантай байсан юм шүү. Аймгийн клубын (хожим аймгийн соёлын ордон гэж нэрлэх болсон – ред.) уран сайханч Юндэн гэдэг хүн манай суманд ирж байсныг би сайн санаж байна. Тэр ирэхээрээ кино гаргаж үзүүлдэг байлаа. Тэр үеийн кино дуугүй байсан болохоор Юндэн гуай гарч байгаа киноны үйл явдлыг өндөр дуугаар уран сайхнаар тайлбарладаг байв. Юндэн гуай ер нь маш олон юм чаддаг хүн байлаа. Тэр олон янзын хөгжим тоглохын зэрэгцээ, дуу дуулна, шүлэг уншиж, ерөөл, магтаал хэлдэг байв. Одоогийнхоор бол нэг хүний сайн театр байсан юм. Түүнийг дагаад сумын төвийнхөн хүүхэд, томцуул бүгд инээж, хөгждөг байв. Баянмөнх суманд аятайхан улаан тоосгон байшинд “Улаан булан” байрладаг байв. Тэр улаан тоосгон байшин модон шалгүй,

таазных нь оронд эрэн даавуу татсан байж билээ. Сумын сайн дурын уран сайханчид заримдаа жүжиг тоглодог байлаа. Сумын төв дээр мандолин тоглодог хүн цөөнгүй байсан юм. Тэд нар нийлээд жижигхэн концерт тоглоно.

Миний багш Гүнсэнноров сайн зохион байгуулагч, сайн сурган хүмүүжүүлэгч бөгөөд хүмүүсийг хөгжөөж, эргэн тойрондоо сайхан уур амьсгалыг бий болгож чаддаг ухаалаг чадвартай хүн байв. Нэг удаа манай сумын “Улаан булан”-д Монголын дуурийн урлагийн оргил болсон “Учиртай гурван толгой” дуурийг хэрхэн тоглосон тухай жаахан хэтрүүлэгтэй ярьж хүмүүсийг хөгжөөж байсныг нь би тодхон санадаг юм. “ Учиртай гурван толгой дуурийг тоглоно гэсэн зарлал хөдөө нутагт тарж, хүмүүс сумын Улаан буланд цугларчээ. Гэтэл тайзны хөшиг нээгдэхгүй удсан юм байх. Хүмүүс хүлээж ядаад

-Та нар тоглолтоо хурдалж үз! Үнээ саах болчихлоо! Тугал бяруу эхтэйгээ нийлэх гээд байна!” гэж шаарджээ. Гэтэл тайзны хөшигний завсраар Улаан булангийн эрхэлгч толгойгоо цухуйлгаж байгаад

-Манай хөгжимчид ирж амжихаа байжээ. Мандолин хөгжимтэй дууриа тоглох боллоо! гэжээ. Үзэгчид дургүй байсан боловч өөр хөгжим байхгүй тул мандолинтай дуурийг үзэхээр зөвшөөрчээ. Ингээд дуурь эхлээд амжилттай явж, үзэгчид идэвхтэй оролцож байжээ. Юндэнг аянаас буцаж ирэхийг Балганы даалгавраар хүлээж байгаа хоёр аймхай эр дуулах аяа дуулж дуусгаад, Юндэнг цохиж унагах үзэгдэлд орох болсон байна. Гэтэл жүжигчид байраа буруу эзэлсэн буюу тайзны нэг талд Юндэн, нөгөө талд тэр хоёр аймхай зэрэгцээд зогссон учир Юндэнгийн оронд нөгөө нөхрийнхөө толгой руу говийн хүүхдүүд хонь хурганд явахдаа барьдаг модон шилбүүрээр цохиж гэнэ. Гэтэл үзэгчдийн дундаас нэг өвгөн :

-Ээ халаг минь. Буруу хүнээ цохичихлоо шүү дээ, чи. За одоо яая гэхэв, ойч ойч! гэж чанга хэлжээ. Тэгээд тайзны нөгөө талд зогсож байсан Юндэн эргэлдэж, эргэлдэж унажээ. Тэр хүчтэй унасан тул бөөн тоос манараад явчихжээ. Дуурийн тоглолт амжилттай болж, хүмүүс инээдэм наадам болсоор тарж явжээ!” гэж. Ийм түүхийг манай багш өөрөө тэр дуурьт тоглож байгаа юм шиг шогтойгоор ярьж хүмүүсийг хөгжөөж байсныг би сайн санадаг юм.

Санаа сэтгэлээр гайхамшигтай нийлж, амьдарч чаддаг жинхэнэ хүнлэг сайхан хүмүүсийн дунд маш тайван, амгалан амьдралын орчин нөхцөлд миний бага нас өнгөрсөн юм. Тэр үед би лимбэ үлээж сурсан, бас дуу дуулдаг байлаа. Мэддэг бүх дуугаа лимбэдээд тоглочихдог байж билээ. 1945 оны намар аргал ачсан тэмээн дээр суугаад, сумын төв очиж сургуульдаа орохоор явж байхдаа лимбээ үлээж байгаад үдэш болоход тэмээн дээрээ унтаад, лимбээ унагаж, гээчихсэн юм. Түүнээс хойш

лимбэтэй болж чадалгүй явсаар олон жилийн дараа нэг удаа лимбэ бариад үлээж үзсэн чинь дуу оруулах байтугай, лимбэнээс дуу гаргаж чадахгүй болсон байж билээ. Би лимбээ гээчихээгүй, эсвэл өөр лимбэтэй болж чадсан бол түүнийг тоглох сонирхол их байсан болохоор сайн лимбэчин болох байсан ч юм билүү, бүү мэд. Тэр үед лимбэнээсээ ердөө салдаггүй байж билээ. Би бас сайн зураг зурдаг байлаа. Хүүхэд хөгжим тоглох, зураг зурах, дуу дуулах авьяастай, түүндээ сонирхолтой, өөрөө оролдож байгааг эцэг эх нь ажиглавал тэр авьяасыг нь хөгжүүлэхэд их анхаарах хэрэгтэй юм билээ. Орчин үед нөхцөл боломж илүү сайн учир “хүүхдийн авьяасыг хөгжүүлэх, дэмжихэд юуг ч битгий хайрла!” гэж хүмүүст хэлмээр юм билээ.

Би өөрийн охин Надя, хүү Толя хоёрыгоо хөгжим тоглуулж сургах санаатай төгөлдөр хуур болон аккордион хөгжим авч, багш хөлсөлж үзсэн боловч тэр хоёр маань сонирхолгүй, сонсгол сайнгүй байсан учир аяндаа орхисон юм. Миний ач охин Наташа /Надягийн охин/ хөгжим тоглох, дуулах авьяасаар хомс боловч хөгжмийг сайн ойлгодог юм. Харин ач охин Дарь-Эрдэнэ /Толягийн охин/ маань сонсгол сайтай, хөгжим тоглож сурах дур сонирхолтой, авьяастай учир 2000 оноос багш авч, төгөлдөр хуур хөгжим сургаж байна. Сайн сурах сонирхол, бас авьяас байгааг нь харж, сайхан ая тоглохыг нь сонсоод эхнэр Вера бид хоёр баярлаж суудаг юм. Манай ураг төрөлд хөгжим тоглож, зураг зурж чаддаг буюу урлагийн хүмүүс байх ёстой. Хөгжим тоглож, дуу дуулж, зураг зурж явдаг хүмүүс хүнлэг, бусдад сайнаар нөлөөлж чадах талаараа илүү байх шиг санагддаг юм. Ямар боловч тийм хүмүүс гоо сайхны таашаал сайтай байдаг юм.

КЮ: Та цаашид урлагийн чиглэлээр сургуульд суралцах хүсэлтэй байсан юм уу?

Д С: Тийм гэж хэлж болох байх. Би Дорноговь аймгийн Баянмөнх сумын бага сургуулийг 1946 онд төгслөө. Миний ах “том” Жамсран ах намайг урлагийн сургуульд оруулахаар Улаанбаатар хот руу аваад явлаа. Хот явахын өмнө нэг ийм хөгтэй явдал болсон юм. Манай нутгийн Балдандорж гэдэг хүү бид хоёр бага сургуулиа хамт төгсөөд, аймгийн төвд ирсэн юм. Би Улаанбаатар явж сургуульд орох, Балдандорж аймагтаа үлдэх хүсэлтэй байв. Гэтэл аймгийн дарга Цагаан, бид хоёрыг, хоёр ээжийн хамт өөрийнхөө өрөөнд дуудаж оруулаад, намайг аймгийн сургуульд үлд, Балдандоржийг Улаанбаатар явж сургуульд ор гэж хэллээ. Ингээд бид хоёр уйлаад, манай ээж нар гуйгаад сууцгааж байтал азаар тэр өрөөнд нэг хүн орж ирэв. Тэр хүн биднийг хараад: -Энэ хүүхдүүд юу болоод уйлж байна? гэж асуулаа.

Аймгийн дарга түүнд учир явдлыг тайлбарлаж байна. Тэгтэл нөгөө том биетэй хүн:

-Энэ хүүхдүүдийг өөрсдийнх нь саналаар хуваарил! гэж хэлээд гараад явчихлаа. Ингэж миний Улаанбаатар явж суралцах асуудал шийдэгдэж байлаа. Тэр өрөөнд биднийг уйлцгаагаад байж байхад орж ирсэн том биетэй хүн бол Дорноговь аймгийн МАХН-ын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Чойжамц гэдэг хүн байж. Сүүлд 1970-аад оны үед Чойжамц гуай МАХН-ын Төв Хорооны Хянан Шалгах Хороонд ажиллаж байхад нь би энэ түүхийг түүнд ярьвал огт санахгүй байж билээ. Бидэндээ бол амьдрал шийдсэн том асуудал байж л дээ. Би түүнд талархал илэрхийлэхэд Чойжамц гуай “хэн нэгэн хүн чамд тус болсон бол түүнийг их, бага гэлгүй мартаггүй явах эр хүний сайн чанар юм шүү!” гэж хэлж байсан билээ. Намайг сурлагаараа арай илүү гэж аймгийн дарга аймгийнхаа сургуульд үлдээхээр зүтгэж байсан юм байж. Миний багын анд Балдандорж маань Дорноговь аймагтаа үлдэж, сүүлд далаад оны үед “аймгийн аврага малчин” цол хүртэж мандаж явсан билээ. Бид хоёр уулзах бүрийдээ багынхаа амьдралыг ярих дуртай байж билээ. Тэр маань 90-ээд оны эхээр бурхан болсон билээ. Балдандоржийн эхнэр Галя олон сайхан охидуудтайгаа Өргөн сумандаа амьдарч байгаа. Ямаа голдуу олон малтай хангалуун амьдардаг, ажилсаг сайхан хүмүүс байдаг юм.

1946 оны намар би ачааны машинд олон хүнтэй хамт сууж, зам зуураа “Жанжин Чойр” гэдэг газар замын буудалд нэг хоноод Улаанбаатарт ирж байлаа. Сайн машин, сайн жолооч таарч замдаа сааталгүй, хурдан явж ирсэн юм. Бид нар одоогийн “Баян зүрх” товчооны орчим байсан модон гүүрийг (Туул голын гүүр –ред.) гараад бүгд машинаас бууж, шороо тоосонд дарагдсан нүүр гараа угаацгааж билээ. Говийн хүн анх удаа урсгал усыг хараад “Хайран ус! Урсаад дуусчихдаггүй юм байхдаа?” гэж гайхаж байлаа. Улаанбаатар хотод ирээд Жамсран ах минь намайг урлагийн сургуульд оруулна гээд бид хоёр хотоор явлаа. Тэгээд бид хоёр тийм сургууль олж чадаагүй байж байтал миний нагац ах Маам :

-Миний сурсан сургууль ойрхон байна. Чи тэнд сур! гээд намайг Санхүү эдийн засгийн техникумд оруулчихлаа.

Намайг тоо бодлого, хэл бичгийн шалгалтаа өгсний дараа техникумын багш Цэрэн намайг нэг өдөр дуудаж уулзаад

-Чи жаахан хүүхэд байна. Нэг насаар өсч ядаж 17 нас хүрч байж ажил хийж эхэлбэл зүйтэй учир бэлтгэл ангид сур! гэж хэлэв. Ингээд Бэлтгэл ангид сурч нэг нас нэмэгдэхийг хүлээх тэр жил би тоо бодлого, хэл бичгийн хичээлийг давтахын зэрэгцээ гол хийдэг ажил маань ээждээ захидал бичих ажил болсон юм. Санхүүгийн техникумын захирал Зул, багш Цэрэн, Түмэн, Тагар, Дашаа, Дулмаа, Дэжидмаа нарын олон сайн

багш нар хожим “Монгол улсын гавъяат багш” болцгоосон билээ. Манай Зул багш хожим Барилгын яамны орлогч сайдаар олон жил ажиллаж байв. Манай сургуулийг төгсөгчдөөс алдар гавъяатай олон хүн гарсан билээ.

Зөвхөн миний сурч байх үед суралцаж байсан Б.Явуухулан, Ц.Гайтав хоёр Монголд төдийгүй, алдар нэртэй яруу найрагчид, уран зохиолын их мастерууд болсон билээ. Тавь жараад оны үед Ц.Гайтавыг МАХН улс төрийн чиглэлийн уран зохиолд их дайчилж байлаа. Хэрэв Ц.Гайтав маань одоо үе шиг чөлөөт уран бүтээлч байсан бол олон сайхан бүтээл бичиж туурвих байсан байх.

Б.Явуухулангийн зохиолуудад орчин үед ая зохион шимтэн дуулж, шүлэг, найраглалуудыг нь их уншиж байна. Монголчууд түүнийг “Дорнын их яруу найрагч” гэж өргөмжилдөг юм. Би тэр аугаа их хүнтэй хамт сурч, нэг үед амьдарч явсан боловч тэр үедээ анхаарч ухаараагүйдээ хожим харамсах сэтгэл төрдөг юм. 1981 оны 12-р сарын 17-ны өдөр Монголын зохиолчдын хорооны дарга С.Удвал гуай намайг зохиолчидтой уулзах уулзалтанд урьж, “Монголын нийгэм, эдийн засгийн асуудлаар ярилцъя!” гэсэн санал тавьсан юм. Тэр үед би Улсын төлөвлөгөөний комиссын даргаар ажиллаж байсан болохоор мэдээлэл ихтэй байж. Би аль болохоор дэлгэрэнгүй мэдээлэл өгч, хэтийн бодлогоор төлөвлөж байгаа зүйлээ илэн далангүй ярьж билээ. Тэр уулзалтын төгсгөлд “Монголын шилдэг яруу найраг” номын эхний хуудсан дээр нь 22 зохиолч гарын үсгээ зураад надад дурсгасныг би өдгөө нандин зүйл болгон хадгалж байдаг юм. Тэр өдөр Б.Явуухулантай уулзсан эцсийн өдөр бөгөөд түүнээс авсан ганц гарын үсэг нь тэр номон дээр байдаг юм.

Санхүүгийн техникумд надаас нэг ангийн хожуу сурч байсан Мясүрэн, Цэвэлсүрэн нар урлагийн байгууллагад насаараа ажиллаж алдар цуутай хөгжмийн зохиолч, жүжигчид болцгоосон билээ.

1946 онд би анх удаа Улаанбаатар хотод ирж байхдаа 13 настай байж. Маам ахынд анх удаа төмстэй хоол идсэнээ мартдаггүй юм. Газар амтагдсан хачин муухай юм байж билээ.

3 Би Эрхүү хотод сурахаар явлаа.

Ичинхорлоогийн Лхагвасүрэн (цаашид **ИЛ**): Та хэдэн онд Санхүүгийн техникумыг төгссөн бэ?

Д С: 1950 онд би “Төсөвт байгууллагын нягтлан бодогч” гэсэн мэргэжлээр Санхүүгийн техникумыг төгслөө. Санхүүгийн техникумд орсон жилээсээ эхлээд төгсөх хүртлээ 4 жил сургуулийнхаа дотуур байранд амьдарлаа. Амьдрах ухаан, хүмүүсийн дунд биеэ авч явах ухаанд сурах

амьдралын анхны их сургууль маань санхүүгийн техникум, түүний дотуур байрны амьдрал болсон юм. Намайг бага сургуульд орсон 1942 оноос манай аймгийн сургуулиудад шинэ кирилл үсэг зааж эхэлсэн юм билээ. Тийм учир би монгол бичиг заалгаагүй бөгөөд өөрөө оролдож жаахан уншдаг болсон, сайн бичиж, уншиж чаддаггүйдээ санаа их зовдог билээ. Би техникумынхаа бэлтгэл ангид суралцаад 1947 оны зун Баянмөнх сумандаа очиж амраад намар нь Умаа, Цагаан хоёртойгоо Улаанбаатарт ирж техникумдаа ээжийгээ санах зовлонгүй суралцах болоод 1950 онд төгссөн юм.

Тэр намар Умаа Улаанбаатарт ирэхдээ Баянмөнх сумын төвд байсан бор гэрээ орхиод ирсэн юм. Буцаж очихоор бодож байсан боловч чадаагүй юм билээ. Тэр гэр минь ингэж үрэгдэж алга болсон юм. Тэр гэрт үлдсэн миний пянз тоглуулагч, түүний арын нүхэнд дөрвөлжин шугамтай зузаан дэвтэр дотор аавын минь ганц фото зураг байсан нь алга болж, олдохгүй болсонд одоо би их харамсаж явдаг юм.

Нар шаргалтаж ээсэн нэ сайхан орой баруун урд зүгээс их холоос морьтой хүн давхин ирж явахыг хараад Умаа минь “Аав нь ирж явна шүү!” гэж хэлж билээ. Бид нар аавыгаа баяртай угтаж байж билээ. Тэгж ирэхдээ аав тэр зураг, болон пянз тоглуулагчийг авчирж өгснийг би мартдаггүй юм. Аавын минь дугуй хээтэй торгон дээлтэй, ташаагаа тулж тухлан суусан тэр сайхан зураг олддогсон бол хамгийн үнэт нандин зүйл байхсан билээ. Гурав, дөрвөн Монголын хуучин дууны пянзтай тэр пянз тоглуулагч сэргээгдэхгүйгээр алга болсон нь ойлгомжтой. Ингэж аавыг минь дурсгах биет жаахан зүйл алга болсон билээ. Барагцаагаар 8x12 /см/ хэмжээтэй аавын минь тэр фото зураг Баянмөнх сумын аль нэг айлын зургийн жаазны ар, авдар савны ёроолд тохиолдлоор хадгалагдаад үлдчихсэн байдаг болов уу? Гэж заримдаа горьддог юм.

Санхүүгийн техникумыг төгсөөд би Сангийн яаманд ажиллахаар хуваарьлагдсан юм. Тэр үед зураг зурдаг маань их хэрэг болов. Сургууль төгсөгчдөд зориулсан хүлээн авалтад Сангийн яамны сайд Дэмчигийн Моломжамц, яамны боловсон хүчний дарга Дангаа нар ирлээ. Дангаа гуай тэр хүлээн авалт дээр намайг дуудаж сайд Д.Моломжамцад танилцуулаад :

-Энэ хүүхэд зураг сайн зурдаг юм. Бид яамандаа авахаар шийдсэн. Манай яамны ханын сонинг гаргаж байг! гэж хэлж байв. Би ингэж аз түшиж Сангийн яаманд ажилд орж байв. Ер нь зураг зурах, дуу дуулах, хөгжим тоглох гэж оролдож байсан минь миний амьдралд аз жаргал авчирж байв. Би Монгол улсын Сангийн яамны алтан босгыг алхан орж байснаас хойш хагас зуун жил өнгөрчээ. Тэнд би хамгийн анх Хянан байцаах газарт байцаагчийн ажил хийж эхэлсэн юм. Мишиг гэдэг хүнийг дагаж

Улаанбаатар хотын оёдлын үйлдвэрт баримтын шалгалт хийхэд оролцлоо. Санхүүгийн хяналт шалгалтын ажилд хамгийн анх удаа оролцсон минь тэр юм. Энэ ажил надад сонин биш, уйтгартай санагдаж билээ. Энд би дөрвөн жил ажилласан юм.

Энэ хооронд ЗХУ-д явж суралцах хүсэл өдрийн бодол, шөнийн зүүд болж байлаа. Арван жилийн 2-р сургуулийн оройн ангид 3 жил суралцаж 1953 онд төгсөөд 10 жилийн боловсролтой болж байлаа. Долоо хоногийн 6 өдөр нь өглөө 9 цагаас оройн 5 цаг хүртэл Сангийн яамандаа ажлаа хийгээд, 6 цагаас оройн 12 цаг хүртэл оройн 10 жилийн сургуульд суралцаж байв. Оройн 10 жилийн сургууль төгссөн тэр жилээ ЗХУ-д суралцах элсэлтийн шалгалтанд орохыг хүссэн боловч сайд Д.Моломжамц гуайд орос хэлний шалгалт өгөөд уначихлаа. Түүнээс хойш нэг жилийн дараа 1954 оны намар Эрхүү хотын Санхүү, эдийн засгийн дээд сургуульд суралцах хуваарь аваад хэсэг нөхдийн хамт Эрхүү хотыг зорин галт тэргээр гарч байлаа. Би ЗХУ-д суралцах элсэлтийн шалгалтаа өгч дуусаад Зүүнбаянд нисэх онгоцоор очиж Умаагаа аваад Улаанбаатарт буцаж ирж байлаа. Умаа бид хоёр анх удаагаа нисэх онгоцонд сууж байгаа минь энэ билээ. Би Эрхүү явах болсон учир Умаа маань Дорноговь аймгийн Зүүнбаянд нефтийн үйлдвэрт ажиллаж байсан том ах Жамсран ахтай хамт байхаар тэнд очсон байсан юм. Ингээд би Эрхүү хот явлаа. Суудлын галт тэрэгний бүтэн цуваанд хэдэн зуун залуучуудтай хөөрч дуулж бужигнаж явсаар хоёр хоногийн аялал дуусч Эрхүү хотод ирлээ.

Эрхүү хотын Санхүү, эдийн засгийн дээд сургууль биднийг хамгийн тохилог дотуур байрандаа суулгаж, сурч амьдрах бүхий л нөхцлөөр хангаж өгсөн билээ. Бид нар хичээлийн гадуур сургуульд зохиогддог олон нийтийн ажилд идэвхтэй оролцдог, орос оюутнуудтай дотно найзалдаг, түүний ачаар богино хугацаанд орос хэлийг сайн сурсан билээ. Би орос дуу дуулах дуртай байв.

Эрхүү мужийн сайн дурын уран сайханчдын фестивалд хоёр удаа оролцож шагналт байранд орж шагнуулсан медаль миний хамгийн гоё нандин зүйл болсон юм. Нэг удаа миний дуулсан монгол, орос хоёр дууг Эрхүүгээс зориуд Монголын радиогоор нэвтрүүлсэн бөгөөд түүнийг Умаа маань сонссоноо надад захиандаа бичиж, надтай уулзсанаас ялгаагүй юм болсон гэж ярьдагсан. Би сургуулийнхаа ханын сонинг гаргадаг, баярын үед сургуулийнхаа барилгыг чимэглэх ажлыг хийдэг байв. Бас волейболын тоглолтуудад бүгдэд нь оролцдог байв.

Эрхүү хотын Санхүү эдийн засгийн дээд сургуулийг олон монгол хүн төгссөн юм. 1934-1938 онд хамгийн анх Ю.Цэдэнбал гуай энэ сургуулийг төгссөн юм билээ. Түүнээс хойш Монгол улсын Сангийн яамны сайдын албан тушаалыг янз бүрийн үед хашиж байсан Д.Моломжамц, Ц.Молом,

С.Бямбажав, Д.Содном нар энэ сургуулийг төгссөн байгаа юм.

4 Монгол улсын Сангийн сайд.

КЮ: Та хэдэн онд Монгол улсын Сангийн яамны сайдаар томилогдсон юм бэ?

Д С: Би сургуулиа төгсөөд 1958 оны 7-р сард Монголд эргэж ирээд Сангийн яамандаа ажилд орсон юм. Сангийн сайд Дүгэрсүрэн гуай намайг байгуулагдаад удаагүй байсан Валютын хэлтсийн даргаар томилчихлоо. Тэр үед Монгол улсын үндэсний валют төгрөгийг өргөн харилцаатай социалист улсуудын үндэсний валюттай харьцуулсан ханш тогтоогүй байснаас улс хоорондын тооцоо хийхэд хүндрэлтэй байлаа. Дэлхийн зах зээлийн үнэ, чөлөөт валютыг улс хоорондын тооцоонд ашигладаггүй, капиталист гэж нэрлэсэн орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцаа бараг байгаагүй, харилцаа бүхий социалист гэж байсан улсуудтай худалдааны тооцоог клирингийн рублээр, худалдааны бус тооцоонд үндэсний валютуудын хооронд харилцан тохиролцож тогтоосон ханшийг хэрэглэдэг, үндэсний валютаар тодорхойлогдсон худалдааны бус тооцооноос гарсан зөрүү үлдэгдлийг тусгай тогтоосон итгэлцүүрээр клирингийн рубльд шилжүүлж улс хоорондын худалдааны тооцоонд оруулдаг байсан юм. Социалист улсууд үндэсний валют хоорондын ханшийг тогтоохдоо сонгож тохиролцсон бараа үйлчилгээний нэр төрөл тоог тухайн хоёр улсын дотоод үнэ тарифаар үндэсний валютаар нь үнэлэн дүгнэж зэрэгцүүлэх аргыг хэрэглэдэг байлаа. Бараа үйлчилгээний нэр төрөл тоо хэмжээ үнэ тарифыг сонгож тохиролцох явцад өөрийнхөө үндэсний валютын ханшийг чангахан тогтоож тохиролцохыг хичээдэг байлаа.

Хамгийн анх удаа 1958 оны намар Румын улстай төгрөг лей хоорондын ханш тохирч тогтоох томилолтоор Бухарест хотод очиж билээ. Румынд очоод гадуур явж үнэ судалж тооцоог маш олон хувилбараар хийж билээ. Шөнө унтаж байснаа нэг мэдэхэд тооцоо хийж нойр хульжсан байдаг байж билээ. Тэгээд босоод л тооцоогоо цаасан дээр хийдэг байлаа. Түүнээс хойш нилээд туршлагатай болж хоёр жилийн дотор социалист бүх оронуудын валюттай төгрөгийн ханшийг тогтоосон нь олон жил бараг хөдөлгөөнгүй хэрэглэгдэж байсан билээ.

Сангийн яам намайг ажилд сургахын зэрэгцээ миний ахуй амьдралыг өөд татсан билээ. Сургуулиа төгсөж ирснээс хойш нэг жилийн дараа надад Улаанбаатар хотын төвд нэгдүгээр дөчин мянгат хороололд хоёр том өрөөтэй байр өгсөн юм. Миний эхнэр Вера бид хоёр 1958 оны долдугаар

сард сургуулийнхаа төгсөлтийн хамгийн сүүлчийн шалгалтыг өгсөн өдөр гэр бүлээ бүртгүүлж, оюутны байрандаа монгол орос хэдэн найз нараа цуглуулаад даруухан хурим хийж, Ангар мөрний эргээр шөнөжин зугаалж, маргааш нь Вера минь Алтайн хязгаарын Славгород хотод байдаг гэртээ очих, би Улаанбаатар хот орохоор хоёр тийш явсан юм. Ингээд түүнээс хойш нэг жилийн дараа Вераг маань Улаанбаатарт ирэхээс өмнө Сангийн яам надад орон сууц өгч байсан билээ. Вера маань Улаанбаатарт ирээд 1959 оноос Улаанбаатар төмөр замын хэрэг эрхлэх газарт төлөвлөлтийн хэлтэст ахлах эдийн засагчаар ажилд орж билээ. Тэндээ 32 жил ажиллаад тэтгэвэрт гарав.

Би Сангийн яаманд Валютын хэлтсийн даргаар 5 жил ажиллад байтал 1963 оны 4-р сард нэг өдөр сайд Дүгэрсүрэн гуай намайг дуудсан байлаа. Би түүний өрөөнд орж ирвэл тэр “Хоёулаа хамт юманд явна!” гэлээ. Гараад Засгийн газрын ордон руу сайд яваад байлаа. Сайд явж байх зуураа:

-За одоо чи бид хоёр МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны хуралд орох байх. Намайг Сайд нарын Зөвлөлд ажилуулна! гэсэн. Миний оронд чамайг Сангийн яамны сайдаар томилохоор ярьж байгаа юм байна! гэв. Би гэнэт ийм томилолтын тухай сонсоод айх, гайхах зэрэгцлээ. Юуны өмнө тэр хариуцлагатай ажлыг хийж чадахгүй байх гэсэн бодол төрөөд тэр тухайгаа сайдад хэллээ. Дүгэрсүрэн гуай:

-Чи бэлтгэгдсэн хүн шүү! Энэ ажлыг хийж чадах ёстой. Эхлээд туршлага дутах байх. Гэвч яамны хамт олон маань сайн. Тэдний дэмжлэгээр ажиллахад богино хугацаанд туршлагатай болно! гэсэн цөөн хэдэн үг хэллээ. МАХН-ын Улс Төрийн Товчооны хурал эхлээд Дүгэрсүрэн гуайг Сайд нарын зөвлөлийн орлогч даргаар томиллоо. Дараа нь намайг Сангийн яамны сайдаар томилох санал танилцууллаа. Ю.Цэдэнбал гуай намайг хараад:

-Энэ нөхрийг чинь би таних юм байна. Асуух асуулт, санал хэлэх хүн байна уу? гэж хэллээ. Ингэж хэлэхэд бүх хүний хараа над дээр буухыг би мэдэрч байлаа. Надаас юм асуух, санал хэлэх хүн байсангүй.

Ю.Цэдэнбал гуай надаас :

-Чамд хэлэх үг байна уу? гэж байна.

Би:

-Яамны сайдын ажлыг хийж чадахгүй байх гэж айж байна! гэж хэллээ. Өөр хэлэх үг ч олдсонгүй.

Ю.Цэдэнбал гуай:

-Төрийн сайдын ажлыг хийж чадахгүй болов уу гэж чиний болгоомжилж байгааг би ойлгож байна. Чи чадах ёстой. Бид чамд туслана гэж хэлээд:

-За батлах уу? гээд асуудал шийдэгдчихлээ. Ю.Цэдэнбал гуай тэр үед

нэг харсан, уулзсан хүнээ мартдаггүй хүн байсан юм. Тэр хурлаас гараад Дүгэрсүрэн гуай бид хоёр Сангийн яаман дээр ирж бүх ажилтнуудаа цуглуулаад мэдээлэл хийлээ. Үнэхээр хэний ч санаанд ороогүй томилгоо болсон юм. Дүгэрсүрэн гуай Сангийн яаман дээр болсон тэр цуглааны өмнө бүх хүнд дуулдахаар “Хурлаа би удирдах уу? Чи удирдах уу?” гэж асуугаад бид хоёр одоо юун тухай ярих гэж байгааг бүх хүнд хялбархан ойлгуулж билээ. Манай сайд Дүгэрсүрэн гуай сэргэлэн хүн байсан юм шүү. Ингэж би 30 настай залуу Сангийн Яамны сайдаар томилогдож байлаа.

5 Их өр.

КЮ: ОХУ-д төлөх өрийн асуудлыг та жаахан тодруулж өгнө үү? Өр үүсэх нөхцөл шалтгаан нь ямар байсан юм бэ?

Д С: Улсын эдийн засаг, нийгмийн бодлогыг боловсруулж төлөвлөдөг, хэрэгжилтийг нь судлаж дүгнэлт гаргадаг, салбаруудын ажлын уялдаа тэнцвэрийг хангах асуудлыг төвлөрүүлж шийддэг төв байгууллага нь Улсын төлөвлөгөөний комисс байлаа.

Эрх барьж байсан МАХН-ын Төв Хороо, Монгол улсын Ардын Их Хурал болон Засгийн газрын зүгээс эдийн засгийн төв байгууллага болох Улсын төлөвлөгөөний комиссын ажил өөдрөг байхад онцгой анхаарч, өндөр шаардлага тавьж ажиллуулдаг байсан нь зөвхөн “төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн систем”-ийн үе байснаар зөвтгөгдөхгүй. Улсад стратегийн бодлого боловсруулдаг ийм төв ямар ч системийн үед байх ёстойгоор тайлбарлагдна.

Ерээд оны эхний жилүүдэд эдийн засаг, нийгмийг шинжилж, бодлого боловсруулж байх учиртайг, төр засгийн үүрэг ролийг үгүйсгэх, зах зээлд бүхнийг даатгах, улс орны амьдралыг зохицуулалт жолоогүй орхих учиргүйг ухаарахгүй байсны харгайгаар төлөвлөлт, эдийн засгийн байгууллагууд үндсэндээ устгагдаж, төв орон нутагт ажиллаж байсан олон зуун эдийн засаг, санхүүгийн сайн мэргэжилтнүүд хэрэггүй мэт болж тараагдсан санагддаг. Тэдний мэдлэг туршлагыг шинэ нөхцөлд ашиглаагүй нь харамсалтай.

Төлөвлөгөө эдийн засгийн төв байгууллага төр засагт чухал байсан бөгөөд цаашид ч чухал байх болно гэсэн бат итгэл надад байдаг. Эрхлэх ажил, түүний арга нь өөрчлөгдөх ёстой нь мэдээж.

Ю.Цэдэнбал гуай 1969 оны 12-р сард намайг Сангийн яамны сайдын ажлаас чөлөөлж Улсын төлөвлөгөөний комиссын нэгдүгээр орлогч дарга, төрийн сайдын албан тушаалд томилохдоо Улсын төлөвлөгөөний комиссыг чадваржуулах, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх,

ялангуяа гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэлийг чанартай боловсруулдаг болох онц шаардлагатайг анхааруулан, сайн ажиллахыг даалгаж байж билээ. Тэр мөчөөс миний амьдрал төлөвлөгөө эдийн засгийн ажилтай салшгүй холбогдсон.

Монголын хөгжилд шаардлагатай, үр ашигтай болохыг үндэслэл тооцоогоор батлаад, социалист гэгдэж байсан улсуудын эдийн засаг, нийгмийн бодлогыг зөвшин зохицуулах ажлын хүрээнд идэвхтэй ажиллаж байсны үр дүнд ЗХУ болон бусад социалист улсуудтай манай улсын эдийн засгийн харилцаа өргөжиж, тэдгээр улсуудаас манайд үзүүлэх тусламж, хөнгөлөлттэй нөхцлөөр өгөх зээл эрс нэмэгдсэн юм.

Тухайлбал: Зөвхөн ЗХУ-аас Монголын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд 1971-1975 онд 450 орчим сая шилжих рублийн зээл тусламж өгч байсан бол үндэслэл тооцоо сайжирсаны ачаар 1976-1980 онд 1.4 тэрбум, 1981-1985 онд 3.2 тэрбум, 1986-1990 онд 3.5 тэрбум шилжих рублийн зээл тусламж авч ашиглагдсан юм.

Ийнхүү 1976 оноос хойш 14 жилийн хугацаанд жилийн 2 хувийн хүүтэй, төлж эхлэх хугацаа нь тухайн таван жилд тохиосон нөхцөлд урьдах зээлийн төлбөрийн шинэ хугацааг 40 хүртэл жилээр сунган тогтоож, хүү оногдуулахыг зогсоодог зэрэг ихээхэн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Монголд барьж байгуулсан дэд бүтэц, үйлдвэрлэл, нийгмийн зориулалттай олон зуун чухал объектууд орчин үед манай улсын эдийн засаг, нийгмийн амьдралын чухал үндэс суурь болж ашиглагдсаар байна.

Эдийн засаг, нийгмийн хөгжлийн урт хугацааны хөтөлбөр боловсруулж, хэтийг харсан бодлоготойгоор гадаадын зээл тусламж ашиглаж чадсаны ачаар манай улс 1970-1990 оны хугацаанд эдийн засгийн хувьд бэхжиж, нийгмийн олон асуудлыг амжилттай шийдсэн билээ.

БНМАУ-ын үндэсний орлого 1960 оноос 1970 онд 30 хувийн өсөлттэй байсан бол 1970 оноос 1980 онд 80 хувиар, 1980-1990 онд 65 хувиар өссөн байна. Үндэсний орлогын жилийн дундаж өсөлт 1970 он хүртэлх арван жилд 2.7 хувь байсан бол 1980 он хүртэлх арван жилд 6.1 хувь, 1990 он хүртэлх арван жилд 5.1 хувь болсон байдаг юм. Орчин үед ийм өсөлт хангах нь мөрөөдөл болоод байна.

Үйлдвэрлэлийн үндсэн салбарууд дээрх хугацаанд амжилттай хөгжсөн гэж хэлж болно. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн 1970 болон 1980 он хүртэлх арван жилүүдэд 14-8 хувиар өсч байсан бол 1990 он хүртэлх арван жил 45 хувиар өссөн. Хөдөө аж ахуй цаг агаараас их хамааралтай байсан боловч түүний уршгийг арилгах талаар авч байсан олон талын арга хэмжээний ачаар мал аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүн жигд биш боловч тасралтгүй нэмэгдэж экспортод ихээхэн хувь эзэлдэг байсан юм.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн жилийн дундаж өсөлт 1970-1990 оны хооронд 7.2-8.7 хувь байсан.

ЗХУ-аас Монголд 1976 оноос 1990 оныг хүртэлх хугацаанд арав шахам тэрбум шилжих рублийн зээл тусламж авч дэд бүтэц болон үйлдвэрийн олон чухал объектууд барьж, эдийн засаг, нийгмийн хөгжлийн чухал нөхцөл бүрдүүлж байсныг зөвхөн төлөвлөгөө төсөл боловсруулалт сайжирснаар тайлбарлаж болохгүй. Үүнд улс төрийн бодлогын нөхцөл шалтгаан нөлөөлсөн нь тодорхой. Олон арван жил хараа нөлөөнд нь байсан Монгол улс хоцрогдсон орноор үлдэх нь ЗХУ-ын сонирхох зүйл биш байснаас гадна далаад оноос зээл тусламжаа нэмэгдүүлэх бололцоо нь өссөнтэй холбоотой. ЗХУ болон социалист гэж байсан улсууд зах зээлээ чөлөөтэй тавьж өгч байсан явдал манай улсын эдийн засгийн хөгжил, экспортын өсөлтөд маш чухал ач холбогдолтой байсан.

Монголын төр засгийн эрх барьж байсан МАХН-ын удирдлага, ялангуяа Ю.Цэдэнбалын баримталж байсан бодлого, идэвхитэй үйл ажиллагаа, түүний нэр хүнд манай улсын гадаад харилцаа, эдийн засгийн хөгжилд чухал ач холбогдол үзүүлж байсныг үнэлэх ёстой.

ЗХУ-аас 1990 оноос урьд авч байсан шилжих рублиэр тодорхойлогдсон зээлийн өрийн асуудлыг одоогийн Оросын холбооны улстай хэрхэн зохицож шийдэх амаргүй асуудалтай залуу үе маань тулгарсан.

Өр үүссэн үеийн хоёр улсын харилцаанд эдийн засгийн харилцааны асуудлыг шийдэхэд улс төрийн бодлогоор хандах явдал давамгайлж байсан. Гадаад худалдаагаар харилцан нийлүүлж байсан бараа үйлчилгээний үнэ тариф нь дэлхийн зах зээлийн үнэ тарифаас ялгаатайгаар тогтоогдон олон жил өөрчлөгдөхгүй хатуу мөрдөгддөг нь заншил болсон байсан. Бараа үйлчилгээний болон зээл тусламжаар барих объектын үнийг ихэнх тохиолдолд нэг талын, тухайлбал ЗХУ-ын талын аж ахуйн нэгжүүдийн санал болгосноор тогтоодог практик байсан. Мөн тэр үед тооцоонд хэрэглэж байсан шилжих рублийн чөлөөт валюттай харьцуулсан ханш жинхэнэ худалдан авах чадварт үндэслэсэн бодит ханш байгаагүй зэргээс тооцоолж зээлийн дүнг шинэчилж тодорхойлох. Түүнчлэн нийгмийн салбарт зориулагдсан зээлийг хөнгөлүүлэх талаар Монголын талаас удаа дараа гаргаж байсан санал анхаарагдаж таарна.

Монголын олон сэхээтнүүд, үүний дотор эдийн засагчид ОХУ-тай хуучин зээлийн өрийн асуудлыг шийдэхдээ Оросын цэрэг Монгол улсын нутаг дэвсгэрт олон жил байрлаж байхдаа олон улсын харилцааны практикт байдаг журмын дагуу монголын талд газрын түрээсийн төлбөр төлдөг байгаагүй, эзэмшиж байсан газар нутгийн эвдрэл бохирдлыг сэргээгээгүйг, Монголын олон сэхээтэн, төр улсын зүтгэлтэн нар Сталины

дарангуйллын үеийн үр уршгаар хэлмэгдэж цаазлагдсан боловч уучлалт хүсээгүй өнгөрсөн, гучаад онд тэр үеийн ЗХУ-ын удирдлагын шаардлагад тулгагдаж гэмгүй олон арван мянган лам нар хэлмэгдэж, олон зуун сүм хийд, соёлын үнэт зүйлс устгагдсан зэргийг бодолцох ёстой гэсэн бодол илэрхийлсээр байдгийг бодолцвол зөв болох байх.

Хэрэв харилцааны өнгөрсөн түүхээ, өвөрмөц харилцаа байсныг сайн бодож болгоож, хуучин зээлийн өрөөс хамтарсан үйлдвэр байгуулахад олгогдсон зээлээс бусдыг үндсэнд нь бүрэн хэмжээгээр хүчингүй болгох тохиролцоонд хүрвэл хоёр улс, ард түмнүүдийн харилцан итгэлцэл, хүндэтгэлийг бэхжүүлэх, хөрш орны цаашдын хамтын ажиллагаанд онцгой сайнаар нөлөөлөх буянтай үйл болох байх гэж бодогддог.

6 Ю. Цэдэнбал гуайг халлаа.

И Л: 1984 оны 8-р сард хуралдсан МАХН-ын 8-р бүгд хурал МАХН-ын ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбал гуайг албан тушаалаас нь огцруулсан шүү дээ. Энэ асуудлаар та тэр үед ямар байр суурийг баримтлаж байсан бэ?

Д С: Монголчууд, ялангуяа төр засгийн удирдах ажилтнууд улс нийгмийнхээ төлөө гэсэн санаа сэтгэлээр нэгдэлтэй байх ёстой. Нэгдэл нягтралгүй байснаас, албан тушаал эрх мэдлийн төлөө тэмцэлдсэний гайгаар Монгол улс хохирч байсан. Хөгжлийн замыг сонгосон 1924 онд өөр үзэл бодол илэрхийлсэн нөхдөө хөнөөж байснаас эхлээд 30-аад оны их хэлмэгдүүлэлт, түүнээс хойш үеийн албан тушаал эрх мэдлийн төлөөх зөрчилдөөний хор уршгийн тухай орчин үед ярьж бичиж байгаагийн гол учир бол хэлмэгдүүлэлт дахин гарахаас, эв түнжингүй байхаас сэрэмжлүүлэхэд оршино байх. Албан тушаал, хувийн сонирхлын төлөө улс нийгмийн ашиг сонирхлыг огоорч явдаг хүмүүсийн аливаа муу үйлдэл эв нэгдэлгүй байдал үүсэх, хэлмэгдүүлэлт давтагдан гарахад хүргэж болохыг анхаарч байх нь зөв болно.

Ю.Цэдэнбал гуай 1984 онд бүх албан тушаалаас нь өөрчилсөн нарийн учир шалтгаан миний хувьд тэр үедээ биш, хожим тодорхой болсон. Хэдийгээр мартамхай болсон, идэвхтэй ажиллах чадвар нь нас ахисан хүний хувьд доройтсон нь ажиглагдаж байсан боловч зарчмын гэж үзэх асуудлаар шийдвэр гаргах болоход Ю.Цэдэнбал гуай эцсийн үг хэлдэг, хамтран зүтгэгч нөхөд нь түүний юу хэлэх, ямар шийдэл гаргахыг нь хүлээдэг, үг дуугүй зөвшөөрдөг байсан нь тодорхой.

Ю.Цэдэнбал гуай өөрөө чадвар мөхөс болж буйгаа мэдэрч байсан байх. Мартсаныг нь сануулах, зөвлөж туслах ёстой гэж өөрийн нь итгэдэг

зарим хүн, ялангуяа эхнэр А.И.Филатовагийн үгнээс гаждаггүй, тэднийхээ нөлөөнд бүрэн автагдсан байсан санагддаг. Нөгөө талаар Монголын нам төрийг удирдах өндөр хариуцлагатай албан тушаалаасаа өөрчлөгдөж, тэтгэврээ тогтоолгоод энгийн иргэний адил амьдрах жамтайн тухай бодох, өөр дээрээ тусган санаачилга гаргаж чадахгүй болтлоо зан суртахуун нь төлөвшсөн байсан байх.

МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчоо (УТТ)-нд хамт ажиллаж байсан нөхөд нь Ю.Цэдэнбал гуай урьдын адил идэвхтэй хөдөлмөрлөх, улс нийгмийн хувь заяаны том асуудлаар зөв шийд гаргаж байх чадвар нь мөхөс болж байгааг, түүний эхнэр А.И.Филатова нь нам төр, засгийн хэрэгт хутгалдан ордог болж байгааг хэдий ажиглавч өөрт нь халдаж хэлж зүрхэлдэггүй байсан нь бас тодорхой.

Ю.Цэдэнбал гуайн эрүүл мэнд, хөдөлмөрийн чадварт гарч байсан өөрчлөлтийг түүний гэр бүлийн хүмүүс, ялангуяа эхнэр А.И.Филатова гуай сайн мэдэж ажиглаж байсан нь маргаангүй. Тэд эхэн үедээ даргад мартсан зүйл байвал сануулж, зарим зөвлөлгөө өгөх зэргээр тус хүргэж байсан бол тэр үйлдэл нь улам, улам идэвхжиж байсан юм. Тэд нар Ю.Цэдэнбалын нэрээр “МАХН, Монголын нам, төр, засгийн үйл хэргийг удирдаж залдаг, захирдаг хүмүүс болж болох юм!” гэсэн ойлголттой болсон байж болох юм.

Ю.Цэдэнбал гуай үе, үе халаасанд нь хийсэн жижиг цаасанд бичсэн зүйлийг гаргаж хараад хэн нэг хүнд үүрэг даалгавар өгч байхыг бид ажиглаж л байсан. Чухам хэний бичсэн буюу санаачилсан удирдамжаар асуудал шийдэгдэж байсан бол гэсэн бодол төрдөг юм. “Авгай”-н догшин ширүүн, бүдүүлэг зан ааш, төр, улс, МАХН-ын хэрэгт, ялангуяа боловсон хүчний асуудалд шууд оролцоод байгааг олон хүн мэдэж байсан боловч буруу үйлдэл хийж байгааг нь хориглодог хүн байгаагүй.

Хэрэв цөөнгүй хүний гайхал дургүйцлийг төрүүлж байсан А.И.Филатовагийн тэр үйлдэл 1984 оноос хойш үргэлжилсэн бол Монголын төр засгийн хэрэг дээрээ Ю.Цэдэнбал гуайн нэрээр түүний эхнэр А.И.Филатова удирддаг болчихсон байж болох юм.

Ямар боловч нэг тов тодорхой зүйл бол Ю.Цэдэнбал гуайг түүний гэр бүлийн хүмүүс, эхнэр А.И.Филатова нь МАХН, Монголын, төр, засгийн хамгийн өндөр албан тушаалд мөнхийн байлгаж, бурхан мэт тахиулж байх сонирхолтой байсан юм. Ю.Цэдэнбал гуай 1990 он хүртэл МАХН, Монголын төр, засгийн удирдлагад, албан тушаалдаа хэвээр байсан бол ардчилсан хувьсгалын үйл явц хэрхэн өрнөх, түүнд Ю.Цэдэнбал болон түүний эхнэр А.И.Филатова яаж хандах байсныг нэг биш хувилбараар төсөөлж болно.

А.И.Филатова гуайн Монголын төр засаг, МАХН-ын удирдлагад

Ю.Цэдэнбалыг насан туршид нь байлгах сонирхол, МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны гишүүн, Сайд нарын Зөвлөлийн 1-р орлогч дарга Д.Майдар гуайн Сайд нарын Зөвлөлийн дарга болох сонирхол нийцэж байсан юм билээ. Ю.Цэдэнбал гуайн ажиллах чадвар доройтсоныг Д.Майдар гуай албан тушаал ахих санаархалдаа ашиглаж, түүнд нь саад болж болох хүмүүсийг зайлуулах үйлдэл хийж байсан нь тодорхой бичигдсэн байдаг юм. А.Филатова, Д.Майдар хоёрын зүгээс МАХН-ын Төв Хорооны УТТ-ны гишүүн, Төв Хорооны эдийн засгийн асуудал хариуцсан нарийн бичгийн дарга Д.Моломжамц болон бусад эдийн засагчдыг ажлаас нь халж, зайлуулах арга эрж, шалтаг зохиож байгаа, түүндээ Монгол-Зөвлөлтийн эдийн засгийн харилцааны асуудлаар гарч байгаа саналыг гуйвуулан ашиглах оролдлого хийж байсан нь хожим тодорхой болсон юм. Тэр үед би Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга, Улсын Төлөвлөгөөний Комиссын даргаар ажиллаж байв. Монгол улсынхаа эдийн засаг, нийгмийн байдалд дүн шинжилгээ хийж, цаашдын хөгжлийн төлөвлөгөө бодлого боловсруулдаг үүргийнхээ дагуу бодит байдлыг нам, засгийн удирдлагад илтгэн, Монголын ашиг сонирхлын асуудлаар саналаа танилцуулдаг байлаа.

МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчоонд 1983 онд өгсөн нэг танилцуулгадаа Монгол-Зөвлөлтийн эдийн засгийн хамтын ажиллагаатай холбогдсон зарим асуудлыг, түүний дотор Монгол-Зөвлөлтийн хамтарсан “Эрдэнэт” үйлдвэрийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар саналаа танилцуулсан юм. “Эрдэнэт” үйлдвэрийн талаар бид:

-Монгол улсын төсвөөс “Эрдэнэт” үйлдвэрт татаас өгч, өгөгдсөн татаасыг / дотаци / оролцуулсан ашгийг хоёр улс хувааж авдаг буруу практикийг өөрчлөх,

-“Эрдэнэт” хамтарсан үйлдвэрээс Монгол улсын төсөвт байгалийн баялаг ашигласны төлбөр төлүүлдэг болох,

-Эдгээр асуудал нааштай шийдэгдэхгүй бол ЗХУ-тай шинээр хамтарсан үйлдвэр байгуулах асуудлыг цаашид Монголын тал дэмжих боломжгүй юм! гэсэн санал гаргасан юм.

Бидний саналд “Эрдэнэт” хамтарсан үйлдвэрийн өндөр ашигтайг, Монголын экспортын нөөцөд том байр эзэлдгийг үгүйсгэсэн зүйл байгаагүй, байх үндэсгүй. Үнэндээ бол арван жилийн өмнө “Эрдэнэт” үйлдвэрийг байгуулах анхны хэлэлцээрийг Д.Майдар дарга дураараа буруу байгуулснаас гарсан алдааг засах тухай олон жил үргэлжилсэн ярианы үргэлжлэл байсан юм.

“Эрдэнэт”-ийн талаархи бидний саналыг ЗХУ-ын Өнгөт металлургийн яам болон Засгийн газар хоорондын комиссын зөвлөлтийн талын албаны зарим нөхөд хүлээж авах дургүй, ярилцахыг хүсдэггүй

байсан бөгөөд “Монголын эдийн засагчид хүлээж авах үндэсгүй санал дэвшүүлж байна!” гэсэн утгаар Зөвлөлт Хобоот Улсын Коммунист Нам (ЗХУКН)-ын Төв Хороонд хүрч танилцуулагдсан юм билээ.ЗХУКН-ын Төв Хороо мэдээлэлтэй танилцаад өгсөн даалгаврын дагуу тэр үеийн ЗХУ-ын Улсын төлөвлөгөөний хорооны хэлтсийн эрхлэгч (сүүлд Засгийн газрын Ерөнхий сайд болсон – ред.) В.Павловаар ахлуулсан төлөөлөгчдийг Монголд ирүүлсэн юм. В.Павлов болон тэр үед манай улсад ЗХУ-аас сууж байсан Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд С.Павлов нар, өөрөөр хэлбэл асуудалд маш бодитой шудрага ханддаг хоёр Павлов хамтран ажиллаж асуудлын учрыг олоод “Монголын талын санал үндэслэлтэй байна!” гэж дүгнэсэн юм. Ингээд Монгол улсын төвлөрсөн төсвөөс “Эрдэнэт” үйлдвэрт татаас төлж байсан явдлыг бүрэн зогсоосон юм. Энэ асуудлыг “Эрдэнэт” үйлдвэрийн зэсийн баяжмалыг ЗХУ-д нийлүүлж байсан үнийг нь нэмэгдүүлж, дэлхийн зах зээл дээр зарагдаж байгаа үнэд ойртуулах замаар шийдсэн юм. Энэ тухай тусгай протоколд 1984 оны 6-р сарын сүүлчээр гарын үсэг зурав. Харин Монголын байгалийн баялаг ашигласны төлбөрийг хамтарсан үйлдвэрээс төлүүлж байх асуудал 1991 он хүрч байж нөхөн олгох замаар шийдэгдсэн юм. “Улс орныхоо ашиг сонирхлыг үндэслэлтэй илэрхийлж хамгаалсан нь зөв!” гэж Д.Моломжамц, Ж.Батмөнх нар болон ЗХУ-аас тус улсад сууж байсан элчин сайд С.Павлов дэмжиж байсан болохоор бид нар саналаа зоригтой хэлдэг байсан юм. Энэ асуудлыг Ю.Цэдэнбал гуайд танилцуулахад “Та нарын зөв!” гэдэг байсан.

Гэтэл, протокол байгуулж манай талын саналыг дэмжиж асуудлыг нааштайгаар шийдвэрлэсэн байсаар атал түүнийг А.И.Филатова, Д.Майдар нар улс төрийн асуудал болгон сөхжээ. “Монгол-Зөвлөлтийн харилцааны үр ашгийг, тухайлбал “Эрдэнэт” хамтарсан үйлдвэрийн эдийн засгийн ашигтай ажиллагааг үгүйсгэдэг “эдийн засагчдын бүлэг” Монголд бий болжээ. Зөвлөлтийн эсрэг, Хятадын талыг баримтлагчид бол Д.Моломжамц, П.Жасрай, Н.Мишигдорж, Долгормаа, Д.Содном зэрэг эдийн засагчид бөгөөд эдгээр этгээдүүдийг яаралтай ажлаас нь халах хэрэгтэй!” гэсэн саналыг Ю.Цэдэнбал гуайд танилцуулжээ.

“Монгол-Зөвлөлтийн хамтын ажиллагааны үр ашгийг үгүйсгэдэг эдгээр хүмүүсийг ажлаас нь халж, нам, төрийн удирдлагаас зайлуулах тухай” тогтоолын төслийг Д.Майдар гуайн даалгавраар Балбар гэдэг хүн бичсэн байна. Энэ тогтоолын төслийг 1984 оны хавар Ю.Цэдэнбал гуайд танилцуулжээ. Энэ тогтоолын төсөл одоо МАХН-ын архивт байгаа. “Ажлаас халах” хүмүүсийн тоонд МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны гишүүн, Сайд нарын Зөвлөлийн дарга Ж.Батмөнх гуайг бас хамруулж байсан юм билээ. Ю.Цэдэнбал гуай тэр хоёрын саналыг хүлээж

аваад, тэдгээр хүмүүсийг ажлаас нь халах бэлтгэл хийхийг МАХН-ын Төв Хорооны Боловсон хүчний хэлтэст үүрэг болгосон байна. Ингээд 1984 оны 7-р сарын эцсээр өөрөө ЗХУ-д амрахаар явжээ. МАХН-ын Төв хорооны Боловсон хүчний хэлтсийн эрхлэгчээр ажиллаж байсан Б.Ламжав гуай “Ийм олон эдийн засагчдыг нэгэн зэрэг ажлаас халах шаардлага байгаа бол учир шалтгааныг нь сайн хэлэлцүүлж байж шийдвэр гаргах хэрэгтэй!” гэж үзээд энэ тухайгаа Ю.Цэдэнбал гуайд хэлжээ. Тэр энэ асуудлыг Ю.Цэдэнбал гуайг амарч ирсний дараа хэлэлцэж шийдвэрлэх зөвшөөрлийг түүнээс авч чадсан байна. Энэ тухай би сүүлд нь Б.Ламжав гуайгаас сонссон юм. Ийм асуудал болж байгааг бид тэр үед нь яаж мэдэх вэ дээ. ЗХУКН-ын Төв Хороонд Монголын төр, засгийн удирдлагад бий болоод байсан зөрчил тодорхой болж, энэ асуудлыг хурцатгаж, Монгол-Зөвлөлтийн эдийн засгийн харилцааны үр ашгийн шалтгаанаар МАХН, Монголын төр, засгийн удирдлагад ажиллаж байгаа эдийн засагчдыг олноор нь хомроглон ажлаас нь халж, нам, төрийн удирдлагаас зайлуулахад хүргэж болохгүй гэсэн дүгнэлтийг тэнд хийжээ.

Эдгээрээс үзэхэд Ю.Цэдэнбал гуай улс орныг удирдах өндөр хариуцлагатай албан тушаалуудын ажлаас чөлөөлөгдөх шаардлагатай болсон, А. И. Филатова, Д.Майдар нар хувийн ашиг сонирхлын үйлдлээрээ энэ асуудлыг түргэтгэсэн болох нь тодорхой харагдаж байгаа юм.

Би 1984 оны 8-р сарын эхээр Сочид амрахаар очоод долоо орчим хоног болж байтал “Улаанбаатарт яаралтай ир!” гэсэн цахилгаан авлаа. Москва хотод ирэхэд Элчин сайд Гүрбадам угтсан бөгөөд ямар учраас яаралтай дуудсан учрыг асуухад “МАХН-ын Төв Хорооны Бүгд хурал хуралдах, түүгээр Ю.Цэдэнбал гуайг албан тушаалуудаас нь чөлөөлөх асуудал хэлэлцэх бололтой!” гэж товч мэдээ өгсөн юм. Нарийн учрыг мэдэхгүй Улаанбаатарт ирсний маргааш Намын Төв Хороонд очиход “Ю.Цэдэнбал гуайг бүх албан тушаалаас чөлөөлөх асуудал бүгд хурлаар хэлэлцэгдэнэ, шалтгаан нь түүний эрүүл мэнд муудсан явдал!” гэж хэлсэн. Тэр үед би Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга бөгөөд Улсын Төлөвлөгөөний Комиссын даргаар ажиллаж байсан, Намын Төв Хорооны Улс Төрийн Товчооны гишүүн биш байсан болохоор улс төрийн болон боловсон хүчний асуудлаас хол хөндий байв.

МАХН-ын Төв Хорооны 1984 оны 8-р сарын Бүгд хурлаар Ю.Цэдэнбал гуайг ажлаас чөлөөлж Ж.Батмөнх гуайг МАХН-ын ТөвХорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн даргаар томилсон бөгөөд Сайд нарын Зөвлөлийн даргын албан тушаалд нь хэвээр үлдээсэн. Түүнээс хойш 4 сарын дараа буюу 1984 оны 12 дугаар сард хуралдсан Намын Төв Хорооны бүгд хурал

болон Ардын Их Хурлын чуулганаас намайг Сайд нарын Зөвлөлийн дарга, МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны гишүүнээр томилсон юм.

Ю.Цэдэнбал гуайн бага хүү Ц.Зориг бичсэн номондоо эцгийгээ цоо эрүүл, ажлын бүрэн чадвартай байхад нь зөвлөлт ба монголын хэсэг хүмүүс хуйвалдаж хэлмэгдүүлсэн, Монголын талаас тэр хуйвалдааныг зохион байгуулсан хүмүүс гэж хардаж бичсэн юмандаа миний нэрийг оруулсан байдаг. Тэр залуу Эрдэнэтийн асуудлаар Монголын эдийн засагчдын баримталж байсан санал зөв болж нааштай шийдэгдсэн, тэр асуудлыг гуйвуулж Зөвлөлтийн эсрэг үзэлтэн болгож олон хүнийг хэлмэгдүүлэх гэсэн А.И.Филатова, Д.Майдар нарын оролдлого бүтээгүйг мэддэггүй, дуулсан бол учир холбогдол үр дагаврыг нь ойлгодоггүй, мөн 1984 оны 12-р сард Улс Төрийн Товчооны гишүүнээр миний томилогдсоныг мэддэггүй байх.

Ямар боловч хүний тухай бичих бол зөвхөн үнэнийг нягтлах ёстой, бичигдэж байгаа хүн уншаад хардлагыг биш үнэнийг үнэлнэ гэдгийг бодож бичих ёстой.

Албан тушаал эрхэмлэгсэд, хардаж сэрдэгсэд, шагнал горьдож гоморхон өшрөгсөд зөвхөн засрашгүй хувиа бодогсод байдаг бөгөөд үг үйлдлээрээ улс нийгэмд, эв нэгдэлд, хамтран зүтгэгчиддээ, хань нөхөртөө ч тус биш гай болж байдаг байх.

Монголын төр засгийн удирдлагад олон арван жил ажилласан Юмжаагийн Цэдэнбал гуайг 1984 онд бүх албан тушаалаас нь огцруулснаас хойш олон жил сайн муугаар нь дуудсан. Тэр хүний ажил амьдрал, гавъяа алдааг бодитой үнэлж түүхэнд үлдээх учиртай.

1990 оноос урьдах 70 орчим жилийн түүхийг Монгол улсын хөгжих боломж алдагдсан олон арван жил гэж үздэг хүмүүс байдаг. Бас 1990 оноос хойших арав гаруй жилийг Монгол хөгжлийн боломжоо ашиглаж чадсан жилүүд гэж үздэггүй хүмүүс олон. Бэрхшээл алдаанаас үүдсэн буюу түргэн хөгжихийг хүссэн бухимдлаа зөөлрүүлж бодитой дүгнэж бодох учиртайг ухаарцгааж байгаа.

Энэ үүднээс үзвэл Монгол улс 1921 оны Ардын хувьсгалын ачаар бид Монгол үндэстнээ сэргээж, тооны хувьд дөрөв дахин өссөн, эрүүл бөгөөд боловсролтой ард иргэдтэй улс болсон, тусгаар тогтнолоо баталгаажуулж 140 гаруй улстай дипломат харилцаа тогтоон Нэгдсэн Үндэстний Байгууллагын нэгэн идэвхтэй гишүүн улс болсон. Одоо ардчилсан, зах зээлийн эдийн засагтай улс болж буй Чингисийн Монгол улсыг даян дэлхий мэддэг болжээ. Монгол хөгжлийн ирээдүйтэй улс гэдэгт эргэлздэг хүн байхгүй.

Ю.Цэдэнбал Монголын төр, засгийг 40 гаруй жил удирдсан.

Монголын төр засгийн удирдлагад түүний ажиллаж байсан хугацаанд улс орон илүү хөгжих боломж ашиглагдаагүй, монголчуудын хүсэл мөрөөдөлд бүрэн хариу өгдөггүй гэж дүгнэх хүн байдаг. Түүхэнд нэг хүний үүрэг их байдаг боловч тэр нэг л хүний ажил ухаанаар улс орон, ард түмний хувь заяа төгөлдөр шийдэгдсэн байх ёстой гэж муйхраар зүтгэж болохгүй. Бидний монголчууд бүгдээрээ социализм байгуулна, бидний ирээдүй түүнд гэж чин сэтгэлээсээ итгэцгээж байлаа. Ю.Цэдэнбал мөн л тийм ирээдүйд итгэж байсан. Итгэл үнэмшилтэй амьдарч байсны төлөө хэн нэгийгээ буруутгах, ад үзэх нь бидний араншин баймгүй. Өнгөрсөн зуунд социалист системээс гадна орчинд Монгол улс оршин тогтнох нөхцөл байгаагүйг бас зөвшөөрөх хэрэгтэй.

Японы милитаристууд 1939 онд Халхын гол орчмоор манай улс руу цэрэг зэвсгийн хүчээр довтлоход Монголоо хамгаалах дайнд гучин нас хүрээгүй залуу Ю.Цэдэнбал монголынхоо дайчдыг улс төрийн удирдлагаар ханган зоригжуулах, бүх талын хангамжийг зохион байгуулах, Зөвлөлт Холбоот Улсын зэвсэгт хүчний удирдлагатай нягт хамтарч ажиллах зэрэг хариуцлагатай албыг фронт дээр биечлэн гүйцэтгэж байсан юм билээ.

Фашизмын Герман 1941 онд Зөвлөлт Холбоот Улсыг довтолж дэлхийн хоёрдугаар дайныг өдүүлэхэд Зөвлөлтийн ард түмэн, зэвсэгт хүчинд үзүүлсэн Монголын ард түмний тусламж дэмжлэгийг гарамгай зохион байгуулсан монголын удирдагчдын нэг нь Ю.Цэдэнбал. Тэр дайнд монголчууд Оросын ард түмний талд баттай зогсож, өчүүхэн боловч бүх бололцоогоо дайчлан тусалж байсан нь Монгол улс, Монголын ард түмэн хувь заяаныхаа төлөө фашизмын эсрэг тэмцэлд идэвхтэй оролцож хувь нэмэр оруулах ёстойг гүн ухамсарлаж ойлгож байсны илрэл. Монголын ард түмний тусламжийн зүйлийг зөвлөлтийн дайчдад газар дээр нь хүргэж өгч байсан хүмүүсийн нэг нь Цэдэнбал гуай.

ЗХУ-ын домогт баатар Г.К.Жуков болон цэргийн бусад олон алдарт командлагч нартай Ю.Цэдэнбал 1939 оноос хамтран зүтгэж, сайн нөхөд болцгоосон. ЗХУ-ын цэргийн олон командлагчид болон Цэдэнбал гуайн хооронд бий болоод олон жил үргэлжилсэн их нөхөрлөл нь Монгол ба Орос улс, ард түмнүүд, зэвсэгт хүчний хоорондын олон жилийн найрсаг харилцаа, харилцан итгэлцэл, бүх талын хамтын ажиллагааны нэг шижим болж байсан.

ЗХУ-ын төр засаг, зэвсэгт хүчний зүтгэлтэн нартай Ю.Цэдэнбал гуай уулзсан хэд хэдэн уулзалтанд байлцан, нөхөрсөг яриаг нь сонсох завшаан надад тохиож байсан. Халхын голын дайн болон дэлхийн хоёрдугаар дайны үед хамтран зүтгэж байсан маш олон хүнийг овог нэрээр нь санаж, гавьяа зүтгэлийг нь дурсан ярьж байхыг сонсоод, түүний журмын нөхдөө

мартдаггүй, тэднийгээ хүндэлж явдаг хүнлэг сайхан чанарыг нь хүмүүс үнэхээр биширч үнэлдэг байсан. Ю.Цэдэнбалыг цэрэг дайны түүх, цэргийн эрдэм ухааныг сайн судалсан өргөн мэдлэгтэй хүн гэж Оросын цэргийн алдартай командлагчид үнэлж хүндэтгэдэг байсан. “Дайсны цэргийн хүчийг бүрэн бүслэлтэд оруулж ялж байсан түүх дэлхийн дайны түүхэнд хоёр дахь удаад 1939 оны Халхын голын дайны үед давтагдсан юм!” гэж ярьдаг байж билээ.

Монгол улсын тусгаар тогтнолын асуудлаар Монголын бүх ард түмний дунд 40-өөд онд санал асуулга явуулж, бүх хүний саналыг нэг бүрчлэн гаргуулах болон дүнг нэгтгэж дэлхийд мэдээлэх ажлыг амжилттай зохион байгуулсан гавьяатай хүмүүсийн нэг нь Ю.Цэдэнбал. Монгол улс Ю.Цэдэнбалын үед л Нэгдсэн Үндэстний Байгууллагад гишүүнээр элсэж тусгаар тогтнолоо баталгаажуулан бэхжүүлж чадсан.

Монголын хүн ам 1950 он хүртэл жилд дөнгөж 0,4-0,8 хувиар өсдөг байсан бол тавиад оны дундуураас хүн амын жилийн цэвэр өсөлт 2,5-3,0 хувь болтол нэмэгдсэн нь эрүүлийг хамгаалах олон талын ажлын үр дүнг тодорхой илэрхийлдэг. Манай улс 1950 онд ердөө л 772 мянган хүнтэй байсан бол 1990 онд 2,15 сая болж 2,8 дахин өссөн.

Монгол улсын 8-аас дээш насны хүн амын дөнгөж 21 орчим хувь нь 1940 онд бичиг үсэг мэддэг байсан. Энэ бол Ю.Цэдэнбалын хөдөлмөрийн гараагаа дөнгөж эхэлж байсан үе. Тэгвэл Цэдэнбалын маш идэвхтэй ажиллаж байсан үед буюу 1965 оны үед сургуулийн насны нийт хүүхэд залуучуудыг найман жилийн буюу бүрэн бус дунд боловсролтой болгох зорилт дэвшүүлэх боломж бүрдэж, 1980-аад оны эхээр тэр дэвшүүлсэн зорилт бүрэн хэрэгжсэн байдаг юм. Дотоод гадаадын их дээд сургууль, техникум, техник мэргэжлийн сургуулиар наяд онд үндэсний мэргэжилтэн, мэргэжилтэй ажилчдаа хангалттай бэлтгэж чаддаг болсон байж билээ.

Ю.Цэдэнбал өөрөө орос хэлийг маш сайн сурч эзэмшсэн, орос хэлд сургах нь боловсрол мэргэжилтэй боловсон хүчинтэй байхын чухал нөхцөл гэж үздэг, тэр итгэлийнхээ дагуу орос хэлийг сайн сурсан байхыг алхам тутамдаа сануулдаг, шаарддаг байсан. Орос хэл сайн эзэмшсэн эсэхийг боловсон хүчнээ сонгох, чухал албан тушаалд хэн нэгийг томилохдоо харгалздаг байсан туршлагыг муулах шоолох биш, түүнээс үлгэр авч гадаад хэлийг халтарлах биш сайн мэддэг эсэхийг шалгаж үнэлдэг болох нь зөв гэж бодогддог. Түүнийг Монголын нам төрийн олон жилийн туршлагатай зүтгэлтэн гэж социалист улсуудын нам төрийн удирдагчид үнэлж хүндэтгэдэг байсан.

Социалист улсууд эдийн засгийн нөөц бололцоо нь нэмэгдэж байсан далаад оноос Монголд дорвитой тус дэмжлэг үзүүлж эхэлсэн.

Гадаадын зээлийг оновчтой зориулалтаар ашиглахын чухал нөхцөл нь улс орны хөгжлийн хэтийн төлөвлөгөөтэй, төлөвлөсөн томхон төсөл нэг бүрээр техник эдийн засгийн үндэслэлээр үр ашиг нь баталгаатай тодорхойлогдсон байх ёстой гэж үздэг байсан. Чухам ийм шаардлага онц чухал болж байгааг Ю.Цэдэнбал гуай 1969 онд намайг Сангийн сайдын ажлаас чөлөөлж Улсын Төлөвлөгөөний Комиссын орлогч даргад томилохдоо хэлж байсан юм. “Комиссын өдөр тутмын ажлыг өөрөө голлон хариуцаж, хэтийн хөгжлийн бодлого схем болон хөгжлийн шийдвэрлэх ач холбогдолтой төслүүдээр үндэслэл боловсруулах ажлыг чи голлож хариуцвал яма вэ?” гэж Улсын Төлөвлөгөөний Комиссын дарга байсан Рэнцэнпэлжээ гуай надад хэлсний дагуу Улсы Төлөвлөгөөний Комиссын ажил зохион байгуулагдаж байсан.

Монгол улсын үйлдвэрлэх хүчнийг хөгжүүлж байршуулах 10-15 жилийн чиглэл схемийг үндэслэл тооцоотой боловсруулах, социалист улсуудын эдийн засгийн ухааны эрдэм шинжилгээний байгууллагатай холбоо тогтоож ажиллах, хэтийн болон таван жилийн төлөвлөгөөг бусад улсынхтай уялдуулж зохицуулах зэрэг өргөн хүрээтэй ажил өрнөж байсныг Ю.Цэдэнбал гуай дэмжиж, зарим тодорхой асуудлыг шийдэхэд зөвлөдөг, дэмждэг байж билээ.

Далаад оны дундуур Монгол улсын үйлдвэрлэх хүчнийг 1990 он хүртэл хугацаанд хөгжүүлэх анхны ерөнхий чиглэл - схем боловсрогдож бэлэн болсонд ач холбогдол өгч, уг схемийг МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчоо авч хэлэлцсэн юм. ЗХУ-ын Улсын Төлөвлөгөөний Хорооны дэргэдэх Үйлдвэрлэх Хүчнийг Судлах Зөвлөл “СОПС” нэртэй эдийн засгийн хүрээлэнгийн захирал нь ахласанхорь гаруй эрдэмтдийг оролцуулсан МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны хурлыг дарга өөрөө удирдаж, Монголын ирээдүйн хөгжлийн асуудлыг бүх талаас уялдаа холбоотой боловсруулсан анхны схемийг өндөр үнэлээд, энэ чухал ажлыг тасралтгүй үргэлжлүүлэх, хөгжлийн схемийг 2000 он хүртэл хугацаагаар боловсруулахад тусгавал зохих асуудлаар, ялангуяа шинжлэх ухаан, тэргүүний технологийн ололтыг ашиглах талаар түүний өгч байсан санал чиглэл нь бичигдэж тэмдэглэгдсэн байдаг. Удирдагч хүн улс орныхоо бодит байдлыг алган дээрээ юмшиг харж дүгнэж, ирээдүйг олон хувилбараар төсөөлөх, ажлаа хариуцаж чадахын жишээг үзүүлж байна даа гэх сэтгэгдэл төрж байсан. Тэр үед Ю.Цэдэнбал гуай үнэхээр ухаан чадвараар, ажлаараа үлгэрлэж чадаж байсан даа.

Чухамдаа дээрх ажлын ачаар манай улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг урагшлуулах дорвитой томхон төслүүд 1976-1990 онд хэрэгжсэн. Энэ хугацаанд Эрдэнэтийн зэсийн үйлдвэр болон байгалийн баялаг ашиглаж экспортын нөөц өсгөх олон үйлдвэр ашиглалтад орсон буюу

бүрэн хүч чадлаар ажиллах болсон. Түлш эрчим хүчний томхон эх үүсвэрүүд бий болсон. Мал аж ахуйн түүхий эдий бүрэн боловсруулдаг болсон. Газар тариалангийн үйлдвэрлэл жигдэрч, үр тариа, төмс, хүнсний ногоогоор хэрэгцээгээ бүрэн хангадаг болж билээ. Чухам л энэ хугацаанд орон сууцыг хороолол хорооллоор иж бүрэн үйлчилгээний газар, сургууль, цэцэрлэг, эмнэлэгтэй хамт хот хөдөөд барьж байлаа. Сангийн аж ахуйнуудыг бараг бүгдийг тохижуулсан. Бүх аймгийн төвд эсвэл сургууль, эсвэл эмнэлгийн орчин үеийн шаардлага хангасан томхон цогцолборыг барьснаас гадна радио релейн шугамаар холбож, аймгуудын төв зурагт хардаг болж, харилцаа холбоо сайжирсан. Их бүтээн байгуулалтын 15 жил байсан гэж хэлэх бүрэн үндэстэй.

Засгийн газар хоорондын комиссын Зөвлөлтийн талын өндөр албан тушаалтан 1983 онд Хөвсгөлийн фосфоритын ордод ашиглалт явуулахад монголын тал сонирхож байна гэсэн албан ёсны санал ирүүл гэсэн шаардлага миний нэр дээр ирүүллээ. Би уг ордод ашиглалт явуулахыг зөвхөн эдийн засгийн өндөр ашигтай байх нөхцөлд монголын тал зөвшөөрөх болно гэсэн хариу цахилгаан төлөвлөөд Ю.Цэдэнбал даргад очиж танилцууллаа. Дарга тэр цахилгааны төслийг үзээд, чиний санал зөв, ийм хариу өгөх хэрэгтэй гээд орос хэл дээр төлөвлөж бичсэн хариу цахилгааныг анхааралтай үзэж нэг үг засаж өгч байж билээ. Улсын Төлөвлөгөөний Комиссын архивт үзвэл тэр цахилгаан байгаа.

Улс орны ашиг сонирхлын төлөө хөдөлмөрлөж байсан хэн боловч зөв үйл ажлынхаа төлөө Ю.Цэдэнбалаас зэм биш дэм авч байсан.

Ю.Цэдэнбал соёлтой, хүмүүстэй маш боловсон, болгоомжтой харилцдаг, түүгээрээ хүндэтгэл хүлээж, үлгэрлэж байсныг олон хүн мэднэ. Өөрсдийнхөө жишээн дээр батлана.

Далаад онд Ю.Цэдэнбал гуайд би нэг удаа ажил танилцуулах явцад санамсаргүйгээр шалгалт өгч билээ. Эдийн Засгийн Харилцан Туслах Зөвлөл (ЭЗХТЗ)-ийн шугамаар далаад оны эхнээс их ажил өрнөж байсан. ЭЗХТЗ-ийн гишүүн улсууд, тэдгээрийн харилцааг хөгжүүлэх Иж Бүрэн Цогцолбор Программ батлагдаж, түүнийг хэрэгжүүлэх ажил бүх байгууллага, үүний дотор төлөвлөгөө эдийн засгийн байгууллагын шугамаар зохиогдож байлаа.

Ю.Цэдэнбал дарга амралтын өдрүүдэд ч тасралтгүй ажиллах бөгөөд гэрт нь дуудагдаж ажил танилцуулах тохиолдол олон гарч байсан юм. Нэг удаа дуудагдаж даалгасан ажлыг танилцуулж дууссаны дараа Ю.Цэдэнбал дарга арынхаа ширээнээс нэг ном гаргав. Тэр нь Эдийн Засгийн Харилцан Туслах Зөвлөлийн Төлөвлөлтийн салбарт хамтран ажиллах Хорооны нэг ээлжит хурлын протокол байлаа. Зузаан протоколыг бүгдийг уншиж судалсан бололтой, олон хуудсанд цаас хавчуулсан, улаан хөх

харандаагаар зурж тэмдэглэл хийсэн харагдлаа.

-Чиний оролцдог энэ Хорооны хурлын протоколыг уншлаа, асуух юм байна гээд хэлэлцсэн асуудал нэг бүрээр ямар учиртай, яагаад гэсэн олон асуудал тавьсан бөгөөд, хагас цаг орчим үргэлжилсэн ярилцлагын эцэст за ойлгогдлоо, олон чухал асуудал хэлэлцэж сонин шийдвэрүүд гаргасан байна гээд протоколыг надад өгсөн.

Ю.Цэдэнбал гуай тэр материалыг уншаад, тодруулж асуух юм байсан биз. Гэхдээ гол нь намайг оролцдог хурлынхаа хэлэлцсэн асуудал, гаргасан шийдвэр, тэдгээрийн учир холбогдлыг сайн мэдэж байгаа эсэхийг нэг бүрчлэн шалгаж үзэж байсан хэрэг бөгөөд тэр нь надад их сургамж болж үлдсэн. Ажилсаг, боловсрол, соёлтой даргын удирдлагад хичээж ажилласан хүн ажил сурдаг байх.

7 Ю. Цэдэнбал гуайд алдаа байсан уу ?

Д С: Ю.Цэдэнбал Монголын төр засгийг дөч гаруй жил удирдах хугацаанд зарим зүйлд алдаж байсан байх. Арван хуруу тэгш хүн байгаагүй нь үнэн. Цэдэнбалын гаргасан хамгийн харамсмаар том алдаа нь баруун хилийн асуудлаа гарсан шийдвэр болов уу гэж боддог. БНМАУ ба Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Хобоот Улс (ЗСБНХУ)-ын хилийн шугамыг 1957 онд тодотгож тогтоох үед Увс аймгийн хойд талаархи хилийн шугамыг тогтооход маргаан гарчээ. Монголын Гадаад Явдлын Яамны сайд байсан Аварзэд гуай хэлэлцээрт Монголын төлөөлөгчдийг ахлаж хилийн шугамыг нилээд хойгуур тогтоох санал дээрээ хатуу зогсож байсан юм билээ. Тэр хүн Засгийн газрынхаа удирдамж дагуу ажилласан л байж таарна.

Хэлэлцээрийн явц, дүнг мэддэг зарим хүн, тухайлбал бүх насаараа Монголынхоо хилийн асуудлаар ажилласан генерал Цэдэн-Иш гуайгаас тэр үед чухам юу болсныг асуухад: “Хоёр талын санал зөрж, олон удаа хэлэлцээ хийсэн боловч тохиролцоонд хүрч чадахгүй мухардмал байдалд хүрсэн. Тэгэхэд Зөвлөлтийн төлөөлөгчдийн гишүүн нэг ахмад хүн санал ийм зөрөөтэй байх нөхцөлд хоёр талын санал болгож буй шугамуудын дундуур нь хил тогтоон тохиролцож болдог гэсэн санаа хэлсэн. Тэр санааг өлгөн авч тохирох нь зөв байсан. Гэвч Аварзэд сайд зөвхөн өөрийн талын санал дээрээ хатуу зогссон. Тэр нь ЗХУ-аас Монгол улсад сууж байсан Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд В.Молотов хилийн хэлэлцээрийн явцад хутгалдан оролцох завшаан болсон. В.Молотов шууд Ю.Цэдэнбалд хандаж дарамт үзүүлэн хатуу шаардлага тавьсны гайгаар Аварзэд сайд ажлаасаа халагдаж, Зөвлөлтийн талын баримталж байсан саналаар хилийн шугам тогтоогдоход хүрсэн гэж яригддаг юм билээ. Тэр хэлэлцээрт

би шууд оролцоогүй юм” гэж Цэдэн-Иш гуай ярьж байсан.

Хойд хилийн асуудал хэр шударгаар шийдэгдсэн болон нарийн учир шалтгааныг би мэдэж чадаагүй байгаа. Хэлэлцээр чухам яаж явагдсаныг сайн мэддэг хүмүүс байгаа. Ямар боловч монголчууд эрт дээр үеэс амьдарч эзэмшиж байсан хэсэг нутгаа, ашиглаж байсан Давст гэж нэрлэдэг чулуун давсны их баялаг нөөцтэй уулаа алдах тэр хэлэлцээрийн нөхцлийг хүлээн зөвшөөрөхөөс өөр ямар ч аргагүй байсан гэдэгт эргэлзмээр байдаг юм. Аварзэд сайд уян хатан байж хоёр талын сонирхлыг тэнцвэржүүлсэн санал бодлоор хэлэлцээр явуулж чадаагүй байж болох. Гэвч тэр нөхрөө тууштай хамгаалаагүй, хашир хахир Молотовын шахалтад орж хэлмэгдүүлсэн юм биш үү гэсэн эргэлзээ төрдгийг нуух юун.

Миний нэг нөхөр Увс аймгийн Давст уулаар нэрлэгддэг Давст сумын уугуул дөрвөд үндэстэн хүн бөгөөд бид хоёр өөр өөрсдийн төрсөн нутаг усны тухай ярина. Нас ахисан нөхөр маань өвөг дээдсийнхэн нь болон өөрийн нь төрсөн бууц, хонь хариулж өссөн нутаг нь хилийн цаана гарчихсан учир одоо нутагтаа очоод төрсөн бууц дээрээ очиж чадахгүй болохоор дурангаар хараад ирдэг болсон гэж ярьж онигор нүд нь нулимсаар чийгтэн суухыг нь хараад харамсдаг.

Тэртээ 40 гаруй жилийн өмнө маргаж байсан боловч, дарамтлагдаж зөвшөөрөхөд хүрч тогтоогдсон байж болох Монгол Оросын хилийн шугамыг шалгах нэртэй ажил олон жил үргэлжилж, энэ 2002 онд олон боть зураг актуудаар баталгаажуулагдаж байгаа юм билээ. Манай талаас улсынхаа хил, түүний түүх үндэслэлийг сайн мэддэг, хилийн шугам шалгаж зөв тогтоох ажлыг хариуцан гүйцэтгэх чадвартай хүмүүс удирдаж оролцсон биз.

Харин, манай төр засгийн удирдагчид 1961 онд урд их хөрш БНХАУ-тай хэлэлцээр хийж Монгол-Хятадын олон мянган км хилийн шугамыг шударгаар тогтоох асуудлыг богино хугацаанд амжилттай шийдвэрлэсэн юм билээ. Олон улсын болон хоёр орны харилцааны тухайн үеийн нөхцөл байдал болон цаг хугацааг оновчтой зөв сонгосон ухаалаг алхмуудыг хийсний үр дүнд Монгол-Хятадын хилийн хэлэлцээр амжилттай болсон байдаг. Түүнд Ю.Цэдэнбал гуай их үүрэг гүйцэтгэсэн болно. Одоо бид хөрш хоёр улстайгаа олон зуун жилийн сорилтоор нэгэнт зөвшилцөн тогтоосон хилээрээ хиллэн, эв найрамдалтай харилцаж, тусгаар тогтнол аюулгүй байдлаа баталгаажуулж байх учиртай.

Ю.Цэдэнбал олон хүнийг хэлмэгдүүлсэн гэж ярьдаг хүмүүс бий. Би хамгийн анх удаа 1964 онд МАХН-ын Төв Хорооны Бүгд хуралд оролцож, улс төрийн амьдрал тэмцэлтэй нүүр тулж билээ. Намын Төв Хорооны тэр Бүгд хурал болон дараа жилийн бүгд хуралд зарим нөхөд Монгол улсын хөгжил удаан байна, энэ нь Ю.Цэдэнбалын бодлого, үйл ажлын, үүний

дотор гадаад бодлогын буруугаас болж байна гэж ширүүн шүүмжилж байсан юм. Тэдгээр нөхөд Ю.Цэдэнбалыг албан тушаалаас нь өөрчлөх зорилготой, одоогийн хэллэгээр бол албан тушаалын төлөө тэмцэж байсан санагддаг. Зарим нэг нь Ю.Цэдэнбалыг огцруулж оронд нь гарах санаархалдаа тэр үеийн ЗХУ-ын удирдлагаас дэмжлэг хүсч байсныгаа хүлээж байхыг би лав сонсож суусан юм даг.

МАХН-ын Төв Хорооны тэр Бүгд Хурал дээр Төв Хорооны ихэнх гишүүд нь Ю.Цэдэнбалыг дэмжиж байсан бөгөөд тэдний дэмжлэг нь ая тал зассандаа биш итгэл үнэмшилдээ тулгуурлаж байсан, тэр нь илт мэдрэгдэж байсан болохоор тэмцэл өрнүүлсэн нөхөд буруутаж арга хэмжээ авагдсан нь тодорхой. Өөрсдөө ч тэр үед буруугаа хүлээж байсан юм.

МАХН-ын Төв Хорооны 1964, 1965 оны Бүгд хурлууд Ц.Лоохууз, Б.Нямбуу, Б.Сурмаажав болон Л.Цэнд нарын асуудлыг хэлэлцэж, хурц шүүмжлэл тэмцэлтэй болсон бөгөөд би анх удаа тийм хурлуудад оролцож байгаа, ямар ч туршлагагүй байсан болохоор ажиглах төдий л байсан.

Орчин үед улс төрийн намуудад хуваагдан талцаж, төр засгийн эрх авах, албан тушаалын төлөө заримдаа худал амлах, гүтгэх зэргээр эрээ цээргүй тэмцэлдэж, өрсөлдөгч нам, хүч, хүмүүсийн нэр төрийг гутаадаг, сонгуульд ялсан улс төрийн хүчин нөгөө намын харъяаллын хүмүүсийг хомроглон ажил амьдралаас нь салгадаг болсонтой зэрэгцүүлж бодоход МАХН-ын Төв Хорооны 1964, 1965 оны Бүгд хурлуудын шийдвэрийг гайхаад баймааргүй, буруутгагдаж байсан хүмүүсийг бараг л үндэсний баатар болгох шахам ярьж байгаа нь утга учир бага шиг санагддаг. Тэр үед нэг намын системийг өөрчлөх, одоогийнх шиг хэлбэрээр ардчилал хөгжүүлэх, зах зээлийн эдийн засгийг бий болгох тухай ярьж тэмцэж байсан гэвэл бүр ч худал юм болно. Улс төр гэдэг бохир тоглоом гэж ярьдаг үнэн бол тэр үнэн урьд байсан, орчин үед арай ч илүү бохирдсон тоглоом болоод байгаа болов уу. Харин буруутгагдсан нөхдийн гэр бүл, ах дүү, хамаатан садан, найз нөхөд, танилууд болох гэмгүй олон хүнийг ажил амьдралаар нь хомроглон хохироож байсныг зөвтгөж хэрхэвч болохгүй. Тийм алдааг зөвхөн шүүмжлээд зогсохгүй, ямар нэг хэлбэрээр орчин үед давтахгүй байх нь чухал юм даа.

Хорьдугаар зууны дал орчим жилд нь дэлхийн улс орнууд социалист ба капиталист гэсэн хоёр бүлэглэлд хуваагдаж, үзэл суртлын хоёр туйлшралд автагдан өрсөлдөж тэмцэлдэж байлаа. Тэр их өрсөлдөөн тэмцлийн гадна үлдэж, аль нэг хүчирхэг улсын нөлөөнд нь автагдахгүй байж чадсан улс орон байгаагүй байх. Монгол улсын хувьд социалист гэж байсан системд хамрагдахаас өөр ямар ч орчин нөхцөл хүйтэн дайны үед байгаагүй. Тийм учраас Монгол улс ЗХУ-аас хараат улс болсон

байсныг түүхэн зайлшгүй нөхцөл байсан гэж үзэх нь зөв, түүний төлөө хэн нэгэн монголын удирдагчийг, үүний дотор Ю.Цэдэнбалыг буруутгах гэж оролдох нь утгагүй гэж бодогддог.

Тухайн түүхэн нөхцөлд жижиг улс орны хувьд ойр дотно байж, түшиж явах түнш улс орныг зөв сонгоход ухаалаг хандах шаардлага зайлшгүй байсан бөгөөд энэ асуудлаар Ю.Цэдэнбалын явуулж байсан бодлого зөв оновчтой байсан, тухайлбал тэр үед ЗХУ-тай хамгийн ойр дотно харилцаатай байснаас Монгол улс алдаагүй, харин хожсон гэж боддог. Социалист систем задарч, хүйтэн дайны тэмцэлдээн арилж, дэлхийн улс орнуудтай адил тэгш харилцах бололцоо бүрдсэн орчин үеийн нөхцөл дэх үзэл бодлоор 1990 ноос урьдах олон арван жилийн түүхэнд тэр үеийнх нь нөхцөл байдлыг харгалзаагүй үнэлэлт өгөх гэж оролдвол буруутаж таарна.

Орчин үед Монгол улс хоёр их хөрш улсуудтайгаа адил тэгш харилцаж, найрсаг харилцаа, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх шинэ аятай нөхцөл бололцоо бүрдсэн бөгөөд ийм бодлого амжилттай хэрэгжиж байна. Жараад оны эхэнд ЗХУ болон БНХАУ хоёулаа социалист системийн улсууд боловч хоорондоо үзэл бодлын зөрчилтэй, харилцаа нь муу байсан бөгөөд БНХАУ-ын тэр үеийн зарим удирдагч нь БНМАУ-ыг Хятад улсын бүрэлдэхүүнд байх ёстой, бие даасан тусгаар улс байхыг нь зөвшөөрөхгүй гэсэн санааг дэлхийд ил хэлж ярьдаг, Монгол улсын нутгийг Хятад улсын нутгийн хэсэг болгож хэвлэсэн газрын зураг сургуулийн сурах бичигт оруулдаг үе байсан.

Ю.Цэдэнбал гуай Монголын төр засгийн удирдлагад 1984 он хүртэл ажиллаж байхдаа социализмын замаар Монголоо хөгжүүлж болно гэдэг үзэл бодолдоо хатуу итгэсэн хэвээр л байсан. Тэр төвлөрсөн төлөвлөгөөт удирдлагыг эрхэмлэж байсан. Төрийн өмч гэсэн өмчийн нэг хэлбэр давамгайлж байх нь зохистой гэсэн үзэл бодлынхоо дагуу хувийн өмчийг, үүний дотор малчдын хувийн өмчийн малыг хязгаарлаж байх ёстой гэсэн санал дээрээ хатуу зогсдог байж билээ. Тэр ард түмний амьдралд муу нөлөөлнө гэж үзэж үнэ өөрчлөх, нэмэх, чөлөөлөх аливаа саналыг зөвшөөрдөггүй, түүнээс их болгоомжилдог байсан юм. Тэр улс төрийн намуудын хувьд бол нэг намын тогтолцоо зөв, МАХН бол удирдан чиглүүлэх гол хүч гэх үзлийг хатуу баримталсан хэвээр байсан. Энэ бүхэн үнэн бөгөөд одоогийн нөхцөлд бүрэн эсрэг үзэл баримтлалаар эдгээр асуудалд ханддаг болоод байна.

Хэрэв Ю.Цэдэнбал наяд оны хоёрдугаар хагас, ерээд оны эхэнд Монгол улсын төр, засгийн удирдлагад байж ЗХУ-д өрнөсөн өөрчлөн байгуулалтын үед хөдөлмөрлөж байсан бол бусдын адил үзэл бодлоо өөрчлөх байсан нь мэдээж. Тийм учраас ажиллаж, амьдарч байсан

тэр цаг үедээ улс орныхоо төлөө гэсэн үзэл бодолдоо итгэж, үнэнчээр хөдөлмөрлөж байсны нь төлөө тэр хүнийг өнөөдрийн өндөрлөгөөс ад үзэж болохгүй.

Бидний монголчууд заримдаа хүний мөс чанаргүй үйлдэл хийдэг. МАХН-ын Төв Хорооны 1984 оны Бүгд хурлын Ю.Цэдэнбалын гавьяа зүтгэлийг магтаж дүгнэсэн илтгэл, 1989 оны Бүгд хурлын Ю.Цэдэнбалыг адалж буруутгасан илтгэл хоёрыг зэрэгцүүлж уншихад тэдгээр илтгэлүүдэд хоёуланд нь санал өгч, батлалцаж байснаа бодоход: би ямар хүн билээ гэж өөрөөсөө асуух хэрэг гардаг. Цаг хугацааны эрхээр юм юм өөрчлөгдөнө. Хүний үзэл бодол ч өөрчлөгдөнө. Гагцхүү хүний мөс чанараа алдахгүй, амиа бодож нөхрөө золиослохгүй байх сэтгэл дутдаг бололтой. Учир шалтгааныг бусдаас биш, өөрөөсөө эр гэсэн үг байдгийг үргэлж санаж явмаар.

Ю.Цэдэнбал гуай амьдралынхаа сүүлийн жилүүдийг эх орноосоо хол, Москва хотод өнгөрөөж, тэнд насан эцэслэсэн. Тэр хүн өөрөө Монголынхоо тэнгэрийг харж, агаараар нь амьсгалж, усыг нь ууж, байгалиа шимтэн харж, монголчуудынхаа дунд байх юмсан гэж санаж мөрөөдөж байсан байхдаа гэж бодоход үнэхээр ерөвдмөөр. Олон арван жил төр засгийг толгойлж байсан хүн маань өндөр хариуцлага хүлээж ажиллах ёстой албыг хаших чадваргүй болсон байхад, хэдийгээр хүндэтгэж хайрлаж байх ёстой боловч, улс орны ашиг сонирхлын үүднээс ажлаас нь чөлөөлөх шийдвэр гаргаж байсан нь аргагүй зөв байсан.

Харин Ю.Цэдэнбалын ажлын чадвар доройтсоныг олон түмэн мэддэггүй, одоогийнх шиг удирдах хүмүүсийн талаар олонд мэдээлдэггүй байсан болохоор мэдэх аргагүй байсан. Гэтэл зарим хүн Ю.Цэдэнбалыг хүмүүс хуйвалдаж ажлаас нь зайлууллаа гэсэн худал яриа гаргаж байсан юм. Ийм нөхцөл байдлаас болж Ю.Цэдэнбал гуайг 1984 оны наймдугаар сараас хойш хэсэг хугацаанд Монголд ирүүлэхээс болгоомжилж байсан нь үнэн.

Хэрэв Ю.Цэдэнбал гуай эрүүл, саруул, хамгийн гол нь түүний хажуугийн хүн буюу эхнэр А.И.Филатовагийн нөлөөнд бүрэн орчихоогүй байсан бол ажлаас нь өөрчлөх болон түүний дараах асуудлыг шийдэхэд хялбар, болгоомжлол бага гарах байсан гэж бодогддог юм. Ю.Цэдэнбал гуай өөрөө “Миний оронд Ж.Батмөнхийг томилох нь зүйтэй!” гэж бичээд өгсөн хуудсыг эхнэр А.И.Филатова нь хажуугаас нь булаан авч урж, устгаж байсан баримт байдаг юм. А.И.Филатовагаас нууж байж дахин бичиж өгсөн хуудас нь одоо МАХН-ын архивт хадгалагдаж байгаа.

Ю.Цэдэнбал гуайнх Москва хотын төвд тохилог орон сууцтай, эхнэр хүүхдүүд нь бүгд ЗХУ-ын харьяат, хоёр хүү нь тэндээ ажил хийдэг байсан бөгөөд 1985 онд даргын хувийн хадгаламжинд нь байсан бүх мөнгийг

гуйвуулж авсан байсан. Ю.Цэдэнбал гуай гэр бүлийнхээ бүх гишүүдийн хамт Москва хотод амьдрах бодолтой, нөхцлөө хангасан байсныг энэ бүхэн харууллаа. Эх орондоо түр ирээд буцах боломж байсан бөгөөд тэр боломжийг ашиглаж байсан. Ийм учраас Ю.Цэдэнбал гуайг бараг зориуд харийн нутагт хориод байсан юм шиг ойлгож болохгүй.

Эхнэр хүүхдүүд нь хэзээ ч Монголын харьяат иргэн байгаагүй, манай улсын хуулиар Монголын иргэн хоёрдмол иргэн байхыг зөвшөөрдөггүй байсан. Одоо ч тийм. Харин түүний эхнэр хүүхдүүдэд Цэдэнбал гуайтай хамт гадаад улсад айлчлахад нь ашиглуулах зорилгоор монголын гадаад дипломат паспорт олгогдсон байж таарна.

8 Ардчилсан хөдөлгөөний эхлэл.

КЮ: 1990 онд Монгол оронд Ардчилсан хөдөлгөөн эхэлсэн. Ардчилсан хөдөлгөөний залуучууд Сүхбаатарын талбай дээр өлсгөлөн зарлаж, МАХН-ын ТХ-ны УТТ-г бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорхыг шаардаж байв. Та тэр үед болсон үйл явдлуудын талаар дурсамжаа бидэнтэй хуваалцана уу?

Д С: Монгол улс улс төр, эдийн засгийн хуучин системээ хэрхэн өөрчилж шинэчлэхийг тухайлбал аажим эсвэл огцом аргаар өөрчлөхийн аль нэгийг сонгох шаардлага чухам 1989 оноос хурц тавигдах болсон билээ. Социализм байгуулж байсан улсуудад өрнөж байсан огцом өөрчлөлтийн нөлөө манайд орж ирж байлаа.

МАХН-ын Төв Хорооны ээлжит бүгд хурал 1989 оны 12 дугаар сард болж улс төр, эдийн засгийн системийн өөрчлөлт шинэтгэлийг эрчимжүүлэх асуудлыг хэлэлцэв. Намын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга Ж.Батмөнх гуай илтгэл тавьж хэлэлцүүлээ. Би эдийн засгийн системийг өөрчилж, зах зээлийн эдийн засгийг бүрдүүлэх асуудлаар өөрийн бодол саналыг бүгд хуралд хэлсэн үгэндээ илэрхийлсэн юм.

МАХН-ын Төв Хорооны тэр бүгд хуралд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн даргын хувьд хэлсэн үгийнхээ гол санааг товчлон авбал:

-Эдийн засгийн системийн өөрчлөлт шинэчлэлтийн ажлын далайц хангалтгүй, тавьсан зорилгод хүрэх тодорхой арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх ажил удаашралтай байна. Чухам ямар арга замаар эдийн засгийн системийн өөрчлөлтийг түргэтгэх эрчимжүүлэхийг ухаалгаар хэлэлцэж шийдэх хариуцлагатай үе болоод байна.

-Онол практикийн олон асуудлаар тодорхой чиг, нэгдсэн ойлголттой болж, нэгдмэл үйл ажиллагаа хангаж, ажлаа эрчимжүүлэх нь зүйтэй

юм. Эдийн засгийн хүрээнд юуны өмнө хоёр үндсэн асуудлыг шийдэх шаардлагатай. Нэгдүгээрт, өмчийн олон хэлбэрийг хөгжүүлж, өмчийн харилцааг боловсронгуй болгох. Хоёрдугаарт, нийгмийн гишүүдийн өндөр үр ашигтай хөдөлмөрийг өрнүүлж байх эдийн засгийн шинэ механизм, шинэ нөхцлийг бий болгох. Эдгээрийг шийдсэнээр хүмүүсийн идэвх үр бүтээлтэй хөдөлмөрийг өрнүүлж, нийгэм, хамт олон, хувь хүний ашиг сонирхлыг зөв хослуулж ойртуулахад байнга үйлчилж байх аж ахуйн харилцааны систем бүрэлдэн тогтоно.

-Өмч, өмчийн харилцаанд оршиж ирсэн гажуудлыг арилгаж, баримталж байсан үзэл онол, хэрэгжүүлж ирсэн практиктаа өөрчлөлт оруулахаас өөр аргагүй. Өмчийн олон хэлбэрт адил нөхцөл тогтоож, төрийн өмчийг өрсөлдөөнөөс чөлөөтэй, дархалсан эрхтэй байхаас ангижруулах ёстой.

-Хөдөлмөрчдийн нийгэм, эдийн засгийн сонирхол, идэвх санаачлага, аж ахуйч байдлыг өрнүүлэхэд нөлөөлж болох өмчийн аливаа хэлбэрийг дэмжин хөгжүүлэх чиглэлийг удирдлага болгох нь зүйтэй.

-Улсын, хоршооллын, хувийн, амины гэх мэт өмчүүдийн байж болох хэлбэрүүдийн талаар, мөн өмчийн хөдөлгөөн хувирал, тэгш эрхээр хангах зарчим зэрэг асуудлыг хуульчилж өгөх хэрэгтэй байна. Эдгээрийн дотроос тодорхой шийдвэр яаралтай гаргах ёстой асуудал бол өмчийн асуудал.

-Жижиг үйлдвэрлэл өвөрмөц давуу талтай. Жижиг үйлдвэрлэл хөгжүүлэхэд хоршооллын болон хувийн өмч илүү тохиромжтой. Үйлдвэрлэлийн хэрэгслийг иргэд хувьдаа гэр бүлээрээ өмчлөн жижиг үйлдвэрлэл, аж ахуй эрхлэхийг дэмжих нь зүйтэй. Бусдын хөдөлмөрийг мөлждөггүй, олсон хуримтлалынхаа зохих хэсгийг улсын санд оруулж байдаг нөхцөлтэйгээр хувийн өмчийг хөгжүүлэх нь зүйтэй.

-Өмчийн тухай тусгай хуулийг ойрын үед боловсруулж, нийт олноор хэлэлцүүлж гаргахаар төлөвлөж байгаа болно. Түүнчлэн гадаадын хөрөнгийг оруулах, хамгаалж байх асуудлаар тусгай хууль гаргах нь зүйтэй гэж үзнэ.

-Эдийн засгийн шинэ механизм бий болгох ажил эхлэлтийн шатандаа байна. Энэ шатанд ажил маань төвлөрсөн төлөвлөлтийг зах зээлийн механизмтэй яаж хослуулах аргыг эрэхэд чиглэж байна. Зах зээл, төвлөрсөн төлөвлөгөөт удирдлага хоёрыг сөргүүлэн тавих хэрэггүй. Улс орон ард түмний хэрэгцээг хангах, улсын нөөц бүрдүүлэх, зах зээлийн тэнцвэр хангахад шаардагддаг үндсэн зүйлийн балансыг улс гартаа барьж байхаас өөр аргагүй. Хөрөнгө оруулалт, татварын нэгдсэн бодлого, мөнгөн хөрөнгийн хөдөлгөөн зэргийг улс төвлөрүүлэн зохицуулж байх шаардлагатай. Хууль тогтоомжийн дагуу аж ахуйн үйл ажиллагааг зохицуулж байх үүргээсээ улс зайлсхийж болохгүй. Гэхдээ бие даасан үйл

ажиллагааг хангах, энэ шаардлагын дагуу төлөвлөлтийн аргад өөрчлөлт оруулах зүй ёсны шаардлага тавигдаж байгаа нь зөв.

-Зах зээлийн системийг бий болгож тэнд үйлдвэрлэгч хэрэглэгч хоёрыг шууд уулзаж харилцдаг нөхцөл бий болгох саналыг би зөв гэж үздэг. Юуны өмнө хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээл бий болгох асуудлыг шийдэх нь зүйтэй. Эхний үед бараа хангалтын тэнцвэр алдагдах, зайлшгүй хэрэгцээг өндөр үнээр хангах зэрэг бэрхшээл гарахыг ойлгож, давж туулахаас аргагүй. Улсын даалгавар, хатуу хяналт, хуваарь, хатуу үнийн системийг байлгаад байвал зах зээл бүрдүүлэх зорилт бүтэхгүй. Зах зээлийг аажим аажмаар өргөтгөнө. Үйлдвэрлэлийн хэрэгсэл, санхүүгийн зах зээлээр зогсохгүй мэдээлэл, шинжлэх ухаан, техник, ажиллах хүчний зах зээл гарч ирэхэд бид бэлэн байх ёстой. Зах зээлийг улс оновчтой зохион байгуулж хөгжүүлэх нь зөв.

-Өмчийн олон хэлбэр, зах зээлийг хөгжүүлэхэд үнэ бүрдэлтийг боловсронгуй болгох ажил маш чухал. Уламжилж ирсэн буруу түвшин, буруу харьцаатай, үнийг иргэдийн бодит орлогыг бууруулахгүйгээр өөрчлөхийг даруй шийдэх саналыг дэмжиж байна. Хатуу тогтоосон, дээд доод хязгаартай болон чөлөөт гэсэн үнийг хэрэглэн аажмаар чөлөөт үнийн системд шилжиж байгаа туршлага сонин. Зах зээлийн механизмыг үнэ үндэслэлгүй өсгөдөг хэрэгсэл болгохгүйн тул өрсөлдөөнийг хөгжүүлэх, үйлдвэрлэгчийн ноёрхол арилгах ажлыг хамтад нь зохиоё. Үүнтэй холбогдуулж зарим томхон үйлдвэр аж ахуйн газрыг хэд хэдэн жижиг үйлдвэр болгон өөрчлөх боломжийг авч үзье. Жижиг үйлдвэр хөгжүүлэх ажлыг шуурхай хэрэгжүүлье.

-Хөдөлмөрлөж бүтээснийхээ хэрээр хэрэглэх ёстойг бүгд мэдэж амьдрах аж ахуйн механизм үйлчилж байх хэрэгтэй юм.

-Малчид тариаланчид маань аж ахуйтайгаа гэрээ байгуулж үндсэн хөрөнгийг түрээсээр авч ажилладаг болж эхэлснээс хойших богино хугацаанд тооцоо нэвтрүүлэх, үр бүтээлтэй хөдөлмөрлөх, нөөцөө дайчлах, аривлаж хэмнэх хөдөлгөөн урьд хэзээ ч байгаагүй хэмжээ далайцтай өрнөж байна. Бодит үр дүн гарч байна. Ийм учраас аж ахуйн бүх салбарт гэрээ түрээсийн боловсронгуй арга хэлбэр, түүний норм норматив, үнэ үнэлгээ зэргийг боловсруулж нэвтрүүлэх ажилд цаг алдахгүй орох хэрэгтэй байна. Ийм гэрээг аль болох урт хугацаагаар байгуулж тогтвортой мөрдөх нь чухал.

-Улсын хөрөнгө оруулалтаар бүрдсэн үндсэн хөрөнгөнд төлбөр оногдуулдаг, ашигт ажиллагааны түвшинг гүйлгээний татвараар зохицуулдаг байхын зэрэгцээ олон нэр хэлбэрийн татвар төлбөр байгааг цэгцэлж орлого ашгаас авах цөөн тооны татварын нэгдсэн систем бий болгох нь зүйтэй. Аливаа татвар төлбөрийн норм хэмжээг удаан

хугацаанд хөдөлбөргүй дагаж мөрдөхөөр хуульчилж баталдаг байх хэрэгтэй гэж үзэж эдгээр чиглэлээр санал боловсруулж байгаа. Үүндээ ашиг хувиарлах аргыг аль алиныг нь хэрэглэх нь зүйтэй гэж үзнэ. Иргэдийн орлогод оногдуулдаг татварын системийг өөрчлөх хуулийн төслийг 1990 оны эхний хагаст олон түмнээр хэлэлцүүлж санал авч батлан гаргах болно.

Дээрхи зүйлийг ярьж эцэст нь, би зарчмын гэж маргаж байсан нэг асуудлаар өөрийн үзэл бодлоо шууд тодорхой хэлсэн байдаг юм. Миний хэлсэн тэр санал: “Манай зарим нөхөд хэвлэлээр дамжуулан эдийн засгийн төлөвлөгөөт удирдлагын аргаа шууд орхин зах зээлийн механизмд шууд шилжье. Бүх төрлийн үнийг хяналтгүй чөлөөтэй болгоё гэсэн санал гаргаж байгаатай би одоогоор санал нийлэхгүй байгаагаа шууд хэлэх ёстой. Учир нь, ийм аргаар эдийн засгийг өөрчлөхөд хүрвэл нийгэм улс төрийн тогтворгүй байдлын нөхцөл бүрдүүлнэ. Төгрөгийн худалдан авах чадвар эрс буурч ард түмний амьдралд шууд нөлөөлнө. Үйлдвэрлэгчид зөвхөн үнийн хөөрөгдлөөр ашиг олоод эхэлнэ. Олон үйлдвэр аж ахуйн газар дампуурна. Улс орон даяар аж ахуйн харьцаа алдагдана. Ийм аюул байгаа учраас нэг хязгаар луу туйлширч, төлөвлөдөг механизмаа гэнэт орхиж зах зээл рүү бодлого зохицуулалтгүй гэнэт хэлбийж ороход юунд хүргэж болхоыг анхаарах хэрэгтэй. Эдийн засаг, нийгэм, улс төрийн шийдвэрлэх олон асуудал байна. Түүнд цаг хугацаа хэрэгтэй. Гэнэт бүтэж, гэнэт үр дүн нь гардаг ид шидтэй зүйл биш, харин ээлж дараагаа олсон олон талын арга хэмжээ, ухаалаг тодорхой үйл ажиллагааны үндсэн дээр алхам алхамаар эв зүйгээ олж, тууштай үр дүнд хүрэх ажил юм”.

Тэр бүгд хурал дээр миний хэлсэн үгийн товч агуулга нь ийм юм. Үүний дараа үйл явдлууд маш хурдан өрнөж байв. Удалгүй 1990 оын 3-р сард МАХН-ын Төв Хорооны Бүгд Хурал хуралдав. Энэ бүгд хурал дээр манай намын удирлагад ажиллаж байсан нөхөд чухам хэн нь хэн бэ гэдэг талаар сайн ойлголттой, ёстой л хэнтэй нөхөрлөж болох, болохгүй гэдэгт өөр өөртөө дүгнэлттэй болцгоосон санагддаг.

МАХН-ын Төв Хорооны 1990 оны 3-р сард болсон Бүгд хурал:

- Цаг үеийн байдал, түүнээс хийх дүгнэлт,
- МАХН-ын онц их хурал хуралдуулах тухай,
- Зохион байгуулалтын асуудал гэсэн асуудал хэлэлцэв.

Улс төр, эдийн засгийн системийн өөрчлөлтийн чиг баримжаа бүрэн тодорхой биш, удаан явцтай байгаа нь үнэн гэдгийг Бүгд Хурал хүлээн зөвшөөрсөн юм. Тэр бүгд хурал дээр гадаад өрийн асуудлаар болсон яриа үйлдэл санаанаас гардаггүй юм. Өнгөрсөн 70-аад жилд ЗХУ-аас Монгол улс их хэмжээний зээл авч өрөнд орсны буруутанг тодруулах санаа гарч ирлээ.

Гэтэл бага насандаа хамт сурч байсан итгэж явдаг нэг нөхөр маань Монголыг гадаад зээлийн их өрөнд оруулсан буруутан бол Д.Содном мөн, би түүнд хамаагүй гэх маягийн юм хэлдэг, ярьдаг байна. Дараахан нь “Чи Монголыг Улсын Төлөвлөгөөний Комисст байхдаа хэд, Сайд нарын Зөвлөлд очсон хойноо хэдий хэмжээний гадаад зээлийн өрөнд оруулсан бэ?” гэж бичсэн асуулт надад ирлээ. Хурал завсарлах үед бэлтгэж тэр асуулгад доорхи хариу өглөө:

“Би Улсын Төлөвлөгөөний Комисст орлогч дарга, даргын албан тушаалд 1969 оноос, Сайд нарын Зөвлөлийн даргаар 1984 оноос ажилласан. Монгол улс 1970-1985 онд 5 тэрбум, 1985-1990 онд 3,5 тэрбум шилжих рублийн зээл тусламжийг Зөвлөлт Холбоот Улсаас авч ашигласан. Энэ бүх зээл тусламж манай улсын эдийн засгийн хүч чадлыг бэхжүүлэх, нийгмийн асуудлыг шийдэхэд зориулагдсан. Ийм зээл тусламжийн ачаар 1975 оноос 1989 онд гарсан өөрчлөлт, бүтээгдсэн зүйлийг зэрэгцүүлж товч танилцуулбал:

- Нүүрс олборлох хүчин чадал 3,2 сая тонноос 8,2 сая тонн болсон.
- Цахилгаан станцуудын суурьлуулсан хүч чадал 266 мегаватт байснаа 890 мегаватт болж нэмэгдсэн.
- Энэ хугацаанд “Эрдэнэт” болон “Монголросцветмет” хамтарсан үйлдвэр байгуулагдаж манай экспортын эх үүсвэрийг эрс нэмсэн.
- Хотуудыг сүүгээр хангадаг үнээний механикжуулсан фермүүд 10 сая литр сүү үйлдвэрлэдэг байсан бол 42 сая литр сүү өгдөг болсон.
- Үр тариа хадгалдаг элеваторууд 200 мянган тоннын багтаамжтай байсан нь 409 мянган тонн болжээ.
- Услалтын систем бүхий тариалангийн талбай 7 мянган га байсан нь 35 мянган га болсон.
- Хүнсний үйлдвэрүүдийн хүч чадал 1,7-2,0 дахин нэмэгдсэн.
- Хагас сая тонн цемент үйлдвэрлэх шинэ үйлдвэртэй боллоо.
- Барилгын ханын материалын үйлдвэрлэлт 2,5-3 дахин нэмэгдсэн. Үүний дотор тоосго 85 сая байсныг 211 сая ширхэгийг, төмөр бетон эдлэл 71 мянга байсныг 215 мянган кубометрийг үйлдвэрлэдэг болсон.
- Хивс 350 мянган кв метр байсныг 2430, сүлжмэл эдлэл 880 мянган ширхэг байсныг 3100 ширхэгийг гаргаж байна.
- Малын арьс ширийг 100 хувь боловсруулж бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.
- Тусламжийн ачаар бараг бүх аймгийн төв телевиз үздэг болсон.
- Орон сууцны нийт ашигт талбай 1 сая 880 мянган метр квадрат байсан бол 4 сая 400 мянган квадрат метр болжээ.
- Ерөнхий боловсролын болон техник мэргэжлийн сургуулийн

хичээлийн байрны суудлын тоо 194 мянга байсаныг 292 мянга болгож өргөтгөсөн.

- Эмнэлгийн ор 14,3 мянга байсан бол 23,4 мянга болсон.

Энэ бүхнийг Монголын бүх иргэд мэдэж мэдэрч байдаг. Цаг бага байсан учир би тоймтой зүйлүүдээс товч танилцууллаа. Ашиглаж байгаа үндэсний орлогын нөөцөд хэрэглээний фондын эзлэх хувь бага, үүнээс болж амьдрал сайжрахгүй байна гэж шүүмжилж байгааг зөв гэж үзэхгүй байна. ЗХУ манайд зээл олгохдоо, бид зээл авахдаа хэрэглээний санд биш, эдийн засгийн суурь салбарыг бэхжүүлэх арга хэмжээнд зориулах бодлого баримталсан нь зүйтэй болсон. Харин зээлийн хөрөнгийг бүрэн үр ашигтай ашиглах, төлөвлөсөн объектыг богино хугацаанд чанартай барих, техник технологи зөв сонгоход дутагдал бий. Хэрэв энэ 15 орчим жилийн богино хугацаанд ийм их хэмжээний зээл тусламж авч дээр дурьдсан баялаг бүтээгдээгүй бол бидний амьдрал 60-аад оны хэмжээнд, түүнээс ч хүндэрсэн нөхцөлд байж болохыг бодоход илүүдэхгүй. Зээлийн өрөнд оруулсан буруутнаар хэн нэгнийг тодруулж золиослох шаардлага гараад байгаа бол тэр золиослогдох хүний нэг би болж таарна. Ийм зээл авч ашиглах, бүтээн барих асуудлыг нааштай шийдүүлэхэд их идэвх гаргаж ажилласан, үндэслэл тооцоо гаргах, итгүүлж үнэмшүүлэх, олон удаагийн гэрээ хэлэлцээ байгуулахад оролцсон хүн нь би мөн!” гэсэн хариу өгч билээ.

Энэ үед улс төрийн тогтворгүй байдал өдрөөс өдөрт нэмэгдэж, “Өөрчлөлт шинэчлэлийг хурдан хийхгүй байна!” гэж нам, төр засгийн удирдлагыг шүүмжилж, эсэргүүцэл, тэмцэл хурцадсаар байв. Бид нийгмийн амьдралыг зохицуулж залах жолоог алдах нөхцөл бүрдүүлж байсныгаа ухаарах ёстой байсан байх.

9 Хүнд үе.

Д С: 1990 онд бид нар Япон улсад айлчлал хийгээд 3-р сарын 4-нд ирсэн бөгөөд 3-р сарын 7-ны өдөр Сүхбаатарын талбайд өлсгөлөн зарлаж хэсэг залуучууд суулаа. Манай улсад урьд хэзээ ч гарч байгаагүй, тайван тэмцлийн хамгийн хурц хэлбэр, хүний амь насар дэнчин тавьсан тэр үйлдэлд хандах туршлагагүй байсан учир нам төрийн удирдлагад байсан бид бүгд тэвдэх байдалд орсон. Харин өлсгөлөнг даруй болиулж хүний амь насанд хохирол гаргахгүйн тулд бололцоотой бүхнийг хийхэд бидний сэтгэл санаа нэг байсан.

Шинэ хүч болох залуучуудаас 8-9 хүн оролцсон өлсгөлөн зарлагчид МАХН-ын монополь эрхийг болиул, Ардын Их Хурлыг тараа гэсэн хоёр шаардлага тавьж байлаа. Гуравдугаар сарын 8-ны амралтын өдөр би ажил

дээрээ байсан бөгөөд Ж.Батмөнх дарга “Их тэнгэрийн ам”-нд байдаг гэртээ дөрвөн өдрийн дараа буюу 13-ны өдөр хуралдуулахаар товлсон МАХН-ын Төв Хорооны бүгд хуралд тавих илтгэлийнхээ төсөл дээр ажиллаж байлаа.

Ийм ноцтой байдлыг хараад юу ч хийхгүй байх аргагүй санагдсан бөгөөд Ж.Батмөнх даргатай утсаар ярьж “Сүхбаатарын талбайд очиж өлсгөлөн зарласан нөхөдтэй уулзаж өлсгөлөнг зогсоох асуудлаар ярилцъя!” гэсэн санал хэллээ. Ж.Батмөнх гуай “Чи өөрөө шийд!” гэсэн хариу хэллээ. Ийм хариу аваад надтай хамт байсан Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга Д.Бямбасүрэнд “Өлсгөлөн зарлагчдыг зохион байгуулж байгаа хүмүүстэй уулзъя!” гэж санал болгож буйг Сүхбаатарын талбайд очиж хэлэхийг хүслээ. Ардчилсан холбооныхонтой холбоотой байсан Д.Бямбасүрэн маань миний саналыг зөвшөөрч тэд нартай очиж уулзлаа. Миний саналын хариуд “Аюулгүй байдлыг хангах явдлыг зохицуулахад хүнд байгаа, нөгөө талаар өргөн олонд мэдээлэх нь чухал учир тантай телевизээр уулзая!” гэсэн хариу ирүүлсэн байлаа. Засгийн газрын ордонд уулзахаар бодож телевизийн нөхөдтэй ярихад техник хэрэгсэлийг ордонд аваачихад хүнд, цаг их зарцуулах тул уулзалтыг телевизийн төвд зохиох санал гарсан. Ингээд 16 цагт телевизийн төвд очихоор тохирлоо. Би Д.Бямбасүрэнгийн хамт тохирсон цагтаа очлоо. Бид хоёр гарч явахдаа МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга, Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн орлогч дарга Ц.Намсрай даргатай дайралдаад, цуг явж уулзалтад оролцох санал хэлэхэд татгалзсан юм. Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн орлогч дарга, Намын Төв Хорооны нарийн бичгийн даргын хувьд энэ хоёр байгууллагын асуудлаар үндсэн шаардлага тавьж байгааг анхаарч уулзалт ярилцлагад оролцвол зүгээр гэсэн санаагаар түүнийг цуг явахыг урьсан хэрэг.

Өлсгөлөн зарлагчдыг төлөөлсөн нөхөд цуварч очсоор 17 цаг болж байхад Э.Бат-үүл, Б.Баабар болон бусад нөхөд уулзалтад оролцсон. Уулзалтын яриаг би эхэллээ. “Та нөхөд Монголын улс төр, эдийн засгийн системийг өөрчилж шинэчлэх арга замыг сонгох шаардлагыг маш хурц хэлбэрээр, тухайлбал, өлсгөлөн зарлаж хүний амь насаар дэнчин тавих аргаар тавьж байна. Өндөр хариуцлагатай, үр дагавар ихтэй энэ асуудлыг эв зүйгээ олж зөв шийдэж чадах эсэхээр та бид нар ард түмнээрээ дүгнүүлэх шалгалт өгөх болоод байна. Та нөхөд 2 үндсэн шаардлага, тухайлбал МАХН-ын эрхийг хязгаарлах, Ардын Их Хурлыг тараах шаардлага тавьж өчигдрийн өдрөөс өлсгөлөн зарлав. Тэдгээр шаардлагаар өнөөдөр эцсийн шийдлийг хэн нэгэн хүн гаргаж хариу өгөх эрхгүй, нам төрийн эрх барих дээд байгууллагад оруулан хэлэлцүүлж шийдүүлэх ёстойг та нөхөд мэднэ. МАХН-ын онц эрхийг хязгаарлах

талаар та нөхдийн ярьж байгаа асуудал 4 хоногийн дараа хуралдуулахаар бэлтгэж байгаа МАХН-ын Төв Хорооны ээлжит бус бүгд хурлын хэлэлцэх асуудалд тусгагдаад байна. БНМАУ-ын Ардын Их Хурлыг тараа гэж буй шаардлага, түүний үндэслэлийг 12 хоногийн дараа хуралдуулахаар бэлтгэгдэж буй Ардын Их Хурлын ээлжит бус чуулганд танилцуулах юм!” гэж яриу.

Гэтэл тэд нар “МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчоог огцруул!” гэсэн шинэ шаардлага тавьж байна гэлээ. “Намын Төв Хорооны ээлжит бус бүгд хурлаар бий болсон байдлыг хэлэлцэх учир УТТ-г огцруулахаар нэмж тавьж байгаа шаардлагыг чинь ярьж таарна!” гэсэн хариу хэллээ. “Нэгэнт бүх шаардлага чинь нам төрийн зохих байгууллагуудын дээд түвшинд хэлэлцэгдэх боллоо, үүнийг та нарт болон телевизээр олон түмэнд мэдээллээ. Ийм учраас өлсгөлөнгөө даруй зогсоохыг та нарт уриалж байна!” гэж нэмж хэлэв. Миний уриалгад тэд тодорхой хариу хэлээгүй. Ингэж бидний уулзалт өндөрлөх болсон.

Телевизэд болсон уулзалтын дараа ажил дээрээ ирэхэд Төв хороо, Засгийн газрын гишүүд, Ж.Батмөнх гуайгаас бусад удирдах хүмүүс бүгд цугларсан, телевизийн ярилцлага уулзалтыг харсан байлаа. Би тэдэнд “Телевизэд болсон уулзалтын тухай танилцуулъя!” гэв. Тэд нар “Хэрэггүй, бид бүгдийг харж, сонссон” гэж билээ. Тэр орой зарим нөхөд Сүхбаатарын нэрэмжит талбай болон Засгийн газрын ордны зүг орж ирдэг гол гудамжуудад цагдаа, цэрэг гаргаж хөл хорих санал гаргаж байсан бөгөөд “Ж.Батмөнх даргад танилцуулахгүйгээр шийдэхгүй!” гэсэн хариу өгч байв.

Маргааш нь буюу 3-р сарын 9-ний өдөр Ж.Батмөнх даргын өрөөнд МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны хурал болж УТТ бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрох шаардлагад хэрхэн хандах асуудлыг хэлэлцлээ. Ж.Батмөнх гуай МАХН-ын УТТ-ны жинхэнэ ба орлогч гишүүн хүн нэг бүрийн саналыг хэлүүлсэн. Бүх хүмүүс “Огцрох нь зүйтэй!” гэсэн бөгөөд огцрохгүй нөхцөлд цус урсах, хүний амь хохирох хүртэл тэмцэл хурцдаж магад, өлсгөлөн цуглааныг өөр замаар зогсоож намжаах аргагүй болсон, шинэ хүчний өөрчлөлт шинэтгэлийг шуурхай явуулах саналыг зарчмын хувьд буруу гэх үндэслэл байхгүйг бүгд адил ойлгож байсан юм.

Ж.Батмөнх гуай хамгийн сүүлд нь миний саналыг асуусан бөгөөд би “УТТ огцрох хэрэгтэй болсон гэдэгт эргэлзэхгүй байна, огцрохыг зөвшөөрч байна. Гэхдээ нам, төр засгийн жолоо барих үүрэг хариуцлагыг чухам ямар хүмүүсийн мэдэлд хэрхэн шилжүүлэх нь зохимжтойг бодохгүй орхиж боломгүй!” гэлээ. Гэвч би энэ талаар тодорхой санал хэлж чадаагүй, хэлье гэвч бодож боловсруулж амжсан тодорхой санал байгаагүй юм.

Ингээд 3-р сарын 9-ний өдрийнхөө үдээс хойш Ж.Батмөнх гуай телевизээр үг хэлж хэд хоногийн дараа болох намын төв хорооны ээлжит бус бүгд хуралд УТТ огцрох асуудал хэлэлцүүлэх болсоныг мэдэгдэж, өлсгөлөнг даруй зогсоож, хүний амь хохироохгүй байхыг уриалсан юм. Ж.Батмөнх гуайг мэдэгдэл хийснээс хойш оройжин телевизээр үзүүлсэн яриа хэлэлцээр явагдаж, үр дүнд нь өлсгөлөнд оролцогсод гэр орондоо харьж хурц байдал намжсан.

Ж.Батмөнх гуайн мэдэгдэлийн дараа 9-ний өдрийн орой өлсгөлөн зогсож, жагсаал цуглаан намжсан учир харьцангуй тайван нөхцлийн цөөн хоногт МАХН-ын Төв Хорооны 1990 оны 3-р сарын 13-ны өдрийн Бүгд хурлыг бэлтгэж хуралдууллаа. Бүгд хуралд Намын Төв Хорооны гишүүдээс 70 гаруй хүн санал хэлсэн бөгөөд УТТ-г огцруулах, Намын төв хорооны удирдлагыг өөрчлөх, мөн МАХН-н онц их хурал зарлан хуралдуулах шийдвэр гарсан юм. Дараа нь 7 хоног өнгөрөөд Ардын Их Хурлын чуулган хуралдаж Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн даргын үүрэгт ажлаас Ж.Батмөнхийг, Сайд нарын Зөвлөлийн даргын үүрэгт ажлаас Д.Содномыг чөлөөлөх асуудал шийдэгдсэн.

Ж.Батмөнх гуай бид хоёр эдгээр албан тушаалаас чөлөөлөгдөх асуудал тавихаа төлөвлөсөн, ярьсан байсан юм. Зарим нэг хүн бид хоёрыг тэр албан тушаалуудад үлдэх бий гэж дэмий зовж байсан бөгөөд түүнийгээ хэлж ч байсан. Тус чуулганы хуралдаанд сууж байхдаа Сайд нарын Зөвлөлийн даргын үүрэгт ажлаас чөлөөлөхийг хүсч чуулганы хуралдаанд хэлэх үгийнхээ төслийг санаа зовж байсан нөхөртөө үзүүлж, болж байна уу гэж асуун тайвшруулж байж билээ.

Намын Төв Хорооны Бүгд хурлын дараа МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн даргад томилогдсон Гомбожавын Очирбат уулзаж, Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн дарга, Сайд нарын Зөвлөлийн даргад томилохоор төлөвлөж байгаа хүмүүсийн талаар миний саналыг асуусан. Би Сайд нарын Зөвлөлийн даргад Ш.Гунгаадоржийг томилбол зүйтэй гэж боддогоо Гомбожавын Очирбатад хэллээ. Урьд өдөр нь санал асууж магад гэж бодоод Д.Бямбасүрэн, Ш.Гунгаадорж хоёртой уулзаж санал солилцож ярьж байсан юм. “Хэрэв надаас санал асуувал Гунгаадоржийг Сайд нарын Зөвлөлийн даргаар томилох санал хэлнэ. Учир нь Гунгаадорж хөдөө аж ахуй, хөдөөгийн амьдралыг сайн мэдэх бөгөөд нөхдийнхөө санал зөвөлгөөнийг авч ажиллаж чадна гэж бодож байна. Гэхдээ эдийн засаг санхүүгийн асуудлаар тулгамдах байх. Д.Бямбасүрэнгийн хувьд шууд хэлэхэд бусдын санал сонсохдоо тааруу гэж ярьдаг. Тэр нь үнэн. Харин эдийн засаг, санхүүгийн ажлыг сайн мэднэ. Иймд Сайд нарын Зөвлөлийн 1-р орлогч даргын ажилд томилох санал хэлнэ. Та хоёр хамтарч, бие биеэ нөхөж дэмжиж ажиллавал сайн байна!”

гэсэн бөгөөд тэр хоёр маань “Зүйтэй, зөвшөөрнө!” гэж хэлж байсан юм. “Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн даргад Пунсалмаагийн Очирбатыг томилох санал байгаа!” гэж Г.Очирбатыг хэлэхэд нь “Би санал нэг байна!” гэж билээ. Ардын Их Хурлын чуулганы хуралдаанаас дурьдсан томилгоог шийдсэн.

Чуулганы хуралдааны дараа Гунгаадоржид Сайд нарын Зөвлөлийн даргын ажлыг хүлээлгэж өглөө. Гунгаадорж миний хөдөө аж ахуй эрхэлсэн орлогчоор ажиллаж байсан, яам тусгай газрууд, тэдгээрийн хариуцах асуудал, ажлын арга технологийг мэддэг, засгийн газрын хэрэг эрхлэх газрын ажилтан нар болон аймаг хотын удирдлагад ажиллагсадыг таних хүн байсан учир ажил хүлээлцэхэд амар байсан.

Төр засгийн удирдах албан тушаалын ажилд олон жил зүтгэсний эцэст 1990 оны гуравдугаар сарын эцэст 57 насандаа огцрон жинхэнэ чөлөөт иргэн болсон.

10 “Ю.Цэдэнбалын тойрон хүрээлэгчид” гэгчид.

Д С: Манай шинэхэн түүхэнд үзэл бодлоор өөр болон захиргаадалтад дургүйцсэн хүмүүст 30, 40-өөд оны үед элдэв “зохиомол хэрэг” тулган хүлээлгэж олноор нь алж, устгаж байжээ. Тэр үеийн нөхцөл байдалд Монгол улсын аюулгүй байдал, тусгаар тогтнолд аюул учруулж болох үйлдэл хийгчид цөөнгүй, түүнтэй тэмцэх шаардлага байж таарна. Гэтэл хэт хавтгайрсан хардлага сэрдлэг, буруу ширүүн тэмцэл, хутган үймүүлэгч, бялдуучлагчдын харгайгаар олон арван мянган гэмгүй иргэд харамсалтайгаар хэлмэгдэж амь үрэгдсэн түүх бий.

Монголын төр засгийг 1921 оноос хойш толгойлж байсан бараг бүх хүмүүс хэлмэгдэж дууссан юм билээ. Дөч тавиад оноос алж хөнөөх аргаар хэлмэгдүүлдэг нь зогссон, харин ажил амьдралаар нь хохироох хэлмэгдүүлэлт үргэлжилсээр байжээ. 1990 онд МАХН-ын тэр үеийн удирдлагад шинээр гарч ирсэн зарим нөхдийн санаачлагаар хийгдсэн ээлжит том хэлмэгдүүлэлт болох шахсан үйлдлээс дүгнэлт хийх, сургамж авахад илүүдэхгүй.

1990 оны 6-р сард МАХН-ын Төв Хороо Бүгд хурлаа зарлан хуралдуулж “Ю.Цэдэнбалыг тойрон хүрээлэгчдийн үйл ажиллагаанд өгөх улс төрийн дүгнэлт” гэсэн асуудал хэлэлцжээ. Хоёр сарын өмнө хуралдсан МАХН-ын онц Их хурлаас байгуулсан тусгай комиссоос энэ асуудлаар илтгэл санал бэлтгэж бүгд хуралд оруулжээ. Илтгэлийн гол санаа санал нь:

-Монголд удирдлагын ганцаар захирах хүнд сурталт дэглэм тогтолцоо байсан. Түүнийг ЗХУ-аас хуулбарлаж байсан гэж дүгнэсэн.

-Түүхэнд Цэдэнбалын эзлэх байрыг тодорхойлсон бөгөөд түүндээ: Ю.Цэдэнбалын хувь нэмэр Монголын ололт амжилтанд орсон. Гэвч Ю.Цэдэнбал матеиарлын болон оюуны нөөц бололцоог бүрэн дүүрэн ухаалаг ашиглаагүй. Хэл, түүх, соёл, аж төрөх ардын ухаан, ёс заншил, монгол сэтгэлгээг хамгаалахад буруу байр суурь баримталж байсан. Монголыг ЗХУ-тай нэгтгэж нийлүүлэхийг хөөцөлдөж байсан. Улсын хилийн асуудлаар алдаа гаргаж байсныг хэзээ ч уучилж болохгүй.

-Дутагдал арилгах, улс хөгжүүлэх эрмэлзлийг мохоож хүнийг үзэл бодлын нь төлөө мөшгөж хохироодог, хүний эрх ноцтой зөрчсөн гэж дурьдаад Ю.Цэдэнбал хувь хүний хувьд социалист системийнхээ хүрээнд олон хувилбараар сэтгэж улс үндэс, ард түмний амин эрх ашигт илүү нийцтэй, илүү хүнлэг энэрэнгүй, ухаалаг ардач хувилбарыг сонгон ашиглах бололцоо байсан нь эргэлзээгүй гэж дүгнэсэн байдаг.

“Ю.Цэдэнбалыг тойрон хүрээлэгчид”-ээр тодруулсан хүмүүсээ гурван зэрэглэлд хуваасан байв. Тухайлбал:

а) Ю.Цэдэнбалд хамгийн ойр дотно байж нөлөөлж, санааг нь хамгаас урьд хэрэгжүүлж байгсад. Тэр нь С.Лувсан, Н.Лувсанравдан, Д.Майдар, Т.Рагчаа, Б.Дэжид, Б.Ламжав, Ц.Намсрай.

б) Уур амьсгалд зохицон оногдсон үүргээ чадах хирээр залгуулж, эрх тушаал хөөцөлдөхийг урьтал болгохгүй, нөхцөл байдалд зохицож байсан хүмүүс. Тэр нь Ж.Батмөнх, Н.Жагварал, Д.Моломжамц, Ц.Дүгэрсүрэн, Б.Лхамсүрэн, М.Пэлжээ.

в) Аялдан дагагчид. Гэхдээ зарим чухал асуудал дээр зөрүүтэй санал, үзэл, бодол баримталж, түүнийгээ зүрхлэн илэрхийлж байсан хүмүүс. Тэр нь Б.Содном нар гэжээ.

“Ю.Цэдэнбалын тойрон хүрээлэгчид” юугаар намын өмнө буруутай вэ? гэсэн асуудал тавьж түүндээ буруутгах 6 зүйлийг бичжээ:

-эдийн засгийн үр ашиг дээшлүүлэх доривтой ахиц гаргаагүй, өр зээл нэмэгдэн ард түмний амьжиргааны түвшин олон жил олигтой дээшлэхгүй байлаа.

-хамтын удирдлага, шүүмжлэл 1964 оноос хойш алга болсон. Санал чөлөөтэй хэлэх боломж хаагдсан.

-боловсон хүчнийг бэлтгэх, сонгох, мэргэжил боловсролыг нь дээшлүүлэх, залгамж халаа бэлтгэх ажил муу байсан.

-онолыг ойшоогоогүй, онолын сэтгэлгээг чөдөрлөсөн.

-Ю.Цэдэнбалын овилгогүй эхнэр А.И.Филатоваг нам, улс, олон нийтийн байгууллагын дотоод хэрэг, боловсон хүчний асуудалд хутгалдан ороход хүргэж, алдар цол гавьяа олгож байв.

-өөрсдөө шийд гарган бие биедээ алдар цол гавьяа шагнал хүртээж, тусгай хангамж, тусламж олгож байв.

Илтгэлд тойрон хүрээлэгчээр тодруулсан хүн нэг бүрээр дүгнэлт өгч ямар шийтгэл хүлээлгэх саналтайгаа Намын Төв Хорооны Бүгд хуралд илтгэсэн. Миний талаар дараах дүгнэлт санал хэлсэн байдаг:

“Д.Содном Сайд нарын Зөвлөлийн орлогч бөгөөд Улсын төлөвлөгөөний комиссын даргаар 10 жил, Сайд нарын Зөвлөлийн даргаар 6 жил ажиллаж эдийн засаг, нийгмийн хөгжлийн гол гол асуудлыг шийдвэрлэхэд чухал үүрэгтэй оролцож байсан хүмүүсийн нэг юм. Д.Содном энэ хугацаанд БНМАУ-ын эдийн засгийг илүү хурдацтай хөгжүүлэх боломжийг бүрэн ашиглах, эдийн засгийн гадаад харилцааны үр ашгийг дээшлүүлж, эдийн засгийн шинэчлэлтийг нийгэм улс төрийн харилцаануудтай нягт уялдуулан иж бүрэн хэрэгжүүлэх талаар идэвхи гарган тууштай ажиллаж чадсангүй. Д.Содном Ю.Цэдэнбалыг аялдан дагалдаж байсан ба эрхэлж байсан албан үүргийнхээ хувьд улс орны нийгэм, эдийн засгийн амьдралд гарсан гажуудал дутагдлын бурууг хуваалцах ёстой хүний нэг юм!” хэмээн илтгэжээ.

Бүгд хурал “Ю.Цэдэнбалыг тойрон хүрээлэгчид”-ийн үйл ажиллагаанд хийсэн улс төрийн дүгнэлт, боловсруулсан саналыг үндсэнд нь зүйтэй гэж үзжээ. Бүгд хурлын тогтоолын хоёрдугаар зүйлд “Нам төрийн дээд удирдлагад олон жил ажиллахдаа улс орны эдийн засаг, нийгэм, улс төр, оюун санааны амьдралд гарсан гажуудал дутагдлыг тухай бүр арилгахгүй улам даамжруулан хуримтлуулж, өөрсдийн байр суурь, үйл ажлаараа Ю.Цэдэнбалын ганцаар захирах хүнд сурталт дэглэмийн гэм согогийг хамгаалан гүнзгийрүүлж, нам ард түмний хүлээлгэсэн их итгэл найдварыг хангалтгүй биелүүлсэн Д.Гомбожав, С.Лувсан, Д.Майдар, Д.Моломжамц, Т.Рагчаа, 60-70-аад оны үед Намын хянан шалгах хорооны ажлын арга барилд гарсан ноцтой дутагдлыг арилгаагүйгээр барахгүй өвлөн үргэлжлүүлж, хууль ёс, намын зарчмыг зөрчиж, хүний хувь заяаг үндэсгүй хохироож байсан Б.Дэжид намын боловсон хүчний бодлогыг гажуудуулан Ю.Цэдэнбалыг аялдан дагалдаж хүмүүсийг үндэсгүй хохирооход оролцож байсан учир Б.Ламжав нарыг МАХН-ын гишүүнээс хассугай!” гэжээ.

Бүгд хурлын тогтоолын гуравдугаар зүйлд “Ганцаар захирах дэглэмийн үед манай нийгмийн амьдралд гарсан дутагдал доголдолд эвлэрэнгүй хандаж нам ард түмний өмнө хүлээсэн өндөр хариуцлагатай үүргээ хангалтгүй биелүүлсэн Ж.Батмөнх, Д.Содном, Б.Алтангэрэл, С.Лувсангомбо, П.Дамдин, Г.Адъяа нарыг МАХН-аас хасахыг сануулж, зэмлэл ногдуулсугай!” гэсэн заалт бий.

МАХН-ын Төв Хорооны 1990 оны 6-р сарын бүгд хурлаар намаас арга хэмжээ авагдсан нам, төр засгийн удирдлагад хуучин ажиллаж байсан дээрхи хүмүүсийг намын бүгд хурлын шийдвэрийн 8-р зүйлээр санал

болгосоны дагуу, мөн зохих баримт материал бүрдлээ гэж үзээд тэр оны 8-р сард Улсын Прокурор тогтоол гарган эрүүгийн хэрэгт татаж мөрдөх байцаах ажил эхэлсэн.

Д.Содномд эрүүгийн хэрэг болгож дараах 3 асуудлаар буруутгах ял төлөвлөсөн байсан:

1. Ю.Цэдэнбалын хувийн хадгаламжийн мөнгийг Орос улсад гуйвуулах зөвшөөрөл гаргаж өгсөн.

2. Насны тэтгэвэрт гарсан зарим хүмүүст тусгай тэтгэвэр тогтоож өгсөн.

3. Нам төрийн удирдах ажилтан нарын хангамжийн талаар тусгай тогтоол гаргасан.

Намайг бол эхний хоёр асуудлаар буруутан болгож яллах оролдлого хийгдсэн юм. Учир нь намайг 1984 оны 12-р сард МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны гишүүнээр томилогдохоос өмнө удирдах ажилтан нарын хангамжийн асуудлаар шийдвэр гарсан байжээ.

Надад тулгаж байсан эрүүгийн гэх хоёр асуудал нь юу байсан бэ:

1. Ю.Цэдэнбалын хадгаламжийн мөнгийг гадаадад гуйвуулах зөвшөөрөл гаргаж өгснийг прокурор Эрдэнэбаатар гэмт хэрэг гэж үзэж байсан бөгөөд түүнд нь няцаалт өгч байлаа. Ю.Цэдэнбалд 40 гаруй жил хөдөлмөрлөх хугацаандаа цалингаасаа хуримтлуулсан нэг сая орчим төгрөг байсан бөгөөд нэгэнт гэр бүлээрээ Москва хотод амьдарч байгаа учир хадгаламжийн мөнгөө гуйвуулан авч ашиглахыг хүссэн. Монгол банкинд үүрэг өгч Ю.Цэдэнбалын хадгаламжийн мөнгөний хэмжээ үндэслэлийг шалгуулаад хүсэлтийн нь дагуу хадгаламжийн мөнгийг нь гуйвуулж өгөхийг зөвшөөрсөн шийдвэрийг Сайд нарын Зөвлөл гаргасан. Шийдвэрийг буруутгах ямар ч үндэслэл байхгүй. Хэрэв Монголын хуулийн байгууллага Цэдэнбалд хувийн хадгаламжийн мөнгөө авч ашиглахыг зөвшөөрснийг буруу гэж шийдвэр гаргавал харин Монголын төр хүний эрхэд хууль бусаар халдсан хэрэг үүсч болно гэдгийг хэлж байлаа. Прокурор Эрдэнэбаатар “хүний мөнгийг гадаадад гуйвуулахад улсад эдийн засгийн хохирол учирдаг гэж ярих нь ямар учиртай вэ?” гэж асуудаг, би түүнд мөнгө гуйвуулах механизм, түүнээс улс хохирдоггүйн учрыг ойлгуулах гэж тайлбарладаг байж билээ.

2. Тусгай тэтгэвэр тогтоосныг гэмт хэрэг болгох оролдлогод нь мөн няцаалт өгч байлаа. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор 1985-1990 онд нийт 5 хүнд тусгай тэтгэвэр тогтоосон бөгөөд тэр тэтгэвэр нь сард 1400 төгрөг өгч байхаар тогтоогдсон байлаа. БНМАУ-ын тэтгэвэрийн тухай хуулиар Сайд нарын Зөвлөлд тусгай тэтгэвэр тогтоож байх эрх олгогдсоны дагуу шийдвэр гаргасаныг буруутгах хууль зүйн ямар ч үндэслэл байгаагүй. Өндөр насны тэтгэвэрийг тогтоосон хэмжээ

нь тэтгэвэрийн хуулиар шууд тогтоогддог дээд хэмжээнээс дөнгөж 140 орчим төгрөгөөр илүү юм гэдгийг, жишиггүй их тэтгэвэр байна гэж үзэх үндэсгүйг бас тайлбарлаж байсан.

Бүртгэх үнэлэх хүмүүсээс гадна гэрч нар, хэд хэдэн цагдаагийн ажилтнууд, бас кино зурагт бичлэг хийх хүмүүсийг дагуулж гэрт орж ирээд бүх эд хогшлыг бүртгэж, үнэ тогтоож акт үйлдэн битүүмжлээд, зарах ашиглах эрхгүй болохыг мэдэгдэж билээ. Верагийн минь ээмэг бөгж, хүзүүний зүүлтүүдийг хурааж нэг хайрцагт хийн лацдаж орхихыг нь хараад, ялангуяа тэр үйлдлийг хийж байхдаа “үүнээс өөр үнэт зүүлтүүд байх ёстой!” гэж нэг гүйцэтгэгч эмэгтэй нь хэлж байхыг сонсоод миний дургүй хүрч байсан. Тэр эмэгтэйн бодлоор бол Верагийн минь хэрэглэдэг зүүлтүүд голохоор юм байж таарч байгаа юм. Заавал хэрэгцээ байхгүй үнэтэй юм цуглуулдаггүй, даруу амьдардаг хүнийг ойлгох чадваргүй хүнд доромжлуулж байх шиг санагдаж билээ.

Харин тэр олон хүн манайд орж ирж эрх чөлөөнд цээргүй халдаж байхад азаар хүүхдүүд гэртээ байгаагүйд би олзуурхдаг юм. Вера бид хоёрт тэвчээр алдахгүйгээр барагтай буруу үйлдлийг өнгөрөөж чадах сэтгэлийн тэнхэл байдгийг мэдэрсэн. Прокурорын шийдвэрээр миний нэр дээр банкинд байсан 20 мянган төгрөгийн хадгаламжийн мөнгийг бас ашиглах эрх хаагдсан байлаа. Өөр хадгаламж байхгүй, ажлаас зайлуулагдсан болохоор цалин гэх юм бараг байхгүй. 1990 оноос эхэлж тойрон хүрээлэгчид гэдэг нэр өгөгдсөн хүмүүсийг байцаах, дарамтлах ажил 1992 оны 8-р сар хүртэл үргэлжилж нийслэлийн шүүхийн шийдвэр гарснаар дуусгавар болсон.

11 “Алдагдсан он, жилүүд”.

И Л: 1990 оноос хойш Монгол оронд өрнөсөн үйл явдлуудын талаар та одоо ямар бодолтой байна вэ? Манайх шиг социализм байгуулж байсан зарим оронд энэ бүх хугацааг “алдагдсан он, жилүүд!” гэж нэрлэдэг юм билээ. Манайд байдал ямар байна вэ?

Д С: БНМАУ-ын Ардын Их Хурлыг шинэчлэх 1990 оны дундуур болсон сонгуулийн дараа шинээр сонгогдсон Ардын Их Хурлаас Улсын Бага Хурал томилогдож хууль тогтоох байнгын үйл ажиллагаа нь эхэлсэн юм.

Улсын Бага Хурал 1992 оны эхэн хүртэл сайн ажилласан. Ахмад болон залуу, янз бүрийн мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн Бага хурлын гишүүд Монгол улсын шинэ Үндсэн хуулийн төсөл боловсруулахын зэрэгцээ ардчилсан төр, зах зээлийн эдийн засгийн шаардлагад нийцүүлж хууль зүйг өөрчлөх, боловсронгуй болгох ажлын эхийг тавихад хүч анхаарлаа

төвлөрүүлж амжилттай ажилласан.

Улсын бага хурлын гишүүд тэр үед улс орны ашиг сонирхлын үүднээс ажиллаж чадаж байсан. Хувь хүн, нам бүлгийн явцуу ашиг сонирхолд зохицох муу зуршилд автагдаж эвдрээгүй цэвэр хэвээр хүмүүс дийлэнх олонхи нь байсанд Улсын Бага Хурлын сайн ажиллагааны учир оршино. Мөн тэр үед улс төрийн хэд хэдэн намын төлөөлөл Засгийн газрын бүрэлдэхүүнд байсан нь оновчтой байсан болов уу. Төрийн ардчилсан тогтолцоо бүрдэх эхлэл тавигдаж байсан үе.

Гэвч байдал маш төвөгтэй байсан. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн системийг ад үзэж зохион байгуулалтын бүтэцтэй нь устгаж байсан боловч зах зээлийн эдийн засагт ямар арга замаар шилжих нь тодорхойгүй байв. Хөдөө аж ахуйн нэгдлүүд тарж малыг иргэд аминдаа авч байлаа. Сангийн аж ахуйнууд задарч механикжуулагчид хөдөө аж ахуйн техникийг хуваан авч, тариалангийн талбайгаа хувааж эзэмшихээр өрсөлдөж эхэллээ. Хашаа худаг эзэнгүйдэж эхэллээ.

Аж үйлдвэрүүд удирдлага зохицуулалтгүй болсноос үйл ажиллагаа нь доголдож, дампуурч эхэлсэн. Авто тээврийн төвлөрсөн баазуудын тээврийн хэрэгсэлийг жолооч нар нь хувьдаа авах тэмцэл, өрсөлдөөн эхэлсэн байлаа. Олон хүн “ганзагын наймаа” эрхэлж эхэлсэн бөгөөд түүнд ямар нэг журам зохицуулалтгүй байв. Худалдаа бэлтгэлийн болон материал техникийн хангамжийн систем устгагдаж эхэлсэн.

“Зах зээл өөрөө бүхнийг зохицуулна. Монголыг туйлдуулж элгээр нь хэвтүүлбэл, босоод, хөгжөөд ирнэ!” гэдэг үзэл бодлыг буруу номоос хальт уншсан, түүнийгээ сурталчилдаг зарим хүмүүс төр засгийн удирдлагад гарцгаасан байлаа. Хуучин социалист гэж байсан улсуудтай бүх талын харилцаа тасарч, ялангуяа ЗХУ-ын эсрэг сурталчилгаа их болж, Монгол-Оросын харилцаа хамтын ажиллагааг зөвхөн харлуулж байв. Эдийн засаг, нийгмийн амьдрал ийнхүү замбараагүй болж байгааг хараад санаа зовохгүй, дуугүй ажиглаж байх аргагүй болсон. Эдийн засгийн системээ чухам яаж өөрчлөх нь тодорхойгүй, цэгцтэй бодлого боловсруулаагүй байсан. Энэ бүхэнд санаа зовж, цөхөхдөө эрх биш анхаарах ёстой гэж итгэн Ерөнхийлөгч П.Очирбат, Ерөнхий сайд Д.Бямбасүрэн нарт хувийн захидал бичиж байлаа.

Би БНМАУ-ын Ардын Их Хурлын гишүүн байж 1992 онд Монгол Улсын шинэ Үндсэн Хуулийг хэлэлцэж батлахад оролцож байснаараа бахархдаг. Монгол улсын Засгийн газар 1996-2000 оны хооронд дөрвөн удаа солигдсон. Төр засгийн тогтворгүй байдлыг дагаад нийгэм бас тайван биш болж, хэрүүл маргалдаан үймээн шуугиан ихдэж, бүтээх ажил цалгардаж, завших, залилах өрсөлдөөн ихдэж байгаа нь ажиглагдсан. Ард түмний санаа сэтгэл тайван биш, ардчиллын ач холбогдол, ирээдүйд зарим

хүн эргэлзэж эхлэх шиг болсон.

Тэр үед “Яамдын удирдлагад заавал мэргэжлийн хүн ажиллах шаардлагагүй, улс төрчид л ажиллавал зохино!” гэсэн үзлээр томилгоо хийгдэж байсны гайгаар эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлыг мэргэжил туршлагагүй хүмүүс удирдах болсноос алдаа гарч байсныг үгүйсгэх аргагүй. Ардчилсан Намын гишүүн, микробиологийн мэргэжилтэй Баабар /Б.Батбаяр/ Сангийн сайдаар томилогдоход санхүү, эдийн засгийн тусгай мэргэжил, туршлага шаарддаг энэ онц хариуцлагатай ажлыг гүйцэтгэж чадна гэдэгт би хувьдаа эргэлзэж байсан. Энэ тухайгаа би Баабарт өөрт нь нэг удаа уулзахдаа хэлэхэд түүнээс “Амжих хэрэгтэй байна шүү дээ!” гэсэн хариу сонсоод, чухам ямар утгаар хэлснийг нь ойлгоогүй өнгөрч байж билээ.

Монгол улсын Засгийн газрын Ерөнхий сайдаар Р.Амаржаргал томилогдсон даруйдаа хариуцлагатай албанд томилогдсоноо ухамсарлаж байгаа, ажлын аппаратаа яаралтай бүрдүүлж буйгаа хэлээд “Ерөнхий сайдын эдийн засгийн бодлогын зөвлөхөөр таныг томилж ажиллуулах саналтай байна, зөвшөөрөх үү?” гэж асуулаа. Ийм томилолтыг би зөвшөөрөх аргагүй гэдгийг хэд хэдэн үндэслэлээр хэллээ. “Мэдээллийг дотоод гадаадаас хүлээж авах болон боловсруулах, өндөр бүтээмжтэй хөдөлмөрлөх, зах зээлийн эдийн засгийн хуулийг мэдэж Монголынхоо нөхцөлд бүтээлчээр хэрэглэх гэх мэт өндөр шаардлага тавигдана. Орчин үеийн шаардлагад миний англи хэл мэдэхгүйгээс эхлээд олон талын мэдлэг чадвар дутна. Тогтоосон цаггүйгээр өдөр, шөнөгүй ажиллах шаардлагыг насны тэтгэвэрт гарсан миний эрүүл мэнд даахгүй. Нөгөө талаар МАХН-ын гишүүн миний үзэл бодол та нөхдийн үзэл бодолтой таарах таарахгүй юм гарч мэднэ!” гэсэн үндэслэлүүд хэлж, татгалзаж билээ. Гэвч Ерөнхий сайд маань “Таны туршлага, зөвлөмж бидэнд зайлшгүй хэрэг болно!” гэж учирлав. Тэгэхэд нь “Хэрэв тийм байгаа бол заавал орон тооны албан тушаалд томилохгүйгээр шаардлага гарсан тухайдаа намайг дуудаж байвал би ирж мэдэх юмаа хэлж зөвлөж байхад болно шүү дээ. Монгол улсын эрх ашгийн асуудлаар санал хэлж, асууж зөвлөж байя!” гэхэд хэн ч татгалзах учиргүй гэлээ.

Ийм ярилцлагын эцэст Р.Амаржаргал: “Тэгвэл та миний орон тооны бус зөвлөх байхыг зөвшөөрөх үү?” гэхэд нь би зөвшөөрсөн юм. Би түүнд “Аливаа асуудлаар санал бодлоо шууд хэлж байх бөгөөд танд таалагдах гэж ам дагаж ажиллахгүй шүү!” гэхэд Ерөнхий сайд “Зүйтэй!” гэж байсан.

Харин: “Таныг миний орон тооны биш зөвлөхөөр ажиллах болсоныг хэвлэлээр зарлана!” гэж хэлэхэд нь “Зөвхөн сурталчилгааны зорилготой томилгоо хийж байгаа юм биш биз?” гэсэн эргэлзээ төрж байсныг нуух юун. Гэхдээ улсын ашиг сонирхлын үүднээс “Залуу Ерөнхий сайдаа

зөвийг нь дэмжиж, алдахаас сэрэмжлүүлэхийн төлөө ажиллах ёстой!” гэсэн бодол давамгайлсан.

Энэ томилгооны дараа нэг нөхөр “Та чинь сөрөг хүчний Ерөнхий сайдын зөвлөх болчихоо юу?” гэж асуугаад, зэмлэх утгатай үг чулуудаж байсан бол харин МАХН-ын удирдах нөхөд, найз нар, танилууд бүгд “Та зөв шийджээ. Буруу тийш нь залж зөвлөхгүй нь ойлгомжтой. Залуу удирдах хүндээ намын харъяалал харгалзахгүй туслах хэрэгтэй. Харин таны зөвлөлгөөг авч байгаасай!” гэж хэлж байцгаасан.

Ерөнхий сайд Р.Амаржаргалын эдийн засгийн бодлогын орон тооны бус зөвлөх байх жил орчим хугацаанд Засгийн газрын ээлжит хуралдаанаар хэлэлцэх асуудлаар бэлтгэгдэж, тараагдсан нууц биш шийдвэрийн төслүүдийг уншиж зарчимын гэж үзэхээр асуудлаар саналаа тэмдэглэж танилцуулдаг байлаа. Анхаарч хүлээж авдаг байсан. Зарим нэг санал анхаарагдаагүй өнгөрсөн бол учрыг түүнээс асуухад “Манай Ардчилсан Намын партизан нартай санал нийлж, шийдвэр гаргахад амаргүй!” гэж учирлаж байсан. Үнэхээр тийм зовлон байсан байж таарна. Миний хэлсэн болгон зөвшөөрөгдөж байх ёстой биш нь ойлгомжтой.

Харин төсөл нь урьдчилж тараагдаагүй буюу нууц гэж үзсэн асуудлаар Засгийн газраас гаргах шийдвэрийн төслүүдтэй танилцах, санал өгөх бололцоо байгаагүй. Зарчмын ач холбогдолтой өмч хувьчлал, төсөв санхүү, банк зээл, үнэ, нийгэм хангамжийн болон гадаад харилцааны зэрэг асуудлаар боловсрогдож байгаа материал, шийдвэрийн төслүүдийг үзүүлдэггүй байсныг, заавал авч үзэх гэж хөөцөлддөггүй байснаа хэлэх хэрэгтэй.

Гэхдээ Ерөнхий сайд Р.Амаржаргалд олон түмний анхаарлын төвд байсан зарим чухал асуудлаар олж мэдсэн зүйлээр өөрөө санаачилж санал зөвлөмж бичиж өгөхийг хичээдэг байж билээ.

Монгол улсын 1992 оны Үндсэн хуульд “Мал, сүрэг бол үндэсний баялаг бөгөөд төрийн хамгаалалтад байна!” гэж заасан боловч яаж ойлгох, яаж хэрэгжүүлэхээ тодорхойлохгүй арваад жил өнгөрлөө. Бид Үндсэн хуулиа хэрэгжүүлэхэд хайхрамж хариуцлагагүй хандаж ирсний нэг жишээ. Үндсэн баялаг мал сүргээ иргэдийн хувийн өмчид өгчихөөд, тэр баялгийн хувь заяаг Монголын төр анхаарлынхаа гадна орхиж болохгүйг Үндсэн хуульдаа тусгасан нь Монголын нийгэм, эдийн засгийн өвөрмөц онцлогоо бодсон хэрэг. Мал сүргийг Монголын төр хамгаалалтдаа авч байхыг Үндсэн хуульд онцолж заасны утга учир нь миний бодоход:

-сүргийн бүтцийг оновчтой, малын үүлдэр угсааг сайн байлгах, Монголын малын генийг хадгалахад төрийн анхаарал, дэмжлэг зайлшгүй.

-малыг гоц халдварт өвчнөөс сэргийлж хамгаалах асуудлыг төр хариуцаж зохион байгуулах ёстой.

-цаг уурын бэрхшээл тохиолдоход гарах хохирлыг бага байлгах, бэлчээр хамгаалах, сайжруулах, бүрэн ашиглахад төрийн бодлого зохицуулалт шаардагдана.

-мал аж ахуйн бүтээгдэхүүнийг бэлтгэх, боловсруулах, борлуулах ажлыг төр зохион байгуулахгүй бол мөд хэрэгжихгүй.

Энэ бүхний үндсэн дээр эдийн засгийн өндөр үр ашигтай салбар хөгжиж, Монголын хүн амын ихэнх хувийг эзэлдэг мал аж ахуй эрхлэгчдийн орлого нь их, амьдрал нь хангалуун байх нөхцөл бүрдэх учиртайд Үндсэн хуулийн санаа орших болов уу. Дээрх чухал ажил зөвхөн төр засгийн зүгээс авч явуулах бодлого зохицуулалтаар амжилттай хэрэгжинэ.

1990 оноос хойш олон жил цаг агаарын нөхцөл харьцангуй тааламжтай, их нутаг хамарсан ган зуд болоогүйгээс энэ асуудалд олигтой анхаарахгүй өнгөрсөн бол 1999-2001 онд ихээхэн нутаг хамарсан ган, зудаар олон сая мал хорогдож, олон хүн амь амьдралаараа хохирсон нь манай төр засгийг гүн бодолд оруулж, мал сүргээ Үндсэн хуулийн дагуу хамгаалалтдаа авахыг хатуу анхааруулав бололтой.

Зарим санал:

1. Малыг иргэдээс худалдан авч боловсруулан мах экспортлох ажлыг ойрын жилүүдэд зохион байгуулах зайлшгүй шаардлагатай. Энэ ажлын ач холбогдол нь:

-малчин иргэдийг орлоготой болгож амьдралыг нь өөд татна.

-мах комбинатууд болон хүнсний үйлдвэрүүд ажиллаж олон зуун хүн ажилтай болно.

-экспортын орлого нэмэгдэж, гадаад худалдааны тэнцвэр сайжирна.

-малын үндсэн сүргийн чанар сайжирч цагийн хатуу үед байх үндсэн сүргийн малын тоо багассанаар бэлчээр талхлагдахаас сэргийлэх, хохирол бага гарах нэг чухал нөхцөл бүрдэнэ.

Нийт малын тоо оны эцэст 26-28 саяд багтаж, жилд 70 орчим мянган тонн мах экспортлож байхад, малын үндсэн сүрэг чанартай, ган зуд болоход үхэл хохирол харьцангуй бага байх болно. Ямааны тоо 1990 онд 4,5 сая байснаа 10 гаруй сая болтол нэмэгдэж хонь тэмээ хорогдож үхэр бага зэрэг өссөнийг сүргийн бүтцэнд гарсан сайн өөрчлөлт гэж үзэхгүй байна.

2. Мал, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг худалдаж авах бэлтгэлийн системийг яаралтай бий болгох хэрэгтэй байна. Монголын иргэд бэлчээрийн мал аж ахуй эрхэлж байгаа гол зорилго нь малыг хариулж, тоолж, харж байхад биш харин түүний ашиг, шимийг ашиглаж амьдрал ахуйгаа сайжруулж байхад оршино. Түүнд нь төр засаг тусалж, зах зээлд оролцож авах ёстой ашиг, орлогоо олж авч байх нөхцлийг нь бүрдүүлж

өгөх ёстой. Үүнийг бэлтгэлийн систем бий болгох, мал бэлтгэж мах экспортлох ажлаас эхлэх нь зөв.

3. Хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуйг яаран устгасан боловч түүний оронд мал аж ахуй эрхлэгчдийн хөдөлмөрийг нэгтгэж байх “хоршооны систем”-ийг бий болгох ажил зохих хэмжээнд анхаарагдахгүй орхигдсон нь их алдаа болсон.

Мал аж ахуй эрхлэгчид “хот айл” болж, айлууд 5-6-аар нэгдэж “нөхөрлөл” болж, нөхөрлөлүүд 5-10-аар нэгдэж “хоршоо” байгуулж, хоршоод нийлж “холбоо” байгуулсан байх арга хэлбэрээр мал аж ахуй эрхлэгчдийн хоршоо бий болгож эхэлсэн зарим аймгийн туршлагыг судалж, нэгдсэн бодлого, арга зөвлөмжөөр хоршооллын хөдөлгөөнийг өрнүүлэх нь чухал юм.

4. Мал эмнэлэгийн асуудлаар тусгай хууль санаачилж, малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тариа, хамуу, цагаан хорхой зэрэг өвчнөөс сэргийлэх, ариутгах эмчлэх ажлыг заавал хийдэг байх, ийм ажлаас зайлсхийсэн нөхцөлд өндөр хариуцлага хүлээдэг журам тогтоох хэрэгтэй. Монголын малыг халдварт өвчнөөс хамгаалах асуудал зөвхөн Монголын төрийн зүгээс явуулах бодлого, зохиох ажлаар шийдэгдэнэ.

5. Монгол нутгийн малын бэлчээрийг хамгаалж, өвс ургамалын бүтцийг хадгалах, ялангуяа талхлагдсан, талхлагдаж байгаа бэлчээр нутгийг онцгой хамгаалалтад авч сэргээх ажлыг цаг алдалгүй зохиох, түүнд эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн нарынхаа тус дэмийг авах шаардлагатай.

Монгол улс, монголчууд мал аж ахуй эрхэлж, байгаль орчинтой ойр зохицож амьдардаг чадвар, заншлаа шинэ зуунд хадгалж чадах эсэх, бахархаж байдаг цэвэр байгаль орчноо хамгаалж үлдэх эсэх том асуудал хурц тавигдаж эхэллээ. Түүнд үнэлэлт авах хариу өгч эхлэх цаг тулаад байна. Олон мянган жил хадгалж чадсан цэвэр байгаль, унаган төрхөөрөө буй ургамал бэлчээрээ одоогийн үе сүйтгэж нүгэл хийх ёсгүй. Хэрэв бэлчээрээ сүйтгэвэл, бэлчээрийн ургамлын чанар өөрчлөгдөж муудвал Монголд мал аж ахуй эрхлэх үндэс суурь үгүй болж сүйрнэ.

Бэлчээр хамгаалах асуудлыг орчин үед хурцаар гаргаж хэлэх, төр засаг, нийт иргэдийн анхаарлыг энэ асуудалд хандуулах онц шаардлагатай болж буйг доорхи үйл явдлаас ойлгож болно.

Нийт нутгийн бэлчээрийн даацаас малын тоо хэтэрсэн. Ерээд оныг хүртэл жилд 8-9 сая төл бойжуулж тэр орчим тооны малыг дотоод хэрэгцээ, экспортод зарцуулаад 25-26 сая мал өвөлжүүлдэг байхад хавар болон зуны эхэн саруудын тарчигдуу бэлчээр 34-35 сая мал, төлийн тэжээлийн хэрэгцээг хангадаг байлаа.

Монголын нутагт мал тархаж байрласан, уурхайн болон гар,

өрөмдмөл худаг олон байсан учир бэлчээр ашиглалт илүү байв. Гэтэл сүүлийн арав гаруй жилд мал борлуулах, ашиглах зах, зээл хомс болсон, түүнийг зохион байгуулаагүй үндсэн шалтгаанаар малын тоо 33 сая болтол өсч, мал сүргийн бүтэц чанарт ихээхэн өөрчлөлт гарлаа.

Оны эцэст тоологдсон 33 сая малыг өвөлжүүлдэг, хавар зуны эхний саруудын тарчиг бэлчээрт 42-43 сая мал бэлчээрлүүлэх болоод байна. Газрын гүнээс ус татах худгуудаа устгаснаас их бэлчээр ашиглаж чадахаа больсныг бодолцвол ашиглаж байгаа бэлчээрийн даацаас хэтэрсэн малтай болсон нь гарцаагүй.

Мал аж ахуй эрхэлдэг олон хүн зах зээлд ойртож амьдралаа өөд татах, зарим хэсэг нь хулгай дээрмээс зугтаж зах хягаазрын нутгаас малаа тууж томхон хотуудад ойр газарт нүүдэллэн суурьшиж байна. Зах хязгаарын нутаг бэлчээр орхигдож, Төв, Сэлэнгэ, Булган зэрэг аймгийн нутагт бэлчээр талхлагдан, өвс ургамалын бүтэц өөрчлөгдөх, шим тэжээл нь доройтож байгаа нь аюултай. Төв, Сэлэнгэ аймгийн малчид бэлчээрээс мал тарга хүч авах нь эрс муудсан тухай ярьж байна.

Бэлчээрийг хамгаалж сэргээх тодорхой ажил зохиовол мал сүргийг төрийн хамгаалалтад байлгах тухай Үндсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэх бодит ажил болно. Бэлчээрээ хамгаалж сэргээе гэвэл мал бэлтгэлийн системтэй, малчдыг хоршоололтой болгох, махыг экспортод гаргах, үндсэн сүргийн малын чанарыг сайжруулах зэрэг дээр дурьдсан саналыг анхаарч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай.

6. Төр засгийн бодлого зохицуулалт, зохион байгуулах ажил Монголд зах зээлийн эдийн засгийг зүгшрүүлэхэд зайлшгүй.

Монгол улсын мал аж ахуйд бэлчээрийн маллагаа зайлшгүй. Тэжээвэр малтай суурьшсан хэсэг буй болгож өргөжүүлж болно. Гэвч нэг биш зуунд манай бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг заншил уламжлагдан үлдэх нь эдийн засгийн болоод бусад шалтгаанаар зайлшгүй.

КЮ: За, сонирхолтой яриа ярьж өгсөн танд баярлалаа.

Д С: Зүгээр.

Пунсалмаагийн Очирбат

1 Миний төрсөн газар.	7 Ж. Батмөнх гуай.
2 Улаанбаатар хотод.	8 Ю. Цэдэнбал гуай.
3 “Хээрийн галуу нисэн үл хүрэх газраас ……………”	9 Монголын ардчилал, шинэчлэл.
4 Ерөнхий инженерээс төрийн сайд хүртэл нэг л алхам бий.	10 Монгол улсын Ерөнхийлөгчийг сонголоо.
5 Эрчим хүчний салбар хөл дээрээ босов.	11 Авгай.
6 1984 оны 8-р сард болсон үйл явдал.	12 Ю. Цэдэнбалын “тойрон хүрээлэгчид”.

1 Миний төрсөн газар.

Конагая Юүки (цаашид **КЮ**): Монгол улсын анхны Ерөнхийлөгч асан Пунсалмаагийн Очирбат тантай уулзаж байгаадаа бид нар маш их баяртай байна. Энэ удаагийнхаа ярилцлагыг таны бага насны дурсамжаас эхэлбэл ямар вэ? Та хэзээ, хаана төрсөн, өөрийн аав, ээж, ах, эгч, дүү нарынхаа тухай бидэнд ярьж өгнө үү?

Пунсалмаагийн Очирбат (цаашид **ПО**): Би 1942 онд Завхан аймгийн Түдэвтэй сумын нутагт Бунхант гэдэг газар төрсөн. Тэр газарт 13-р зууны үеийн Монголчуудын дээдсийг оршуулсан 7-8 бунхан байдаг учраас Бунхант гэж нэрлэсэн байх.

Миний эцэг Гонсын Гэндэнжав гэдэг хүн байв. Тэр Галуутайн хүрээний том лам байсан юм. Зурхайн ухаанаар мэргэжсэн гэдэг юмуу даа. Тэгээд хар хүн болоод манай ээжтэй гэрлэжээ.

Миний ээжийг Цогтын Пунсалмаа гэдэг. Манай ээж айлын 13 хүүхдийн хамгийн том нь юм. Би ээж, аавынхаа том хүү нь юм. Намайг 5 настай байхад манай эцэг нас барсан юм. Эцгийг нас барснаас хойш 3 жил ээж бид нар нутагтаа амьдарч байгаад, дараа нь Улаанбаатарт нүүж ирсэн юм. Ээж миний дүүг айлд өргүүлээд, ганц намайг аваад Улаанбаатарт ирж байлаа. Миний дүүг аавын дүүд өргүүлсэн юм. Тэр бас Галуутайн хүрээний том лам байв. Лам хүнд хүүхэд байхгүй шүү дээ. Миний бага дүү манай аавыг нас барах үед нэг ойлд хүрээгүй шахуу байж. Хоёр бага хүүхдийг хол газар авч явах нь ээжид хэцүү байсан байх. Бид нар түүнээс хойш уулзаагүй. Манай аав нас барахдаа “Хүүгээ номтой хүн болгоорой!” гэж захисан гэдэг. Тэр үед номтой болох газар бол ганцхан Богдын хүрээ байлаа шүү дээ. Улаанбаатар хотыг дээр үед ингэж нэрлэж

байсан юм.

КЮ: Та нар Богдын хүрээнд яаж нүүж ирсэн бэ? Хол газар нүүх бол тийм амархан биш шүү дээ?

ПО: Яахав дээ, тэр үед чинь тэмээн жингээр л нүүж ирнэ шүү дээ. Богдын хүрээ орох гэж манай нутгийн 2 айл бидэнтэй хамт нүүсэн юм. Манайх хэдэн мал, гэр, эд юмсаа зараад, ачилгын нэг тэмээтэй, уналгын нэг морьтой, замдаа хүнс болгох, Улаанбаатарт ирээд зараад мөнгө болгож, амьдрал залгуулах зорилготой хэдэн хонь туугаад нутгаасаа гарсан юм. Намайг арагт хийгээд тэмээнд тэгнэчихнэ шүү дээ.

КЮ: Та араг дотор сууж ирсэн юм уу?

ПО: Тэгэлгүй яахав. Араг дотор сууж ирсэн юм. Би тэр үед найман настай л байлаа. Бид нар наадам өнгөрөөгөөд 7-р сарын дундуур нутгаасаа гараад, 9-р сарын эхээр Улаанбаатарт ирж байлаа. Замдаа сар гаруй явсан байгаа юм. Манай ээжийн хамгийн бага дүү түрүүлээд Улаанбаатарт ирсэн байв. Ээж маань тэр дүүгээ бараадаж яваа юм байж л дээ. Тэр үед би бага байсан болохоор юу ч мэдэхгүй л байлаа. Гэхдээ мэдэхгүй биш ээ, бас нарийн юм бодож байсан шиг байгаа юм.

Завхан аймгаас Улаанбаатар хүрэхэд, Хангайн нуруунаас эх авсан, ширүүн урсгалтай, ус ихтэй, олон голыг гатладаг юм. Архангай аймагт Чулуутын гол гэдэг ширүүн урсгалтай, их алдартай гол бий. Бид нар тэр голыг гатлаж байсан байдал одоо болтол санаанаас гардаггүй юм. Тэмээ бол усанд их муу амьтан юм шүү дээ. Голын эргээс холдоод, яг дунд нь хүрч ирэхэд, усны шуугиан улам их болоод л, тэмээ хөвчих гээд байгаа юм шиг надад санагдаад байж билээ. Ээж морь унаад голоор гарсан юм. Би “Ээж мориноосоо уначих вий!” гэж айгаад, тэмээнд ачсан араг дээрээ босож зогсоод, гол гаталж яваа ээжийнхээ хойноос харж байв. Харин ээж “Хүү минь, араг дээрээсээ уначих вий!” гэж ус гаталж яваа морин дээрээ эргэн, эргэн харсаар явж байлаа. Ээж, хүү хоёр ингэж бие биендээ санаа зовж, олон голыг гатлаж билээ. Би бага байсан боловч ямарч л байсан ээжийнхээ төлөө санаа тавих тэнхээтэй л байсан байгаа юм. Тэгж явсаар бид нар Улаанбаатарт ирж байлаа.

Манай ээж 33-тай, залуухан байлаа. Тэр үед би аавынхаа дээлийг нөмрөөд унтдаг байлаа. Би дүүдээ “Аавынхаа дээлэн дээр шээж болохгүй шүү!” гэж захидаг байж билээ. Манай ээж хэдэн жилийн дараа дахин хүнтэй суугаад, би 5 дүүтэй болсон хүн. Нэг дүү Дондовсамбуу нутагтаа малаа малаад амьдарч байна. Миний хамгийн хайртай дүү 13 нас хүрээд,

баян айлын морь уургалж яваад морьноос унаад нас барсан юм Нэг дүү Улаанхүү, одоо Цусны төвийн захиралын алба хашиж байна. Нэг дүү Жаргал “Скай Плаза” төвийн менежер, бага дүү Очирхуяг “Бороо Гоулд” Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани (ХХК)-д Японы “Комацу” гэдэг машин барьж байна. Дүү нарын хувьд ийм байна.

2 Улаанбаатар хотод.

КЮ: Анх Улаанбаатарт хүрч ирээд ямаршуухан байв даа?

ПО: Улаанбаатарт анх ирэхэд хөдөөний над шиг хүүхдэд төөрчихмөөр их хүнтэй, машин, тэрэгтэй газар шиг санагдаж байлаа шүү дээ. Манай хөдөө газар машин байхгүй. Биднийг Улаанбаатарт ирж явах замд машин дайралдаж байсан юм. Тэр машинаас мал үргээд, хэцүү юм болдог байлаа. Бид нар Улаанбаатарт нэгэнт сургууль эхэлснээс хойш орж ирсэн учир тэр жил би сургуульд ороогүй, харин дараа жил нь 9 настай байхдаа бага сургуульд орж байлаа. Тэр үед зарим хүүхэд 15 настай 1-р ангид ордог байлаа шүү дээ.

Манай гэр “Өндөр хоршоо”-ноос баруун хойш ойрхон байв. Одоо “Өндөр хоршоо”-ны байранд Дүрслэх урлагийн музей байрлаж байна. Түүний зүүн хойд талд л баахан айлын хашаа байсан юм. Түүний хойд талд нэг аптека, түүний ард талд нарийн боовны гудамж байгаад, тэрний ар талд дахиад айлын хашаанууд байсан бөгөөд тэнд манай гэр буусан юм.

Тэр үед “радио” гэдэг дугуй таваг шиг хар юм байв. Тэр байнга л ямар нэгэн юм ярьж байдаг байлаа. Бид нар хүүхдүүд анх радио сонсоод, “хүн нь хаана байна вэ?” гээд түүний араар нь шагайж хардаг байв. Би Улаанбаатарт ирээд төмс гэдэг ногоог идэж чаддаггүй байлаа. Төмс гэдэг чинь нэг их нялуун, шорооны амттай, муухай зүйл байлаа шүү дээ. Улаан лууван, шар лууван гэдэг нэртэй ногоо байдаг шүү дээ. Шар лууван их чихэр амттай ногоо юм л даа. Бид нар хүүхдүүд түүнийг шууд түүхийгээр нь иддэг байлаа. Би ч иймэрхүү л нөхөр байсан даа. Амгаланбаатар хотын 8-р сургууль анх 1932 онд байгуулагдсан юм билээ. Би тэр сургуулийн нэгдүгээр ангид 1951 онд орж байлаа.

КЮ: Тэр үед тэнд таны таних хүн байсан юм уу?

ПО: Би ямар хүн таних вэ дээ. Ээж тэнд амьдардаг хүнтэй суусан юм. Анх тэр сургууль дээр би нэг хүүхэдтэй хамт очсон юм. Энэ бол 8-р сарын 25-ны өдөр байсан. Бид хоёр сургуульд бүртгүүлэх санаатай очсон юм. Одоо сургуульд орох хүүхэд бүртгүүлэхдээ ээж, аавыгаа дагуулаад цэцэг,

навч бариад, шинэ хувцасаа өмсөж, их гоёчихоод очиж байна шүү дээ. Их сайхан баярын өдөр болсон байна. Бидний үед тийм байсангүй.

Бид хоёр тэр сургууль дээр очлоо. Олон хүүхэд цугласан байна. Урт ширээн дээр олон багш нар суугаад бүртгэл хийж байгаа бололтой байна. Тэгээд нэг багшийн дэргэд очоод би: “Бид 2 сургуульд бүртгүүлэх гэж ирлээ!” гэж хэлэв. Тэгтэл тэр багш “Овог, нэрээ хэл!” гэж байна. “Овог, нэр гэж юуг хэлж байгаа юм бэ?”. Би бодоод дуугүй зогсож байтал тэр багш “Чиний эцгийн нэр хэн бэ?” гэж байна. “Аав байхгүй!” гээд би хэлчихлээ. Тэр багш над руу нэг сүрхий том харснаа “Чамд ээж байна уу?” гэж байна. “Тийм!” гэж би хэллээ. “Ээжийг чинь хэн гэдэг юм бэ?” гэж тэр багш асууж байна. “Пунсалмаа!” гээд би хэлчихлээ. Ингэж би “Пунсалмаагийн Очирбат” гэсэн нэрээр бага сургуульд бүртгүүлсэн юм. “Пунсалмаа!” гэж ээжийнхээ нэрээр бүртгүүлэх хоёр янзын шалтгаан надад байсан байх. Нэгдүгээрт миний эцэг лам хүн байсан болохоор эцгийн нэрийг хамаагүй хэлдэггүй шүү дээ. Тэр тусмаа талийгаач болсон болохоор бүр болохгүй. Цээртэй юм. Энэ бол хуучин уламжлал юм л даа. Түүнээс гадна “эцгийнхээ нэрийг хэлчихвэл энэ багш яах бол?” гэсэн бодол надад төрсөн байх. Тэр үед лам хүний хүүхэд өөрийнхөө гаралыг үнэнээр нь хэлэхэд бас хэцүү байлаа шүү дээ. Лам нарыг чинь “шар феодал” гэж нэрлээд, “ангийн дайсан” гэж үзэж байлаа шүү дээ. Ийм хүний хүүхэд сургууль, соёлд орох нь тийм ч чөлөөтэй биш байв. Ер нь болохгүй байлаа шүү дээ. Тэр үед л надад тийм ухаан байсан юм. Ийм учиртай юм. За ингээд сургуульд орлоо. “Онц” сурдаг, томоотой сайн хүүхэд байсан.

КЮ: Жаахан сахилгагүй байсан байх аа?

П О: Сахилгагүй ч жаахан, жаахан байсан байх шүү. Тэгэхгүй яаж байх бэ?

КЮ: Тэр үед Амгаланбаатар хот ямар байсан бэ?

П О: Тэр Амгаланбаатар хот бол Улаанбаатарын зүүн талд байдаг шүү дээ, та нар ч мэдэх байх. Тэр “Амгаланбаатар гацаа” гэсэн нэртэй байв. Бүр дээр үеэс наймаачид хятадын худалдаачид суудаг байж. Тэнд хэдэн сайхан дугана байв. Тэнд бас жанжин Сүхбаатарын нэрэмжит “Ардын үлгэр жишээ клуб” ажиллаж байв. Монголын театрын урлагийн олон алдартнууд тэндээс төрж гарсан юм. Амгаланбаатарт хот бол жанжин Сүхбаатарын төрсөн газар шүү дээ. Түүний эцэг “Цагаан дээлт” Дамдин энд амьдарч байж.

Амгаланбаатар бол Улаанбаатар дотроо их сонин онцгой газар юм шүү. Улаанбаатарын зүүн талд өөр нэг сонин газар байсан нь Улаанхуаран юм. Тэнд цэргийн хуаран байрладаг, цэргийн дарга нар амьдарч байж. Тэр үед “Жаахан том болоод 15-16 хүрээд сургуулиа бушуухан төгсөөд мэргэжилтэй хүн болоод ээжийгээ тэжээх юмсан!” гэдэг бодол надаас огт салдаггүй байлаа. “Ээж минь намайг л хүн болгох гэж яваа юм шүү!” гээд бодоод байсан юм болов уу даа. Дотроо ээжийгээ их хайрладаг, хүндэлдэг хүүхэд байжээ.

Тэгээд 7-р ангид байхдаа 8-р ангийн шалгалт өгөх гэж үзлээ. Тэр үед анги алгасаж шалгалт авдаггүй байж. Дараа жил нь 8-р ангид байхдаа 9-р ангийн шалгалт хамт өгөөд 10-р ангид орчихлоо. Тэгээд би 1960 онд Нийслэлийн 10 жилийн 14-р сургуулийг төгсөв. Тэгээд ЗХУ-ын Ленинград хотод Уул, уурхайн дээд сургуульд сурахаар боллоо.

3 “Хээрийн галуу нисэн үл хүрэх газраас

КЮ: Та энэ сургуулийг өөрөө сонгож авсан уу?

ПО: Энэ сургуулийг би өөрөө сонгоогүй юм. Би бол сэтгүүлч мэргэжилтэй болох хүсэлтэй байсан. “Ломоносовын нэрэмжит Москвагийн Улсын Их Сургуулийн сэтгүүлчийн ангид суралцана!” гэж би бодож байлаа. Тэгээд болоогүй юм. Тэр үед МАХН-ын Төв Хорооноос “сурлага сайтай, эрэгтэй хүүхдийг уул, уурхайн мэргэжлийн чиглэлийн сургуульд суралцуулах хэрэгтэй!” гэсэн чиглэл өгсөн юм билээ. Тэгээд Ленинград хотод Уул, уурхайн дээд сургуульд суралцахаар болов. Тэр үед дунд сургуульдаа “онцсайн” сурдаг хүүхдүүд дотроос шилж аваад өрсөлдөөнт шалгалтнд оруулж, тэнцвэл гадаадад явуулж сургадаг журамтай байв. Орос улсад дээд сургуульд сурч, мэргэжил эзэмших явдал бол их аз завшаантай хэрэг бөгөөд манай олон үеийн залуучуудын мөрөөдөл байв. Жирийн малчин, ажилчны хүүхдүүдэд ЗХУ-ын дээд сургуульд үнэ, төлбөргүй суралцах боломжийг олгож байсан нь социализмын үеийн нэг их давуу тал юм шүү.

Миний сурсан Уул, уурхайн дээд сургууль бол 1773 онд байгуулагдсан, дэлхийн техникийн анхны сургуулиудын нэг юм. Сайхан сургууль шүү. Би энэ сургуулийг 1965 онд уул, уурхайн инженер мэргэжлээр төгссөн юм. 1990 онд би энэ сургуульдаа дахин очиж шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалав. Ямар ч үед Оросын инженерийн боловсролын түвшин дэлхийд дээгүүрт ордог юм шүү дээ. Сүүлийн жилүүдэд манайхаас Орос улсад явж суралцах хүний тоо их цөөрсөн байна. Ленинград бол дэлхийд хосгүй түүхийн том, сайхан хот. Ер нь

миний л мэдэх Оросын хотуудаас хамгийн сайхан нь. Хүмүүс нь сайхан ааш зантай, их нөхөрсөг. Москвагийн хүмүүс тийм биш шүү дээ. Олон хөлийн газарболоод тэгдэг юм уу. Ленинградын гудамж талбай нь сайхан, бараг л байшин болгон нь түүх өгүүлнэ дээ. Далайн том боомт хот юм. Их Петер хаан анх энэ хотын суурийг тавьсан юм. Орос орны “Баруун европыг харах цонх!” гэж нэрлэдэг шүү дээ. 1917 онд Октябрийн хувьсгал ялсны дараа В.И.Ленин Орос улсын нийслэлийг Москвад шилжүүлэх шийдвэр гаргасан юм билээ. Түүнээс хойш бас Оросын “хойд нийслэл” гэж нэрлэдэг болсон юм.

Би оюутан байхдаа 1965 онд гэрлэж, хуримаа энэ хотод хийж байлаа. Манай эхнэр Ш. Цэвэлмаа бид хоёр нэг дунд сургуульд сурч байв. Намайг 8-р ангид сурч байхад Ш. Цэвэлмаа 5-р ангийн сурагч байлаа. Манайх хоёр охинтой. Том охин Очирмаа маань Москва хотод дээд сургуульд сурч, инженер-эдийн засагч мэргэжилтэй болсон. Одоо Москвад суугаа Монгол улсын Элчин сайдын яамны худалдааны асуудал эрхэлсэн нарийн бичгийн даргын ажлыг хийж байна. Бага охин Оюумаа Бээжингийн Их сургууль төгссөн. Одоо “Айвенхоу Майнз” (Ivenhoe Mines) компанид захиргааны удирдлагын албанд ажиллаж байна.

4 Ерөнхий инженерээс төрийн сайд хүртэл нэг л алхам бий.

Ичинхорлоогийн Лхагвасүрэн (цаашид **ИЛ**): Та төгсөж ирээд хаана анх ажилд орсон бэ?

П О: Би төгсөж ирээд Аж үйлдвэрийн яамны Хүнд үйлдвэрийн хэлтэст, уул, уурхайн асуудал хариуцсан мэргэжилтэнгээр ажилласан. Тэр үед Аж үйлдвэрийн яамыг сайд Паавангийн Дамдин удирдаж байв. 1960 онд П.Дамдин гуай 29 настай байхдаа Монгол улсын Аж үйлдвэрийн яамны сайдаар томилогдож байсан юм билээ. Намайг ирэх үед манайд мэргэжилтнүүд цөөн байж. Тэр үед Шарын голын нүүрсний уурхай ашиглалтад орж байв. Тэнд голдуу зөвлөлтийн мэргэжилтнүүд ажиллаж байлаа. Тэнд монгол инженерүүд хэрэгтэй байж. 1967 оны 1-р сараас намайг энэ уурхайн ерөнхий инженерээр томилсон юм. Намайг тэнд очихоосөмнө уурхайн ерөнхий инженерээр Михаил Адамович Навасардянц гэдэг орос хүн ажиллаж байлаа.

1960-70-аад онуудад Монгол улсын уул, уурхайн салбарын эрчимтэй хөгжлийн үе эхэлсэн юм. Налайхын нүүрсний уурхай шинэчлэгдэж, Шарын голын нүүрсний уурхай, Адуун чулууны нүүрсний ил уурхай ашиглалтанд орж байв. Бараг бүх аймгуудад нүүрсний уурхайнууд байгуулагдсан юм. Би Шарын голын нүүрсний уурхайд бараг 6 жил

ажиллаад, 1972 онд Түлш, эрчим хүчний үйлдвэр, Геологийн яамны орлогч сайдаар томилогдов. Тэр үед энэ яамны сайдаар Мятавын Пэлжээ гуай ажиллаж байв. Аж үйлдвэрийн яамнаас салж, Түлш, эрчим хүчний үйлдвэр, геологийн бие даасан яам байгуулагдсан юм.

КЮ: Тэр үед яамны орлогч сайдыг томилоход ямар журмыг мөрдлөг болгож байсан бэ? МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчоо энэ асуудлыг хэлэлцдэг байсан уу?

ПО: Хэлэлцэнэ. Заавал хэлэлцэнэ. Тэр хурал дээр Улс Төрийн Товчооны бүх гишүүд, орлогч гишүүд нь сууна шүү дээ. Хурлыг МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбал гуай өөрөө удирдана. Намайг орлогч сайдаар томилох хурлыг тэр өөрөө удирдсан юм. Ю.Цэдэнбал гуай намайг тэнд сууж байсан УТГ-ны гишүүдэд танилцуулсны дараа “За, чи намтраа оросоор ярь!” гэж хэлсэн. Тэгээд би одоо чамд ярьж байгаа юм шиг өөрийнхээ намтрыг яриад зогсож байлаа. Оросоор ярьсан.

Ер нь би анх Ю.Цэдэнбал гуайтай 1971 онд уулзсан юм. Намайг Шарын голын нүүрсний уурхайн ерөнхий инженер байхад МАХН-ын 16-р Их хурал хуралдав. Би энэ хуралд төлөөлөгчөөр оролцолоо. Тэр үед намын Их хурлын төлөөлөгчөөр сонгогдох явдал бол маш хариуцлагатай, том шагнал байлаа шүү дээ. Үйлдвэр албан байгууллагуудаас ажил хөдөлмөрөөрөө шалгарсан, хамгийн шилдэг хүмүүсийг намын Их хурлын төлөөлөгчөөр сонгодог байв. Би бас сүрхий байсан байгаа юм шүү. Дархан хотоос сонгогдсон намын Их хурлын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд ороод Улаанбаатарт ирсэн юм. Тэр үед Ю.Цэдэнбал гуайн нэр хүнд их өндөр байлаа шүү дээ. Бид нар шиг үйлдвэрт ажиллаж байгаа хүмүүс түүнтэй уулзвал “их аз завшаантай хэрэг!” гэж үздэг байлаа. Нөгөө талаас тэр алдартай хүнээс их айж, сүрдэж байлаа. Зөвхөн би ч биш, хүн болгон л тийм байлаа шүү дээ.

КЮ: Та Түлш, Эрчим хүч, Геологийн яамны орлогч сайдын ажлыг хэдэн жил хийсэн юм бэ?

ПО: Орлогч сайдаар би 4 жил ажилласан. 1976 онд Түлш, эрчим хүч, геологийн яамыг 2 хувааж, Түлш, эрчим хүчний яам, Геологи, уул, уурхайн яам гэсэн хоёр яамыг шинээр байгуулсан юм. Нэг нь нүүрсний үйлдвэр, цахилгаан эрчим хүчний асуудлыг хариуцаад, нөгөө нь геологи хайгуул, өнгөт металлын асуудлыг хариуцах болсон юм. 1970 оны дунд үеэс Монголын аж үйлдвэрийн хөгжилд их ахиц гарч байв. Манай дотоодын цахилгаан эрчим хүчний хэрэгцээ эрс нэмэгдэж, түүнийг хангах цахилгаан

станцууд баригдаж, олон уурхайнууд ашиглалтанд оров. Дархан хот, Улаанбаатар хотыг холбосон өндөр хүчдэлийн цахилгааны шугам, сүлжээ бий болов. Улаанбаатар хотод шинээр ашиглалтанд орсон олон орон сууцыг цахилгаан, дулаанаар хангах шаардлагатай болов. Бусад аймгуудын эрчим хүчний асуудал ч их хурцаар тавигдаж эхэлсэн үе юм. Улаанбаатар хотод Эрчим хүчний шинэ эх үүсвэр барьж бий болгох, Зөвлөлт Холбоот Улс (ЗХУ)-ын Сибирийн Эрчим хүчний системтэй холбогдож, эрчим хүчийг худалдаж авах асуудлыг шийдвэрлэх шаардлага их хурцаар тавигдаж байлаа.

Нөгөө талаас геологи хайгуулын ажлыг чанарын шинэ түвшинд гаргаж, Монголын эрдэс баялагийн түүхий эдийг эрж хайх, илрүүлсэн нөөц баялагийг Эдийн Засгийн Харилцан Туслалцах Зөвлөлийн (ЭЗХТЗ, оросоор Совет Экономической Взаимопомощи /СЭВ/ —ред.) гишүүн орнуудын хэрэгцээнд эр дотроо ЗХУ-ын хэрэгцээнд нийлүүлэх шаардлагатай болсон үе юм. Энэ зорилгоор эрдэс түүхий эдийн эрэл хайгуулыг бие дааж хийх хэрэгтэй болов. Ийм учир шалтгааны улмаас энэ хоёр яамыг шинээр байгуулсан юм. Ингээд намайг Түлш, эрчим хүчний яамны сайдаар томилсон. Энэ үед би дахиад УТТ-ны хурлаар оров.

КЮ: Та дахиад өөрийн намтрыг оросоор ярьж өгсөн үү?

ПО: Үгүй яриагүй. Тэр үед Ю.Цэдэнбал гуай болон УТТ-ний бусад гишүүдтэй бүр танил болчихсон байлаа шүү дээ.

М.Пэлжээ сайд бид хоёрыг очиход Ю.Цэдэнбал гуай ажлынхаа өрөөнд, МАХН-ын Төв хорооны УТТ-гишүүн, нарийн бичгийн дарга Д.Моломжамц гуайтай хамт сууж байв. Би ч яахав дээ, жаахан хүн шүү дээ. Тэгээд доогуурхан, холхон шиг л суучихлаа. Тэгсэн чинь Ю.Цэдэнбал гуай “Чи наашаа суу!” гээд өөрийн хажууд байгаа сул суудлыг зааж байна. Тэгээд би тэр суудалд нь очоод суучихлаа. Өөр арга байсангүй. Би М.Пэлжээ сайдынхаа дээд талд нь гараад суучихаж байгаа юм. Эрэмбэ алдсан хэрэг болж байна шүү дээ.

Ингээд Ю.Цэдэнбал гуай шинэ яам байгуулах шаардлага гарсан тухай ярьж байна. Тэр хэсэг ярьж байснаа “П.Очирбат чамайг Түлш эрчим хүчний яамны сайдаар томилох тухай бид ярьж байна. Энэ асуудлаар чиний өөрийн санал, бодлыг сонсох гэсэн юм!” гэж байна.

Би ийм асуудал яригдах тухай мэдээгүй явсан болохоор нилээд тулгамдлаа. Тэгээд “Эрчим хүчний яам байгуулах нь зөв байх аа. Харин шинэ яамны сайдаар намайг томилох асуудал яригдаж байгаа юм байна. Би энэ их ач холбогдолтой, их өндөр, хариуцлагатай салбарын яамны сайдын ажлыг хийж чадахгүй байх. Би эрчим хүчний мэргэжлийн хүн биш,

би эрчим хүч мэдэхгүй, би уурхайн мэргэжлийн хүн шүү дээ!” гэж хэллээ. Гэтэл Ю.Цэдэнбал гуай “Чи энэ салбарын ажлыг мэдэхгүй гэдгээ мэдэж байгаа чинь их сайн хэрэг. Чи залуу хүн, мэдэхгүй юмаа хурдан, богино хугацаанд мэдэж ав! Энэ ажлыг хий! Чамайг ийм байр суурьтай байна гэдгийг би Улс Төрийн Товчоонд танилцуулна. Одоо УТТ-ны хурал эхлэх гэж байна. Та хоёр жаахан хүлээх үү?” гэлээ.

Ингээд 20-30 минутын дараа УТТ-ны хурал эхэллээ. Ю.Цэдэнбал гуай тэр хурлыг удирдаж байв. Хурал эхлээд нилээд удлаа. Ю.Цэдэнбал гуай шинэ яамдууд байгуулах шаардлага гараад байгаа талаар нийлээд ярьсныхаа дараа сайд нарыг нь томилох асуудал руу орлоо. Тэгээд “нөхөр П.Очирбатыг Түлш, эрчим хүчний яамны сайдаар томилох санал оруулж байна! Юм асуух хүн байна уу?” гэлээ. Тэнд цугларсан УТТ-ны гишүүд дотроос надаас юм асуух хүн гарсангүй. Тэгээд л бүгд гар өргөөд л баталчихлаа. М.Пэлжээ гуайг Геологи, уул уурхайн яамны сайдаар томилох асуудал руу орлоо. Харин М.Пэлжээ гуайгаас хүмүүс маш их юм асуулаа. Тэр үед социалист орнуудын ЭЗХТЗ өөрийн гишүүн орнуудад байгалийн баялагийг эрж хайх, олдворлох, хамтарч ашиглах талаар их ажил зохиож эхэлсэн байв. Тэгээд ер нь монголын геологичид одоогоор юу, юу олоод байна, цаашдаа шинээр юуг олох гэж байна, “Эрдэнэт”-ээс (зэсийн томоохон орд дээр байгуулсан уулын баяжуулах үйлдвэр — ред.) өөр юу байна? гээд л М.Пэлжээ сайдаас асуугаад байв. Шинэ зорилго, шинэ үүрэг өгөх гээд байсан юм байж л дээ. Ингээд бид хоёр батлагдлаа.

5 Эрчим хүчний салбар хөл дээрээ босов.

КЮ: Яамны жинхэнэ сайдын ажлыг хүлээж авахад ямар байв даа. Ажил нь их хэцүү юү? Та цоо шинэ яам байгуулахаар болсон байна шүү дээ.

ПО: Би ер нь дандаа шинэ юманд ноогдож байдаг хүн байгаа юм. Шарын голын нүүрсний уурхайн анхны монгол ерөнхий инженер болж байлаа. Тэр үйлдвэр сая нэг зуун мянган тонн нүүрс гаргах хүчин чадалтай, 40-50 тонны даацтай “Белаз” машинаар нүүрсээ зөөдөг, бас төмөр зам ашигладаг үйлдвэр байлаа. Тэр үед монголд тийм үйлдвэр байсангүй. Энэ бол манай анхны том үйлдвэр байлаа. Бүх юм нь шинэ байлаа. Техник нь шинэ, хүмүүс нь шинэ байв. Тэр техникийг эзэмшдэг мэргэжилтэй, туршлагатай уурхайчид байсангүй. Түр курсээр жолооч болсон хүмүүст тэр хүчирхэг, шинэ техникийг эзэмшихэд их бэрхшээл гарч байв. Техникийн эвдрэл, гэмтэл байнга гардаг байлаа. Тэгээд эвдэрсэн техникээ засах хэрэгтэй болно. Ингэж эхлэж эвдээд, дараа засаж байж сая жинхэнээр нь эзэмшинэ шүү дээ. Ажилчид, мастерууд, технологийн

инженерүүд цөм саяхан сургууль төгссөн залуучууд, туршлага муутай байлаа. Тийм хамт олныг удирдаж ажиллах, төвийн районуудыг нүүрсээр хангах асуудал бол их хүчин чармайлт шаардаж байсан юм.

Энэ ажил төр, засгийн байнгын анхааралын төвд байв. Ямар нэгэн цахилгаан станцыг бага ч гэсэн хугацаагаар нүүрсээр тасалдуулахад л бөөн шуугиан дэгдэж, хэл ам үүсдэг байлаа. Би өөрөө удирдах ажил хийж үзээгүй хүн очсон шүү дээ. Иймэрхүү байдлаар ажиллаж байгаад яамны орлогч сайд болсон юм. Орлогч сайдын ажил надад бас их том сургууль болсон. Орлогч сайд чинь дээрээ бас даргатай шүү дээ. Тийм болохоор бас учиртай. Гэхдээ яамныхаа хамаг нарийн юмыг хийнэ л дээ. Яамны “хар ажилчин” чинь орлогч сайд байдаг юм шүү дээ. Жинхэнэ сайд бас гайгүй, орлогч нараараа гол гол ажлаа хийлгэчихэж болно шүү дээ. Бас сайн туслахуудтай байвал бүр ч сайн байдаг юм. Яамыг шинээр бүрдүүлэхэд бас л хэрдээ амаргүй л байсан л даа. Тэгээд яахав, би 9 жил яамны жинхэнэ сайдын ажлыг хийсэн. Дараа нь Гадаадтай эдийн засгийн талаар харилцах улсын хорооны даргаар томилогдож байлаа.

КЮ: Яагаад тийм ажил хийх болсон юм бэ? Шал өөр салбар биз дээ?

П О: Тиймээ, шал өөр салбар шүү дээ. Тэр ч яахав дээ, бас нэг учиртай юм. Би нэг удаа Ю.Цэдэнбал даргад өргөдөл өгсөн юм. Энэ бол 1982 оны сүүлчээр болсон явдал юм. Би тэр өргөдөлдөө “Намайг яамны сайдын үүрэгт ажлаас чөлөөлж, Москвад байдаг ЭЗХТЗ-ийн дэргэдэх удирдлагын институтэд эрдэм шинжилгээний ажилтанаар томилож өгөөч!” гэсэн хүсэлт тавьсан юм.

И Л: Та өөрөө ийм асуудал тавьсан юм уу? Сайдын ажлаасаа татгалзах шалтгаан байсан юм уу?

П О: Татгалзах шалтгаан байсан юм аа. Яахав дээ, нэг тиймэрхүү, янз бүрийн л шалтгаан байсан даа. Ю.Цэдэнбал гуай миний энэ хүсэлтийг зөвшөөрөөгүй юм. “Чи эрүүл мэндээ бодож байгаа бол эмчилгээ хийлгэ! Тэгээд энэ ажлаа хий!” гээд байсан. Ингэж Ю.Цэдэнбал гуай зөвшөөрөхгүй байсаар байгаад 1985 онтой золгосон юм. 1985 онд дээр хэлсэн шинэ ажилд томилогдсон юм.

КЮ: Ийм хороо шинээр байгуулагдсан юм уу?

П О: Үгүй ээ, үгүй, хуучин байсан юм. Түүний даргаар Б.Салдан гэдэг хүн ажиллаж байв. Тэр хүн эрүүл мэндийн шалтгаантай болоод энэ

ажлыг хийхээ больсон юм. Түүнийг Унгар улсад суух элчин сайдаар томилсон юм. Намайг эрчим хүчний салбарын хүнд ажлаас чөлөөлж, хөнгөн ажилд шилжүүлж байгаа юм. Гэхдээ улсын хорооны даргын ажил бол яамны сайдын зиндааны ажил шүү дээ. Харин нүүрсний уурхай руу ордоггүй, цахилгаан станцын дуу, шуугианаас хол, голцуу гадаадад явдаг, их хөгжилтэй, зугаатай, гоё цагаан цамцтай байж болдог ажил юм л даа. Уурхайд бол цагаан цамцтай байж болохгүй шүү дээ. Ийм ажил хийдэг хүнийг “цэнхэр захтан” ч билүү, “цагаан захтан” ч билүү, шоглож нэрлэдэг юм. Би ийм ажил хийдэг боллоо.

6 1984 оны 8-р сард болсон үйл явдал.

И Л: 1984 онын 8-р сард хуралдаж, Ю.Цэдэнбал гуайн асуудлыг авч хэлэлцээд, түүнийг бүх албан тушаалаас нь огцруулсан МАХН-ын ТХ-ны ээлжит бус 8-р бүгд хурлын ажиллагаанд та оролцсоно уу? Та болсон үйл явдлын талаар тодруулж өгнө үү?

П О: Би оролцсон шүү. 1984 онд би Түлш Эрчим Хүчний Яамны сайдынхаа ажлыг хийж байсан шүү дээ. МАХН-ын Төв хорооны гишүүн, АИХ-ын депутат байлаа. Би чинь яамны сайд учир төрийн бүх л сонгуульд орно шүү дээ. Тэр үед ардчилсан сонгууль байсангүй. Би Ардын Их Хурлын депутатаар 3 удаа сонгогдсон хүн юм шүү дээ. Тэр үед сонгууль яаж явж байсан талаар би товч тайлбар хэлье.

Тухайлбал миний нэрийг 60-р тойрогт дэвшүүллээ. МАХН-ын Төв хорооноос дэвшүүлнэ шүү дээ. Тэгээд намайг сурталчлах хоёр “ухуулагч” томилоно. Би тэр хоёртой хамт миний нэр дэвшсэн тойрогт очино. Тэр хоёр намайг тэнгэрт гартал магтана. “Энэ П.Очирбат бол ерөөсөө маш их сайн хүн байгаа юм шүү!” гээд магтана. Тэр тойрогт надаас өөр хүний нэр дэвшихгүй. Надтай өрсөлдөх өрсөлдөгч байхгүй гэсэн үг шүү дээ. Тус тойргийн сонгуулийн насны бүх хүн сонгуульд оролцож, бүгд миний төлөө саналаа өгөх ёстой. Тойргийн сонгуулийн насны хүмүүсийг бүгдийг нь санал хураалтад оролцуулах маш хатуу үүргийг сонгуулийн тойргийн комисст өгдөг байсан юм. Тойргийн сонгуулийн насны хүмүүс санал хураалтад 99,99 хувь оролцсон байх ёстой байв. Хэрэв энэ үзүүлэлт тухайлбал 97,98 хувь байвал сонгуулийн тойргийн комиссынхан арга хэмжээ авхуулж, шийтгүүлдэг байв. “Яагаад тойргийн сонгуулийн насны хүмүүсийг санал хураалтад дутуу оролцуулсан бэ?” гээд улс төрийн том асуудал босож ирнэ шүү дээ. Тийм учраас тэд нар маш том хариуцлага хүлээдэг байлаа. Тэд нар өөрийн тойрогт байдаг хүмүүсийн дунд судалгаа явуулж, улс төрийн идэвхи муутай, эсвэл архи уудаг, хүмүүсийг олж

тогтоогоод, тэдний гэрт нь очоод “Та сонгуулийн санал хураах өдөр гэртээ байж байгаарай! Санал хураалтад оролцоорой!” гэж урьдчилан гуйдаг байв. Тэгээд санал хураах өдөр тусгай хүн тэр хүний гэрт ирж, түүнийг урьж авч ирээд, санал хураалтад оролцуулж, саналыг нь авдаг байв. Тийм хүмүүс санал хураах өдөр “Сонгууль надад хамаагүй!” гэж хэлээд өөр ажил хийгээд, эсвэл зугаа, цэнгэлээ хөөгөөд явчихвал бөөн хэрэг мандана шүү дээ. Тэр үеийн хуулиар 18-аас дээш настай хүн сонгох, сонгогдох эрх эдэлдэг байв. Одоо ч тийм байгаа. Онцгой цөөхөн тохиолдолд сонгуулийн эрхийг нь хязгаарладаг юм.

Сонгуулийн саналын хуудсан дээр “Пунсалмаагийн Очирбат” гэдэг ганцхан хүний нэрийг л бичсэн байна. Саналаа өгч байгаа хүн саналын хуудсанд ямар нэг үзэг харандаа хүргэхгүй. Тэнд бичигдсэн нэрийг тойруулж дугуйлахгүй. Саналын хуудсыг нугалаад шууд саналын хайрцагт хийх ёстой юм. Ингэж тэр хүний төлөө саналаа өгч байв. Тэр хүний төлөө саналаа өгөх хүсэлгүй бол саналын хуудсанд бичигдсэн нэрэн дээгүүр зураад, дарж болно. Гэхдээ хүмүүс тэр нэрийг бараг дарахгүй шүү. Тийм учраас П.Очирбат бас 100% юм уу, 99,99 хувийн санал авна. Ийм амархан сонгуулийн системтэй байсан юм шүү дээ. Тийм учраас би Ардын Их Хурлын депутатаар 3 удаа сонгогдсон юм. 1990 онд 4 дэхь удаагаа сонгогдлоо.

Гэхдээ 1990 оны сонгууль бол урьд өмнөх сонгуулиас эрс өөр сонгууль болсон юм. Тэр үед МАХН-аас өөр улс төрийн хүчнүүд буй болсон үе байсан болохоор нэг суудлын төлөө 78 хүн өрсөлдөж байв. Асар их өрсөлдөөнтэй сонгууль болж байлаа. Социализмын үеийн сонгуулийн үед намайг магтдаг ухуулагч томилж өгдөг байсан шүү дээ, тэгвэл ардчилсан сонгуулийн үед намайг магтах хүн байхгүй боллоо. Сонгуульд өрсөлдөж байгаа бид нар өөрөө өөрийгөө магтдаг болов. Магтахгүй бол сонгож өгөхгүй шүү дээ. “Би бол ёстой их сайн хүн байгаа юм шүү дээ. Надаас өөр сайн хүн ерөөсөө байхгүй л дээ. Би чинь бол их шалгарсан хүн байгаа юм шүү дээ! Би ийм, ийм ажил хийсэн, их сүрхий хүн шүү та минь ээ!” гэх мэтээр өөрөө өөрийгөө магтах хэрэгтэй болов. Тэгээд миний яриаг сонсохоор ирсэн хүмүүсээс “Та минь ээ, намайг сонгож өгөөрэй!” гээд л гуйдаг болов.

1990 оны Ардын Их Хурлын сонгуульд би Шарын голын сонгуулийн тойрогт өрсөлдсөн юм. Уг нь Улаанбаатар хотын Яармагийн дэнж хавийн тойрогоос миний нэрийг дэвшүүллээ. Ингээд тэр тойрог дээр өрсөлдөхөөр бэлтгэж байтал Социал-демократ намынхан ирээд “Та энд битгий “шаврын хаалт” болоод бай л даа! Өөр газар оч л доо! Бид нар энэ тойрог дээр овоо ажиллачихсан юм. Энэ тойрогос сонгогдох магадлал байна. Та энэ тойрог дээр манай хүнийг унагаж баллах гээд байна шүү дээ! Та эндээс

явж үз!” гэв. Ингээд би Шарын гол руу явсан юм. Би тэнд ажиллаж байсан хүн шүү дээ. Тэнд очоод “Та минь ээ, Та нар П.Очирбатыгаа таньж байгаа биз дээ? Одоо намайг сонгоод өгөөрэй!” гээд гуйхаар, сонгож л таараа шүү дээ. Тэгээд далан хэдэн хувийн санал аваад, сонгогдов. Дажгүй шүү.

И Л: Тэр үед МАХН-ын ТХ-ны хорооны гишүүдийг яаж сонгодог байсан юм бэ?

П О: ТХ-ны гишүүдийг Намын их хурлаас сонгодог байлаа. Гэхдээ бас л бодлогоор сонгоно шүү дээ. МАХН-ын ТХ-ны УТТ эхлээд нэрсийн жагсаалтыг нь баталчихна шүү дээ. Тэнд баталсан л бол хүндрэлтэй асуудал гарахгүй. Намын их хурлаар хэлэлцээд л баталчихна. Ер нь тэр үед нам, төрийн чухал бүх асуудлаар эхлээд МАХН-ын ТХ-ны УТТ-ны шийдвэр гарч байсан юм шүү дээ. Ийм шийдвэр гараагүй бол нэгч асуудлыг хаана ч шийдэгддэггүй байв. Тэр үед сайд, дарга нар бүгдээрээ л Төв Хорооны гишүүн байлаа. Би Төв хорооны гишүүн, АИХ-ын депутат боллоо. Тэгээд л төрийн, намын сонгуультай, засгийн газрын гишүүн, их том сайд байхгүй юу. Тэгээд Гадаадтай эдийн засгийн талаар харилцах улсын хорооны дарга боллоо. Энэ бол 1985 он шүү дээ.

Энэ үе бол манай хувьд нэг тийм анхаарал татсан үе байсан юм. Учир нь манай эдийн засаг бүхэлдээ ЗХУ-ын тусламж дээр тогтож байв. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн бүх асуудлыг ЗХУ-аас ямар нэгэн тусламж өгвөл төлөвлөж болдог, тусламж өгөхгүй бол төлөвлөж болдоггүй байв. Мөнгө байхгүй болохоор юугаа төлөвлөх юм бэ? Тийм биз дээ? Энэ төлөвлөлтийг ЗХУ-тай 5 жилийн өмнөөс зохицуулдаг болов. 1985 оны 4-р сард би ийм зохицуулалт хийх зорилгоор томилолт аваад Москвад очлоо. ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын эдийн засгийн байнгын хороодын хурал боллоо. Би тэр хуралд оролцож, социалист орнуудын эдийн засгийн гадаад харилцааны асуудал хариуцсан сайд, дарга нартай уулзаж, танилцлаа. “Би нэг ийм хүн байна шүү, та минь ээ. Та нартай танилцаж, хамтран ажиллах, харилцаа, холбоо тогтоох хүсэлтэй байна!” гэж би тэнд ярьж явлаа. ЗХУ-д М.С.Горбачёвын “престройка” эхэлж байсан үе шүү дээ. Цаг үе өөрчлөгдөх хандлага орчихсон байлаа. Зүүн Европын социалист орнууд бүгдээрээ л яах вэ? юу хийх вэ? гэж байсан үе. Тэр үед социалист орнууд дотроос барууны хөрөнгөтөн орнуудтай эдийн засгийн талаар хамгийн их өргөн харилцаатай байсан нь Югослав, Унгар хоёр юм. Бусад нь ч гайгүй. Польш бол нэлээн дураараа байсан даа. Унгарт 1956 онд, Чехословакад 1968 онд засгийн газрынхаа бодлогыг эсэргүүцсэн томоохон үйл явдал болсон байв. Зүүн Европын социалист орнууд амжилтанд хүрсэн туршлагаа ил, тод ярьдаг болж байв. Ийм үед

л би энэ салбарт ажиллаж эхэлж байв. Манайх бас нэг их шинэ зарчим дэвшүүллээ. Би шинэ хүн учраас их зоригтой байлаа. “Урд нь ямар байсныг сайн мэдэхгүй байна, уучлаарай!” гэж хэлээд, өөрийнхээ саналыг зүтгүүлж, зөвшөөрүүлэх аятайхан боломжтой байв.

Тэр үед ЗХУ-ын техник, эдийн засгийн тусламжийг ашиглах хоёр хэлбэр манай улсад зонхилж байлаа. Нэг дэх нь “түлхүүр гардаж авах” хэлбэр байв. Ямар нэгэн үйлдвэр, аж ахуйн газрыг ЗХУ-ын тал өөрийн 100 %-ийн хүч, хөрөнгөөр барьж бэлэн болгоод, манай талд хүлээлгэж өгдөг байв. Бид нар ямар ч ажилд нь оролцохгүй, бэлэн болсон шинэ үйлдвэр, аж ахуйн газрын зөвхөн түлхүүрийг нь л гардан авч байв. Бид ийм хэлбэрийн тусламжийг аль болохоор багасгах бодлого барьж байв. Түүний оронд ямар нэгэн үйлдвэр, аж ахуйн газрын барилгыг нь бид өөрсдөө барьж байгуулаад, түүнд шардлагатай техник хэрэгслийг ЗХУ-аас манайд нийлүүлдэг хэлбэрт шилжихийг зорьж байв. Ийм хэлбэр бол нилээд давуу талтай байв. Юуны өмнө монголчууд ажилтай болох боломжтой байв. Хоёрдугаарт хамгийн гол нь зардал нь эрс багасдаг байлаа. Учир нь манайд ажиллаж байсан зөвлөлтийн мэргэжилтнүүд маш өндөр өртөгтэй байсан юм.

КЮ: Гадаадын мэргэжилтнүүдийн зардлыг Монголын тал хариуцдаг байсан юм уу?

ПО: Тэгнэ шүү дээ. Тэдний бүх зардлыг Монголын тал хариуцдаг байв. Гадаадын мэргэжилтнүүдийн бүх зардлыг зээлийн хөрөнгөөс гаргаж байв. ЗХУ манайд зээл өгчихөөд, түүнийхээ нилээд хэсгийг нь өөрийн мэргэжилтнүүдийн зардал хэлбэрээр эргүүлээд авчихдаг байв. Тэр нь манайд зээлийн өр болоод үлдэнэ шүү дээ. Тэдний мэргэжилтнүүд маш их зардал, өндөр хангамж шаарддаг байв. Зээл ингэж хамгийн үр ашиггүй хэлбэрээр зарцуулагддаг байв. Бас гол нь хяналт маш муутай байлаа. ЗХУ-ын тал “За, энэ бол 600 сая рублийн зээл шүү!” гэж хэлээд манайд өгнө шүү дээ. Дотроо хэдэн сая нь юунд зарцуулагдаж байгааг мэдэх арга байхгүй. Задалсан төсвийг манайд өгөхгүй. Бөөнөөр л пал хийтэл өгнө. Бид нар чинь тийм зээлийг үг дуугүй хүлээгээд авч байв. Тэгээд л тэр 600 сая рублийг манай өрийн дансанд оруулаад бүртгэчихнэ. Өөрөөр хэлбэл би чамаас хэдэн төгрөг зээлээр авч байгаагаа тоолж авч чаддаггүй, харин тэр зээлийг өгч байгаа чиний хэлсэн тоог л үг дуугүй, таг харанхуй хүлээгээд авч байна гэсэн үг шүү дээ. Бид ийм байдлыг өөрчлөх зорилт тавьж байв.

Бид нар Улаанбаатарт ажиллаж байсан ЗХУ-ын барилгын трестүүдэд монгол ажилчдын тоог нэмэгдүүлэхийг зорьж байлаа. Тэр үед ЗХУ-ын

гурван том барилгын трест Монголд ажиллаж байв. Тэнд монгол ажилчин их цөөхөн байлаа. Нэгэнт цаг үе өөрчлөгдөх янзтай байсан болохоор бид олдож байгаа боломжийг дээд зэргээр ашиглахыг зорьж байсан юм. Бидний тавьсан асуудлуудыг ЗХУ-ын тал бараг хүлээн зөвшөөрсөн юм.

Би Гадаадтай эдийн засгийн талаар харилцах улсын хороонд 1985 онд очсон шүү дээ. 1987 онд шинэчилсэн зохион байгуулалт хийсэн юм. Гадаад худалдааны яам, Гадаадтай эдийн засгийн талаар харилцах улсын хороо, Материал, техникийн хангамжийн улсын хороо гэсэн 3 том байгууллагыг нийлүүлээд Эдийн засгийн гадаад харилцаа, хангамжийн яамыг байгуулсан юм. Би энэ шинэ яамны сайдаар томилогдов. Энэ бол хангамж, гадаад худалдаа, зээл, тусламжийг нийлүүлсэн нэг яам байв. Энд ажиллаж байгаад 1990 оны ардчилсан хувьсгалтай золгосон юм. 1990 оны 3-р сард МАХН-ын ТХ-ны Бүгд хурал хуралдаж МАХН-ын УТТ-г бүрэн бүрэлдэхүүнээр нь огцруулах шийдвэр гаргалаа. Энэ Бүгд хуралаас МАХН-ын ТХ-ны шинэ бүрэлдэхүүнийг баталлаа. УТТ бүрэн шинэчлэгдлээ. ТХ-ны шинэ бүрэлдэхүүн Гомбожавын Очирбатыг МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн даргаар сонголоо.

Тэр үед миний нэрийг Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга, Ерөнхий сайд хоёрын аль нэгэнд нь дэвшүүлэх тухай яриа гарсан юм шиг байна билээ. Ийм яриа явсаар байгаад миний нэрийг АИХ-ын Тэргүүлэгчдийн даргын албан тушаалд дэвшүүлэхээр тогтсон бололтой. Энэ талаар миний өөрийн саналыг ерөөсөө асуугаагүй юм шүү дээ. Нэг өдөр МАХН-ын ТХ-ны УТТ шинэ бүрэлдэхүүнээрээ хуралдаж, Сайд нарын Зөвлөлийн даргын албан тушаалд Ш.Гунгаадоржийн нэрийг, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн даргын албан тушаалд миний нэрийг дэвшүүлэх шийдвэр гаргасан юм. Энэ асуудлаар нэг, хоёр хүн санал хэлээд бидний нэр батлагдаж байв. Ингээд 1990 оны 12-р сард АИХ-ын чуулган ажлаа эхэллээ. Энэ чуулганаар намайг БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн даргаар томилчихлоо. Тэр үед МАХН-ын урьд нь мөрддөг байсан журам хэвээрээ байв. МАХН-ын УТТ л шийдсэн бол төр, засгийн аппарат түүний шийдвэрийг л биелүүлэх үүрэгтэй байлаа шүү дээ. Ингэж би АИХ-ын Тэргүүлэгчдийн даргаар томилогдчихлоо.

КЮ: Одоогийн хуулиар бол Монгол улсын төрийн тэргүүн, ерөнхийлөгч биз дээ?

П О: Тийм. Гэхдээ тэр үед манайд “төрийн тэргүүн” гэдэг албан тушаал байгаагүй юм. МАХН-ын шийдвэрээр бүх ажил явдаг байлаа. МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга нь МАХН-ын Төв Хороо, Улс Төрийн Товчооны үйл ажиллагааг урьдын адилаар удирддаг байв. АИХ-ын

Тэргүүлэгчид бол Ардын Их Хурлын чөлөөт цагт төрийн дээд эрхийг барьдаг байв. АИХ-ын Тэргүүлэгч 9 гишүүн байсан юм. Энэ 9 гишүүн хуралдаж, хамтын шийдвэр гаргана шүү дээ. Тийм журамтай байв.

Би АИХ-ын Тэргүүлэгчдийн даргаар томилогдоод шууд ажлаа хүлээж авсангүй.

Бид нар тэр үед өдөр бүр хуралдаж байсан тул ажил хүлээлцэх зав байсангүй. Хэлэлцэж, шийдвэрлэх асуудал маш олон байж л дээ. Ингээд гурван өдөр хуралдаад, дөрөв дэх өдөр нь Ж.Батмөнх гуай АИХ-ын Тэргүүлэгчдийн даргын ажлыг надад хүлээлгэж өгсөн юм.

7 Ж. Батмөнх гуай.

КЮ: Ж.Батмөнх гуай ер нь ямар албан тушаал хашиж байсан юм бэ?

ПО: Ж. Батмөнх гуай бол 1974 оноос 1984 оны 8-р сар хүртэл Сайд нарын Зөвлөлийн даргын албыг хашиж байсан юм. 1984 оны 8-р сарын дундуур хуралдаж, Ю.Цэдэнбал гуайн асуудлыг хэлэлцсэн МАХН-ын ТХ-ны УТТ-ны хурлыг Ж.Батмөнх гуай удирдсан байх. Энэ үед Ю.Цэдэнбал гуай Улаанбаатарт өөрөө байгаагүй юм. Тэрээр 1984 оны 7-р сарын сүүлчээр Москвад руу амрах зорилготой явсан юм билээ. Ю.Цэдэнбал гуай анх явахдаа тэнд ердөө 2 долоо орчим хоног л амрах зорилготой байсан юм шиг байгаа юм. 8-р сарын сүүлчээр манайд Халх голын дайны ялалтын баяр болдог шүү дээ. Ю.Цэдэнбал гуай амарч ирээд тэр баярт оролцохоор бэлтгэж, олон ажил хийхээр төлөвлөж байсан юм билээ. Энэ баярт оролцуулахаар ЗХУ-аас их олон хүнийг урьсан байж. Ю.Цэдэнбал гуайг Москвад байхад нь УТТ хуралдаж, бүх албан тушаалаас нь халах шийдвэр гаргажээ. Энэ хуралд Кремлийн эмч Евгений Чазов Москвагаас ирж оролцсон юм билээ. Хурлын дараа УТТ-ны гишүүн Д.Моломжамц, Т.Рагчаа, Ц.Намсрай зэрэг хүмүүс Москвад очиж Ю.Цэдэнбал гуайтай уулзаж, УТТ-ноос гаргасан шийдвэрийг танилцуулсан байх. Тэд нар түүнийг ажлаас нь халахыг “өөрөө зөвшөөрсөн!” гэсэн яриатай буцаж ирсэн юм байж. Үнэн хэрэгтээ бол энэ шийдвэрийг өөрөө бараг зөвшөөрөөгүй юм шиг байгаа юм. “Би заавал Улаанбаатарт очиж, Бүгд хурлын ажиллагаанд оролцно! Намын идэвхтнүүдэд талархал илэрхийлэх ёстой!” гээд байсан юм шиг байна билээ. 1984 оны 8-р сарын 23-нд МАХН-ын ТХ-ны ээлжит бус 8-р бүгд хурал хуралдаж Ю.Цэдэнбал гуайг бүх албан тушаалаас нь халах асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэсэн юм. Ю.Цэдэнбал гуай бол 1952 оноос 1974 оныг хүртэл Сайд нарын Зөвлөлийн даргаар ажиллаж байгаад, 1974 онд энэ албан тушаалаасаа чөлөөлөгдөж, АИХ-ын Тэргүүлэгчдийн даргаар томилогдсон юм. Үүний зэрэгцээгээр

1940 оноос эхлээд Ю.Цэдэнбал гуай МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн даргын албан тушаалыг хашиж байлаа шүү дээ. Гэхдээ 1954 оноос 1958 оны хүртэл МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн даргын албыг Д.Дамба гуай хашиж байсан юм. 1984 оны 8-р сар хүртэл Ю.Цэдэнбал гуай МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, АИХ-ын Тэргүүлэгчдийн даргын албан тушаалыг хавсарч байсан юм. Ю.Цэдэнбал гуайн асуудлаар урьд нь МАХН-ын ТХ-ны УТТ хуралдаж шийдвэрээ гаргасан тул Бүгд хурлаар энэ асуудлыг хэлэлцэхэд бэрхшээл гараагүй юм. Энэ бүгд хурал Ж.Батмөнх гуайг МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн даргаар сонгосон юм. Үүний дараа 1984 оны 12-р сард ажлаа эхэлсэн АИХ-ын чуулган Ж.Батмөнх гуайг АИХ-ын Тэргүүлэгчдийн даргаар томилсон юм. Би МАХН-ын ТХ-ны Бүгд хурлын гишүүн учраас Ю.Цэдэнбал гуайн асуудлыг хэлэлцсэн Бүгд хуралд суусан юм шүү. Бас АИХ-ын чуулганы ажилд ч оролцож байв.

1990 онд Монгол оронд Ардчилсан хөдөлгөөн үүсэж, Сүхбаатарын талбайд хэсэг залуус өлсгөлөн зарлаж, МАХН-ын ТХ-ны УТТ бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрох шаардлага тавьлаа. Тэдний тавьсан шаардлагын дор МАХН-ын ТХ-ны УТТ товчоо бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрох шийдвэр гарсан юм. 1990 оны 3-р сард хуралдсан МАХН-ын ТХ-ны Бүгд хурал Ж.Батмөнх гуайг МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн даргын албан тушаалаас нь чөлөөлсөн юм. Энэ Бүгд хурал МАХН-ын ТХ-ны ерөнхий нарийн бичгийн даргаар Гомбожавын Очирбатыг сонгосон юм. 1990 оны 12-р сард ажлаа эхэлсэн АИХ-ын чуулган Ж.Батмөнхийг АИХ-ын Тэргүүлэгчдийн даргын албан тушаалаас нь чөлөөлсөн юм.

8 Ю. Цэдэнбал гуай.

ПО: Ю.Цэдэнбал гуай бол асар их юм уншдаг, их хөдөлмөрч хүн байлаа шүү дээ. Тэр үеийн хамгаалалт их хатуу байв. Хажуугаар нь орос авгай нь их хатуу, хачин ааштай, хэцүү хүн байв. Ю.Цэдэнбал гуайд дотно найз нөхөд байсангүй. Дан ганцаараа л өдөр, шөнөгүй ажилладаг хүн байлаа. Найз нартайгаа уулзаад, сайхан наргиад, хөгжилдөөд “100 грамм татах” явдал ердөө байсангүй. Энэ бүгдээс харахад тэр хүн асар хүнд нөхцөлд ажиллаж, амьдарч байжээ.

КЮ: Та түүнтэй олон уулзаж байсан уу?

ПО: Олон уулзаж байсан. Зөндөө л уулзсан. Загнуулж ч байлаа. Нэг бүтэн сайн өдөр би хамт ажилладаг Д.Хурцтай тэдний гэрт хонины мах чанаж идээд, “шимийн архи” уугаад сууж байлаа. Бид хоёр ид халаад л анекдод

яриад хөгжилдөж байтал Ю.Цэдэнбал даргын комиссар гаднаас ороод ирлээ. Тэр:

-П.Очирбат сайд аа, таныг Ю.Цэдэнбал дарга яаралтай дуудаж байна. Одоо яаралтай ир гэсэн шүү! гэж байна. “Ю.Цэдэнбал дарга дуудаж байгаа болохоор маш яаралтай чухал хэрэг гарч дээ! Заавал очих ёстой!” гэж бодлоо. Очиж болно л доо. Гэтэл архи сэнгэнэж байдаг. Ингээд бөөн сандраан болж байгаа юм. Би ер нь архи уухаараа нүүр улайдаггүй хүн л дээ. Би чинь хөх нүүртэй хүн шүү дээ. Хамаг хувцасандаа үнэртэй ус түрхээд, Ю.Цэдэнбал даргын ажлын өрөөнд нь явж орчихлоо. Өөр ямар ч арга байсангүй. Энэ чинь маш их хачин юм болж байгаа юм шүү дээ. Тэгтэл “Баянгол” хүүхдийн амралтын газар гал түймэр гарч, нэг байшин шатсан юм байж. Ю.Цэдэнбал гуай “Тэр байшин шатсан шалтгаан нь тогтоогдоогүй байна. Цахилгааны утаснаас түймэр эхэлсэн байж магадгүй. Цаашид цахилгааны утаснаас гал гарахгүй байх талаар яаралтай арга хэмжээ ав! Хүүхдүүдийг галын аюулаас хамгаалах ажлыг урьдчилан сайн зохион байгуул!” гэсэн маш хатуу үүрэг өглөө.

1970-аад оны дундуур л байх, Чилийн Коммунист Намын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Луис Корвалан Монголд албан ёсны айлчлал хийхээр ирлээ. Түүнийг Ю.Цэдэнбал дарга өөрийн суудаг 30-р байрандаа уриад, оройн зоог барьсан юм байна л даа. Гэтэл тэр орой түүний байшинд цахилгаан тасарчээ. Ийм үед Ю.Цэдэнбал дарга шууд л сайд П.Очирбатыг дуудна шүү дээ.

КЮ: Ийм үед Ю.Цэдэнбал гуай хүмүүстэй яаж харьцдаг байв. Тэр хариуцлага алдсан хүмүүстэй ширүүн харьцдаг байсан уу?

П О: Гайгүй шүү. Ю.Цэдэнбал дарга их уурлаж, хүнтэй ширүүн, муухай харьцдаггүй хүн байсан. Ер нь бол их зөөлөн хүн юм шүү дээ. Хүнийг загнах, хүнтэй хэрэлдэж, маргах, муухай авир огт гаргадаггүй хүн байсан. Харин үгээр биш, бичгээр бол тэр хүн хариуцлагагүй байна, түүнийг донгодож, шийтгэх хэрэгтэй гэсэн заавар өгдөг байсан. Энэ чинь ажил шүү дээ. Тэгэх ёстой юм. Ю.Цэдэнбал гуай бол хүний хувьд их сайхан хүн шүү дээ. Ой ухаан их сайтай хүн байв. Оросын генералууд, Иван Иванович Ивановуудыг бүгдийг нь нэрлэнэ шүү дээ.

9 Монголын ардчилал, шинэчлэл.

И Л: Та МАХН-ын Төв Хорооноос арга хэмжээ авахуулж байсан гэж “Тэнгэрийн цаг” номондоо дурьдсан байна билээ?

П О: Тэгэлгүй яахав, би донгодуулсан байхгүй юу. Тэр үед Дархан хотын цахилгаан станцын түлш дамжуулах хоолой дэлбэрсэн юм. Түүнээс өмнө Улаанбаатар хотын 3-р цахилган станц дээр бас дэлбэрэлт болсон юм. Тэгээд “Ерөөсөө энэ эрчим хүчнийхэн хариуцлагагүй байна! Сайд П.Очирбат аваар, осол гарахгүй байх талаар арга хэмжээ аваагүй байна! Их муу ажиллаж байна!” гээд намайг донгодсон юм. Хариуцлага алдсан хүнийг Намын Төв Хорооны бүгд хурлын тогтоол гарч донгодно шүү дээ. “Намын донго” гэдэг бол их айхтар хэцүү зүйл байлаа. Хир барагтай бол тэр “донго”-ноосоо салахгүй. “Донго”-ноосоо салж чадахгүй бол ажлаасаа сална шүү дээ.

КЮ: Та тэгээд яаж “донго”-ноосоо салав даа?

П О: Яахав дээ, их сайн ажилладаг л болсон юм байлгүй дээ. Тэгээд сүүлд нь бас МАХН-ын ТХ-ны тогтоол гарч намайг “донго”-ноос салгасан юм.

КЮ: Ингээд та АИХ-ын Тэргүүлэгчдийн даргаар сонгогджээ. Таны хувьд энэ бас л цоо шинэ ажил биз дээ?

П О: Тийм шүү. Энэ цоо шинэ ажил байлаа. Энэ үе бол их онцлогтой үе шүү дээ. Монгол оронд өөрчлөлт шинэчлэлт ид өрнөж байлаа. 1990 онд манайд 270-280 орчим шинэ эвсэл, холбоод бүртгүүлсэн байв. Социализмын үед бол Монголын Үйлдвэрчний Эвлэл, Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэл, Монголын Улаан Загалмайн нийгэмлэг, Монгол-Зөвлөлтийн найрамдлын нийгэмлэг гэсэн цөөн тооны олон нийтийн байгууллага ажиллаж байв. 1990 онд анх түрүү Ардчилсан холбоо, Ардчилсан социалист хөдөлгөөн, Шинэ дэвшилт хөдөлгөөн байгуулагдав. Бас Нэгдэлчдийн холбоо, Хүнсчдийн холбоо, Тээвэрчдийн холбоо гэх мэтийн холбоод гарч ирлээ. Тус бүрдээ өөр өөрсдийн шаардлагыг тавьж эхлэв. Энэ бол мэргэжлийн байгууллагуудыг төлөөлсөн шаардлагууд байв. Түүнээс гадна улс төрийн намууд байгуулагдлаа. Эд нар ардчилсан хувьсгалыг хийсэн аваргууд юм шүү дээ.

Ингээд улс төрийн намууд, МАХН-тай өрсөлдөж, бидэнтэй эн тэнцүү эрх, мэдэл авах сонирхолтой байв. Тэд нар ийм зорилт тавиад тэмцэж эхэлж байлаа. Энэ дундаас “Монгол улсын сонирхол, эрх, ашиг!” гэдэг юмыг ялгаж, салгаж авах ёстой байв. “Хэнээс юуг нь авах вэ?” гэдэг бол их чухал асуудал байлаа. Ганцхан “МАХН-ыг!” гээд бусдыг нь хэрэгсэхгүй байж болохгүй. “Бусдыг нь!” гээд МАХН-ыг хэрэгсэхгүй байж болохгүй. Тэгэхлээр тэдний дунд зөвшилцөл хийх хэрэгтэй байв. Ингэж тохирч зөвшилцөхийн тулд тэд нартай олон удаа уулзаж, олон цагаар ярьж

байж, сая нэг юм дундын шийдвэрт хүрдэг байлаа. Тэгэхгүй бол энэ олон үзэл, бодолтой улс төрийн намууд чинь өөр өөрсдийнхөө үзэл бодлыг хамгаалаад л, гэжөөд л суучихна шүү дээ, маш хэцүү дээ. Тэгээд л тэдний эвийг нь олохыг хичээдэг байлаа.

Тэр үед намайг нэг хэсэг нь “бөөрөнхий Очирбат” гэж нэрлэдэг болов. Тэр үед либералчлахгүйгээр ерөөсөө болдоггүй байлаа. Өөрөөр хэлбэл “чинийх ч зөв, чамд ч авах юм байна!” гэж хэлэх хэрэгтэй байв. Ингээд хэлчихээр бас “Миний хэлсэн бүгд зөв!” гээд бодчихно шүү дээ.

“Бөөрөнхий Очирбат” гэдэг нэрийг МАХН-ын талаас гаргаж ирсэн юм. “П.Очирбат МАХН-ын гишүүн байж намынхаа үзэл бодлоор явсангүй, харин бөөрөнхийлөөд л байна шүү дээ. Энэ нөхөр юу хийгээд байна вэ? Ийм ардчилал байж болохгүй шүү дээ!” гээд л ярина даа. Хэцүү байлаа. Бид ажлынхаа өрөөнд хонох тохиолдол маш олон гардаг байв. Тэр үед маш олон хурал болдог байв. Тэр бүгдэд АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга оролцох хэрэгтэй. Маргааныг нь таслах хэрэгтэй. Маргалдаж байгаа талуудыг эвлэрүүлэх хэрэгтэй. Ийм хурлууд их удаан үргэлжлэнэ дээ. Шөнийн 2-3 цагаас нааш тарахгүй.

И Л: Та чинь “Дарга бол мэргэжил!” гэж хэлээд шуугиан тарьж байсан байх аа?

П О: Тиймээ, би тэгж хэлсэн. Тэгээд манайхан намайг их шүүмжилсэн. “Менежер” гэдэг чинь мэргэжил юм. Диплом авч менежер болдог шүү дээ. Энэ “менежер” гэдэг англи үг монголоор “дарга” гэсэн үг болж байгаа юм. Тэгээд яагаад шүүмжлээд байгаа юм бэ? гэж би асуудаг байлаа. “Менежер” гэж англиар хэлэхээр “мэргэжил” болдог, монголоор “дарга” гэж хэлэхээр яагаад мэргэжил биш болчихдог юм бэ? гээд би намайг шүүмжлэгчдээс асуудаг юм. Тэд нар надад хариу хэлж чаддаггүй юм. Тэгсэн хирнээ хэвлэлээр дүүрэн шүүмжлэл бичээд байсан юм аа.

И Л: Таны “дарга” мэргэжил чинь АИХ-ын Тэргүүлэгчдийн даргын ажил хийж байхад чинь хэрэг болсон уу?

П О: Удирдах ур чадвар гэдэг нэг ойлголт байдаг юм. Би саяхан “Удирдах ур чадвар” гэдэг нэртэй номоо шинэчилж гаргалаа. Би энэ номыг 1980 онд бичсэн юм л даа. Одоо түүнийг орчин үеийн менежментийн онол, тактиктэй холбоод, ардчилалын үе, зах зээлийн үетэй холбож үзлээ. Ингээд харсан чинь удирдлагын ухаан гэдэг бол аль ч үед зарчимын хувьд үндэс нь ижил байгаа нь харагдаж байна. Яагаад? Удирдлагын ухаан гэдэг чинь ямар нэгэн мод, төмрийг удирдах тухай биш, хүнтэй харьцах,

хүний ажлыг аль болох үр, өгөөжтэй зохион байгуулах, хүнийг хөгжүүлэх, хүний мэдлэг боловсрол, соёл, ёс суртахуун, зан араншинг сайжруулах, хүнийг сайн хүн болгох тухай ухаан юм. Ийм зорилтыг хэрэгжүүлж чадсан цагт сайн хамт олныг бүрдүүлж, сайн бүтээл гаргаж чаддаг юм. Хүнгүйгээр ямар ч техникийн систем өөрөө буй болж хөгжихгүй шүү дээ. Түүнийг чинь хүн бүтээж байгаа юм. Тэгэхлээр менежментийн ухаан буюу удирдлагын ухаан гэдэг бол хүнийг хөгжүүлэх ухаан юм. Энэ чинь шинжлэх ухаан шүү дээ. Нөгөө талаар энэ бол бас ур чадварын асуудал юм.

КЮ: Та АИХ-ын тэргүүлэгчдийн даргын албыг хэдэн жил хашсан бэ?

ПО: Хэдхэн сар л болсон юм. 1990 оны 3-р сараас 9-р сар хүртэл ажиллав. АИХ-ын Тэргүүлэгчид Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулав. 1960 оны Үндсэн хуулийн “Төрийн байгуулалтын тухай” гэдэг бүлгийг бүрмөсөн өөрчиллөө. Бага хуралтай, Их хуралтай, Засгийн газартай, Ерөнхийлөгчтэй байх бүтэцийг буй болгох шинэ бүлгийг бичиж батлав. Тэр Үндсэн хуульд байсан “МАХН бол Монголын нийгмийг удирдан чиглүүлэгч улс төрийн хүч мөн!” гэсэн утгатай заалтыг хүчингүй болгоод, олон намын системтэй болох шинэ заалтыг орууллаа. Бас сонгуулийн хуулинд өөрчлөлт орууллаа. Ингээд сонгуулийн шинэ хуулиар 1990 оны 7-р сард АИХ-ын сонгуулийг явууллаа. Шинэ АИХ-ыг байгуулж аваад, АИХ-ын гишүүд дотроос Улсын Бага Хурлыг байгууллаа. Улсын Бага хурал бол манай байнгын ажиллагаатай парламентийн эхний хэлбэр болсон юм. Тэр үед Монгол улсын Ерөнхийлөгчийг АИХ-ын гишүүд дотроос сонгосон юм. 1990 оны 9-р сард намайг “БНМАУ-ын ерөнхийлөгч” гэдэг шинэ албан тушаалд сонгосон юм.

10 Монгол улсын Ерөнхийлөгчийг сонголоо.

КЮ: Монгол улсын Ерөнхийлөгчийг сонгоход танаас өөр хүний нэр дэвшсэн үү?

ПО: Дэвшсэн. Цогт-Очирын Лоохуузын нэрийг дэвшүүлсэн юм. Пунсалмаагийн Очирбат бол МАХН-ын гишүүн шүү дээ. “Нэг намаас нэг хүний нэрийг дэвшүүлээд түүнийгээ сонгож болохгүй!” гэж үзээд, улс төрийн бусад намууд дундаасаа Ц.Лоохуузын нэрийг дэвшүүлсэн юм.

ИЛ: Та урьд нь Ц.Лоохууз гуайг таньдаг байсан уу?

П О: Танилгүй яахав. Таньдаг байсан. Ц.Лоохууз гуай чинь амьдралын их ухаантай, гэсвэр хатуужилтай, их ажилсаг хүн. Юмыг түс тас шударга шулуун хэлдэг, шүүмжилдэг, өөрийн байр суурийг илэн далангүй илэрхийлдэг, түүнийгээ хатуу хамгаалдаг, дээд удирдлагын хүмүүст долгинож, хоёр нүүр гаргадаггүй хүн юм.

И Л: 1964 оны 12-р сард хуралдсан МАХН-ын 6-р бүгд хурал дээр тэр Ю.Цэдэнбал гуайг их хурц шүүмжилсэн юм билээ. Ц.Лоохууз гуайд ингэж шүүмжлэх ямар шалтгаан байсан юм бол?

П О: Байсан байх аа. Сангийн аж ахуйнуудыг удирдах газрын дарга асан Ц.Лоохууз, Өмнөговь аймгийн МАХН-ын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга асан Б.Нямбуу, Статистикийн төв газрын дарга асан Б.Сурмаажав нар шүүмжилсэн юм. Б.Сурмаажав гуай “Монголын эдийн засаг ерөөсөө хөгжихгүй байна. Гэтэл МАХН-ын их хурал, бүгд хурал дээр монголын эдийн засаг хөгжөөд байна, Монгол цэцэглэж байна! гэж яриад байна. Тэр хөгжил чинь хаа байгаа юм бэ? Тэр худлаа, ерөөсөө хөгжиж байгаа юм байхгүй байна!” гэж хэлсэн юм.

Балдандоржийн Нямбуу гуай “Ерөөсөө Ю.Цэдэнбалын ажлын арга барил хоцрогдож байна, боловсон хүчний буруу бодлого явуулж байна, МАХН-ын Төв Хорооны бүтэц, бүх удирдах албан тушаалд дандаа Увс аймгийн хүнийг томилож, Ю.Цэдэнбал өөрийгөө тойруулан өөрийн хүнийг цуглуулж байна, бусад нь яах юм бэ?, ажил хийж болохгүй юм уу?” гэсэн асуудал тавьсан юм.

Цогт-Очирын Лоохууз гуай бол “ерөөсөө Монголын эдийн засгийн бодлого үндсээрээ буруу байна. Бусдын гар харж, тусламжид дулдуйдаж улс, орноо хөгжүүлдэг практик дэлхийд байхгүй. Өөрснөө ажил хийж сурах хэрэгтэй, өөрсдийн нөөц бололцоог ашиглах хэрэгтэй. Ю.Цэдэнбалын үйл ажиллагаа, бодлого үндсээрээ буруу байна. Энэ алдаатай, буруу бодлогоо даруйхан засаж, залруул, өөрчил! Ерөөсөө МАХН-ын ТХ-ны УТТ-ны бүрэлдэхүүнийг шинэчлэх хэрэгтэй! Гаднаас салхи орохгүй, юм хийдэггүй, өөрсдөө санаа оноо гаргадаггүй, өөрсдийгөө элдвээр хамгаалсан хэдхэн хүн тэнд суугаад байна! МАХН-ын бодлого буруу байна!” гэж шүүмжилсэн юм. Тэгэхлээр тэд нарыг “Та нар хуйвалдсан байна!” гэж гүтгээд, “Намын эсрэг бүлэг” гэсэн нэр зүүлгээд, цөлсөн юм. Тэд нар чинь Ю.Цэдэнбалын эсрэг үг хэлж, Ю.Цэдэнбалыг шүүмжилсэн юм. МАХН-ын эсрэг хандаагүй юм. Тэр үед “нам бол Ю.Цэдэнбал юм! Ю.Цэдэнбал бол нам юм!” гэдэг болчихсон байлаа шүү дээ. Энэ үгийг анх удаа МАХН-ын ТХ-ны Бүгд хурал дээр Бугын Дэжид гэдэг хүн хэлсэн юм. Тэр хүн Баян-Өлгийн аймгийн МАХН-ын

хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, Дотоод Яамны сайд, МАХН-ын ТХ-ны Хянан Шалгах Хорооны дарга, МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүн зэрэг албыг хашиж явсан хүн. Энэ үг бол Оросоос хуулбарлаж авсан үг байсан юм. Тэнд Лениний тухай “Бид Ленин гэхээр намаа гэдэг! Намаа гэхээр Ленин гэдэг!” гэсэн үг байв. Тэгэхлээр тэр үед МАХН гэдэг чинь Ю.Цэдэнбал болчихсон байлаа шүү дээ. Иймэрхүү маш буруу хандлага гарсныг Ц.Лоохууз нар маш хурц шүүмжилсэн юм. Тэд нар энэ шүүмжлэлийг хэлж байхад би ЗХУ-д оюутан байсан.

КЮ: Тэгэхлээр та эд нарын тухай оюутан байхдаа сонсож байжээ?

П О: Тэгсэн. Сонсолгүй яахав. Оюутнууд чинь тэртэй тэргүй шинэ юманд их соргог ханддаг хүмүүс шүү дээ. “Өө зүйтэй, шүүмжлэх хэрэгтэй!” гээд л ярьцгаана шүү дээ. Түүний өмнөхөн “сэхээтний төөрөгдөл” гээд их олон хүмүүсийг ажлаас нь халаад л, улс орон даяар бөөн шуугиан дэгдэж байлаа. Энэ тухай оюутнуудын дунд их яриа болж байлаа шүү дээ. Ноолуур өгөөд байдаг монголын амьд ямаа Оросын хүүхдийн тоглоомын резинэн ямаатай адилхан үнэтэй байлаа шүү дээ. Ийм юмнуудыг чинь оюутнууд дуулчихсан л яриад л байна шүү дээ.

Тэр үед “үндэсний үзэлтэн” гэсэн нэр, хаягтай болсон хүн олон байсан юм. Чингис хааны тухай ярьж болохгүй байлаа. Чингис хааны тухай ярьсан хүн “үндэсний үзэлтэн”, “Монгол бичиг” гээд ярьвал бас “үндэсний үзэлтэн” гээд зарлачихна шүү дээ. “Сэхээтний төөрөгдөл” гэсэн арга хэмжээний үеэр Бямбын Ринчин зэрэг манай том эрдэмтдийн бүтээсэн номыг нь шатаагаад, өөрийг нь шоронд хийчихдэг байлаа шүү дээ. “Үндэсний үзэл” байхгүй бол үндэстэн яаж тогтох вэ? “Үндсэрхэг үзэл” гэвэл өөр хэрэг. Тухайлбал, “арий үндэстэн бол хамгийн шилдэг нь байх ёстой, еврейчүүдийг цөмийг устгах ёстой!” гэдэг байлаа шүү дээ. Энэ бол үндсэрхэг үзэл. Энэ үзлийг дэвэргэж болохгүй. Аюултай. Харин Монгол үндэстэн гэдгээрээ бахархаж, энэ үндэстнээ хамгаалахгүй юм бол бид ерөөсөө “Монгол” гэж байгаад яах юм бэ? Тэгээд яах юм бэ? Хятадтай нэгдэх юмуу, Оростой нэгдэх юм уу, Японтой нэгдэх юм уу? Тэгж болохгүй шүү дээ. Тэгэхлээр энэ болгоныг чинь оюутнууд, сэхээтнүүд шүүмжилдэг, ярьдаг байлаа шүү дээ. Монгол хүн өөрөө байсан цагт л Монгол үндэстэн байна шүү дээ. Харийн хүний зааснаар яваад л, харийн хүний хий гэсэн болгоныг хийгээд л, харийн хүний бодсоноор бодоод л байвал юу болох вэ? Тэгвэл зүгээр “амьтай сүг” болчихно шүү дээ. Тэгж явж яасан ч болохгүй. Сэтгэлгээ, бодол санаа нь Орос байж болохгүй. Оросын төлөө, Орос шиг ярьж, бодож болохгүй.

11 Авгай.

КЮ: Ю.Цэдэнбал гуай өөрөө орос хэлээр сайхан ярьдаг байсан биз?

ПО: Өө, сайхан ярина шүү. Ю.Цэдэнбал гуай чинь өөрөө ч нэг их “үндэсний үзэл”-ийг их ад үзээд, буруутгаад байдаг хүн биш шүү. Өөрөө монгол бичгээр сайхан бичнэ. Өдрийн тэмдэглэлээ монгол бичгээр хийдэг байж. Ер нь монголжуу хүн байсан юм. Зөвлөлтийг дэмжиж, тийм бодлого барьж байж тусламж авах хэрэгтэй байж. Тусламж авах нэг арга юм даа. Тэгэхгүй бол Монгол улс “үндэсний үзэл”-тэйгээ байлаа гээд, юу хожих вэ? Бие даагаад урагшилж, том амжилтанд хүрэх үү? Хүрч болох юм. Гэхдээ мөнгө хэний гарт байна, түүний хараанд л байдаг шүү дээ. Манай монгол эрчүүд мөнгөө авгай нартаа бариулдаг юм. Эрчүүдэд мөнгө байхгүй, цалингаа авчраад л авгай нартаа тушаагаад л өгчихдөг шүү дээ. Тэгээд л “100 грамм татах” болохоор авгайгаасаа мөнгө гуйна даа. Ингээд тэднийхээ хараанд нь ороод, гарт нь баригдаж байгаа юм л даа. Зөвлөлт, Монголын харилцаа үүнтэй л адилхан юм болж байж.

ИЛ: Ш.Цэвэлмаа гуай чөлөөт хэвлэлд ярилцлага өгөхдөө “П.Очирбат нэг удаа хоосон хонуулсан!” гэж ярьсан байна билээ.

ПО: Энэ бол манайх Шарын голд байхад болсон явдал юм л даа. Шарын голын нүүрсний уурхайн ерөнхий инженер сардаа 1100 төгрөгний цалин авдаг байв. 1960-аад онд 1100 төгрөг бол сайдын авдаг цалин шүү дээ. Тэгээд уурхай төлөвлөгөөгөө биелүүлбэл бас мөнгөн шагнал авдаг байлаа. Ингээд сардаа би 1200-1500 төгрөгний орлоготой байлаа. Гэтэл манайх заримдаа мөнгөгүй болчихдог юм. Тэгээд би Ш.Цэвэлмаагаас “Чи энэ мөнгөө яадаг юм? Мөнгө байхгүй гэдэг чинь юу гэсэн үг вэ?” гэж асуудаг байлаа. Тэгтэл тэр нэг удаа “Очирбат аа, чи өөрөө энэ мөнгөө бариад үз л дээ!” гэж байна. “Тэгье! Энэ айлын төсвийг би барьж байя!” гэж хэллээ. Тэгээд нөгөө их цалингаа аваад, кармандаа хийчэхээд, их том хүн явдаг боллоо. Дэлгүүрт очиж, эхнэр, хүүхдүүдэд хэрэгтэй зүйлийг нь авч өгдөг боллоо. Тэгсэн нэг өдөр ажил тараад ирлээ. Уурхайн ажил хүнд шүү дээ. Нилээд ядарсан байх. Манай хөргөгчинд юу ч байсангүй, мах ч байсангүй, ногоо ч байхгүй. Тэгээд “Идэх юм байхгүй юу?” гээд эхнэрээс ширүүхэн асуулаа. Тэгтэл эхнэр “Мэдэхгүй. Та л мэднэ шүү дээ. Та л ногоо, махаа авах ёстой биз дээ! Та энэ айлын төсвийг барьж байгаа шүү дээ!” гэж байна. Кармандаа байсан нөгөө их мөнгөө үзтэл тэр ч дуусчээ. Тэгээд тэр шөнө бид нар хоол хийж идэлгүй, хоосон хонолоо. Тэгээд “За больё, энэ мөнгийг чи барь!” гэж эхнэрт хэллээ. Түүнээс хойш дахиж мөнгө бариагүй,

амархан дуусдаг, шал дэмий юм байна билээ.

И Л: Ю.Цэдэнбал гуай бас орос авгайнхаа нөлөөнд байсан болов уу?

П О: Байлгүй яхав дээ. Ю.Цэдэнбал гуайн найз нөхөргүй, хөндий, ганцаардмал байдалд тэр орос авгай нөлөөлдөг байсан байх. Хааяа бас энд тэнд хүлээн авалт дээр “100 грамм” таталгүй яхав дээ. Тийм үед тэр “авгай” уурладаг, загнадаг, наадуулыг нь бас загнадаг байсан гэнэ билээ. УТГ-ны гишүүдийг загнадаг байв. “Та нар Ю.Цэдэнбалд архи өглөө! Та нар Ю.Цэдэнбалыг архичин болгох гээд байна уу?” гээд л бөөн юм болох жишээтэй. Тийм учраас тэр хүн бол хөөрхий минь, хувийн жаргал эдлээгүй байж магад. Дан ганц л төрийн албанд зүтгэж байсан байх. Бүх юм хаалттай, хязгаарлагдмал, хол хөндий байж. Гаднаас нь харахад их том эрх, дархтай юм шиг мөртөө хувийн талаасаа ямар ч эрх чөлөөгүй, хөөрхийлөлтэй байж. Дуртай цагтаа чөлөөтэй гараад, найзуудтайгаа уулзаад, хөдөө гол, горхины эрэг дээр очоод, жаахан зугаацаад, амрах эрх, чөлөө түүнд байсангүй. Орос “авгай” мэдвэл бөөн юм болно. Болохгүй.

Монгол айлд ороход заавал сүүтэй цайгаар дайлдаг шүү дээ. Энэ чинь манай ёс, заншил юм. Гэтэл Төрийн тусгай хамгаалалтын 3-р газрын хүмүүс тэр цайг нь авч өөр газарт тавиад, Ю.Цэдэнбал гуайд өөрсдийнхөө авч яваа цайнаас өгдөг байлаа. Малчин айлын эзэн шимийн архи аягалаад өгвөл бас түүнийг нь аваад өөр газарт тавьчихаад, өөрсдийнхөө “баталгаат архи”-ийг Ю.Цэдэнбал гуайд өгдөг байлаа. Тэр нь ихэнх тохиолдолд ус байдаг юм. Тийм хачин юм болдог байлаа шүү дээ.

Би Ерөнхийлөгч болоод энэ бүх хачин зүйлүүдийг бүгдийг нь байхгүй болголоо. Малчин айлд ороод, эзэгтэйнх нь хийж өгсөн цайг нь уугаад, хоолыг нь идээд, айлын эзний аягалж өгсөн шимийн архийг нь уугаад явж байлаа. Монгол айлын гэрт хонодог байлаа. Айлын авгай, нөхөр, хүүхдүүд нь унтаж байна шүү дээ. Би хойморт нь унтана. Би ингэж явж байв. Тэгээд надад “Хээгүй Очирбат” гэсэн нэр өгчихсөн юм. Ард түмэнд тэгж ойр дотно байх ёстой юм. Ямар ч монгол айлын эзэгтэй муудсан цай зочиндоо өгдөггүй юм. Энэ бол манай уламжлалт ёс заншил. Өгсөн цайг нь уухгүй бол тэр эзэгтэйн сэтгэл нэг л сэвтэй үлдэнэ шүү дээ. Хүний сайхан сэтгэлийг ингэж сэвтүүлж болохгүй. Гэрийн эзэгтэйн хийж өгсөн аягатай цайнаас амсдаггүй, уудаггүй, тийм муухай ёс Монголд байхгүй. Ер нь цаашид ч бий болохгүй байх. Монгол хүн их цайлган, цагаан сэтгэлтэй шүү. Үнэн голоосоо итгэдэг, үнэн голоосоо баярладаг, бас үнэн голоосоо гомддог юм. Хуурамч юм байхгүй. Хоёр нүүр байхгүй. Ард түмэндээ итгэхгүй, дайсан юм шиг хандаж болохгүй шүү дээ.

Орос, Хятад хоёрт хоёуланд нь монголчууд амьдарч байна. Өвөр

Монгол, Буриад Монгол, Халимаг Монгол, Тува гээд. Энэ чинь бүгд ижилхэн монголчууд шүү дээ. Би Ерөнхийлөгч байхдаа Чингис хааны мэндэлсний 830 жилийн ойг тэмдэглэж, АИХ-ын танхимд их том хурал зохион байгуулж, өөрөө илтгэл тавьж байв. Тэгж монголчуудын сэтгэлд нь байнга байж байдаг, эмзэг сэдвийг нь хөндөж байлаа. Энэ бол олон жил хориотой сэдэв байсан шүү дээ. Хүмүүс “Өө, энэ их зүйтэй байна!” гээд дэмжээд эхэлж байгаа юм.

Монголчууд чинь үндэснийхээ уламжлалыг асар их хүндэтгэдэг, аугаа их түүхтэй ард түмэн шүү. Олон тасархай Хятад орон бүхэлдээ Монголын мэдэлд олон зуун жил байлаа. Нэгдмэл Хятад улс байсангүй. Үүнийг Монголчууд буй болгосон юм. Олон зуун жил бид нар тэнд эзэн болж суулаа шүү дээ. Хубилай сэцэн хаан Их Юань гүрнийг байгуулсан их түүх бий. Энэ чинь Монголын түүх. Орос орон бүхэлдээ Монголын мэдэлд байлаа. Чингисийн хүүхдүүд, ач нарын байгуулсан “Их Алтан ордны улс” олон зуун жил оршин тогтнож байлаа. Одоо тэдний хойч үе Орос оронд амьдарч байна. Орос орон бүхэлдээ “Алтан ордны улс”-ын нөлөөн дор өндийж боссон юм. Түүний орыг залгамжилж авсан юм. Энэ бүхэн бол нийт хүн төрлөхтний түүхийн нэг хэсэг, Монголын ард түмний туулж өнгөрүүлсэн, өөрөө бүтээсэн түүх шүү дээ. Тэгэхлээр бидэнд яриад байх юм байгаа биз дээ? Энэ бүхэн монгол хүний генээр дамжаад, монгол хүний сэтгэл, зүрхэнд нь хадгалагдаж байдаг юм. Социализмын үед энэ бүхэн их бүдгэрч, түүнийг хайр найргүй устгаж, арилгахыг оролдсон юм. Ер нь хүн юм гуйгаад явах дургүй биз дээ? Хүний эрхэнд байх дургүй биз дээ? Монгол хүн ч адилхан шүү дээ. Социализмын үед монгол хүний дургүй олон зүйлийг хүчээр хийхийг оролдож байв. Өөрсдөөс нь үл хамаарах шалтгаанаар буй болсон ийм нөхцөл, байдлын улмаас тэр үед монгол хүний сэтгэл зүй ерөнхийдөө их гутрангуй аястай болсон юм.

Үндэстэн ямар нөхцөлд сөнөж, мөхдөг вэ? Оюун санааны доройтолд орсон нөхцөлд л мөхдөг байх. Түүнийг мөхөөхийн тулд оюун санааг нь хордуулах хэрэгтэй байх. Ингэж түүнийг сулраагаад, бутраагаад, дарж авдаг байх. Тийм учраас монгол хүний “үндэсний бахархал”, “үндэсний үзэл” гэдэг зүйлийг сэргээх зайлшгүй шаардлага байсан юм. Ингэж сэргээж чадах юм бол хүмүүс өөрсдөө бие дааж амьдрах, өөрөө өөрийнхөө төлөө, өөрийнхөө үндэстний төлөө амьдрах сэтгэл зүй нь сэргэж, урам ордог юм байна. “Хүний эрхээр жаргахаар өөрийн эрхээр зовсон нь дээр!” гэдэг бол монголчуудын ярьдаг үг. Энэ бол монгол философи юм.

Манайд 1962 онд Чингис хааны мэндэлсний 800 жилийн ойн арга хэмжээнүүд боллоо. Гэтэл энэ ойн арга хэмжээнд оролцсон хүмүүс бүгд шийтгүүлсэн юм шүү дээ. Тухайлбал Ц.Дамдинсүрэн гуай энэ ойн үер болсон эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьжээ. Гэтэл түүнийг

буруутгаад бичсэн номыг нь, бас түүний хийсэн “1000 жилийн түүхийн он, цагийн тоолол”-ыг улсын хэвлэх үйлдвэрийн хашаанд шатааж байлаа шүү дээ. Бямбын Ринчин гуайг ч бас адилхан. Тэр хуралд оролцсон бусад том, том эрдэмтэд, номтой сэхээтнүүдийг ийш тийш нь цөллөө. Тухайлбал, ШУА-д ажиллаж байсан хүнийг цахилгаан станцийн химийн лабораторийн ажилтан болгож өөрчилж байв. Энэ бол нөгөө “үндэсний үзэл” гэдгийг дарж байгаагийн нэг жишээ юм. Энэ бол “улс, үндсээ” гэсэн үзлийг дарж байгаагийн нэг илрэл юм. “Үндэсний үзэл” гэдэг манайд ингэж бүрхэгдэж, ихээхэн доройтсон юм. Одоо бол ихээхэн сэргэж байна шүү дээ. Одоо бол олон түмний зовхи нь дээшээ байна.

1990 оны 7-р сарын 11-нд би АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга болсноосоо хойш анхныхаа наадмыг хийлээ. Наадам бол манай ард түмний үндэсний их баяр юм. Ургамал ус жигдэрч, айраг цагаа бялхаж, ард түмний сэтгэл тэнийсэн зуны дэлгэр сайхан цагт болдог юм. “Хөлтөй нь хөлхөж, хөлгүй нь мөлхөж үздэг Монгол Наадам!” гэж манайхан ярьдаг шүү дээ. Би монгол дээлтэй гарч ирээд наадмын талбайн ногоон зүлгэн дээр дэвссэн хонины цагаан эсгий дээгүүр алхаж, “Есөн хөлт цагаан туг”-ныхаа дэргэд очиж зогсоод, төрийн дуулаллаа эгшиглүүлж байгаад, ард түмэндээ хандаад үг хэлэв. Энэ агшинд олон хүн уйлсан гэж хожим дуулсан юм шүү. Урд нь наадам болж л байсан, гэхдээ ард түмэн уйлж, сэтгэл нь хөдлөж байсангүй. 15.000 хүний багтаамжтай Наадмын талбай дүүрэн хүнтэй байсан. П.Очирбатыг хараад хүмүүсийн сэтгэл нь хөдлөж уйлахгүй шүү. Монгол наадмыг монгол ёсоор нь хийж байгаад хүмүүсийн сэтгэл хөдөлж байгаа юм. Монгол ёс, монгол газраа эргэж ирж байгааг хүмүүс мэдэрч байна шүү дээ.

КЮ: Ю.Цэдэнбал гуай наадмыг нээж үг хэлэхдээ монгол дээл өмсдөггүй байсан юм уу?

П О: Монгол дээлийг чинь Ю.Цэдэнбал гуайн үеэс хорьчихсон юм шүү дээ. Ю.Цэдэнбал гуай дандаа костюмтай явдаг хүн байлаа. Тэгээд наадмын талбайд гарч, ард түмэнд ойртож ирэхгүй. Тээр дээр асар дотроос товчхон үг хэлдэг байлаа. Би энэ байдлыг өөрчилсөн. Энэ наадмын нээлтийн бүх сценарыг алдарт зураглаач Д.Балжинням зохиоход би өөрөө оролцсон. Шинэ цаг эхэлж байгааг хүмүүст мэдүүлэх хэрэгтэй байв. Үүнд олон цагийн ухуулга хэрэггүй.

Наадмын нээлтийн тэр агшин хүмүүст маш их юм бодогдуулж байгаа юм. Монголчууд бол нүүдэлчид учраас мэдээллийг дандаа амаар дамжуулж ирсэн уламжлалтай юм. Эмээ, өвөө нар том, том туульс, үлгэр, домгийг дандаа цээжилчихсэн ярьж байдаг шүү дээ. Хонио хотлуулчихаад,

хүүхэд, залуучуудад шууд цээжээрээ үлгэр, тууль ярьж өгдөг шүү дээ. Зохиогч нь мэдэгдээгүй, том, том туульсууд манайд олон бий. Хэзээ, хэн зохиосныг нь мэдэх арга байхгүй. Гэтэл амнаас ам дамжин яригдсаар, улам баяжсаар өнөөтэй золгосон байна. Наадмын тухай мэдээ ч бас ингэж амнаас ам дамжин яригддаг юм. Бүтэн жилийн турш ярих ярианы сэдэв болдог юм. Одоо суурин амьдралд шилжиж байгаа тул манайхан их бичдэг болж. Би “Тэнгэрийн цаг” номоо ерөнхийлөгчийн албыг хашиж байхдаа бичсэн юм шүү дээ. Тэгээд юу гэж бодогдсон юм бэ гэхлээр “Анхны төрийн тэргүүн болсон хүн юу бодож байсан, юу хийж байсан тухай, өөрийнхөө хийсэн буруу, зөв зүйлийнхээ тухай, гаргасан алдаа, онооныхоо тухай өөрөө бичье!” гэж шийдсэн юм. Дараа нь мэдэхгүй хүмүүс энэ болсон үйл явдлуудыг янз бүрээр тааж бичнэ шүү дээ.

1990 онд зах зээлийн эдийн засаг гэдгийг жинхэнэ утгаар нь ойлгож хүлээж авдаг хүн ховорхон байлаа. Тийм учраас тэр үед энэ сэдвээр хэлсэн миний зарим үг нийгэмд их дуулиан тарьж байлаа. Би нэг удаа хөдөлмөрчидтэй хийсэн уулзалт дээр “Төр төмөр нүүртэй байдаг юм!” гээд хэлчихлээ. Зах зээлийн эдийн засаг, ардчилсан ёсонд шилжиж байгаа нь энэ гээд нийгэмд эмх замбараагүй байдлыг буй болгож болохгүй шүү дээ. Ямар ч үед буруу үйлдэл хийвэл хэнд ч өршөөл байх ёсгүй. Энэ бол ийм утгатай үг юм. Гэтэл энэ үгийг тойроод их шуугиан дэгдэж билээ. “П.Очирбат бол их хатуу, харгис нөхөр байна шүү!” гээд л шуугиж байв. Бас эмэгтэй хүний 45 төгрөгний гутал, 700 төгрөгний гутлын тухай нэг яриа их шуугиан тарьсан юм.

Зах зээлийн үед хүний орлогын хэмжээ нь тэр хүний хэрэглээг тодорхойлно. Орлого багатай бол тансаг юм хэрэглэж чадахгүй. Энэ бол зах зээл өөрөө зохицуулж байгаа зүйл. 1990-ээд оны зах, зээл арай эхлээгүй байх үед энэ яриа болсон юм. Социализмын үед хүн болгон өмсдөг, ЗХУ-д үйлдвэрлэсэн, эмэгтэй хүний гутал байсан юм. Үнэ нь 45 төгрөг байв. Хямдхан, хөлд эвтэйхэн, чанартай сайн гутал л даа. Хүн болгон түүнд дуртай байв. Бүгдээрээ л түүнийг өмсдөг байв. Тэр үед чинь манайд төдийгүй, бусад социалист оронд ч адилхан, өргөн хэрэглээний барааны сонголт бараг байдаггүй байлаа. Бүх хүн бараг нэг ижилхэн л юм хэрэглэдэг байлаа. 1990-ээд оны эхээр манайд Австри улсад үйлдвэрлэсэн эмэгтэй хүний гутал импортоор орж иржээ. Австри бол гутал сайн хийдэг орон шүү дээ. Тэр гутлыг манай дэлгүүрт 700 төгрөгөөр зарж эхэлжээ. Уг жинхэнэ үнэ нь тийм биш, түүнээс ч их байсан байх. Гэтэл хүмүүс энэ гутал яагаад ийм их үнэтэй байгааг гайхаад, нийгэмд бөөн яриа болж байсан юм.

Ер нь энэ үед өргөн хэрэглээний барааны үнэ өсөх хандлагатай болчихсон байсан үе юм. Ийм үед хөдөлмөрчидтэй хийсэн нэг уулзалт дээр

“орлого сайтай хэсэг нь 700 төгрөг, түүнээс дээш үнэтэй гутал өмсөөд, орлого багатай нь 45 төгрөг, түүнээс хямд гутал амсөж болно шүү!” гэсэн утгатай үг би хэлсэн юм. Гэтэл “П.Очирбат ард түмнийг ялгаварлаж, дугаарлаж байна. Үнэтэй юм хэрэглэдэг нэг хэсэг, хямд юм хэрэглэдэг нэг хэсэг бий болох юм байна! Зах зээл ийм байх ёсгүй!” гээд л шуугив. Энэ бол социализмын үеийн “хүн бүгд адил, тэгш байх” тухай үзэл, бодол шууд үйлчлэлд байгаагийн жишээ юм л даа. Энэ мэтчилэнгийн олон хэцүү асуудалтай тулгарч байлаа.

12 Ю. Цэдэнбалын “тойрон хүрээлэгчид”.

И Л: 1990 оны 6-р сард хуралдсан МАХН-ын Төв Хорооны ээлжит Бүгд хурлаар “Ю.Цэдэнбалын тойрон хүрээлэгчид”-ийн асуудлыг авч хэлэлцсэн шүү дээ. Ер нь яагаад ийм асуудал тавигдсан юм бэ? “Ю.Цэдэнбалын тойрон хүрээлэгчид” гэж хэн бэ?

П О: 1990 оны 3-р сард МАХН-ын Төв Хорооны УТТ бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорсон шүү дээ. Засгийн газар ч огцорлоо. “Энэ юуны учир вэ? Энд ажиллаж байсан хүмүүс Монголын ард түмний өмнө ямар буруу хэрэг хийсэн юм бэ? Зүгээр огцруулахын тулд огцруулж байгаа бол нэг хэрэг, буруу хэрэг хийсэн бол нэг хэрэг. Буруу хэрэг хийсэн юм бол тэдэнд хариуцлага хүлээлгэхгүй юм уу? Ямар буруу хэрэг хийсэн юм бэ? Буруу нь юундаа байсан юм бэ? Үүнийг шалгаж тогтоогооч ээ!” гэсэн яриа нийгэмд их газар авч байв. Энэ үед 1990 оны 4-р сард МАХН-ын Онц их хурал хуралдав. Энэ их хурлаас Ю.Цэдэнбалтай он, удаан жил хамт ажиллаж байсан МАХН-ын ТХ-ны УТТ-ны гишүүд, Сайд нарын Зөвлөлийн дарга, орлогч даргаар ажиллаж байсан олон хүнийг “Ю.Цэдэнбалын тойрон хүрээлэгчид” гэж тодорхойлсон юм. Тэгээд тэдний улс оронд учруулсан хохиролыг шалгаж тогтоох комисс буюу ажлын хэсэг байгуулах шийдвэр гаргасан юм. Энэ комисс нийт 41 хүнийг шалгасан юм. Ингээд 1990 оны 6-р сард МАХН-ын ТХ-ны 3-р бүгд хурал хуралдаж “Ю.Цэдэнбалын тойрон хүрээлэгчид”-ийн асуудлыг шалгасан комиссын илтгэлийг авч хэлэлцээд, тогтоол гаргасан юм. Энэ тогтоолд 7 хүнийг МАХН-аас хасахаар заасан юм. Эдгээр хүмүүсийг буруутгасан гол үндэслэл нь “Ю.Цэдэнбалын алдаатай бодлого болон сэхээтнүүдийг хэлмэгдүүлсэн зэрэг буруу үйл ажиллагааг нь таслан зогсоохгүй, түүнтэй эвлэрч байсан, удирдлагын эв нэгдлийг хангах нэрийдлээр бие биендээ найр тавьж, тал засаж, элдэв хөнгөлөлт, тусгай хангамж эдэлж, улсын хөрөнгийг зүй бусаар зарцуулж, намын сахилгыг гажуудуулсан!” гэдэг дүгнэлт хийсэн юм. Энэ долоон хүний тоонд Ю.Цэдэнбал гуай өөрөө

багтаж байв.

Энэ бүгд хурал ийм шийдвэр гаргахаас өмнө 1990 оны 4-р сарын 6-нд МАХН-ын ТХ-ны УТТ шинэ бүрэлдэхүүнээрээ хуралдаж, Ю.Цэдэнбалд Улсын баатар, Хөдөлмөрийн баатар, маршал цол олгосон өмнөх тогтоолуудаа хүчингүй болгохыг шийдвэрлэсэн 15 тоот тогтоол гаргав. Тэр үед мөрдөгдөж байсан хуулиар УТТ-ны энэ шийдвэрийг АИХ-ын Тэргүүлэгчдийн газар хэрэгжүүлэх ёстой байв. Ингээд 1990 оны 4-р сарын 18-ны өдөр АИХ-ын Тэргүүлэгчдийн 97-р дугаар зарлигт АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга, Нарийн бичгийн дарга, тэргүүлэгч гишүүд, бүгд 8 хүн гарынхаа үсгийг зурлаа. Энэ зарлигаар Ю.Цэдэнбалд олгосон “БНМАУ-ын баатар”, “Хөдөлмөрийн баатар”, “БНМАУ-ын маршал” цолыг тус тус хасаж, БНМАУ-ын баатарын “Алтан таван хошуу” медаль, БНМАУ-ын Хөдөлмөрийн баатарын “Алтан Соёмбо” медаль, Сүхбаатарын одон хоёр, Маршал цолны “Од” тэмдэгийг тус тус хураахаар шийдвэрлэсэн юм.

Ю.Цэдэнбал гуайг янз бүрийн үед шагнаж байсан төрийн дээд шагналуудыг хурааж авах шийдвэрийг миний удирдаж байсан АИХ-ын тэргүүлэгчдийн газар өөрөө санаачилж гаргаагүй, тэр үед мөрдөгдөж байсан хуулийн дагуу МАХН-ын ТХ-ны УТТ-ны гаргасан шийдвэрийг хэрэгжүүлсэн хэрэг явдал байв.

Ер нь Ю.Цэдэнбал гуай гадаад, дотоодын нийлээд 40 гаруй одон медалиар шагнуулсан юм билээ. Ю.Цэдэнбал гуай бас армийн генерал цолтой хүн. Бусад одон медалууд, цолнууд нь өөрт нь үлдсэн юм шүү дээ. Энэ бол нэг хүний шийдвэр биш. АИХ-ын Тэргүүлэгчдийн хамтын шийдвэр. Ерөнхийлөгчийн зарлиг биш. Энэ шийдвэрийг гагцхүү АИХ хүчингүй болгох эрхтэй юм.

ЮК: За, цаг, зав гаргаж маш сонирхолтой яриа ярьж өгсөнд танд их баярлалаа.

П О: Зүгээр ээ. Зүгээр.

Төгсгөлийн уг

И.Лхагвасүрэн

Монгол улс ардчилал, зах зээлийн харилцаанд шилжиж эхэлснээс хойш даруй арав гаруй жил өнгөрчээ. Энэ хооронд манай орны улс төр, эдийн засаг, нийгмийн амьдаралд томоохон өөрчлөлтүүд орлоо. Энэ болтол бид улс төрийн нэг намын удирдлагын доор, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоотой олон жилийг ардаа орхижээ. Улс орныхоо хөгжил дэвшил, ард түмнийхээ сайн сайхан амьдралтай холбоотой бүхий л асуудлыг эрх баригч цорын ганц МАХН-ын бодлогоор тодорхойлж ирсэн билээ. МАХН төрийн эрхийг дангаараа барьсан дал гаруй жилийн дотор талын Монголын нүүр царай танигдахгүй болтлоо өөрчлөгдсөнтэй маргах хүн гарахгүй биз ээ. Улс орныхоо тусгаар тогнолыг харийн түрэмгийлэгчдээс байлдан хамгаалж, эцэг өвгөдөөс үлдээж өгсөн, нутаг усаа хадгалж чадсан билээ. Орчин үеийн хот, суурингууд сүндэрлэн босож, нүүдэлчин түмний амьдарлын хэв маяг үндсээрээ өөрчлөгдөх эх сууриуд нь тавигдав. Үеийн үед монголчууд бидний амьдралын эх сурвалж болж ирсэн таван хошуу малаа өсгөж, шинэ шинэ үйлдвэрүүд байгуулж, “монголд үйлдвэрлэв” гэсэн хаягтай бүтээгдэхүүнүүдийг нь дэлхийн зах зээлд гаргаж эхэлсэн билээ. Онгон эзлүүд, атар газрыг эзэмшиж, олон мянган га талбайд тариа, ногоо тариалах болсон нь хүн амаа хүнсээр хангаад зогсоогүй, ургац сайтай жил хөрш орнуудын хүнсний хэрэгцээнд нийлүүлдэг болсон билээ. Ард түмнийхээ эруул мэндийг хамгаалж, хүн амаа урд хожид байгаагүй ихээр өсгөж, өсвөр настнаасаа эхлээд өглөх настнаа хүртэл толгой дараалан бичиг үсэгтэй болж, шинжлэх ухаан боловсрол, соёл цэцэглэн хөгжиж, монгол хун оюун ухаанаараа дэлхийн түвшинд өрсөлдөж эхэлсэн билээ. Сансар огторгуйд иргэнээ нисгэж чадсан цөөхөн орны нэрсийн жагсаалтанд Монгол гэдэг нэр тодоос тод бичигдэв. Авьяас билэгт ард түмний маань түүхийн ахархан богино хоромд хийсэн бүтээсэн нь орчлонгийн хүн бүхний нүдэнд ив ил, тодоос тод харагдаж байгаа билээ. Гэхдээ энэ бол нэг л тал нь. Нөгөө талд нь харийн гүрний нөлөөнд автаж, хамаг улс орноо барьцаанд тавьж, унасан газар угаасан усныхаа нэг хэсгийг найр тавин өгч, гэм хийгээгүй гурван түмэн иргэнээ цаазын тавцанд илгээж, ард түмнийхээ ариун шүтээн болсон олон зуун сүм хийдийг нь галдан шатааж, дэлхийн соёлын өвд данстай мөнхийн бүтээлүүдийг мөхөөн устгасан нь энэ намын бодлогоор хийж гүйцэтгэсэн ажил мөн гэдэгтэй маргаад хэрэггүй биз ээ. Улс Монголынхоо төлөө хоёргүй сэтгэлээр зүтгэж явсан ухаантай, авьяастай, авхаалжтай нэг

хэсгийгээ “ардын дайсан”, “хувьсгалын эсэргүү”, “сэхээтний төөрөгдөл”, “намын эсрэг бүлэг”, “үндэсний үзэлтэн” гэх мэтийн зохиомол нэр хаяг зүүлгэж, алдаг, халдаг, цөлдөг байсан нь бас л энэ намын олон үеийн удирдагчдын шууд тушаалаар хийгдсэн ажил гэдэг нь маргашгүй үнэн билээ. 90-ээд онд эхэлсэн ардчилсан үйл явцыг хамгийн их эсэргүүцэгч нь энэ нам байсны гэрч нь бид нар өөрсдөө болоод сууж байна. Монгол орныг дэлхийн хэмжээнд “муухай харагдуулж байгаа” их авилгалын хэрэг, эх орны эрдэс баялагийг “хөрөнгө оруулалтыг дуудах” нэрийн дор гадна, дотны доншуучлагч нарт худалдсан бусармаг үйлдлүүд бол төрийн эрхийг одоо болтол барьсаар байгаа энэ намын шинэ удирдагч нартай холбоотой болохыг нь нотолсон, баталсан мэдээллүүд манай “шар”, “хар” хэвлэлүүдээр дүүрэн гарсаар байгаагийн уншигч нь ч бас бид нар өөрсдөө болсон билээ. Олон намууд байгуулагдаж, ардчилсан сонгуулиуд явагдаж, улс орныхоо хөгжил дэвшил, ард түмнийхээ сайн сайхны төлөө гэсэн бүхэн үгээ хэлж, үйлээ бүтээж болдог сайхан цаг ирснийг бид хамтдаа мэдэрч, үзэж, хүртэж яваа билээ. Арилжаа, наймаа хөгжиж, авдаг өгдөгийн тоо нэмэгдэж, ард түмэн арвин баялагийн эзэн нь болох замдаа ороод байгаа нь бас маргашгүй үнэн билээ. Гэхдээ энэ нам биднийгээ урьдын адил удирдсаар, “хайрлуулсаар”, “энхрийлүүлсээр” байгаа нь ч бас л маргашгүй үнэн мөнөөсөө мөн билээ. Эх орны хувь заяаг жолоодож ирсэн МАХН эхнээсээ л нэг хүн шиг нэгдмэл, цул байгаагүй гэдэгтэй маргах хүн гарахгүй биз ээ. МАХН-ын дотор өнөөг хүртэл маш олон үзэл, бодол уралдаж, тэмдэлдэж, нэг нь ялж, нөгөө нь ялагдаж ирсэн урт удаан түүх бий. Цаг үеэ дагаад тэмцлийн зорилго, хэлбэр, агуулга нь өөрчлөгдөж байсан нь мэдээж. Бас цаг үеэ дагаад тэмцлийг шийдэж байсан арга, хэлбэр нь өөрчлөгдөж байсныг бид мэднэ. Уншигч авхай танд нэгэн цаг үеийн дотор энэ намын дотор өрнөж байсан хүрц, ширүүн тэмцлийг манлайлж, эцэст нь “Эсэргүү” нэртэйгээр цөллөгт хорин таван жилийг үдсэн гайхамшигтай хүмүүсийн ярьсан яриа, хэлсэн үгийг өргөн барилаа.

Та тунгаан болгооно уу.